ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕД МАЛ АМЬТАНД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ЗААВАР БОЛОН СТАНДАРТУУД (LEGS)

Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар болон стандартууд (LEGS) нь хүмүүнлэгийн хямралд өртсөн, мал аж ахуй эрхэлдэг орон нутгийн иргэдэд хүргэх тусламжийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх олон улсын багц заавархилгаа юм. Нотолгоонд суурилсан тэргүүлэх туршлагад үндэслэсэн Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар болон стандартууд (LEGS) нь ард иргэдэд өөрсдийн мал хөрөнгө, амьжиргаагаа хамгаалах, сэргээхэд зориулагдсан зохистой, үр дүнтэй хариу арга хэмжээг тодорхойлон, хэрэгжүүлэхэд нь орон нутагт ажиллаж буй мэргэжилтнүүдэд хөтөч болдог.

Гарын авлагын энэхүү шинэ хэвлэлт нь 2009 оноос хойш хуримтлуулсан шинэ туршлага, нотолгоог тусгасан бөгөөд хэрэглэхэд хялбар болгох үүднээс иж бүрнээр нь шинэчлэн боловсруулагдсан юм. Тус номонд наад захын стандартууд, голлох үйл ажиллагааг дүрслэн харуулж, тухайн ард иргэдэд хандан зургаан төрлийн гол дэмжлэг туслалцаа болох малын тоо толгойг цөөлөх, мал эмнэлгийн үйлчилгээний дэмжлэг үзүүлэх, малын хашаа хороо, тэжээл хангамж, усан хангамж болон малжуулах үйл ажиллагааны зааварчилгаа, дэлгэрэнгүй мэдээлэл, шийдвэр гаргалтын шалгуур үзүүлэлтүүдийг тухайн учирсан гамшгийн үе шат, мөн хүйсийн тэгш байдал болон хамгаалалт зэрэг нийтлэг анхаарах асуудлыг харгалзсаны үндсэн дээр тусган өгсөн юм. Улмаар гол сэдвүүдийг улам сайжруулан, нэмэлт мэдээлэл оруулсан бөгөөд жишээ нь бэлэн мөнгө эсвэл эрхийн бичиг олгох, даван туулах болон дасан зохицох чадвар, уур амьсгалын өөрчлөлт, мал хамгаалал, хуарангийн нөхцөлд амьдарч буй хүмүүсийг малжуулах зэрэг нэмэлт мэдээлэл оруулан сайжруулсан болно.

Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар болон стандартууд (LEGS) нь ард иргэдийн амьжиргаанд мал, амьтан нь ихээхэн ч чухал үүрэгтэй байдаг нутаг оронд онцгой байдлын үеийн тусламж үзүүлж буй ажилтнууд болох тусламжийн байгууллага, олон улсын байгууллага болон Засгийн газруудын хөтөлбөрийн менежер, техникийн экспертүүдэд, түүнчлэн донор болон бодлого боловсруулагчд гээд хэн бүхэнд амин чухал шаардлагатай гарын авлага билээ.

"Хэрэглэхэд хялбар, гамшгийн хариу арга хэмжээний өргөн сонголт бүхий, илүү олон тооны жишээ судалгаа бүхий энэхүү гарын авлагын хоёрдахь хэвлэлт нь анхны хэвлэлтийнхээ тогтоосон өндөр стандартыг давахуйц хэмжээнд боловсруулагджээ"

Нийл Марсланд (Ром хот дахь Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Гамшгийн үеийн үйл ажиллагаа, сэргээн босголт хариуцсан Ахлах техникийн ажилтан)

"Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар болон стандартууд (LEGS) нь хүмүүнлэгийн ажилтнуудад зориулсан аргачлалуудын чухал хэсэг юм"

Жеймс Сойер (Дэлхийн мал, амьтан хамгаалах байгууллагын Гамшгийн удирдлага хариуцсан захирал)

"Мал аж ахуй нь амьжиргааны гол эх үүсвэр болсон газар нутгуудад ажиллаж буй хөгжлийн болон хүмүүнлэгийн ажилтнуудад миний бие Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар болон стандартууд (LEGS) ашигла хэмээн санал болгож байна"

Жоани О»Фланаган (Ирландын Тройкайр байгууллагын Хүмүүнлэгийн хөтөлбөрийн захирал)

The Sphere Project

Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар болон стандартууд (LEGS) болон Сфере төслийн Хүмүүнлэгийн арга хэмжээний наад захын стандартууд нь харилцан хамаарал бүхий цогц стандартууд юм.

LEGS
Livestock Emergency Guidelines & Standards

9 789992 925409

LEGS Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар болон стандартууд Хоёрдахь хэвлэл

LEGS

Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар болон стандартууд

Хоёрдахь хэвлэл

LEGS
Livestock Emergency Guidelines & Standards

Онцгой байдлын үед Мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах Заавар болон Стандартууд (LEGS)
Хоёрдахь хэвлэл

Монгол хэлнээ хөрвүүлсэн баг: Орчуулгын багийг П.Болортуяа ахлан, энэхүү гарын авлагын 1,6,7 дугаар бүлгийг П.Болортуяа (Мал эмнэлгийн ухааны магистр), 2,3 дугаар бүлгийг Д.Мөнхтуяа, 4 дүгээр бүлгийг Ө.Эрдэнэбилэг (Мал эмнэлгийн ухааны доктор), 5 дугаар бүлгийг Ц.Пүрэвхүү (Мал эмнэлгийн ухааны доктор), 8,9 дүгээр бүлэг, хавсралтуудыг Д.Ганхуяг нар орчуулав.

Орчуулгыг шүүн тунгаасан: П.Доржсүрэн (Монгол улсын Малын гавъяат эмч), Ө.Эрдэнэбилэг (Мал эмнэлгийн ухааны доктор), Б.Энхтуяа (Мал эмнэлгийн ухааны магистр).

LEGS гарын авлагын бүтэц

Онцгой байдлын үед
Мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах Заавар болон Стандартууд (LEGS)

Хоёрдахь хэвлэл

LEGS

PRACTICAL ACTION Publishing

Практикал Акшион Паблишн ХХК
Шумачер Төв
Боуртонон төв
Dunsmore,Rugby,
Warwickshire CV23 9QZ, UK
www.practicalactionpublishing.org

© Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар болон стандартууд төсөл 2014

Эхний хэвлэл 2009
Хоёрдахь хэвлэл 2014

Хатуу хавтастай хэвлэл ISBN 978-1-85339-860-5
Нимгэн хавтастай хэвлэл ISBN 978-1-85339-861-2
Номын санд зориулсан электрон хэвлэл ISBN 978-1-78044-860-2
Электрон хэвлэл ISBN 978-1-78044-861-9

Зохиогчийн эрх хамгаалагдсан. Зохиогчийн зөвшөөрөлгүйгээр энэхүү ном, аль нэг хэсгийг электрон, цаасан хэлбэрээр болон өнгөтөөр хувилах, дахин хэвлэх, бичлэг хийх, мэдээлэл хадгалах, хувиргах системд хадгалахыг хориглоно.

Энэ номын каталогийн бичлэг Их Британы Номын санд хадгалагдаж байгаа.

1988 оны Зохиогчийн загвар, эрхийг хамгаалах Актын дагуу энэхүү номыг зохиогчийн эрхийг баталгаажуулсан болно.

LEGS (2014) Онцгой байдлын үед Мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах Заавар болон Стандартууд, Хоёрдахь хэвлэл
Ригби, Их Британи: Практикал Акшион Паблишн
http://dx.doi.org/10.3362/9781780448602

1974 оноос хойш Практикал Акшион Паблишн нь дэлхий даяар олон улсын хөгжлийн хөтөлбөрийг дэмжиж олон тооны ном, мэдээллийг хэвлэн тараасан болно. Практикал Акшион Паблишний худалдааны нэр нь Практикал Акшион Паблишн ХХК (Компаний регистрийн дугаар 1159018) юм. Практикал Акшион Паблишн нь зөвхөн өөрийн буяны байгууллагын зорилгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг бөгөөд ямар нэгэн ашиг олсон тохиолдолд Практикал Акшион буцааж өгнө. (Буяны байгууллагын регистрийн дугаар 247257, ВАТ Групп, Регистрийн дугаар 880992476).
Номын хавтас, текстийг Мессагио Студи,
Индексийг ЛизПафсет, Наррогате
Аудио бичлэгийг Буукграфт ХХК, Строуд,
Глоусестэршайр бэлтгэж Реплика Прессд хэвлэв.

LEGS гарын авлагын хэвлэлийн албан ёсны эрхийг ээмшигчээс олгосон зөвшөөрлийн дагуу Монгол Улсын ХХААХҮЯ, НҮБ-ын ХХААБ-ын техник хамтын ажиллагааны TCP/MON/3602 төслийн санхүүжилтээр Мерси Кор Монгол байгууллагын LTS2 төслийн хүрээнд Сэлэнгэ Пресс ХХК -ний хэвлэх үйлдвэрт хэвлэв.

Гарчиг

	LEGS-н танилцуулга ба номыг хэрхэн ашиглах тухай	ix
1.	Мал амьтан, амьжиргаа ба онцгой байдал	1
2.	Мал амьтанд чиглэсэн бүх тусламжид харгалзах нийтлэг стандарт, асуудлууд	13
3.	Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох	55
4.	Мал амьтны тоо толгойг бууруулах техникийн стандарт	91
5.	Мал эмнэлгийн үйлчилгээний техникийн стандарт	129
6.	Тэжээл хангамжийн техникийн стандарт	181
7.	Усан хангамжийн техникийн стандарт	219
8.	Мал амьтны хашаа хороо ба байршуулалтын техникийн стандарт	253
9.	Малжуулах үйл ажиллагааны техникийн стандарт	287
10.	Хавсралтууд	340

Номын тухай

“LEGS-н хоёрдахь хэвлэл нь хэрэглэхэд хялбар, хариу арга хэмжээний олон хувилбар, тохиолдол болон судалгаагаар баяжуулсан, эхний хэвлэлээс илүү өндөр стандартыг хангасан. Энэ нь мал аж ахуйд тохиолдох онцгой байдлын үед хэрэгжүүлэх хөтөлбөрийн хамгийн сайн дадал, жишиг хэвээр байх болно.»

Нейл Марсланд, Шуурхай Үйл ажиллагаа, Сэргээн босголтын газрын Техникийн ахлах мэргэжилтэн, ДХХААБ, Ром

“LEGS нь өөрсдийн ажил үүргийн дагуу мал амьтантай холбоотой арга хэмжээ хэрэгжүүлж буй хүмүүнлэгийн ажилтны амин чухал арга хэрэгсэл юм. Бид LEGS-г гамшгийн үнэлгээ хийх, мал аж ахуйд онцгой байдал үүссэн үед оновчтой хариу арга хэмжээ авах талаар засгийн газрын хүмүүсийг сургахад ашигладаг. Сайн судалж хийсэн, практик шинж чанартай учраас бид эдгээр заавар, стандартыг хүлээн зөвшөөрдөг.»

Жеймс Сойер, Гамшгийн Менежметийн захирал, Дэлхийн Амьтан хамгаалах нийгэмлэг

“Энэхүү Онцгой байдлын үед Мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах Заавар, Стандартуудын шинэ хэвлэл нь 2009 онд хэвлэгдсэн гарын авлагад үндэслэсэн, хэрэглэж буй хүмүүсийн туршлагыг багтаасан нь зөвхөн мал аж ахуйн мэргэжилтнүүдээс гадна хүмүүнлэгийн үйл ажиллагааны чанарыг сайжруулахыг зорьж байгаа хүн бүрт чухал гарын авлага юм. Шинэ хэвлэл нь амьжиргааг тал бүрээс нь авч үзэж, мал аж ахуйг тал бүрээр дэмжихэд чухал ач холбогдолтой юм»

Сара Пантулиано, Хүмүүнлэгийн Бодлогын Группын захирал,ОДИ, Лондон

“Би LEGS-н хоёрдахь хэвлэл гарсанд талархаж байна. Энэ нь гамшгийн үед мал аж ахуйд чиглэсэн арга хэмжээг оновчтой болгоход орон нутгийн чадавхийг бэхжүүлэх практик ач холбогдолтой. Мал аж ахуй эрхлэгчдийн чадавхийг тогтвортой байлгахын тулд бэлэн байдлыг хангах нь чухал бөгөөд LEGS стандартыг хэрэглэснээр бусад авран хамгаалах салбарт онцгой байдлын хариу арга хэмжээний зардлыг бууруулж болно. Би “мал амьтан нь амьжиргааны гол эх үүсвэр болсон газар хөгжлийн болон хүмүүнлэгийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд LEGS-г ашиглах”-ыг зөвлөж байна.»

Жоанне Офланнаган, Хүмүүнлэгийн Хөтөлбөрийн Зохицуулагч, Тросайри, Ирланд

LEGS-н танилцуулга ба номыг хэрхэн ашиглах тухай

LEGS гэж юу вэ?

Онцгой нөхцөл байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар, стандартууд (LEGS) нь хүмүүнлэгийн хямралд өртсөн хүмүүст туслах зорилгоор мал сүрэгт чиглэгдсэн арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэхэд баримтлах олон улсын заавар болон стандартын иж бүрдэл юм. LEGS нь амьжиргааг дэмжих гурван зорилтыг авч үздэг. Үүнд: нэн яаралтай тусламж үзүүлэх, амьжиргааны эх үүсвэр болсон мал сүргийг хамгаалах, гамшигт өртсөн хүмүүст тэдний амьжиргааны эх үүсвэр болгон малжуулах. LEGS нь үндсэн хоёр стратегийг хэрэгжүүлснээр хүний амь нас, амьжиргааг хамгаалахад дэмжлэг болно. Үүнд:

- LEGS нь онцгой байдлын үед мал сүрэгт чиглэгдсэн хамгийн тохиромжтой арга хэмжээг тодорхойлоход туслах.
- LEGS нь сайн туршлагад суурилсан арга хэмжээний стандарт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гарын авлагаар хангах.

LEGS-н гарал үүсэл ба хоёрдахь хэвлэл

LEGS нь "мал аж ахуй нь хүмүүсийн хувьд ач холбогдолтой амьжиргааны эх үүсвэр" гэдгийг дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөх болсонтой холбоотой. Тэдний ихэнх нь ядуу, эмзэг бүлгийн хүмүүс учраас байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшгийн үед мал аж ахуйг дэмжин ажиллах нь хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөрийн чухал бүрэлдэхүүн хэсэг байдаг.

LEGS-н эхний хэвлэл нь гамшгийн үед мал сүрэгт чиглэсэн арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд хандивлагчид, хөтөлбөрийн менежер, техникийн шинжээчид, бусад хүмүүст гарын авлага шаардлагатай болсон учраас 2009 онд хэвлэгдсэн. Мал амьтнаас амьжиргаа нь бүрэн хамааралтай малчид, мал бүхий иргэдэд байгаль цаг уурт нийцүүлэн төлөвлөлт хийх шаардлага үүссэн байна. Эхний хэвлэлд төрөл бүрийн байгууллагын оролцоо, дүгнэлт, нотолгоонд суурилсан сайн дадлыг хэрэглэж буй орон нутгийн туршлага зэргийг багтаасан. Хоёр дахь хэвлэл нь 2009 оноос хойш олж авсан шинэ туршлага, нотолгоо, гарын авлагыг хэрэглэгчидтэй хийсэн хэлэлцүүлгийн дүн, тэднээс гарсан саналаар баяжигдсан болно. LEGS гарын авлагыг ашиглахад хялбар болгон шинэчлэн хэвлэсэн.

LEGS-г хэн хэрэглэх вэ ?

LEGS нь онцгой байдлын үед мал сүрэгт чиглэсэн үйл ажиллагаанд оролцдог бүх хүмүүст зориулагдсан. Үүнд:

- LEGS нь мал амьтан нь амьжиргааны чухал хэрэгсэл болсон газар нутагт яаралтай тусламж үзүүлж байгаа хүмүүст зориулсан. Мөн хүмүүнлэгийн байгууллага, хоёр ба олон талт байгууллагууд болон Засгийн газрын ажилтнууд хэрэглэж болно.
- LEGS нь гамшигт нэрвэгдсэн үед яаралтай арга хэмжээ хэрэгжүүлэх, санхүүжүүлэгч, хандивлагчид, засгийн газрын байгууллагын шийдвэр гаргагч нарт мөн хамааралтай.
- LEGS-н гурав дахь хэрэглэгч нь боловсролын болон олон нийтийн байгууллагууд юм.

LEGS-н хамрах хүрээ ба чиг хандлага

LEGS-г онцгой нөхцөл, амьжиргаа, мал сүрэгт тусламж үзүүлэх хэрэгцээ зэрэгцэн үүссэн, онцгой байдлын үед мал сүргийг хамгаалах шаардлага тулгарсан, гамшгийн дараа мал аж ахуйг сэргээн босгоход дэмжлэг үзүүлэхэд зориулсан болно. LEGS нь бүх төрлийн мал амьтдад зориулсан (шувуу мэтийн жижиг амьтад, тээврийн болон ачлагын зориулалтын мал, тэмээ, үхэр мэтийн бусад том мал). Байгаль орчин, газар нутгийн хувьд өөр өөр ямар ч нөхцөлд мал сүрэг нь чухал учраас LEGS нь тухайн орон нутгийн иргэд (фермер, малчид), хот суурин газар, захын хороололд мал маллаж буй иргэдийг хамруулсан. Мөн LEGS нь нүүлгэн шилжүүлсэн болон хуаранд[1] амьдарч буй малтай иргэдийг зөвлөмжөөр хангана.

LEGS нь Sphere стандартад заасны дагуу «хүн наад захын *хоол, хүнс, амьдрах нөхцөлөөр* хангагдсан байх ёстой» гэсэн зарчмыг тусган боловсруулсан. Энэхүү хүний эрхэнд тулгуурласан чиг хандлагыг авч үзэн амьжиргааны зорилтуудыг тодорхойлсон. LEGS нь зөвхөн гамшгийн үед яаралтай хариу арга хэмжээ хэрэгжүүлэхээс гадна гамшгийн дараа сэргээн босголтын үе шат, урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээг багтаасан болно (*Хайрцаг 1.1*) Гамшгийн бэлэн байдал нь онцгой байдал үүссэн үед хариу арга хэмжээний хамгийн чухал хэсэг бөгөөд энэ нь цаашид хүний амь, амьдралыг аврахын тулд амьжиргааны эх үүсвэрийг хамгаалахад чухал үүрэгтэй.

Хайрцаг 1.1 **Гамшгийн үед амьжиргааг дэмжихэд тулгарах асуудлууд**

Гамшгийн үеийн хариу арга хэмжээнд амьжиргааг дэмжихдээ бэлэн байдлыг хангах болон гамшгийн дараах сэргээн босголтын үед хэрэгжүүлж байгаа тусламж болон хөгжлийн хөтөлбөрийн хоорондын хамтын ажиллагааг бий болгох хэрэгтэй. Зарим хандивлагчид болон ТББ-ууд нь энэхүү шинэ чиг хандлагыг ашиглан хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлдэг. Тухайлбал: нүүдэлчдэд зориулсан олон талт нийгмийн хамгааллын тогтолцоо, фермер, мал аж ахуй эрхлэгчдийг цаг агаарын аюултай үзэгдлээс хамгаалсан даатгалын систем гэх мэт. Тусламжийн болон хөгжлийн хөтөлбөрийг уялдуулснаар хөгжлийн мэргэжилтнүүд тухайн хамтрагчаа гамшгийн үед илүү уян хатан даван туулах чадвартай болоход дэмжлэг үзүүлнэ.

LEGS нь хүмүүнлэгийн арга хэмжээний үр дүнг сайжруулахад голлон анхаарсан. Гамшгийн үед мал аж ахуй эрхлэгчдийн эмзэг байдал нь нийгэм эдийн засаг, улс төр, байгаль орчин, хүн ам зүйн хүчин зүйлүүдээр тодорхойлогддог учраас хүмүүнлэгийн ажил нь эдгээрийг анхаарлын гадна хаяж болохгүй. Мөн хөгжлийн болон эмзэг байдлыг өөрчлөх урт хугацааны бодлоготой уялдуулах хэрэгтэй. Хүмүүнлэгийн ажил нь цаашид мал аж ахуй эрхлэгчдэд болон гамшгийн эрсдлийг нэмэгдүүлж болзошгүй уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэж болох нөлөөллийг харгалзан үзэх шаардлагатай.

Гэхдээ дээрх асуудлууд нь маргаан дагуулдаг хэдий ч LEGS –н амьжиргаанд суурилсан чиглэл нь тусламжийн болон хөгжлийн хөтөлбөрүүдийг уялдуулан хэрэгжүүлэхэд дэмжлэг болно. LEGS-н вэб хуудсанд "LEGS ба уян хатан байдал" асуудал дэвшүүлсэн өгүүлэлийг харна уу: <http://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2012/01/LEGS-and-Resilience-Discussion-Paper-final2.pdf>.

Гамшгийн үед мал аж ахуйд хэрэгжүүлсэн төслийн үр дүн, нөлөөллийн үнэлгээ төдийлөн хийгддэггүй (хүмүүнлэгийн төслүүдийн хувьд энэ нь бодитой зүйл юм) ч LEGS-н стандарт, гарын авлагыг боловсруулахдаа

нотолгоонд суурилсан болно. LEGS-н анхны хэвлэл гарснаас хойш хариу арга хэмжээний шинэ төрөл бий болсон. Тухайлбал гамшгийн үед бэлэн мөнгө, эрхийн бичиг тараах нь амьжиргааг дэмжих үйл ажиллагаанд чухал болох нь нотлогдсон (www.cashlearning.org/ харна уу). Иймээс мал аж ахуйг дэмжих бэлэн мөнгө, эрхийн бичгээр хангах хөтөлбөрийн талаар *3 дугаар бүлэг* (*Анхдагч үнэлгээ, ба хариу арга хэмжээг тодорхойлох*), зарим техникийн бүлгийн (*4-9*) холбогдох хэсэгт тусгагдсан.

Түүнчлэн бусад төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд эмзэг бүлгийн өрхүүдэд нөлөөлөх байдал, ямар төрлийн арга илүү тохирох, хэрэглэхэд шаардлагатай мэдээлэл цуглуулах талаар тусгасан. LEGS-н энэхүү хэвлэлд үнэлгээний шатандаа яваа, нотолгоо хангалтгүй байгаа арга хэмжээний талаар тусгаагүй болно.

Бусад холбогдох стандарт, заавруу д

LEGS нь сайн дадлын талаарх стандарт, гарын авлага бөгөөд шийдвэр гаргагчдад туслах зорилготой. Гамшгийн үед хэрэгжүүлэх мал аж ахуйтай холбоотой арга хэмжээг нарийвчлан зааварчлахыг зориогүй. Энэ төрлийн зааварчилгаа нь бүлэг тус бүрийн төгсгөлд ашигласан хэвлэлийн жагсаалтад тусгагдсан. Тухайлбал НҮБ-ын Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллагаас (ХХААБ) гаргасан Гамшгийн үеийн мал сүрэгт чиглэсэн арга хэмжээний гарын авлагыг LEGS-н нэмэлт хэсэг болгон ашигласан (FAO, 2015).

LEGS ба Sphere

LEGS-г боловсруулахдаа *Sphere гарын авлагын-Хүмүүнлэгийн хариу арга хэмжээний хэсэг дэх Хүмүүнлэгийн тунхаг, наад захын стандарт*ыг тусгасан (Sphere төсөл, 2011). LEGS-н агуулга, зохион байгуулалтыг амьжиргааны эх үүсвэр болох мал сүргийг хамгаалах, сэргээх болон бусад хүмүүнлэгийн хариу арга хэмжээг хооронд нь уялдуулахын тулд Sphere гарын авлагын нэмэлт болгон загварчилсан. Иймээс LEGS нь Sphere гарын авлагын дагалдах хэсэг юм. Мөн дараах бусад стандартууд хамаарна. Үүнд:

- *Боловсролын наад захын стандартууд: Бэлэн байдал, Хариу арга хэмжээ, Сэргээн босголт* (INEE, 2010)
- *Эдийн засгийг сэргээх наад захын стандартууд* (SEEP, 2010)

- *Хүмүүнлэгийн үйл ажиллагаанд хүүхдийг хамгаалах наад захын стандартууд* (CPWG, 2012).

Үндэсний заавар зөвлөмжүүд

Зарим улс орнуудад гамшгийн үед мал сүрэгт чиглэсэн хариу арга хэмжээний тухай Үндэсний гарын авлагууд байдаг учраас LEGS-г түүний нэмэлт хэсэг болгон ашиглаж болно. Мөн LEGS-г Үндэсний заавар, зөвлөмж шинээр боловсруулахад ашиглаж болно.

Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх

LEGS-д хил дамжин халдварладаг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг тусгаагүй бөгөөд энэ талаар Хил дамжин халдварладаг мал амьтан, ургамлын өвчнөөс урьдчилан сэргийлэх төв (FAO-EMPRES) гэх мэт бусад олон улсын байгууллагаас гаргасан, хүлээн зөвшөөрөгдсөн гарын авлага байдаг. Мөн Дэлхийн Мал амьтны эрүүл мэндийн байгууллагын (OIE, 2013) *Хуурай газрын амьтдын кодын* 7.6 Өвчинтэй тэмцэх зорилгоор мал амьтныг устгах бүлэгт өвчинтэй тэмцэх арга хэмжээний талаар нарийвчлан заасан байдаг. Энэхүү бүлгийн төгсгөл дэх *Ашигласан хэвлэлийн* жагсаалтаас харна уу.

Гэрийн тэжээвэр амьтад

LEGS-н хүмүүнлэгийн болон амьжиргааны талаарх арга хэмжээнд гэрийн тэжээвэр амьтдын талаар тодорхой дурдаагүй, учир нь энэ төрлийн амьтад нь өөрсдийн эздэд л нийгмийн ашиг тусаа өгдөг. LEGS-н стандарт, гарын авлагад энэ талаар тусгагдаагүй байдаг бөгөөд энэ талаарх нарийвчилсан зааврыг АНУ-ын Хөдөө аж ахуйн Яамны Мал амьтны тавлаг байдлыг хангах төвөөс (AWIC) авах боломжтой. Энэхүү бүлгийн төгсгөл дэх *Ашигласан хэвлэлийн* жагсаалтаас харна уу.

Мал амьтны тавлаг байдал

LEGS нь хүмүүнлэгийн хууль, зарчимд тулгуурласан учир хамгийн түрүүнд хүний нийгмийн хамгааллыг авч үздэг. Мөн LEGS нь мал амьтны тавлаг байдлын зорилтод үндэслэгдээгүй хэдий ч арга хэмжээнүүд нь малын тавлаг байдлыг хангахад чиглэгдсэн байдаг учраас энэ талаар үнэлгээ

хийхдээ "*таван эрх чөлөө*" нийтлэг зарчмыг ашигладаг. Үүнд:

1. *Өлсөх, цангахаас ангид байлгах*- эрүүл мэнд, биеийн хөгжлийг хэвийн хадгалахад шаардлагатай ус, тэжээлээр хангагдах
2. *Тохь, тухгүй байдлаас ангид байлгах*- хашаа, хороо, амрахад тохиромжтой газар бүхий орчин нөхцөлөөр хангагдах
3. *Гэмтэл, өвчнөөс ангид байлгах*- өвчнөөс урьдчилан сэргийлэх эсвэл шуурхай оношлох, эмчлэх
4. *Төрөлхийн араншингаа хэвийн байдлаар илэрхийлэх эрх чөлөө*- тухайн мал амьтанд тохирсон орон зай, тоног төхөөрөмжөөр хангах
5. *Айдас, дарамтаас ангид байлгах*- айдас, дарамтгүй байх нөхцөл, эмчилгээгээр хангах

LEGS-н арга хэмжээ нь мал амьтны тавлаг байдал, "таван эрх чөлөө" зарчимтай хэрхэн уялдах талаар бүлэг тус бүрт тусгасан. Мал амьтныг хүнлэг аргаар нядлах гэх мэт мал амьтны тавлаг байдалтай холбоотой бусад зааврыг ДМАЭМБ-ын *Хуурай газрын мал амьтны эрүүл мэндийн кодоос* ашиглах боломжтой (OIE). Энэхүү бүлгийн төгсгөл дэх *Ашигласан хэвлэлийн* жагсаалт харна уу.

LEGS-г хэрхэн ашиглах вэ? Номын тойм

LEGS нь гамшгийн арга хэмжээг оновчтой төлөвлөх, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх үндсэн зорилготой. Гэсэн хэдий ч төслийн хэрэгжүүлэх хугацаа, эсвэл төсөл дууссаны дараа гамшгийн хариу арга хэмжээг нягтлах, үнэлэхэд жишиг болгон ашиглаж болно. LEGS гарын авлага нь хоёр үндсэн хэсэгтэй. Үүнд:

Хамарсан сэдэв	Бүлэг
1. Ерөнхий зарчим , шийдвэр гаргалт ба төлөвлөлт	
Мал амьтан, амьжиргаа ба онцгой байдал LEGS-н зорилтын тойм	Бүлэг 1
LEGS нийтлэг стандартууд	Бүлэг 2
Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох	Бүлэг 3
2. Өвөрмөц арга хэмжээ	
Мал амьтны тоо толгойг бууруулах	Бүлэг 4
Мал эмнэлгийн үйлчилгээ	Бүлэг 5
Тэжээл хангамж	Бүлэг 6
Усан хангамж	Бүлэг 7
Мал амьтны хашаа хороо ба байршуулалт	Бүлэг 8
Малжуулах	Бүлэг 9

Ерөнхий зарчим, шийдвэр гаргах ба төлөвлөлт (1–3 бүлэг)

Бүлэг 1: Мал амьтан, амьжиргаа ба онцгой байдал – гол асуудлын тойм

Энэхүү бүлэгт дараах асуултуудын ерөнхий зааврыг үзүүлсэн. Үүнд:

- Мал аж ахуйн төсөл яагаад хүмүүнлэгийн хариу арга хэмжээнд чухал вэ?
- LEGS нь хүний эрхэнд тулгуурласан хандлагатай яаж холбогдсон бэ?
- LEGS-н амьжиргааг дэмжих зорилтууд юу вэ?
- Гамшгийн төрлүүд мал аж ахуй эрхэлж байгаа хүмүүст яаж нөлөөлөх вэ?

Бүлэг 2: LEGS-н нийтлэг стандартууд

Энэхүү бүлэгт гамшгийн үед мал сүрэгт чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх нийтлэг стандартуудыг нарийвчлан тусгаснаас гадна үндсэн зарчим, ажиллах арга барилын талаар тайлбарлах болно.

Бүлэг 3: Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох

Энэхүү бүлэгт гамшгийн үеийн мал аж ахуйн төслийн анхдагч үнэлгээг

хэрхэн хийх, оновчтой ажиллагааны хэлбэрийг хэрхэн тодорхойлох арга замыг тусгасан. Гарын авлагыг хэрэглэж байгаа хүмүүст Шийдвэр гаргахад би ямар төрлийн мэдээллийг цуглуулах хэрэгтэй вэ?, мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийсний дараа ямар үйл ажиллагааг орон нутгийн оролцогч талуудын хамт хийх хэрэгтэй вэ? гэсэн асуултанд хариулахад тусална.

Мөн гамшгийн үе шат тус бүрт тохирох техникийн арга хэмжээг тодорхойлохын тулд LEGS-н Оролцооны Хариу арга хэмжээг тодорхойлох матрикс (PRIM)-ыг хэрхэн ашиглах талаар тайлбарласан. Нийтлэг стандартууд (*Бүлэг 2, Нийтлэг стандартууд ба мал сүрэгт хамааралтай нийтлэг асуудлууд*), LEGS-н өвөрмөц арга хэмжээний *(4-9 дүгээр бүлэг)* мэдээллүүд нь ижил загвартай.

Стандарт

Стандартууд нь гамшгийн хариу арга хэмжээний чухал хэсгүүдийг үзүүлсэн чанарын тодорхойлолт юм.

Үндсэн үйл ажиллагаа

- Стандарт тус бүрт тухайн стандартыг хангахын тулд хэрэгжүүлэх алхам эсвэл үйл ажиллагааг тусгасан.

Зааварчилгаа

1. Зааварчилгааг үндсэн үйл ажиллагаатай холбон унших шаардлагатай ба энэ нь Стандартыг хэрэглэх үед анхаарах хэрэгтэй асуудлыг тусгасан

LEGS өвөрмөц арга хэмжээнүүд (Бүлэг 4–9)

LEGS-н техникийн арга хэмжээний тухайд Мал амьтны тоо толгойг бууруулах *(Бүлэг 4)*, Мал эмнэлгийн үйлчилгээ *(Бүлэг 5)*, Тэжээлийн хангамж *(Бүлэг 6)*, Усан хангамж *(Бүлэг 7)*, Мал амьтны хашаа хороо ба байршуулалт *(Бүлэг 8)*, Малжуулах *(Бүлэг 9)* бүлгүүд хамрана. Эдгээр бүлэгт дараах өвөрмөц заавар, техникийн мэдээллийг үзүүлсэн. Үүнд:

- чухал шаардлагатай асуудлуудыг тодорхойлох
- олон төрлийн арга хэмжээний хувилбараас сонголт хийхэд шийдвэрийн модны загварыг ашиглах

- давуу ба сул талыг тодорхойлсон хүснэгт, хэрэгжүүлэх цаг хугацаа
- стандарт, үндсэн үйл ажиллагаа, зааварчилгаа (*Бүлэг 2 Нийтлэг стандартуудад заасан форматтай адил*)
- жишээ судалгаа бүхий хавсралтууд ба үнэлгээний шалгах хуудас, ашигласан хэвлэлийн жагсаалт гэх мэт нэмэлт техникийн мэдээллүүд. Эдгээр лавлах мэдээллүүдийг LEGS-н вэб хуудасны нөөц хэсгээс авч ашиглах боломжтой.

Жишээ, судалгаа

LEGS-н гарын авлагын ихэнх бүлэгт туршлага, тухайн бүлэгт хамаарах чиглэлийг үзүүлэхийн тулд жишээнүүдийг оруулав. Хоёр төрлийн судалгаа, жишээний хамт багтсан байгаа.

Үүнд:

- Үйл ажиллагааны жишээ судалгаа нь төслийг загварчлах, хэрэгжүүлэх, үйл ажиллагааг орон нутгийн нөхцөлд хэрхэн тохируулах талаар тайлбарласан.
- Нөлөөллийн жишээ судалгаа нь гамшгийн үед мал аж ахуйг дэмжихэд амьжиргаанд үзүүлэх нөлөөлөл болон бусад амьжиргааны эх үүсвэр, хүнсний тэжээллэг чанарт гарах үр дүнг дүгнэхэд түлхүү анхаарсан.

Ашигласан хэвлэл ба цаашид уншиж судлах материал

CPWG (Child Protection Working Group) (2012) *Minimum Standards for Child Protection in Humanitarian Action*, CPWG, Geneva, <http://cpwg.net/ minimum-standards>[accessed14May2014].

FAO (Food and Agriculture Organization of the United Nations) (2015) *Technical Interventions for Livestock Emergencies: The How-to-do-it Guide*, Animal ProductionandHealthManualsSeries,FAO, Rome.

FAWC (FarmAnimalWelfareCouncil)(undated)*FiveFreedoms*[webpage],-FAWC, London,<http://www.fawc.org.uk/freedoms.htm>[accessed-21May2014].

INEE(Inter-AgencyNetworkforEducationinEmergencies)(2010)*MinimumStandardsfor Education: Preparedness, Response, Recovery*, INEE, NewYork, <http://toolkit.ineesite.org/toolkit/Toolkit.php?PostID=1002> [accessed 15May2014].

LEGS (Livestock Emergency Guidelines and Standards) (2012) *LEGS and Resilience: Linking Livestock, Livelihoods and Drought Management in the*

Horn of Africa, Addis Ababa, <http://www.livestock-emergency.net/wp-content/uploads/2012/01/LEGS-and-Resilience-Discussion-Paper-final2. pdf>[accessed19May2014].NRC/CMP(NorwegianRefugeeCouncil/Camp ManagementProject)(2008)*TheCampManagementToolkit*,NRC/CMP,Oslo,

<http://www.nrc.no/camp> [accessed 24 June2014].

OIE (World Organisation for Animal Health) (2013) "Killing of Animals for Disease ControlPurposes",in*TerrestrialAnimalHealthCode*,chapter7.6,OIE,Paris,

<http://www.oie.int/index.php?id=169&L=0&htmfile=chapitre_1.7.6.htm>[accessed19May2014].

SEEP (Small Enterprise Education and Promotion) Network (2013) *Minimum Economic Recovery Standards* (MERS), SEEP Network, Washington, DC, Practical Action Publishing, Rugby. <http://www.seepnetwork.org/minimum- economic-recovery-standards-resources-174.php>[accessed-15May2014].

Sphere Project (2011) *Humanitarian Charter and Minimum Standards inHumanitarian Response* (the Sphere Handbook), The Sphere Project, Geneva, Practical ActionPublishing,Rugby.<www.sphereproject.org/>[accessed15May2014].

Цахим хуудас

AWIC(AnimalWelfareInformationCenter),UnitedStatesDepartmentofAgriculture National Agricultural Library, <http://awic.nal.usda.gov/companion-animals/ emergencies-and-disaster-planning>[accessed-22May2014].

CashLearningPartnership,Oxfam,Oxford,<www.cashlearning.org/>[accessed19 May2014].

FAO-EMPRES-AH (Food and Agriculture Organization of the United Nations EmergencyPreventionSystemforAnimalHealth),Rome,<http://www.fao.org/ ag/againfo/programmes/en/empres/home.asp>[accessed-21May2014].

Санамж

1. LEGS, дэх «хуаран» нь Хуарангийн Менежментийн Гарын авлага дахь (NRC/CMP, 2008) төрөл бүрийн хуаран эсвэл хуаран маягийн суурьшил – «дүрвэгсдэд зориулан төлөвлөсөн эсвэл өөрсдөө хуаран байгуулсан, хамтын төв, дамжин өнгөрөх, буцаах төв гэх мэт түр зуурын суурин» гэсэн ойлголт юм. Үүнд: нүүлгэн шилжүүлэлтийн төв хамаарна.
2. Илүү дэлгэрэнгүй мэдээлэл <http://www.fawc.org.uk/freedoms.htm> харна уу

БҮЛЭГ 1

Мал амьтан, амьжиргаа, ба онцгой байдал

Танилцуулга

Энэхүү бүлэгт дараах асуултуудыг авч үзэн ерөнхий зааврыг багтаасан. Үүнд:

- Мал аж ахуйн төсөл яагаад хүмүүнлэгийн хариу арга хэмжээнд чухал вэ?
- Төрөл бүрийн гамшиг мал сүрэг эрхэлж байгаа хүмүүст яаж нөлөөлөх вэ?
- LEGS нь хүний эрхэнд тулгуурласан чиг, хандлагатай яаж уялдсан бэ?
- LEGS-н амьжиргааг дэмжих зорилтууд юу вэ?

Амьжиргаа ба онцгой байдал

Хүмүүнлэгийн үйл ажиллагаанд гамшигт нэрвэгдсэн хүн амын амьжиргааны талаар авч үзэх асуудал чухлаар тавигдаж байна. Энэ нь зөвхөн хүний амь насыг аврахаар хязгаарлагдахгүй тэдний амьжиргааг хамгаалах, бэхжүүлэх асуудал юм. Энэхүү асуудал нь гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн амьжиргааг зөвхөн нөхөн сэргээхэд туслах биш урт хугацаанд даван туулах чадварыг нэмэгдүүлэх, цаашид өртөж болзошгүй гэнэтийн цочрол, гамшгийн эмзэг байдлыг бууруулахад оршино.

Амьжиргааны чиг хандлагыг харгалзан үзэх нь тусламж болон хөгжлийн санаачлагуудын ангид байдал, зөрчил бүхий уламжлалт хандлагыг өөрчилж хооронд нь уялдуулахад чухал юм. (*LEGS-н танилцуулга бүлэг, Хайрцаг 1.1* харна уу). Өнөө үед шуурхай хариу арга хэмжээ нь богино хугацаанд хүний амь аварсан байж болох ч тухайн үед орон нутгийн амьжиргааны стратегийг хамгаалж чадаагүй, устгасан байж болох талтай. Мөн одоо байгаа хөгжлийн санаачлагуудыг сулруулж, орон нутгийн үйлчилгээний хангамжид сөрөг нөлөө үзүүлдэг. Хөгжлийн чиг хандлага нь гамшгийн болон хөгжлийн хөтөлбөрийн арга хэмжээнүүд хоорондоо тусгаар, хамааралгүй байх нь ашигтай байж болох хэдий ч тусламжийн зорилгыг хариуцсан хүмүүс орон нутгийн хөгжлийн үйл ажиллагаа, түүн дотроо орон нутгийн хүмүүсийн амьжиргааг сайжруулах асуудлыг харгалзан үзэх нь ач холбогдол юм. LEGS нь энэхүү асуудал дээр үндэслэгдсэн болно.

Мал амьтан ба амьжиргаа

Мал амьтан нь дэлхий нийтэд олон хүний амьжиргаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Амьжиргааны гол тулгуур нь мал амьтан болсон малчид, мал болон газар тариалан хослон эрхлэгчид, газар тариалан голлон эрхэлдэг хэдий ч үхэр, ямаа, гахай эсвэл шувууг туслах аж ахуйн хэлбэрээр ууبراг тэжээл эсвэл орлогын нэмэлт эх үүсвэр болгон ашигладаг жижиг тариалан эрхлэгчид мэтийн мал аж ахуй эрхэлж байгаа төрөл бүрийн хүмүүс байдаг. Мөн үйлчилгээ үзүүлж буй төрлөөс хамаарч янз бүрийн мал аж ахуй эрхлэгчид байдаг. Тухайлбал, луус эсвэл илжиг тэрэг зэрэг ердийн хөсгөөр орлого олдог хүмүүс, бизнес нь мал аж ахуйгаас түлхүү хамааралтай байдаг худалдаачид, дэлгүүрийн эзэн болон бусад төрлийн наймаачид байдаг. Мал амьтан нь мөн хот суурин газрын оршин суугчдын орлого эсвэл хүнсний нэмэлт эх үүсвэр болж байдаг.

LEGS-н "мал амьтан" гэсэн ойлголтод хүний амьжиргаанд ашигладаг бүх төрлийн мал амьтдыг авч үздэг. Мөн LEGS нь нүүлгэн шилжүүлсэн, хуарандˡ амьдарч буй мал бүхий хүмүүсийг зааврaар хангана.

Тогтвортой Амьжиргааны Хамрах Хүрээ (The Sustainable Livelihoods Framework, DFID, 1999) нь гамшгийн болон хөгжлийн нөхцөл байдал аль алиныг нь ойлгох, дүн шинжилгээ хийхэд ашигтай арга хэрэгсэл юм. Хамрах хүрээ нь өөр өөр байдаг боловч, "хөрөнгө" (*Нэр томьёоны тайлбарыг* харна уу) гэдгийг янз бүрээр ойлгодог. Энэ нь айл өрхүүд амьжиргааныхаа үндсэн стратеги болгон ашиглаж байгаа зүйлс гэсэн ойлголтоос эхэлнэ. Хүмүүнлэгийн хөтөлбөрт хөрөнгө гэдэг нь маш чухал, учир нь санхүүгийн болон нийгмийн хөрөнгө их байх тусам хямралыг даван туулах чадвар илүү байдаг. Мал аж ахуй эрхлэгчдийн хувьд өөрсдийн хөрөнгийг амьжиргаандаа нэмэр болгон ашиглах асуудал нь тэдний эмзэг байдал, чиг хандлага, гадаад бодлого, засаглалаас хамаардаг учраас амьжиргааны талаар ямар нэгэн судалгаа хийхдээ эдгээрийг зайлшгүй харгалзан үзнэ.

Мал амьтан нь санхүүгийн болон нийгмийн хөрөнгө болох

Мал аж ахуй эрхлэгчдийн ихэнхэд нь мал амьтан нь чухал ач холбогдолтой санхүү, хүнс (сүү, мах, цус, өндөг) болон орлогын (зарах, бараагаар солих, тээврийн хэрэгсэл болгох, ажлын хүч болгон ашиглах, түрээслүүлэх) эх үүсвэр болдог. Мал аж ахуй эрхлэгчдийн хувьд мал

амьтан нь нийгмийн уламжлалт бүлэгт оролцсоноор (овгийн гишүүн, худ ургийн холбоо эсвэл найзууд гэх мэт) харилцаа холбоог бий болгох, бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэхээс гадна бэлэг сэлт, төлбөр тооцоо хийхэд ашиглагддаг.

Эмзэг байдал

Эмзэг байдал нь гэнэтийн цочрол, чиг хандлагыг тэсвэрлэх хүмүүсийн чадвартай холбоотой. Sphere гарын авлагад эмзэг хүмүүс гэж «физик, нийгэм, байгаль орчин, улс төрийн хүчин зүйлс хосолсоноос байгалийн эсвэл хүний хүчин зүйлсээс хамааралтай гамшиг эсвэл аливаа мөргөлдөөнд өртөж болзошгүй хүмүүсийг» гэж тодорхойлжээ (Sphere, 2011: 54). Мал амьтан нь амьжиргааны эх үүсвэр болсон айл өрхүүд, хувь хүмүүсийн эмзэг байдал нь мал амьтантай шууд холбоотой. Мал амьтан нь тэдний хувьд үндсэн хөрөнгө, үнэ цэнэтэй байх тусам тэдгээр айл өрх цочролыг даван туулах чадвар илүү байдаг. Амьжиргаанд мал амьтны гүйцэтгэх үүргийг ойлгох, онцгой байдлаас үүсэх үр нөлөөний талаар *Гуравдугаар бүлэгт Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох* тусгасан бөгөөд энэ нь мал аж ахуйд чиглэсэн хариу арга хэмжээг хэрхэн оновчтой тодорхойлоход чухал үүрэгтэй. Мал аж ахуйд чиглэгдээгүй хэдий ч хүнсний тусламж, бэлэн мөнгө тараах, эсвэл ажлын хөлсөнд бэлэн мөнгө, хүнс өгөх зэрэг нь мал аж ахуйд чиглэсэн хариу арга хэмжээнд дэмжлэг болдог. Учир нь эдгээр үйл ажиллагаа нь богино хугацаанд мал аж ахуйд учрах хохирлыг багасгахаас гадна эргэн сэргэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Чиг хандлага

Чиг хандлагад урт хугацаанд өөрчлөгддөг хүн ам зүй, уур амьсгалын өөрчлөлт, эдийн засгийн хандлага зэрэг амьжиргааны стратегид нөлөөлөх зүйлсийг авч үздэг. Хүмүүнлэгийн хариу арга хэмжээг төлөвлөхдөө чиг хандлагыг тэр болгон анхааралд байдаггүй ч энэ нь мал аж ахуйд үзүүлэх дэмжлэгийг оновчтой тодорхойлоход чухал ач холбогдолтой байдаг. Жишээ нь: мал амьтан нь амьжиргааны эх үүсвэр болдог мал аж ахуй эрхлэгчдэд олон төрлийн дэмжлэг туслалцаа үзүүлдэг хэдий ч гамшиг болсон үед мал амьтнаа алдах эрсдэл өндөр байдгийг харгалзан бэлэн мөнгө өгөх зэрэг бусад төрлийн дэмжлэг үзүүлвэл илүү үр дүнтэй байж болно.

Бодлого ба зохион байгуулалт

Ямар ч төрлийн гамшгийн үед албан болон албан бус бодлого, зохион байгуулалтыг хэрэглэх нь мал амьтныг амьжиргааны эх үүсвэр болгон ашиглах чадварыг нэмэгдүүлдэг. Жишээ нь: мал эмнэлгийн үйлчилгээ, татвар, худалдаа, экспортлох бодлогоор дэмжих нь мал амьтанд тулгуурласан иргэдийн амьжиргаанд нөлөөлдөг.

Онцгой байдлын үед мал амьтныг хамгаалах, бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь иргэдийн амьжиргааг дэмжихэд чухал гэдгийг нотлохын тулд амьжиргаанд дүн шинжилгээ хийх нь үр дүнтэй. Энэхүү чиг хандлага нь Sphere Гарын авлагад заасан «амьжиргааны стратегийг хамгаалах ба дэмжих», ялангуяа "үр ашигтай хөрөнгийг хадгалах» гэсэн шаардлагыг бүрэн хангана (Sphere, 2011:151 and 153).

Гамшгийн төрөл, мал аж ахуй эрхлэгчдэд учрах гамшгийн хор хохирол

Хүмүүнлэгийн онцгой нөхцөл байдлыг удаан явцтай, гэнэтийн болон хавсарсан гамшиг гэж ангилсныг *Хүснэгт 1.1* д үзүүлэв. Холбогдох жишээг *Хайрцаг 1.1* харуулав. Зарим төрлийн гамшиг нь маш удаан явцтай, хямралын үе шатууд давтагдаж байдаг. Жишээ нь: Зудын үед Сэрэмжлүүлэгээс Түгшүүр, Онцгой байдлын үе шат руу шилжээд хэвийн байдалд оролгүйгээр эргээд Сэрэмжлүүлэгийн шатанд шилждэг.

Хүснэгт 1.1 Гамшгийн төрлүүд түүний хор уршиг

Гамшгийн төрөл	Жишээ	Хор уршиг
Удаан явцтай гамшиг • Үргэлжилсэн онцгой байдал зарлах хүртэл олон сарын турш амьжиргаанд стресс үүсгэдэг • Олон жил үргэлжилсэн үйл явдал • Тодорхой газар нутаг эрсдэлд орсон, урьдчилсан байдлаар эрсдэлд өртөх нь тодорхой • Ган гачиг ньдервөн үндсэн үе шаттай: Сэрэмжлүүлэг, түгшүүр, онцгой байдал, нөхөн сэргээлт (*Нэр томьёоны* тайлбараас харна уу) • Эрт илрүүлэх тогтолцоо байдаг хэдий ч эрт хариу арга хэмжээ хэрэгжүүлэхэд тохиромжгүй	Ган,зуд (Монголд)	• Сэрэмжлүүлэг, түгшүүрийн үе шатанд тэжээл, усны хомсдолоос мал амьтны биемахбодын байдал, ашиг шим аажмаар мууддаг. Мал амьтны зах зээлийн үнэ буурч үр тарианы үнэ нэмэгдэж, хүний хүнсний хангамжийн аюулгүй байдал алдагдана • Онцгой байдлын үе шатанд өлсгөлөн, усны хомсдолд өртөснөөр мал олноор өлбөрч үхдэг. Хүний хүнсний хангамжийн аюулгүй байдал алдагдана • Хэрвээ үржлийн мал үхэж, хорогдсон эсвэл өөр төрлийн ган гачиг дахин тохиолдвол мал сүргийг нөхөн сэргээх асуудалд хүндрэл учирна
Гэнэтийн гамшиг • Маш богино хугацаанд эсвэл сэрэмжлүүлэх хугацаагүй гэнэт тохиолддог. Зарим газар нутаг эрсдэлтэй гэдэг нь тодорхой байдаг • Түгшүүрийн дохиог өмнөх хэдхэн минутад л өгөх боломжтой • Ихэнх хор уршиг нь гэнэт эсвэл хэдхэн цагт, хэдхэн өдөрт тохиолддог • Дараа нь гэнэтийн хор уршигаар үргэлжилдэг (*Нэр томьёоны тайлбар* харна уу) Үүнд: – эхлээд эрт үеийн нөхөн сэргээлт үе шат дараа нь нөхөн сэргээлт үндсэн үе шат, энэ нь гамшгийн төрлөөс хамаарна. Учир нь зарим нь хэдэн өдөр , – (шар усны үер гэх мэт), сар, эсвэл жилээр (газар хөдлөлт гэх мэт) үргэлжилдэг.	Үер, газар хөдлөлт, хар салхи галт уулсын дэлбэрэлт, цунами	• Хүн эсвэл мал амьтан олноор үхэж, хорогдож, энэ үйл явдал эхний үед нэмэгдэнэ • Мал амьтныг хамгаалахад чиглэсэн үйлчилгээ, дэд бүтэц байхгүй болно • Хүн ам, мал сүрэг шилжих хөдөлгөөнд орсон эсвэл мал сүргээсээ тусгаарлагдсан байна • мал амьтныг хамгаалахад чиглэгдсэн үйл ажиллгааг хэрэгжүүлэх боломжгүй болсны улмаас хор хохирол урт хугацаанд үргэлжилнэ.

Гамшгийн төрөл	Жишээ	Хор уршиг
Хавсарсан гамшиг • Удаан хугацааны улс төрийн тогтворгүй байдал, эсвэл дотоод ба гадаад зөрчил даамжирсантай холбоотой • Цаг хугацааны хувьд маш олон жил эсвэл хэдэн арван жил үргэлжилсэн • Энэ үед удаан явцтай эсвэл гэнэтийн гамшиг тохиолдож хавсарсан гамшгийн нөхцөл байдлыг улам хүндрүүлдэг	• Зүүн Сомали • Зүүн Конгын Бүгд Найрамдах улс • Суданы Дарфур муж • Афганистан	• Аливаа мөргөлдөөний улмаас хүн ба мал амьтан алагдаж эсвэл бэртэж гэмтэнэ • Цэргийн бүлгийнхэн мал амьтныг хулгайлах эсвэл хөрөнгө дээрэмдэх» • Үйлчилгээ, зах зээл хязгаарлагдмал эсвэл мөргөлдөөний улмаас үгүй болно • Дэд бүтэц, харилцаа холбоо хязгаардлагдмал • Хүн ам, мал амьтан шилжих хөдөлгөөнд орно • Мөргөлдөөний улмаас үйлчилгээ, зах зээл, малын бэлчээр эсвэл усны хангамж буурна • Хүн амын хүнсний хангамжийн аюулгүй байдал алдагдана • Хэрвээ нэмэлт гамшиг тохиолдвол дээрх нөхцөл байдал улам хүндэрнэ

Хайрцаг 1.1 Удаан явцтай, гэнэтийн болон хавсарсан гамшгийн үр нөлөөний жишээ

Удаан явцтай гамшгийн хор уршиг

1999–2000 онд Кени улсад тохиолдсон гангийн үеэр хоёр сая гаруй хонь ямаа, 900,000 үхэр, 14,000 тэмээ хорогдсон байна. Энэ ган гачигт нэрвэгдсэн малчдын нийт бог мал, үхрийн 30%, тэмээний 18%-ийг эзэлж байна. Нийгэмд олон сөрөг нөлөө үзүүлсэн. Тухайлбал гэр бүлүүд тусдаа байх, малчдын нийгмийн харилцаа холбоо тасрах, хоол хүнс түгээх төв болон суурьшлын бүс рүү нүүх зэрэг сөрөг үзэгдлүүд гарсан. Хүнсний хэрэгцээгээ хангах малгүй болсон тул олон малчид хүнсний тусламжаас хараат болсон. Ган дуусан хэдий ч зарим малчдын хувьд маш олон тооны мал хорогдож, амьжиргаагаа залгуулах боломжгүй болсон учраас дахин мал маллаагүй байна. (*Эх сурвалж: Aklilu and Wekesa, 2002*)

Гэнэтийн гамшгийн хор уршиг

2004 онд Энэтхэгийн далайд үүссэн цунами үед гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн мал сүрэгт үлэмж хэмжээний хохирол учирч маш олон тооны гэрийн тэжээвэл амьтад (шувуу, хонь, ямаа, үхэр, одос үхэр гэх мэт) хорогдсон. Жишээ нь Индонезид 78,000 гаруй бод мал, 61.000 одос үхэр, 52.000 ямаа, 16.000 хонь, 1.5 сая орчим тахиа гамшгийн үеэр үхсэн байна. Үүнээс гадна малын хашаа саравч,агуулах, боловсруулалт хийдэг тоног төхөөрөмжүүд эвдэрч, хадлан, үр тарианы үлдэгдэл, сүрэл, хашсан бэлчээрүүд сүйрч үгүй болсон. (*Эх сурвалж: FAO, 2005*)

Гэнэтийн гамшиг нь ган гачгаар үргэлжилсний улмаас үүссэн хор хохирлын жишээ

2001 онд Энэтхэгийн Гужарат мужид болсон газар хөдлөлтийн үеэр 9000 орчим үхэр, одос үхэр, ямаа хорогджээ. Газар хөдлөлт нь мал амьтан бэлчээрт гарсны дараа буюу өглөө болсон бөгөөд хэрвээ бэлчээрт гараагүй байсан үед тохиолдсон бол байшин, барилга нурсны улмаас илүү их хохирол амсах байв. Хэдий тийм боловч аврах үйл ажиллагаа нь нэн тэргүүнд хүн амд чиглэгдэх учраас мал амьтан орхигдож, тэжээл ус хайн тэнүүчилж эхлэх байсан. Зарим нэг нь гамшигт өртөж үхэх эсвэл бэртэл гэмтлээс шалтгаалан хорогдоно. Газар хөдлөлтийн хор уршиг нь хоёр жилийн ган гачгаар үргэлжилж нөхцөл байдлыг улам хүндрүүлсэн байна.

Газар хөдлөлтийн өмнө бэлчээр, тэжээлийн хомсдолтой байсан нь олон мал амьтан тэжээлийн дороитолд оржээ. Газар хөдлөлтийн үеэр олон тооны усан сан, мал эмнэлгийн барилгууд нурж сүйрсэн нь мал амьтанд үйлчилгээ үзүүлэхэд сөргөөр нөлөөлсөн байна. (*Эх сурвалж: Goe, 2001*)

Хавсарсан гамшиг

Суданы Дарфур мужид олон жил үргэлжилсэн зэвсэгт мөргөлдөөн, ган гачгийн улмаас мал аж ахуйгаас хүнс, орлогоо олдог малчид, мал, газар тариалан хослон эрхлэгчдийн 50 хувь нь өртсөн байна. Мөргөлдөөн, ган гачиг хосолсон учраас олон тооны малаа алдсан байна. Зарим тосгоны хүмүүсийн 70–100 хувь нь малаа бусдад дээрэмдүүлжээ. Мал олноор бөөгнөрч мал эмнэлгийн үйлчилгээ (аюулгүй байдал алдагдсаны үр дагавар) тасарснаар малын хорогдлын хэмжээ эрс нэмэгдсэн.

Судан-Ливийн хил орчмын малын худалдаанд хүндрэл учирснаар амьжиргаанд сөрөг үр дагавар авчирчээ. Гангийн улмаас байгалийн эх үүсвэр шавхагдаж уламжлалт нүүдлийн зам, бэлчээрийн газрыг ашиглахад зөрчил үүсжээ. Малын үнэ маш хямд байсан тул малчид үлдсэн малаа бараг үнэгүй шахам борлуулж байв. (*Эх сурвалж: ICRC, 2006; Hйlиne Berton, personal communication, 2008*)

LEGS-н зарчим ба зорилт

Мал амьтан ба хүний эрхэнд тулгуурласан чиг хандлага

LEGS-д хүний эрхэнд тулгуурласан чиг хандлагыг харгалзан (*Хайрцаг 1.2* харна уу) олон улсад авч үздэг хоёр үндсэн эрх буюу хүнс болон амьдралын наад захын стандартаар хангагдах эрхийг[2] чухалчлан үзсэн. Мал аж ахуй эрхлэгчид онцгой байдлын үед өөрсдийн мал амьтныг хамгаалах, нөхөн сэргээх туслалцаа авах эрхтэй. Учир нь мал амьтан нь тэдний хувьд хүнс үйлдвэрлэх, гэр бүлийг дэмжих, амьдрах стандартыг хангах үндсэн хөрөнгө юм. Олон улсын хүмүүнлэгийн хуулинд мөргөлдөөн, дайны[3] үед хүмүүсийн үндсэн хөрөнгө болох мал амьтныг хамгаалах нь тэднийг өөрсдөө амьд үлдэхэд чухал байдаг гэсэн заалт бий.

Хайрцаг 1.2 **Хүний эрхэнд тулгуурласан чиг хандлага**

Хөгжлийн болон гамшгийн хөтөлбөрийн нэг хэсэг нь хүний эрхийг хангах байдаг. Хүний эрхийн талаар 1948 онд Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал гарснаас хойш 1966 онд иргэний болон улс төрийн эрх (CP), эдийн засаг, нийгэм, соёлын эрх (ESC) батлагдсан. Мөн арьс өнгөөр, эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах, эрүү шүүлт тулгах, хүүхдийн эрх гэх мэт олон төрлийн хүний эрхийн гэрээнүүд байдаг.

Хүний эрхийн заалт тус бүрт «үүрэг хүлээгч» нь хүний эрхийг хамгаалах, хангах үүргийг хүлээдэг. Хоол, хүнсээр хангагдах хүний эрхийн хувьд улс орнууд тэдгээрийг хангах чиглэлээр эрчимтэй ажиллах шаардлагатай байдаг.

Хүний эрхэнд тулгуурласан хөгжлийн болон гамшгийн үйл ажиллагаанд оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгохын тулд хүний эрхтэй холбоотой төрөл бүрийн арга хэрэгсэл, тунхаг мэдэгдлүүдийг ашигладаг. Энэхүү чиг хандлагыг ашиглах нь хөгжлийн болон гамшгийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцоо, эрх мэдэл, хариуцлагыг хангах, ялгаварлан гадуурхалаас ангид байхад дэмжлэг болдог. Ялангуяа хоол хүнсээр хангагдах эрхийг хангахад онцгой чухал юм. (*Эх сурвалж: Akliluand Wekesa, 2002*)

LEGS-н амьжиргааг дэмжих зорилтууд

Дээрх эрхүүд болон мал амьтны амьжиргаанд гүйцэтгэх үүргийг үндэслэн LEGS нь амьжиргааг дэмжих гурван зорилтыг авч үзсэн. Үүнд.

Зорилт 1: тухайн үеийн мал аж ахуйн нөөц боломжийг ашиглан нэрвэгдсэн хүн амд яаралтай тусламж үзүүлэх;

Зорилт 2: гамшигт нэрвэгдсэн хүн амын үндсэн хөрөнгө болох мал сүргийг хамгаалах;

Зорилт 3: гамшигт нэрвэгдсэн хүн амын мал аж ахуйтай холбоотой хөрөнгийг нөхөн сэргээх.

1-р зорилт нь тухайн бүс нутагт байгаа мал амьтныг ашиглан хүн амд яаралтай тусламж үзүүлэх, ингэснээр хоол хүнс, орлого, тээвэр зэргээр нэн даруй ашиг тусыг хүртэх боломжтой болдог. Эдгээрийг хангах нэг арга нь мал сүргийн тоо толгойг бууруулах төсөл хэрэгжүүлэх явдал юм.

2-р зорилт нь гамшгийн үед мал аж ахуйн нөөц боломж нь чухал учраас түүнийг хөрөнгө гэдэг үүднээс хамгаалах, хадгалахад чиглэгддэг бөгөөд (тэжээл, ус, хашаа хороо, мал эмнэлгийн үйлчилгээгээр хангах) гамшгийн дараа түүний үйлдвэрлэлийг нөхөн сэргээх боломжийг бий болгоно. Онцгой байдлын үе шатанд мал амьтан нь тухайн айл өрхөд шууд ашиг тус болдог хэдий ч заримдаа ашиг тусаа өгч чаддаггүй.

3–р зорилт нь олон тооны мал үхэж хорогдсон, үндсэн мал сүргийг (Зорилт 2) хамгаалах эсвэл дэмжлэг үзүүлэх боломжгүй нөхцөлд хамааралтай. Өмнө нь 3-р зорилт нь гамшгийн дараа мал амьтныг тэжээл, ус, хашаа саравч, мал эмнэлгийн үйлчилгээгээр хангахад чиглэгдэж байсан юм. Гэвч зарим тохиолдолд мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд бэлэн

мөнгө тараах нь илүү үр дүнтэй байдаг талаар *Бүлэг 9 (Малжуулах)* харуулах болно.

LEGS-н дээрх гурван зорилт нь орон нутгийн үйлчилгээ үзүүлэгч, ханган нийлүүлэгчид, зах зээлийг бүх чиглэлээр дэмжих зорилготой. Энэ нь бүх төрлийн гамшгийн үед хэрэгжүүлж байгаа амьжиргааг дэмжих хөтөлбөрийн чухал хэсэг юм (*Хүснэгт 1.1* харна уу). LEGS нь гамшгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар орон нутагт дэмжлэг үзүүлэхээс гадна гамшгийн дараа нөхөн сэргэх, урт хугацааны хөгжилд нь хувь нэмэр оруулахыг зорьсон.

Ашигласан хэвлэл ба цаашид уншиж судлах материал

Aklilu, Y. and Wekesa, M. (2002) *Drought, Livestock and Livelihoods: Lessons from the 1999–2001 Emergency Response in the Pastoral Sector in Kenya*, Humanitarian Practice Network Paper No.40, Overseas Development Institute (ODI), London, <http://www.odihpn.org/documents/networkpaper040.pdf> [accessed 13 May 2014].

DFID (Department for International Development) (1999) "Sustainable livelihoods guidance sheets". Available from:<http://www.ennonline.net/resources/667> [accessed20May2014].

FAO (Food and Agriculture Organization of the United Nations) (2005) "Tsunami reconstruction" [web page] <http://www.fao.org/ag/tsunami/assessment/ animal.html>[accessed 19 May 2014].

Goe,M.R.(2001) *Assessment of the Scope of Earthquake Damage to the Livestock Sector in Gujarat State,India*,Consultancy Mission Report, Food and Agriculture Organization(FAO) of the United Nations,Bangkok/Rome.

ICRC (International Committee of the Red Cross), Economic Security Unit(2006)

Food-Needs Assessment: Darfur, ICRC, Nairobi.

OHCHR (Office of the High Commissioner for Human Rights) (1996–2014) "International Human Rights Law" [web page] <http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/InternationalLaw.aspx> [accessed 19 May 2014].

Sphere Project (2011) *Humanitarian Charter and Minimum Standards inHu-*

manitarian Response (the Sphere Handbook), The Sphere Project, Geneva, <www. sphereproject.org/>[accessed15May2014].

Young,H.,Taylor,A.,Way,S.-A.andLeaning,J.(2004)"Linking rights and standards: the process of developing "rights-based" minimum standards on food security, nutrition and food aid", *Disasters* 28(2): 142–159 <http://dx.doi.org/10.1111 /j.0361-3666.2004.00249.x>.

Санамж

1. *LEGS* танилцуулга хэсэгт дурдсан «хуаран» гэдэг нь дүрвэсэн малчид өөрсдөө олж суурьшсан байж болох түр зуурын суурин газрыг илэрхийлнэ.
2. Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхийн тухай Олон Улсын Гэрээний Зүйл 11(2), Дэлхийн Хүний Эрхийн тухай Тунхаглалын Зүйл 25(1). Хүний эрхийн талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг http://www. ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/ InternationalLaw.aspx холбоосоор харна уу
3. 1949 оны Женевийн Гэрээ: Олон улсын Зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсэдийг хамгаалах нэмэлт, Протокол I (Art.54)1977; Олон улсын бус Зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгсэдийг хамгаалах, Протокол II(Art.14) 1977. Олон улсын хүмүүнлэгийн хуулийн тухай илүү дэлгэрэнгүй мэдээлэлийг http://www. icrc.org/eng/war-and-law/ холбоосоор харна уу.

БҮЛЭГ 2

Мал амьтанд чиглэсэн бүх тусламжид харгалзах нийтлэг стандарт, асуудлууд

Бүдүүвч 2.1 LEGS нийтлэг стандартууд

Танилцуулга

Нийтлэг стандартуудын ач холбогдол

Энэхүү бүлэгт дараагийн бүлгүүдэд нарийвчлан тусгах онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаатай холбоотой нийтлэг найман стандартуудыг тусгав. Үүнд:

1. Оролцоо
2. Бэлэн байдал
3. Чадвар
4. Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох
5. Техникийн дүн шинжилгээ болон тусламж
6. Хяналт, үнэлгээ болон амьжиргаанд үзүүлэх нөлөө
7. Бодлого болон нөлөөлөл
8. Уялдаа холбоо

Бүдүүвч 2.1-т гамшгийн үед мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаанд эдгээр нийтлэг стандартууд хэрхэн холбогддогийг харуулсан байна. Оролцоо болон уялдаа холбоог бүхий л үйл ажиллагааны туршид зайлшгүй хэрэглэх ба бусад зургаан нийтлэг стандартыг үйл ажиллагааны өмнөх бэлтгэл эсвэл тодорхой үе шатанд л баримтална (тодорхой нэг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ашиглагдах *LEGS-н хариу арга хэмжээний үе шатуудын* хураангуйг *Хавсралт Е*-с харна уу). Эдгээр нийтлэг стандартуудыг авч хэрэгжүүлснээр байгууллагын хувьд дараагийн бүлгүүдэд танилцуулагдах текникийн үйл ажиллагааны стандартуудыг хэрэгжүүлэхэд дөхөм болно.

LEGS-н нийтлэг стандартууд нь Sphere гарын авлагад (Sphere, 2011) үндэслэгдэн гарсан боловч мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаанд илүү төвлөрснөөрөө онцлогтой. Хэрэв уншигч та хүмүүнлэгийн үйл ажиллагааны нийтлэг стандартууд, хариуцлагатай түншлэлийн стандарт болон Хүмүүнлэгийн үйл ажиллагааны хариуцлагатай байдлын харьцуулсан үзүүлэлт зэрэг мэдээллийг Sphere гарын авлагаас харна уу (HAP, 2007).

Энэхүү бүлэгт аливаа хариу арга хэмжээний үед анхаарах LEGS-н бусад салбаруудтай холбоотой нийтлэг дөрвөн асуудлыг багтаасан.

Бусад бүлгүүдтэй холбогдох нь

LEGS гарын авлагад тусгагдсан техникийн бүх үйл ажиллагааг нийтлэг стандартуудаас эхлэн танилцуулж байна. Иймд мал амьтанд чиглэгдсэн өвөрмөц үйл ажиллагааг хэрэгжүүлэх техникийн стандартуудыг уншиж эхлэхээс өмнө энэхүү бүлэгтэй танилцах нь чухал юм.

Нийтлэг асуудлууд

LEGS-н нийтлэг асуудлууд нь Sphere (2011) гарын авлагад өгүүлсэнтэй ижил төстэй. Эхний гурав нь эмзэг байдалтай (хүйс ба нийгмийн тэгш байдал, ХДХВ/ДОХ болон хамгаалалт) холбоотой бол дараагийнх нь байгаль орчин болон уур амьсгалын асуудлыг авч үздэг. Sphere гарын авлагад дурдсанаар: "залуу, өндөр настан, эмэгтэйчүүд эсвэл хөгжлийн бэрхшээлтэй байх гэх мэт тухайн хүнийг аюулд өртөмхий болгож, эрсдлийг нэмэгдүүлж болох хүчин зүйлсийг ойлгож мэдэх нь маш чухал» (Sphere, 2011:86).

Ашиг хүртэгч нийгмийн бүлэг бүр онцгой байдлын үед хариу үзүүлэх өөрсдийн гэсэн чадавхитай байдаг. Эдгээрт мал аж ахуйн үйлдвэрлэл, байгалийн нөөцийн менежменттэй холбогдох уламжлалт мэдлэг, чадварууд орно. Онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах, нийгмийн бүлгүүдийг хамруулах болон үйл ажиллагаа зохион байгуулахад нутгийн иргэд болон орон нутгийн байгууллагууд чухал үүрэгтэй. Мал аж ахуйн төслийн ерөнхий үйл ажиллагаа, хэтийн төлөв болон өвөрмөц арга хэмжээний талаар зааварчилгааг багтаасан болно.

Хүйсийн болон нийгмийн тэгш байдал

Ялгаатай үр нөлөө. Онцгой нөхцөл байдал хүмүүст янз бүрээр нөлөөлдөг. Хүний эрхэнд тулгуурласан Sphere болон LEGS нь онцгой байдлын хариу арга хэмжээний үед эрх тэгш байдлыг хангахыг уриалж, нийгмийн ямар нэг ялгаварлал гаргахгүй байхыг зорьдог. Энэ нь хүүхдүүд, өнчин хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд эсвэл шашин шүтлэг, яс үндэс, нийгмийн гарал угсаараа ялгаварлан гадуурхагддаг эмзэг бүлгүүдэд илүү анхаарал хандуулах асуудал юм. Тэр тусмаа хүйсийн асуудал маш чухалд тооцогддог, тухайлбал ямар нэг гамшгийн үед эрэгтэй болон эмэгтэй хүмүүсийн нөөц бололцоо, дасан зохицох чадавхи нь өөр

өөр байдаг тул хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч байгууллагууд үүнийг анхааралдаа авах шаардлагатай. Зарим тохиолдолд эмэгтэйчүүдийн дасан зохицох байдал нь тэдний эмзэг байдлыг нэмэгдүүлдэг талтай (жишээ нь бэлгийн дарамт шахалтад орох гэх мэт).

Эрх, үүрэг ба хариуцлагаа ойлгох. Амьжиргааны үндсэн хөрөнгийн хувьд мал амьтны эзэмшил, маллагаа, түүнд тавих хяналтын асуудал мал амьтанд чиглэгдсэн онцгой байдлын үйл ажиллагааны үед нэн тэргүүнд тавигддаг. Мал аж ахуй эрхлэгч нийгмийн бүлгүүдийн дунд мал амьтанд анхаарал хяналт тавих гэдэг нь зүгээр нэг "эзэмших" гэдэг ойлголтоос илүүтэйгээр үүрэг, хариуцлага гэж тооцогддог. Тиймээс онцгой байдлын үеийн хариу арга хэмжээ нь мал аж ахуйд эмэгтэйчүүдийн үүрэг, эрх болон хариуцлагын тухай ойлголт дээр тулгуурлах нь зүйтэй. Үүнд тэдний өдөр тутмын, байнгын оролцоо болон үүрэг хариуцлага, мал амьтантай хамааралтай өмч эзэмших, түүнд хяналт тавих (ашиглах болон зарцуулах эрх) хамаарна. Дараагийн анхаарах чухал асуудал бол мал амьтны төрөл, насны ялгааг харгалзан үзэх нь чухал юм. Тухайлбал эмэгтэйчүүд өсвөр төл малаа хариуцдаг байж болох юм. Зарим нүүдэлчдийн хувьд эмэгтэйчүүд нь хоол хүнс бэлтгэх ажлынхаа хүрээнд малын гаралтай бүтээгдэхүүн (сүү, цөцгий, арьс шир гэх мэт) бэлтгэх ажлыг хариуцдаг бол, эрэгтэйчүүд захиран зарцуулах (зарах, солих эсвэл бэлэглэх) үүргийг гүйцэтгэдэг. Онцгой нөхцөл байдлын үеэр ихэвчлэн эмэгтэйчүүд, охидын ажлын ачаалал нэмэгдсэнээр нь тэдний сурч боловсрох зэрэг үндсэн эрх хязгаарлагдаж, өмчлөх эзэмших эрх багасдаг.

Дүн шинжилгээнд мэдээлэл цуглуулах. Номын гуравдугаар бүлэгт *(Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох)*, гамшгийн хамрах хүрээ, хор уршгийн талаар мэдээллийг цуглуулж, анхдагч үнэлгээ хийхдээ хүйсийн болон бусад эмзэг байдалтай холбоотой асуудлыг онцгой анхаарах хэрэгтэй. Тухайлбал ямар нэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүйсийн оролцоо ялангуяа эмэгтэйчүүдийн ажлын ачаалал, мал амьтны маллагаа, үүрэг хариуцлагад сөрөг үр дагавар гарч болох эсэхийг сайтар тооцох хэрэгтэй. Онцгой нөхцөл байдлын үед хүйсийн үүрэг оролцоо өөрчлөгдөх ч тохиолдол бий. Жишээлбэл: эрэгтэй нь өөр газар руу ажил хайхаар явсан бол мал амьтанд хяналт тавих эмэгтэйчүүдийн хариуцлага нэмэгдэнэ. Эсрэгээрээ, эмэгтэй нь гэрээсээ явсан тохиолдолд эрэгтэй нь малтайгаа үлддэг. Эцэст нь тэмдэглэхэд хүйсийн тэгш байдал нь тусламжийн байгууллагад ажиллагсдад ч хамааралтай бөгөөд эмэгтэйчүүдийн оролцоог харгалзах нь чухал юм. Энэ асуудлыг үнэлэх арга зүйг *Хавсралт 3.2-д* харуулав.

(Энэхүү бүлгийн төгсгөл дэх *Ашигласан хэвлэлийн жагсаалтын* IASC, 2006-аас дэлгэрэнгүй мэдээллийг харна уу).

Эмзэг байдал болон эрх тэгш байдлын тухай ойлголт. Онцгой байдлын үед нийгмийн давхарга ялангуяа эмзэг бүлэгт учрах хор хохирол нь өөр байдгийг анхааран үзэх хэрэгтэй. Тухайлбал, нөөц боломжоо ашиглах, мал маллах , хяналт тавих байдал нь хэрхэн өөрчлөгдсөн, тэдэнд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ажлын ачаалал болон үүрэг хариуцлагад нь ямар нэг өөрчлөлт орж болох эсэхийг тооцож үзэх нь зүйтэй. Бүлгүүдийг нас, үндэс угсаа эсвэл нийгмийн гарлаар нь ангилж болно. Онцгой байдлын үеийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд эмзэг байдлыг нэмэгдүүлж байдаг хүйсийн болон нийгмийн бусад харилцааны асуудлуудыг ойлгож мэдэх нь чухал ач холбогдолтой.

ХДХВ/ДОХ

ХДХВ/ДОХ нь дэлхий нийтэд тулгамдсан эрүүл мэндийн асуудал хэвээр байсаар байна. Африкийн Сахарын цөл дэх бүс нутаг хамгийн ихээр өртсөн бөгөөд халдвартай хүмүүсийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь илүү давамгайлж байна. Энэхүү өвчин нь цар тахал болсноор мал аж ахуй эрхлэгчид мал маллаж үндсэн хэрэгцээгээ хангах чадварт сөргөөр нөлөөлж байна.

Хүн амын дундах ХДХВ/ДОХ-н халдвар нь малын өвчин, ган, үер, мөргөлдөөн, дэд бүтцийн сул хөгжил, санхүүгийн хүндрэл, зах зээлд нэвтрэх боломжийг улам хүндрүүлж байна.

Иймээс дараах асуудлуудыг авч үзэх шаардлагатай. Үүнд:

- *Мал амьтан ба ажиллах хүч.* ХДХВ/ДОХ-н халдвартай хүмүүс мал маллахад бие махбодын хувьд сул дорой байдаг бөгөөд энэ нь малын гаралтай бүтээгдэхүүний гарц муудах, хоол тэжээлийн хомсдолд орох, орлого буурах гэх мэтчилэн сөрөг үр дагавар авчирдаг. Хүүхэд, өнчин хүүхэд эсвэл өндөр настан өрх толгойлж, малаа хариулах шаардлага үүсдэг. Эдгээр бэрхшээлүүд нь онцгой байдлыг улам хүндрүүлдэг учраас мал амьтанд чиглэсэн үйл ажиллагааг тухайн нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх хэрэгтэй.
- *Мал амьтан ба хоол тэжээл.* ХДХВ-н халдвартай хүмүүсийн хувьд өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүнийг хоол хүнсэндээ хэрэглэж байх зайлшгүй шаардлагатай байдаг. Ретровирусын эсрэг эмийн (ARV) үр нөлөөг нэмэгдүүлэхэд сайн чанарын хоол тэжээл хэрэгтэй.

Тиймээс онцгой байдлын үед мал амьтнаа алдах нь ХДХВ-н халдвартай хүмүүсийн хүнсний хангамжид сөрөг нөлөөтэй.

- *Зооноз өвчин.* ХДХВ-н халдвартай хүмүүс зооноз буюу малаас хүнд халдварладаг өвчнүүдэд маш өртөмтгий байдаг. Зооноз өвчинд сүрьеэ, бруцеллёз, токсоплазм мэтийн өвчнүүд багтдаг. Ялангуяа сүрьеэ өвчин төрөх насны эмэгтэйчүүдийн нас баралтын гол шалтгаан болж, ХДХВ-н халдвартай хүмүүсийн нас баралтад нөлөөлдөг (Дэлхий дээрх ДОХ-оор нас баралтын гурван хүн тутмын нэг). Энэ өвчин ядуу, эмзэг бүлгийнхэнд хамгийн ихээр аюул учруулдаг. Сүрьеэ нь ХДХВ-н биемахбодид үржих явцыг идэвхижүүлж, ДОХ өвчлөлийг хүндрүүлдэг. Иймээс зооноз өвчнөөс сэргийлэх нь ХДХВ-н халдвартай хүмүүсийн эмзэг байдлыг бууруулахад чухал ач холбогдолтой.
- *Мэдлэг болон ур чадвар.* Хүүхдүүддээ мал маллах арга ухааныг өвлүүлэхээсээ өмнө эцэг эх нь нас барчихвал мал маллах залгамж халаа, мэдлэг уламжлал алдагдахад хүрнэ. Хэрэв малын эмч хүн ХДХВ-ээр халдварласан тохиолдолд мал эмнэлгийн үйлчилгээ, хүртээмж үзүүлэх боломжгүй болно.
- *Нийгмийн тусгаарлалт болон гадуурхалт.* Нийгмийн тусгаарлалт, гадуурхалт ХДХВ-н халдвартай хүмүүст нийтлэг тохиолддог. Мал услах худаг зэрэг нийтийн эзэмшлээс ашиглахыг нь хориглох эсвэл бүр өөрийн хот, суурингаа орхиж явахаас өөр аргагүй байдалд ч хүргэдэг. Эмчилгээний зардлаа төлөх болон оршуулга хийхэд малаа зарж төлбөр тооцоо хийдэг нь өрхийн малын тоог ихээр бууруулдаг. Онцгой байдлын үед ХДХВ-н халдвартай хүмүүс илүү эмзэг байдаг бөгөөд тэдний амьжиргаа маш амархан сүйрч үгүй болдог.

ХДХВ-н халдвартай хүмүүст нөлөөлж буй аливаа нэг онцгой байдлын үр дагаврыг анхааралдаа авч, арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ тэдний тусгай хэрэгцээ, шаардлагыг тусгаж өгөх хэрэгтэй. Мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаа нь ХДХВ/ДОХ-н халдвартай хүмүүсийн гэр бүлийнхэний хэрэглэдэг аргууд дээр тулгуурлан хэрэгжих зүйтэй.

Хамгаалалт

Sphere (2011) болон *Хүмүүнлэгийн үйл ажиллагаанд Хүүхдийг Хамгаалах наад захын стандартууд* (CPWG, 2012) зэрэг номд хүний түгээмэл эрх болон хүмүүнлэгийн үйл ажиллагааны тухай хуульд үндэслэн хямралд өртсөн хүмүүсийн аюулгүй байдал, нэр төр ба бүрэн бүтэн байдлыг алдагдуулалгүйгээр хүмүүнлэгийн тусламж үзүүлэх тодорхой *Зааварчилгаа*г багтаасан байдаг. Онцгой байдлын үед ялангуяа мөргөлдөөнтэй хавсарсан тохиолдолд нэрвэгдсэн хүн амыг хамгаалахад төвийг сахих шаардлагатай болдог ба нийгмийн бүлгүүд, хувь хүмүүс нь бэлгийн хүчирхийлэл, хулгай, дээрэм, албадлага, дэлбэрэлт, дайралт, нөөцийн хомсдол, газар нутаг сүйтгэх болон үйлчилгээ доголдох зэрэг тохиолдлын хохирогч болох магадлал ихэсдэг. Иймээс арга хэмжээ авч буй байгууллагууд тэдний үйл ажиллагаа нь ашиг хүртэгчдийг нэмж аюулд учруулахгүй байх тал дээр анхаарах хэрэгтэй.

LEGS нь хамгаалалтын дараах дөрвөн зарчмыг дэмждэг бөгөөд илүү дэлгэрэнгүйг Sphere гарын авлагаас үзэж болно. (Sphere, 2011:25–47):

Хамгаалалтын зарчим 1: Аюул учруулахаас зайлсхийх.

Хамгаалалтын зарчим 2: Тусламжийг алагчлалгүй, шударгаар түгээх.

Хамгаалалтын зарчим 3: Хүмүүсийг хүчирхийллээс хамгаалах.

Хамгаалалтын зарчим 4: Шаардлагатай хуулийн тусламж авах, эрхээ хамгаалах болон дарамт шахалтаас эргэн хэвийн байдалдаа ороход нь туслах.

Дэлхий нийтэд мал амьтан нь санхүүгийн үнэт эд хөрөнгөд тооцогддог бөгөөд сайн чанарын хоол хүнсний эх үүсвэр юм. Мөн мал амьтан нь үргэлж хөдөлгөөнд байдаг. Тиймээс аюултай орчинд байгаа мал амьтан хулгай болон зэвсэгт бүлэглэлийн бай болдог. Мал амьтантай холбоотой онцгой байдлын үед хүмүүсийг хамгаалах, эрсдлийг бууруулах арга хэмжээ авахаасаа өмнө хамгаалах аргуудад дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Жишээ нь:

- Мал амьтныг хамгаалах эсвэл малжуулах үйл ажиллагаа нь өрхийн хулгай дээрэмд өртөх эрсдлийг нэмэгдүүлж, байдлыг хурцатгах талтай. Аюулгүй байдлаас хамаарч ямар төрлийн мал амьтан нь эд

хөрөнгө, эдийн засгийн ашиг авчрах эсэх нь тодорхойлогдоно.

- Мал маллахад эмэгтэйчүүд, охидын хувьд хол газар явж малаа бэлчээх, услах шаардлага гардаг. Энэ нь тэднийг хүчирхийлэл, бэлгийн дарамт эсвэл хулгайлагдах эрсдэлд оруулдаг.
- Дүрвэгсэд илүү өртөмтгий байдаг бөгөөд олон тооны мал нь хулгайчдын анхаарлыг татах, таньж мэдэхгүй газар малаа бэлчээх, услах нь халдлага дайралтад өртөх эрсдлийг нэмэгдүүлдэг.
- Байгалийн нөөц хомс үед малаа өөр нутаг дэвсгэрт шилжүүлэн маллах нь үндсэн оршин суугчидтай зөрчил үүсэх эрсдлийг дагуулж байдаг.

Мал амьтныг хамгаалах асуудал нь эргээд орон нутагт зөрчил үүсгэж болзошгүй, тодорхой төрөл зүйлийн мал өсгөх нь амьжиргаанд ашиг тусаа өгдөг хэдий ч аюулгүй байдлын хувьд эрсдэл дагуулах сөрөг тал ч байдаг. Энэ төрлийн дүн шинжилгээг Анхдагч үнэлгээний нэг хэсэг болгон хэрэгжүүлэх нь онцгой байдалтай холбоотой зөрчил үүсэхээс сэргийлэх тохиромжтой арга юм (*Бүлэг 3, Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох*).

Байгаль орчин болон уур амьсгал

Мал амьтан амьд үлдэх, ашиг шимээ өгөх нь ус, бэлчээр гэх мэт байгалийн нөөц баялгаас хамааралтай байдаг. Иймд мал амьтанд тулгуурласан амьжиргааг дэмжих үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд байгаль орчны тогтвортой менежмент чухал хэрэгтэй юм. Урт хугацааны хөгжлийн хүрээнд авч үзвэл мал аж ахуйтай холбоотой байгаль орчны асуудал нь нарийн төвөгтэй бөгөөд үүнтэй холбоотойгоор хүнсний хангамжийн бодлого, үйлдвэржсэн мал аж ахуй, олон улсын худалдаа, уур амьсгалын өөрчлөлт гэх мэт олон төрлийн тулгамдсан асуудлууд гарч ирдэг.

Хөгжиж буй улс орнуудад уламжлалт мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тогтолцоо олон төрөл байх ба Африк, Ази тивийн өргөн уудам нутагт бэлчээрлэн аж төрөх нүүдлийн аж ахуй байхад, хот сууринтайгаа хаяа дэрлэн гахай, шувууны үйлдвэрлэл явуулдаг хэсэг ч байна. Нүүдлийн мал аж ахуйд улирлын чанартай бэлчээрийг ашигладаг нь үр дүнтэй, тогтвортой арга гэж үздэг хэдий ч шилжилт хөдөлгөөнд хориг тавигдах эрсдэлтэй. Мал амьтныг төвлөрсөн газар тэжээдэг (жишээлбэл хашигдсан бэлчээр, тахианы байр гэх мэт) эрчимжсэн аж ахуйн хувьд хөрс, усны бохирдуулах зэрэг байгаль орчинд сөрөг нөлөө

үзүүлдэг. Орчны эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл сул тохиолдолд мал өвчлөх, хорогдох, малын ашиг шим буурах, үйл ажиллагааны зардал нэмэгдэх, хүн өвчлөх эрсдлийг нэмэгдүүлдэг.

Онцгой байдлын өмнөх болон тохиолдсон үед мал аж ахуйгаас үүдэлтэй байгаль орчны сөрөг нөлөөг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Жишээ нь:

- Гангийн улмаас бэлчээр, тэжээл, усны хомсдол үүсэж, усны эх үүсвэр тойрсон малын тоо нэмэгдэж, бэлчээр талхлагдах эрсдэлтэй.
- Дүрвэгсэд малтайгаа хамт хуаранд суурьшсанаас хязгаарлагдмал газарт маш олон тооны малын бөөгнөрлийг бий болгодог. Хэдийгээр өвс, ус хангалттай байсан ч эрүүл ахуйн асуудлыг анхаарах, орон нутгийн иргэдийн өөрсдийн ашигладаг бэлчээр болон худгийг ашиглах нь нөөцийг багасгаж, байгаль орчны сүйрэлд хүргэх аюултай.
- Мөргөлдөөн эсвэл бусад хүчин зүйлээс шалтгаалан нүүдэл, шилжилт хөдөлгөөнд хориг тавих нь мал амьтны хэвийн бэлчээрлэхийг хязгаарлаж улмаар ашиглаж буй бэлчээр нь талхлагдах, малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.

Зарим онцгой байдлын үед байгаль орчны асуудалд малын гаралтай хог хаягдлын менежмент, мал нядалгааны дараа дайвар бүтээгдэхүүн, малын сэг зэмийг устгах гэх зэрэг орно. Үерийн үед хэдэн мянган мал үхэж хорогдож болзошгүй бөгөөд энэ нь байгаль орчинд ихээхэн сөрөг нөлөө дагуулдаг.

Уур амьсгалын өөрчлөлт. Хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй нүүрстөрөгчийн давхар исэл, хүлэмжийн хийн ялгаралт зэрэг дэлхий нийтийг түгшээсэн уур амьсгалын өөрчлөлтүүд тохиож байна. Уур амьсгалын энэхүү өөрчлөлт нь мал амьтан болон малчдад шууд ба шууд бус хэлбэрээр их бага хэмжээгээр нөлөө үзүүлдэг. Шууд үр дагавар температурын өөрчлөлт, усны хомсдол, мал амьтны өвчний хөдлөл зүй, бэлчээрийн ургамлын төрөл зүйлийн өөрчлөлт зэрэг орно. Шууд бус үр дагаварт хүн, мал амьтны хоол тэжээлийн хомсдол, үнийн өөрчлөлт, уур амьсгалын өөрчлөлтөд зохицох зорилгоор био түлш боловсруулах хэлбэрээр газрыг ашиглах зэргийг дурьдаж болно. Хамгийн чухал нь LEGS-н хувьд ган, үер, хүчтэй салхи шуурга зэрэг давтамж нь мэдэгдэхүйц нэмэгдэж буй цаг агаарын аюулт үзэгдлийг анхаарах бөгөөд зарим урт хугацааны уур амьсгалын өөрчлөлт нь малчдын эмзэг байдлыг нэмэгдүүлж, эргэн сэргэх хурд, чадамжийг нь бууруулж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн чиг хандлага дэлхийн улс орнуудад харилцан адилгүй байна. Жишээлбэл: Өмнөд Африкт илүү хуурайшилттай байгаа бол баруун Африкт хур тунадасны хандлага тодорхойгүй харин зүүн Африкт илүү чийгшилтэй (хэдийгээр хур тунадасны дундаж хэмжээ нэмэгдсэн боловч гангийн давтамжийг сааруулж чадахгүй) байна.

Цаг агаарын гэнэтийн өөрчлөлтийн төлөв байдал, одоогийн болон өнгөрсөн хугацааны өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх нь амаргүй бөгөөд учир нь эдгээрийн аль аль нь хурдацтайгаар өөрчлөгдөж байна. Ерөнхийдөө шинжлэх ухааны үүднээс бол уур амьсгалын өөрчлөлт нь зарим төрийн бус байгууллага болон хэвлэл мэдээллээр зарлаж байгаагаас харьцангуй бага хэмжээгээр явагдаж байгаа гэж тайлбарлаж байна. Саяхан хэд хэдэн шинжлэх ухааны бүтээлд уур амьсгалын өөрчлөлтөөс илүүтэйгээр гангийн нөлөө их байгааг Сомалид 2011 онд тохиосон гангийн жишээгээр тайлбарлажээ.

Гангийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хэрхэн бэлэн байдлаа сайжруулах тал дээр гамшгийн эрсдлийг бууруулахаар ажиллаж буй байгууллагуудад хэд хэдэн тодорхой чиглэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй өгсөн байна. Шинжлэх ухаан хөгжихийн хэрээр аюул гамшгийн ирээдүйн чиг хандлага болон магадлалын талаарх шинэ судалгаа, ололтуудыг цаг алдалгүй олж мэдэх нь малчдын дунд гамшгийн эрсдлийг бууруулахаар ажиллаж буй байгууллагуудын хувьд нэн чухал. Энэ нь гангийн шалтгаан, цаашдын хандлагын талаарх шинжлэх ухааны таамаглал, ололтыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд чухал ач холбогдолтой.

Нийтлэг стандартууд

Нийтлэг стандарт 1: Оролцоо

Гамшигт нэрвэгдсэн ард иргэдийг мал амьтанд чиглэсэн хөтөлбөрийн төлөвлөлт, үйл ажиллагааны хэрэгжилт, хяналт, үнэлгээнд идэвхитэй оролцуулах

Үндсэн үйл ажиллагаа

- Хүн амын тодорхой нэг хэсэг болон эмзэг бүлгийг тодорхойлж, тэдэнд урьдчилан үнэлгээ хийх болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, үнэлгээ хэрэгжилт (*Зааварчилгаа 1, 2* харна

уу), хяналтын үйл явцад (*Зааварчилгаа 3* харна уу) идэвхтэй оролцохыг урриална.

- Тухайн орон нутагт уламжилж ирсэн мал аж ахуйн үйлдвэрлэл, эрүүл мэндийн талаарх мэдлэг, туршлага, дасан зохицох арга барил, өмнө нь мал амьтанд үзүүлдэг байсан үйлчилгээнүүдийг баримтжуулан хадгалж, тэдгээрийг тогтвортой байдлын үзүүлэлт болгон ашиглах (*Зааварчилгаа 4* харна уу).
- Нийгмийн болон соёлын хэм хэмжээг тодорхойлсны үндсэн дээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх (*Зааварчилгаа 5* харна уу).
- Хэрэгжүүлэх хөтөлбөрийн үйл ажиллагаа болон аргачлалын талаар орон нутгийн төлөөлөл, эсвэл тодорхой хэсэг болон эмзэг бүлгийг төлөөлж буй нийгмийн бүлгүүдтэй хэлэлцэнэ (*Зааварчилгаа 6* харна уу).

Зааварчилгаа

1. **Бүлгүүдийн төлөөлөл.** Мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагааг оновчтой төлөвлөх, тодорхойлох, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, ялангуяа мал аж ахуй эрхэлдэг эсвэл малын гаралтай бүтээгдэхүүнээс орлого олдог хүн амын тодорхой хэсэг болон эмзэг бүлгийнхэний төлөөлөлийг оролцуулах хэрэгтэй. (Энэ бүлгийн төгсгөлд байгаа *Жишээ судалгаа 2.4-г харна уу*). Ийнхүү иргэдийн төлөөллийг хамруулахдаа тэдний идэвхитэй оролцоог хэрэгжилтийн бүх үе шатанд хангах нь чухал. Мал сүргийг бодитоор болон боломжийн хэрээр ашиглах, эзэмших байдал хүмүүсийн хөрөнгө чинээ, хүйсийн байдал болон бусад хүчин зүйлсээс хамааран янз бүр байдаг. Иймээс анхдагч үнэлгээг хийхдээ эдгээр үзүүлэлтийг харгалзан үзэж ялгаатай бүлэгт чиглэсэн өөр өөр үр нөлөөтэй үйл ажиллагааг гаргаж ирнэ. Хөрөнгө чинээтэй хүмүүс үхэр, тэмээ зэрэг бод мал эзэмшдэг бөгөөд тэдэндээ зориулж тусламж хүсдэг байхад ядуу өрхүүд голдуу ямаа, хонь, шувуу болон илжиг зэрэг жижиг амьтдад чиглэсэн тусламж хүсдэг байх жишээтэй. Тиймээс байгууллагууд эдгээр ялгааг нарийн мэдэрч анхаарал хандуулан ажиллах хэрэгтэй. Эмэгтэйчүүд болон бусад эмзэг бүлгийнхэнийг оролцуулахад саад бэрхшээл гардаг тул үнэлгээний болон хэрэгжүүлэх үе шатны аль алинд нь харгалзан үзэх хэрэгтэй.
2. **Оролцооны төрөл.** Гамшигт өртсөн хүн ам нь тэнд хэрэгжүүлэх хөтөлбөрт оролцох эрхтэй бөгөөд үүнийг хөтөлбөрийн үр дүнг

сайжруулахад хийж буй оюун санааны хөрөнгө оруулалт гэж үздэг. Иргэд орон нутагт нь хэрэгжих онцгой байдлын үйл ажиллагааны төрөл, хэлбэрийг сонгоход оролцох боломжтой байх ёстой. "Оролцоо" хэмээх нийтлэг стандартын хүрээнд орон нутгийнханы мэдлэг, ур чадварыг тусламжийн байгууллагуудын үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд туслах чухал нөөц гэж үздэг бөгөөд үүнийг идэвхтэйгээр ашиглахыг зөвлөдөг. Идэвхитэй оролцоонд тулгуурлан хэрэгжсэн хөтөлбөр нь илүү тогтвортой үр ашиг, үйлчилгээг үлдээдэг байна. Хүн амын оролцоотойгоор тусламж үзүүлэх зорилтот бүлгийг тодорхойлох нь тусламжийн хуваарилалтыг ухаалаг оновчтой хийхэд чухал нөлөөтэй. (*Нийтлэг стандарт 5* харна уу). Мэдээж ийм хэмжээний оролцоог хангах нь амаргүй, тэр тусмаа гэнэтийн гамшгийн үед, гэхдээ оролцоо нь LEGS-н гол зорилго хэвээр байх бөгөөд хүний эрхэнд тулгуурласан урт хугацааны тогтвортой үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг эрмэлзэх болно.

3. **Хариуцлага болон оролцоо.** Онцгой байдлын үед хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийхэд олон нийтийг оролцуулах нь хүмүүнлэгийн байгууллагын болон оролцогчдын орон нутаг дахь хариуцлагыг сайжруулах маш чухал арга юм. *(Нийтлэг стандарт 6: Хяналт, үнэлгээ болон амьжиргаанд үзүүлэх нөлөө* хэсгийг харна уу*)*. Мөн HAP стандарт харна уу. (HAP , 2007).

4. **Тогтвортой байдал.** Мал амьтнаас хамааралтай байдаг иргэд мал сүргээ маллах, малын эрүүл мэндийн талаар нарийн уламжлалт мэдлэгтэй байдаг бөгөөд энэ нь мал амьтанд чиглэгдсэн хөтөлбөр хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Гамшгийн эсрэг хариу арга хэмжээнд оролцоог дэмжиж, орон нутгийн мэдлэг, ур чадварыг таньж, дасан зохицох тогтвортой арга барилыг бий болгож, өмнөх үйлчилгээ, тогтолцоог сайжруулан ашиглаж чадвал эдгээр үйлчилгээ нь удаан хугацаанд тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлнэ. Мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулахдаа тухайн хүмүүнлэгийн ажиллагаа нь орон нутгийн хувиараа ажил үйлчилгээ эрхлэгчдийг тусгаарлаж болохгүй. Энэ нь орон нутгийн тогтолцоонд сөргөөр нөлөөлдөг.

5. **Нийгмийн болон соёлын хэм хэмжээ.** Нийгэм, соёл болон шашны зан үйл нь мал аж ахуй эрхлэх, малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулахад нөлөөлдөг. Тодорхой төрлийн мал амьтан, малын гаралтай хоол хүнс хэрэглэх нь гадны хүмүүсийн хувьд хэвийн

байж болох ч орон нутгийн ёс заншлаар хориотой байж болно. Хүмүүс шинэ арга туршлагаас үргэлж зайлсхийгээд байдаггүй ч иймэрхүү үйл ажиллагаа их цаг зарцуулахаас гадна олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг явуулах талаар олон жилийн туршлагатай хүмүүсийн дэмжлэг шаардлагатай. Шуурхай үйл ажиллагаа явуулах шаардлагатай үед нийгэм, соёлын хэм хэмжээг мэддэг байх нь тохиромжтой арга хэмжээг хэрэгжүүлэхэд чухал юм.

6. **Олон нийтийн бүлгүүд.** Олон нийтийн эсвэл нутгийн уугуул байгууллагууд нь гамшгийн үеийн үйл ажиллагаа явуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь эмзэг бүлгийн ашиг хүртэгч нарыг тодорхойлохоос эхлээд үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ зэрэг болно. Олон нийтийн төлөөллийн байгууллагууд нь бэлчээрийн талбай, усны нөөц зэрэг байгалийн нөөцийн менежменттэй холбоотой асуудалд гол үүрэгтэй байдаг. Эдгээр бүлгүүдийн оролцоог мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд тусгаснаар үйл ажиллагааны тогтвортой байдал, амьжиргаанд үзүүлэх эерэг нөлөөллийг бий болгоно.

Нийтлэг стандарт 2: Бэлэн байдал

Онцгой байдлын үеийн хариу арга хэмжээ нь бэлэн байдал, бэлэн байдлын төлөвлөгөө болон эрт үеийн хариу арга хэмжээг авах зэрэг гамшгийн эрсдлийг бууруулах зарчимд үндэслэгдэнэ.

Үндсэн үйл ажиллагаа

- Гамшгийн эрсдлийг бууруулах ажил нь байгууллагуудын гамшгийн төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн нэг хэсэг болно (*Зааварчилгаа 1* харна уу).
- Урт хугацааны хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж буй тохиолдолд, өөрсдийн үйл ажиллагаа явуулж буй газар нутагт өмнө нь тохиолдож байсан гамшгийн төрөл, давтамж, аюулын зэрэг ба хариу арга хэмжээнээс авсан сургамжыг тогтмол эргэн харж байх хэрэгтэй (*Зааварчилгаа 2* харна уу).
- Энэхүү мэдээлэл дээр үндэслэн байгууллагууд үйл ажиллагаа эхлэх цэг, зарцуулах санхүүжилтийн олгогдох шат дараалал болон бусад нөөцийг тусгасан болзошгүй байдлын төлөвлөгөө боловсруулна (*Зааварчилгаа 2* харна уу).

- Бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулахдаа байгууллагын худалдан авалт, захиргааны үйл явц, гамшгийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч болох аливаа саад бэрхшээлийг харгалзан үзнэ (*Зааварчилгаа 3* харна уу).
- Гангийн үед хэрэгжүүлэх бэлэн байдлын төлөвлөгөө нь гангийн мөчлөгийн зарчим дээр үндэслэгдэх бөгөөд шат дараалсан эрт үеийн хариу арга хэмжээг багтаасан байна (*Зааварчилгаа 4* харна уу).
- Олон нийтийг болзошгүй онцгой нөхцөл байдалд бэлэн байхыг уриалах (гэнэтийн болон удаан явцтай аль ч тохиолдолд). Гадны хэрэгжүүлэгч байгууллагууд нь орон нутгийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх, дасан зохицох чадвар, нийгмийн гишүүдийн мэдлэгийг дээшлүүлэх, эмзэг байдлыг бууруулахтай холбоотой бодлого журмыг сурталчлах зэргээр бэлэн байдлыг хангахад дэмжлэг үзүүлнэ (*Зааварчилгаа 5* харна уу).
- Бүх гамшгийн үед хэрэгжүүлдэг үйл ажиллагааны төлөвлөгөө нь гамшгийн дараах нөхөн сэргээлт, урт хугацаанд амьжиргааг дэмжих асуудлыг тусгасан төгсгөлийн стратегитай байна (*Зааварчилгаа 6* харна уу).
- Хөтөлбөр хэрэгжүүлэхдээ тухайн газрын байгаль цаг уурын нөхцөл байдлын талаарх бодитой шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллийг ашиглавал үр дүнтэй (*Зааварчилгаа 7* харна уу).

Зааварчилгаа

1. **Гамшгийн эрсдлийг бууруулах.** Урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхэд үүсэж болзошгүй онцгой нөхцөл байдалд эмзэг бүлгүүдийн даван туулах чадвар, гамшгийн эрсдлийг бууруулах талаар тусгана. Энэ нь байгууллага, нийтийн бэлэн байдлын төлөвлөгөөний нэг хэсэг байх бөгөөд (гамшгийн үед гамшгийн үйл ажиллагааны зарцуулах санхүүжилт, төлөвлөгөө), эсвэл үүсэж болох гамшгийн үр нөлөөг багасгах бэлэн байдлын төлөвлөгөөтэй байна. Жишээ нь: бэлэн байдлыг хангахын тулд өвс тэжээл нөөцлөх, мал эмнэлгийн эм бэлдмэлийн хангамжийн сүлжээ үүсгэх гэх мэт.
2. **Бэлэн байдлын төлөвлөгөө болон үйл ажиллагаа.** Ган, үер зэрэгт давтамжтайгаар өртдөг газруудад бэлэн байдлын

төлөвлөгөөтэй байх нь эрт шуурхай хариу арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлнэ. Туршлагаас харахад гангийн эсрэг эрт хариу арга хэмжээ авах нь хүмүүсийн амьжиргааг хамгаалах гол хүчин зүйл болдог. Газар хөдлөлт, үер мэтийн гэнэтийн гамшгийн үед бага ч гэсэн сэрэмжлүүлэх дохио өгснөөр бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа хэрэгжиж эхэлнэ. Тодорхой салбарт урт хугацааны хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлдэг туршлагатай тусламжийн байгууллагын мал амьтанд чиглэгдсэн хариу арга хэмжээ нь амжилттай, үр дүнтэй хэрэгжсэн тохиолдлын ихэнх нь гамшгийн болон хөгжлийн хөтөлбөрүүдийг хооронд нь уялдуулан хэрэгжүүлсэнтэй холбоотой. Иймд төлөвлөгөөг болж өнгөрсөн гамшгийн талаарх мэдлэг, үйл ажиллагаа, санхүүжилтийн хүрээнд хэрэгжиж болохуйц хариу арга хэмжээний төрөл зэрэгт үндэслэн гаргана. Бэлэн байдлын төлөвлөгөөг орон нутгийн оролцогч талуудтай хамтран боловсруулах нь чухал бөгөөд гамшгийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнд зарцуулагдах санхүүжилт нь урьдаас тодорхой тусгагдсан байна (бүлгийн төгсгөлд байгаа *Жишээ, судалгаа 2.3*-г харна уу). Эрт зарлан мэдээлэх тогтолцоотой уялдуулах нь чухал байдаг. Мөн бэлэн байдлын төлөвлөгөөнд холбогдох ажилтнууд, шаардлагатай газруудад олон нийтийн бүлгийн гишүүдийг сургах ажлыг тусгах бөгөөд ингэснээр урьдчилан төлөвлөсөн арга хэмжээ илүү үр дүнтэй явагдах болно.

3. **Худалдан авалт болон захиргааны зохицуулалт.** Онцгой байдал үүссэн үед хариу арга хэмжээ хэрэгжүүлэхэд байгууллагын зүгээс уян хатан байдал, шийдвэр гаргах зэрэгтэй уялдуулан захиргааны журмуудаа сайн нягтлан үзэх хэрэгтэй бөгөөд энэ нь үр дүнтэй хариу арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Амьжиргаанд тулгуурласан гамшгийн эсрэг хариу арга хэмжээ авах үед малын тэжээлийг их хэмжээгээр яаралтай худалдан авах шаардлага гардаг. Мөн тээврийн компани, хүнс тэжээл нийлүүлэгч, мал эмнэлгийн ажилчид зэрэг хувийн хэвшлийнхэнтэй гэрээ байгуулах хэрэгтэй болдог. Шаардлагатай тохиолдолд хэрэгжүүлэгч байгууллага эсвэл санхүүжүүлэгчийн зөвшөөрлөөр бэлэн мөнгө тараах эсвэл эрхийн бичиг олгох шинэ тогтолцоо нэвтрүүлэх шаардлага гардаг.

4. **Гангийн мөчлөгийн менежмент.** Энэ менежмент нь өөр өөр төрлийн хариу арга хэмжээнд тохирсон тусгай үзүүлэлтүүдтэй

бөгөөд эдгээрийг онцгой байдлын шаардлагатай үе шатанд хослуулан хэрэгжүүлдэг (гангийн мөчлөгийн үе шатуудын тодорхойлолтыг *Нэр томьёоны тайлбар* хэсгээс харна уу). Энэ аргачлал нь гангийн эрт үед цаг алдалгүй хариу арга хэмжээ авахыг зөвлөх нь цаашилбал тусламжийн үйл ажиллагаа үзүүлэхээс малчдад илүү үр ашигтай байдаг (жишээ нь малжуулах эсвэл доройтсон малыг тэжээснээс мал амьтны тоо толгойг бууруулах нь илүү үр ашигтай гэх мэт).

5. **Олон нийтийн бэлэн байдал.** Олон нийттэй урт хугацаанд хамтран ажиллаж буй байгууллагууд цаашид үүсэж болох магадлалтай гэнэтийн, удаан явцтай гамшгийн эсрэг бэлэн байдлын төлөвлөгөө гаргахад олон нийтэд туслалцаа үзүүлэх хэрэгтэй. Жишээлбэл: газар хөдлөлтөд тэсвэртэй малын хашаа саравч барих (*Бүлэг 8, Мал амьтны хашаа хороо ба байршуулалт*); малын тэжээлийн нөөц бүрдүүлэх (*Бүлэг 6, Тэжээл хангамж*); мал амьтныг урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамруулах аян зохион байгуулах (*Бүлэг 5, Мал эмнэлгийн үйлчилгээ*); эсвэл мал амьтны амьтны зах зээлийн боломжийг хөгжүүлэх гэх мэт (*Бүлэг 4, Мал амьтны тоо толгойг бууруулах*). Бэлэн байдлын төлөвлөлт нь орон нутгийн байгууллагуудын (одоо үйл ажиллагаа явуулж байгаа эсвэл онцгой байдлын үед ажилладаг бүлгүүд) чадавхийг бэхжүүлэхэд анхаарах хэрэгтэй бөгөөд үүнээс тэд эмзэг байдлын учир шалтгаан, түүнийг хэрхэн бууруулах талаар туршлагатай болно. Ийм хэлбэрээр сурч мэдсэн туршлага нь олон нийтийн болон гадны бусад байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх боломжтой (*Нийтлэг стандарт 7 х*арна уу).

6. **Гарах стратеги.** Ихэнх тохиолдолд онцгой байдлын хариу арга хэмжээнүүд нь дараагийн үе шат руу шилжих эсвэл урт хугацааны хөгжлийн санаачлага хэлбэрээр үргэлжлэх эсэхээ тодорхой төлөвлөлгүйгээр хэрэгжсэн байдаг. Онцгой байдалд зориулагдсан санхүүжилт дуусанаар үйл ажиллагааг гэнэт зогсоох нь (жишээ нь аюул өнгөрсөн гэж үзсэн тохиолдолд) ашиг хүртэгч иргэдийн хувьд сөрөг үр дагавар авчирдаг. Онцгой байдлын нөхөн сэргээлтийн арга хэмжээг хэрэгжүүлэгч эсвэл бусад оролцогч талууд амьжиргааг урт хугацаанд тогтвортой дэмжих үйл ажиллагаатай уялдуулан боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.

7. **Цаг уурын төлөвийн мэдээг ашиглах.** Урт хугацаагаар гаргасан шинжлэх ухааны үндэслэлтэй уур амьсгалын өөрчлөлтийн (ерөнхийдөө хамгийн багадаа 20 жилийн дараах байдлаар гардаг)

мэдээ нь бэлэн байдлыг хангах төлөвлөгөөнд тийм ч тохиромжтой байдаггүй. Гэвч байгууллагууд НҮБ-н Уур Амьсгалын Өөрчлөлттэй улс орнуудад чиглэсэн Хөгжлийн хөтөлбөр эсвэл Hadley төв дэх PRECIS загварын системийг ашиглах сургалтад хамрагдсан мэргэжилтнүүдийн гаргасан төлөв байдлын талаарх мэдээлэлийн эх үүсвэрийг ашиглаж болно.

Нийтлэг стандарт 3: Техникийн туслалцаа ба байгууллагын чадвар

Онцгой нөхцөл байдлын үед мал амьтанд чиглэсэн хөтөлбөрийг үр дүнтэй төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэхэд тухайн ажилтнаас зохих хэмжээний чадвар, хандлага, туршлага шаардана.

Үндсэн үйл ажиллагаа

- Хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан нь хүн амын аль ч төрлийн болон эмзэг бүлгийн төлөөлөлтэй хамтран үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, зах зээлийн, шуурхай оролцооны үнэлгээ хийх, мал амьтантай холбоотой үйл ажиллагааны талаарх мэдлэг, ур чадвартай байна (*Зааварчилгаа 1* харна уу).
- Тухайн ажилтан нь хүний эрх, хүмүүнлэгийн үйл ажиллагааны зарчмууд болон тэдгээрийн мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаатай хэрхэн холбогддог талаар мэдлэгтэй байх хэрэгтэй (*Зааварчилгаа 2* харна уу).
- Амьжиргааг дэмжих хөтөлбөрийн зарчмуудын талаар мэдлэгтэй байх хэрэгтэй (*Зааварчилгаа 2* харна уу).
- Ажилтнуудын хамгаалалт, аюулгүй байдлыг анхаарах (*Зааварчилгаа 3* харна уу).

Зааварчилгаа

1. **Техникийн ур чадвар болон мэдлэг.** Мал амьтны чиглэлээр ажиллагсдын мэргэжлийн ур чадвар, ажлын бүтээмж нь техникийн мэдлэг, туршлага, хандлага, харилцааны ур чадварыг хэрхэн зохистойгоор хослуулан ажиллаж байгаагаас хамаарна. Ерөнхийдөө хөтөлбөрийн менежер, удирдлагууд нь онцгой байдлын хариу арга хэмжээний талаар сайн мэддэг ч мал амьтны талаарх мэдлэг багатай байдаг. Эсрэгээрээ мал аж ахуйн мэргэжилтнүүд болох малын эмч, мал зүйч гэх мэт хүмүүсийн

хувьд оролцооны үнэлгээ, төсөл боловсруулах эсвэл амьжиргааг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх талаар ур чадвар дутмаг байдаг. Эмзэг бүлгийнхэнтэй ажиллаж байсан туршлага нь олон нийттэй ажиллаж, холбогдох үйл ажиллагааг төлөвлөн явуулахад хамгийн чухал чадвар байдаг. Тусламжийн чиглэлээр ажилладаг мал аж ахуйн мэргэжилтнүүдэд үйл ажиллагаа төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх оролцооны аргачлалыг зааж сургах стандарт байх ёстой.

2. **Хүний эрх болон амьжиргаанд тулгуурласан аргачлалууд.** Мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаанууд нь хүний эрхтэй холбоотой байдаг (*Бүлэг 1, Мал амьтан, амьжиргаа ба онцгой байдал).* Иймд тусламжийн чиглэлээр ажилладаг мал аж ахуйн мэргэжилтнүүд нь хүний эрх, хүмүүнлэгийн үйл ажиллагааны талаарх мэдлэгтэй байх ёстой. Мөн амьжиргааг дэмжих хөтөлбөр, зах зээлийн суурь судалгаа хийх мэдлэгтэй байвал зохино. Эдгээр мэдээллүүдийг онцгой байдал үүсэхээс өмнө богино хугацааны сургалтаар олгож болно.

3. **Ажилчдын аюулгүй байдал.** Ажилчдын бие махбодын аюулгүй байдал болон гамшигт нэрвэгдсэн газарт саадгүй хүрч ажиллах боломжийг хэрэгжүүлэгч байгууллага хариуцна. Аюулгүй байдал сул байх нь хамгаалалт гаргах, нэмэлт машин техник хөлслөх, сайн холбоо харилцааны төхөөрөмжөөр тоноглох гэх мэт үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлдэг. Үйл ажиллагаагаа цаг хугацаанд нь хэрэгжүүлж чадахгүй, эцсийн мөчид өөрчлөх зэрэг нь хариу арга хэмжээний чанар, ур дүнд сөргөөр нөлөөлдөг. Байгууллагын ажилчдын аюулгүй байдлыг хангах талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэлийг Сайн дадлын Хүмүүст Тусламж үзүүлэх кодоос (People in Aid, 2003) харна уу.

Нийтлэг стандарт 4: Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох

Анхдагч үнэлгээгээр мал амьтны амьжиргаанд гүйцэтгэх үүрэг, үүссэн онцгой байдлын мөн чанар, цар хүрээ болон үйл ажиллагаа, бодлогын хүрээнд дүн шинжилгээ хийнэ. Хамгийн оновчтой, цаг хугацааны хувьд хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээг оролцооны аргаар тодорхойлно.

Үндсэн үйл ажиллагаа

- Анхдагч үнэлгээ нь *Бүлэг 3* (*Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох)*-т зааснаар системтэй, асуулгыг оролцооны аргаар мэргэшсэн ажилтнаар авахуулж үр дүнг өмнөх үйл ажиллагааны мэдээлэлд тулгуурлан нэгтгэн боловсруулна (*Зааварчилгаа 1* харна уу).
- Үнэлгээний үр дүнг гамшигт нэрвэгдсэн иргэдийн хүн амын бүтцээр болон эмзэг бүлгүүдээр ангилан харуулна.
- Үнэлгээгээр холбогдох эрх бүхий байгууллагын өөрсдийн харьяа нутаг дэвсгэр дэх хүн амыг хамгаалах үйл ажиллагааны орчин, мал амьтанд чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж, чадавхийг тодорхойлно (*Зааварчилгаа 2* харна уу)
- Үнэлгээнд орон нутагт ажиллаж байгаа үйлчилгээ үзүүлэгчид, зах зээлийг тодорхойлж хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь эдгээр оролцогчидтой хэрхэн уялдаж ажиллах, тэдний үйлчилгээ, зах зээлийг цаашид тогтвортой хэвээр байлгах стратегийг тодорхойлно (*Зааварчилгаа 3* харна уу).
- Үнэлгээнд хүмүүсийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж байгаа, тодорхой үйл ажиллагааг хориглосон бодлого, зохицуулалтын талаарх түргэвчилсэн дүн шинжилгээг оруулсан байхаас гадна албан ёсны хууль дүрмийг сахиулах орон нутгийн зохицуулах байгууллагуудын чадавхийг нягтлан үнэлнэ (*Зааварчилгаа 4* харна уу).
- Гуравдугаар бүлэгт зааснаар *(Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох)* гол ашиг хүртэгчид, олон нийтийн төлөөллийг оролцуулан хариу арга хэмжээг тодорхойлно (*Зааварчилгаа 5* харна уу).
- LEGS-н амьжиргааг дэмжих зорилтуудаас дор хаяж нэгийг нь хангасан оновчтой, тухайн цаг хугацаанд хэрэгжүүлэх боломжтой хариу арга хэмжээг сонгоно (*Зааварчилгаа 6* харна уу).

Зааварчилгаа

1. **Үнэлгээний сэдэв болон аргачлал.** *Гуравдугаар бүлэгт (Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох)* мал амьтны амьжиргаанд гүйцэтгэх үүрэг, үүссэн онцгой байдлын мөн

чанар, цар хүрээ болон нөхцөл байдлын дүн шинжилгээ гэсэн гол асуудлуудыг хамруулна. Гуравдугаар бүлэгт үнэлгээний шалгах хуудасны асуултууд болон нэмэлт мэдээллийн эх сурвалжуудыг тусгасан.

2. **Хамгаалалт.** Мал амьтан бол үнэт хөрөнгө учраас мал бүхий иргэд түрэмгийлэл, хулгайд өртөх эрсдэл өндөр байдаг (дээр дурьдсан нийтлэг асуудлууд сэдвийн *Хамгаалалт* хэсгийг харна уу). Мал аж ахуй эрхлэхтэй холбоотойгоор мал тонон дээрэмдсэн талаарх сүүлийн үеийн мэдээлэл, мал аж ахуй эрхлэх арга туршлага, мал маллагаатай холбоотой ажил үйлчилгээ эсвэл зах зээлийн хувьд эрсдэлтэй арга хэмжээг судлахын тулд орон нутгийн болон орчны аюулгүй байдлын дүн шинжилгээ хийнэ. Тухайлбал мал амьтан бэлчээрлэх болон услахад аюултай газар руу нүүх, тэсрэх бөмбөг, дэлбэрэлт тохиолддог газарт бэлчээх, хараа хяналтгүй газар малаа хонуулах эсвэл зэвсэгт бүлэглэлийнхэнд шаардлагатай мал амьтныг хариулж анхаарлыг татах зэрэг болно. Үнэлгээ нь олон тооны малтай байх эсвэл малын гаралтай бүтээгдэхүүн хүрэлцээтэй байхын аль нь амьжиргааны хувьд илүү ач холбогдолтой болохыг дүгнэн шинжлэх ба хамгаалахад гарах эрсдлүүд ч үүнд хамаарна. Зарим тохиолдолд хамгаалалтыг нэмэгдүүлэх зорилгоор уламжлалт мал маллагааны аргыг өөрчлөх шаардлага гардаг. Ялангуяа эмзэг бүлгүүдийг энэ үнэлгээнд хамруулж хамгаалалтын хэрэгцээг нь тодорхойлох хэрэгтэй. Онцгой байдлын үе дэх хамгаалалтын талаар ерөнхий мэдээлэл авахыг Sphere гарын авлагын Хамгаалалтын Зарчмууд хэсэг (Sphere, 2011), Хүмүүнлэгийн үйл ажиллагаанд хүүхдийг хамгаалах наад захын стандартууд (CPWG, 2012)-г уншина уу.

3. **Орон нутгийн үйлчилгээ болон зах зээл.** Мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаа нь тухайн орон нутаг дахь ажил үйлчилгээ, зах зээлийг дэмжиж байх нь амьжиргааг дэмжих хөтөлбөрийн нэг чухал хэсэг юм. Орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчдэд малын тэжээл ханган нийлүүлэгч, ус түгээгч, малын эмч, мал эмнэлгийн техник ажилтан, худалдаачид болон тээвэрлэгчид хамрагдана. Нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ (*Бүлэг 3 Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох*), эдгээр оролцогчдын одоогийн болон боломжит чадавхи, зах зээлийн хямралд үзүүлэх нөлөөг (дэлгэрэнгүй мэдээлэлийг Зах зээлийн үнэлгээ-SEEP Network, 2010; Albu,2010: Barrett харна уу) судалсан байх хэрэгтэй.

Зарим улс оронд мал эмнэлгийн үйлчилгээ бүрэн хувьчлагдаагүй байдаг учраас улсын болон хувийн хэвшлийн ажилтнуудын дунд өрсөлдөөн бий болж засгийн газрын ажилтнууд хувийн хэвшлийнхээс илүү давуу эрх эдлэх магадлалтай.

4. **Бодлого ба зохицуулалт.** Үндэсний хэмжээний бодлого, зохицуулалт нь мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагааны заримд нь саад болж, заримыг нь дэмжиж байдаг. Зарим улс оронд олон нийтийн малын эрүүл мэндийн ажилтныг албан ёсоор хүлээн зөвшөөрдөггүй учраас мал эмнэлгийн үйлчилгээ хязгаардлагдмал байдаг. Нөгөө талаар орон нутгийн татвар, гаалийн татвар эсвэл хүнд суртал зэрэг нь зах зээлд чиглэсэн шуурхай хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд саад учруулдаг. Нөхцөл байдлын үнэлгээ нь бодлого зохицуулалтыг авч үзэх бөгөөд онцгой байдлын үед тэдгээрийн хэрэгжих боломжийг тодорхойлно. Онцгой байдлын үед зарим нэг шинээр туршсан ажлын үр дүнгээс хамаарч бодлого, зохицуулалтад өөрчлөлт оруулах шаардлага үүсдэг. Зарим онцгой байдал ялангуяа, зөрчил мөргөлдөөнтэй холбоотой үед засгийн газар болон бусад талуудаас гаргасан албан болон албан бус бодлого шийдвэр нь энгийн иргэдийн амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлдэг. Жишээ нь: хил дамнан нүүхийг хязгаарлах, худалдаа арилжааг зогсоох, иргэдийн өмч хөрөнгийг албадан хураах зэрэг болно. Анхан шатны үнэлгээгээр эдгээр бодлого зохицуулалтыг олж тогтоосноор тохирсон арга хэмжээ авч чадна (*Нийтлэг стандарт* 7: *Бодлого болон нөлөөлөл*).

5. **Хариу арга хэмжээг тодорхойлох.** Бүлэг 3-т (*Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох*) нарийвчилсан зааварчилгаа, оролцооны арга болох Оролцооны аргаар хариу арга хэмжээг тодорхойлох матриц (PRIM) багтаасан байгаа бөгөөд энэ нь анхан шатны судалгааны үр дүнд үндэслэн мал амьтанд чиглэгдсэн онцгой байдлын хариу арга хэмжээг тодорхойлох аргачлал юм. Энэ үйл явцад орон нутгийн оролцогчид (ялангуяа тухайн газар нутагт үйл ажиллагаа явуулж байгаа), орон нутгийн эрх баригчид болон олон нийтийн төлөөлөл (нүүж ирсэн болон хүлээж авч буй аль аль талаас, мөн эрэгтэй эмэгтэй, эмзэг бүлгүүд гэх мэт) оролцуулна.

6. **Амьжиргааны зорилт.** Мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаа нь хамгийн багадаа амьжиргааг дэмжих нэг зорилтыг хангах ёстой

(*Бүлэг 1, Мал аж ахуй, амьжиргаа болон онцгой байдал*) бөгөөд эдгээр нь яаралтай тусламж үзүүлэх, эд хөрөнгийг хамгаалах эсвэл нөхөн сэргээхэд чиглэсэн байна.

Нийтлэг стандарт 5: Техникийн дүн шинжилгээ болон тусламж

Мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаа нь техникийн дүн шинжилгээ дээр суурилсан байх бөгөөд оролцооны зарчмаар нээлттэй, шударга хэрэгжинэ.

Үндсэн үйл ажиллагаа

- Үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнө оролцооны аргыг ашиглан эхний ээлжинд хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэгжих боломж, тохиромжтой эсэхэд дүн шинжилгээ хийнэ (*Зааварчилгаа 1* харна уу).
- Эмзэг бүлгийн мал амьтны боломжит болон бодит хэрэгцээ шаардлагыг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг боловсруулж,олон нийтээр хэлэлцүүлнэ (*Зааварчилгаа 2* харна уу).
- Эмзэг бүлгийнхнийг төлөөллийг оролцуулан зорилтот бүлэг тодорхойлох аргыг сонгож, ашиг хүртэгчдийг тодорхойлно (*Зааварчилгаа 3* харна уу).

Зааварчилгаа

1. **Техникийн дүн шинжилгээ.** LEGS-н бүлэг тус бүрт хэрэгжүүлэхээр сонгосон арга хэмжээ, хувилбарын тохиромжтой байдал, хэрэгжих боломжид дүн шинжилгээ хийх аргачлалыг тусгасан. Үүнд тодорхой техникийн үнэлгээний шалгах асуултууд, давуу сул талыг харуулсан хүснэгт, шийдвэрийн модны загвар, хэрэгжүүлэх зохистой хугацаа, нийтлэг асуудлууд болон Стандарт, Үндсэн үйл ажиллагаа, Зааварчилгаа зэрэг багтсан болно. Эдгээр аргачлал нь тохиромжтой цаг хугацаанд үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхэд тусална. LEGS гарын авлагын төгсгөлд *Хавсралт Е*-д хариу арга хэмжээний хөтөлбөр боловсруулах 5 алхам, хийх аргачлалуудыг хураангуйлан оруулсан.
2. **Зорилтот хүрээг тодорхойлох шалгуур үзүүлэлт.** Зорилтот бүлгийг сонгох шалгуур үзүүлэлтийг олон нийтийн төлөөллийг

оролцуулан боловсруулж, анхдагч үнэлгээгээр олж авсан эмзэг бүлгийн талаарх мэдээллийг тусгах хэрэгтэй. Мал амьтнаас бүрэн хамааралтай амьдардаг ихэнх иргэдийн дунд хөрөнгө чинээ, хүйс болон нийгмийн харилцаанаас хамааран эмзэгт тооцогддог бүлгүүдээ дэмжих орон нутгийн уламжлал, заншил байдаг. Тиймээс орон нутгийн бүлгүүд нь өөрсдийн энэ уламжлалт тогтолцоонд тулгуурлан зорилтот бүлгийг сонгон шалгаруулахад тусалж чадна. Сонгох шалгуур үзүүлэлт нь орон нутгийн нөхцөл байдлаас (хот суурин/хөдөө орон нутаг) хамаарна. Дээрх байдлыг харгалзан бэлэн мөнгө олгох нь үйл ажиллагааны нэг хэлбэр байж болно.

3. **Зорилтот хүрээг тодорхойлох аргачлал.** Ашиг хүртэгчид нарыг сонгох ажлыг ил тод, шударга байлгахын тулд зорилтот бүлгийг тодорхойлох арга хэлбэрийг өргөн хүрээг хамарсан олон нийтийн төлөөллүүд болон эмзэг бүлгүүдээр хүлээн зөвшөөрүүлэх хэрэгтэй. Ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх үүднээс боломжтой бол олон нийтийн уулзалт цуглаан зохион байгуулах хэрэгтэй. Энэ уулзалтаар сонгох шалгуур үзүүлэлтийг тайлбарлаж, сонголтыг шууд хийнэ. Хэдийгээр зарим нийгмийн бүлгийн хувьд нийгэм соёлын хэм хэмжээнээс шалтгаалан олон нийтийн дунд сонголт явуулах нь тохиромжгүй байж болно. Бүх нийтийг хамарсан хавтгайруулсан сонголт эсвэл тодорхой ангилалтай сонголт (хүйс, нас, газарзүйн байрлалаар), хувь хүнд чиглэсэн сонголт болон бусад олон сонголтын төрлүүд байдаг. Ямар ч арга хэлбэрийг ашигласан бай үр ашгийг тэгш бус хүртэхээс сэргийлж хариуцлагатай, ил тод байдлыг хангах зорилгоор зорилтот хүрээг тодорхойлох явцыг тодорхой тайлбарлаж ашиг хүртэгч нийгмийн бүлгүүдийн хяналтан дор явуулах шаардлагатай. Төслийн хэрэгжилтийн явцад сонголтыг дахин шалгах хэрэгтэй бөгөөд эмзэг бүлгүүд төлөвлөгдсөний дагуу хамрагдаж байгаа эсэхийг хянана.

Нийтлэг стандарт 6: Хяналт, үнэлгээ болон амьжиргаанд үзүүлэх нөлөө

Хяналт, үнэлгээ болон амьжиргаанд үзүүлэх нөлөөний дүн шинжилгээг хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгах, боловсронгуй болгох, цаашид явуулах үйл ажиллагаанд сургамж, туршлага болгох зорилгоор явуулдаг.

Үндсэн үйл ажиллагаа

- Үйл ажиллагааны төлөвлөлтийн явцад хяналт, үнэлгээ хийх тогтолцоог цаг алдалгүй бий болгоно (*Зааварчилгаа 1* харна уу).
- Хяналт үнэлгээ явуулах нөхцөл бүрдмэгц ашиг хүртэгчдийн оролцоотойгоор хийнэ (*Зааварчилгаа 2* харна уу).
- Хэрэгжилтийн явцад гарч болох, зайлшгүй өөрчлөх шаардлагатай асуудлыг шуурхай илрүүлэх, сайжруулах зорилгоор байнга, давтамжтай хяналт, үнэлгээ хийнэ (*Зааварчилгаа 3* харна уу).
- Хяналт үнэлгээний тогтолцоо нь үйл ажиллагааны зах зээлд үзүүлж буй нөлөөллийг анхаарах (үйл ажиллагаа нь бэлэн мөнгөнд суурилсан эсвэл бусад төстэй хэлбэрээр ч бай) (*Зааварчилгаа 3* харна уу).
- Хяналтын тогтолцоо нь техникийн үйл явц, түүнээс гарах үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүд тус бүрийг ашиг хүртэгчдээр хийлгэж, хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан, ашиг хүртэгч нар хамтран үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг хэмжиж хянана (*Зааварчилгаа 4* харна уу).
- Үнэлгээг төсөлд тусгагдсан зорилтуудтай харьцуулан хийх бөгөөд үүнийг үйл ажиллагааны болон олон нийтээс тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдийг хослуулан хэмжинэ (*Зааварчилгаа 4* харна уу).
- Үр нөлөөг гамшигт нэрвэгдсэн хүн амын амьжиргаанд гарсан өөрчлөлтөөр үнэлнэ (*Зааварчилгаа 5* харна уу).
- Мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаанд олон төрлийн байгууллага оролцож байгаа нөхцөлд хяналт үнэлгээний тогтолцотг хөтөлбөрийг бүхэлд нь хамарсан байхаар стандартчилж, үр нөлөөг хэмжинэ. Хяналт үнэлгээний тайланг олон нийтийн бүлгүүд болон хэрэгжүүлэгч талууд зэрэг холбогдох бүх хамтран ажиллагсдад өгнө (*Зааварчилгаа 6* харна уу).
- Хяналт үнэлгээний тогтолцоо нь бүх оролцогч талуудын мэдлэг, туршлагад үндэслэгдэнэ (*Зааварчилгаа 7* харна уу).

Зааварчилгаа

1. **Хяналт үнэлгээг нэн тэргүүнд тавих.** Сүүлийн жилүүдэд хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөрийн нэг хэсэг мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаа нь хүмүүсийн амьжиргаанд хэрхэн нөлөөлсөн нь тодорхой бус байсаар байна. Үүний нэг шалтгаан нь мал амьтанд тусламж үзүүлэх төслүүд нь хяналт үнэлгээ хийх талаар анхаарал хандуулаагүй, тааруухан хэрэгжсэн, эсвэл энэ тал дээр санхүүжилт байхгүй байсантай холбоотой юм. Гэнэтийн гамшгийн үед үйл ажиллагааг төлөвлөх явцад хяналт үнэлгээ хийх нь цаг хугацааны хувьд боломжгүй хэдий ч мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагааг ихэвчлэн удаан явцтай эсвэл хавсарсан гамшгийн үед хэрэгжүүлдэг. Иймээс хяналт, үнэлгээ явуулах хангалттай цаг хугацаа байдаг. Хяналт үнэлгээ хийх суурь судалгааг нь өмнөх баримт бичгүүд дээрээс (эмзэг байдлын үнэлгээ гэх мэт) эсвэл оролцооны аргачлалын дагуу асуулга хэлбэрээр хуучин мэдээллүүдийг цуглуулан ашиглаж болно. Хяналт үнэлгээний шалгах асуултуудыг бүлэг тус бүрт хавсралтаар оруулсан байгаа.
2. **Оролцооны аргаар хяналт үнэлгээ хийх.** Нийтлэг стандартад заасны дагуу мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагааны хяналт үнэлгээг оролцооны аргаар хийж болно. Гамшгийн нөхцөл байдлаас хамааран бүрэн оролцоо бүхий хяналт үнэлгээний тогтолцоо бий болгох боломжгүй хэдий ч малчид хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр нөлөөг мэдэрч байдаг тул тэдний хариуцлагыг нэмэгдүүлж, чанартай мэдээлэл цуглуулах үүднээс тэдний оролцоог хангах нь чухал.
3. **Хяналт.** Хяналт тавих нь онцгой байдлын үед мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагааны чухал аргачлал боловч хамгийн сул хэрэгждэг үйл ажиллагааны нэг юм. Энэ нь үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад хэрэгжилт, зарцуулалтыг зорилт, ажлын төлөвлөгөөтэйгээ харьцуулан хянах боломжийг олгодгоос гадна өөрчлөлт хийх шаардлагатай хэсгийг цаг алдалгүй тодорхойлох, үр дүнг сайжруулахад чухал ач холбогдолтой. Жишээ нь мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааны үед (зарж борлуулах эсвэл нядлах аль ч тохиолдолд) эмзэг байдлыг нэмэгдэх эрсдлээс сэргийлэх үүднээс малын үнэ ханшийг хянаж байх шаардлагатай. Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхэд нийгмийн эрүүл мэндийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн заалтууд

болох хүрч болохуйц, хүртээмжтэй, худалдан авч чадахуйц, хүлээн зөвшөөрөгдсөн болоод чанартай гэсэн шаардлагуудыг малын эрүүл мэнд дээр ч мөн хэрэгжүүлж болно. Хяналтын тогтолцоо нь малын өвчний тохиолдлын мэдээллийг багтаавал энэ нь өвчний тандан судалгаанд хувь нэмэр оруулна. Малжуулах үйл ажиллагааны үр дүнг үнэлэхийн тулд малын ашиг шимийн үзүүлэлт, сүргийн бүтцийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий суурь судалгаа, хяналтын тогтолцоо шаардлагатай байдаг. Учир нь бэлэн мөнгө тараахтай холбоотой арга хэмжээнүүд нь орон нутгийн зах зээлд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг учраас тухайн зах зээл дэх гол нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг үнэлгээ хийхдээ харгалзана. Хяналтын нэгдсэн тайлан мэдээ нь хандивлагчид, засгийн газар болон ашиг хүртэгч иргэд ба холбогдох байгууллагуудад маш чухал хэрэгтэй байдаг учраас үнэлгээ хийхэд хэрэгцээт мэдээлэлийн эх үүсвэр болдог.

4. **Орон нутгийн хяналт үнэлгээний үзүүлэлтүүд.** Хяналт үнэлгээг оролцооны аргаар хийхдээ орон нутгийн иргэдийн өөрсдийнх нь баримталдаг малаас авах ашиг шимийн үзүүлэлтийг ашиглаж болно. Үүнийг төслийн үйл ажиллагааны хяналтын мэдээлэлтэй нэгтгэхэд тухайн хэрэгжүүлсэн төслийн үр дүн тодорхой харагдана.

5. **Амьжиргааны үр нөлөө.** Онцгой байдлын үед мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаанд үнэлгээ хийхдээ зөвхөн үйл ажиллагааны хэрэгжилт, зорилтуудаа биелүүлсэн эсэхэд анхаарлаа хандуулж, мал эд хөрөнгө, амьжиргаанд үзүүлсэн нөлөөг орхигдуулах хандлагатай байдаг. Хэрэв төслийн зорилтууд нь хүмүүсийн амьжиргаанд гарсан өөрчлөлтийг хамруулаагүй бол, үнэлгээ нь түүний үр нөлөөг дутуу дүгнэх магадлалтай. Амьжиргаанд үзүүлсэн үр нөлөө гэдэг нь эмзэг бүлгийн малын гаралтай бүтээгдэхүүний хэрэглээ, мал болон бүтээгдэхүүнээ зарж борлуулснаар олсон орлого, малаас авах ашиг шим эсвэл малаа бэлэглэх, зээлэх зэргээр ашиглах зэрэг нийгмийн шинжтэй ашиг хүртсэн мэдээллүүд багтана. Үр нөлөөг тодорхойлох үнэлгээ нь төслийн зүгээс дээрх үр ашгийг бууруулсан эсвэл нэмэгдсэнээр тодорхойлогдоно. Оролцооны аргаар үр нөлөөг үнэлэх нь үр дүнд нөлөөлж, ашиг хүртэгчдийн мэдлэг нэмэгдсэнээр дараагийн төслийн төлөвлөлтөд оролцох оролцоог хангана.

6. **Аргачлалуудын уялдаа холбоо.** Олон төрлийн байгууллагуудыг

хамруулсан хөтөлбөрийн хяналт үнэлгээг хийхдээ стандартчлагдсан, зохицуулалтын аргачлалыг ашиглах нь хөтөлбөрийн бүхий л хүрээг хамарсан туршлагыг бий болгоно. Стандарчлагдсан аргачлал нь бүх байгууллагуудын үндсэн зорилтууд, нийтлэг тохиолддог аргачлалд тулгуурлах бөгөөд олон нийтийн тодорхойлсон үзүүлэлтүүдийг өөр өөр газруудад хэрэглэх боломжтой уян хатан байна.

7. **Сургамж.** Онцгой байдлын үед үйл ажиллагаа хэрэгжүүлдэг байгууллагууд нь алдаагаа давтах, сургамж авахгүй байх тохиолдол гардаг (жишээг ProVention, 2007-с харж болно). Энэхүү асуудлыг шийдэхэд бүх хамтран ажиллагч талууд онцгой байдлын үед хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа хяналт, үнэлгээг үр дүнтэй зохион байгуулахад цаг хугацаа, хүч хөдөлмөрөө зарцуулж, туршлагаа хуваалцах нь асуудлыг шийдвэрлэхэд тус нэмэр болдог. Хяналт үнэлгээний тогтолцоо нь баримт мэдээлэлийг харилцан солилцох, хариу арга хэмжээний арга техникийн талаар (бодит нөхцөл байдлын үнэлгээ гэх мэт), бие биеэсээ суралцах боломжтой байна. Хяналт үнэлгээний мэдээлэл нь онцгой байдлын үед амьжиргааг дэмжихэд чиглэсэн хариу арга хэмжээ хэрэгжүүлэхэд саад учруулж буй асуудлыг тодорхойлоход хэрэг болдог. (*Нийтлэг стандарт* 7).

Нийтлэг стандарт 7: Бодлого болон нөлөөлөл

Онцгой байдлын хариу арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, болон нэрвэгдсэн хүн амын амьжиргааг дэмжих үйл ажиллагааг явуулахад саад учруулж буй бодлого, журмыг тодорхойлж, анхаарал хандуулах

Үндсэн үйл ажиллагаа

- Үндсэн эд хөрөнгө болох мал амьтныг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээхэд нөлөөлж буй бодлогын асуудлыг тодорхойлох (*Зааварчилгаа1* харна уу).
- Бусад оролцогч талуудтай хамтран холбогдох түвшинд дэмжлэг үзүүлэх эсвэл бусад төрлийн үйл ажиллагаагаар (орон нутгийн, үндэсний, бүсийн эсвэл олон улсын) дамжуулан холбогдох бодлогын асуудлыг олж тогтоох (*Зааварчилгаа 2* харна уу).
- Бодлогын дүн шинжилгээ хийж гамшгийн эмзэг байдалд нөлөөлж

байгаа гол шалтгааныг илрүүлэх (*Зааварчилгаа 3* харна уу).

- Хяналт, үнэлгээний тогтолцоо нь бодлогын хэлэлцүүлэг, дэмжлэг үзүүлэх ажилд шууд нөлөөлөхөд баримт болдог (*Зааварчилгаа 4* харна уу).
- Мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаанд нөлөөлөл үзүүлэхдээ уур амьсгал, хүрээлэн буй орчны өөрчлөлт зэргийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр дурьдан ашиглах (*Зааварчилгаа 5* харна уу).

Зааварчилгаа

1. **Бодлогын саад бэрхшээлд дүн шинжилгээ хийх.** Бодлогын саад бэрхшээл нь амьжиргаанд тулгуурласан онцгой байдлын үйл ажиллагааны хэрэгжилтэд хүндрэл учруулах эсвэл үр дүн болон үр нөлөөг нь хязгаарладаг. Тиймээс эдгээр бэрхшээлийг гамшгийн хариу арга хэмжээний Анхдагч үнэлгээгээр илрүүлэн гаргаж ирэх нь чухал ач холбогдолтой. Үүнд: Нэгдүгээрт, төлөвлөсөн үйл ажиллагаанууд нь бодитой, хэрэгжих боломжтой байх, Хоёрдугаарт, холбогдох байгууллагууд, хамтран ажиллагсдын зүгээс үүсч болох асуудлуудыг тодорхойлох. LEGS-н Бүлэг 3 (*Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох*) дахь нөхцөл байдлын үнэлгээний шалгах асуултад онцгой байдлын үед мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нөлөөлөх бодлого журам байгаа эсэхийг олж тогтоох асуултууд багтсан. Малын шилжилт хөдөлгөөнийг хорих, экспортын хориг, нядалгааны тухай хууль, зөвшөөрлийн журмууд, татварын бодлого, тусламжийн байгууллагуудын үйл ажиллагааны сул уялдаа холбоо, хүн болон малын хил дамжих нүүдэл, гамшгийн менежментийн үндэсний бодлого, гол хамтран ажиллагч байгууллагын дотоод дүрэм журам зэргийг авч үзэх хэрэгтэй.
2. **Бодлогын асуудалд нөлөөлөх.** Хүний эрхэнд тулгуурласан гамшгийн эсрэг болон хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа байгууллагын тоо өсөн нэмэгдэж байгаагийн хэрээр гамшгийн эсрэг хариу арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх сонирхол нэмэгдэж байна. Гэхдээ дээрх асуудлыг гамшигт өртсөн иргэдийн өмнөөс эсвэл тэдэнтэй хамтарч ажиллах чадвар нь тэдний үйл ажиллагаа явуулж байгаа орчноос ихээхэн хамаарна. Бодлогын өөрчлөлт бол урт хугацааны үйл явц бөгөөд онцгой нөхцөл байдлын

үед хэрэгжүүлэх зүйлсийг хязгаарлалт болж байж болох талтай (*Зааварчилгаа 3* харна уу). Зарим мөргөлдөөний үед засгийн газар болон эрх баригчдын зүгээс иргэд, босогчдын бүлэг болон сөрөг хүчнийхний дарамт, шахалт үзүүлэх бодлого нь засгийн газрын үйл ажиллагааны нэг хэсэг байдаг. Ийм тохиолдолд засгийн газарт нөлөөлөх гэсэн оролдлого үр дүнгүй байх бөгөөд түүнийг санаачилсан этгээдэд аюул учруулж болно. Нөлөөлөл явуулж байгаа тохиолдолд янз бүрийн хамтран ажиллагч талуудтай (санхүүжүүлэгч, үндэсний болон олон улсын хэрэгжүүлэгч байгууллагууд, иргэний нийгэм) харилцан уялдаатай ажиллах нь чухал.

3. **Суурь шалтгаан.** Мал аж ахуй эрхлэгчдийн амьжиргааг дэмжих нь гамшгийн эсрэг арга хэмжээ болохоос гадна гамшгаас үүдэлтэй эмзэг байдлыг нэмэгдүүлдэг эсвэл түүнд нөлөөлж буй урт хугацааны улс төрийн болон нийгмийн зохион байгуулалтын хүчин зүйлсийг олж тодорхойлох нь чухал. Ингэснээр гамшгийн эсрэг хариу арга хэмжээг бодлогын хүрээнд урт хугацаанд хэрэгжүүлэх боломж бүрдэх бөгөөд гамшгийн менежментийг үр дүнтэй явуулах, амьжиргааг дэмжин ажиллахад чухал ач холбогдолтой.

4. **Хяналт ба үнэлгээний баримт нотолгоо.** Хяналт үнэлгээний мэдээллийг амьжиргаанд тулгуурласан онцгой байдлын хариу арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэхэд мэдээлэл болгон ашиглана. Иймд хяналт, үнэлгээг төлөвлөхдөө түүнийг хэрхэн ашиглах талаар анхааран үзнэ.

5. **Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөл үзүүлэхэд нээлттэй хандах.** Малчдын хувьд уур амьсгалын өөрчлөлт нь чухал ач холбогдолтой зүйл гэж үздэг хандлага байх ба энэ нь магадгүй нэг талыг барьсан хандлага байх магадлалтай. Энэ нь дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж буй олон төрлийн уур амьсгалын хүчин зүйлс, бүс нутгийн төлөв байдал, өөр хүчин зүйлээс үүдэлтэй эрүүл мэндийн асуудал зэргийг ялган ойлгохгүй байдалд хүргэдэг. Хэрэгжүүлэгч байгууллагууд нь мал аж ахуй эрхлэгчдэд уур амьсгалын талаарх ойлголтыг шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбарлаж, гарах үр дагаврыг ил тод нээлттэй ойлгуулах хэрэгтэй.

Нийтлэг стандарт 8: Уялдаа холбоо

Мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанууд нь амь нас, амьжиргааг аварч хамгаалах гэсэн хүмүүнлэгийн зарчимд тулгуурлан хэрэгждэг ч ямар ч тохиолдолд хүний амь насыг аврах яаралтай үйл ажиллагаанд саад учруулж болохгүй.

Үндсэн үйл ажиллагаа

- Мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд байгууллага хоорондын арга барил нэгдмэл байж, хүлээн зөвшөөрсөн стратегийн дагуу ажиллана (*Зааварчилгаа 1* харна уу).
- Тухайн байгууллага мал сүрэгт үнэлгээг хийх боломжгүй, хэрэгцээтэй хариу арга хэмжээг авч чадахгүй тохиолдолд үүнийгээ хэрэгжүүлэх чадавхи бүхий бусад байгууллагад мэдэгдэж, гүйцэтгүүлэх (*Зааварчилгаа 2* харна уу).
- Хүмүүсийн амь нас эрсдэлд байгаа газарт мал амьтанд чиглэгдсэн арга хэмжээ нь хүний амийг аврах хүмүүнлэгийн ажилд саад учруулах ёсгүй (*Зааварчилгаа 3* харна уу).
- Боломжтой бол дундын нөөц бололцоогоо бүрэн ашиглаж, үр нөлөөг нэмэгдүүлэх үүднээс мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагааг хүмүүнлэгийн бусад тусламжтай хамтатган гүйцэтгэх (*Зааварчилгаа 4* харна уу).
- Мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаа нь ашиг хүртэгчдийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх, амьжиргаанд аюул учруулах ёсгүй (*Зааварчилгаа 5* харна уу).
- Онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах болон урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхийн аль алинд нь хандивлагч, засгийн газрын зорилтыг тусгаж хамтран ажиллагч талууд хамтран ажиллана (Зааварчилгаа 6 харна уу).

Зааварчилгаа

1. **Уялдаа холбоо.** Нийгмийн тодорхой болон эмзэг бүлгийн хүмүүст үзүүлэх тусламжийн ажлууд нь мал амьтанд чиглэгдсэн онцгой байдлын хариу арга хэмжээтэй уялдсан байх нь чухал. Хэрэв өөр өөр байгууллагууд янз бүрийн тусламж үзүүлж байгаа бол тэдгээрийг хооронд нь давхцуулахгүйгээр чухал хэрэгцээт тусламжийг

орхигдуулахгүй хэрэгжүүлэх шаардлагатай. Хэрэв тэжээл, ус, эрүүл мэндийн үйлчилгээг зэрэг үзүүлэх шаардлагатай бөгөөд аль нэгийг нь орхигдуулбал энэ нь бусад үйл ажиллагааныхаа үр дүнг бууруулах эрсдэлтэй. Жишээ нь малд тэжээл, ус өгсөн ч өвчнөөр хорогдох магадлалтай. Өөр өөр байгууллагууд ижил төрлийн тусламж үзүүлж буй тохиолдолд хэрэгжүүлж буй арга хэмжээг хооронд нь уялдуулан зохицуулах нь чухал. Жишээ нь хөрш зэргэлдээ газар нутагт мал амьтны тоо толгойг бууруулах хөтөлбөрийн хүрээнд худалдан авах үнийг ялгаатай тогтоох эсвэл малжуулах ажлыг янз бүрээр (үнэгүй, зээл, урамшуулал гэх мэт) хэрэгжүүлбэл бие биенийхээ ажлыг үгүйсгэдэг. Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхдээ төлбөрийн өөр өөр хэлбэр мөрдвөл энэ нь үйл ажиллагааны эрчийг сулруулж, ашиг хүртэгчдийн дунд төөрөгдөл үүсгэнэ. Ган зуд зэрэг гэх мэт удаан явцтай гамшгийн үед шат бүрт оновчтой үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ. (Техникийн бүлэг бүрийн төгсгөлд үйл ажиллагааг хэрэгжүүлэх зохистой хугацааг харуулсан байгаа.).

2. **Чадвар, мэдлэг туршлага.** Тодорхой газар нутагт амьжиргааг дэмжих мал сүргийн үнэлгээ, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх нь өөрийн гэсэн онцлогтой бөгөөд байгууллага бүрт энэ төрлийн мэдлэг, туршлага тэр болгон байдаггүй. Иймээс хангалттай мэдлэг туршлагагүй бол бусад байгууллагаас тусламж авах хэрэгтэй

3. **Хүмүүнлэгийн нэн тэргүүний зорилтууд.** Онцгой байдлын үед нэрвэгдсэн хүн амын амь насыг нь авран хамгаалах тусламж үзүүлэх нэн тэргүүний ажиллагаа байдаг. Энэхүү тусламж нь ямар нэгэн саадгүй хэрэгжих шаардлагатай бөгөөд мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаа нь ямар нэг байдлаар сөргөөр нөлөөлж болохгүй. Онцгой байдлын үеийн тээвэрлэлт, харилцаа холбоо болон бусад нөөц бололцоо хязгаарлагдмал үед мал амьтанд туслах багийнхан өөрт байгаа хоол хүнс, ус, байр болон эмнэлгийн үйлчилгээг шаардлагатай байгаа хүмүүст нэн түрүүнд өгөх хэрэгтэй. Жишээ нь усаар хангах үйл ажиллагаа нь хүн ам, мал амьтныг зэрэг хангах эсвэл усыг чанараар ангилж түгээнэ.

4. **Нэгдсэн арга хэмжээ ба нөөц хуваарилах** Ихэнх хүмүүнлэгийн тусламжийн үед олон төрлийн үйл ажиллагаа зэрэг явагддаг. Хамтарсан хөтөлбөрийг үр дүнтэй болгох, нөөцийг оновчтой хуваарилах, бусад салбаруудтай хамтран ажиллахын тулд зохицуулалтыг сайн хийх хэрэгтэй (бүлгийн төгсгөл дэх *Жишээ*

судалгаа 2.1 болон *2.2*). Иймд байгаа нөөцөө дээд зэргээр ашиглах үүднээс мал амьтанд чиглэгдсэн арга хэмжээг бусад салбарын үйл ажиллагаатай уялдуулах шаардлагатай. Жишээ нь тусламжийн бараа хүргээд буцаж байгаа ачааны машиныг ашиглан мал амьтны тоо толгойг бууруулах хөтөлбөрт хамрагдсан мал амьтныг ачих, хүн, мал амьтны эм, бэлдмэлийг хөргөгчид хамт хадгалах, хүмүүст зориулан барьсан сууцны хаягдлаар малын хашаа хороо барих гэх мэт.

5. **Аюул учруулахгүй байх.** Онцгой байдлын үед хэрэгжүүлж байгаа амьжиргааг дэмжих хөтөлбөр нь хүний амь нас аврах ажиллагаанд ямар нэгэн аюул учруулж болохгүй. Эдгээрт амьжиргаа, зах зээл болон үйлчилгээ зэрэгт ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй мөн ашиг хүртэгчдийн аюулгүй байдлыг эрсдэлд оруулахгүй, нийгмийн тэгш бус байдлыг тогтворгүй болгож болохгүй.

6. **Уялдаа холбооны дэс дараалал.** Туршлагаас харахад хэрэгжүүлэгч байгууллага, санхүүжүүлэгч болон засгийн газрын хоорондын уялдаа холбоо нь үр дүнтэй хүмүүнлэгийн тусламж үзүүлэхэд чухал үүрэгтэй байх хэдий ч энэ нь оролцогч бүрээс ихээхэн цаг хугацаа, хүн хүч шаардаж байдаг. Санхүүжүүлэгч болон засгийн газар нь хэрэгжүүлж буй онцгой байдлын арга хэмжээнийхээ үр дагавар, амьжиргаатай хэрхэн холбогдох талаар сайн ойлголттой байх хэрэгтэй. НҮБ-н багцын тогтолцоо эсвэл түүнтэй төстэй үндэсний хэмжээний хэрэгжүүлэгч байгууллага нь энэхүү уялдаа холбоог хангах ажлыг хариуцдаг. Тухайн бүс нутагт болон гамшгийн үед тодорхой чиглэлээр дагнасан ажлын бүлэг байгуулах нь хэрэгжүүлэх арга хэмжээг уялдуудах, үүрэг хариуцлагаа ойлгох, амьжиргааг дэмжиж буй хөгжлийн хөтөлбөрүүдийг уялдуулж, нэгдмэл үйл ажиллагаанд дэмжлэг болно (*Жишээ судалгаа 2.1*). Санхүүжүүлэгч байгууллагууд нэгдсэн арга хэмжээ хэрэгжүүлэхийг шаардах хэрэгтэй.

Нийтлэг стандартыг хэрэгжүүлсэн ***жишээ судалгаа***

*2.1 Үйл явцын жишээ судалгаа: Кени улсад хэрэгжсэн мал амьтныг нядалж тоо толгойг бууруулах төслийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангасан байдал***

2005 оны эхээр Кенийн Туркана хотод Белгийн VSF ТББ мал амьтан борлуулах зах зээлийг бий болгох, мөн зорилтот бүлгийг хүнс тэжээлээр хангах зорилгоор мал амьтны тоо толгойг бууруулах төслийг хэрэгжүүлсэн. VSF төслийг хэрэгжүүлэхэд засгийн газрын дүүрэг хариуцсан албад болон мал амьтанд үйлчилгээ үзүүлдэг хэд хэдэн талуудтай хамтран ажилласан бөгөөд эдгээр нь үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал уялдаа холбоо болсон байна.

Турканагийн малчдаас хувийн худалдаачид ямааг тохиролцсон үнийн дагуу худалдан авч дүүргүүд дэх сургууль болон эрүүл мэндийн төвүүдэд тараасан. Малчид төслөөс борлуулалтын 20 хувьтай тэнцэх хэмжээний төлбөрийг нөхөж авчээ. Үүний үр дүнд 2500 – 3000 малчдын 6000 гаруй ямааг 300 гаруй худалдаачид болон 100 орчим, эмнэлэг, сургуулиудад түгээжээ. Гэхдээ хэрэгжилтийн үед хэд хэдэн сорилтуудтай тулгарсан байна. Үүнд:

- бүх худалдаачдын дунд хүлээн зөвшөөрөгдсөн үнийг тогтоох
- худалдаачдын зүгээс тавигдаж байсан ашиг бага, банкны төлбөр өндөр болон тэжээлийн зардал гэх мэт асуудлууд
- эмзэг бүлгийн болон алс нутагласан малчдыг зах зээлтэй холбох
- олноор ирж буй ямааг (ирсэн өдрөө нядалгаанд орох ёстой) хаших хашаа саравч хангалтгүй
- байгууллагууд махыг хоол хүнсэндээ шууд хэрэглэхийн оронд өөр уургийн бүтээгдэхүүнээр сольж хэрэглэх гэсэн хандлагууд.

Хэдийгээр малчдыг оролцуулсан үйл ажиллагаанд бэрхшээл тулгарсан хэвээр байсан ч хэрэгжүүлэгч байгууллагуудын дундах эерэг хамтын ажиллагаа, уялдаа холбоо нь төслийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. (Эх сурвалж: Watson and van Binsbergen, 2008).

2.2 Үр нөлөөний жишээ судалгаа: Өмнөд Судан дахь хавсарсан гамшгийн үед урт хугацааны оролцоо болон уялдаа холбоо

1993 – 2000 онд удаан хугацааны зөрчил мөргөлдөөн үргэлжилж байсан Өмнөд Суданд НҮБ-н Олон Улсын Хүүхдийг Ивээх Сан болон Туффс их сургууль хамтран мал амьтанд чиглэгдсэн өргөн хүрээтэй хөтөлбөр хэрэгжүүлсэн юм. 600,000 гаруй км газар нутаг, 10 сая гаруй малыг хамруулахыг зорьсон бөгөөд Суданы Иргэдийн тэгш эрхийн төлөөх хөдөлгөөн болон 12 төрийн бус байгууллагатай түншлэн ажилласан. Эдгээр түншүүд хамтран олон нийтэд суурилсан малын эрүүл мэндийн тогтолцоо, өөр өөр орон нутагт хэрэгжүүлэх төслийн төлөвлөлт, хэрэгжилт болон хяналтын зааврыг бий болгосон. Үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо гол цөм нь байсан бөгөөд олон нийттэй хамтран ажилладаг төрийн бус байгууллагууд орон нутагт тохиолддог малын өвчнийг эрэмбэлэх, олон нийтэд суурилсан малын эрүүл мэндийн ажилтнаар бэлтгэх хүмүүсийг сонгох, хөтөлбөрийн үйл ажиллагааг оролцооны аргачлалаар үнэлэх зэрэг үйл ажиллагаа зохион байгуулсан. Мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаанд ерөнхий хяналт тавьж байхаар орон нутгийн мал эмнэлгийн зохицуулах зөвлөлийг байгуулжээ. Төслийн хугацаанд 150 гаруй мал эмнэлгийн зөвлөх, зохицуулагчаар удирдуулсан 1500 гаруй олон нийтэд суурилсан малын эрүүл мэндийн ажилтан мөн 40 мал эмнэлгийн мэргэшсэн ТББ-н ажилтан бэлтгэгдсэн. Энэхүү малд чиглэсэн хөтөлбөрийн сайн зохицуулалт, олон нийтийн оролцоо, хичээл зүтгэлийн үр дүнд өмнөд Судан дахь үхрийн мялзанг устгаж чаджээ. 1993 онд энэхүү оролцооны аргачлал танилцуулагдахаас өмнө жил бүр 140,000 гаруй үхэр мялзангийн эсрэг вакцинжуулалтад хамрагддаг байв. 1993 оноос хойш, вакцины хамрах хүрээ 10.6 дахин нэмэгдэж, вакцинд хамрагдсан малын тоо 1993 онд 1.48 сая, 1994 онд 1.78 саяд тус тус хүрсэн юм. 1998 оноос хойш өмнөд Суданд үхрийн мялзангийн тохиолдол дахин бүртгэгдээгүй байна (Эх сурвалж: Leyland, 1996; Jones et al., 2003).

2.3 Үйл явцын жишээ судалгаа: Өмнөд Этиоп дахь уялдаа холбоо болон бэлэн байдлын төлөвлөлт

Өмнөд Этиопид Хүмүүнлэгийн болон хөгжлийн тусламж үзүүлэгч Католик байгууллага (Cordaid) өмнөд Омо дахь эрсдлийн менежментийн төслийг хэрэгжүүлэхээр орон нутгийн ТББ болон Этиопын Нүүдэлчдийн судалгаа, хөгжлийн байгууллагатай (EPaRDA) хамтран ажилласан. Тухайн нутгийн өмнөх түүхээс харахад удаан явцтай ган эсвэл гэнэтийн үер зэрэг онцгой байдал аль нь ч үүсэх магадлалтай байсан учраас болзошгүй байдлын төлөвлөгөө боловсруулж, үр дүнтэй хариу арга хэмжээг цаг

алдалгүй авахад шаардагдах санхүүгийн тогтолцоог бий болгожээ. 2006 оны наймдугаар сард өмнөд Суданы Омо гол эргээсээ даван үерлэж 14 тосгон үерт автсан. Энэ үер нь орон нутгийн иргэд болон засгийн газрын хувьд маш гэнэтийн тохиолдол болж, 363 хүн амиа алдаж, 3,200 мал хорогдсон. 21,000 гаруй хүн гэр орноо алдсан бөгөөд олон тооны иргэдийн ургац, тариалан сүйрсэн байна.

Бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу бусад байгууллагуудтай хамтран гамшгийн хариу арга хэмжээг хэрэгжүүлсэн. Cordaid, EP-aRDA болон FarmAfrica хамтран хүмүүст зориулсан хоол хүнс, байр сууцаар хангах үйл ажиллагаатай хамт малын эрүүл мэнд болон тээвэр зохицуулалтыг дэмжих зэргээр мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлжээ. Дүүргийн захиргаанаас мал эмнэлэг, хүний эрүүл мэнд, тээвэр зууч болон тусламжийн бараа түгээлт зэрэг асуудлуудыг хариуцсан дүүргийн захирагчаар ахлуулсан онцгой байдлын хороог байгуулсан бөгөөд энэхүү хороо нь энэхүү Ерөнхий зохицуулах хороонд мэдээлэх үүрэгтэй ажиллажээ.

Cordaid болон бусад түншүүд нь малын эрүүл мэндийн онцгой байдлын хороотой хамтран ажилласан. Хороо нь өдөр тутмын үйл ажиллагаагаа ерөнхий хороонд танилцуулж, мал эмнэлгийн ажилчдыг шилжүүлэх, нийтийг хамарсан вакцинжуулалт, эмчилгээг зохион байгуулах зэрэг мал амьтанд чиглэгдсэн бүхий л үйл ажиллагааг зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээндээ бүх оролцогч талуудыг хамруулсан нь ажил үйлчилгээ давхардал гаргалгүй зохион байгуулжээ. (Эх сурвалж: Cordaid, 2006).

2.4 Үр нөлөөний жишээ судалгаа: Эритреаний эргэн ирсэн дүрвэгсэдийн амьжиргаа, оролцоо болон илжиг тараасан тухай

1991 оны Эритреан–Этиопын зөрчилдөөн шийдэгдсэний дараа ойролцоогоор 500,000 Эритреан дүрвэгсэд зүүн Суданд амьдарч байв. Дүрвэгсдийг эх оронд нь буцаан авчрах ажлыг Эритреаний засгийн газар, НҮБ-н байгууллагууд хамтран эхлүүлсэн бөгөөд Эритреанд эргэн ирж, суурьших хөтөлбөрийг (PROFERI) боловсруулжээ. PROFERI хөтөлбөрийн туршилтын шатанд 4,500 дүрвэсэн өрхийг (25,000 орчим хүн) буцаан авчрах зорилт тавьсан бөгөөд байр сууц, хоол хүнс, ус, эмнэлгийн үйлчилгээ, сургууль, сайжруулсан зам болон үр будаа, багаж хэрэгсэл, мал амьтнаар хангах тусламжийг санал болгосон.

Ойролцоогоор 420 ам долларын үнэ бүхий хэд хэдэн төрлөөс бүрдсэн сүрэг малыг өрх бүрт олгосон. *Хүснэгт* 2.1-т олгогдсон малын төрөл, тоог харуулав. PROFERI төслийг боловсруулах үеэр, Суданд байсан Эритреаний дүрвэгсэдтэй холбоо тогтоох боломж бага байсан учраас тэдэнд ямар төрлийн мал илүү хэрэгтэй болох талаар мэдээлэл бараг байгаагүй. Ийнхүү ашиг хүртэгчдийг оролцуулах боломж дутмаг байсан тул тэдгээрийн гэр бүлтэй ярилцлага хийж хэрэгцээ шаардлагыг нь судалжээ. Энэ үйл ажиллагааны үр дүнд сонгогдсон малын бүтцэд нилээд өөрчлөлт оруулж тэр тусмаа илжиг болон бог малын тоо ихээр нэмэгдсэн. Цөөн тооны бод мал авах хүсэлт байсан бөгөөд илжигний тоо 6 дахин нэмэгдсэн. Хийгдсэн ярилцлагууд болон төслийн хяналтын үр дүнгээр илжиг нь малынхаа хувьд ч тээврийн хэрэгслийн хувьд ч илүү ач холбогдолтой байдаг нь тогтоогдсон. Хүмүүс тэднийг захаас хэрэгтэй бараагаа зөөх, ус түлээнд явахдаа болон хувийн уналгандаа ашигладаг байна.

Буцан ирсэн дүрвэгсдийн дунд өрхүүдийн 80 хувь нь тэдэнд олгосон мал амьтан тэр дундаа илжигийг хамгийн их үр шимээ өгч байгаа гэжээ. Илжиг нь харьцангуй хямд үнэтэй, хариулахад хялбар, бусад малыг бодоход өвчлөлд өртөх нь бага байдаг (Эх сурвалж: Catley and Blakeway, 2004; Hamid, 2004). Энэ жишээ нь ашиг хүртэгчдийг мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагааны төлөвлөлтөнд оролцуулах, мөн LEGS-н гол стандарт болох Оролцоо ямар чухал ач холбогдолтойг тодорхой харуулж өгсөн.

Хүснэгт 2.1 PROFERI төслөөс дүрвэгсдийн хүссэн малын тоо толгойн задаргаа

Мэдээллийн эх сурвалж	500 өрх дутамд олгогдох малын тоо					
	Тэмээ	Илжиг	Үхэр	Одос	Хонь	Ямаа
PROFERI төслийн төлөвлөлт	50	50	100	150	1000	1000
Ашиг хүртэгч өрхүүдтэй хийсэн ярилцагаар(n=2090)	38	313	79	12	2060	1724

Ашигласан хэвлэл ба цаашид уншиж судлах материал

Albu, M. (2010) Emergency Market Mapping and Analysis Toolkit, Practical Action Publishing, Rugby.

ALNAP (Active Learning Network for Accountability and Performance in Humanitarian Action) (2003) ALNAP Annual Review 2003, Humanitarian Action: Improving Monitoring to Enhance Accountability and Learning, ALNAP, London, <http:// www.alnap.org/resource/5198.aspx> [accessed 20 May 2014].

ALNAP (2006) Review of Humanitarian Action in 2005, Evaluation Utilisation, Global Welfare: A Realistic Expectation for the International Humanitarian System? ALNAP, London, <http://www.alnap.org/resource/5223> [accessed 19 May 2014].

Barrett, C.B., Bell, R., Lentz, E.C. and Maxwell, D.G. (2009) "Market information and food insecurity response analysis", Food Security 1: 151–168 <http://dx.doi. org/10.1007/s12571-009-0021-3>.

Benson, C. and Twigg, J. with Rossetto, T. (2007) Tools for Mainstreaming Disaster Risk Reduction: Guidance Notes for Development Organisations, ProVention Consortium, Geneva, <http://www.preventionweb.net/english/professional/ publications/v.php?id=1066> [accessed 14 May 2014].

Catley, A. and Blakeway, S. (2004) "Donkeys and the provision of livestock to returnees: lessons from Eritrea", in P. Starkey and D. Fielding (eds), Donkeys, People and Development: A Resource Book of the Animal Traction Network for Eastern and Southern Africa (ATNESA), pp. 86–92, Technical Centre for Agricultural and Rural Cooperation, Wageningen, The Netherlands, <http://www.atnesa.org/donkeys/ donkeys-catley-returnees-ER.pdf> [accessed 14

May 2014].

Catley, A., Leyland, T. and Bishop, S. (2008) "Policies, practice and participation in protracted crises: the case of livestock interventions in South Sudan", in

L. Alinovi, G. Hemrich and L. Russo (eds), Beyond Relief: Food Security in Protracted Crises, pp. 65–93, Practical Action Publishing, Rugby.

Cordaid (2006) Ethiopian Partners Emergency Report, Cordaid, Addis Ababa. CPWG (Child Protection Working Group) (2012) Minimum Standards for Child

Protection in Humanitarian Action, CPWG, Geneva, <http://cpwg.net/ minimum-standards> [accessed 14 May 2014].

Emergency Capacity Building Project (2007) Impact Measurement and Accountability in Emergencies: The Good Enough Guide, Oxfam, Oxford.

FAO/WFP (Food and Agriculture Organization of the United Nations/World Food Programme) (undated) Passport to Mainstreaming a Gender Perspective in Emergency Situations: Key Analytical Questions for Designing Gender-Sensitive Humanitarian Interventions, Socio-Economic and Gender Analysis Programme (SEAGA), FAO/WFP, Rome, <http://www.livestock-emergency.net/userfiles/file/ assessment-review/FAO-WFP.pdf>[accessed 14 May 2014].

Goe, M.R. (2005) Livestock Production and HIV/AIDS in East and Southern Africa, [Working Paper], FAO, Rome, <http://www.livestock-emergency.net/userfiles/ file/assessment-review/Goe-2005.pdf> [accessed 15 May 2014].

Gosling, L. and Edwards, M. (2003) Toolkits: A Practical Guide to Planning, Monitoring, Evaluation and Impact Assessment, Save the Children, London.

Hallam, A. (1998) Evaluating Humanitarian Assistance Programmes in Complex Emergencies, Good Practice Review No. 7, Humanitarian Practice Network, Overseas Development Institute (ODI), London, <http://www.odihpn.org/ documents/gpr7.pdf> [accessed 15 May 2014].

Hamid, E. (2004) "The importance of donkeys in a restocking programme in Eritrea", in P. Starkey and D. Fielding (eds), Donkeys, People and Development: A Resource Book of the Animal Traction Network for Eastern and Southern Africa (ATNESA), pp. 84–85, Technical Centre for Agricultural and Rural Cooperation, Wageningen, The Netherlands, <http://www.atnesa.org/donkeys/donkeys- ezedeen-restocking-ER.pdf> [accessed 14 May 2014].

HAP (Humanitarian Accountability Partnership), Editorial Steering Committee (2007) Standard in Humanitarian Accountability and Quality Management, HAP- International, Geneva, <www.hapinternational.org/> [accessed 25 June 2014]. Harvey, P. (2004) HIV/AIDS and Humanitarian

Action, Humanitarian Policy Group (HPG) Report 16, ODI, London, <http://www.odi.org.uk/sites/odi.org.uk/files/odi-assets/publications-opinion-files/283.pdf> [accessed 19 May 2014].

Herson, M. and Mitchell, J. (2005) "Real-time evaluation: where does its value lie?", in Humanitarian Exchange Magazine, Issue 32, December 2005, Humanitarian Practice Network, ODI, London, <http://www.odihpn.org/humanitarian- exchange-magazine/issue-32/real-time-evaluation-where-does-its-value-lie> [accessed 15 May 2014].

IASC (Inter-Agency Standing Committee) (2006) Women, Girls, Boys and Men: Different Needs – Equal Opportunities, Gender Handbook in Humanitarian Action, IASC, Geneva, <http://www.humanitarianinfo.org/iasc/documents/ subsidi/tf_gender/IASC%20Gender%20Handbook%20(Feb%202007).pdf> [accessed 15 May 2014].

ICRC (International Committee of the Red Cross) (2013) Professional Standards for Protection Work, ICRC, Geneva, <http://www.icrc.org/eng/assets/files/other/ icrc-002-0999.pdf> [accessed 15 May 2014].

INEE (Inter-Agency Network for Education in Emergencies) (2010) Minimum Standards for Education: Preparedness, Response, Recovery, INEE, New York, <http:// toolkit.ineesite.org/toolkit/Toolkit.php?PostID=1002> [accessed 15 May 2014]. Jones, B., Araba, A., Koskei, P. and Letereuwa, S. (2003) "Experiences with community-based and participatory methods for rinderpest surveillance in parts of southern Sudan", in K. Sones and A. Catley (eds), Primary Animal Health Care in the 21st Century: Shaping the Rules, Policies and Institutions, proceedings of an international conference, Mombasa, 15–18 October 2002, African Union Interafrican Bureau for Animal Resources, Nairobi, <http://sites.tufts.edu/ capeipst/files/2011/03/Jones-et-al-Mombasa.pdf> [accessed 15 May 2014].

Leyland, T. (1996) "The case for a community-based approach with reference to southern Sudan", in The World Without Rinderpest, pp. 109–120, FAO Animal Production and Health paper 129, FAO, Rome. Available from: <http://www. fao.org/docrep/003/w3246e/w3246e00.htm#TOC> [accessed 28 May 2014].

ODI (Overseas Development Institute) (1999) What Can We Do with a Rights-based Approach to Development? ODI Briefing Paper 3, ODI, London. Available from:

<http://www.livestock-emergency.net/resources/assessment-and-response/> [accessed 15 May 2014].

OHCHR (Office of the High Commissioner for Human Rights) (2006) Frequently Asked Questions on a Human Rights-Based Approach to Development Cooperation, OHCHR, New York and Geneva, <http://www.ohchr.org/Documents/ Publications/FAQen.pdf> [accessed 15 May 2014].

Pasteur, K. (2002) Gender Analysis for Sustainable Livelihoods Frameworks: Tools and Links to Other Sources, draft. Available from: <http://www.livestock- emergency.net/resources/assessment-and-response/> [accessed 15 May 2014].

People in Aid (2003) Code of Good Practice in the Management and Support of Aid Personnel, People in Aid, London, <http://www.peopleinaid.org/code/> [accessed 15 May 2014].

ProVention Consortium (2007) M&E Sourcebook, ProVention Consortium, Geneva.

Roche, C. (1999) Impact Assessment for Development Agencies: Learning to Value Change, Oxfam, Oxford, <http://policy-practice.oxfam.org.uk/ publications/impact-assessment-for-development-agencies-learning-to-value- change-122808> [accessed 15 May 2014].

Sandison, P. (2003) Desk Review of Real-Time Evaluation Experience, Evaluation Working Paper, UNICEF, New York, <http://www.unicef.org/evaldatabase/files/ FINAL_Desk_Review_RTE.pdf> [accessed 15 May 2014].

SEEP (Small Enterprise Education and Promotion) Network (2010) Minimum Economic Recovery Standards (MERS), SEEP Network, Washington, DC,

<http://www.seepnetwork.org/minimum-economic-recovery-standards- resources-174.php> [accessed 15 May 2014].

Slim, H. and Bonwick, A. (2005) Protection: An ALNAP Guide for Humanitarian Agencies, ODI, London.

Sphere Project (2011) Humanitarian Charter and Minimum Standards in Humanitarian Response (the Sphere Handbook), The Sphere Project, Geneva, <www. sphereproject.org/> [accessed 15 May 2014]. See chapter on "Protection principles" (pp. 25–47).

UNDP (United Nations Development Programme) Climate Change Country

Profiles [online] <http://www.geog.ox.ac.uk/research/climate/projects/undp-cp/> [accessed 19 May 2014].

Vavra, J. (2005) Best Practices: Gender and Conflict in Africa, Management Systems International and US Agency for International Development, Washington, DC. Available from: <http://www.livestock-emergency.net/resources/assessment- and-response/> [accessed 15 May 2014].

Watson, D.J. and van Binsbergen, J. (2008) Review of VSF-Belgium"s "Turkana Emergency Livestock Off-Take" Intervention 2005, Research Report 4, International Livestock Research Institute (ILRI), Nairobi, Kenya, <http://cgspace. cgiar.org/bitstream/handle/10568/234/RR4_LivestockOfftakeIntervention. pdf?sequence=1> [accessed 19 May 2014].

Wood, A., Apthorpe, R. and Borton, J. (eds) (2001) Evaluating International Humanitarian Action: Reflections from Practitioners, Zed Books/ALNAP, London.

World Vision (2012) Minimum Inter-Agency Standards for Protection Mainstreaming, World Vision UK and World Vision Australia, London and Sydney, <https://www. humanitarianresponse.info/topics/procap/document/world-vision-minimum- inter-agency-standards-protection-mainstreaming-march> [accessed 15 May 2014].

Санамж

1. Дэлгэрэнгүй мэдээлэлийг Боловсролын наад захын стандарт: Бэлэн байдал, Хариу арга хэмжээ, Сэргээн босголт (INEE,2010).
2. Дэлхийн Зөн (2012) Хамгааллын асуудлыг тусгах байгууллага хоорондын стандарт болон Олон Улсын Улаан Загалмайн Хороо (2013) Хамгаалах ажлын М*эргэжлийн Стандарт.*

БҮЛЭГ 3

Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох

Танилцуулга

Энэ бүлгээр гамшгийн үед мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах нь тохиромжтой эсэхийг тодорхойлдог анхдагч үнэлгээ хийх талаар зөвлөгөөг багтаасан. Мал амьтанд чиглэгдсэн арга хэмжээ авах нь тохиромжтой гэж үзсэн тохиолдолд ямар төрлийн тусламж шаардлагатай болохыг тодорхойлох PRIM буюу оролцооны аргаар хариу арга хэмжээг тодорхойлох матрицийг энэхүү бүлэгт танилцуулна.

Анхдагч үнэлгээ

1. Нэрвэгдсэн хүн амын амьжиргаанд мал амьтны гүйцэтгэх үүрэг юу вэ?
2. Үүссэн онцгой байдлын мөн чанар, үр нөлөө юу вэ?
3. Орон нутгийн нөхцөл байдал, чадавхи болон тогтолцоонд тулгуурлан ямар үйл ажиллагаа хэрэгжүүлбэл тохиромжтой вэ?

Хариу арга хэмжээг тодорхойлох

- Оролцооны аргаар хариу арга хэмжээг тодорхойлох матриц (PRIM)

Холбогдох техникийн үйл ажиллагааны бүлэг (4–9) тус бүрт шийдвэрийн модны загвар болон үнэлгээнд ашиглах шалгах асуултууд хавсаргасан.

Анхдагч үнэлгээ

Ямар ч төрлийн гамшгийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэхээс өмнө үүссэн онцгой байдлын төрөл, үе шат, аюулын зэрэг, амьжиргааг дэмжих мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах үндэслэл, хэрэгжүүлэх боломж, эсэх эсвэл ямар нэгэн арга хэмжээ авах шаардлагатай эсэх талаар анхдагч үнэлгээгээр тодорхойлно. Анхдагч үнэлгээ нь аль чиглэлээр үйл

ажиллагаа хэрэгжүүлэх нь хамгийн үр дүнтэй болохыг шийдвэрлэх эхний алхам юм. Мөн тодорхой чиглэлээр илүү нарийвчилсан үнэлгээ хийхэд хэрэгцээтэй суурь мэдээллийг гаргаж ирдэг. (*Бүлэг 4–9* харна уу).

Анхдагч үнэлгээ нь гурван хэсгээс бүрдэх бөгөөд оновчтой хэсгийг сонгож ашигласнаар богино хугацаанд мэдээлэл авах боломжтой болдог. Мөн дээрх хэсгүүдийг бүгдийг нь ашиглаж болно.

Үнэлгээний асуултууд

1. Амьжиргаанд мал амьтны гүйцэтгэх үүрэг

Мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагааны хэрэгжилт нь гамшгийн үеэр нэрвэгдсэн хүн амын амьжиргаанд мал амьтны гүйцэтгэх үүргээс шалтгаалдаг. Доорх бүлэг асуултууд нь тухайн орон нутгийн амьжиргаанд мал амьтны ач холбогдол, үүргийг тодорхойлох зорилготой. Эдгээр асуултад хариулснаар мал амьтанд чиглэгдсэн хариу арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг тодорхойлно. Мал сүргийн маллагаа, ашиг хүртэх болон эзэмших хэлбэр зэрэг нь хөрөнгө, хүйс, эмзэг байдлаас хамааран ялгаатай байдгийг ойлгох нь чухал ач холбогдолтой. Эдгээр гол асуултууд нь тогтсон, өөрчилж болохгүй зүйл биш бөгөөд тодорхой нөхцөлд тааруулж өөрчилж болно.

Гол асуултууд

1.1 Гамшигт нэрвэгдсэн газар нутагт ердийн үед амьжиргаагаа залгуулдаг үндсэн арга хэлбэрүүд нь юу байдаг вэ?

1.2 Мал амьтныг ямар зориулалтаар ашигладаг вэ? (хоол хүнс, орлого, нийгмийн, унаа хөсөг, тээвэрлэлтийн зориулалтаар г.м)

1.3 Ердийн үед хоол хүнснийхээ хэдэн хувийг мал сүргээс хангадаг вэ?

1.4 Ердийн үед орлогынхоо хэдэн хувийг мал сүргээс олдог вэ? юунд зарцуулагддаг вэ?

1.5 Гэр бүлийн гишүүн бүр ялангуяа хүйс болон насны хувьд малаа зарж борлуулах, хэрэглэх зэргээр мал маллагаанд (хэрэглээ болон зарж борлуулах эрх г.м) ямар үүрэгтэй оролцдог вэ? Малын төрөл болон нас, улирлын онцлогоос хамаарсан өөрчлөлт байвал тэмдэглэж авах.

1.6 Ямар хууль тогтоох байгууллага болон удирдлага мал амьтны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, байгалийн нөөцийн менежментийн асуудалд оролцдог болон тэдний үүрэг юу болох?

1.7 Нийгмийн харилцаа болон эрх мэдлийн хүрээнд мал аж ахуйн менежментэд нөлөөлж буй гол хүчин зүйлүүд юу байна вэ?

1.8 Хүнд хэцүү цаг үе тулгарсныг илтгэдэг үзүүлэлтүүд болон түүнийг даван туулах үндсэн стратеги юу вэ? (жишээ нь хоол хүнсний хомсдол, малаа олноор нь нядлах юмуу зарах, шилжилт хөдөлгөөн, гэр бүлийн гишүүд биенээсээ холдож суурьших, бусад эд хөрөнгөө зарж борлуулах г.м) Эдгээр стратеги цаашдаа амьжиргааны аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх үү?

Дүгнэлт/Төгсгөх цэг

Мал амьтан нь гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн амьжиргаанд чухал үүрэг гүйцэтгэдэг үү? Мал амьтанд чиглэгдсэн хариу арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлага үүссэн үү?

2. Онцгой байдлын мөн чанар болон үр нөлөө

Анхдагч үнэлгээгээр үүссэн гамшгийнын хүн амд үзүүлсэн нөлөөллийг илрүүлж, хариу арга хэмжээ авах шаардлагатай эсэх мөн өөр ямар мэдээлэл хэрэгтэй байхыг тодорхойлно.

Гол асуултууд

2.1 Үүссэн гамшгийн төрөл юу вэ? Удаан явцтай, гэнэтийн эсвэл хавсарсан уу?

2.2 Онцгой байдал үүсэхэд ямар хүчин зүйл нөлөөлсөн бэ (ган, үер, дайн самуун гэх мэт)?

2.3 Тухайн газар нутагт энэ төрлийн онцгой байдал өмнө нь үүсч байсан уу?

2.4 Онцгой байдал ямар үе шатандаа яваа вэ (сэрэмжлүүлэг, түгшүүр, онцгой байдлын, гамшгийн дараах яаралтай тусламжийн, эрт үеийн нөхөн сэргээлт, нөхөн сэргээлтийн гэх мэт)?

2.5 Хүн амын ямар хэсэг эсвэл мал амьтны аль төрөл нэрвэгдсэн бэ?

2.6 Хүн амд гамшгийн үзүүлсэн нөлөөлөл ямар байна вэ? Ялангуяа:

- Нэрвэгдсэн хүн амын хоол хүнсний төлөв байдал ямар байна вэ?
- Өвчний дэгдэлт ямар байна вэ?
- Нас баралтын үзүүлэлт ямар байна вэ?
- Эмэгтэйчүүд, хүүхдүүд, ХДХВ-н халдвартай хүмүүс, угсаатны бүлгүүд гэх мэтчилэн эмзэг бүлгүүдэд ямар нөлөө үзүүлж байна вэ? (эмзэг байдлын дүн шинжилгээнд ашиглагдах материалыг бүлгийн төгсгөлөөс харна уу)
- 1.8-р асуултад дурьдагдсан "хүнд хэцүү цаг үеийг" даван туулах стратеги хэрэгжиж байна уу?
- нэрвэгдсэн хүн ам дунд нүүх, өөр тийшээ шилжин суурьших үзэгдэл илт ажиглагдаж байна уу? Хэрэв тийм бол ямар хүмүүс мөн тэд мал сүргээ хамтад нь авч явж байна уу?
- Нүүж очиж байгаа газар нь ямар үр дагавар гарч байна?

2.7 Мал сүргээ хариулахад үүссэн онцгой байдал ямар үр нөлөө үзүүлж байна вэ? Тодруулбал:

- Бэлчээх болон тэжээхэд ямар үр нөлөө үзүүлсэн бэ?
- Мал сүргээ услахад ямар үр нөлөө гарсан бэ?
- Өдөр тутмын болон улирлын чанартай шилжилт хөдөлгөөнд ямар үр нөлөө үзүүлсэн бэ?
- Малын худалдаачид болон зах зээлд нийлүүлэгч малын бүтээгдэхүүнд ямар үр нөлөө үзүүлсэн бэ? (борлуулалт, үнэ, малын болон үр тарианы хоорондох худалдааны нөхцөл, тэжээл болон эм ханган нийлүүлэгчид)
- Мал сүргийн үйлчилгээнд ямар үр нөлөө үзүүлсэн бэ(мал эмнэлгийн үйлчилгээ, эмийн сан)?
- Байгалийн нөөцөд ямар үр нөлөө үзүүлсэн бэ?
- Ажлын хүчин дэх хүйсийн хуваарилалтад ямар үр нөлөө үзүүлсэн бэ?
- Нэрвэгдсэн хүн ам мал сүргийнхээ талаар цаашид ямар төлөвлөгөөтэй байна вэ?

2.8 Онцгой нөхцөл байдал мал сүрэгт ямар үр нөлөө үзүүлсэн бэ? (шаардлагатай бол малыг төрлөөр нь ангилна) Тодруулбал:

- Мал сүргийн нөхцөл байдал хэр доройтсон бэ?
- Малын эрүүл мэндэд ямар үр нөлөө үзүүлсэн бэ?
- Малын ашиг шим муудсан уу(сүү, мах, цус, өндөгний арилжаа гэх мэт)?
- Малын өвчлөл нэмэгдсэн үү?
- Гэр бүлийн хэрэгцээнд зориулан мал нядлах нь ихэссэн үү?
- Малын хорогдлын түвшин хэр байна вэ?
- Малын хашаа, саравчид ямар нэг үр нөлөө үзүүлсэн үү?
- Сөрөг үр нөлөөллийн түвшин хэр байна вэ?

2.9 Онцгой байдлын байгаль орчинд үзүүлсэн үр нөлөө хэр байна вэ? энэ үнэлгээг хийх хэдэн хэдэн аргачлал байдаг, жишээлбэл Benfield UCL Аюулт үзэгдлийн судалгааны төв болон CARE Интернэшиональ-н гаргасан Байгаль орчны түргэвчилсэн үнэлгээний аргууд, FRAME-н үнэлгээний аргууд (Kelly, 2005; UNHCR, 2009).

2.10 Ирж буй улирлын урьдчилсан төлөв байдал ямар байна вэ? (цас, бороо, халалт, хуурайшилт, аюулгүй байдалд нөлөөлөх асуудлууд, хүнс тэжээлийн боломж гэх мэт)

Дүгнэлт/Төгсгөх цэг

Онцгой байдлын үеийн үйл ажиллагаа шаардлагатай юу?

3. Нөхцөл байдлын дүн шинжилгээ

Энэ үнэлгээ нь үйл ажиллагаа явуулах орчны тухай таньж мэдэх, тулгарч болзошгүй саад бэрхшээлийг тодорхойлох, хамтран ажиллагсадтай давхцаж буй арга хэмжээ болон хамтран ажиллах боломжуудыг тодорхойлно.

Гол асуултууд

3.1 Нэрвэгдсэн газар нутагт гол оролцогчид нь хэн болох мөн тэдний үүрэг юу вэ?

3.2 Зохицуулалт хийж буй тал байна уу?

3.3 Ямар үйлчилгээ, тоног төхөөрөмжийг ашиглах боломжтой байгаа вэ? Үүссэн онцгой байдал эдгээрт ямар үр нөлөө үзүүлсэн байна вэ

(засаг захиргааны үйлчилгээ, зах зээл, мал аж ахуйн үйлдвэрлэл, эрүүл мэндийн үйлчилгээ гэх мэт)?

3.4 Ямар нөөц боломжууд байна вэ (орон нутгийн уламжлалт даван туулах тодорхой стратеги гэх мэт)?

3.5 Нэрвэгдсэн газар нутагт онцгой байдлын хариу арга хэмжээ авч байсан эерэг, сөрөг ямар түүхүүд байна вэ (Сайн, муу туршлагууд, сургамжууд)?

3.6 Одоогийн нөхцөл байдал ямар байна вэ? Хэрэгжихээр сонгох үйл ажиллагаанаас (*Бүлэг* 4–9) хамаарч тэдгээртэй холбогдох асуудалд нарийвчилсан үнэлгээ хийнэ. Зарим зөрчилдөөнтэй нөхцөл байдлын үед эдгээр асуултууд маш чухал ач холбогдолтой байдаг бөгөөд зарим асуудлын эргэлзээг тайлахад хэрэг болдог.

- Харилцаа холбоо хэр явагдаж байна вэ?
- Аюулгүй байдлын түвшин ямар байна вэ?
- Мал сүргийг нүүлгэх, шилжүүлэх боломж ямар байна (боломжит газрууд, түүнтэй холбоотой зөрчилдөөн байна уу?)
- Малчдын хувьд аюулгүй байдалтай холбоотой тулгарч буй гол асуудлууд юу байна?
- Дэд бүтцийн одоогийн нөхцөл байдал ямар байна? (зам, тээвэр гэх мэт)
- Бэлэн мөнгөний болон эрхийн бичиг олгох үйл ажиллагаа явуулах нөхцөл (жишээлбэл аюулгүй байдал, төлбөр шилжүүлэх механизм болон хүргэлтийн сонголтууд) хэр байна вэ?
- Хил хязгаартай холбоотой асуудлууд байна уу?
- Мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулахад бодлогын болоод хууль эрхзүйн зүгээс саад хориг тулгарч байна уу? Жишээ нь малын нүүдэл, экспортыг хориглох, нядалгаатай холбоотой хууль тогтоомж, татварын бодлого, лицензтэй холбоотой дүрэм журам, тусламжийн байгууллагуудын уялдаа холбоо, үндэсний гамшгийн менежментийн бодлогууд, болон хамтран ажиллагч байгууллагын дотоод бодлого журмууд.
- Бодлого журамд гарсан өөрчлөлтүүд эмзэг байдалд нөлөөлсөн үү?

Дүгнэлт/Төгсгөх цэг

Дээрх хариултаас харахад тухайн орон нутагт ямар нэг төрлийн арга хэмжээ хэрэгжүүлэхэд тулгарч болох асуудлууд байна уу? Жишээ нь шилжилт хөдөлгөөн хийхэд учирч болох аюулгүй байдлын асуудлууд байна уу? Нэрвэгдсэн хүн амд хэрэгцээтэй дэмжлэгийг үзүүлж байгаа бусад байгууллагууд байна уу?

Үнэлгээний арга болон аргазүй

Байгаа мэдээллүүдийг нягтлах

Ерөнхийдөө үнэлгээний зарим мэдээлэл нь бэлэн байдлын төлөвлөгөөний нэг хэсэг болон онцгой нөхцөл байдал үүсэхээс өмнө цуглуулагдсан байх ёстой. (*Бүлэг 2, Нийтлэг стандартууд ба мал амьтанд хамааралтай нийтлэг асуудлууд; Нийтлэг стандарт 2*). Гэнэтийн гамшгийн үед ч хэрэв тухайн газар гамшигт өртөмтхий бол бэлэн байдлыг хангах мэдээлэл урьдчилан бэлтгэгдсэн байх боломжтой. Тухайн орон нутагт хөгжлийн чиглэлээр удаан хугацааны турш үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага нь олон нийтийн хамтаар болон дотооддоо бэлэн байдлын чадавхийг хөгжүүлэх хамгийн их боломжтой байдаг. Энэ нөхцөлд амьжиргааны стратеги, үйлдвэрлэлийн тогтолцоо, нийгмийн болон соёлын хэм хэмжээ, үйл ажиллагаа явуулж буй гол оролцогчид, байгууллагын чадамж, бололцоог ойлгодог, мэддэг байх нь түргэвчилсэн үнэлгээний магадлалыг өндөрсгөнө.

Нэмэлт мэдээллийг засгийн газрын тайлан, хүн, малын эрүүл мэндийн тоон мэдээллүүд, ТББ-н тайлан болон бусад ашиглаж болох нээлттэй мэдээллүүдээс цуглуулж авна. Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бусад байгууллагууд эмзэг байдлын үнэлгээ гэх мэт нэмэлт мэдээлэлд хэрэг болох онцгой байдлын анхдагч, дэлгэрэнгүй үнэлгээ явуулсан байж болно. Хамтран ажиллагсад ч мөн өөрсдөө тоон болон чанарын мэдээллийн нэгэн гол эх сурвалж болж байдаг. Сансрын тандан судлалтын зурган мэдээ болон газарзүйн мэдээллийн тогтолцооны (GIS) мэдээ нь уст цэгийн болон бусад байгалийн нөөцийн байршлын зураглал гаргахад хэрэгтэй.

Онцгой байдлыг урьдчилан таамаглах, гамшиг тохиохоос өмнө эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах зорилгоор бүс нутгуудад эрт урьдчилан мэдээлэх тогтолцоог хөгжүүлж байна. Энэ тогтолцоо нь

хүнсний аюулгүй байдал болон хүмүүсийн хоол тэжээлийн мэдээлэлд голлон төвлөрдөг бөгөөд малын нөхцөл байдал гэх мэт амьжиргааны зарим үзүүлэлтүүдийг багтаадаг. Эрт зарлан мэдээлэл болон онцгой байдлын үнэлгээний мэдээг хөрвүүлэх, ангилах системийн тоо нэмэгдсээр байна *(Хавсралт 3.1*).

Ийнхүү ангилал хийгдсэнээр онцгой нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд маш хэрэгтэй бөгөөд нь хариу арга хэмжээг мэдэхэд туслана. Хэдийгээр нарийвчилсан дүн шинжилгээ, ангилал хийх зэрэгт анхаарлаа хандуулах хэрэгтэй ч онцгой байдлын үед хариу арга хэмжээ яаралтай, үр дүнтэй үзүүлэхээс хойш нь татаж болохгүй. Урьдчилсан, цагаа олсон хариу арга хэмжээ нь удаан явцтай гамшгийн үед илүү чухал бөгөөд үйл ажиллагааны үр ашиг болон зардлын харьцааг цаг хугацааны хувьд бууруулах ач холбогдолтой.

Оролцооны аргачлалууд

Энэ бүлэгт дурдагдаж буй үнэлгээнүүд нь ашиг хүртэгч олон нийтийн төлөөлөл болон гол хамтран ажиллагсдыг хамруулсан оролцооны аргаар төлөвлөлт хийх үйл явцын нэг хэсэг юм (*Бүлэг 2, Нийтлэг стандартууд ба мал амьтанд хамааралтай нийтлэг асуудлууд, Нийтлэг стандарт 1: Оролцоо*). Онцгой байдлын үед ялангуяа гэнэтийн гамшгийн үед яаралтай хариу арга хэмжээ авах хэрэгцээ шаардлагаас хамааран оролцооны аргыг ашиглах боломж хязгаарлагдмал байдаг талтай. Үнэлгээнд ашиглах аргачлал нь чухал бөгөөд үүгээр дамжуулан хамтын ажиллагаа, оролцоонд тулгуурласан хариу арга хэмжээ хэрэгжүүлэх чиглэлийг тогтооно. Орон нутгийн оролцоо нь мэдээллийн чанарыг сайжруулдаг. Иймээс үнэлгээний баг нь үнэлгээ хийхдээ орон нутгийн иргэдийн төлөөлөл, хамтран ажиллагч орон нутгийн байгууллагуудыг оролцуулах хэрэгтэй. Үнэлгээний багийг бүрдүүлэхдээ эмзэг байдал, LEGS-н нийтлэг асуудлууд болох хүйс, нийгмийн эрх тэгш байдал зэргийг харгалзан үзэж эмзэг бүлгийн төлөөллийг оролцуулна. Үүнээс гадна мэдээлэл цуглуулах явцад эмзэг бүлгүүдээс жигд хамруулна. Үнэлгээний багт орон нутгийн талаар зохих мэдлэгтэй малын эмч, бусад мэргэжилтнүүд багтах ёстой.

Үнэлгээнд ашиглах гурван бүлэг асуултын хариултыг нь орон нутгийн удирдлагатай уулзах, олон нийтийн хэлэлцүүлэг хийх үеэр эсвэл нэмэлт цуглуулсан мэдээллүүдээс авч болно. Хүн амд чиглэсэн онцгой байдлын үеийн үнэлгээтэй харьцуулахад мал амьтанд чиглэгдсэн үнэлгээ нь шинжээчдийн үзэл бодол дээр тулгуурласан голчлон чанарын мэдээлэл

байдаг. Зарим тохиолдолд тоон мэдээлэл, дүн шинжилгээ нь үндэслэл муутай байх тохиолдол гардаг. Жишээ нь одоогоор хүний хоол хүнсний шуурхай үнэлгээний загварыг мал амьтанд чиглэгдсэн үнэлгээнд адилтган хэрэглэх жишиг арга байхгүй, малын хорогдлыг тооцох тодорхой стандарт ч байхгүй байна. Үүнээс гадна зарим тохиолдолд малчид малын тоогоо мэдээлэх дургүй байдаг. Мал амьтны амьжиргаанд гүйцэтгэх үүргийг тогтоох нь энэхүү үнэлгээний гол зорилго бөгөөд энэ нь нийгмийн бүлэг, бүс нутгаас хамааран харилцан адилгүй байдаг.

Оролцооны аргууд

Мал аж ахуйтай холбоотой асуудал, бэрхшээл, шийдвэрийг шуурхай үнэлэх олон төрлийн аргууд байдаг. Эдгээр аргуудыг дараах гурван үндсэн бүлэгт хуваана:

- *Албан бус ярилцлагын аргууд*
  - Гол мэдээлэгчидтэй хийх ярилцлага: орон нутгийн ТББ, засгийн газрын ажилтан, уламжлалт болон олон нийтийн байгууллагын удирдлагууд, шашны удирдагчид, эмэгтэйчүүдийн бүлэг болон бусад иргэний нийгмийн байгууллагууд
  - Фокус бүлгийн хэлэлцүүлэг (эрэгтэй, эмэгтэй болон хөрөнгө чинээний бүлгээр нь ангилна)
  - Хагас бүтэцтэй ярилцлага, дүрслэл болон оноо өгөх аргыг дэмжих зорилгоор ашигладаг (доорх хэсгээс харна уу).
- *Дүрслэлийн аргууд*
  - Оролцооны аргаар орон нутгийн нөөц, үйлчилгээ, зах зээл, бэлчээрийн газар, уст цэг, мал эмнэлгийн үйлчилгээ болон мал нүүдэллэхтэй холбоотой бусад мэдээллийг зураглалаар гаргана.
  - улирлын хуанли
  - Венн диаграм
- *Эрэмбэлэх болон оноо өгөх аргачлалууд*
  - Мал амьтанд тулгамдаад байгаа асуудлуудыг эрэмбэлэх
  - Мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагааны үр нөлөөг оноогоор дүгнэх матриц

– Малын өвчний хор хохирлыг харьцуулах.

Мал амьтны шуурхай үнэлгээг оролцооны аргаар хийхтэй холбоотой зарим асуудлууд:

- *Сургалт.* Оролцооны аргууд болон дүн шинжилгээгээр гарах мэдээллийн үнэ цэнэ нь орон нутгийн оролцоотой үнэлгээ, өвчний тархалтын судалгаа болон бусад төстэй чиглэлээр сургагдсан ур чадвар, туршлагатай багийн гишүүдээс ихээхэн хамаардаг.
- *Давхар шалгах.* Оролцооны аргаар цуглуулсан мэдээг олон нийтийн түвшний үнэлгээ болон засгийн газар, бусад байгууллагуудын тайлан дахь мэдээтэй (орон нутгийн зах зээл дээрх малын болон үр тарианы үнэ гэх мэт) давхар тулгах. Мал аж ахуй, байгалийн нөөц, дэд бүтцийн нөхцөл байдлыг шууд ажиглан мэдэж болно.
- *Түүвэрлэх.* Цаг хугацаа хангалтгүй бол үнэлгээний баг, хамтран ажиллагсад тухайн хүн амын бүлгүүдээс түүвэрлэн сонгож гурван гол бүлгийн асуултад хариу авах боломжтой бөгөөд ингэхдээ түүвэрт бүх эмзэг бүлгийг хамруулна. Зорилготой сонголт хийхдээ тухайн түүвэр нь хувь хүн болон бүлэг хүмүүсийн шинж чанарыг агуулж төлөөлж чадахуйц байна. Ганд нэрвэгдсэн ядуу, эмэгтэй малчид эсвэл үерт автсан тосгоны оршин суугчид гэх мэт маш чухал мэдээлэгчдийг хувь хүний болон бүлгийн онцлог шинж дээр нь тулгуурлан сонгодог. Түүврийн аргаар цуглуулсан мэдээлэл нь шууд эмзэг бүлгүүдэд хамааралтай.
- *Суурь судалгаа.* Оролцооны аргаар үнэлгээг амжилттай хийвэл суурь судалгаанд шаардлагатай чухал мэдээллүүдийг цуглуулж чаддаг. Жишээ нь малын хорогдлыг нас, төрлөөр нь харьцуулан гаргах гэх мэт. Энэ төрлийн мэдээлэл нь үнэлгээ хийх, богино хугацаанд шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой бөгөөд (*Бүлэг 6, Тэжээлээр хангах*) мал эмнэлгийн үйлчилгээний (*Бүлэг 5, Мал эмнэлгийн үйлчилгээ*) төсөлд хэрэгтэй суурь судалгааны үзүүлэлт болно.
- *Тоон мэдээлэл.* Үнэлгээнд оноо өгөх, эрэмбэлэх аргыг хэрэглэснээр тоон мэдээлэл цуглуулж чаддаг. Энэ аргаар олон удаа мэдээлэл цуглуулж сан бүрдүүлснээр статистикийн боловсруулалт хийх боломжтой болдог.

Хавсралт 3.2 Оролцооны аргуудыг Анхдагч үнэлгээний гурван төрлийн асуултад хэрхэн ашиглахыг харуулав.

Бүлгийн төгсгөл дэх ашигласан хэвлэлийн жагсаалтаас үнэлгээний аргачлал, аргазүйн талаар дэлгэрэнгүй мэдэж болно.

Мал амьтанд чиглэгдсэн хариу арга хэмжээг тодорхойлох

LEGS-н зорилтуудыг LEGS-н техникийн үйл ажиллагааны төрлүүдтэй холбох

LEGS-н амьжиргааг дэмжих аль нэг эсвэл гурван зорилтыг хангахын тулд өөр өөр төрлийн техникийн үйл ажиллагааг дангаар эсвэл хослуулан хэрэгжүүлнэ. LEGS-н хүрээнд мал амьтны тоо толгойг бууруулах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, тэжээл, ус, хашаа хороогоор хангах болон малжуулах гэсэн зургаан үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Амьжиргааны зорилтууд болон техникийн үйл ажиллагаа хоорондын харилцан хамаарлыг тайлбарын хамт *Хүснэгт 3.1-т* харууллаа. Үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг (*4-9*)-р бүлгүүдээс үзнэ үү.

Хүснэгт 3.1 LEGS-н амьжиргааг дэмжих зорилтууд ба техникийн хувилбарууд

Амьжиргааг дэмжих зорилтууд	Техникийн үйл ажиллагаа (болон төрлүүд)	Хэрэгжүүлэх арга зам ба анхаарах асуудал
1. Гамшигт нэрвэгдсэн хүн амд байгаа мал амьтны нөөц боломжоор яаралтай тусламж үзүүлэх	**Мал амьтны тоо толгойг бууруулах** (арилжаалах)	• Удаан явцтай гамшгийн эхний шатанд авч хэрэгжүүлбэл тохиромжтой • Үлдэж байгаа мал сүргийг удаан хугацаанд хамгаалах боломжтой болно • Малчид бэлэн мөнгөтэй болно • Гэнэтийн зарим гамшгийн үед малын тэжээл, хашаа хороо болон мал хариулах хүн хүч дутмаг байгаа өрхүүд малаа бэлэн мөнгө болгох • Дэд бүтэц сайтай, сонирхсон худалдан авагчтай, бодлогын хувьд иймэрхүү үйл ажиллагааг дэмжсэн орчинтой байх шаардлагатай

	Мал амьтны тоо толгойг бууруулах (нядлах)	• Гамшгийн үед малаа зарж борлуулах боломжгүй болсон үед хэрэгжүүлбэл тохиромжтой • Бэлэн мөнгө эсвэл хүнс болгож болно • Нядалгаа хийх хүчин чадал, ур чадвар болон түгээх механизм шаардлагатай • Гадны байгуулагуудаас тусламж дэмжлэг шаардагдах
2. Гамшигт нэрвэгдсэн хүн амын мал эд хөрөнгийг хамгаалах	**Мал эмнэлгийн үйлчилгээ** (хувийн мал эмнэлгийн үйлчилгээ; улсын мал эмнэлгийн салбарын үйл ажиллагааг дэмжих	• Онцгой байдлын бүх үе шатанд мал сүргийг хамгаалах мөн нөхөн сэргээхэд эерэг нөлөөтэй • Вакцинжуулах болон урьдчилан сэргийлэх эмчилгээ зэрэг бэлэн байдлыг хангах арга хэмжээг багтаасан • Мал сүргийг хамгаалахын тулд тэжээл, усаар хангах болон малжуулах зэрэг бусад үйл ажиллагаатай хамтран хэрэгжүүлнэ • Үйл ажиллагаа явуулж буй, боломжтой үйлчилгээ үзүүлэгчид (засгийн газрын, хувийн болон олон нийтэд суурилсан) болон мал эмнэлгийн үйлчилгээ нийлүүлэгч шаардлагатай.
	Тэжээлээр хангах (онцгой байдлын үеийн тэжээл, суурин тэжээх, тэжээлийн цэг)	• Онцгой байдлын үеэр болон дараа нь үлдсэн мал сүргийг хамгаалахад чухал үүрэгтэй • Хүртээмжтэй тэжээл, тээвэрлэх эсвэл хадгалах байр сав шаардлагатай • Ган гачгийн үед усны хангамжийг орлоно • Зардал ихтэй тээвэрлэлт шаардагддаг • Үлдсэн мал сүргийг хамгаалахад чухал үүрэгтэй
	Усаар хангах (уст цэг; ус зөөвөрлөх)	• Чанарын шаардлага хангах усны эх үүсвэр эсвэл шинэ эх үүсвэр бий болгох шаардлагатай • Орон нутагт хэрэгжүүлэх усны үр дүнтэй менежментийн тогтолцоо шаардлагатай • Ихээхэн хүч хөдөлмөр (ялангуяа шинэ уст цэг байгуулахад) болон хөрөнгө мөнгө (ус зөөвөрлөх) шаардагдана

Амьжиргааг дэмжих зорилтууд	Техникийн үйл ажиллагаа (болон төрлүүд)	Хэрэгжүүлэх арга зам ба анхаарах асуудал
	Малын хашаа саравч (түр болон урт хугацааны хашаа саравчаар хангах)	• Халуун, хүйтэн уур амьсгалаас хамгаалах, аюулгүй байлгах, тарж алга болохоос сэргийлэх, хүн болон малын эрүүл орчин бүрдүүлэх зэрэг олон хэрэгцээ шаардлагыг хангана • Цаг уурын хатуу ширүүн нөхцөлтэй, гэнэтийн гамшгийн үед голчлон хэрэглэнэ • Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зориулалтаар (газар хөдлөлтөд тэсвэртэй саравч г.м) мөн гамшгийнын дараа мал сүргийг хамгаалах зорилгоор хэрэглэнэ • Газрын эрх, байгаль орчны асуудлууд болон тэжээл, усаар хангах зэрэг илүү өргөн хүрээний асуудлыг хөнддөг
3. Гамшигт нэрвэгдсэн хүн амын эд хөрөнгө болох мал амьтныг нөхөн сэргээх	**Малжуулах** (эд хөрөнгө болох мал амьтныг нөхөн сэргээх)	• Онцгой байдлын дараа малчдыг малаа нөхөн сэргээхэд нь туслах, эсвэл цөөн тооны бог мал өгч амьжиргаанд нь дэмжлэг үзүүлж болно • Гэнэтийн аюул өнгөрсний дараа, мал аж ахуйн хохирлыг тооцож, нөхөн сэргээх үе шатанд авч хэрэгжүүлбэл тохиромжтой • Өртөг өндөртэй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй асуудал гардаг • Тухайн газар нутгаас эсвэл тээвэрлэх боломжтой газраас мал амьтны хангалт хийх боломжтой байхыг шаардана • Хуваарилж өгсөн малыг тэжээх хангалттай байгалийн нөөцтэй байх шаардлагатай, • Ашиг хүртэгчдийг зөв сонгох, тохирох мал сүргийг сонгох, ашиг хүртэгчийг хуваарилж өгсөн малыг хариуцаж чадах эсэхийг судлах мөн мал эмнэлгийн үйлчилгээнүүд боломжтой байдаг эсэхийг шалгах нь амжилттай хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй

		• Малын эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаа, сургалт явуулах нь малын үхэл хорогдлыг бууруулна. • Малжуулах нь ашиг хүртэгчдэд богино хугацаанд хүнсний болон бусад дэмжлэг хэрэг болох магадлалтай
	Мал эмнэлгийн үйлчилгээ, ус, тэжээл болон хашаагаар хангах	• Дээр дурьдагдсан зүйлүүд • Техникийн үйл ажиллагаануудыг сэргээн босгох үе шатанд үргэлжлүүлэн явуулснаар мал сүргийг хүч тамир оруулан сэргээх бөгөөд цаашид тохиолдож болох гамшигт өртөх эмзэг байдлыг бууруулна

Оролцооны аргаар хариу арга хэмжээг тодорхойлох матриц (PRIM)

PRIM (Оролцооны аргаар хариу арга хэмжээг тодорхойлох матриц) нь LEGS-н амьжиргааг дэмжих зорилтуудыг хангахын тулд мал аж ахуйд ямар төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлбэл хамгийн оновчтой, үр дүнтэй болохыг орон нутгийн хамтран ажиллагсад, иргэдийн төлөөлөлтэй хэлэлцсний үр дүнд тодорхойлон гаргадаг аргачлал юм. PRIM –ыг анхдагч үнэлгээний үр дүнг ашиглан оролцогч талуудтай (эрэгтэй, эмэгтэй аль аль төлөөллүүдийг хамруулсан) хийнэ.

PRIM нь үнэлгээний дүгнэлтэд үндэслэн техникийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх замаар (мал амьтны тоо толгойг бууруулах; мал эмнэлгийн үйлчилгээ; тэжээл; ус; хашаа хороогор хангах; малжуулах) LEGS-н амьжиргааг дэмжих 1) мал амьтанд тулгуурласан яаралтай тусламж үзүүлэх; 2) эд хөрөнгийг хамгаалах; 3) эд хөрөнгийг нөхөн сэргээх зорилтыг хангахад чиглэгдэнэ. Онцгой байдлын үе шатуудад амьжиргааг дэмжих гурван зорилтыг хангах үүднээс техникийн үйл ажиллагааг дангаар болон хослуулан хэрэглэх талаар авч үзнэ. Матрицийн баруун гар талд үйл ажиллагаа хэрэгжүүлэх зохистой хугацааг төлөвлөхийг харуулсан бөгөөд бэлтгэл ажил хангах, дараагийн алхамуудыг төлөвлөх хугацааг олгоно. Гэнэтийн болон удаан явцтай гамшгийн төрлөөс хамааран онцгой байдлын үе шат бүр өөр байдаг.

Эдгээр үе шатуудын талаарх тодорхойлолт *Нэр томьёоны тайлбар* хэсэгт байгаа хэдий ч PRIM-г ашиглаж буй оролцогчид нөхцөл байдалд тулгуурлан өөрсдөө онцгой байдлын үе шатаа тодорхойлно. Хавсарсан

гамшгийн үед гэнэтийн эсвэл удаан явцтай онцгой нөхцөл байдал аль ч үед үүсэж болох бөгөөд түүнд нь тохирсон PRIM-г хэрэглэнэ (*Жишээ судалгаа С*). Удаан явцтай эсвэл гэнэтийн онцгой нөхцөл байдлын аль ч нь тохиолдоогүй хавсарсан гамшгийн үед PRIM-н зөвхөн зүүн гар талын хэсгийг (амьжиргааг дэмжих зорилтууд гэх мэт) ашиглана.

PRIM бол LEGS-н амьжиргааг дэмжих зорилтыг хангахын тулд орон нутгийн хамтран ажиллагсад, иргэдийн төлөөлөлтэй хэлэлцсний үр дүнд онцгой байдлын ямар үе шатанд ямар төрлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь оновчтой байхыг шуурхай тодорхойлж, дүгнэх боломжтой.

Бүдүүвч 3.1 Оролцооны аргаар хариу арга хэмжээг тодорхойлох матриц (PRIM)

LEGS-н гурван зорилтыг техникийн үйл ажиллагаануудтай тохируулна

Гэнэтийн , удаан явтай гамшгийн төрлөөс хамааран үе шатуудыг тогтооно.

Техникийн үйл ажиллагааны хувилбарууд	Амьжиргааны зорилтууд			Гамшгийн үе шатууд		
	Яаралтай тусламж	Эд хөрөнгийг хамгаалах	Эд хөрөнгийг нөхөн сэргээх			
Мал амьтны тоо толгойг бууруулах	-	-	-	→		
Мал эмнэлгийн үйлчилгээ	*****	***	***	→	→	→
Тэжээл	***			→	→	
Ус						
Хашаа хороо		****				
Малжуулах			****			→

Хамтран ажиллагчдын хамтаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь LEGS-н зорилтуудыг хангахад хэр зэрэг нөлөөтэйг үнэлж тогтооно.

Хамтран ажиллагсдын хамтаар үйл ажиллагааны хэрэгжих хугацааг онцгой байдлын үе шатуудад тохируулах сумаар тэмдэглэнэ

PRIM загваруудыг ашигласан жишээнүүдийг дор үзүүлсэн болно. Ашиглаж болох загваруудыг *Хавсралт 3.3* ба LEGS-н вебсайтаас авч болно. LEGS-н техникийн үйл ажиллагаануудын алийг ч орхигдуулж болохгүй. Амьжиргааг хамгаалах, бэхжүүлэх техникийн үйл ажиллагааг дангаар нь эсвэл хослуулан хэрэгжүүлэх зохистой цаг хугацаа нь онцгой байдлын үе шатаас хамааран өөр өөр байна. Техникийн үйл ажиллагааны үнэлгээний шалгах асуулт, Зааварчилгааг *4-9*-р бүлэгт нарийвчлан заасан болно.

Анхдагч үнэлгээ, PRIM-н оролцоонд суурилсан хэлэлцүүлгийн үр дүн, хэрэгжүүлэгч байгууллагын чадавхи зэрэг нь мал сүрэгт тулгуурласан амьжиргааг дэмжих оновчтой үйл ажиллагаа хэрэгжүүлэх боломж, цаг хугацааг тодорхойлоход чухал үүрэгтэй.

PRIM жишээ судалгаанууд

PRIM аргачлалыг олон төрлийн онцгой байдлын тохиолдолд ашиглаж болохыг доорх жишээгээр харуулав. Жишээ тус бүрийг үр дүнгийн хамт тайлбарласан болно.

PRIM нь оролцогчдын санаа бодол, үнэлгээний үр дүн дээр тулгуурлан төлөвлөлт хийх нэг төрлийн аргачлал юм. Энэ арга нь үзүүлэн таниулах хэлбэрээр ашиглагдах болохоос биш түүнээс гарсан зөвлөмж нь заавал биелүүлэх тушаал шийдвэр биш юм. Оролцогчид энэ аргыг ашиглахдаа хувь хүмүүсийн туршлага, сонирхол дээр тулгуурладаг учраас ямар нэгэн алдаа гарч болзошгүйг анхаарах хэрэгтэй. Тухайн онцгой нөхцөл байдал тус бүрт тохирсон PRIM нийтлэг загвар гэж байдаггүй учир түүнийг тухай бүр үүссэн нөхцөл байдлыг хэрэгцээ, байршилд үндэслэн оролцогчид өөрсдөө тодорхойлно.

Жишээ судалгаа А: Гэнэтийн гамшиг– Азид тохиолдсон газар хөдлөлт

Хүснэгт 3.2 PRIM жишээ судалгаа А

Техникийн үйл ажиллагаанууд	Амьжиргааны зорилтууд			Гамшгийн үе шатууд		
	Яаралтай тусламж	Эд хөрөнгийг хамгаалах	Эд хөрөнгийг нөхөн сэргээх	Гэнэтийн хор хохирол	Эрт үеийн нөхөн сэргээлт	Нөхөн сэргээлт
Малын тоо толгойг бууруулах	т/б	т/б	т/б			
Мал эмнэлгийн үйлчилгээ	**	*****	*****	→	→	→
Тэжээл	**	*****	*****	→		
Ус	*	*	*	→		
Хашаа хороо	***	***	***	→	→	
Малжуулах	т/б	т/б	*****			→

LEGS-н амьжиргааг дэмжих зорилтуудыг үнэлэхдээ:

***** Маш сайн эерэг үр нөлөөтэй

**** Сайн үр нөлөөтэй

*** Тодорхой хэмжээний үр нөлөөтэй

** Багахан үр нөлөөтэй
* Маш бага үр нөлөөтэй
т/б Тохиромжтой бус

Онцгой байдлын үе шатуудыг тэмдэглэхдээ:

→ үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай хугацаа

Жишээ судалгаа А-н тайлбар

- Энэ жишээний хувьд зах зээлийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан тохиолдолд малыг зарж борлуулан нэрвэгдсэн өрхүүдэд яаралтай тусламж үзүүлэх боломжгүй. Мал амьтныг нядалж тоо толгойг бууруулах үйл ажиллагаа илүү тохиромжтой байж болох бөгөөд ийм онцгой байдлын үед мал амьтан нь ус, тэжээлгүйгээс үүдэн хорогдох магадлалтай байдаг тул нэрвэгдсэн өрхөд ашиг шим өгөх нь бага.
- Мал эмнэлгийн үйлчилгээг гэнэтийн хор уршгийн үед мал сүргийг аврах яаралтай тусламжийн хэлбэрээр хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь эрт үеийн нөхөн сэргээлт болон нөхөн сэргээлтийн үед ч мал сүргийг хамгаалах, нөхөн сэргээхэд маш чухал хувь нэмэр оруулдаг.
- Тэжээлээр хангах нь мал сүргийг хамгаалах, нөхөн сэргээхэд тустай. Хэрэв газар хөдлөлтийн тухай урьдчилсан анхааруулга авсан бол ус, тэжээл нөөцлөх зэрэг арга хэмжээ авч болно.
- Газар хөдлөлт одоогийн байгаа ус ханган нийлүүлэгчдэд хэр зэрэг нөлөөлснөөс хамааран усаар хангах үйл ажиллагаа хэрэгжүүлэх хэдий ч үр дүн муутай байдаг. Малын төрөл болон хашаа саравчны хэрэгцээнээс шалтгаалан хашаа хороогоор хангах үйл ажиллагаа нь мал сүргийг хамгаалах болон нөхөн сэргээхэд үр ашгаа нэн даруй өгдөг. Хэрэв сэрэмжлүүлэх хугацаа хангалттай байсан бол мал сүргийг нурж сүйрэх магадлалтай хашаа хорооноос гарган хорогдлоос сэргийлэх боломжтой. Гэнэтийн хор хохирол болон эрт үеийн нөхөн сэргээлтийн үед нэрвэгдсэн мал сүргийг дулаан, хуурай хашаа хороогоор хангах нь түүнийг хамгаалж, нөхөн сэргээхэд чухал хувь нэмэртэй.
- Эд хөрөнгийг нөхөн сэргээхийн хувьд малаа алдсан хүмүүст малжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой ба үүнийг зөвхөн нөхөн сэргээлтийн үе шатанд л хэрэгжүүлнэ.

Жишээ судалгаа B: Удаан явцтай гамшиг – Африкт тохиолдсон ган

Хүснэгт 3.3 PRIM жишээ судалгаа B

Техникийн үйл ажиллагаанууд	Амьжиргааны зорилтууд			Гамшгийн үе шатууд			
	Яаралтай тусламж	Эд хөрөнгийг хамгаалах	Эд хөрөнгийг нөхөн сэргээх	Сэрэмжлүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээлт
Мал амьтны тоо толгойг бууруулах	*****	***	**	→	→	- →	
Мал эмнэлгийн үйлчилгээ	*	*****	****	→	→	→	→
Тэжээл	*	***	****		→	→	
Ус	*	***	****		→	→	
Хашаа хороо	т/б	т/б	т/б				
Малжуулах	т/б	т/б	*****			→	→

LEGS-н амьжиргааг дэмжих зорилтуудын үнэлэхдээ:

***** Маш сайн эерэг үр нөлөөтэй

**** Сайн үр нөлөөтэй

*** Тодорхой хэмжээний үр нөлөөтэй

** Багахан үр нөлөөтэй

* Маш бага үр нөлөөтэй

т/б Тохиромжтой бус

Онцгой байдлын үе шатуудыг тэмдэглэхдээ:

→ үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай хугацаа

Жишээ судалгаа B-н тайлбар

- Африкт нүүрлэсэн гангийн жишээ нь Азид тохиолдсон газар хөдлөлтийн үед хэрэгжүүлсэн арга хэмжээнээс тэс өөр байгаа нь харагдаж байна. Сэрэмжлүүлэг болон түгшүүрийн үед малыг худалдаалан тоо толгойг бууруулахад нь бэлэн мөнгө олгосон нь нэрвэгдсэн өрхүүдэд нэн даруй үр ашгаа өгдөг. Мөн зарим

талаараа мал сүргийг хамгаалж байгаа хэлбэр юм (үлдэж байгаа малд хомсдсон нөөцөө ашиглах өрсөлдөөн багасч, мал борлуулж олсон мөнгөөрөө үлдсэн малдаа хэрэгцээтэй тусламжийг авч чадна). Хэрэв малаа борлуулах ажлыг онцгой байдлын үе хүртэл хойшлуулбал малын тарга тэвээр муудаж ашиг шим нь буурдаг. Энэ тохиолдолд нядалж тоо толгойг бууруулах үйл ажиллагааг явуулж (тасалдсан сумаар тэмдэглэсэн) нэрвэгдсэн өрхүүдэд яаралтай тусламж хүргэж болно.

- Энэ жишээн дээр гангийн эхэн үед малыг зарж борлуулах үйл ажиллагааг нядалж бууруулахаас илүүд үзэж байгаа зах зээлийн үйл ажиллагааг дэмжиж мөн малчдын гарт бэлэн мөнгө хэлбэрээр хүргэх зорилготой юм.
- Мал эмнэлгийн үйлчилгээг гангийн бүх үе шатанд хэрэгжүүлж болох бөгөөд малын хорогдол, өвчлөлөөс сэргийлж, ганг даван туулах чадварыг сайжруулдаг тул мал амьтныг хамгаалах болон нөхөн сэргээхэд чухал үр нөлөөтэй.
- Сэрэмжлүүлэг, түгшүүрийн үед ус, тэжээлээр хангах нь малыг хамгаалах мөн цаашид нөхөн сэргээхэд тусална.
- Энэ жишээний хувьд хашаа хороогоор хангах шаардлагагүй
- Нөхөн сэргээлтийн үе шатанд малжуулах үйл ажиллагаа явуулах нь мал сүргийг нөхөн сэргээхэд ихээхэн хувь нэмэр оруулна.

Сүүлийн жишээгээр удаан явцтай гамшиг мөргөлдөөнтэй хосолсон үед үйл ажиллагааны ямар сонголтууд тохиромжтой, хэрэгжих боломжтойг харуулав.

Жишээ судалгаа С: Хавсарсан гамшиг – Африкт удаан хугацаанд үргэлжилсэн зөрчил гангийн улмаас улам хурцадсан нь

Хүснэгт 3.4 PRIM жишээ судалгаа С

Техникийн үйл ажиллагаанууд	Амьжиргааны зорилтууд			Гамшгийн үе шатууд			
	Яаралтай тусламж	Эд хөрөнгийг хамгаалах	Эд хөрөнгийг нөхөн сэргээх	Сэрэмжлүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээлт
Мал амьтны тоо толгойг бууруулах	***	*	*			- →	
Мал эмнэлгийн үйлчилгээ	*	*****	****	→	→	→	→
Тэжээл	*	*****	*****		→	→	
Ус	*	**	**		→	→	
Хашаа хороо	***	***	***	→	→	→	→
Малжуулах	т/б	т/б	*****				→

LEGS-н амьжиргааг дэмжих зорилтуудын үнэлэхдээ:

***** Маш сайн эерэг үр нөлөөтэй

**** Сайн үр нөлөөтэй

*** Тодорхой хэмжээний үр нөлөөтэй

** Багахан үр нөлөөтэй

* Маш бага үр нөлөөтэй

т/б Тохиромжтой бус

Онцгой байдлын үе шатуудыг тэмдэглэхдээ:

→ үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай хугацаа

Жишээ судалгаа С-н тайлбар

- Жишээ судалгаа В-тэй харьцуулахад ихэнх боломжит үйл ажиллагаанууд (мал эмнэлгийн үйлчилгээ, тэжээл, ус болон малжуулах гэх мэт) тохиромжтой хэвээр байгаа бөгөөд нэрвэгдсэн хүн амд бодитой үр нөлөө үзүүлэх боломжтой байна.

- Зах зээлийн тогтолцоо болон дэд бүтэц доголдсон байдаг тул малыг зарж борлуулан тоо толгойг бууруулах боломжгүй. Нядалж тоо толгойг бууруулж болох хэдий ч (тасалдсан сумаар харуулав) хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээлээс хамаарна.
- Тэжээлээр хангах нь малыг хамгаалах болон нөхөн сэргээхэд туслах бөгөөд ялангуяа иргэд малаа хашсан, бэлчээрлэх боломжгүй нөхцөлд үүссэн тохиолдолд илүү тохиромжтой. Үүний адилаар аюулгүй байдлын үүднээс жирийн үед ашигладаг уст цэгийг ашиглах боломжгүй болдог тул малаа хамгаалах болон нөхөн сэргээхэд туслах зорилгоор усаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- Хашаа хороогоор хангах нь *Жишээ судалгаа В*-н хувьд ач холбогдолгүй байсан бол энэ жишээний хувьд нүүлгэн шилжүүлэлт, аюулгүй байдлын (хулгай дээрэм гэх мэт) асуудлаас үүдэн хамгийн чухал үйл ажиллагааны нэг болсон байна.
- Эдгээр бүх үйл ажиллагааны хэрэгжилт нь хэрэгжүүлэгч байгууллагын зөрчилтэй нөхцөл байдалд хэрхэн ажиллах чадавхиас хамаарна.

LEGS-н зорилтууд шууд бусаар хүрэх аргууд: бэлэн мөнгө тараах болон эрхийн бичиг олгох

Хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөрт бэлэн мөнгө тараах нь нэмэгдсэн ба энэ төрлийн хариу арга хэмжээг LEGS-н зорилтуудыг хангахад ашиглах болсон байна. *Хүснэгт 3.5* бэлэн мөнгө тараах нийтлэг хэлбэрүүдийг хэрхэн хэрэглэж болох жишээний хамт харуулсан. Бүлгийн төгсгөлд байгаа ашигласан хэвлэлийн жагсаалтаас зах зээлийн үнэлгээ хийх болон бэлэн мөнгөний хариу арга хэмжээний тогтолцооны талаар дэлгэрэнгүй судалж болно.

Хүснэгт 3.5 Бэлэн мөнгө тараах үйл ажиллагааны тодорхойлолт болон ашиглалтын жишээнүүд

Бэлэн мөнгө тараах тогтолцоо	Тодорхойлолт
Буцаан авахгүйгээр бэлэн мөнгө тараах	*Ямар нэг нөхцөл эсвэл ажлын шаардлагагүйгээр шууд олгогдох мөнгөн тэтгэлэг* Онцгой байдлын эсвэл хөгжлийн хөтөлбөрийн алинд ч энэ тэтгэлгийг олгож болох бөгөөд (жишээлбэл нийгмийн хамгааллын хөтөлбөрийн нэг хэсэг болгон) амьжиргааг нөхөн сэргээх эсвэл хамгаалах болон үндсэн хэрэгцээг хангах зорилготой. Онцгой байдлын үед үнэлгээгээр үндсэн хэрэгцээг тодорхойлсны дараа бэлэн мөнгийг олгодог. Зах зээл хэвийн байгаа нөхцөлд энэ арга хэмжээ тохиромжтой бөгөөд энэ нь өрхүүдэд өөрсдийн хамгийн чухал хэрэгцээг тодорхойлон түүндээ зарцуулах боломжийг олгодог.
Буцааж авах нөхцөлтэй бэлэн мөнгө тараах	*Хүлээн авагч нь мөнгө авсаныхаа хариуд ямар нэг зүйл хийдэг (сургуульд явах, тариалангийн үр суулгах эсвэл цэргээс халагдах гэх мэт)* Мөнгийг зориулалтын дагуу ашиглагдаж байгаа эсэхэд хяналт тавьсны үндсэн дээр үе шаттайгаар олгодог *Энэ төрлийн тэтгэлэг нь айл өрхийг хүүхдээ сургуульд эсвэл вакцинд хамруулах зэргээр тодорхой үйлчилгээнд хамрагдахыг дэмжих зорилготой хөгжлийн арга хэмжээ хэлбэрээр ч хэрэгждэг* Нөхцөлт тэтгэлэгийг зориулагдах ёстой үйлчилгээ нь хэвийн явагдаж байгаа, тодорхой стандартыг хангасан тохиолдолд л хэрэгжүүлдэг.
Зардал бууруулах шууд бус мөнгөн хэлбэр (орлогоос чөлөөлөх)	*Эрүүл мэндийн үйлчилгээний эсвэл сургуулийн төлбөр гэх мэт үндсэн хэрэгцээний зардлыг бууруулах зорилготой тэтгэлэг эсвэл хөнгөлөлт* Хөгжлийн зорилгоор голчлон хэрэгжүүлдэг бөгөөд онцгой байдлын үед хэрэглэсэн жишээ бий. Нядалгааны төлбөр, нүүх зөвшөөрлийн төлбөр, худалдааны татаас, мал эмнэлгийн үйлчилгээний төлбөр эсвэл ачаа тээврийн зардал, шатахууны үнэ, засгийн газраас хөнгөлөлттэй олгосон тэжээлийн үнийн зөрүү зэрэгт хөнгөлөх үзүүлэх хэлбэрээр мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаанд шууд бусаар оролцоно.

Бэлэн мөнгө тараах тогтолцоо	Тодорхойлолт
Ажил эрхлэлт, олон нийтийн ажлаас бэлэн мөнгө авах	*Олон нийтийн эд хөрөнгийг сэргээн босгох юмуу барьж байгуулах ажилд оролцоноор бэлэн мөнгө юмуу эрхийн бичиг авах* Энэ арга хэмжээ нь онцгой байдлын дараагаар нөхөн сэргээх болон нийгмийн хамгааллын хөтөлбөрийн алинд ч тохиромжтой. Олон тооны ажлын байртай байгаа тохиолдолд хэрэгжинэ. Үйл ажиллагааны зорилго нь ашиг хүртэгчид үндсэн эсвэл урт, богино хугацааны зайлшгүй хэрэгцээгээ хангах орлого олох нөхцөлийг хангах юм
Эрхийн бичиг	*Хүлээн авагч нь тодорхой төрлийн бараагаар сольж авах хэвлэмэл цаас, баримт эсвэл тасалбар* Эрхийн бичиг нь тогтсон үнийн дүнгээр (худалдагчаас хүссэн бараагаараа солилцож болох) эсвэл тодорхой бараа үйлчилгээнд л зориулагдсан байна. Бэлэн мөнгөний болон барааны эрхийн бичиг нь тодорхой худалдаалагч, үйлчилгээ үзүүлэгчдийн урьдчилан сонгогдсон дэлгүүрээр үйлчлүүлэхээр заагдсан байдаг.

Эх сурвалж: Vetwork, 2011, based on Jaspars et al.,2007; Harvey, 2007; and Horn Relief, 2010

Дээрх аргын заримыг онцгой байдлын үеэр мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд тохиромжтой болохыг *Хүснэгт 3.6*-д үзүүллээ. Дэлгэрэнгүй мэдээллийг үйл ажиллагааны бүлэг тус бүрээс харах боломжтой.

Хүснэгт 3.6 LEGS-н үйл ажиллагаанд бэлэн мөнгө тараах тогтолцоог хэрэгжүүлэх сонголтууд

Техникийн үйл ажиллагаанууд болон хувилбарууд	Бэлэн мөнгө шилжүүлэх төрлүүд				
	Буцаан авахгүй мөнгөн тэтгэлэг	Буцаагдах мөнгөн тэтгэлэг	Ажил хийснээр олгогдох мөнгө	Шууд бус тэтгэлэг	Эрхийн бичиг
Мал амьтны тоо толгойг бууруулах					
Арилжаалах	*			√	√
Нядлах	*				√
Мал эмнэлгийн үйлчилгээ:					
Хувийн эмнэлгийн эрүүл мэндийн үйлчилгээ	√				
Улсын эмнэлгийн үйл ажиллагааг дэмжих		√		√	√
Тэжээл:	√				
Онцгой байдлын үед тэжээл түгээх		√			√
Байран тэжээх цэг		√			√
Ус:					
Уст цэг	√		√		
Ус зөөвөрлөх		√			√
Хашаа хороо:	√				
Малын түр хашаа хороо		√	√		√
Удаан хугацаанд байрших хашаа хороо		√	√		√
Малжуулах:	√				
Мал, эд хөрөнгийг орлуулах		√			√
Мал эд хөрөнгийг бүтээх		√			√

Тэмдэглэгээ: **Арилжаалах болон нядлах хэлбэрээр мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагаа тухайн өрхөд малынх нь дунд тохирсон мөнгө олгож байгаа тул буцааж олгогдохгүй мөнгөн шилжүүлгийн төрөлд багтана. Эх сурвалж: Vetwork, 2011*

Хавсралт 3.1: Онцгой байдлын үеийн эрт сэрэмжлүүлэх, ангиллын систем

- *Дасан зохицох стратегийн индекс.* CARE хөтөлбөрөөс боловсруулсан шуурхай үнэлгээний аргачлал бөгөөд өрх айлын хоол хүнсний аюулгүй байдлыг дөрвөн гол өөрчлөлт дээр үндэслэн ангилсан нь: хоолны хэмжээний өөрчлөлт; богино хугацаанд хоол хүнстэй болох боломж; хооллох шаардлагатай хүмүүсийн тоо буурах болон хүнсний норм юм. Эдгээрээс дүгнэсэн оноогоор хоол хүнсний аюулгүй байдлын одоогийн болон цаашдын төлөвийг тодорхойлдог.
- *Өлсгөлөнг урьдчилан мэдээлэх тогтолцоо* (FEWS-NET). Энэ санаачлагыг АНУ-н Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID) гаргасан бөгөөд хоол хүнсний аюулгүй байдалд учруулж буй аюулыг урьдчилан анхааруулах, мэдээллийн сүлжээ бий болгох болон мэдээллийг түгээх орон нутгийн чадавхийг бэхжүүлэх зорилготой.
- *Дэлхий дахины мэдээ болон Эрт зарлан мэдээлэх тогтолцоо* (GIEWS). Энэхүү НҮБ-н Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага (FAO) нэвтрүүлсэн үйлчилгээ нь дэлхий нийтэд хоол хүнсний нөхцөл байдлыг мэдээлэх болон тодорхой улс орнуудад нүүрлэж болзошгүй хоол хүнсний хямралыг урьдчилан анхааруулах зорилготой. GIEWS нь мөн Дэлхийн Хоол Хүнсний Хөтөлбөртэй (WFP) хамтран засгийн газрууд болон олон улсын байгууллагуудад хүнсний нийлүүлэлтийн сүлжээний үнэлгээ хийж өгдөг.
- *Өрхийн эдийн засгийн аргачлал (HEA).* Английн Хүүхдийг Ивээх сангаас боловсруулсан энэ аргачлал нь тогтвортой амьжиргааны тодорхойлолтыг үндэс суурьтай болгон амьжиргааны бүсүүдийг тогтоож, эдгээрт онцгой байдлын үзүүлсэн нөлөөлөлд дүн шинжилгээ хийн хэрэгцээт хүнсний шаардлагыг тодорхойлдог.
- *Хүнсний аюулгүй нэгдсэн байдал болон* Хүмүүнлэгийн үе шатны ангилал (IPC). НҮБ-н Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллагаас (FAO) боловсруулсан бөгөөд Сомали дахь хүнсний аюулгүй байдал болон хоол тэжээлийн дүн шинжилгээг хийхэд ашигласан. Өөр

өөр газар нутаг, онцгой байдлын үед үүссэн хүнсний аюулгүй байдлын асуудлыг ангилдаг. IPC нь хүний эрүүл мэнд болон амьжиргааны үзүүлэлтийн жагсаалтыг хариу арга хэмжээний стратегитэй болон эрт үеийн анхааруулгатай холбон ашигладаг. Мөн цогц мэдээллийг газарзүйн зурган хэлбэрээр харуулж, баримт нотолгоо болон хүн амын мэдээлэлд дүн шинжилгээ хийдэг.

- *Хүмүүнлэгийн тусламж болон тээвэрлэлтийн үйл ажиллагааны үнэлгээ, хяналтыг стандартчилах (SMART).* Үүнийг хэд хэдэн байгууллага хамтран гаргасан бөгөөд хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн төлөв болон нас баралтын үнэн бодит, найдвартай мэдээллээр хангадаг. Шийдвэр гаргахад ашиглана. SMART нь мөн судалгаа хийх гарын авлага болон дүн шинжилгээ хийх компьютерийн програм бүтээсэн бөгөөд үүнийг нь хавсарсан гамшгийн мэдээллийн бааз дээр суурилан хөгжүүлсэн ба CE-DAT гэж нэрлэдэг.
- *Эмзэг байдлын үнэлгээний хороод (VACs).* Өмнөд Африкийн Хөгжлийн Нийгэмлэгээс (SADC) үүсэлтэй бөгөөд гишүүн орнуудынхаа эмзэг байдал болон онцгой байдлын үеэр хэрэгцээ шаардлагын үнэлгээ хийх ажлыг зохицуулдаг. VACs нь одоо байгаа суурь мэдээллийг амьжиргааны анхдагч мэдээлэлтэй хослуулан дүн шинжилгээ хийдэг.

Хавсралт 3.1-д ашигласан хэвлэлийн жагсаалт

FEWS-NET (Famine and Early Warning Systems Network) [online] <www.fews.net/> [accessed 15May 2014].

FSNAU (Food Security and Nutrition Analysis Unit for Somalia) (2006) *Integrated Food Security and Humanitarian Phase Classification: Technical Manual, Version 1*, FAO/FSNAU, Nairobi, <http://www.fao.org/docrep/009/a0748e/a0748e00.htm>[accessed 15May 2014].

See also the Integrated Food Security Phase Classification (IPC) website: <www.ipcinfo.org/> [accessed 15May 2014].

GIEWS (Global Information and Early Warning System) [online] <http://www.fao.org/ GIEWS/english/index.htm>[accessed 19May 2014].

LEGS (Livestock Emergency Guidelines and Standards) (2014), *Livestock Emer-*

gency GuidelinesandStandards,2ndEdition,PracticalActionPublishing:Rugby.

Save the Children UK (2005) *The Household Economy Approach: What is It and WhatcanItbeUsedFor?*SavetheChildrenUK,London.Availablefrom:<http://www.livestock-emergency.net/ resources/assessment-and-response/> [accessed15May2014].

Save the Children UK (2008) *The Household Economy Approach: A Guide for ProgrammePlannersandPolicyMakers*,SavetheChildrenUK,London,<http:// www.savethechildren.org.uk/resources/online-library/household-economy-approach-guide-programme-planners-and-policy-makers>[accessed15May 2014].

SMART (Standardized Monitoring and Assessment of Relief Transitions) (2005) *MeasuringMortality,NutritionalStatusandFoodSecurityinCrisisSituations: The SMART Protocol, Version 1*, SMART, Tulane University, New Orleans,<www.smartindicators.org/> [accessed15May2014].

Хавсралт 3.2: Оролцооны аргууд

Арга	Үнэлгээний шалгах хуудас	Сэдэв
Өдөр тутмын / улирлын хуанли	1.5	Хүйс/нас болон үүрэг оролцоо
Хүйсийн дүн шинжилгээ- Нөөц ашиглах эрх (Pasteur,2002)	1.5 1.7	Хүйсийн хяналт болон нөөц ашиглах эрх Хүйс болон эрх мэдлийн харилцааны дүн шинжилгээ
Зураглал гаргах	2.5 2.6 2.7 2.7 2.9 2.10	Нэрвэгдсэн газрын хүрээ Нэрвэгдсэн эмзэг бүлгүүд "Ердийн»болон онцгой байдлын үеийн үйлчилгээ, хэрэгсэл Байгалийн нөөцийн зураглал (өмнө ба дараа): бэлчээр; ус; нүүдэл Байгаль орчинд учруулсан нөлөө Улирлын өөрчлөлтүүд
Цагийн хуваарилалт/ Цагийн төлөв	2.4 2.7 2.7 2.7 2.8	Онцгой байдлын үе шатууд Мал амьтан худалдаалах төлөв Малын үнийн төлөв Малын бүтээмжийн төлөв Малын өвчний төлөв
Тоон харьцаа	1.3,1.4 2.6 2.6 2.7,2.8	Орлого/хоол хүнсний нөөц Хүнс тэжээлийн төлөв дэх өөрчлөлт Хүний өвчлөл дэх өөрчлөлт Малын худалдаа, үнэ, бүтээмжийн өөрчлөлт
Эрэмбэлэх/ дугаарлах	1.3,1.4 2.8 3.5	Орлого/хоол хүнсний нөөц Малын байдал, хорогдол, өвчлөл Өмнөх үр дүнтэй хариу арга хэмжээнүүдийн түүх
Хөрөнгийн жагсаалт	2.6	Нэрвэгдсэн хүн ам (зорилтот бүлгийг тогтоох)
Вени диаграм	1.6 3.1,3.2	Захиргааны байгууллагуудын үүрэг болон харилцаа холбоо Гол оролцогчид болон тэдний уялдаа холбоо

** Дугаар нь бүлгийн эхэнд дурьдагдсан гол асуултуудын дугаар.*

Орон нутгийнханы оролцоотой үнэлгээний (PRA) аргачлалтай холбоотой илүү дэлгэрэнгүй мэдээллийг Ашигласан материалын жагсаалтаас харна уу.

Хавсралт 3.3: LEGS-н Оролцооны аргаар хариу арга хэмжээг тодорхойлох матриц

Хүснэгт 3.7 Гэнэтийн гамшгийн үеийн PRIM

Мэргэжлийн үйл ажиллагаанууд	Амьжиргааны зорилтууд			Гамшгийн үе шатууд		
	Яаралтай тусламж	Эд хөрөнгийг хамгаалах	Эд хөрөнгийг нөхөн сэргээх	Гэнэтийн хор хохирол	Эрт үеийн нөхөн сэргээлт	Нөхөн сэргээлт
Мал тоо бууруулах						
Мал эмнэлгийн үйлчилгээ						
Тэжээл						
Ус						
Хашаа, саравч						
Малжуулах						

Хүснэгт 3.8 Удаан явцтай гамшгийн үеийн PRIM

Мэргэжлийн үйл ажиллагаанууд	Амьжиргааны зорилтууд			Гамшгийн үе шатууд			
	Яаралтай тусламж	Эд хөрөнгийг хамгаалах	Эд хөрөнгийг нөхөн сэргээх	Сэрэм жлүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээлт
Мал амьтны тоог бууруулах							
Мал эмнэлгийн үйлчилгээ							
Тэжээл							
Ус							
Хашаа, саравч							
Малжуулах							

LEGS-н амьжиргааг дэмжих зорилтуудын үнэлэхдээ:

***** Маш сайн эерэг үр нөлөөтэй

**** Сайн үр нөлөөтэй

*** Тодорхой хэмжээний үр нөлөөтэй

** Багахан үр нөлөөтэй

* Маш бага үр нөлөөтэй

т/б Тохиромжтой бус

Онцгой байдлын үе шатуудыг тэмдэглэхдээ:

→ үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай хугацаа

Ашигласан хэвлэл ба цаашид уншиж судлах материал

ActionAid International (undated) *Participatory Vulnerability Analysis: A Step-by- Step Guide for Field Staff*, ActionAid International, London. Available from:<http://www.livestock-emergency.net /resources/ assessment-and-response/> [accessed 17 May 2014].

Albu, M. (2010) *Emergency Market Mapping and Analysis Toolkit (EMMA),* Practical Action Publishing, Rugby.

Barrett, C.B., Bell, R., Lentz, E.C. and Maxwell, D.G. (2009) "Market information and food insecurity response analysis", *Food Security* 1: 151–168 <http://dx.doi. org/10.1007/s12571-009-0021-3>.

Catley, A. (2005) *Participatory Epidemiology: A Guide for Trainers*, African Union/Interafrican Bureau for Animal Resources, Nairobi, <http://www. participatoryepidemiology.info/userfiles/PE-Guide-electronic-copy.pdf> [accessed 17 May 2014].

Catley, A., Alders, R.G, and Wood, J.L.N. (2012) "Participatory epidemiology: approaches, methods, experiences", *The Veterinary Journal* 191: 151–160.<http://dx.doi.org/10.1016/j.tvjl.2011.03.010>.

Currion, P. (2014) "Sphere for Assessments", The Sphere Project and ACAPS, Geneva.

FAO (undated) *Gateway to Farm Animal Welfare* [website], FAO, Rome, <http://www. fao.org/ag/againfo/themes/animal-welfare/en/> [accessed 17 May 2014].

FAO and ILO (Food and Agriculture Organization of the United Nations and International Labour Organization) (2009) *The Livelihood Assessment Toolkit: Analysing and Responding to the Impact of Disasters on the Livelihoods of People*, FAO and ILO, Rome and Geneva, <http://www.fao.org/fileadmin/ user_upload/emergencies/docs/LAT_Brochure_LoRes.pdf> [accessed 17 May 2014].

FAWC (Farm Animal Welfare Council) (2012) *Opinion on Contingency Planning for Farm Animal Welfare in Disasters and Emergencies*, FAWC, London. Available from: <http://www.defra.gov.uk/fawc/> [accessed 23 May 2014].

FAWC (undated) *Five Freedoms* [web page], Farm Animal Welfare Coun-

cil, London,<http://www.fawc.org.uk/freedoms.htm> [accessed 19 May 2014].

Harvey, P. (2007) *Cash-Based Responses in Emergencies*, Humanitarian Policy Group (HPG), Overseas Development Institute (ODI), London, <http://www. odi.org.uk/sites/odi.org.uk/files/odi-assets/publications-opinion-files/265.pdf> [accessed 29 May 2014].

Harvey, P. and Bailey, S. (2011) Cash Transfer Programming in Emergencies, Humanitarian Practice Network, Good Practice Review No. 11, ODI, London.

Heath, S.E. (1999) Animal Management in Disasters: A Handbook for Emergency Responders and Animal Owners, Mosby, Maryland Heights, Missouri.

Hermon-Duc, S. (2012) MPESA Project Analysis: Exploring the Use of Cash Transfers Using Cell Phones in Pastoral Areas, Тйлйcoms Sans Frontиres and Vйtйrinaires Sans Frontиres, Germany and Nairobi.

Holland, J. (ed.) (2013) Who Counts? The Power of Participatory Statistics, Practical Action Publishing, Rugby.

Horn Relief (2010) Guidelines for Cash Interventions in Somalia, Horn Relief, Nairobi. ICRC and IFRC (International Committee for the Red Cross and International Federation of Red Cross and Red Crescent Societies) (2007) Guidelines for

Cash Transfer Programming, ICRC and IFRC, Geneva.

IDS (Institute of Development Studies) (2005) Desk Review: Identification of Factors that Trigger Emergency Needs Assessments in Slow-Onset Crises, Strengthening Emergency Needs Assessment Capacity (SENAC) Project, Emergency Needs Assessment Branch (ODAN), World Food Programme, Brighton, <http://www. ids.ac.uk/files/FinalTriggeringFactorsFeb06.pdf> [accessed 17 May 2014].

IIED (International Institute for Environment and Development) (1995) RRA Notes 20: Livestock [online], IIED, London, <http://pubs.iied.org/6089IIED.html?k=PLA Notes&r=p> [accessed 17 May 2014].

IIED (2002) PLA Notes 45: Community-Based Animal Healthcare, IIED, London, <http:// pubs.iied.org/9218IIED.html?k=PLA Notes&r=p> [accessed 17 May 2014].

Jaspars, S., Harvey, P, Hudspeth, C. and Rumble, L. (2007) A Review

of UNICEF"s Role in Cash Transfers to Emergency-Affected Populations, Working Paper, United Nation"s Children"s Fund (UNICEF) Office of Emergency Programmes (EMOPS), Geneva.

Kelly, C. (2005) Guidelines for Rapid Environmental Impact Assessment in Disasters, [Rapid Environmental Assessment Tool], Benfield Hazard Research Centre, UCL, London and CARE International. Available from: <http://www.proactnetwork. org/proactwebsite/resources/tools-for-environmental-assessment> [accessed 26 June 2014].

Mattinen, H. and Ogden, K. (2006) "Cash-based interventions: lessons from southern Somalia", Disasters 30(3): 297–315 <http://dx.doi.org/10.1111/j.0361-3666.2005.00322.x>.

OIE (World Organisation for Animal Health) (2012b) Terrestrial Animal Health Code, 22nd edn, vol. 1, OIE, Paris, <http://www.oie.int/international-standard-setting/ terrestrial-code> [accessed 17 May 2014].Oxfam (2008) Situation Analysis Knowledge Map. Interactive program available on request from Oxfam. Contact:<EFSLteam@Oxfam.org.uk>.

Oxfam (2007) Programme Guidelines on Animal Welfare, Oxfam, Oxford.

Pasteur, K. (2002) "Gender analysis for sustainable livelihoods frameworks: tools and links to other sources", draft. Available from: <http://www.livestock-emergency. net/resources/assessment-and-response/> [accessed 17 May 2014].

Pretty, J.N., Guijt, I., Thompson, J. and Scoones, I. (1995) Participatory Learning and Action: A Trainer"s Guide, IIED, London, <http://pubs.iied.org/6021IIED. html?c=part&r=p> [accessed 17 May 2014].

ProVention Consortium (2007) Community Risk Assessment Toolkit, ProVention Consortium, Geneva, <http://www.eldis.org/go/topics/resource-guides/ climate-change/key-issues/disaster-risk-reduction/disaster-risk-reduction- thematic-areas&id=31537&type=Document#.U3pe1rkU_Vh> [accessed 17 May 2014].

SEEP (Small Enterprise Education and Promotion) Network (2010) Minimum Economic Recovery Standards, SEEP Network, Washington, DC, <http://www. seepnetwork.org/minimum-economic-recovery-standards-resources-174. php> [accessed 15 May 2014].

Sphere Project (2011) Humanitarian Charter and Minimum Standards in Humanitarian Response (the Sphere Handbook), The Sphere Project, Geneva. See Core Standard 3: Assessment (pp. 61–65). <www.sphereproject.org/> [accessed 15 May 2014].

Trench, P., Rowley, J., Diarra, M., Sano, F. and Keita, B. (2007) Beyond any Drought: Root Causes of Chronic Vulnerability in the Sahel, The Sahel Working Group, IIED, London, <http://pubs.iied.org/pdfs/G02317.pdf> [accessed 17 May 2014].

UNHCR and CARE (United Nations High Commissioner for Refugees and Cooperative for Assistance and Relief Everywhere) (2009) Framework for Assessing, Monitoring and Evaluating the Environment in Refugee-Related Operations (FRAME Toolkit), joint UNHCR and CARE project, <http://www. unhcr.org/4a97d1039.html> [accessed 15 May 2014].

UNICEF (United Nations Children"s Fund) (2005) Emergency Field Handbook: A Guide for UNICEF Staff, UNICEF, New York, <http://www.unicef.org/publications/files/ UNICEF_EFH_2005.pdf> [accessed 17 May 2014].

Vetwork (2011) The Use of Cash Transfers in Livestock Emergencies and their Incorporation into the Livestock Emergency Guidelines and Standards (LEGS), Animal Production and Health Working Paper No. 1, FAO, Rome. Available from: <http://www.livestock-emergency.net/resources/general-resources-legs- specific/>.

Young, H. and Jaspars, S. (2006) Food-Security Assessments in Emergencies: A Livelihoods Approach. Humanitarian Practice Network Paper 36, ODI, London.<http://www.odihpn.org/documents/networkpaper036.pdf> [accessed 17 May 2014].

Zicherman, N. with Khan, A., Street, A., Heyer, H. and Chevreau, O. (2011) Applying Conflict Sensitivity in Emergency Response: Current Practice and Ways Forward, Humanitarian Practice Network Paper No. 70, ODI, London.

Санамж

1. Оролцооны асуулга нь асуудал, боломж болон шийдэлд орон нутгийн хүмүүсийн оролцоотой хийх системчилсэн дүн шинжилгээ юм. Хэрэв сайн хийж чадвал оролцооны асуулга нь эмзэг болон ядуу бүлгүүдийн үзэл бодлыг ойлгоход туслах тул асуултуудаар бүлэг нэг бүрийн мэдээллийг автоматаар гаргаж харуулах боломжтой.

БҮЛЭГ 4

Мал амьтны тоо толгойг бууруулах техникийн стандарт

Мал амьтны тоо толгойг бууруулах

Танилцуулга

Ган шиг удаан явцтай гамшгийн явцад бэлчээр тэжээл, усны дутагдлаас үүдэн мал амьтны тарга хүч буурсаар байдаг. Мал амьтны тоо толгойг бууруулах нь хэт эцэж турах, зах зээлийн үнэлэмжээ алдах улмаар нийгмийн эрүүл мэндэд эрсдэл учруулахаас өмнө гамшигт нэрвэгдсэн мал сүргийг эргэлтэд оруулж байгаа үйл явц юм. Мал амьтны тоо толгойг бууруулснаар нэгэнт хорогдох малаасаа ашиг олоод зогсохгүй эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай байгаа мах болон бэлэн мөнгийг хангаж өгдөг.

Энэ бүлэгт онцгой байдлын хариу арга хэмжээ болгон мал амьтны тоо толгойг бууруулахын ач холбогдол, энэ үйл ажиллагааны хувилбар болон түүнийг хэрэгжүүлэх зохистой арга хэрэгслийн хамтаар нь танилцуулах болно. Энд дурдагдах стандарт, үндсэн үйл ажиллагаа, зааварчилгааг хувилбар бүрт дагаж мөрдөх хэрэгтэй. Энэ бүлгийн төгсгөлд хавсралтад байгаа хяналт үнэлгээний шалгах хуудсын дагуу хийгдсэн жишээ судалгаа оруулсан байгаа. Ашигласан хэвлэлийн жагсаалтыг бүлгийн төгсгөлд хавсаргасан.

Мал амьтны тоо толгойг бууруулах нь LEGS-н амьжиргааг дэмжих зорилттой холбогдох нь

Мал амьтны тоо толгойг бууруулах нь гамшигт нэрвэгдсэн гэр бүлд болон үлдсэн мал сүргийг хамгаалахад шууд туслалцаа болдогоороо LEGS-н амьжиргааг дэмжих нэг ба хоёрдугаар зорилттой шууд холбогдож байдаг Үүнд:

- Зах зээлд борлогдох боломж багатай эсвэл илүүдэл малаа худалдан борлуулснаас гамшигт нэрвэгдсэн ард иргэд бэлэн мөнгөтэй болж шууд ашиг хүртэж байна.
- Мал амьтны борлуулалтаас олсон ашгаараа үлдэх малаа гамшгаас амьд авч үлдэх боломжоо баталгаажуулснаар амьжиргааны эх үүсвэр болсон мал хөрөнгөө хамгаалж байна.

Гамшгийн хариу арга хэмжээ болгон мал амьтны тоо толгойг бууруулахын ач холбогдол

Мал амьтны тарга хүч муудах, үхэж хорогдох нөхцөл бүрдсэн гангийн

үед мал амьтны тоо толгойг бууруулахыг нийтлэг хариу арга хэмжээ болгон хэрэгжүүлдэг. Ингэснээр гамшигт нэрвэгдэн үхэж хорогдож болох мал амьтныг бэлэн мөнгө болон мах болгон хувиргаж байгаа хэлбэр юм. Мал амьтны тоо толгойг бууруулснаар дутагдалтай байгаа мал амьтны тэжээл, бэлчээр, усан хангамжийн ачааллыг бууруулж үлдсэн мал сүргийн ашиглах нөөцийг нэмэгдүүлж өгдөг. Нядалсан мал амьтны мах нь эмзэг бүлгийн өрхийн хүнсний хангамжид тус нэмэр болдог. Гэвч үер, газар хөдлөлт гэх мэтийн гэнэтийн гамшгийн үед мал сүрэг үхэж хорогдсон буюу амьд үлдсэн ч гэсэн мал амьтны тоо толгойг бууруулах хариу арга хэмжээг ихэвчлэн хэрэгжүүлэх боломжгүй байдаг. Далайн хар шуурга, түймэр гэх мэт гамшгийн үед мал амьтны тэжээлийн эх үүсвэр устсан бол мал амьтны тоо толгойг бууруулах нь зохистой хариу арга хэмжээ болно.

Мал амьтны тоо толгойг бууруулах нь мал амьтны тавлаг байдлыг хангах "таван эрх чөлөө" нийтлэг зарчмыг энэхүү гарын авлагын *Танилцуулга* хэсэгт өгүүлсний хоёр нь болох "*өлсөх болон тохь тухгүй байдлаас ангид маллах*" зарчимд нийцнэ. Нядлах болон борлуулах мал амьтныг илүү таатай орчинд тааваараа байх боломжийг хангахын дээр нядлах гэж байгаа бол өлсөх, цангахтай хосолсон өвдөлт, тарчлалтаас ангид байлгахад анхаарах хэрэгтэй. Мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааны үед тухайлбал мал амьтныг барих ачих, тээвэрлэх, нядлахад өвтгөх, айлгах үргээх, тарчлаахгүй байхыг баталгаажуулахад онцгой анхаарал тавих хэрэгтэй.

Мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааны хувилбар

Мал амьтныг худалдан борлуулах ба нядлах гэсэн нийтлэг хоёр үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Хувилбар 1: Мал амьтныг худалдан борлуулж тоо толгойг бууруулах

Мал амьтныг борлуулах нь мал амьтны зах зээл унаж байх үед мал амьтны худалдаа эрхлэгчдэд тусалдаг. Мал аж ахуйн зах зээлийн ийм уналт нь эрэлт буурах, зах зээлд нийлүүлэгдэх мал амьтны тоо багасах, эрэлт багатай мал нийлүүлэгдэх, мал амьтны тарга хүч муу байх, малчид малаа зарахыг хүсэхгүй байх зэргээс шалтгаалдаг. Энэ байдал нь мал

амьтны үнэ унах, мал амьтны худалдаа эрхлэгчид бизнесээ орхиход хүргэдэг.

Мал амьтныг худалдан борлуулж тоо толгойг бууруулахын зорилго нь мал амьтны тарга хүч буурах, зах зээлийн үнэ цэнээ алдан зарагдахгүй болохоос өмнө борлуулахад нь тусладаг. Мал амьтныг худалдан борлуулснаар дараах ашиг тусыг олно.

- гамшигт нэрвэгдсэн нутгийн иргэдийг бэлэн мөнгөөр хангах
- малчид, мал амьтны худалдаа эрхлэгчдийн хооронд урт хугацааны харилцаа холбоо сүлжээ бий болгох
- олон тооны мал амьтан, малчдад үр нөлөө үзүүлж чаддаг арга хэмжээ
- мал амьтныг шууд худалдан борлуулах нь гангийн үед хүмүүнлэгийн байгууллагын шууд оролцоогүй хэрэгжүүлж болдог нэлээд үр ашигтай аргын нэг юм.

Гамшгийн үед мал амьтныг худалдан борлуулж тоо толгойг бууруулахад мал худалдан авах хүсэлтэй худалдаа эрхлэгчид, дотоод болон гадаад зах зээлд мал амьтны мах болон амьд мал амьтны эрэлт хэрэгцээ их байх нь амжилттай хэрэгжихэд түлхэц болдог. Мал амьтны худалдаа эрхлэгчид мал амьтныг шууд нядалгаанд оруулдаггүй хаа нэгтэй тарга хүч автал маллаж байгаад нядлах эсвэл цааш дамжуулан худалдах нь элбэг байдаг.

Мал амьтны худалдаа эрхлэгчдэд үзүүлэх нийтлэг туслалцаанд малчид худалдаачдыг нэг дор уулзуулах, богино хугацааны зээл, нөхөн олговор, татвар, хураамжийн чөлөөлөлт зэргийг хамруулна. Мал амьтны худалдаа эрхлэгчидтэй, малчдыг уулзуулах нь хамгийн энгийн бөгөөд үр ашигтай үйл ажиллагаа юм.

Онцгой байдлын үед зарим хүмүүнлэгийн байгууллага, Засгийн газар мал амьтны худалдаа эрхлэгчидтэй ажиллахаас илүүтэй мал амьтныг шууд худалдан авах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Энэ арга хэмжээ сайн талтай боловч иймэрхүү үйл ажиллагаа нь мал аж ахуйн зах зээлийн урт хугацааны тогтвортой байдлыг алдагдуулахгүй байхад анхаарах хэрэгтэй.

Хувилбар 2: Мал амьтныг нядалж тоо толгойг бууруулах

Гамшгийн үед мал амьтныг борлуулах үйл ажиллагаа зогссон үед хувийн байгууллагаас илүүтэй гадны хүмүүнлэгийн байгууллагын санаачилгаар мал амьтныг нядлах ажлыг эхлүүлдэг. Энэ нь орон нутагт зах зээл уналтанд орж, мал зарагдахгүй, мал амьтны худалдаа эрхлэгчид бизнесээ орхин явсан үед хэрэгжүүлэх зохимжтой арга юм. Худалдан борлуулагдаагүй үлдсэн мал амьтны хувьд тарга хүч нь буурч, зах зээлийн үнэ унасан байдаг. Энэ тохиолдолд хүмүүнлэгийн байгууллага тэдгээр мал амьтныг худалдан авч нядлах ажлыг зохион байгуулдаг бөгөөд мал амьтны шинэ махыг гамшигт нэрвэгдсэн нутгийн иргэдийн хүнсний хэрэгцээнд тараадаг. Мах түргэн мууддаг бүтээгдэхүүн учраас хэрвээ махыг шууд нядалсан даруй тарааж чадахгүй бол давслах, чанах, хатаах зэргээр нөөшлөн хадгалах арга хэмжээ авах шаардлагатай.

Мал амьтныг нядалж тоо толгойг бууруулах нь мал амьтныг худалдан борлуулж тоог бууруулахтай харьцуулахад харьцангуй зардал өндөртэй арга юм. Зардлын зарим хэсэг нь мах түгээх, мах, арьс ширийг боловсруулах ажлын байр бий болгох зэрэгт зарцуулагддаг. Мөн мал амьтны тавлаг байдал ба нийгмийн эрүүл мэндтэй холбоотой нядалгааны болон мах боловсруулах газрыг сайжруулах зардал ч орно.

Энэхүү арга хэмжээний ашиг хүртэгчид нь:

- боломжоор хязгаарлагдмал нутгийн иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд зэрэг нядалгаанд малаа худалдан борлуулахаар сонгогдсон иргэд
- олон ам бүлтэй өрх, ганц бие эцэг эхчүүд, өнчин болон тэжээгчээ алдсан өрх, өндөр настан ба бусад эмзэг бүлгийн хүнсний махыг тусламжаар авахаар сонгогдсон өрх (хэрвээ тухайн тохиолдолд хангалттай хэмжээний мах байгаа бол маргаан үүсэхээс сэргийлж тухайн нутгийн иргэдэд жигд хуваарилан тарааж болно, бусад хүмүүнлэгийн байгууллагууд хүнсний тусламжийн нэг хэсэг болгон эмнэлэг, сургууль, хорих байгууллагыг хамруулан махыг голдуу тарааж байдаг)
- мал нядалгааны газар болон мах бэлтгэх, боловсруулах газрын ажиллагсад нь ашиг олох, ирээдүйд хэрэгцээтэй чадвар эзэмших замаар ашиг хүртэгчид болж болно.

Нэмэлт хувилбар: 3: Мал амьтныг нядалж устгах

Мал амьтан ихээхэн турж эцсэн, өвчилсөн тохиолдолд мах нь хүний хүнсний хэрэгцээнд тэнцэхээргүй бол нядалгааны өмнөх болон дараах үзлэгийн дүнд үндэслэн мал эмнэлгийн ба нийтийн эрүүл мэндийн удирдах албан тушаалтан устгах шийдвэр гаргадаг. Энэ тохиолдолд нийгмийн эрүүл мэндийн эрсдлийг бууруулах үүднээс устгасан мал амьтны сэг зэмийг устгах ёстой. Сэг зэмийг устгах аргачлалын тухай *5-р бүлэгт Мал эмнэлгийн үйлчилгээ* хэсэгт илүү дэлгэрэнгүй авч үзэх болно.

Мал амьтны тоо толгойг бууруулах янз бүрийн хувилбарын давуу, сул тал, гол шаардлагыг нэгтгэн *Хүснэгт 4.1*–д харууллаа.

Хүснэгт 4.1 Мал амьтны тоо толгойг бууруулах хувилбарын давуу ба сул тал, голлох шаардлага

Хувилбар	Давуу тал	Сул тал	Гол шаардлага
1.Мал амьтныг худалдан борлуулж тоо толгойг бууруулах	• Шууд хэрэгцээт бэлэн мөнгөөр хангах ба үлдсэн малд хөрөнгө оруулалт хийх • Гамшгийн даван туулах уламжлалт стратегийг бэхжүүлэх • Бэлчээр, тэжээл усны нөөцийн хомсдолын дарамтаас ангижрах • Олон тооны мал амьтныг хамруулж чаддаг • Ихэнх зардал мал амьтны худалдаа эрхлэгчдээс гардаг тул харьцангуй бага зардалтай • Малчид ба мал амьтны худалдаа эрхлэгчдийн хооронд урт хугацааны харилцаа холбоо, сүлжээ бий болдог. • Мал амьтны тавлаг байдлыг хангадаг.	• Мал турж эцэн боломжит үнэ цэнээ алдахаас өмнө хэрэгжүүлсэн байхыг шаарддаг • Сонгосон эмзэг бүлгийн иргэд хамрагдахад хүндрэлтэй • Мал амьтныг зохисгүй барьж, ачих,тээвэрлэх явцад тавлаг байдалд нь эрсдэл үүсэх талтай • Үлдсэн мал сүрэг нь гамшгийн дараа амьжиргаанд шаардлагатай малаа нөхөн сэргээхэд хүрэлцэхгүй байх	• Мал худалдан авах сонирхолтой худалдаа эрхлэгчид байх • Малчид малаа зарахыг хүсэж байх • Мал, махны дотоод ба гадаадын хангалттай зах зээл байх • Дэд бүтэц: зам, мал худалдах зах, мал амьтны бэлчээр тэжээл, усан хангамж ба аюулгүй байдал • Хүмүүнлэгийн байгууллага мал амьтныг худалдах ба зээлд зуучлах тохиромжтой арга барилтай байх • Хүмүүнлэгийн байгууллагын хувийн хэвшлийг татан оролцуулах зохистай арга барил

2.Мал амьтныг нядалж тоо толгойг бууруулах	• Бэлэн мөнгөөр хангаж үлдсэн малд хөрөнгө оруулалт хийх нөхцөлийг бүрдүүлдэг • Бэлчээр, тэжээл усны нөөцийн хомсдолын дарамтаас ангижрах • Хүнсний нэмэгдэл тусламжаар хангах • Илүүдэл нойтон махыг нөөшлөн хадгалж чаддаг • Орон нутгийн иргэд ажлын байраар хангагдах боломж бүрддэг	• Хэрэгжүүлэх үйл ажиллагааны хувьд илүү төвөгтэй • Захиргааны зардал өндөртэй • Мал худалдан авах зардал нэмэгдсэнээр үйл ажиллагааны зардал өсдөг • Урт хугацааны тогтвортой байдал сул • Олон тооны мал амьтныг хамруулах боломжгүй • Үлдсэн мал сүрэг нь гамшгийн дараа амьжиргаанд шаардлагатай малаа нөхөн сэргээхэд хүрэлцэхгүй байх	• Сонгосон ашиг хүртэгчид туслахад орон нутгийн байгууллага нь удирдах, зохион байгуулах боломжтой байх • Хэрэгжүүлэгч байгууллагууд хэрэглэх арга барил, тухайлбал үнийн стратеги зэрэг асуудлаа уялдуулан зохицуулсан байх • Хүнсний тусламжид мах авах хүсэлтэй байх • Хэрэгжүүлэгч байгууллага нь хөтөлбөрийг удирдах бүтэц зохион байгуулалтын чадамжтай байх • Нийгмийн эрүүл мэндийн бодлогод нийцэж байх • Мал нядалгааны дэд бүтэцтэй байх болон буй болгох боломжтой байх • Мал амьтныг нядлах, мах түгээх байгууллага нутгийн зан заншлын хэм хэмжээг баримталж байх
3.Нядалж устгах	• Мал амьтанд энэрэнгүй хандах • Малчид үр ашиггүй хөрөнгөөсөө зарим зүйлийг буцаан авах	• Хүнсний туслалцаа болохгүй ба урт хугацааны ашиг тус байхгүй	• Мал сүрэг туйлын эцэнхий хүнсэнд хэрэглэх болон зах зээлд зарагдах боломжгүй байх • Нядалгааны өмнөх болон дараах үзлэг хийх орон нутгийн чадамжтай байх

Б 4 Малын тоо толгойг бууруулах

Үйл ажиллагааг хэрэгжүүлэх зохистой цаг хугацаа

Онцгой байдлын үе шатаас шалтгаалан мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааны хувилбарыг тодорхойлдог. Удаан явцтай гамшгийн сэрэмжлүүлэг болон түгшүүрийн үе шатанд мал амьтныг борлуулах нь илүү үр ашигтай байдаг (*Нэр томъёоны тайлбарыг* харна уу). Мал амьтны тоог нядалж бууруулах арга хэмжээг голдуу мал амьтны тарга хүч бууран зах зээлд зарагдахааргүй болсон мал сүрэгт тохиолдсон онцгой байдлын түгшүүрийн төгсгөл, онцгой байдлын буюу шуурхай нөхөн сэргээлтийн шатанд хэрэгжүүлдэг (*Хүснэгт 4.2* харна уу).

Хүснэгт 4.2 Мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зохистой цаг хугацаа

Хувилбар	Гэнэтийн гамшиг			Удаан явцтай гамшиг			
	Гэнэтийн хор хохирол	Эрт үеийн нөхөн сэргээлт	Нөхөн сэргээлт	Сэрэм-жлүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээлт
1.Мал амьтныг худалдан борлуулах	Ерөнхийдөө авч хэрэгжүүлэх боломжгүй			→			
2.Мал амьтныг нядалж хэрэгцээлэх	Ерөнхийдөө авч хэрэгжүүлэх боломжгүй				→		
3.Мал амьтныг нядалж устгах	→					→	

Зах зээлийн нөхцөлд малчид малын үнийг санхүүгийн утгаар дангаараа тодорхойлох нь ховор бөгөөд аливаа нөхцөлд мал амьтны амьд үлдэх боломж, бусад олон хүчин зүйлийг тооцож үзэх шаардлагатай болдог. Гангийн ид үед тэд мал амьтныг ямар үнээр ч хамаагүй борлуулахыг хүсэж байсан ч борооших анхны шинж илрэхэд тэдний санаа бодол өөрчлөгддөг. Иймээс өөрчлөгдөж болох нөхцөл байдлыг харгалзан авах хариу арга хэмжээ нь уян хатан байхаас гадна өөр хувилбарыг хэрэгжүүлэх боломжтой байх хэрэгтэй.

Sphere болон LEGS бусад бүлэгтэй холбогдох нь

Мал амьтны тоо толгойг бууруулах хүмүүнлэгийн арга хэмжээний зорилго нь үлдэж байгаа ялангуяа үржлийн цөм сүргийн малын гамшгийг даван

туулах чадварыг нэмэгдүүлэхэд оршиж байдаг. Иймээс мал амьтны тоо толгойг бууруулах нь LEGS-н бусад үйл ажиллагаа тухайлбал мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, мал амьтныг тэжээл, усаар хангах (*Бүлэг 5-7*) зэрэгтэй салшгүй холбоотой юм. *Гуравдугаар бүлэгт* дурдсан LEGS-н Оролцооны аргаар хариу арга хэмжээг тодорхойлох матрикс (PRIM) нь анхдагч үнэлгээг хийхэд чухал арга хэрэгсэл байх бол *Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх 5-р бүлэг* нь сэг зэмийг устгахад баримтлах мэдээллийг агуулсан болно.

Гангийн дараа өрхийн амьжиргааг хэвийн хэмжээнд хүртэл сэргээхэд шаардлагатай тооны мал сүргийг нөхөн сэргээхэд хэдэн жил шаардагдах тул бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч, фермерийн аж ахуйд дан ганц малжуулах үйл ажиллагаа хангалттай байж чаддаггүй. Хүнсний тусламж мэтийн нэмэлт хүмүүнлэгийн туслалцаа шаардагддаг бөгөөд энэ ажилд Sphere байгууллагын гарын авлага тус нэмэр болно.

Нийтлэг болон харгалзан үзэх бусад асуудлууд

Хүйсийн асуудал

Нийгмийн янз бүрийн бүлэг, давхаргад мал амьтныг эзэмших, маллахад эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөр өөр үүрэгтэй байдаг. Хүйсийн ийм асуудлыг ойлгох нь мал амьтны тоо толгойг бууруулах хувилбар ба ашиг хүртэгчдийг сонгоход чухал ач холбогдолтой. Жишээлбэл, мах түгээх нь эмэгтэйчүүдэд гэр бүлээ хооллоход тус нэмэр болдог бол мал худалдан борлуулснаас олох бэлэн мөнгө нь эрэгтэйчүүдийн зарцуулах эрхийг нэмэгдүүлж түүнд эмэгтэйчүүдээс тавих хяналт бага байдаг талтай. Бэлбэсэн болон өрх толгойлсон эмэгтэйчүүдийг ашиг хүртэгчдээс гадна үлдээхгүй байхад илүү их анхаарч байх хэрэгтэй.

ХДХВ/ДОХ

ХДХВ нь эмзэг өрхийг буй болгож байдаг ба тэдгээрийн дийлэнх нь хагас буюу бүтэн өнчин байдаг. ХДХВ/ДОХ өвчтэй хүмүүс нийгэм хамт олноосоо гадуурхагдаж, ашиг хүртэгч бүлгээс хасагдсан байж болох талтай. Ретровирусын эсрэг эм (ARVs) ууж байгаа хүмүүс эмчилгээгээ үр дүнтэй болгохын тулд нэмэгдэл тэжээллэг хүнс шаардагддаг нь тэдгээр нь хоол хүнсний харьцангуй бага хэмжээтэй махнаас л хангагдаж байдаг.

Хамгаалалт

Овог аймгийн мөргөлдөөн, үймээн самууны үед мал, малчдын аль аль нь эрсдэлтэй нөхцөлд байдаг. Мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагаа нь мал амьтныг олноор нэг дор цуглуулах, малчдад их хэмжээний бэлэн мөнгө тараах зэрэг нь дээрх эрсдлийг нэмэгдүүлэхэд хүргэдэг. Хүмүүнлэгийн байгууллагууд аюулгүй байдал нь эрсдэлтэй бүсэд бэлэн мөнгөнөөс илүүтэйгээр эрхийн бичгийг хэрэглэдэг.

Байгаль орчин ба уур амьсгал

Мал амьтны тоо толгойг бууруулахтай холбоотой байгаль орчны нөлөөлөл нь эерэг ба сөрөг талтай байх бөгөөд зарим нөлөөлөл үйл ажиллагаа дуусан ч үргэлжилдэг. Иймд дараах асуудлуудыг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд:

- Мал нядалгаа нь халдварлагдсан сэг зэмийг оролцуулаад хог хаягдалыг буй болгодог тул бохирдол үүсэхээс зайлсхийж аюулгүй болгон устгах шаардлагатай. Арьс ширийг идээлэх ажиллагаа ч мөн дээрхтэй адил асуудал үүсгэдэг.
- Байгалийн нөөц хомсдсон ган мэтийн гамшгийн үед мал амьтны тоог их хэмжээгээр бууруулах нь орон нутагт дахь дарамтыг багасгаж чаддаг.
- Дүрвэгсдийн хуаран ба мал амьтны зах орчимд олон тооны мал амьтныг бөөгнөрүүлснээр байгаль орчинд богино хугацаанд сөрөг нөлөө үзүүлдэг.
- Нутгийн үүлдрийн мал амьтан аюулд өртсөн үед хамгаалах арга хэмжээ авч чадаагүй бол орон нутгийн биологийн аль нэгэн төрөл зүйлийг устгахад хүргэдэг.

Зорилтот бүлгийг сонгох

Урьдчилан тохиролцсон шалгуур үзүүлэлтүүд ба хамгийн сүүлд хийгдсэн эмзэг байдлын үнэлгээнд суурилсан ашиг хүртэгчдийн шударга сонголтыг хийхэд нутгийн иргэдийн идэвхтэй оролцоо чухал байдаг. Худалдаа эрхлэгчдийн зорилго нь ашгаа нэмэгдүүлэх байдгаас малчид малаа зарах дургуй байдаг, аюулгүй байдал нь хангагдаагүй, мал худалдан авах, нядлах байгууламж муутай нийгмийн бүлгийг орхигдуулж болох талтай. Тэгэхээр мал амьтны худалдаа эрхлэгчдэд үзүүлэх аливаа туслалцаа нь эмзэг бүлгийг орхигдуулахгүй байх нөхцөл болзолыг тусгасан байх хэрэгтэй.

Даван туулах стратеги ба уламжлалт мэдлэг

Мал аж ахуй эрхлэгчид нь мал сүрэгт тулгарсан онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах, даван туулах уламжлалт стратегитэй байдаг. Малчдын мал аж ахуйн уламжлалт мэдлэг, чадвар нь ямар мал амьтныг худалдах, нядлах, ямар малыг үлдээхийг сонгоход чухал ач холбогдолтой байдаг. Малчин бүр мал нядлах, мах бэлтгэх, мах нөөшлөн хадгалах талаар арвин туршлагатай байдаг.

Хуаран байгуулах

Мал бүхий дүрвэгсдийг байршуулах хуаранд тусгайлан анхаарал хандуулах шаардлага гардаг. Мал амьтныг олон тоогоор бөөгнөрүүлэх нь малын хулгайч нарын анхаарлыг татсан цэг болох учраас аюулгүй байдлыг хангах нэмэлт арга хэмжээ авах шаардлага гардаг. Хуаранд мал нядлах, мах түгээх, мал амьтны сэг зэм, хүнсний шаардлага хангахгүй гулууз устгах зэрэг нь орчны эрүүл ахуйн нөхцөл муудах, бохирлогдох зэргээр нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийг нэмэгдүүлж байдаг.

Стандартууд

Мал амьтны тоо толгойг бууруулах арга хэмжээ нь малчдын хувьд ийм арга хэмжээ хэрэгжүүлээгүй бол мал нь үнэ цэнэгүй болох, үхэж хорогдох эсвэл хямд үнэтэй болох зэрэг малын үнэ цэнэ алдагдахаас сэргийлдэг. *Бүдүүвч 4.1*-д мал амьтны тоо толгойг бууруулах санаачлагыг төлөвлөх явцад анхаарах шаардлагатай гол асуултын шийдвэрийн модны загварыг дүрслэн харуулсан байгаа. Мал амьтныг худалдан борлуулж тоо толгойг бууруулах нь мал тарга хүчээ алдаагүй, зах зээлийн үнэ нь унахаас өмнө хэрэгжүүлэх боломжтой байдаг. Энэ үе өнгөрснөөс хойш зөвхөн мал амьтныг нядалж тоо толгойг бууруулах хувилбар хэрэгжүүлж болно. Онцгой байдлын бэлэн байдал, нөхцөл байдлын эрт үеийн дүн шинжилгээ нь мал амьтны тоо толгойг бууруулах боломжтой зохистой хариу арга хэмжээ мөн үү гэдгийг шийдэхэд чухал байдаг.

Хүснэгт 4.1 Малын тоо толгойг бууруулах шийдвэрийн модны загвар

Тайлбар:
"Үйлдэл хийхгүй" гэсэн үр дүн (онцгойлон үзэх асуудал гараагүй бол)"гэдэг нь газар дээр нь ямар нэг арга хэмжээ авч болохгүй гэсэн үг яг биш гэхдээ гол асуултуудад "тийм" гэсэн хариулах боломжтой байх үүднээс цаашид шаардлагатай сургалт буюу чадавхийг сайжруулах асуудлууд шаардлагатай байж болох юм.

Малын тоо толгойг бууруулах стандарт 1: Үнэлгээ ба төлөвлөлт

Зах зээлийн нөхцөл ба малын тарга хүчтэй нийцсэн мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааны хувилбарыг сонгоно.

Үндсэн үйл ажиллагаа

- Мал аж ахуйтай холбоотой эрт сэрэмжлүүлэгийн мэдээлэл, гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөг үнэлэх ашиглах (*Зааварчилгаа 1* , 2 харна уу)
- Мал аж ахуйн зах зээлд ойр ойрхон хяналт хийх (*Зааварчилгаа 3* харна уу)
- Мал амьтны тарга хүч, эрүүл мэндийг ойр ойрхон хянаж байх (*Зааварчилгаа 4* харна уу)
- Мал амьтныг борлуулахад мал амьтны худалдаа эрхлэгчид худалдан авах хүсэлтэй байх, мал сүрэг хангалттай тарга хүчтэй байхад хэрэгжих боломжтойг тооцон үзэх (*Зааварчилгаа 3*, *4* харна уу)
- Мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагаанд хамруулж болох мал амьтны зохистой нас, хүйс, төрөл, зүйлийг тодорхойлох нь орон нутгийн нөхцөл байдал, уламжлалт мэдлэг, практикаас шалтгаалдаг (*Зааварчилгаа 5* харна уу)
- Үнэлгээг баталгаажуулахын тулд онцгой байдлын үеийн нийгмийн зохион байгуулалт болон хөгжлийн нөхцөл байдлыг өргөн хүрээтэй харгалзан үзэх (*Зааварчилгаа 6* харна уу)
- Нэрвэгдсэн нийгмийн бүлгийн хамруулалтыг баталгаажуулахын тулд энэ арга хэмжээний төлөвлөлт, үнэлгээний ажилд нэрвэгдсэн иргэдийг бүрэн хэмжээгээр хамруулах (*Зааварчилгаа 7* харна уу)
- Мал сүрэг, малчид, хүмүүнлэгийн байгууллагын ажиллагсдын аюулгүй байдлыг баталгаажуулах үүднээс аюулгүй байдлын үнэлгээ хийх (*Зааварчилгаа 8* харна уу)
- Мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагаанаас гарах стратегийг урьдчилан боловсруулах (*Зааварчилгаа 9* харна уу)

Зааварчилгаа

1. **Эрт сэрэмжлүүлэг ба онцгой байдлын бэлэн байдал.** Ихэнх ганд нэрвэгддэг нутгуудад хүмүүнлэгийн байгууллагуудад мал амьтны тоо толгойг бууруулах хугацааг тооцон үзэх зарим нэг эрт сэрэмжлүүлгийн тогтолцоо, онцгой байдлын бэлэн байдлын төлөвлөгөөтэй байдаг.
2. **Зохистой цаг хугацаа.** Мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагаа нь онцгой байдлын үе шаттай нягт уялдах ёстой (*Хүснэгт 4.2* харна уу).
3. **Мал аж ахуйн зах зээлийн мониторинг.** Мал худалдан авах эрэлт нэмэгдээгүй байхад малын зах дээр илүү олон тооны мал худалдахаар авчрах буюу малын үнэ унах зэрэг нь мал аж ахуйн зах зээлийн хямралын дохио болдог. Малчид малаа ердийн зах зээлд борлуулан болзошгүй сүйрлээс аврах гэж ороллдог. Мал амьтны зах зээлийн үнэ 25 хувь унах буюу үр тариа-мал амьтны үнийн харьцаанд 25 хувийн өсөлт гарах нь голдуу мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааг эхлүүлэх санамж болж өгдөг. *Хавсралт 4.1* байгаа мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааны шалгах хуудсыг харна уу .
4. **Мал амьтны тарга хүчний мониторинг.** Мал амьтны тарга хүч буурах нь мал сүрэгт аюул учруулахуйц хямрал нүүрлэж байгаагийн шалгуур үзүүлэлт болдог. Мал амьтны тарга хүч ердийнхөөс муу, мал олигтой таргалаагүй байгааг нутгийн малчид тодорхойлж чадна.
5. **Мал амьтны тоо толгойг бууруулахад малын төрлийг сонгох** Үхрийн тоо толгойг бууруулах нь хүрээлэн байгаа орчинд үзүүлэх шууд нөлөө ихтэйн дээр орон нутгийн эдийн засагт ихээхэн бэлэн мөнгийг оруулж байдаг. Гэвч үхэр зарж борлуулах нь эмэгтэйчүүд ба эмзэг бүлгийг асуудлыг орхигдуулж тэгш бус, хүйсийн тэнцвэртэй бус байдлыг үүсгэж байна. Мал амьтны тоо толгойг бууруулахад хонь, ямааг илүү оруулснаар илүү олон эмзэг бүлэг ашиг хүртэх боломжтой болдог. Ерөнхий зарчим нь малчид ирээдүйд мал сүргээ нөхөн сэргээхийн тулд залуу үржлийн эм малын тоо толгойг бууруулах үйл ажиллагаанд хамруулахгүй үлдээх хэрэгтэй.

6. **Хөгжлийн ба нийгмийн зохион байгуулалтын нөхцөл байдал.** Мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагаатай холбоотой тодорхойлсон эрсдэл болон боломжийг баталгаажуулах үүднээс үүссэн онцгой байдлын нөхцөл байдлыг ойлгосон байх хэрэгтэй. (*Нийтлэг стандарт 7: Бодлого болон нөлөөлөл* хэсгийг харна уу). Үүнд хамааралтай мэдээлэлд дараах зүйлийг багтааж болно.
   - хилийн худалдааны хориг, дотоод дахь мал амьтны отор нүүдэл, тээвэр туувар, зөвшөөрөл ба татварын дэглэм, зээл авах ба мөнгө шилжүүлэх, нийгмийн эрүүл мэндийн болон мал эмнэлгийн дүрэм журам ба дэд бүтэц
   - бусад байгууллагаас үзүүлж байгаа туслалцааг уялдуулан зохицуулах шаардлагатай, өөр хоорондоо өрсөлдөхгүй байх
   - хэрэгжүүлэгч байгууллагын хувийн хэвшилтэй хамтран ажиллах, зээл олголт, мал болон орон нутгийн үйлчилгээг олж авах үйл явцыг зохицуулах бодлого журам.
7. **Нутгийн иргэдийн оролцоо.** Нутгийн иргэдийн оролцоог хангасан гол түншлэгч, ашиг хүртэгчид (эмэгтэйчүүдийг оруулаад), орон нутгийн эрх баригчдын төлөөлөл ба бусад хүмүүнлэгийн байгууллагын төлөөлөл, адил аргаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа бол бүх байгууллагыг оролцуулсан бүтцийг (ихэвчлэн зохицуулах бүлэг хэлбэртэй) бий болгох хэрэгтэй.
8. **Аюулгүй байдал.** Мал амьтны тоо толгойг бууруулах ажиллагаа нь одоо байгаа аюулгүй байдалтай холбоотой асуудал учруулах эсэхийг тооцох хэрэгтэй. Хүмүүнлэгийн байгууллага нь ажилчдаа болон гэрээлэгч нарын аюулгүй байдлыг баталгаажуулах, хамгаалах үүрэгтэй байдаг. Бэлэн мөнгө авч явахын оронд эрхийн бичиг хэрэглэх мэтийн хувилбарыг судалсан байх хэрэгтэй.
9. **Гарах стратеги.** Мал амьтны тоо толгойг бууруулах ажиллагааг урт бус хугацааны туршид сөрөг үр дагавар гаргахгүйн тулд үйл ажиллагааг хэзээ яаж дуусгах төлөвлөгөө чухал байдаг. Малчид малаа зарж борлуулах, худалдаа эрхлэгчид мал худалдан авахаар зах зээлд оролцох зэрэгт нөлөөлдөг мал аж ахуйн зах зээлийн үнэ, тарга хүчний өөрчлөлт, борооших зэрэг онцгой байдлын гэнэтийн өөрчлөлтөд дасан зохицох уян хатан чадавхитай байх шаардлагатай.

Мал амьтны тоо толгойг бууруулах стандарт 2: Малыг худалдан борлуулж тоо толгойг бууруулах

Энэ үйл ажиллагаа нь онцгой нөхцөлд худалдан борлуулах боломжтой малыг зах зээлд нийлүүлэх.

Үндсэн үйл ажиллагаа

- Гамшигт нэрвэгдсэн нийгмийн бүлгийг хамруулах (*Зааварчилгаа 1* харна уу).
- Мал, махны эрэлтийг үнэлэх ба өртөгийн ба нийлүүлэлтийн сүлжээн дэх сул талыг тодорхойлох (*Зааварчилгаа 2* харна уу).
- Гол түншлэгчдээ тодорхойлох (*Зааварчилгаа 3* харна уу).
- Мал амьтныг худалдан борлуулах газар нутгаа сонгох, борлуулах боломжтой мал, дэд бүтэц, аюулгүй байдлыг тооцон үзэх (*Зааварчилгаа 4* харна уу).
- Мал амьтныг сонгон авах, зарж борлуулах үнийг тогтоох шалгуураа хэлэлцэн тохирч мэдээлэх (*Зааварчилгаа 5* харна уу).
- Мал борлуулах ажиллагааны зардлыг тооцон үнэлэх (*Зааварчилгаа 6* харна уу).
- Мал амьтныг зарж борлуулан тоо толгойг бууруулах үйл ажиллагааг амжилтад хүргэх гол туслалцааг зөв тодорхойлох ба үнэлэх (*Зааварчилгаа 7* харна уу).
- Тусламжийн үйл ажиллагаанд хяналт хийх, хэрэгжүүлэх (*Зааварчилгаа 8,9* харна уу).

Зааварчилгаа

1. **Зөвшилцөл ба зохицуулалт.** Зохицуулах бүлгийн (*Стандарт 1, Мал амьтны тоо толгойг бууруулах, зааварчилгаа 7* харна уу) зорилго нь мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, эмзэг бүлгийн иргэдийг орхигдуулахгүй байхыг анхаарна.
2. **Мал аж ахуйн зах зээл ба өртгийн ба нийлүүлэлтийн сүлжээг үнэлэх нь.** Мал амьтныг худалдан борлуулж тоо толгойг бууруулах үйл ажиллагааны үр дүнд зах зээлд орж ирэх илүүдэл

тооны мал амьтныг шингээх эрэлт заавал байх ёстой. Энэ нь дотоодын болон экспортын эцсийн зах зээл эсвэл мал амьтныг худалдаж аваад хадгалах, эцэнхий мал амьтныг бордож тэжээх дундын зах зээл хэлбэрээр байж болдог. Үнийн мэдээлэл, зарагдсан мал амьтны тоо, эрэлт нийлүүлэлтийн хэлбэр, мал амьтны захын зохион байгуулалт ба худалдааны сүлжээ зэрэг мэдээллийг засаг захиргааны болон төрийн өмчийн оролцоотой байгууллагаас (ХАА-н Яам, Худалдааны яам, Статистикийн газар) авах боломжтой байдаг.

3. **Түншлэл.** Мал амьтныг амжилттай худалдан борлуулж тоо толгойг бууруулах нь үйл ажиллагааг хэрэгжүүлж буй хүмүүнлэгийн байгууллага, мал амьтны худалдаа эрхлэгчдийн хоорондын түншлэлээс хамаарч байдаг. Худалдаачдын Холбоо тохиромжтой түншийг олоход тусалж болох юм. Үүрэг хүлээсэн түншлэгчдийн голлох бүлэг нь мал худалдан авах санаачлагыг удирдаад аваад явах сонирхол чадамжтай байх хэрэгтэй (*Жишээ судалгаа 4.1* харна уу).

4. **Тусламжийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх газар нутаг.** Мал амьтныг худалдаж, тоо толгойг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зохистой газар нутгийг сонгохдоо дараах үнэлгээнд үндэслэнэ. Үүнд:
   - хүмүүнлэгийн байгууллагын ажилтнууд, малчид, мал амьтны худалдаа эрхлэгчдийн нийтлэг аюулгүй байдал
   - худалдан борлуулахаар хангалттай тооны мал нийлүүлэх
   - мал амьтны худалдаа эрхлэгчдэд мал худалдан авах сонирхол
   - боломжийн дэд бүтэц: зам, мал амьтны түр зуурын зах, мал амьтны бэлчээр усны хүрэлцээ гэх мэт
   - мал амьтны хөдөлгөөнд тавигдсан мал эмнэлгийн хорио цээрийн байдал.

5. **Мал амьтны сонголт ба үнэ тогтоолт.** Мал амьтны худалдан борлуулж тоо толгойг бууруулах зорилго нь мал амьтны ердийн зах зээл хүндэрсэн үед түүнийг дэмжих явдал юм. Онолын үүднээс бол энэ арга хэмжээ нь малчид, мал амьтны худалдаа эрхлэгчдийн хооронд шинээр харилцаа тогтоох, гүнзгийрүүлэн хөгжүүлж байна. Худалдан авах мал амьтны төрөл, зүйл нь ердийн зах зээлд тарга хүчтэй мал амьтныг борлуулдагтай ойролцоо илүүдэл эр сувай

мал голлож байх хэрэгтэй. Мал амьтныг худалдан борлуулж тоо толгойг бууруулах хөтөлбөрийн дэмжлэгтэй зарагдаж байгаа мал амьтны үнэ ил тод, шударга байхын тулд урьдчилан зохицуулах бүлэгтэй тохиролцох хэрэгтэй (*Зааварчилгаа 1* харна уу).

6. **Борлуулалтын зардал.** Захын хураамж, мал амьтныг тууварлах, нядлах зөвшөөрлийн төлбөр, махны үзлэг шинжилгээний хөлс зэрэг нь мал амьтныг худалдан борлуулалтын зардал болдог бөгөөд эдгээр нь голдуу мал амьтны худалдаа эрхлэгчид хариуцдаг. Иймд эдгээр зардал нь хэт өндөр байх нь алслагдсан зах зээл, мал амьтны тарга тэвээр муу мал борлуулах нь арилжааг хязгаарладаг. Эдгээр төлбөр хураамж нь бэлэн мөнгөний орлого муутай орон нутгийн байгууллагад орлогын чухал эх үүсвэр болдог. Иймэрхүү төлбөрийг түр хугацаагаар зогсоох нь хамгийн зохимжтой хэлбэр юм.

7. **Голлох туслалцаа.** Онцгой нөхцөлд явагдаж байгаа мал амьтны арилжаанд зохистой туслалцааг тодорхойлохын тулд хямралын нөхцөл байдлын саад бэрхшээл, сул талыг сайтар ойлгох нь чухал байдаг. Одоо болтол явагдаж байгаа ердийн зах зээлийг хямруулахгүйн тулд үзүүлэх туслалцаа нь бэрхшээлийг даван туулах, хөнгөвчлөхөд чиглэгдсэн байх хэрэгтэй. Эдгээр туслалцаанд дараах зүйлийг хамруулж болох юм. Үүнд:

   - мал амьтны түр захад ашиглах хашаа хороо, бэлчээр, тэжээл, ус, нэмэгдэл аюулгүй байдлын зохицуулалт, арбитрын үйлчилгээ зэргийг бүрдүүлэн түр зах байгуулан зарлан мэдээлэх замаар мал амьтны худалдаа эрхлэгчид ба малчдыг уулзуулах
   - мал амьтны худалдаа эрхлэгчдийн мал худалдан авах зээл өгөх (арилжааны зээл авахад зуучлан туслах)
   - алслагдсан нутгаас мал тууварлах, тээвэрлэхэд дэмжлэг үзүүлэх-мал амьтны худалдаа эрхлэгчдэд бензин түлшний тэтгэлэг олгох нь орон нутгийн зах зээлд ирэхэд чухал хөшүүрэг болох талтай, гамшигт нэрвэгдсэн нутагт тусламжийн бараа хүргэсэн ачааны хоосон машиныг мал тээвэрлэхэд ашиглах боломж байдаг.
   - түр хугацаагаар бууруулсан буюу түдгэлзүүлсэн орон нутгийн татвар, хураамжаас олох орлогыг нутгийн захиргаанд нөхөн олгох.

8. **Хэрэгжиж байгаа туслалцааг баталгаажуулах.** Шаардлагатай туслалцааг тодорхойлсны дараа хэрэгжүүлэгч байгууллагад үйл ажиллагааны туршид хэрэгжүүлэх хэрэгцээт нөөц байгаа эсэхийг баталгаажуулах хэрэгтэй. Туслалцаа нь өөрчлөгдөх үед нөхцөл байдалд тохирсон хариу арга хэмжээ нь уян хатан байх шаардлагатай, тухайлбал мал амьтны тарга хүч зах зээлд борлогдохгүй болтол буурах хүртэл гэх мэт.

9. **Хяналт шинжилгээ.** Мал амьтныг худалдан борлуулж тоо толгойг бууруулах үйл ажиллагааны хяналт үнэлгээ нь энэ үйл ажиллагааны тоон ба чанарын мэдээллийг цуглуулж цаашид үр дүн, үр нөлөөний үнэлгээ хийх, сайн туршлагыг баримтжуулахад чухал ач холбогдолтой байдаг. Мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааны мониторинг ба үнэлгээний шалгуур үзүүлэлтийг *Хавсралт 4.2* оос харна уу.

Мал амьтны тоо толгойг бууруулах стандарт 3:
Мал амьтныг нядалж тоо толгойг бууруулах

Гамшигт нэрвэгдсэн нийгмийн бүлгийг бэлэн мөнгө ба махаар хангах, ажлын байр нэмэгдүүлэх замаар хямралд өртсөн малаас үнэ цэнийг олж авахад оршино.

Үндсэн үйл ажиллагаа

- Гамшигт нэрвэгдсэн нийгмийн бүлгийг хамруулах (*Зааварчилгаа 1* харна уу).
- Нутгийн иргэдийн оролцоотойгоор мал амьтныг нядлах зориулалтаар худалдан авах газар, өдөр сар зэргийг тодорхойлох ба зарлан мэдээлэх (*Зааварчилгаа 2* харна уу).
- Худалдан авах мал амьтны үнэ ба төлбөрийн хэлбэрийг мал амьтны төрөл зүйл, нас тус бүрээр тохиролцох (*Зааварчилгаа 3,4,5* харна уу).
- Ашиг хүртэгчдийг сонгох ба бараа солилцоо, сайн дурааараа хувь нэмэр оруулах шалгуур үзүүлэлтийг тохиролцох ба ашиг хүртэгчдийг тодорхойлох (*Зааварчилгаа 6,7,8* харна уу).
- Нядлахаар сонгож авах мал амьтны шалгуурыг гарган тохиролцох (*Зааварчилгаа 10* харна уу).

- Шинэ болон хатаасан мах түгээх шалгуур үзүүлэлтийг тохиролцох (*Зааварчилгаа 10* харна уу).
- Мал нядлах, мах бэлтгэх, мах нөөшлөн хадгалахдаа орон нутгийн зан заншил, уламжлалыг мөрдөх ба мал амьтны тавлаг байдлын стандартыг судлах (*Зааварчилгаа 11* харна уу).
- Мал нядалгаатай холбоотой үүсэх нийгмийн эрүүл мэндийн эрсдлийг үнэлэх, дүрэм журмыг дагаж мөрдөх (*Зааварчилгаа 12* харна уу).
- Мал амьтны арьс, ширийг боловсруулах нөхцөл бололцоог үнэлэх ба тохиролцох (*Зааварчилгаа 6* харна уу).
- Хүнсний хэрэгцээнд тохирохгүй гулууз махыг аюулгүй устгах (*Зааварчилгаа 13* харна уу).

Зааварчилгаа

1. **Нутгийн иргэдийн оролцоо.** Мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааны төлөвлөлт ба хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зохицуулах бүтцийг үйл ажиллагааг эхлэхээс өмнө сэргээх буюу шинээр байгуулсан байх хэрэгтэй (*Стандарт 1, Мал амьтны тоо толгойг бууруулах Зааварчилгаа 7, Стандарт 2, Зааварчилгаа* 1 харна уу). Зохицуулах бүлэг нь доорх зүйлсийг тодорхойлсон байх хэрэгтэй.
   - ашиг хүртэгч янз бүрийн бүлгүүдийг сонгох шалгуур үзүүлэлт
   - нядлахаар худалдан авах мал амьтныг сонгох шалгуур үзүүлэлт
   - мал амьтны түр зуурын захыг байгуулах орон газар, цаг хугацаа
   - бэлэн мөнгөний оронд эрхийн бичиг хэрэглэх эсэх,
   - шаардлага хангасан мал нядалгааны газар
   - шинэ ба хатаасан махыг тараах цаг хугацааны шалгуур үзүүлэлт.
2. **Мал худалдан авах газар ба хугацаа.** Мал амьтны түр зуурын зах нь тарга хүч муудсан мал амьтныг хэт хол тээвэрлэх, туухаас сэргийлж гамшигт нэрвэгдсэн нутагт аль болох ойр байх хэрэгтэй. Худалдааны өдөрлөг болох хугацааг урьдаас тогтоон сайтар зарлан мэдээлэх нь чухал. Хүмүүнлэгийн байгууллагын ажилтнууд мал худалдан авах захуудын хооронд явах хугацааг

тооцон нарийвчилсан хуваарь хийх хэрэгтэй. Мал амьтныг хаших хашаа хороо, ус тэжээлээр хангах боломжтой байх төдийгүй мал эмнэлгийн үзлэг хийх, хүмүүнлэгийн байгууллагын хүмүүс ажиллах үйлчилгээ үзүүлэх нөхцөлөөр хангасан байна.

3. **Мал худалдан авах үнэ.** Гамшигт нэрвэгдсэн нутгийн иргэдтэй худалдан авах мал амьтны үнийг мал амьтны төрөл зүйл, нас хүйсээр тохиролцон зарлан мэдээлэх хэрэгтэй. Ижил аргачлалаар мал амьтныг худалдан авч нядлах үйл ажиллагааг тухайн нутагт явуулж байгаа бусад хүмүүнлэгийн байгууллагуудтай өөр хоорондоо өрсөлдөхгүй байх, үл ойлголцол үүсэхээс сэргийлж зохицуулалтыг хийсэн байх нь зүйтэй (*Нийтлэг стандарт 8: Уялдаа холбоо* хэсгийг харна уу). Хэрвээ боломжтой бол зах зээлийн бодит үнэ, хүмүүнлэгийн байгууллагын нядлахаар худалдаж авч байгаа мал амьтны үнийг хянан (ямар байгууллага ямар үнэ төлж байна) шаардлагатай бол тэдгээртэй нийцүүлж болно. Хүмүүнлэгийн байгууллагаас нядлахаар худалдан авч байгаа үнэ нь ердийн зах зээлийн үнээс дээгүүр байж болох ч ирээдүйд малаа зарах малчдад бага ашиг олоход нөлөөлж болох талтай. Гэвч хүмүүнлэгийн байгууллагаас мал худалдан авах үнийг хэт өндөр тогтоох нь хэвийн үйл ажиллагаа нь алдагдсан орон нутгийн мал амьтны захыг улам тогтворгүй болгох талтай.

4. **Эрхийн бичиг.** Эрсдэл ихтэй бүс нутгуудад бэлэн мөнгө авч явснаас эрхийн бичиг ашиглах хувилбар байж болохыг тооцон үзэх хэрэгтэй. Эрхийн бичгийг илүү аюулгүй орчинд дараа нь бэлэн мөнгөөр сольж авах боломжтой байдаг (*Жишээ судалгаа 4.5* харна уу). Энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрхийн бичгийн тогтолцоо хэрхэн ашиглахыг тайлбарлан өгөх нь чухал байдаг.

5. **Худалдан авалт.** Хүмүүнлэгийн байгууллагууд мал амьтныг өөрсдөө шууд худалдан авахаас гадна орон нутгийн бүлгүүд болон хувь хүмүүстэй гэрээлэн гүйцэтгүүлж болдог. Тухайн нутагт боломжтой бол гэрээ байгуулах нь илүү зохимжтой, учир нь энэ хэлбэрээр хэрэгжүүлэхэд амар хялбар, зардал багатай, орон нутгийн байгууллагуудад туслалцаа болдгоороо давуу талтай байдаг. Хүмүүнлэгийн байгууллагын гэрээлэгчид төлж буй үнэ, гэрээлэгч байгууллагын малчдад төлж буй мал амьтны үнэ ил тод ба харилцан тохиролцсон байх ёстой (*Жишээ судалгаа 4.3* харна уу).

6. **Ашиг хүртэгчдийг сонголт.** Мал амьтныг нядалж тоо толгойг бууруулах үйл ажиллагаанд оролцох ашиг хүртэгчдийн янз бүрийн бүлгийг тодорхойлж, сонгох хэрэгтэй. Мөн нядалсан мал амьтны арьс, ширийг хэн эзэмшиж ашиглах талаар гэрээнд тусгах хэрэгтэй (*Жишээ судалгаа 4.3* ба *4.5* харна уу).

7. **Мах түгээх.** Мах хүлээн авагч нь айл өрх, орон нутгийн байгууллагууд тухайлбал сургууль, эмнэлэг, хорих газар, түүнчлэн дүрвэгсдийн хуарангийн оршин суугчид байж болно. Мах түгээх ажиллагааг орон нутгийн зохицуулах бүлгээр дамжуулан хэрэгжүүлэх, өөрийн гэсэн шалгуур үзүүлэлттэй түгээлтийн сүлжээтэй байх, мөн одоо хэрэгжиж байгаа хүнсний түсламж түгээх үйл ажиллагаатай холбогдон хэрэгжүүлж болдог (*Жишээ судалгаа 4.3* харна уу).

8. **Материаллаг хувь нэмэр.** Мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагаанаас ашиг хүртэгч ихэнх нийгмийн бүлгүүдээс зарим нэг материаллаг хувь нэмэр оруулах үүрэг хүлээдэг. Эдгээрт аюулгүй байдлыг хангахад үүрэг хариуцлага хүлээх буюу хөдөлмөр ба материалаар хувь нэмэр оруулах зэргийг хэлэлцэж тохиролцох шаардлагатай байдаг.

9. **Нядлах мал сүргийн сонголт.** Мал амьтныг худалдан борлуулж тоо толгойг бууруулах үйл ажиллагаатай адилаар хөгшин, үржлийн бус, ихэвчлэн эр сувай мал амьтныг голчлон борлуулахад анхаарч аль болох залуу үржлийн мал амьтныг үлдээх хэрэгтэй.

10. **Шинэ махыг хатаасан махтай харьцуулах нь.** Ихэнх нийгмийн бүлэг шинэ мах хэрэглэхийг илүүд үздэг бөгөөд хэрэгжүүлэхэд хялбар байдаг. Шинэ мах нь хурдан мууддаг бүтээгдэхүүн учраас түгээх, тээвэрлэх, хадгалах боломжоос шалтгаалан нэг дор нядлах мал амьтны тоог хязгаарлаж байдаг. Хатаасан мах нь мал амьтныг олноор нядлан, илүүдэл махаа дараа хэрэглэхээр боловсруулан нөөцөлж болдгоороо давуу талтай. Боловсруулж нөөшилсөн мах нь шинэ махтай харьцуулахад илүү өргөн хүрээтэй түгээх боломжтойн дээр хатаасан мах тараах нь зан заншил, уламжлалын хувьд хүлээн зөвшөөрөхүйц байдаг. Махыг хатааж боловсруулах нь шинэ ажлын байр бий болгох, ур чадвар хөгжүүлэх боломж нээн өгдөгөөрөө давуу талтай. Гэвч махыг аюулгүй хатаахын тулд бэлтгэл ажлыг хангах, эрүүл ахуйн байгууламж, цэвэр ус, тохиромжтой агуулах сав хэрэгцээтэй болдог.

11. **Мал нядлах арга.** Мал амьтныг нядлах нь орон нутгийн зан

заншлын хэм хэмжээ, туршлагад тулгуурлахаас гадна мал амьтны тавлаг байдлын суурь шалгуур үзүүлэлтийг зөрчиж болохгүй. Мал амьтныг нядлахад энэрэнгүй байдлаар хандах, аюулгүй байдлыг хангах үүднээс (олс дээс, цахилгаан муужруулагч, буу, хутга, хөрөө, сагс, түмпэн сав) зэрэг үндсэн тоног төхөөрөмж, усаар хангагдсан энгийн нядалгааны хавтан, ялааны хамгаалалт, цус, хаягдал цуглуулах устгах цэг зэргийг бэлтгэсэн байх хэрэгтэй. Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд хангалттай ажиллах хүч шаардлагатай болдог бөгөөд хэрвээ шаардлагатай бол тэдэнд сургалт явуулж удирдлагаар хангах хэрэгтэй болдог.

12. **Нийгмийн эрүүл мэндийн эрсдэл.** Боом, Рифт хөндийн халуурал зэрэг зооноз өвчин ба бэтэг (*Echinococcus*) зэрэг шимэгч хорхойн өвчин нь мал нядлах, мах түгээх ажиллаагаатай холбоотойгоор хүнд дамжин халдварлаж болох талтай. Ялангуяа хоол хүнсний дутагдалд орсон, өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүс илүү өртөмхий байдаг. Мал нядлах үйл ажиллагааг төлөвлөхийн өмнө нийгмийн эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ хийсэн байх хэрэгтэй (*Бүлэг 5 Мал эмнэлгийн үйлчилгээ* хэсгийг харна уу). Нядалгаанд орох мал ба гулууз маханд нядалгааны өмнөх ба дараах үзлэгийг мэргэжлийн хүмүүсээр хийлгэсэн байх нь чухал. Ямар нэгэн мал, гулууз мах хүнсний хэрэгцээнд тэнцэхгүй бол аюулгүй байдлаар устгах хэрэгтэй (*Зааварчилгаа 13* харна уу). Сэлгээт мал нядалгааны газар нь өвчин тархах эрсдлийг багасгахад тус нэмэр болдог. Мах нь амархан мууддаг бүтээгдэхүүн тул эрүүл ахуйн сайн нөхцөлөөр хангах нь хоол хүнсээр дамжих өвчин, хордлого гарах эрсдлийг бууруулах чухал ач холбогдолтой. Дүрвэгсдийн хуаранд мал мядлах, мах эвдэж төхөөрөхөд маш болгоомжтой төлөвлөлт шаардах ба өвчин тархахаас зайлсхийх, нийгмийн эрүүл мэндийг баталгаажуулах үүднээс түр зуурын нядалгааны байгуулж байгуулах хэрэгтэй.

13. **Халдварлагдсан гулууз мах ба нядалгааны хаягдлыг устгах нь.** Хүнсэнд тэнцэхгүй халдварлагдсан гулууз мах, бохир ус, нядалсан мал амьтны чацга баас зэргийг байгаль орчин болон нийгмийн эрүүл мэндэд хор хөнөөлгүйгээр устгах хэрэгтэй. Эдгээр аргуудад булж устгах голдуу хлорын шохойтой булах, гулуузыг шатаах буюу хорио цээр тогтоох зэрэг орно. Бохир ус болон дотор эрхтний ялгадасыг хүний ундны усны эх үүсвэрийг бохирдуулахааргүй зайлуулах ёстой. *Мал эмнэлгийн нийгмийн эрүүл мэндийн Стандарт 3 ба үхсэн мал амьтны сэг зэм устгах* хэсгийг бас үзнэ үү.

Мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааны *жишээ судалгаа*

4.1 Үр нөлөөний жишээ судалгаа: Мал амьтны тоог худалдан борлуулж бууруулах– Этиоп улс

Энэхүү судалгаанд Өмнөд Этиопийн Моуалэд мал амьтныг худалдан борлуулж тоо толгойг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлсний үр нөлөөний үнэлгээг 2006 онд хийсэн үр дүнгээс харуулсан болно. Хоёр мал амьтны худалдаа эрхлэгч тус бүрт 25000 ам.долларын зээлийг АНУ-н Хүүхэд Хамгаалах сангаас олгон тус нутгийн малчдаас үхэр худалдан авахад зуучлан тусалсан байна. Үүний үр дүнд тэд нийтдээ 1.01 сая ам.долларын өртөг бүхий 20000 толгой үхрийг худалдан авсан байна. Дунджаар 5 405 өрх үхрээ худалдсан бөгөөд өрх бүр үхэр борлуулалтаас 186 ам.доллар олсон ажээ. Мал амьтныг худалдан борлуулж тоо толгойг бууруулах үйл ажиллагааны зардал, үр ашгийн харьцаа нь хүмүүнлэгийн зардлын нөхцөлөөр тооцоход 41:1 байсан байна.

Гангийн үед мал амьтны тоо толгойг бууруулснаас олсон орлого нь өрхийн орлогын 54 хувийг бүрдүүлж байсан бөгөөд энэхүү орлогоороо хүнс хоол худалдан авах, үлдсэн малаа арчлах, гэр ахуйн бусад зардлаа нөхөх, төрөл садандаа туслах, түүгээр зогсохгүй өр зээлээ төлөх хадгаламжаа нэмэгдүүлэхэд ашигласан байна. Мал амьтны тоо толгойг бууруулснаар олсон орлогынхоо 79 хувийг орон нутгийн гаралтай бараа үйлчилгээг худалдан авахад ашигласан аж. Энэ арга хэмжээнээс олсон орлогынхоо 37 хувийг үлдэж байгаа малдаа тухайлбал малаа машинаар тээвэрлэж отрын бэлчээрт хүргэхэд зарцуулсан байна. Этиоп улс дахь үйлчилж байгаа амьд үхэр, хөргөсөн үхрийн махны хөрвөх чадвартай экспортын зах зээл нь мал амьтныг худалдан борлуулж тоо толгойг бууруулах үйл ажиллагааны чухал хөшүүрэг болсон төдийгүй гангийн үед мал, мах экспортлогч, нүүдлийн малчдын эмзэг бүлгийн хооронд эерэг холбоос үүсгэж болохыг харуулж чадсан байна.

4.2 Үйл явцын *жишээ судалгаа*: *Мал амьтныг худалдан борлуулж тоо толгойг бууруулахад тээвэрлэлтэд мөнгөн тэтгэлэг олгох– Кени улс*

2001 онд Белгийн улсын Хил Хязгааргүй Малын Эмч нар Төрийн бус байгууллага Хойт Кенийн Турканад ганд нэрвэгдсэн нутгийн иргэдэд туслахдаа янз бүрийн үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байна.

Тээвэрлэлтэд мөнгөн тэтгэлэг олгох

Турканы нүүдэлч малчдаас мал худалдан авч дүүргийн зах болон том худалдаачдад дахин зардаг мал амьтны худалдаа эрхлэгчдийн мал худалдан авалтыг нэмэгдүүлэх зорилгоор Белгийн Хил Хязгааргүй Малын эмч байгууллагаас мал амьтныг тээвэрлэн зах зээлд хүргэх зардлын 40 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэлэг олгосон байна. Мөн Турканаас гадагш махыг экспортолдог мал амьтны том худалдаачдад мөн тэтгэлэг өгсөн байна. Энэ үйл ажиллагааг баталгаажуулах нь дараах байдлаар явагдсан:

- хяналтын ажилтан дүүргийн тээврийн шалган нэвтрүүлэх цэг дээр маягтад гарын үсэг зуран оролцож буй тээврийн хэрэгсэлийн фото зургийг авч баталгаажуулна
- явсан он сар өдөр, мал худалдан авсан газрын байршил, мал амьтны гарал үүсэл, төрөл, тоо толгой зэргийг нарийвчлан тусгасан орон нутгийн удирдлага, мал амьтны эмчийн албан тоот, тээвэрлэлтийн баримт
- орон нутгаас мал ачигдсан гэсэн нутгийн захиргааны удирдах ажилтны тодорхойлолт зэргийг бүрдүүлж байсан.

Нядлах болон шахаж бордохоор нийтдээ 117070 ам.долларын үнэ бүхий 1175 үхэр, 3584 толгой бог мал Кенийн нийслэл Найроб хотруу тээвэрлэгдсэнээс гадна 20688 толгой бог дүүрэг дотроо зөөгдсөн байна. Энэ бүх үйл ажиллагаанд 52790 ам.долларын тээвэрлэлтийн мөнгөн тэтгэлэг өгсөн нь 3340 ам.доллараар төсвөөсөө хэтэрсэн ажээ. Энэ үйл ажиллагааны нэг давуу тал нь түүний нягтлан бодох бүртгэл ба захиргааны зохицуулалт байсан. Гэсэн хэдий ч залиланг хянахад амаргүй байснаас төсөв маш амархан дуусаж байсан аж. Хэдийгээр өндөр түвшний албан тушаалтан, маркетингийн холбоо, нутгийн захиргааны ажилтнуудтай хамтран ажиллаж байсан нь төслийн амжилтад чухал байсан ч авилгалд өртөх магадлалтай байсан байна (Эх сурвалж: Aklilu and Wekesa, 2002).

Ажлын байр буй болгох боломж

Бельгийн Хил Хязгааргүй Малын эмч нар Төрийн бус байгууллага хатаасан мах тарааж түүнийг боловсруулах үйл ажиллагаагаар нутгийн иргэдийг ажлын түр байраар хангасан байна. Нутгийн эмэгтэйчүүдийн боловсруулсан нэг килограмм хатаасан мах тутамд дөрвөн ам.доллар

төлж байсан. Үүнээс гадна нядлах мал амьтны толгой тутамд 0.15 ам.доллар төлж, харин хатаасан килограмм махны үзлэг, агуулах, харуул хамгаалалтад 1.15 ам.доллар төлж нутгийн иргэдэд орлого олгох боломж бүрдүүлсэн байна.

4.3 Үйл явцын жишээ судалгаа: Мал амьтныг нядлахаар гэрээгээр худалдан авсан нь-Кени улс

2000 онд Хуурай Газрын Хөгжлийн Фокус ТББ (ALDEF) Хойд Кенид мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. ALDEF ТББ орон нутийн иргэдээс хөтөлбөрт мал нийлүүлэх найдвартай гэрээт гүйцэтгэгч нарыг өөрсдийн гишүүдийн дундаас тодорхойлж өгөхийг хүссэн. Эдгээр сонгогдсон гишүүд нь эмэгтэйчүүдийн бүлгийг нэмээд 200 гаруй байсан бөгөөд тэдэнд ALDEF байгууллагын зүгээс бичил зээл авахад нь туслалцаа үзүүлсэн байна. Эдгээр бүлгүүд нэлээд хэмжээний бог малын багцыг нийлүүлж чадсан. Мөн эмэгтэй гэрээт гүйцэтгэгч нараас сургууль болон эмнэлгүүдэд үхэр, тэмээ нийлүүлсэн. Худалдан авах үнийн хувьд бог мал бүрт 15 ам.доллар, харин нэг толгой үхэр эсвэл тэмээ нь 66 ам.доллар байхаар хатуу тогтоосон байна. Харин төслийн хоёр дахь үе шатанд энэ үнэ бог мал тутамд 17.50 ам.доллар, тэмээ 73 ам.доллар, харин үхэр 80 ам.доллар болж өссөн байна. Гэрээт гүйцэтгэгч нарт худалдан авах мал амьтны төрөл, зүйл нас хүйсийг тухайлбал, ган гачигийг даван туулах чадваргүй, ихэнхдээ эр мал, хөх дэлэн нь гэмтсэн эм мал, хөгшин, сувай болон өмнө нь хээл хаясан зэргийг худалдан авахаар зарлаж байсан. ALDEF болон гэрээт гүйцэтгэгч нар нь ханган нийлүүлэх мал амьтны төрөл зүйл, тоон дээр харилцан тохиролцсон тохиолдолд гэрээ байгуулж байсан. Гэрээт гүйцэтгэгч нар нь ALDEF-т мал амьтныг дээр дурдсан үнээр зарж борлуулсан бөгөөд ашгийг өөрсдөө авч үлджээ. Худалдан авсан мал амьтныг нутгийн иргэдийн зөвлөлд дамжуулж өгөх бөгөөд ирүүлсэн бичигт үндэслэн төлбөрийг хийнэ. Гэрээт гүйцэтгэгч нарын зүгээс хөтөлбөрт нийтдээ 950 үхэр буюу тэмээ ба 7,500 бог мал нийлүүлсэн байна. Төсөл нь нийт долоон хот орчмын, мөн төдий тооны хүн ам сийрэг хөдөө нутгийг хамарсан бөгөөд мал амьтны нядалгааг долоо хоногт хоёр удаа эдгээр бүс нутгийн нядалгааны газар хийж байсан. Шинэ махыг үр шим хүртэгч нарт тогтмол нийлүүлж байсан. Тухайлбал, хоёр хонь/ямааг найман айлын дунд долоо хоногт нэг удаа нийлүүлж байжээ. Орон нутгийн байгууллагууд долоо хоног тутам тодорхой хуваарийн дагуу мах хүлээн авч байжээ. Жишээлбэл

нэг долоо хоногт нэг сургуульд хоёр үхэр/тэмээг, 3-4 үхэр/тэмээг ахлах сургууль бүрт, эмнэлэгт долоо хоногт зургаан ямаа; сүрьеэгийн төвд долоо хоногт гурван ямаа, зургаан асрамжийн газарт долоо хоногт нэг ямаа болон нэг үхрийг өгөх зэргээр хуваарилж өгдөг байсан.

ALDEF ТББ мал нядлан махаар хангах хөтөлбөрийнхөө ашиг хүртэгчдийг сонгоход нутгийн иргэдийн зөвлөлөөр дамжуулан иргэдийг татан оролцуулсан байна. Эмзэг бүлгийн өрхийг сонгож тэдний жагсаалтыг олон нийтэд зарлан мэдээлсэн байна. Энэхүү жагсаалтыг иргэд шударга бус, санал нийлэхгүй, шүүмжлэлтэй хандвал иргэдийн зөвлөлд буцаан дахин шийдвэр гаргуулж байсан. Иргэдийн зөвлөл ашиг хүртэгчдийг сонгохоос гадна гэрээт гүйцэтгэгчээс мал хүлээн авах, махыг ашиг хүртэгч өрхөд түгээх, арьс ширийг цуглуулах, маргааныг шийдвэрлэх, ALDEF-тай холбоо тогтоох онцгой эрхтэй байсан. Иргэдийн оролцооны түвшин өндөр байснаар төслийн үйл ажиллагаа цагтаа хийгдэж дууссан байна.

4.4 Үр нөлөөний *жишээ судалгаа*: *Мал амьтныг нядалж тоо толгойг бууруулах ба хатаасан мах түгээх-Этиоп улс*

CARE Этиопоос 2006 оны эхээр Өмнөд Этиопын гангийн үед мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь ган гачгаас болж үхэх магадлалтай мал амьтны тоо толгойг бууруулах, мөн гамшигт нэрвэгдсэн хүмүүсийг махаар хангах явдал байв. Худалдан авсан мал амьтныг нядалж, махыг нь хатааж борцлон, хүмүүст түгээдэг байсан.

Нийтдээ 2,411 төрөл бүрийн мал амьтныг нядалж, нийт 2,814 кг хатааж борцолсон махыг савлаж, хүн амд тараасан байна. Савалж хатаасан махны жин нь 0,5 кг-аас 0,75 кг байх бөгөөд айл өрх бүр ойролцоогоор 2,16 кг хатаасан мах хүлээж авсан байна. Мал худалдан авах тогтоосон үнэ нь үхэр 33 ам.доллар, тэмээ 66 ам.доллар, хонь ба ямаа 7.50 ам.доллар байсан. Худалдан авалтыг орон нутгийн хоршоогоор дамжуулан ашгийн тодорхой хувь дээр нь нэмээд арьс, ширийг авахаар тохиролцон гүйцэтгүүлсэн ажээ. Нийтдээ 1,121 айл өрх малаа худалдаж, энэ нь нийтдээ 25,590 ам доллар болсон бөгөөд үүнээс үзэхэд айл өрх бүр малаа зарж борлуулснаас дунджаар 23 ам.долларын ашиг олсон байна.

Төслийн үр нөлөөний үнэлгээгээр мал амьтны тоо толгойг бууруулах төслийн хүрээнд малаа борлуулснаас олсон орлого гангийн

үеийн өрхийн орлогын 38 хувийг бүрдүүлж байсан. Энэхүү орлогынхоо 45 хувийг өрх гэртээ хоол хүнс худалдан авахад, 18 хувь орчмыг мал эмнэлгийн үйлчилгээ авахад, 6 хувийг мал аж ахуйн бусад зардалд зарцуулсан байна (Эх сурвалж: Demeke, 2007).

Түүнчлэн хатаасан махны илчлэг чанарын үр нөлөөг тооцон үзсэн байна. Хатаасан махны гол илчлэг чанар нь уураг байгаа 2,16 кг хатаасан мах янз бүрийн нас хүйсний хүмүүсийн хоол хүнсний хоногийн хэрэгцээт шаардалагыг хэрхэн хангахыг тооцон гаргаж болно. Жишээлбэл:

- 2,16 кг хатаасан мах 1-3 насны хүүхдийн 92 өдрийн уургийн хэрэгцээг хангаж чадна
- мөн хэмжээний хатаасан мах 19-30 насны жирэмсэн эмэгтэйчүүдийн 17 өдрийн уургийн хэрэгцээг хангаж чадахаар байна (Эх сурвалж: Catley, 2007).

4.5 Үйл явцын жишээ судалгаа*: Эрхийн бичиг ба мах түгээлт–Кени улс*

CARE олон улсын байгууллага 2000 онд Кени улсад мал амьтны тоо толгойг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлсэн. Гэвч тус Гарисса дүүрэгт үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй, аюулгүй байдал нь хангагдахгүйн улмаас цэргийн хамгаалалт авахад хүрч байсан ажээ. Энэ бүсэд мал худалдан авсаны төлбөрт бэлэн мөнгө өгөхийн оронд Гариссад байгаа CARE-гийн оффисоос бэлэн мөнгөөр сольж авч болох эрхийн бичиг олгосон байна. Ашиг хүртэгчид өөрсдийн эрхийн бичгээ өөрсдөө юмуу итгэмжлэгдсэн хүнээр өгч явуулан бэлэн мөнгөөр сольж байсан төдий оршин суугаа газраа тусгай эрхтэй худалдаачдаас эрхийн бичгээ мөнгө болгон сольж болохоор байсан. Энэ эрхийн бичгийн системийг ашиглан тус дүүрэгт 850 толгой үхэр, 250 толгой бог мал худалдан авчээ.

Кени улс дахь CARE хүнсний бүтээгдэхүүн түгээх хөтөлбөртөө мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагаагаар бэлтгэсэн махыг нэмж түгээлтээ хэрэгжүүлсэн байна. 39 –н хооллох төвүүдэд 25 үхэр юмуу 50 богийн аль нэгийг хуваариласан байна. CARE-н ажилтнууд тэдгээр мал амьтны нядалгааг хянан харин шинэ махыг ашиг хүртэгчид тараах ажлыг орон нутгийн тусламж үзүүлэх зөвлөлд хариуцуулан үлдээсэн. Орон нутгийн тусламж үзүүлэх зөвлөл нь арьс, ширийг эмэгтэйчүүдийн бүлгүүдэд өгөх үүрэг хүлээсэн байна (Эх сурвалж: Aklilu and Wekesa, 2002).

4.6 Үйл явцын *жишээ судалгаа*: *Махны тусламж хүргэх зөвлөл–*

Кени улс

2000 онд Хойт Зүгийн Тусламж Хөгжлийн Агентлаг (NORDA) Кени улсын хойт нутгийн хорин төв дээр мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Мал амьтны түр зуурын захаас хонь, ямаа, үхрийг нутгийн иргэдтэй тохирцсон үнээр худалдан авсан байна. Ашиг хүртэгч өрхүүдийг дотроо бүлгээр зохион байгуулагдахыг хүсээд дөрвөн өрхийн дунд нэг хонь юмуу ямаа, 30 өрхийн дунд үхэр өгөхөөр хуваарилсан байна. Тэгээд тэдгээр бүлгүүд малаа авч нядлан төхөөрч махаа адил тэгш хуваж авахаар зохицуулсан. Энэ арга хэмжээгээр 13 тонн махыг 6000 ашиг хүртэгчид хүргэж чадсан байна (Эх сурвалж: Aklilu and Wekesa, 2002).

4.7 Үйл явцын *жишээ судалгаа*: Нэмэгдэл тэжээлээр хангах ба *мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагаа–Нигер улс*

2004 оны сүүлээс Нигерт бэлчээрийн ургац доройтож, борооны хэмжээ багассанаар гандах хямрал нүүрлэсэн байна. Jeunesse En Mission Entraide et Developpement (JEMED-Малчдын төлөөх Христийн ТББ) Нигерийн төв бүсийн бэлчээрийн үнэлгээ хийх ажлыг орон нутгийн иргэдийн бүлгүүдээр хийлгэсэн. Мөн JEMED байгууллагаас зах зээлд малаа зарахыг сонирхож байгаа гэр бүлд туслах схемийг боловсруулан гаргасан. JEMED-ийн зүгээс тээврийн хэрэгслээр хангасан бөгөөд үр шим хүртэгч нарын төлөөлөл малаа (айл өрх бүрээс нэг юмуу хоёр бод мал эсвэл хэсэг бог мал) заржборлуулахаар Нигерийн хил рүү авч явах бөгөөд тэнд боломжийн үнээр зарж чаддаг байна.

Мал амьтны тоо толгойг бууруулах энэ төлөвлөгөөгөө мал амьтны нэмэгдэл тэжээлийн хөтөлбөртэй холбосон бөгөөд үр шим хүртэгч айл өрхүүд нь үлдсэн малаа тэжээх зорилгоор өвс, мал амьтны тэжээл худалдан авахыг зөвшөөрсөн байна. Мал амьтны тоо толгойг бууруулах төлөвлөгөөг хэрэгжүүлж дуусахад нийтдээ 4,849 бог мал, 462 бод малыг зарж борлуулсан байсан бөгөөд үүний зэрэгцээ 317,199 кг үр тариа худалдан авсан төдийгүй улаан буудайн хивэг, жугарын сүрэл зэргийг худалдаж авсан байна. (Эх сурвалж: Jeff Woodke, personal communication, 2008)

Хавсралт 4.1: Мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааны үнэлгээний шалгах хуудас

Мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааны хувьд ерөнхийд нь

- Онцгой байдал аль шатандаа орсон байна вэ?
- Мал амьтны зах дээр авчирч байгаа малын тарга хүч ямар байна вэ?
- Мал амьтны зах дээр зарахаар ирж байгаа мал амьтны тоо нэмэгдэж байна уу?
- Мал аж ахуйн зах зээлийн үнэд ямар нэгэн өөрчлөлт гарч байна уу?
- Үйл ажиллагаа хэрэгжүүлэх бүс нутагт ямар хамтран ажиллагч байна вэ?
- Онцгой байдалд өртсөн хувь хүмүүс, өрх, нийгмийн бүлгүүдээс аль нь хамгийн эмзэг өртөмхий байна вэ?
- Мал амьтны тоо толгойг бууруулахад хэн ашиг хүртэж байна вэ?
- Зохицуулах бүлэг байгуулагдаж чадсан уу?
- Мал амьтны тавлаг байдлын шалгуур үзүүлэлтүүдийг тооцон үзсэн үү?
- Энэ бүс нутагт мал амьтны хөдөлгөөн хийх, бэлэн мөнгө авч явахад аюулгүй юу?
- Мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлж чадах ямар орон нутгийн байгууллага байгаа вэ?

Мал амьтныг худалдан борлуулж тоо толгойг бууруулах

- Тухайн бүс нутагт мал амьтны худалдаа эрхлэгчид ажиллаж байгаа юу?
- Мал худалдан борлуулахад таатай дэд бүтэц байгаа юу?
- Мал амьтныг түр хугацаагаар байлгах хашаа хороо байгаа юу?
- Тэндээс ачааны машин хөлсөлж болох уу?
- Ус ба бэлчээр ашиглах бололцоотой юу?

- Тэнд мал амьтныг ачихтай холбоотой мал амьтны тавлаг байдалд нөлөөлөх асуудал байгаа юу?
- Тэнд мал амьтны тээвэр, туувар, худалдаатай холбоотой бодлогын гол бэрхшээл юу вэ?
- Хамгийн эмзэг бүлгийн хүмүүс зах зээлд оролцоход ямар бэрхшээл саад учраад байна вэ?

Мал амьтныг хүмүүсийн хүнсний хэрэгцээнд зориулан нядлах

- Нядалгааны ямар байгууламж орон нутагт байна вэ?
- Мал амьтныг нядлахтай холбоотой орон нутгийн шашны болон соёлын ямар хэв хэмжээ байгаа вэ? Тэд мал амьтны тавлаг байдлын шалгуурыг хүлээн авах талаар зөвшилцдөг үү?
- Мал нядлах, мах бэлтгэх, арьс шир идээлэх гэх мэтийн үйл ажиллагаатай холбоотой орон нутагт хүйсийн ямар үүрэг байдаг вэ?
- Онцгой байдалд нэрвэгдсэнээс малаа нядалж борлуулснаас ашиг хүртэж чадах хувь хүмүүс, өрх, нийгмийн бүлгүүдээс аль хамгийн эмзэг вэ?
- Алслагдсан тосгонд хүрэхийн тулд түр зуурын зах зээл байгуулах хэрэгтэй юу?
- Мал амьтныг нядалж тоо толгойг бууруулах үйл ажиллагаанаас махаар хангах аль эмзэг бүлгийг сонгох хэрэгтэй вэ?
- Мал амьтныг нядалж борлуулах ажиллагааг хэрэгжүүлбэл ямар хувь хүмүүс ажиллах хүчний боломжоос ашиг хүртэж болох вэ?
- Мал амьтныг нядлахын өмнөх болон дараах үзлэгийг хийх чадамж байгаа юу?
- Арьс, ширийг боловсруулах системийг буй болгож чадах уу?

Мал амьтныг нядалж устгах

- Халдварлагдсан гулуузны арьс, ширийг боловсруулж чадах уу?
- Халдварлагдсан гулуузыг устгах ямар байгууламж одоо байгаа вэ?

Хавсралт 4.2: Мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааны хяналт үнэлгээний шалгуур үзүүлэлтийн жишээ

Мал амьтныг худалдан борлуулж тоо толгойг бууруулах

	Үйл явцын шалгуур үзүүлэлт (*болж байгаа үйл ажиллагааг хэмжих*)	**Үр нөлөөний шалгуур үзүүлэлт (*болж байгаа үйл ажиллагааны үр дүнг хэмжих*)**
Мал амьтныг худалдан борлуулж тоо толгойг бууруулах үйл ажиллагааг төлөвлөх	• Төр захиргааны байгууллага ба мал амьтны худалдаа эрхлэгчидтэй хийсэн уузалтын тоо; уулзалтад оролцсон хамтран ажиллагчдын төрөл, хамрах хүрээ • Орон нутгийн иргэдтэй хийсэн уулзалтын тоо; уулзалтад оролцсон хүмүүсийн тоо, нас хүйс	• Өөр өөр оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхой тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уулзалтын тэмдэглэл • Зах зээлийн эрэлтээр баталгаажсан малын худалдаачдын уртай худалдаж авдаг мал амьтны төрөл • Хэрэгцээгээр оновчтой тодорхойлсон мал байлгах газар нутаг • Орон нутгийн засаг захиргаатай тохиролцсон татвар болон бусад захиргаа аж ахуйн асуудлууд • Мал цуглуулах, худалдан авах хуваарь, систем, мал худалдан авахаар тохиролцсон үнэ, төлбөр тооцооны механизм зэргийг тусгасан боловсруулсан орон нутгийн нийгэм хамт олны түвшний төлөвлөгөө
Хэрэгжүүлэх: Мал худалдан авах	• Оролцох мал амьтны худалдаа эрхлэгчдийн тоо • Зарагдсан мал амьтны тоо, төрөл өрх ба бүс нутгаар	• Мал борлуулснаас олсон орлого өрхөөр • Мал амьтны борлуулалтаас олсон орлогын зарцуулалт хэрэглээгээр (хүнс, мал амьтны тэжээл, нүүдэл хийх, эм худалдах гэх мэт) • Нөхөн сэргэх үе шатанд байгаа өрхийн мал амьтны тоо толгойг мал амьтны тоог бууруулаагүй өрхтэй харьцуулсан үзүүлэлт (хөрөнгийн бүлгээр) • Гангийн дараах үед өрхийн мал сүргийн өсөлтийг мал амьтны тоог бууруулагүй өрхтэй харьцуулсан үзүүлэлт (хөрөнгийн бүлгээр) • Бодлогод нөлөөлсөн байдал

Мал амьтныг нядалж тоо толгойг бууруулах

	Үйл явцын шалгуур үзүүлэлт *(болж байгаа үйл ажиллагааг хэмжих)*	**Үр нөлөөний шалгуур үзүүлэлт *(болж байгаа үйл ажиллагааны үр дүнг хэмжих)***
Мал амьтныг нядалж тоо толгойг бууруулах үйл ажиллагааг төлөвлөх	• Орон нутгийн иргэдтэй хийсэн уулзалтын тоо; уулзалтад оролцсон хүмүүсийн тоо, нас хүйс • Сонгосон байршил бүрт байгуулагдсан мал амьтны тоо толгойг бууруулах ажлыг зохион байгуулах нутгийн иргэдийн зөвлөл	• Өөр өөр оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхой тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уулзалтын тэмдэглэл • Мал амьтны тоо толгойг бууруулах орон нутгийн зөвлөлийн тодорхойлолт • Хэлэлцэн тохирч боловсруулсан үйл ажиллагааны төлөвлөгөө – ашиг хүртэгчдийн сонгох шалгуур үзүүлэлт – худалдан авах мал амьтны төрөл тохиролцсон үнэ, төлбөр хийх нөхцөлийн хамт – мал нядлах, мах бэлтгэх, арьс, шир боловсруулах ажилд оролцуулах нутгийн иргэдийг хөлслөх, төлбөр тооцоо
Хэрэгжүүлэлт: Нядалгаа ба мах түгээлт	• Ашиг хүртэгч өрх ба хүмүүсийн тоо • Тухайн нутаг ба нэрвэгдсэн өрхөөс худалдан борлуулсан мал амьтны тоо, төрөл • Өрх бүрт түгээсэн махны хэмжээ • Түр ажилд гэрээлэгдсэн нутгийн иргэдийн тоо	• Малаа худалдан борлуулсан хүмүүс- мал амьтны борлуулалтаас олсон орлого, өрхөөр, орлогын зарцуулалтаар • Мах хүлээн авсан хүмүүс- махны хэрэглээ ба эмэгтэйчүүд ба хүүхдэд үзүүлэх илчлэг чанар • Түр ажилд гэрээлэгдсэн хүмүүс- олсон орлого ба түүний зарцуулалт

LEGS-н үнэлгээний арга хэрэгслийг доорх холбоосоор орж LEGS веб хуудаснаас үзэх боломжтой. <http://www.livestock-emergency.net/resources/general-resources-legs-specific/>.

Ашигласан хэвлэлийн жагсаалт ба цаашид уншиж судлах материал

Abebe, D., Cullis, A., Catley, A., Aklilu, Y., Mekonnen, G. and Ghebrechirstos, Y. (2008) "Impact of a commercial de-stocking relief intervention in Moyale district, southern Ethiopia", Disasters 32(2): 167–186, <http://dx.doi.org/10.1111/j.1467-7717.2007.01034.x>.

Aklilu, Y. and Wekesa, M. (2002) Drought, Livestock and Livelihoods: Lessons from the 1999–2001 Emergency Response in the Pastoral Sector in Kenya, Humanitarian Practice Network Paper 40, Overseas Development Institute (ODI), London.

Barton, D. and Morton, J. (1999) "Livestock marketing and drought mitigation in northern Kenya", unpublished paper, Natural Resources Institute (NRI), London.

Catley, A. (ed.) (2007) Impact Assessment of Livelihoods-Based Drought Interventions in Moyale and Dire Woredas, Ethiopia, Pastoralists Livelihoods Initiative, Feinstein International Center, Tufts University, Medford, MA, together with CARE, Save the Children USA, ad USAID-Ethiopia, <https://wikis.uit.tufts.edu/confluence/download/attachments/14553622/IMPACT~1.PDF?version=1>[accessed 17 May 2014].

Catley, A. and Cullis, A. (2012) "Money to burn? Comparing the costs and benefits of drought responses in pastoralist areas of Ethiopia", Journal of Humanitarian Assistance, 24 April 2012, <http://sites.tufts.edu/jha/archives/1548> [accessed17 May 2014].

Demeke, F. (2007) "Impact assessment of the PLI/ENABLE emergency livestock interventions in Dire Woreda, Borana Zone", in A. Catley (ed.), Impact Assessment of Livelihoods-Based Drought Interventions in Moyale and Dire Woredas, briefing paper, pp. 22–42, Pastoralists Livelihoods Initiative, Feinstein International Center, Tufts University, Medford, MA, <https://wikis.uit.tufts.edu/ confluence/download/attachments/14553622/IMPACT~1.PDF?version=1> [accessed 17 May 2014].

Gill, R. and Pinchak, W. (1999) Destocking Strategies during Drought, Texas A&M University, College Station,Texas, <http://varietytesting.tamu.edu/forages/drought/Destocking%20Strategies%20During%20Drought.pdf> [accessed 17May 2014].

LEGS (Livestock Emergency Guidelines and Standards) (2014), Livestock Emergency Guidelines and Standards, 2nd Edition, Practical Action Publishing: Rugby.

Morton, J. and Barton D. (2002) "Destocking as a drought-mitigation strategy: clarifying rationales and answering critiques", Disasters 26(3): 213–228 <http:// dx.doi.org/10.1111/1467-7717.00201>.

Toulmin, C. (1994) "Tracking through drought: options for destocking and restocking", in I. Scoones (ed.), Living with Uncertainty: New Directions in Pastoral Development in Africa, pp. 95–115, Intermediate Technology Publications, London.

Turner, M.D. and Williams, T.O. (2002) "Livestock market dynamics and local vulnerabilities in the Sahel", World Development 30(4): 683–705 <http://dx.doi. org/10.1016/S0305-750X(01)00133-4>.

Санамж:

1. Хатаасан ба шинэ мах бэлтгэх, арьс, шир боловсруулахад оролцуулах нь түр ажлын байр бий болгох, ур чадвар хөгжүүлэхэд тусалж байдаг.
2. Нийт хамрагдсан өрхийн тоог гаргахын тулд өрхийн тоог бүс ба төслөөр нэгтгэн гаргана.

БҮЛЭГ 5

Мал эмнэлгийн үйлчилгээний техникийн стандартууд

Мал эмнэлгийн үйлчилгээ

Танилцуулга

Энэхүү бүлэгт онцгой нөхцөл байдал үүссэн үед мал эмнэлгийн үйлчилгээ яагаад чухал талаар өгүүлсэн болно. Мөн мал эмнэлгийн үйл ажиллагаа болон түүний тохиромжтой хувилбарыг тодорхойлох арга хэрэгслийг танилцуулна. Стандартууд, үндсэн үйл ажиллагаа, хувилбар бүрийг дагаж мөрдөх зааварчилгааг оруулав. Жишээ судалгааны талаар энэ бүлгийн төгсгөлд өгүүлэх болно. Тэдгээр нь үнэлгээ, хяналт шинжилгээ хийх шалгах хуудас бүхий нэмэлт хавсралтыг багтаасан. Мөн энэхүү бүлгийн төгсгөлд үндсэн лавлах баримт бичгийн жагсаалтыг хавсаргав.

LEGS амьжиргааны зорилттой холбогдох нь

Мал амьтанд тохиолдсон гамшгийн нөхцөл байдлын үед мал эмнэлгийн туслалцааг үзүүлэх нь LEGS-н амьжиргааны хоёр зорилтод хүрэхэд тусална. Үүнд:

- хямралд өртсөн ард иргэдийн амьжиргааны гол хөрөнгө мал амьтныг хамгаалах
- хямралд өртсөн ард иргэдийн гол хөрөнгө мал амьтныг сэргээх буюу нөхөн сэргээх.

Гамшгийн хариу арга хэмжээнд мал эмнэлгийн үйлчилгээ чухал болох нь

Гамшиг нь мал амьтны өвчлөл болон эмзэг байдлын эрсдлийг нэмэгдүүлдэг. Иймээс гамшгийн үр нөлөө нь мал амьтны эрүүл мэндэд олон янзаар тусна. Жишээ нь:

- Ган, зуд, хүйтэн өвлийн үед бэлчээр тэжээлийн нөөц хомсдон малын тарга хүч муудан, биеийн эсэргүүцэл сулран өвчинд өртөх эрсдэл нэмэгддэг.
- Үер, хөрсний гулгалт зэрэг гамшгийн үед өнгөн хөрс онгилогдож хөрсний халдварт өвчин тухайлбал боом өвчин гарах эрсдэл нэмэгдэнэ.
- Газар хөдлөлтийн гамшиг нь мал амьтныг ихээр гэмтээж бэртээдэг.
- Өөр өөр газар нутагт байсан мал амьтан нь хоорондоо нийлж холилдох нөхцөлд өвчин гарах, зөөвөрлөгдөх эрсдлийг улам нэмэгдүүлдэг.

- Шинэ газар нутагт нүүдэллэн очсон мал нь тухайн нутагт гардаг өвчний эсрэг дархлаагүй байдгаас шалтгаалан өвчлөх эрсдлийг нэмэгдүүлдэг.
- Бөөнөөр суурьшиж байгаа хүмүүс болон амьтны хооронд зооноз (малаас хүнд халддаг) өвчин дамжих эрсдэлтэй.

Мал эмнэлгийн туслалцаа нь мал амьтныг хамгаалж, эрүүл мэндийг бэхжүүлснээр малын гаралтай хөрөнгийг хамгаалж байна. Малын эрүүл мэндийг хамгаалснаар гамшгийн үед ч мал аж ахуйн бүтээгдэхүүний хангамжийг тогтвортой байлгана. Ерөнхийдөө мал эмнэлгийн вакцин, эм нь малын өртөгтэй харьцуулж үзвэл үнэтэй биш. Мал эмнэлгийн үйлчилгээ тухайлбал вакцинжуулалт, эрт оношилгоо, эмчилгээ нь өндөр халдварлалттай халдварт өвчний улмаас мал амьтан гэнэт олноор үхэж хорогдохоос сэргийлж чадна. LEGS нь мал амьтны гол өвчнүүд, олон улсад бүртггэгдсэн цар тахалын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ба тэмцэх үйл ажиллагааг хамаарахгүй, энэхүү үйл ажиллагаа нь Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ), Нэгдсэн Үндэсний байгууллага (НҮБ)-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ)-аас гаргасан тусгайлсан заавар, журамд заасан байдаг тухай *Танилцуулга* бүлэгт дурдагдсан билээ.

Өвчний дэгдэлтийн зэрэгцээ ужиг өвчний үр нөлөөг хязгаарлахад мал эмнэлгийн үйлчилгээ чиглэдэг. Мал эмнэлгийн үйлчилгээ нь сүү сааль, төлөрхөг чанар, ачлагын малын ашиглалтыг нэмэгдүүлснээр мал амьтнаас олох үр ашгийг сайжруулдаг. Хаана мал ихээр өвчилж хорогдоно үүнийг эргэн сэргээхэд иргэдэд тодорхой хугацаа шаардагдана. Мал эмнэлэг нь иргэдийн амьжиргаа болсон мал сүргийг (үүнд бэлчээрийн мал, ганц илжиг, хөллөгөөний хос шар, цөөхөн тахиа байсан ч багтаана) нөхөн сэргээхэд тусалдаг.

Гамшгийн эсрэг хариу арга хэмжээний нэг хэсэг болох мал эмнэлгийн үйлчилгээ нь *Танилцуулга* хэсэгт тодорхойлогдсон мал амьтны тавлаг байдлын талаарх "таван эрх чөлөө" гэж нэрлэгдсэн *өвдөлт, гэмтэл болон өвчнөөс ангид байх* шаардлагыг хангахад туслана. Энэхүү үйл ажиллагааг хэд хэдэн арга замаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- өвчнөөс сэргийлэх тухайлбал вакцинжуулах буюу дархлаажуулах;
- шуурхай оношлох болон эмчилгээ хийх;
- паразитын эмчилгээ эсвэл тураалд орсон мал амьтанд амин дэм, эрдэс бодисыг олгож тэнхрүүлэх замаар мал сүргийн эрүүл

мэндийг сайжруулах;

- тандалт судалгаа болон мэдээлэлийг сайжруулах замаар өвчний эсрэг шуурхай арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх;

Мал эмнэлгийн туслалцааны хувилбарууд

Энэ бүлэгт гамшгийн хариу арга хэмжээний үед мал эмнэлгийн салбараас үзүүлэх туслалцааны хувилбаруудын талаар өгүүлсэн ба үндсэн хоёр хэсэгт хуваагдана. Үүнд:

- *мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээ*
- *мал эмнэлгийн нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа*

Мал эмнэлгийн туслалцаа нь дээрх хувилбараар хязгаарлагдахгүй нэгээс дээш буюу дэд хувилбарыг сонгож хэрэгжүүлнэ. Тэдгээрийг сонгохдоо нь орон нутгийн нөхцөл байдал, хийгдсэн үнэлгээ болон төлөвлөлтөөс хамаарна. (*Мал эмнэлгийн туслалцаа стандарт 1-ийг* харна уу)

Хувилбар 1: Мал эмнэлгийн эмнэлзүйн (клиникийн) үйлчилгээ

Мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээнд эмчилгээ болон вакцинжуулалт хамаарах ба эдгээр нь гамшиг буюу онцгой нөхцөл байдал үүсэхэд хамгийн түрүүнд хэрэгжүүлдэг арга хэмжээнүүд юм. Ашиг шим хүртэгчдийн малд үзүүлэх эмнэлзүйн үйлчилгээ нь төрийн ба хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжин мал эмнэлгийн туслах ажилтны тухайлбал олон нийтэд суурилсан малын эрүүл мэндийн ажилтны (CAHWs) оролцоотой болон оролцоогүйгээр хэрэгжинэ. Хөгжиж буй олонх орнуудад мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээ нь төрийн буюу улсын хэлбэрээс хувийн хэвшилд шилжих шилжилтийн үе шатандаа байна. Хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээ нэмэгдэж байгаа нь чанартай мал эмнэлгийн үйлчилгээний үндсэн эх үүсвэр болно. Гэвч олонх мал эмнэлгийн мэргэжилтэн нар хот суурин газар эсвэл өндөр хөгжсөн томоохон фермийн аж ахуйг түшиглэн үйл ажиллагаагаа явуулах сонирхолтой байдаг. Харин бусад газруудад гол үйлчилгээ хүргэгч нар нь мал эмнэлгийн туслах ажилтнууд юм.

Олон нийтийг түшиглэн малын эрүүл мэндийг хамгаалах (CBAH) ажиллагаа нь гамшгийн хариу арга хэмжээний үед хамгийн

тохиромжтой байдаг. Олон нийтэд суурилсан малын эрүүл мэндийн ажилтан нь мал эмнэлгийн клиникийн болон нийгмийн эрүүл мэндийн мал эмнэлгийн үйлчилгээг хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Ялангуяа хямрал удааширч сунжирсан үед олон нийтэд түшиглэн мал эрүүл мэндийг хамгаалах систем нь мал амьтны хорогдлыг бууруулах, мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулж хүртээмжтэй, хэрэгцээтэй, бололцоотой, хүлээн зөвшөөрөгдөхүйц байдгийг судалгаа харуулсан. Төлөвлөлтөө мал эмнэлгийн эрэгтэй, эмэгтэй туслах ажилчид, малын эрүүл мэндийн асуудлаар эдгээр системийн үйлчилж байдаг малчдыг хамруулан оролцооны аргаар хийнэ. Зарим улс орнуудад хэдийгээр олон нийтэд суурилсан мал амьтны эрүүл мэндийн ажилтанг ажил үүргээ гүйцэтгэх эрхзүйн зохицуулалт байдаггүй боловч мал эмнэлгийн үйлчилгээг хүргэдэг бусад механизмуудаас нь илүү тохиромжтой хэлбэр нь юм.

Хүмүүнлэгийн хямралын үед мал эмнэлгийн мал эмчлэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь доголддог учраас дараах хоёр чиглэлийн үйл ажиллагааг нэгэн зэрэг суурин болон хөдөлгөөнт хэлбэрээр хэрэгжүүлэх шаардлагатай болдог. Эдгээр нь:

1.1 *малд нэг бүрчлэн үзлэг болон эмчилгээ хийх*

1.2 *мал сүргийг өргөн хүрээтэйгээр вакцинжуулах буюу эмчилгээний хөтөлбөр*

1.1 Мал амьтанд үзлэг болон эмчилгээ хийх. Энэ үйл ажиллагааны үед мал сүрэгт одоо байгаа өвчин эмгэгийг оношлон, илрүүлэх үзлэг хийж, түүнд тохирсон эмчилгээ хийнэ. Энэ үед янз бүрийн айл өрхийн мал сүрэгт өөр өөр өвчтэй байгаа мал нэг бүрт тохирсон эмчилгээ үйлчилгээг үзүүлэх хэрэгтэй болдог. Зарим орнуудад энэхүү арга хэмжээг ард иргэд, хувийн мал эмнэлэг, төрийн засаг захиргааны байгууллагатай хамтран мал эмнэлгийн үйлчилгээ авах эрхийн бичгийн тогтолцоог ашиглан хэрэгжүүлдэг (энэ бүлгийн төгсгөлд байгаа *Жишээ судалгаа 5.1 болон 5.2 дах*ь хэсгээс харна уу). Шууд ба шууд бус хэлбэрээр бэлэн мөнгө олгох үйл ажиллагаа нь айл өрхүүдийн зүгээс хувийн мал эмч нарт үйлчилгээний төлбөрийг хийх боломжийг олгодог. Ингэснээр өвчний тохиолдол бүрт мал эмнэлгийн эмчилгээ үзүүлж чаддагаас гадна эм тариаг үнэгүй тарааж, мал эмнэлгийн үйлчилгээг үнэгүйдэхээс сэргийлдэг.

1.2 Өргөн хүрээний вакцинжуулалт болон эмчилгээний хөтөлбөрүүд.

Ихэнх тохиолдолд яаралтай өргөн хүрээний вакцинжуулалт эсвэл эмчилгээ хийх хөтөлбөр нь мал аж ахуй эрхлэгчдэд үнэ төлбөргүй хийгддэг. Онцгой байдал тохиолдсон үед малын өвчнөөс сэргийлэх зорилгоор вакцинжуулалт, туулгалт, боловсруулалт хийх нь нэг удаагийн арга хэмжээ бөгөөд олон тохиолдолд үүнийг малчдаас төлбөр гаргуулахгүйгээр үнэ төлбөргүй хийдэг. Түүнийг хийж гүйцэтгэж байгаа мал эмнэлгийн байгууллагуудад санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлдэг.

- Өргөн хүрээнд хийдэг эмчилгээний хөтөлбөр нь ихэнхдээ малын паразитын эсрэг эмийг ялангуяа шимэгчид болон гадна паразит буюу хачиг ширхнээс сэргийлэх зорилгоор ашигладаг. Төсөл хэрэгжүүлэгч болон ашиг хүртэгчдийн зүгээс энэхүү өргөн хүрээг хамарсан хөтөлбөр нь эерэг нөлөө үзүүлж байдаг талаар тэмдэглэсэн байдаг. Хэдий тийм ч малын вакцинжуулах болон эмчилгээний арга хэмжээний үр нөлөө буюу эдийн засгийн ашиг нь хязгаарлагдмал байдгийг зарим нэг системийн шинжилгээний тайланд дурдсан байна (ган болох үед өргөн хүрээнд туулгалт хийсэн тухай *Жишээ судалгаа 5.4* хэсгээс харна уу). Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар стандартууд (LEGS)-н баримт бичигт өргөн хүрээнд хийх эмчилгээ хийх стандарт багтаагүй болно. Өргөн хүрээнд туулгалт хийх шийдвэр гаргаж сонголт хийх, хэзээ, хэрхэн хийх, үр нөлөөний талаар LEGS-н зүгээс үнэлгээ хийхийг зөвлөмж болгосон (*Нийтлэг стандарт* 6*: Хяналт, үнэлгээ болон амьжиргааны үр нөлөө* хэсгээс харна уу). Өргөн хүрээнд туулгалт, боловсруулалт хийх хөтөлбөрийн зарим үр дагавар нь гамшгийн дараа илэрдэг учраас үнэлгээний төлөвлөлт, цаг хугацаа зэрэг хүчин зүйлийг харгалзах хэрэгтэй.
- Өргөн хүрээнд вакцинжуулалтыг тухайлбал боом, дуут хавдар, цусан халдварт, Ньюкасль зэрэг халдварт өвчин тархсан үед олонтоо хэрэгжүүлдэг. Өргөн хүрээнд хийх вакцинжуулалтыг хэдийгээр гэнэтийн болон удаан явцтай гамшгийн үед өргөн хэрэглэдэг ч амьжиргаанд нөлөөлж байгаа нөлөө нь хязгаарлагдмал байдаг (*Жишээ судалгаа 5.3* хэсгээс харна уу). Түүнчлэн LEGS-н баримт бичигт масс вакцинжуулалт буюу өргөн хүрээнд дархлаажуулалт хийх тухай стандарт багтаагүй болно. Хэрвээ өргөн хүрээнд дархлаажуулалт хийхээр бол Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар стандартууд (LEGS)-н

баримт бичигт заасны дагуу үнэлгээ хийхийг зөвлөмж болгодог (*Нийтлэг стандарт 6: Хяналт, үнэлгээ болон амьжиргааны үр нөлөө* хэсгээс харна уу).

Хувилбар 2: Улсын мал эмнэлгийн үйлчилгээ

Гэнэтийн ба удаан явцтай гамшгийн нөхөн сэргээх үе шат буюу удаан хугацаанд сунжирсан гамшгийн үед улсын мал эмнэлгийн үйлчилгээнд туслах нь маш чухал ач холбогдолтой байдаг. Улсын мал эмнэлгийн үйлчилгээг дэмжих нь улсын мал эмнэлгийн чадавхийн сул талыг сайжруулах эсвэл үйлчилгээ огт байдаггүй газар шинээр бий болгоход чиглэгдэнэ. Энэ нь үндсэн хоёр хэсгийг багтаана. Үүнд:

2.1 *мал* эмнэлгийн нийгмийн эрүүл мэнд

2.2 *мал амьтны өвчний тандан* судалгааны тогтолцоо

2.1 Мал эмнэлгийн нийгмийн эрүүл мэнд. Мал эмнэлгийн нийгмийн эрүүл мэнд гэдгийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), ДМАЭМБ болон НҮБ-ын ХХААБ-аас хамтран "Зооноз өвчний эмчилгээ, урьдчилан сэргийлэлт болон хүнсний аюулгүй байдлын асуудлыг ойлгуулахад мал эмнэлгийн шинжлэх ухааны ойлголт, арга хэрэгсэлээр дамжуулан хүний бие махбод, оюун санаа, нийгмийн сайн сайханд оруулж буй хувь нэмрийг хэлнэ" гэж томьёолсон байдаг. Мал эмнэлгийн нийгмийн эрүүл мэнд нь мал амьтнаас хүнд дамжин халдварладаг ялангуяа хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдээр тухайлбал мах, сүүгээр дамжин халдварлах зооноз өвчнөөс хэрэглэгчийг хамгаалахад чухал үүргийг гүйцэтгэдэг. Мал эмнэлгийн нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэхэд нь улсын болон хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлж байгаа малын эмч нар төдийгүй эрүүл мэнд, хөдөө аж ахуй, харилцаа холбоо болон бусад салбарын мэргэжилтэн нар хамтран оролцдог.

Мал амьтнаас хүнд дамжин халдварладаг өвчнүүд нь малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн тухайлбал сүү, мах хэрэглэх эсвэл мал амьтантай шууд харьцах үед дамжин халдварлана. Эдгээр өвчнийг хяналтад авах нь нийгмийн салбарын нэг чухал үүрэг юм. Мал амьтнаас хүнд дамжин халдварладаг өвчнүүдэд боом, сальмонеллёз, сүрьеэ, бруцеллёз, галзуу, хамуу, Рифт хөндийн халуурал, өндөр хоруу чанартай шувууны томуу багтана. ДМАЭМБ болон НҮБ-ын ХХААБ-аас гаргасан эдгээр өвчнийг хяналтад авах, тэмцэх арга хэмжээний талаарх тусгайлсан заавар, журам

(мал амьтны тавлаг байдлыг багтааж) байдаг талаар *Танилцуулгад* дурдсан байгаа болно.

Мал эмнэлгийн нийгмийн эрүүл мэнд нь малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний тухайлбал мах, сүүний хүнсний аюулгүй байдлыг багтаана. Зарим мал эмнэлгийн зориулалттай эм нь үлдэгдэл байдлаар хүнсэнд хадгалагдаж, улмаар тэдгээр нь хүний хүнсний хэрэгцээнд хэрэглэгддэг. Хүмүүнлэгийн хямрал болсон үед хүнсний аюулгүй байдал, хүнсний баталгаат байдлын тухай ойлголт алдагддаг. Түүнчлэн тухайн нутагт гамшгийн нөхцөл байдалтай байгаа үед хүнсний баталгаат байдал алдагдсанаас хүүхдийн хоолны тэжээллэг чанар эрс муудсан байдаг. Зарим тохиолдолд хүүхдийн хоолны тэжээллэг чанарын үзүүлэлт нь ДЭМБ-аас гаргасан стандарт үзүүлэлтээс доош орсон байна.

Ийм нөхцөлд байгаа хүмүүсийн хүнсний баталгаат байдал нь улам дордож, эрсдэл үргэлжлэн, өвчтэй хүмүүсийн биеийн жин буурах, эмийн бодисын үлдэгдэл агуулсан мах, сүүг хүнсэндээ хэрэглэх байдал түгээмэл болно.

2.2 Мал амьтны өвчний тандан судалгааны тогтолцоо

Малын өвчний тандан судалгаа гэдэг нь малын өвчнийг ялангуяа халдварт өвчнийг судлах, мэдээлэх, зураглах системийг хэлнэ. Малын өвчний тандан судалгаа хийхэд олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтнууд чухал үүрэгтэй. Зарим бүс нутагт тухайлбал Африкийн зүүн хойт эрэгт мал, малын гаралтай түүхий эдийн бүтээгдэхүүнүүд нь малчдын амьжиргаанд маш чухал ач холбогдолтой. Худалдаанд мал амьтны эрүүл мэндийн олон улсын стандарт, өвчний мэдээлэл болон өвчтэй малыг экспортлох/импортлох эрсдэл нөлөөлдөг. Улсын мал эмнэлгийн малын өвчний тандалтын мэдээллийн сан нь мэдээллийн голлох эх сурвалж болдог.

Онцгой байдлын үед малын өвчний тандах үйл ажиллагааг төрийн байгууллагуудтай хамтран төлөвлөж загварчилдаг ба тэд дараах үүргийг хэрэгжүүлдэг.

Хүмүүнлэгийн хямралын үед хийгдэх өвчний тандалт судалгааны үйл ажиллагааны жишээнүүд:

- өвчний мэдээллийг сайжруулахын тулд, нийгэмд чиглэсэн сурталчилгаа хийх

- өвчнийг мэдээлэх малын эмч, мал эмнэлгийн туслах ажилтан нарыг сургалтад хамруулах
- албан ёсны улсын хэмжээний тандалтын тогтолцоог малын эмч, мал эмнэлгийн туслах ажилтнуудтай холбож өгөх
- өвчнийг цаг тухайд нь илрүүлэх болон хариу арга хэмжээг хэрэгжүүлэх
- өвчний тандалт судалгааны үр дүнгийн талаар эргэн мэдээлэх.

Мал эмнэлгийн туслалцааны үндсэн болон дэд хувилбарын давуу болон сул талыг *Хүснэгт 5.1* хэсэгт нэгтгэн харуулав.

Хүснэгт 5.1 Мал эмнэлгийн туслалцааны хувилбаруудын давуу болон сул тал

Хувилбар 1. Мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээ		
Дэд хувилбар	**Давуу тал**	**Сул тал**
1.1 Мал амьтанд үзлэг болон эмчилгээ хийх	• Өвчний тохиолдол бүрт үзүүлэх мал эмнэлгийн үйлчилгээ уян хатан байна • Хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгчдэд тухайлбал эрхийн бичгийн тогтолцоогоор дамжуулан үйлчилгээ үзүүлдэг • Ялангуяа сайтар сургагдсан, бэлтгэгдсэн малын эмч, мал эмнэлгийн туслах ажилтан нарыг ашиглан өргөн хүрээг хамрах боломжтой • Эрсдэлд байгаа айл өрхийн малыг тодорхой зорилгоор урьдчилан сэргийлэх, эмчлэх буюу дархлаажуулах стратегийг баримтална • Мал амьтны хорогдол байсаар байхын үр нөлөөний зарим тоон нотолгоо байдаг	• Хэрвээ үйлчилгээг үнэ төлбөргүй хэрэгжүүлбэл үйлчилгээний хугацаа болон хамрах хүрээ нь санхүүжилтээс хамааран хязгаарлагдаж болзошгүй • Хэрвээ үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлбэл хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгч нарт сөргөөр нөлөөлнө • Орон нутагт хэрэглэж байгаа эмийн бодисын чанар төдийлөн хангалтгүй байдаг

1.2 Мал сүргийг вакцинжуулах, туулгалт боловсруулалт хийх үйл ажиллагаа	• Төлөвлөх болон хэрэгжүүлэхэд хялбар • Өргөн хүрээнд туулгалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүйтэн хэлхээ төдийлөн шаардлагагүй • Нэг мал амьтанд зарцуулах зардал нь бага • Хэрвээ туулгалт, боловсруулалтыг үр дүнтэй хийж чадвал мал амьтны эрүүл мэнд болон ашиг шимд сайнаар нөлөөлнө • Өргөн хүрээнд туулгалтын арга хэмжээг хэрэгжүүлснээр жишээлбэл эрхийн бичгийн тогтолцоогоор дамжуулан мал эмнэлгийн салбарт ашиг орлогыг авчирна	• Олонх нутагт лабораторийн чадавхи сул тул тухайн мал амьтны өвчнийг оношлох болон баталгаажуулах боломж хомс • Тархвар судлалын суурь судалгаа мэдээлэлгүйгээр өргөн хүрээтэй вакцинжуулалтын арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулахад нэн түвэгтэй • Хамрах хүрээ нь техникийн шалгуур үзүүлэлтээс илүүтэй санхүүжилтээс хамаардаг • Үнэ төлбөргүй туулга, боловсруулалт болон өргөн дархлаажуулалт хийснээр мал эмнэлгийн хувийн хэвшлийн ашиг орлогод сөргөөр нөлөөлнө • Олонх вакцин нь хүйтэн хэлхээний тогтолцоо шаарддаг • Вакцинжуулалтын арга хэмжээ нь тэжээллэг хангалтгүй байсны улмаас аль хэдийнээ турж эцсэн зарим мал амьтанд вакцин тарих үед хангалтгүй дархлаа тогтох эрсдэл бий болгодог • Орон нутагт хэрэглэж байгаа эмийн бодисын чанар төдийлөн хангалтгүй байдаг

→ Хувилбар 2. Улсын (нийтийн) мал эмнэлгийн үйлчилгээг дэмжих		
Дэд хувилбар	**Давуу тал**	**Сул тал**
2.1 Мал эмнэлгийн нийгмийн эрүүл мэнд	• Нийтийн ойлголтыг сайжруулахад өртөг зардал нь хямд • Мал эмнэлэг болон эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагаанд тус дэм болно	• Төрөлх хэлээр нь олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгааны материалыг бэлтгэх, туршихад тусгайлсан нэмэлт мэдлэг шаарддаг • Хэрвээ цаг хугацаанд нь, зөв менежмент хийхгүй бол хүмүүсийн амьжиргааг шууд дэмжих туслалцааны нөөцийг үр ашиггүй зарахад хүргэнэ
2.2 Мал амьтны өвчний тандан судалгааны тогтолцоо	• Бусад бүх мал эмнэлгийн үйл ажиллагааг нягт уялдуулан хамтран хэрэгжүүлснээр арга хэмжээний үнэлгээнд эерэг нөлөөлнө • Мал эмнэлгийн төв болон гамшигт нэрвэгдсэн орон нутгийн мэргэжлийн байгууллагуудын харилцаа холбоо сайжирна • Зарим улс орон, бүс нутагт малын гаралтай бүтээгдэхүүний олон улсын худалдаа өргөжүүлэхэд хувь нэмэр болно	• Сайн тодорхойлогдсон тандалтын зорилтууд дээр үндэслэх шаардлагатай • Үйл ажиллагаанд баримжаалсан нь мэдээлэлд тулгуурсан үйл явцыг удирдахад хялбар байдаг • Хэрвээ цаг хугацаанд нь, зөв менежмент хийхгүй бол хүмүүсийн амьжиргааг шууд дэмжих туслалцааны нөөцийг үр ашиггүй зарахад хүргэнэ

Үйл ажиллагааг хэрэгжүүлэх зохистой хугацаа

Гамшгийн болон гамшгийн бус ямар ч үед мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээ үзүүлэх нь зохистой. Хэдийгээр улсын мал эмнэлгийн үйл ажиллагааг гамшгийн хор уршгийг арилгах үе шатанд авч хэрэгжүүлэх нь илүү тохиромжтой ч мал сүргийг цаг алдалгүй эмчлэх, эдгэрүүлэх, мал амьтны өвчлөл, хорогдлыг бууруулахад чиглэсэн яаралтай арга хэмжээг хэрэгжүүлнэ. (*Хүснэгт 5.2*).

Хүснэгт 5.2 Мал эмнэлгийн үйлчилгээг явуулах боломжит хугацаа

ХУВИЛБАРУУД	Гэнэтийн гамшиг			Удаан явцтай гамшиг			
	Гэнэтийн хор хохирол	Шуурхай нөхөн сэргээлт	Нөхөн сэргээлт	Сэрэмжлүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээлт
1. Мал эмнэлгийн эмнэл зүйн үйлчилгээ	→	→	→	→	→	→	→
2. Улсын Мал эмнэлгийн үйлчилгээ			→				→

Бусад бүлэгтэй холбогдох нь

Мал эмнэлгийн үйлчилгээ нь амьжиргаанд суурилсан мал аж ахуйн бусад үйл ажиллагаатай холбоотой хэрэгждэг. Гамшгийн үед мал эмнэлгийн үйлчилгээ нь дангаараа мал амьтныг амьд, ашиг шимээ хадгалан үлдэхийн баталгаа болохгүй. Мал амьтанд тэжээл болон ус *(Бүлэг 6, Тэжээл хангамж, Бүлэг 7, Усан хангамж)* зарим газар нутагт хашаа хороо *(Бүлэг 8, Мал амьтныг хашаа саравчаар хангах ба байршуулалт)* шаардлагатай.

Үлдэж хоцорсон малын эрүүл мэндийг хамгаалдагаараа малын тоо толгойг бууруулах (*Бүлэг 4, Мал амьтны тоо толгойг бууруулах*) үйл ажиллагаа нь мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээ болон иргэдэд суурилсан малын эрүүл мэндийг хамгаалах системд хамаардаг. Малын тоо толгойг бууруулах зорилгоор нядлахад мал нядалгааны өмнөх болон дараах үзлэг хийдгээрээ мал эмнэлгийн нийгмийн эрүүл мэндийн хувь нэмэр чухал байдаг. Мөн мал эмнэлгийн үйлчилгээ малжуулах (*Бүлэг 9, Малжуулах*) үеийн худалдан авахаас өмнөх болон худалдсаны дараах эмнэлзүйн үйлчилгээнүүдэд шаардагдана.

Нийтлэг болон харгалзан үзэх бусад асуудлууд

Хүйсийн ба нийгмийн тэгш байдал

Гамшгийн үед хоол хүнсний баталгаат бус байдал болон бусад аюул заналд эмэгтэйчүүд илүү өртөмтгий байдаг. Мал эмнэлгийн анхдагч үйлчилгээг адил тэгш, үр дүнтэйгээр мал амьтдын өмчлөгчд болон ашиглагчдад хүргэхэд хүйсийн асуудлыг ойлгох нь чухал. Гамшгийн үйл ажиллагаанд хүйсийн гүйцэтгэх үүрэг, хариуцлага, төлөвлөгдсөн үйл ажиллагаанд тэднийг татан оролцуулах зэргийг харгалзан үзэх нь чухал юм. Эмэгтэйчүүд (охид) нь бог мал эсвэл нялх төл малын өвчнийг ялган таних, тэднийг эмчлэхэд чухал үүрэг гүйцэтгэж болох юм. Мөн эмэгтэйчүүд мал эмнэлгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцоно. Тухайлбал:

- Олонхи нийгмийн давхрагад мал амьтныг арчлан маллах, менежментийн үйл ажиллагаа хүйсийн харьцаанд хуваагдана. Эрэгтэй болон эмэгтэй хүмүүс нь өөр өөр үүрэг гүйцэтгэнэ.
- Ямар нэгэн гамшиг тохиолдоогүй хэвийн нөхцөлд мал амьтны бүтээгдэхүүн худалдаалах болон мал эмнэлгийн ажилтны үүргийг эмэгтэйчүүд ихэнхдээ гүйцэтгэж байдаг. Мал аж ахуйн сургалт хийдэг ажилтан нар, тэдний сургалтын хөтөлбөр нь эрэгтэйчүүд рүү илүүтэй чиглэсэн байдаг. Эмэгтэйчүүдийн хийх ажилд эрэгтэйчүүдийг сургавал сургалтын үр нөлөө бага болно.
- Гамшгийн үед мал амьтны эрүүл мэндийг асуудал хариуцсан ажилтан нь бод малыг тухайлбал үхрийг илүү хамгаалахад анхаардаг. Иймээс эмэгтэй хүний маллаж байгаа мал амьтад орхигдох талтай.
- Нийгмийн дэд бүлэг тодорхойлох болон тэдгээрийн мал амьтны эрүүл мэндийн гол асуудалд анхаарах нь тун чухал. Өртөмтгий эмзэг бүлэгт тухайлбал өрх толгойлсон эмэгтэйчүүдийг оруулна. Зарим бүлгүүд өөр төрлийн амьтан малладаг. Жишээ нь шувуу, бог мал, илжиг гэх мэт
- Эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдийг бодвол түлээ болон ус зөөвөрлөхөд илжигийг илүүтэйгээр ашигладаг. Малын эрүүл мэндийн асуудал хариуцдаг ажилтнуудад нар ажлын зориулалтай малыг эмчлэх мэдлэг болон сонирхол багатай.

- Заримдаа эмэгтэйчүүд нь гамшгийн үед бүх төрлийн мал амьтны арчилгаа маллагааг хариуцдаг.

Дээрх шалтгаануудын улмаас шаардлагатай мэдээлэл болон мал амьтны эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаанууд нь эмэгтэйчүүд болон эмзэг өртөмтгий бүлэгт чиглэсэн байвал зохино. Эмэгтэйчүүдийн уламжлалт мал эмнэлгийн мэдлэгийг ажлын төлөвлөлтөндөө анхаарч үзэж болох юм. Боломж болон нөхцөл бүрдсэн үед эмэгтэйчүүдийг тухайлбал өвөрмөц чиглэсэн арга хэмжээнүүд болон нутгийн олон нийтэд түшиглэсэн малын эрүүл мэндийн ажилтнаар татан оролцуулбал зохино.

ХДХВ/ДОХ

Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ) болон дархлал хомсдолын хам шинж (ДОХ)-тэй хүмүүсийн дархлааг сулруулах аюултай учраас тэднийг зооноз буюу мал амьтнаас хүнд дамжин халдварладаг өвчнөөс урьдчилан сэргийлэх нь туйлын чухал. Мал амьтан хүн өөр хоорондоо ойр хамт байх нь зооноз өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг. Эдгээр нөхцөлүүд нь хот болон хот орчимд дүрвэсэн хүн мал амьтанд илүү эрсдэлтэй. Мал эмнэлгийн үйл ажиллагааны дэмжлэг нь ДОХ-оор өвчлөгсдийн өртөмтгий байдлыг бууруулахад чиглэнэ. Мөн малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, тухайлбал өндөг, мах, сүү нь ДОХ-той хүмүүсийн хоол тэжээлд чухал үүрэгтэй. Иймд малын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаагааг сайжруулснаар мал амьтны ашиг шим дээшлэх ба ингэснээр эерэг нөлөөг үзүүлнэ.

Эрсдлийг бууруулахын тулд хоол хүнсийг зохистой бэлтгэж, боловсруулах шаардлагатай. Мал эмнэлгийн нийгмийн эрүүл мэнд нь хүний эрүүл мэндийг хамгаалах байгууллага, тэдний мэдээлэл, үйл ажиллагаатай нягт уялдаатай байх ёстой. Sphere гарын авлагад эрүүл ахуй болон хүний эрүүл мэндийн үйлчилгээний наад захын стандартын талаар дурдсан байдаг. Эдгээрийг мал эмнэлгийн хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй хамтад нь хэрэгжүүлэх хэрэгтэй.

Хамгаалалт

Бэлэн мөнгө болон өндөр үнэ өртөгтэй малын эм авч яваа олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтан нь хулгай болон халдлагад өртөх магадлалтай. Малын эрүүл мэндийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд аюулгүй байдлыг хангаж ажиллах шаардлагатай. Хөрш

суурин, айлаас мал амьтныг хулгайлах зэрэг нь өөрийн мал сүрэгт өвчин гаргах нэг шалтгаан болдог. Мөн малын тоног хэрэгсэл, бусад зүйлсийг хулгайлах нь эрсдлийг бий болгоно.

Байгаль орчин ба цаг агаар

Эмзэг ядуу малчид нь гамшиг үүсгэдэг цаг агаарын үзэгдэл тухайлбал ган, зуд, хар салхи болон үер зэрэгт өртөмхий байдаг. Эдгээр цаг агаарын эрс тэс үзэгдэл нь өөр хоорондоо хоршиж улмаар өвчлөлийг нэмэгдүүлдэг. Паразит хорхой нь чийглэг, дулаан нөхцөлд өвчлөлийг илүүтэй үүсгэнэ. Хачгаар дамжин халдварладаг зарим вируст өвчнүүд тухайлбал Рифт хөндийн халуурал нь шумуул ихээр үржих нөхцөлийг бий болгодог ба бороотой чийглэг улиралд ихээр гардаг. Их хэмжээний хуурайшил, ган эсвэл цас их орж хүйтрэх нь бэлчээрийн гарцыг бууруулж улмаар мал тарга тэвээр авч чадахгүй, тэжээлийн хомсдолд оруулан мал амьтныг халдварт болон паразиттах өвчинд нэн мэдрэмтгий болгоно. Мөн цаг агаартай хоршсон гамшиг нь зайлшгүй нэмэлт мал эмнэлгийн үйл ажиллагааг тухайлбал нэмэлт тэжээлээр хангахтай хамтран хэрэгжүүлэхэд хүргэдэг.

Мал сүргийг хамгаалахын тулд тэжээл, ус, мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлж өвчлөл, хорогдлыг бууруулан бэлчээрийн өвс ургамлаас гадна нэмэлт тэжээл олгох замаар мал аж ахуйн хөгжлийн тогтвортой байдлыг хангана. Ялангуяа ган мэтийн байгалийн хатуу ширүүн үзэгдэл нь гамшгийн нөхцөлийг бий болгох тул байгаль орчны боломжит нөлөөлөлд илүү анхаарал хандуулах хэрэгтэй. Мал эмнэлгийн үйлчилгээ нь малын тоо толгойг нэмэгдүүлдэг, ингэснээр малын тоо өссөнөөр тогтворгүй байдал үүсдэг гэсэн нийтлэг буруу ойлголт байдаг.

Үнэндээ мал эмнэлгийн үйлчилгээ нь эрүүл, ашиг шим сайтай, таваарлаг, тогтвортой сүргийг бий болгоход тусладаг.

Орон нутгийн чадавхи

Мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээ нь ихэвчлэн олон нийтийн оролцоо, дэмжлэгт суурилж явагдана. Эдгээр үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийн мал маллагаа, арчилгаа хийдэг чадавхи ихээхэн үүрэгтэй. Үйлчилгээ үзүүлэх загвар, үнэлгээ хийх, хүргэх үйл ажиллагаанд малчдын хувь нэмэр чухал. Тэд мал амьтны эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудын талаар тухайлбал өвчний шинж тэмдэг, өвчин дамжин

тархах замууд, өвчнийг хяналтанд авах, таслан зогсоох арга замуудын тухай өөрийн гэсэн мэдлэг, туршлагатай болсон байдаг. Энэ мэдлэг нь ялангуяа фермерийн болон хагас фермерийн аж ахуйн хүмүүст илүү байдаг. Орон нутгийн хүмүүсийг нутгийн олон нийтэд түшиглэсэн малын эрүүл мэндийн ажилтан болоход туслах, сургах замаар энэ мэдлэгийг тэдэнд олгоно. Олон нийтэд суурилсан мал амьтны эрүүл мэндийн тогтолцоо нь алслагдсан нутагт амьдарч байгаа хөдөөгийн иргэдэд мал эмнэлгийн үйлчилгээ, мал эмнэлгийн нийгмийн эрүүл мэнд болон мал амьтны өвчний тандалтын тогтолцоог хүргэх үр ашигтай зам болно.

Хүрэх боломж

Дэд бүтэц болон харилцаа холбооны хөгжил хангалтгүй байгаа бүс нутагт мал эмнэлгийн үйлчилгээг хүргэх нь хэвийн үед ч бэрхшээлтэй байдаг.

Малчид газар нутгаа сэлгэн нүүхэд тэдэнд байнгын мал эмнэлгийн үйлчилгээг хүргэхэд олон нийтэд түшиглэсэн эрүүл мэндийн ажилтан явганаар эсвэл завиар явж хүрэх шаардлага гарна. Гамшгийн үед алсад байгаа хүмүүсийн өртөмхий байдал илүү байна. Иймэрхүү нөхцөлд мал эмнэлгийн туслах ажилтан нар нь тухайн орчинд үйл ажиллагаа хэрэгжүүлж чаддаг тул үйлчилгээг хүргэх хамгийн сайн түнш юм. ДМАЭМБ-ын олон улсын стандартад зааснаар олон нийтэд түшиглэсэн малын эрүүл мэндийн ажилтанг мал эмнэлгийн туслах ажилтанд тооцдог нь заримдаа мал эмнэлгийн байгууллагын эсэргүүцэлтэй тулгардаг. Магадгүй, тэд хууль эрхзүйн хувьд хүлээн зөвшөөрөгдөхгүй байгаа нь тэдний чадавхийн талаар алдаатай ойлголттой холбоотой. Тэд нар нь мэргэжлийн үйлчилгээг монопол байдалд хүргэх хандлагатай байж магадгүй (*Нийтлэг стандарт 7: Бодлого болон нөлөөлөл*). Сайтар бэлтгэгдсэн болон сургагдсан орон нутгийн хүмүүсийг гамшгийн үед мал эмнэлгийн үйлчилгээг хүргэх, удирдах нөөц хүчин болгоход анхаарах хэрэгтэй.

Бололцоо болон зардлыг нөхөн олгох талаар

Орон нутгийн иргэдэд мал эмнэлгийн үйлчилгээг хүргэхэд ялгаатай аргуудыг санал болгоно. Гурван хувилбарын талаар *Хайрцаг 5.1.* дотор дэлгэрэнгүй тусгасан байна.

Гамшгийн үед үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд нь заримдаа мал эмнэлгийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлж болно. Энэхүү

практик нь өртгийг буцаан олгоход үндэслэсэн үйлчилгээ дээр суурилна. Энэ нь малчдад зарим үйлчилгээ үзүүлэгчээс нь төлбөргүй, зарим үйлчилгээ үзүүлэгчээс төлбөртэй үйлчилгээ авч байгаа талаар эндүүрэл үүсгэж болзошгүй. Энэ нь мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгчийн байнгын орлогыг бууруулан бусад үйлчилгээг чөлөөтэй үзүүлэхэд зарим хүндрэлийг учруулдаг. Мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэх нь хямралд өртсөн хүмүүст ач холбогдолтой ч энэ нь зардал хэмнэх буюу шударга байдал нь маш хязгаарагдмал. Зарим тохиолдолд малын бага эмчийн ажил үйлчилгээ нь хямд байдаг тул энэ төрлийн систем амьжиргаанд дэмжлэг үзүүлдэг. Хөгжиж байгаа улс орнуудад мал эмнэлгийн үйлчилгээг хувьчилсан нь ядуу малчдын хувьд төлбөрийн чадваргүй учраас мал эмнэлгийн үйлчилгээ авах сонирхолгүй байдаг. Энэ нь ядуу малчдын хувьд энгийн, хямд үнэтэй, олон нийтэд суурилсан хувийн мал эмнэлгийн клиник үйлчилгээг ашиглах сонирхолтой байдгаар нотлогддог.

Гамшгийн үед мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээг хурдан шуурхай, шударга, ашигтай байдлаар хүргэхдээ ашиг хардаг орон нутгийн хувийн үйлчилгээ үзүүлэгчдэд ханддаг нь мал эмнэлгийн үйлчилгээг санхүүгийн хувьд ч, чанартай үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ч бэрхшээл учруулж байдаг. Бэлэн мөнгө тараах нь гамшгийн хариу арга хэмжээний үед мал эмнэлгийн тусламж үйлчилгээг хэрэгжүүлэхэд магадгүй тохиромжтой арга хэрэгслийн нэг юм.

Хайрцаг 5.1 **Онцгой байдлын үед мал эмнэлгийн үйлчилгээ хүргэх нь: Төлбөрийн гурван хувилбар**

1 *Үнэ төлбөргүй үйлчилгээг хүргэх.* Хамрах хүрээ нь ихэвчлэн гадны байгууллагын санхүүжилтээс хамаарна. Олонх тохиолдолд зөвхөн гамшигт нэрвэгдсэн хүн амын багахан хэсэгт хүрч үйлчилнэ. Хэрвээ эмнэлзүйн үйлчилгээ нь тусламжийн байгууллагын ажилтнаар дамжин хүрч байгаа бол орон нутгийн үйлчилгээ, зах зээл, урт хугацаанд хүчтэй байх, хөгжлийн процесс нь удаашрах магадлалтай. Ямар нэгэн удирдлага, хяналтгүй бол уг үйлчилгээ нь эцсийн цэг дээр үнэгүй хүргэгдэхгүй байх эрсдэлд орж магадгүй юм.

2 *Одоогийн буюу шинээр сургагдсан мал эмнэлгийн туслах ажилтнууд.* Ихэвчлэн эдгээр ажилтнууд мэргэжлийн үйлчилгээг олон нийтэд арай бага үнэлгээгээр хүргэдэг. Энэхүү хэлбэр нь орон нутгийн чадавхийг бэхжүүлэх, тогтолцоог дэмжиж цаашид гамшгийн үр нөлөөг бууруулахад тусалдаг. Мөн энэ нь үйлчилгээний хүрэлцээ болон бэлэн байдлыг сайжруулдаг. Нөгөө талаас мал эмнэлгийн үйлчилгээг санхүүгийн хувьд чанартай удирдах асуудал чухал болж эхлэнэ.

3 *Үйлчилгээнд зориулсан төлбөрийг танилцуулах.* Энэ хувилбарт үйлчилгээ нь гамшгийн идэвхтэй үе шатанд үйлчилгээг үнэгүй, харин төгсгөлийн үе шатанд мал аж ахуйн зах зээл ажиллаж эхэлмэгц үйлчилгээний төлбөрийг шаардана. Энэхүү хувилбарын эрсдэл нь эхний хувилбарын эрсдэлтэй төстэй байна. Энэ нь урьд өмнө нь үйлчилгээг үнэ төлбөргүй авч байсан хүмүүст төлбөр төлж эхлэх нь хүндрэлтэй байж болох юм.

Бэлэн мөнгө тараах аргачлалыг ашиглах нь Хямралын үед мал эмнэлгийн болон мал эмнэлгийн туслах ажилтан нар шаардлагатай үйлчилгээг хүргэхийн тулд гэрээ байгуулж, зарим механизм тухайлбал эрхийн бичиг зэргийг ашигладаг. *Бүлэг 3: Анхдагч үнэлгээ болон хариу арга хэмжээг тодорхойлох* нь хэсэгт гамшгийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэх үед бэлэн мөнгө болон эрхийн бичиг ашигласан тухай дурдагдсан. Бэлэн мөнгө тараах аргыг хамгийн ядуу болон эмзэг

өртөмтгий бүлгийн малчдад туслахад зориулан хэрэглэдэг. Энэ нь гамшгийн үед хувийн хэвшлийн үйлчилгээг хэвийн явуулахад тус нэмэр болно. Бэлэн мөнгө болон эрхийн бичиг нь ялангуяа мал эмнэлгийн клиник үйлчилгээг үзүүлэхэд нэмэр болдог. Төрийн мал эмнэлгийн зарим үйл ажиллагаа нь нөхөн олговор эсвэл шууд бус тэтгэмж олгох хэлбэртэй байж болно. Энэ талаар энэхүү бүлгийн төгсгөлд *Жишээ, судалгаа 5.1; 5.2 болон Малжуулах хэсэг гэсэн 9 дүгээр бүлгийн Жишээ судалгаа 9.8* хэсгээс харна уу.

Хуаран

Хүн болон мал амьтан шилжин нүүдэллэх нь өвчин тархах нөхцөлийг бий болгодог. Өвчин дамжих эрсдэл нь олон малчдын янз бүрийн насны мал амьтад нь усны эх үүсвэрийн эргэн тойронд холилдсон тохиолдолд маш өндөр болдог. Иймээс мал амьтны өвчний эрсдлийг бууруулах зарим өвөрмөц арга хэмжээг хэрэгжүүлдэг. Жишээлбэл, шинээр авчирсан малыг бусад мал амьтнаас тусгаарлан өвчнөөс урьдчилан сэргийлэх хорио цээрт оруулах, өөр нэг хэлбэр нь мал амьтдын дунд өвчний тархалтыг бууруулах туслах зорилгоор тус тусад нь уст цэгт услах явдал юм. Нүүдэллэж явах үед мал эмнэлгийн нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ чухал юм. Жишээ нь: Малчдыг мал амьтны өвчний шинж тэмдгийг мэддэг, хэзээ, хэнд хэрхэн мэдээлдэг талаар сайтар сургаж бэлтгэх хэрэгтэй. Тэдэнд мөн өвчнөөс урьдчилан сэргийлэх сайн дадал, ур чадварыг эзэмшүүлбэл зохино.

Стандартууд

Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхийн өмнө гамшигт өртсөн хүн амын хэрэгцээ, тэнд байгаа мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгч нарын чадвар ба боломжийг *Бүдүүвч 5.1*-т байгаа шийдвэрийн модны загварыг ашиглан нарийвчлан тооцон үзнэ.

Бүдүүвч 5.1 Мал эмнэлгийн клиник үйлчилгээ хийх шийдвэрийн модны загвар

Тайлбар:

1. *Төрийн эсвэл хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээг аль нь ч үзүүлэх боломжгүй байвал (жишээ нь зэвсэгт мөргөлдөөнтэй газарт) гадны байгуулага хариу арга хэмжээг хязгаарагдмал цаг хугацаанд хийж гүйцэтгэнэ.*
2. *"Үйлдэл хийхгүй" гэсэн үр дүн (онцгойлон үзэх асуудал гараагүй бол)»гэдэг нь газар дээр нь ямар нэг арга хэмжээ авч болохгүй гэсэн үг яг биш гэхдээ гол асуултуудад «тийм» гэсэн хариулах боломжтой байх үүднээс цаашид шаардлагатай сургалт буюу чадавхийг сайжруулах асуудлууд шаардлагатай байж болох юм.*

Мал эмнэлгийн туслалцааны стандарт 1:
Үнэлгээ ба төлөвлөлт

Мал эмнэлгийн үйлчилгээний хэрэгцээг үнэлэх, арга хэмжээг эрэмбэлэхэд хямралд өртсөн иргэд, ялангуяа эмзэг бүлгийг идэвхтэй хамруулна.

Үндсэн үйл ажиллагаа

- Хямралд өртсөн хүн амын дундах бүх хамааралтай дэд бүлгийг хамруулан орон нутгийн мал эмнэлгийн удирдах байгууллага, үйлчилгээ үзүүлэгчидтэй хамтран мал эмнэлгийн үйлчилгээний хэрэгцээний шуурхай үнэлгээ хийж, хэрэгжүүлэх ажлыг эрэмбэлнэ. (*Зааварчилгаа 1-ийг харна уу*).
- Хямралд өртсөн нутаг (үүнд дүрвэсэн болон хүлээн авч байгаа нутаг орон)–ийг хамруулан газрын зураг гаргах, бүх мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгч нарын одоогийн чадавхи, хэрвээ туслалцааны байгууллагаас тусалбал буй болох чадамжийг шинжлэх (*Зааварчилгаа 2*-ыг харна уу)
- Үйлчилгээ үзүүлэгчдийн ажил үйлчилгээг гамшгийн өмнөх үеийн төлбөрийн нөхцөлтөй холбон судлаж энэхүү үнэлгээгээ баталгаажуулна (*Зааварчилгаа 2* харна уу).
- Өвөрмөц арга хэмжээний стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эсвэл эрхзүйн орчинд түргэвчилсэн үнэлгээ хийнэ (*Зааварчилгаа 3* харна уу).

Зааварчилгаа

1. Шуурхай оролцооны үнэлгээ хийхийн тулд:

- оролцооны аргад тусгайлан сургагдаж бэлтгэгдсэн туршлагатай мал эмнэлгийн ажилтан нарыг ашиглана.
- эмзэг бүлгийг чухалчлахад тусгайлан анхаарал тавих
- орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон хувийн хэвшлийн мал эмнэлгийн ажилтан нартай зөвлөлдөх
- мал амьтны эрүүл мэнд болон тавлаг байдлын асуудлыг тодорхойлж, эрэмбэлж, малын төрөл болон өртөмтгий бүлэгт

яаралтай туслалцаа үзүүлэхийг зорих

- боломжтой ба тохирох чанартай хоёрдогч мэдээллийн бодит байдлыг давхар шалгах[2].

Хавсралт 5.1 дэх хэсэгт үнэлгээний үзүүлэлтийн жагсаалт болон аргуудын талаар дурдсан болно (Мөн *Хавсралт 3.2: Оролцооны аргууд, Бүлэг 3: Анхдагч үнэлгээ болон хариу арга хэмжээг тодорхойлох нь* хэсгийг харна уу). Мал амьтны өвчний албан ёсны судалгаа нь тухайлбал асуумж болон лабораторийн онош гамшгийн үед хэрэгжүүлэх боломж муутай байдаг. Малын өвчний тухай хамгийн үнэ цэнэтэй мэдээлэл олж авлаа ч гэсэн нэмэлт цаг хугацаа, зардал ба шуурхай ажиллагааны хэрэгцээтэй холбоотой баталгаажуулах нь ховор байдаг. Үргэлжилсэн хямралын үед малын өвчинтэй тэмцэх стратегийг тодрхойлохын тулд малын өвчний илүү системтэй тандалт судалгааг хийх хэрэгтэй. Эдгээр тохиолдолд тархвар судлалын аргуудыг хэрэглэх нь илүү зохистой юм. (Catley, 2005).

2. Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгч нарын байршил болон дүн шинжилгээ. Одоо байгаа мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгч нарын (малын эмч, мал эмнэлгийн бүх төрлийн туслах ажилтан) байршил, тэдний үйл ажиллагаа, хамрах хүрээний зураглал нь тусламжийн байгууллагын эмзэг бүлэгт хүрэх, мал эмнэлгийн үйлчилгээ хүргэх, хүрээгээ төлөвлөх, үйлчилгээний стратегээ тодорхойлоход хэрэг болдог. Газрын зураглал гаргах дүн шинжилгээ хийхдээ төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэгчдийн үнэ ханшийг оруулна. Янз бүрийн улс орнуудад мал эмнэлгийн туслах ажилтан нарын ангилал өөр байдаг боловч дараах зүйлс багтдаг. Үүнд:

- мал эмнэлгийн туслахууд
- мал амьтны эрүүл мэндийн үйлчилгээ эрхлэгч/туслах нар
- мал эмнэлгийн техникийн ажилтнууд
- тухайн улсын болон олон улсын мал эмнэлгийн хууль эрхзүй болон кодод заагдсан олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтан
- орон нутгийн эмийн сан, уламжлалт аргаар мал эмчилдэг хүмүүсийг оролцуулсан албан бус мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэгч нар.

Зарим гамшгийн үед (ихэвчлэн зэвсэгт мөргөлдөөн) улсын ба хувийн мал эмнэлгийн аль нь ч хүрэлцээтэй үйлчилгээ үзүүлж чадах боломжгүй байдаг. Ийм тохиолдолд холбогдох гадны байгууллагууд сургагдсан орон нутгийн олон нийтэд түшиглэсэн малын эрүүл мэндийн туслах ажилтан ба

малчдаар дамжуулан олон нийтэд суурилсан мал амьтны эрүүл мэндийн үйлчилгээг дэмжих нь зохистой байдаг. Энэхүү үйл ажиллагаа нь хувийн хэвшил болон засгийн газрын чадавхийн төлөвлөгөө дээр суурилан хийх бөгөөд гарах стратегийн хэсэг болгон хэрэгжүүлэх хэрэгтэй.

3. Бодлого болон хууль эрх зүйн хүчин зүйлс. Шуурхай үнэлгээнд хэрэгжүүлэх хувилбаруудтай холбоотой Засгийн газар болон агентлагын бодлого, дүрэм, журмыг шуурхай тоймлон үзэж оруулах хэрэгтэй. Жишээлбэл:

- Зарим улс орнуудад мал эмнэлгийн туслах ажилтан нарын мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулах эрхийг хуулиар зөвшөөрөөгүй буюу эсвэл тодорхой хүрээнд хязгаарласан байдаг.
- Зарим улс орнуудад мал амьтны өвчнийг хяналтад авах бодлогод зарим зүйлс тухайлбал хяналтанд авах аргууд нь тун хязгаарлагдмал тусгагдсан, сонголтгүй эсвэл дагаж мөрддөггүй.
- Мөн малын эмийг бүртгэх эрх бүхий үндэсний байгууллагын эмийн бүртгэлд мал эмнэлгийн зориулалттай тухайн бүтээгдэхүүн хэрэглэхийг хязгаарласан байдаг.
- Онцгой нөхцөл байдалд хурдан шуурхай хэрэгцээтэй худалдан авалтыг хориглосон зарим донор байгууллагын хүнд сурталтай шаардлага нь заримдаа малын эмийн худалдаанд саад учруулдаг.
- Байгууллагын болон донорын бодлого нь зардлаа нөхөх төлөвлөгөөнд саад тотгор учруулж болох юм.

Бодлогын агуулга гэдэг ойлголт нь боломжит хязгаарлалтуудыг хүлээн зөвшөөрөх, бодлогын арга хэмжээний суурийг тавих хоёуланд нь амин чухал *(Бүлэг 2, Нийтлэг стандартууд ба мал амьтанд хамааралтай нийтлэг асуудлууд, Нийтлэг стандарт 7: Бодлого болон нөлөөлөл).*

Клиник мал эмнэлгийн туслалцааны стандарт 1: Үйлчилгээг төлөвлөх

Мал эмнэлгийн туслалцааг орон нутгийн нийгэм, техник, аюулгүй байдал, бодлогод нийцүүлэн гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн идэвхтэй оролцоотойгоор төлөвлөнө.

Үндсэн үйл ажиллагаа:

- Үйлчилгээний төлөвлөлтийг баталгаажуулахын тулд анхан шатны үнэлгээний мэдээллийг ашиглан дүн шинжилгээ хийх ба эмзэг бүлгийг хамруулан хямралд өртсөн хүмүүсийн идэвхтэй оролцоо дээр үндэслэнэ (*Зааварчилгаа 1-ийг* харна уу*).*
- Үйлчилгээний төлөвлөлт нь хүн амын эмзэг хэсэгт хүрч үйлчлэх өвөрмөц арга замууд, ялангуяа хүртээмж болон чадварын талаарх бэрхшээлийг тооцон оруулсныг шалгаж үзэх (*Зааварчилгаа 2-ыг* харна уу*).*
- Үйлчилгээний төлөвлөлт нь эрт анхааруулгын системээр илрүүлж болох цаг агаарын гэнэтийн үзэгдэлтэй холбоотой өвчний дэгдэлтийн эрт илрүүлэх шалгуур үзүүлэлтийг харгалзан үзсэнийг баталгаажуулах (*Зааварчилгаа 3-ыг* харна уу*).*
- Үйлчилгээний төлөвлөлтөд шаардагдах мал эмнэлгийн зориулалттай вакцин, эмийг яаралтай худалдан авалт хийх шаардлага ба хадгалах боломж түүнээс гадна бүтээгдэхүүний зохистой чанар болон орон нутгийн түвшинд тэдгээрийг боломжит агуулах зэргийг харгалзан үзсэнийг бататгах (*Зааварчилгаа 4-ийг* харна уу*).*
- Үйлчилгээний төлөвлөлтөд шаардлагатай бол орон нутгийн үйлчилгээ үзүүлэгч нарыг түргэвчлэн сургах төлөвлөгөөг оруулсан эсэхийг шалгаж үзэх (*Зааварчилгаа 5-ыг* харна уу*).*
- Үйлчилгээний төлөвлөлт нь орон нутгийн нийгэм, соёлын хэм хэмжээ, ялангуяа хүйсийн үүрэг рольтой уялдаж байгаа эсэхийг нягтлаж үзэх (*Зааварчилгаа 6-г* харна уу*).*
- Үйлчилгээний төлөвлөлт нь орон нутгийн хүмүүс, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгч нар, туслалцаа үзүүлж байгаа бусад газрын ажилтан нарын аюулгүй байдлыг дээд зэргээр хангаж байгаа эсэхийг нягтлан үзэх (*Зааварчилгаа 7 харна уу).*
- Үйлчилгээний төлөвлөлт нь хэрэгжүүлэх газарт боломжтой үйлчилгээний төлбөртэй нийцэж байгаа эсэхийг нягталж үзэх (*Зааварчилгаа 8 харна уу).*
- Үйлчилгээний төлөвлөлт нь мал эмнэлгийн туслах ажилтнуудын мэргэжлийн удирдлагаар хангах чадавхийг буй болгоход чиглэгдсэн эсэхийг нягталж үзэх (*Зааварчилгаа 9 харна уу).*

Зааварчилгаа

1. **Үнэлгээний үр дүнд суурилсан төлөвлөлт.** Үйлчилгээний төлөвлөлт нь анхан шатны үнэлгээний явцад гарсан мал амьтны эрүүл мэндийн асуудлыг эрэмбэлэн тодорхойлоход чиглэгдэнэ. Мал эмнэлгийн анхан шатны зохих үйлчилгээ нь мал амьтны эрүүл мэндийн бүх асуудалд чиглэн ажиллах боломж муутай төдийгүй зохимжгүй юм. Олонх тохиолдолд хязгаарагдмал хэмжээтэй мал амьтны вакцин болон эм бэлдмэл нь тухайн газар нутагт хамгийн чухал ач холбогдолтой өвчнүүдийг эмчлэх, уг өвчнийг таслан зогсоож чадна. Иймээс мал амьтны өвчнийг ач холбогдлоор нь эрэмбэлсний үндсэн дээр хийгдэх мал эмнэлгийн үйлчилгээг малчдыг оролцуулан бүх ашиг хүртэгчид талууд харилцан ойлголцож, хүлээн зөвшөөрсөн байх шаардлагатай. Хэрвээ тодорхой зүйлд чиглэсэн эрэмбэлэлт хийж чадахгүй тохиолдолд (жишээлбэл, хүйтэн хэлхээ мэтийн зайлшгүй техникийн дэмжлэг байхгүй бол) бүх ашиг хүртэгчдийг оролцуулаад бүх оролцогч талууд үйлчилгээг мөн харилцан зөвшөөрсөн байх хэрэгтэй. Үүнтэй адилаар үйлчилгээ үзүүлэх зохистой цаг хугацааг (ялангуяа вакцинжуулалт) оролцогч бүх талуудтай сайтар зөвлөлдөн өөр хоорондоо сайтар харилцан ойлголцсон байх шаардлагатай. Боломжтой бол үйлчилгээний төлөвлөлтөд гамшигт нэрвэгдсэн нутгийн хүн ам идэвхтэй оролцох хэрэгтэй.

2. **Эмзэг бүлэгт хүрэх.** Үйлчилгээний төлөвлөлт эмзэг бүлгийн мэдэлд байгаа хэрэглээний мал амьтны төрөл, тэдгээр мал амьтны эрүүл мэндийн асуудлыг анхаарна. Мал эмнэлгийн үйлчилгээ авах эрх тэгш байдлыг хангахын тулд үйлчилгээний хүртээмж ба боломжит байдалд тусгайлан анхаарал хандуулна. Дэд бүтэц алслагдмал нутагт тээвэрлэлтийн өртөг өндөр байгаагаас (жишээ нь агаарын тээвэр) хамрагдалт нь хязгаарагдмал байж болно. Энэ тохиолдолд мал эмнэлгийн мэргэжлийн туслах ажилтан нарт түшиглэж ажиллах ба тэд нар явган эсвэл орон нутгийн нөхцөл байдалд тохирсон бусад тээврийн хэрэгсэл (илжиг, унадаг дугуй, завь)-ийг ашиглаж үйлчилгээ үзүүлэх боломжит хувилбар байж болох юм. Зарим тохиолдолд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх хөтөлбөр малын эмч нарыг орон нутгийн боломжит тээврийн хэрэгслээр хангахад тусалдаг.

Гэнэтийн гамшгийн үед тээвэрлэлт үнэгүй байж болох ч харин үргэлжилсэн хямралын үед тээврийн зардал хуваах хэлбэр боломжтой

байдаг. Үйлчилгээний төлбөрийн стратегийг үйлчилгээ шуурхай жигд хүргэх, аль болох хувийн хэвшлийн мал эмнэлгийг дэмжихээр тооцон үзэх хэрэгтэй. Илүү олон өртөмтгий бүлэг байвал хувийн хэвшлийн мал эмнэлгийн эмч ажиллагсад нь богино хугацаанд үйлчилгээг хүргэхийн тулд байгууллагуудтай нэмэлт гэрээг байгуулдаг. Эрхийн бичгийн схемийг ашиглаж болно (*Жишээ судалгаа 5.1 болон 5.2 хэсгийг* харна уу). Хувийн хэвшлийн мал эмнэлгүүд идэвхтэй ажилладаг, мал эмнэлгийн үйлчилгээнд төрөөс татаас олгодог нутагт сонгосон эмзэг бүлгийн үйлчилгээний үнэнд боломжоор нь хөнгөлөлт үзүүлээд, тухайн нутагт дагаж мөрдөж байгаа үйлчилгээний үнийн бодлогыг дагаж мөрдөх хэрэгтэй. Эндүүрэл гарахаас сэргийлэхийн тулд олон нийтийн оролцоо, тэдний төлөөлөлтэй энэ асуудлаар гэрээ байгуулах шаардлагатайн дээр бүх оролцогчдод тодорхой мэдээлэх хэрэгтэй.

3. **Цаг агаартай холбоотой үүсэх өвчний дэгдэлтийн бэлэн байдал**. Олон тооны мал амьтны өвчин нь цаг уурын өөрчлөлттэй тухайлбал бороо орох буюу аадар буух зэрэгтэй хамааралтай байдаг. Тухайлбал зүүн Африкт Рифт хөндийн халуурал өвчин нь El Nino үзэгдлээс үүдсэн үргэлжилсэн бороо орж үер буух тай нягт холбоотой байдаг. Мал эмнэлгийн яаралтай үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ цаг агаарын үзэгдэл болон мал амьтны өвчлөлийн хоорондох уялдаа холбооны талаарх мэдлэгийг сайжруулах ажлыг хамтад нь авч үзнэ (Хил дамжин халдварлах өвчний мэдээллийн эх сурвалжийг холбох тухай *Танилцуулга хэсэгт бусад стандарт болон гарын авлагатай холбогдох гэсэн нэртэй бүлгийг* харна уу).

4. **Яаралтай худалдан авалт болон хадгалалт.** Туслалцааны байгууллагууд малын эмийг худалдан авах туршлага хязгаарлагдмал байдаг хэмээн шинжээчид үздэг. Янз бүрийн ханган нийлүүлэгчийн эм болон вакцины чанар нь орон нутгийн болон олон улсын хэмжээнд авч буй эх үүсвэрээс шалтгаалан өөр өөр байна. Нийлүүлэгч нарын хувьд ч их хэмжээгээр хүчинтэй эмийг заагдсан хугацаанд нийлүүлэх чадавхи нь өөр өөр байдаг. Өргөн хүрээтэй олон тооны барааг худалдан авалтад зарим хүндрэл бэрхшээл үүсдэг. Мал эмнэлгийн зарим вакцин нь тухайн нутгийн омгоор хийгдсэн байдаг тул, вакцины найрлагыг зөв эсэхийг сайтар нягтлах шаардлагатай болдог. Орон нутгийн импортлогч нар ихэнхдээ тухайн улсынхаа нийслэлд голчлон төвлөрч, эмийг шаардагдах хэмжээгээр түргэн нийлүүлэх боломжтой байдаг. Хэдий тийм ч эмийн чанар, хүчинтэй хугацаа,

эм хадгалах нөхцөлүүдийг нягтлан шалгах хэрэгтэй. Мал эмнэлгийн зориулалттай олонх вакцин болон зарим нэрийн эмийг орон нутагт хэрэглэх үед ч хүйтэн хэлхээний нөхцөлд хадгалахыг шаарддаг. Тэд орон нутагтаа тээвэрлэлтийн болон хадгалалтын зориулалт бүхий хүйтэн хэлхээний төхөөрөмж худалдан авах ба хэрэглэх хэрэгцээгүй бол тэдэнд тээвэрлэлтийн хүйтэн хэлхээг баталгаажуулж өгөх хэрэгтэй. Хуаран маягийн суурьшилд хүйтэн хэлхээ ба агуулах дутагдалтай учраас агуулах нь бодитой бэрхшээл болж байх талтай. Хүн эмнэлгийн зориулалттай хүйтэн хэлхээний барилга байгууламжийг зарим тохиолдолд хамтран ашиглаж болох юм. Гэвч хүн эмнэлгийн мэргэжилтэн нар эмнэлгийн зориулалттай хүйтэн хэлхээнд мал эмнэлгийн эм, вакциныг хадгалахыг зөвшөөрөхгүй байх нь түгээмэл байдаг. Үнэтэй хүйтэн хэлхээний байгууламжийн давуу талыг бий болгохын тулд шийдвэр гаргах түвшингийн гэрээ хийх хэрэгтэй.

5. **Сургалтын төлөвлөгөө.** Мал эмнэлгийн одоо ажиллаж байгаа ажиллагсад болон шаардлагатай үйлчилгээг шуурхай хүргэхэд богино хугацааны давтан сургалт шаардагдана. Тэдгээр сургалт нь дараах зүйлд гол анхаарлаа хандуулна. Үүнд: 1) эрэмбэлсэн өвчнүүдэд эмнэлзүйн оношилгоо хийх, 2) мал эмнэлгийн эм, вакциныг зөв хэрэглэх Орон нутгийн малын эмч нарын чадавхаас хамааран энэхүү давтан сургалт хийх хэрэгцээ байнга байдаггүй. Мал эмнэлгийн туслах ажилтан нарыг тухайлбал нутгийн олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтанг сонгон авч сургалтанд хамруулан гамшгийн хөтөлбөрөөс илүүтэй олон нийтийг түшиглэн малын эрүүл мэндийг хамгаалах тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай гарын авлагаар хангах хэрэгтэй. (*Ашигласан хэвлэл* болон Catley et al., 2002 хэсгийг харна уу). Энэхүү арга нь гамшгийн нөхцөл байдал бий болсон үед шуурхай хариу арга хэмжээг авах тохиромжтой, олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтанг сонгох болон сургахад хамаатай сайн дадалын зарчим байж болох юм. Гэвч онцгой байдал ужгирах буюу дуусах үе шатандаа орох үед олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтны мэдлэг, ур чадварыг сайжруулах дараагийн сургалтыг хийхийг зөвлөмж болгодог. Зарим орнуудад олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтныг бэлтгэх тогтолцоонд зориулсан үндэсний хэмжээний тогтолцооны стандарт болон гарын авлага, зааврууд байдгаас гадна богино хугацааны сургалтын гарын авлага, практик болон оролцоот сургалтууд байдаг.

6. **Нийгэм, соёлын хэм хэмжээ.** Мал эмнэлгийн туслалцааг төлөвлөхөд тухайн орон нутгийн нийгэм, соёлын хэм хэмжээ ялангуяа тэдгээр үйл ажиллагаанд оролцож байгаа эсвэл үйлчилгээ үзүүлж байгаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын харилцаа, гүйцэтгэх үүрэг хариуцлагыг бодолцох шаардлагатай. Зарим газарт эмэгтэйчүүдийн хувьд амьдарч байгаа нэг газраас нөгөөд шилжих, ганцаараа чөлөөтэй явах зэрэг нь одоо болтол хязгаарлагдсан хэвээр байна. Хэдийгээр иймэрхүү хуучинсаг соёл байгаа ч эмэгтэйчүүдийг ялангуяа тэднийг сонгож болон сургаж олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтан болгон үйл ажиллагаа явуулахдаа ашиглана. Мөн эмэгтэй малчид нь хамгийн эмзэг өртөмтгий бүлэгт хамаардаг болно.

7. **Хамгаалалт.** Мал аж ахуй нь орон нутгийн эдийн засаг болон хүмүүсийн амьжиргаанд туйлын өндөр ач холбогдолтой бол малын эм нь өндөр үнэтэй байдаг. Жижиг хэмжээтэй, өндөр үнэтэй зүйлүүд нь хулгайлагдах болон дахин цаашид дамлан худалдахад хялбар байдаг. Үйлчилгээний төлөвлөлтийг гаргахдаа мал эмнэлгийн ажилтанд учрах хүчирхийлэл, хулгай, дээрэм зэрэг эрсдлийг тооцож үзнэ. Мал амьтан нь ихэвчлэн суурьшлын бүсээс алсад бэлчээрлэнэ. Заримдаа мал амьтан ус, бэлчээрт хүрэхийн тулд алс хол туугдах нь байдаг. Мал эмнэлгийн ажилтан нар тэдгээр газар нутагт очиж ажиллаж магадгүй тухайлбал зэвсэгт мөргөлдөөнтэй үед тэд эрсдэлд орж болзошгүй. Энэ нөхцөлд орон нутгийн мал эмнэлгийн туслах ажилтан нарын хувьд газар нутгийн нөхцөл байдлыг сайтар мэддэг орон нутгийн хүмүүстэй хэл амаа амархан ололцож ойлголцдог учраас илүү тохиромжтой байж болох юм.

8. **Үйлчилгээний төлбөр.** Нотлох баримт бичиг, үйлчилгээний загварт заагдсан боломжтой бүх хэлбэрээр үйлчилгээний төлбөрийг олгоно. Эрхийн бичгийн схем нь мал малладаг хамгийн эмзэг өртөмтгий бүлэгт хэрэглэдэг арга юм. Бусад хүмүүсийн хувьд үйлчилгээний төлбөр хийсний дараа нөхөж олгож болно. Засгийн газар нь вакцинжуулах бүхий л үйл ажиллагааг «хувь хүний эрх ашигт» бус харин «нийтийн эрх ашигт» хандсан арга хэмжээ хэмээн үзэх шаардлагатай. Клостиродын төрлийн өвчин мэтийн мал амьтан хооронд амархан дамжиж тархаад байдаггүй өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахдаа хувийн эрх ашгийг харгалзан үзнэ. Онолын хувьд хувийн хэвшил нь хамгийн сайн тоноглогдсон, сайн үйлчилгээ хүргэгч юм.

9. **Мал эмнэлгийн туслах ажилтан нарт мэргэжлийн зөвлөгөө**

хүргэх. Хаана мал эмнэлгийн туслах ажилтан нар тухайлбал олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтан үйл ажиллагаа явуулж байна тэд мал эмнэлгийн мэргэжилтний удирдлагын дор ажиллах хэрэгтэй. Мэргэжлийн удирдлага нь мал эмнэлгийн бэлдмэлийг зөв хэрэглэж байгаа хяналт хийх, өвчний мэдээллийг орон нутгаас үе шаттай удирдах албан тушаалтан хүртэл мэдээлэх, олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтан нь орон нутгийн, улсын болон хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээтэй уялдуулахад таатай нөлөөлнө.

Мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээний стандарт 2: Үзлэг, эмчилгээ

Үзлэг болон эмчилгээ нь гамшигт нэрвэгдсэн нутгийн иргэдийн идэвхтэй оролцоотойгоор зохистой хэрэгжүүлнэ.

Үндсэн үйл ажиллагаа

- Бүх оролцогчдын гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох. Хаана, хэн, юу хийх шаардлагатайг гэрээнд бичиж тэмдэглэнэ *(Зааварчилгаа 1* хэсгийг харна уу*).*
- Өвчтэй буюу гэмтэж бэртсэн мал амьтныг хүмүүнлэг энэрэнгүй аргаар аюулгүй нядалж устгах *(Зааварчилгаа 2* хэсгийг харна уу*).*

Зааварчилгаа

1. ***Эрх үүрэг болон хариуцлага.*** Гамшгийн үед мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээнд гарч болох нэг хүндрэлтэй асуудал нь ашиг хүртэгчдийн хоорондын зохицуулалт юм. Жишээлбэл, үйл ажиллагаанд оролцогч өөр өөр хүмүүсийн эрх үүрэг, хариуцлага ойлгомжгүйгээс үйлчилгээний зорилго, хамрах хүрээний талаар хуурамч хүлээлт үүсэх, үнийн зохицуулалт эсвэл ашиг хүртэгчийн сонголтоос үүссэн эндүүрэл үүсэх зэрэг. Иймэрхүү олон хүндрэлээс сэргийлэхийн тулд ашиг хүртэгчдийн зөвөлгөөн, олон нийтийн оролцоог хангах, орон нутгийн эрх бүхий байгууллагууд болон хувийн хэвшлийн төлөөлөлтэй нягт хамтран ажиллавал зохино. Харилцан ойлголцлын санамж бичиг буюу бусад ижил төстэй гэрээ баримт бичгийг байгуулан оролцогчдын эрх үүрэг, хариуцлагыг сайтар тусгасан байх шаардлагатай. Энэ нь харилцан маргаан үүсэхээс сэргийлж чадах үндсэн лавлах баримт бичиг юм.

2. ***Малыг хүмүүнлэг энэрэнгүй аргаар аюулгүй нядалж устгах.*** Мал амьтныг энэрэнгүй аргаар аюулгүй нядалж устгахад хүмүүнлэг стандарт болон дадлыг ашигладаг. Өвчлөл болон гэмтэл бэртэл зэргээс шалтгаалан нядлах устгах аргыг сонгох ба зарим гулууз махыг хүнсний хэрэгцээнд ч ашиглаж болно (*Мал эмнэлгийн нийгмийн эрүүл мэндийн стандарт 2: Ариун цэвэр болон хүнсний эрүүл ахуй* гэсэн хэсгийг харна уу).

Мал эмнэлгийн нийгмийн эрүүл мэндийн стандарт 1: Зооноз өвчнүүд

Мал амьтнаас хүнд халдварладаг өвчин (зооноз)—өөс сэргийлэх, тэмцэхэд чиглэсэн үйлчилгээ, мэдээллийг хүн амд хүргэх явдал юм.

Үндсэн үйл ажиллагаа

- Мал амьтны эрүүл мэндийн асуудлын анхдагч үнэлгээнд зооноз өвчний үнэлгээ ба тэдгээрийн чухалчлалыг оруулна (*Зааварчилгаа 1* хэсгийг харна уу).
- Зооноз өвчинтэй тэмцэх арга хэмжээг мал эмнэлгийн клиник үйлчилгээ үзүүлэхтэй холбох юмуу дангаар нь төлөвлөн хэрэгжүүлэх (*Зааварчилгаа 2* хэсгийг харна уу).

Зааварчилгаа

1. ***Үнэлгээ.*** Мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээний стандарт 1:-ийн Үйлчилгээний төлөвлөлтийн хүрээнд оролцооны аргаар шуурхай үнэлгээ хийхэд зооноз өвчний бодит тохиолдол буюу эрсдлийн шуурхай үнэлгээг оруулах хэрэгтэй. Гамшгийн үед зооноз өвчний эрсдэл байнга нэмэгдэж байдаг. Үүний шалтгаанд дараах зүйлүүд хамаарна. 1) боом өвчин нь мал амьтны урьд өмнө очдоггүй байсан шинэ нутаг бэлчээрт нүүхтэй холбоотой гардаг; 2) галзуу өвчин нь орон нутгийн золбин ба гэрийн тэжээвэр махчин амьтад, малын сэг зэм, хог дээр цугласантай холбоотой; 3) зооноз өвчин нь хүн мал амьтантай шууд харьцахтай холбоотойг; 4) дүрвэгсдийн хуаранд мал амьтан, хүн олноор бөөгнөрснөөс тэдний эрүүл ахуйн нөхцөл доройтсноос; 5) усны хангамж алдагдсанаас.

2. **Зооноз өвчнийг хяналтанд авах нь.** Зооноз өвчинд хяналт

тавих аргууд өвчнөөсөө хамааралд янз бүр байдаг. Тухайлбал зарим өвчний хувьд мал эмнэлгийн туслах ажилтнууд нь малчдад мэдээллийг шууд өгөх буюу эсвэл тараах материал өгөн мэдээллээр хангаж болдог. Тэдгээр туслах ажилчид тухайлбал галзуугаас сэргийлэх өргөн хүрээний вакцинжуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх эсвэл золбин нохойн өсөлтийг хянахад нь тусалж болно. Эмэгтэйчүүдэд хүрч ажиллах нь ихээхэн ач тустай учир нь тэд нар мал амьтны эрүүл мэндийн менежментийн асуудалд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг гэвч тэд өвчинтэй тэмцэх арга хэмжээг орхигдуулдаг. Хувийн малын эмч нарын үйлчилгээний төлбөрийг туслалцааны байгууллагаас гаргуулан богино хугацаатайгаар энэ ажилд ашиглаж болно. Зооноз өвчинтэй тэмцэхэд туслалцааны байгууллага хоорондын болон бүс нутаг хоорондын хамтын ажиллагаа зохицуулах хэрэгтэй байдаг. Хүний эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах, тэдний нөөц чадавхийг тухайлбал хүйтэн хэлхээний байгууламжийг ашиглах зэргээр нягт хамтран ажиллах хэрэгтэй (*Мал эмнэлгийн эмнэлзүйн стандарт 1: Үйлчилгээний загвар, Зааварчилгаа 4* хэсгийг харна уу).

Мал эмнэлгийн нийгмийн эрүүл мэндийн стандарт 2: Ариун цэвэр болон хүнсний эрүүл ахуй

Малын гаралтай бүтээгдэхүүний хэрэглэх, малыг нядалж устгахад баримтлах ариун цэвэр, хүнсний эрүүл ахуйн арга хэмжээнд үндэслэгдэнэ.

Үндсэн үйл ажиллагаа

- Үргэлжилсэн хямралын үед мал нядалгааны талбай байгуулна (*Зааварчилгаа 1* хэсгээс харна уу).
- Нэрвэгдсэн нутгийн хүмүүсийн хэрэглэж байгаа мал нядалгааны талбай, бойнд махны үзлэгийг хэвшүүлэх (*Зааварчилгаа 1* хэсгээс харна уу).
- Хүнсийг аюулгүй бэлтгэх сайн дадлыг дэлгэрүүлэх (*Зааварчилгаа 2* хэсгээс харна уу).

Зааварчилгаа

1. **Мал нядлах байгууламж болон махны хяналт шалгалт.** Хуаран маягийн суурьшлын, эсвэл мал нядлах байгууламж нь сүйдсэн үед нядалгааны талбайг барьж байгуулах нь мал нядалгааг хүнлэг зарчмаар хийх, түүнээс гадна махыг эрүүл ахуйн шаардлага ханган бэлтгэх, сургагдсан ажиллагсдаар махны үзлэг хийлгэхэд зохимжтой байдаг, Хэрвээ яаралтай мал амьтны тоо толгойг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр бол мал амьтны тавлаг байдал, эрүүл мэнд болон эрүүл ахуйн стандартыг мөрдөж, суурин буюу хөдөлгөөнт нядалгааны цехийг байгуулж ашиглана (*Бүлэг 4, Мал амьтны тоо толгойг бууруулах* хэсгээс харна уу). Эдгээр бүх тохиолдолд мал нядалгааны талбайн байрлалыг тодорхойлох, загварыг гаргахад орон нутгийн мал аж ахуйн ажиллагсад буюу нядлагч нартай зөвлөлдөнө. Махны хяналтын үйл ажиллагаа ерөнхийдөө бараг дадал болсон зүйл. Нядлагдсан мал амьтны дотор дайвар бүтээгдэхүүнийг аюулгүй устгахыг баталгаажуулна.

2. **Олон нийтийн ойлголт**. Үнэлгээгээр илрүүлсэн зүйл дээр үндэслэн хүнсийг аюулгүй арчлах, бэлтгэх сайн дадлын талаарх олон нийтийн ойлголт, боловсролыг сайжруулах нийтийг хамарсан аян зохион байгуулах хэрэгтэй. Тухайлбал сүрьеэ болон бруцеллёзын хяналтыг мал амьтан эсвэл махыг хоол хүнсэнд бэлтгэхэд анхаарах, буцалгасан сүүг хэрэглэх замаар эрүүл ахуйн сайн дадлыг сайжруулахыг зөвлөх замаар хэрэгжүүлнэ.

Мал эмнэлгийн нийгмийн эрүүл мэндийн стандарт 3: Малын сэг зэмийг устгах

Үхсэн мал амьтны сэг зэмийг аюулгүй устгах, булшлахтай холбоотой үйл ажиллагааг багтаана.

Үндсэн үйл ажиллагаа

- Сэг зэмийг устгах хэрэгцээг үнэлэх (*Зааварчилгаа 1* харна уу).
- Сэг зэмийг устгахад эрүүл ахуйн дэглэмийг мөрдөж ажиллах (*Зааварчилгаа 2* харна уу).

Зааварчилгаа

1. **Хэрэгцээний үнэлгээ**. Гал түймэр, газар хөдлөлт зэрэг гамшиг болсон үед шархтсан гэмтсэн мал амьтныг энэрэнгүй аргаар устгах шаардлага гардаг. Ган болон зуд зэрэг удаан явцтай гамшиг болон зарим үед өргөн хүрээг хамарсан үер ус эсвэл хар шуурганы улмаас олон тооны мал амьтан үхдэг. Эндээс үхсэн мал амьтны сэг зэмийг устгах, булшлахад эрүүл ахуйн нөхцөл шаардлагатай юу гэсэн асуулт урган гарна. Үхсэн мал амьтны сэг зэм нь өвчин тархах үндэс болох ба хог хаягдлыг үүсгэн гадаад орчныг бохирдуулж, нохой, үнэг, мануул, чоно зэрэг махчин амьтад нэг дор олноор цугларах нөхцөлийг бүрдүүлнэ. Нөгөө талаас өвлийн улиралд мал амьтад нь тэжээлийн дутагдалд орж, даарч хөрч (төгсгөлийн шатанд байгаа уушигны хатгаатай төстэй өвчнүүд) тэдгээрээс шалтгаалан үхсэн мал амьтны сэг зэм нь хүн, мал амьтны эрүүл мэндэд аюул эрсдэл үүсгэнэ. Мөн түүнчлэн сэг зэмийг устгах нь усны эх үүсвэрийг бохирдуулж болзошгүйгээс гадна газрын хөрсөнд шингэхгүйгээр их хэмжээний бохирдолтыг үүсгэдэг. Мөн мал олноор үхэж хорогдох нь малчдын сэтгэлзүйд нөлөөлөн, тэдэнд ихээхэн гарз хохирлыг учруулна. Зөвхөн эдгээр үндэслэлээр сэг зэмийг устгах ажлыг зохион байгуулна.
2. **Сэг зэм зайлуулах**. Байгаль орчин болон эрүүл мэндийн асуудалтай холбоотой. Хэрвээ усны эх үүсвэр байгаа газарт мал амьтныг булшилбал бохирдолт үүсэх тул үүнээс зайлсхийх хэрэгтэй. Мал амьтны сэг зэмийг булшлах хамгийн үр дүнтэй арга нь задлагч бодисыг хэрэглэх явдал юм. "Ажил-бэлэн мөнгө" гэсэн схемийн дагуу олон нийтийн нөхөрлөлийн гишүүдийг сэг зэмийг булшлах үйл ажиллагаанд татан оролцуулан тэдэнд ажлын хөлс олгох нь үр дүнтэй. (*Жишээ судалгаа 5.6* харна уу). НҮБ-ын ХХААБ-аас 2015 онд гаргасан хүүр, сэг зэмийг булшлах техникийн гарын авлагыг харна уу.

Мал амьтны өвчний мэдээллийн тогтолцооны стандарт 1.
Мал амьтны өвчний тандалт, судалгаа

Үргэлжилсэн гамшгийн туршид мал амьтны өвчний тандалт судалгааны тогтолцоо нь туслалцаа үзүүлж байгаа гамшигт өртсөн хүн амыг хамарч байдаг.

Үндсэн үйл ажиллагаа

- Мал эмнэлгийн эмнэлзүйн үйлчилгээнд хийсэн хяналтын туршид мал амьтны гол гол өвчний мэдээллийг цуглуулах үйл ажиллагааг багтаана (*Зааварчилгаа 1* харна уу).
- Мал амьтны өвчний дэгдэлтэд хариу арга хэмжээ авах, оношийг баталгаажуулах, халдварын эх үүсвэрийг бүртгэх, шалтгааныг олох, хаагуур тархсаныг,хяналтанд авахад ямар арга хэмжээг зайлшгүй авах шаардлагатай байгааг багтаасан малын өвчний судалгаа хийх (*Зааварчилгаа 2* харна уу).
- Үргэлжилсэн хямралын үед мал амьтны өвчний тандалт, устгах үндэсний стратеги хэрэгжиж байгаа бол тэдгээр стратеги болон бодлоготой зэрэгцэн мэдээлэл цуглуулна (*Зааварчилгаа 3* харна уу).
- Мал амьтны өвчний мэдээллийг цуглуулах болон тайланг холбогдох мал эмнэлгийн байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулах зохицуулах байгууллагыг баталгаажуулна (*Зааварчилгаа 4* харна уу).

Зааварчилгаа

1. **Байнгын хяналт.** Мал эмнэлгийн ажиллагсдын клиник үйл ажиллагааны мониторинг нь малын өвчлөлийн тохиолдол, эмчилгээ ба тэмцэх арга хэмжээг бүртгэснээр малын өвчний тандалтын тогтолцоонд хувь нэмэр оруулна. Иймэрхүү тоон мэдээлэл нь хэрвээ малын өвчлөл, хорогдол нь малын төрөл зүйлээр, малын өвчин нь хүн амд учруулж байгаа эрсдэлтэй холбоотой бүртгэгдсэн бол хамгийн ач холбогдолтой байдаг. Мониторингийг боломжтой бол засаг захиргааны удирдах байгууллагуудтай хамтарсан байхаар төлөвлөх хэрэгтэй.
2. **Мал эмнэлгийн шинжилгээ судалгаа**. Мал эмнэлгийн хөтөлбөр болон тусламжийн байгууллагууд нь өвчний гаралтыг шинжлэн судлах чадавхитай байх хэрэгтэй. Олон туслалцааны байгууллагын хөтөлбөрийн хүрээнд энэ үүргийг малын өвчний судалгаагаар түүн дотроо задлан шинжилгээ, лабораторийн оношлогоог багтаагаад мэргэшсэн баг юмуу хувь хүмүүст итгэмжлэн хүлээлгэдэг. Хэрвээ иймэрхүү туслалцаа байхгүй бол туслалцааны байгууллага

холбогдох дээжийг цуглуулан улс дотроо эсвэл гадаад орнуудын оношлогооны лабораторит илгээхэд бэлтгэх хэрэгтэй. Энэ бүх үйл ажиллагаа нь улсын мал эмнэлгийн мөрдөн шалгах тогтолцоог хэрэгжүүлэхэд шаардлагатай бөгөөд өвчний албан ёсны оношийг төрийн захиргааны байгууллагаас олон нийтэд мэдээлнэ. Үргэлжилсэн хямралын үед туслалцааны байгууллага мал эмнэлгийн ажиллагсдын чадавхи ба малын өвчний илрүүлэлтийг дэмжих зорилгоор орон нутгийн бага оврын оношлогооны лабораторийг буй болгон ажиллуулах талаар бодолцох хэрэгтэй. Боломжтой бол хүн эмнэлгийн лабораториудтай хамтран ажиллах хэрэгтэй. Өвчний эх үүсвэр болон халдвар тархах замын талаарх мэдээллийг цуглуулахад газар дээр нь ажиллаж байгаа ажилтанд туслах үүднээс асуумжийн жагсаалт бүхий стандарт хүснэгтийг гаргаж өгнө.

3. **Мал амьтны өвчний тандалт судалгаа**. Олон орнуудад мал амьтны зарим өвчнийг хяналтад авах эсвэл устгах үндэсний болон олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Тандалт судалгаа хийх аргачлалыг олон улсын байгууллагууд буюу ДМАЭМБ болон НҮБ ХХААБ-аас гаргасан байдаг. Тухайн нутагт боломжтой бол үргэлжилсэн хямралын үед малын өвчний тандан судалгааны тогтолцоонд дээрх аргачлалыг дагаж мөрдөнө. Хэрвээ тандан судалгааны стандарт үйл явцыг хэрэгжүүлэхэд бэрхшээл үүсэхээр бол үндэсний хэмжээний байгууллагууд (хэрвээ үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа бол) зохицуулах юмуу ДМАЭМБ болон НҮБ ХХААБ-ын тандалт судалгааны аргыг тухайн улс, орон нутгийн нөхцөл байдалдаа тохируулсан аргаар хэрэгжүүлнэ.

4. **Мэдээлэх/тайлагнах**. Үргэлжилсэн хямралын үед бүх байгууллагууд сар бүр тандалтын тайланг засгийн газрын нэгтгэн хариуцдаг хүнд илгээнэ. Гэвч тайлангууд нь бүсийн түвшинд нэгтгэгдэж, тандалтын мэдээллийн санд ороод, орон нутгийн мэдээллийн сан хариуцдаг мал эмнэлгийн ажилтанд хүргэгднэ.

Мал эмнэлгийн үйлчилгээний талаарх жишээ судалгаа

5.1 *Үйл явцын жишээ судалгаа*-Кени улсад нэвтрүүлсэн мал эмнэлгийн *эрхийн бичгийн тухай*

Гамшгийн хөтөлбөрөөр дамжуулан малын эмийг үнэгүйгээр олгоход гардаг нийтлэг асуудлыг шийдвэрлэх хэрэгжүүлэх зорилгоор Кени улсын баруун хойд хэсэгт Олон Улсын Улаан Загалмайн нийгэмлэг (ОУУЗН) болон хувийн хэвшлийг оролцуулан эрхийн бичгийн схемийг туршсан. Эрхийн бичгийг сонгогдсон өрхөд олгох бөгөөд фермерүүд нь нутгийн олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтан болон мал эмнэлгийн туслах ажилтанд төрөл бүрийн эмчилгээ үйлчилгээ туслалцаа авсаны төлөөх төлбөрт өгнө. Эрхийн бичиг нь 1,000 Кени шиллингийн үнэтэй (14 US доллар) бөгөөд дөрвөн нэрийн эмийг хэрэглэхээр тооцож тодорхой хязгаарлалт тогтоосон байна. Нутгийн олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтан болон мал эмнэлгийн туслах ажилтан нь үйлчилгээ үзүүлсэн хувийн хэвшлийн малын эмчээс үйлчилгээ төлбөрийн баримтыг эрхийн бичгээр солилцоно. Ингээд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлсэн хувийн малын эмчид ОУУЗН нь эрхийн бичгийн үнэ болон үйлчилгээний төлбөрийг буцааж олгодог. Энэхүү схемд 3000 гаруй хүнийг хамарсан 500 гаруй өрх айл хамрагджээ. Энэ үйл ажиллагааны давуу тал нь олон нийтэд суурилж үйлчилгээ авах шаардлагатай өрх айлд чиглэсэн, мөн олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтан болон хувийн хэвшлийн малын эмч нарын сүлжээг ашиглан үр дүнтэй мал эмнэлгийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэсэн явдал юм. Олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтан нарыг Кени Улсын мал эмнэлгийн товчооноос гаргасан гарын авлагын дагуу тусгайлсан сургалтанд хамруулсан. Энэхүү үйл ажиллагааны сул тал нь төлөвлөлтийн шатанд маш их хугацаа шаарддаг, учир нь зохион байгуулалт, мониторинг хийх загвар, схемийг нарийвчлан гаргах шаардлагатай байдаг. Мал амьтны төрөл бүрт тохиолддог эрүүл мэндийн янз бүрийн асуудалд шаардлагатай эмийн хүрээнд дөрвөн бүтээгдэхүүн байсныг нэмж өргөжүүлсэн.

Нөгөө талаас энэ нь загвар болон олгох схемийн хооронд зөрчлийг бий болгоно. (эх сурвалж**:** Mutungi, 2005)

5.2 Үйл явцын жишээ судалгаа. Этиоп улсад нэвтрүүлсэн мал эмнэлгийн эрхийн бичгийн тухай

Этиоп Улсын Засгийн газар, НҮБ-ын ХХААБ болон зарим төрийн бус байгуулагууд (ТТБ)-тай хамтран гангийн үеийн хохирлыг даван туулах зорилгоор мал эмнэлгийн эрхийн бичгийг нэвтрүүлсэн. Төслийн хүрээнд алс орших газруудад хувийн хэвшлийн малын эмч үйл ажиллагаанд оролцоогүй бөгөөд харин Улсын мал эмнэлгийн төлөөлөл нь тухайн орон нутгийн хувийн мал эмнэлгийн худалдаа эрхлэгчид, олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтан болон орон нутгийн захиргаатай хамтран хэрэгжүүлсэн. Хамгийн үр дүнтэй загварыг хамтын ажиллагаа болон судалгаа хөгжлийн агентлаг (ACROD) боловсруулан эмчилгээ үйлчилгээний нийт өртөг бүхий эрхийн бичигт ноогдох үнийн дүнгийн 30 хувийг олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтанд олгосон. Ингэснээр олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтан нь хувийн хэвшлийн эмийн аптекээс зохих эмийг заавал худалдан авах үүрэг хүлээсэн. Нэг удаагийн эмчилгээ үйлчилгээг үзүүлсний дараа нутгийн олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтан нь үнийн дүнгийн 70 хувийг эрхийн бичгээр харин үлдсэн 30 хувийг бэлэн мөнгө хэлбэрээр буцаан олгосон. Тэд нар бэлэн мөнгөө хамтын ажиллагаа болон судалгаа хөгжлийн агентлаг (ACROD)-т буцаан өгч дахин нэмж эрхийн бичгийг авч байсан. Хамтын ажиллагаа болон судалгаа хөгжлийн агентлаг (ACROD) нь нутгийн олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтны эмний үнийг нөхөн олгоод дээр нь эмчилгээний үнийн 20 хувьд үндэслэн үйлчилгээний бага хэмжээний төлбөрийг нэмж олгоно. Энэхүү эрхийн бичгийн аргыг хэрэгжүүлснээр дараах сургамж гарсан. Үүнд:

- Янз бүрийн эрхийн бичиг гаргаж байгаа төслүүд нь хүн амын хамгийн нэн ядуу, эмзэг, дийлэнх нь өрх толгойлсон эмэгтэйчүүдэд чиглэгдсэн.
- Төслөөс төсөлд эрхийн бичгийн үнэ цэнэ өөр өөр байсан боловч өндөр үнэтэй эрхийн бичиг тараасан төслүүд нь илүү үр дүнтэй амжилттай хэрэгжсэн. Хэрвээ эрхийн бичгийг үнэ бага бол ашиг хүртэгсэд эмзэг хүлээн авч, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь маш их шүүмжлэлтэй учирч байсан.
- Ямар нэгэн дурын өвчин биш тухайн нутаг дэвсгэрт нийтлэг гардаг өвчнүүдийн эмчилгээнд энэхүү эрхийн бичиг зориулагдсан.

НҮБ-ын ХХААБ нь хөтөлбөрийн хэрэгжилт, хүртээмжтэй байдал, үйлчилгээний чанарын үндсэн индикаторуудыг ашиглан хөтөлбөрийн үнэлгээг хийсэн, мөн түүнчлэн хувийн болон улсын мал эмнэлэгт хөтөлбөрийн үр нөлөө хэр байгааг тодорхойлсон. Үнэлгээгээр хөтөлбөрийн загварчлал, хэрэгжүүлэлт, хяналт шинжилгээ, үнэлгээнд заагдсан энэхүү үйл ажиллагаанд оролцсон нутгийн олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтан, хувийн мал эмнэлгийн эмийн сан болон бусад бүх оролцогч талууд нь эрхийн бичгийн схем нь гамшгийн туршид ашиг хүртэгч нарт шаардлагатай мал эмнэлгийн үйлчилгээг хүргэсэн үр ашигтай, үр дүнтэй арга хэмжээ болсон гэж дүгнэсэн (эх сурвалж**:** Regassa and Tola, 2010).

Мөн АНУ-ын Хүүхдийг ивээх сангаас үнэлгээг хийхэд эрхийн бичгийн тогтолцоог хэрэгжүүлсэн өрхийн мал сүргийн хорогдол үлэмж буурсан, малчдад ашиг тустай хөтөлбөр болсон байна. Тэд мал эмнэлгийн үйлчилгээний эрхийн бичиг олгосон тогтолцоо нь хувьчлагдсан тогтолцоо, бэлчээрийн мал амьтан, тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн нутгийн мал амьтны эрүүл мэндэд эерэгээр нөлөөлсөн, үүнийг бусад газар нутагт хэрэгжүүлбэл үр дүнтэй гэж зөвлөсөн (эх сурвалж**:** Simachew, 2009, quoted Vetwork, 2011).

5.3 Үр нөлөөний жишээ судалгаа: Гамшгийн туршид мал амьтны вакцинжуулалтын хязгаарлалт

Этиоп улсад олон жилийн турш бэлчээр нь ганд нэрвэгдсэн нутагт тус улсын Засгийн газар болон төрийн бус байгууллагуудтай хамтран олон сая тун вакциныг олгох замаар өргөн дархлаажуулалтыг хэрэгжүүлсэн. Энэ үйл ажиллагаа нь тус улсын гурван бүс нутагт тохиолдсон гантай жилүүдэд вакцинд хамрагдсан болон вакцинжуулалтад хамрагдаагүй мал сүргийн өвчний үхлийн тоог харьцуулж, мөн амьжиргаа болсон малыг хэрхэн хамгаалсан нөлөөллийг үнэлсэн. Үхэр, тэмээ, бог малын хувьд ганд нэрвэгдсэн газарт тэдгээр өвчнөөс сэргийлэх өргөн вакцинжуулалт хийгдсэн болон таригдаагүй өрхийн малд тохиолдсон хорогдлын хувь хэмжээнд эрс мэдэгдэхүйц ялгаа гараагүй байна. Вакцинжуулалтын үр нөлөө багатай байдгийг үйл ажиллагаа хэрэгжүүлж буй зарим нэг техникийн асуудлуудтай холбон тайлбарладаг хэдий ч үнэндээ бол хэвийн нөхцөлд буюу гамшгийн өмнө мал амьтныг вакцинжуулах ёстой байдаг. Вакцинжуулалтын үр нөлөө бага байгаа нь ямар нэгэн хямралгүй, хэвийн үед мал сүргийг вакцинжуулах нь зүйтэй гэсэн

зөвлөмжийг баталж байсан. Эдгээр дүгнэлтүүд нь Этиоп дахь гамшгийн зохицуулах байгууллага, хандивлагч нарт гангийн үед хэрэгжүүлсэн мал эмнэлгийн үйлчилгээг дэмжих, хувийн хэвшилтэй хамтран мал эмнэлгийн эрхийн бичгийн схемийг хэрэгжүүлэх дэмжлэг үзүүлэх асуудлыг эргэн харж үзэхэд хүргэсэн. Үнэлгээгээр гамшгийн үед мал амьтныг вакцинжуулах нь амьжиргаанд үр нөлөөтэй гэдгийг бусдад ойлгуулах, вакцинжуулалт нь мал сүргийг бүрэн хамгаалдаг гэсэн ташаа ойлголтоос сэргийлэх, үр ашигтай үйл ажиллагаа болох чухал ач холбогдолтой байсан. (Эх сурвалж: Catley et al., 2009)

5.4 *Үр нөлөөний жишээ судалгаа- Кени улсад гангийн үеийн мал амьтны өргөн хүрээтэй туулгалтын хязгаарлалт*

Хойд Кенид мал сүрэгт өргөн хүрээтэй туулгалт хийх нь гангийн үеийн мал эмнэлгийн нийтлэг хариу арга хэмжээний нэг байдаг. Жишээбэл, 2008-2009 онд 6 улсад 474-аас доошгүй мал аж ахуйн үйл ажиллагаа хэрэгжүүлсний дотор мал амьтны өргөн хүрээтэй туулгалт нь хамгийн нийтлэг үйл ажиллагааны нэг байсан. Ганд нэрвэгдсэн бүс нутагт хэрэгжүүлсэн өргөн хүрээтэй туулгалтын үр нөлөөг сонирхон мэдэхийг хүссэн судлаачид 2012 онд таван дүүргийн 120 өрх айлтай ярилцлага хийжээ. Төрөл бүрийн шимэгчид нь малын эрүүл мэндэд ялгаатай нөлөө үзүүлж байсан нь мал амьтанд шимэгчдээс шалтгаалсан өвчний үр нөлөөг хэмжихэд техникийн хүндрэл байгааг судалгааны загвар харуулсан. Хэдий тийм ч судалгааны тайланд Гангийн үед туулгалтын эмийг олгох нь малын ашиг шимд бага, заримдаа огт нөлөө үзүүлдэггүй гэсэн ойлгомжтой нотолгоо болсон гэж дүгнэжээ. Хэдийгээр борооны улиралд малд туулгалтын эмийг олгосны дараа ашиг шим нь нэмэгдэнэ гэж төсөөлж байсан ч бэлчээрийн чанар ба усны хүрэлцээ зэрэгцэн сайжирч байгаа учраас дан ганц туулгалтын эм хэрэглэсний үр нөлөөгөөр үүссэн өөрчлөлт гэж үзэх боломжгүй байсан. Судалгааны илтгэлд дурдсанаар гангийн үед мал сүрэгт өргөн хүрээтэй туулгалт арга хэмжээний ашиг тусын талаар ойлголтыг илүү сайжруулах, ирээдүйн үр нөлөөний талаар сайтар судлахыг зөвлөсөн байна. (FAO, 2012;4)

5.5 *Үр нөлөөний жишээ судалгаа- Афганистан дахь мал эмнэлгийн үйл ажиллагаа*

Афганистан улсад 5 гаруй жилийн турш үргэлжилсэн зэвсэгт мөргөлдөөний улмаас нийт мал сүргийн 60-80 хувийг алдсан. Олон Улсын Улаан

Загалмайн Хорооноос (ICRC) 2002-2003 онуудад тус улсын төвийн бүсэд орших хоёр сууринд малын эрүүл мэндийг сайжруулах замаар малчдын амьжиргааг дэмжихэд чиглэсэн мал эмнэлгийн үйлчилгээг хэрэгжүүлсэн. Төсөл нь нийт мал сүргийг бүрэн хамруулах замаар паразит өвчний гаралтыг бууруулах явдал байлаа. Энэ төслийг Афганы хоёр малын эмч болон нутгийн олон нийтэд түшиглэсэн мал амьтны эрүүл мэндийн ажилтны багууд хамтран хэрэгжүүлсэн. Мал нэг бүрт 2002 оны намар, 2003 оны хавар, дахин 2003 оны намрын улиралд туузан болон хялгасан хорхойн эсрэг туулгалт хийж мал эмнэлгийн үнэ төлбөргүй үйлчилгээг үзүүлсэн. Нутгийн малчин нэг бүрт мал өвөлждөг зүчээ, малын хашаа зэргийг халдваргүйжүүлэхэд шаардлагатай нунтаг хэлбэрийн эмийн бодисыг олгосон. Эхний эмчилгээнд 57,000, хоёр дахь ээлжинд 154,000 харин гурав дахь ээлжийн эмчилгээнд 248,000 мал хамрагдсан. Эдгээр мал нь 5,300 өрх айлд хамаарагдана. Нийт хонь, ямааны 80 хувь, үхрийн 14 хувь, адууны 6 хувь тус тус эмчилгээнд хамрагджээ.

Эмчилгээний явцад мөн үйлчилгээний цэгүүдэд үйл ажиллагаа дуусаны дараагаар мониторинг хийсэн. Мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлснээр дараах үр дүн гарсан. Үүнд: Эмчилгээнд хамрагдсан өрхийн тоо хоёр дахин өссөн, мал амьтны амьдын дундаж жин нэмэгдэж, хэвтэр бууцанд ариутгал халдваргүйтгэл хийгдэж, малын үржил болон төл малын амьдрах чадвар сайжирсан, төслийн үйл ажиллагаа дуусан ч эдгээр эерэг нөлөө үргэлжилж, малын эмч нар ажлаа үргэлжлүүлэн хийх боломжтой болж малчдын зүгээс мал эмнэлгийн үйлчилгээний төлбөрөө бүрэн төлж малаа эмчлүүлдэг болсон. (эх сурвалж: Oxfam, 2005)

5.6 *Үйл явцын жишээ судалгаа- Монгол улсад малын сэг зэм устгасан нь*

Монгол улсад зун нь ган болсноос өвөл маш хүйтэн болсон. Зун нь хур тунадас ороогүйгээс бэлчээрийн гарц муудаж, мал тарга тэвээрэг аваагүйгээр өвөлтэй золгосон. Цас ихээр унаж хүчтэй шуургатай, бэлчээрт мөсөн бүрхүүл тогтож, хамгийн доод хэмжээ буюу-50 хэм хүртэл хүйтрэхийг "зуд" хэмээн нэрлэдэг. Адуу, үхэр, хонь, ямаа, тэмээ, сарлаг нь тураалд орж улмаар хөлдөж үхнэ. Тус улсад 1999-2000 онд зуд болсон бол 2009-2010 онд хамгийн олон тооны мал хорогдсон зуд дахин болжээ. Монголд 1999-2000 онд нийт 30 сая толгой малаас 11,2 сая толгой мал хорогдсон тухай тус улсын Засгийн газрын илтгэлд дурджээ. Хөдөө орон нутагт нүүдэллэж амьдардаг олон тооны малчид

зудын улмаас малаа алдаж их хэмжээний хохирлыг амссан. Тус улсын болон олон улсын байгууллагууд малын тэжээл болон мал эмнэлгийн үйлчилгээг дэмжсэн арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP) нь 2010 онд гурван аймагт 2,7 сая толгой малын сэг зэмийг устгах булшлахад туслалцаа үзүүлсэн. Энэ нь Монгол улсад 2010 оны зудад нэрвэгдсэн газар нутгийн 20 хувийг эзэлж байна. Тухайн үйлчилгээг хэрэгжүүлсэн 18,605 хүнд ажлын хөлсөнд бэлэн мөнгө олгосон, мөн шатахууны зардлыг нөхөж олгох хэлбэрээр нийтдээ 121,600 ам доллар олгосон ба энэ нь орон нутгийн банкны үйлчилгээ хэвийн явуулахад тус нэмэр болсон. "Ажил хийгээд хөлсийг бэлэн мөнгөөр авах" (Ажил-бэлэн мөнгө) гэсэн загвар нь нийгмийн болон хүйсийн тэгш байдлыг хангахад чиглэж, гамшигт ихээр нэрвэгдсэн хүмүүст сэтгэлзүйн хохирлыг даван туулахад тус дэм болсон. Олон улсын хөгжлийн байгууллагууд тухайлбал Швейцарын олон улсын хөгжлийн агентлаг, Мерси Кор олон улсын байгууллага нь Монгол Улсын засгийн газартай хамтран бусад аймгуудад "ажил хийгээд хөлсийг бэлэн мөнгөөр авах" гэсэн санаачлагыг дэмжин хамтран ажилласан. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (UNDP) нь Монгол Улсын Засгийн газартай хамтран үлдсэн аймгуудад зудын улмаас хорогдсон малын сэг зэмийг устгах хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлсэн. (эх сурвалж: Baker, 2011; UNDP, 2010)

5.7 *Үйл явцын жишээ судлал: Кени улсад тохиолдсон их гангийн үед мал амьтны эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ*

Хойд Кенийн фермерүүдийн бэлчээрийн чадавхийг сайжруулах төслийг Кенийн хойд хэсгийн Маршабит (*Marsabit*) болон Мояли (*Moyale*) дүүрэгт тус тус хэрэгжүүлсэн. Кени улсад болсон 2005-2006 оны их гангийн үеэр Засгийн газрын мэдээгээр тус дүүргийн нийт мал сүргийн 65-85 хувь нь хорогдсон. Бэлчээр болон ус нь мал сүргийн хэрэгцээг нэгэнт хангахаа больж, мал сүрэг өвчинд нэрвэгдэх байдал нэмэгдсэн. Тус улсын Мал эмнэлгийн байгууллага, Африкийн фермерүүд НҮБ ХХААБ-д хүсэлт тавьж тэдний санхүүжилтээр малын эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн төслийг хэрэгжүүлсэн. Төслийн зорилго нь төсөл хэрэгжих нутгийн үржлийн үндсэн эх сүргийн эрүүл мэндийг сайжруулах, паразиттах өвчний гаралт тархалтыг бууруулах, бүтээгдэхүүний гарцыг тогтвортой байлгахад чиглэж байв. Төсөл нь дээрх хоёр дүүргийн нийт малын 20 хувийг хамруулан мал эмнэлгийн эмчилгээ, туулгалт хийх

арга хэмжээг хэрэгжүүлсэн. Африкийн фермерүүд, орон нутгийн төрийн мал эмнэлгийн байгууллагын эмч, малын эрүүл мэндийн үйлчилгээнд туслах ажилтан, нутгийн олон нийтэд түшиглэсэн мал эрүүл мэндийн туслах ажилтан (CAHWs) болон бусад түнш байгуулагуудын төлөөлөл хамтран эмчилгээ, туулгалтын арга хэмжээг хэрэгжүүлэв. Үйлчилгээний үндсэн хэсэг нь шимэгч болон трипаносомыг устгах арга хэмжээ байлаа. Өөр нэг үйлчилгээний багц нь өвчтэй буюу турж эцсэн малд витамин олгож антибиотик, паразитын эсрэг эмчилгээг хослуулан хийж байв. Эмчилгээний төлбөрийн хувьд бэлэн мөнгө эсвэл түүнийг орлуулах төлбөрийн бусад хэлбэрийн талаарх мэдээллийг *Хүснэгт 5.3*–ээс харна уу.

Хүснэгт 5.3 2005-2006 оны гангийн үеэр олгосон эмчилгээний төлбөр

Үнэ	Төлбөрийн орлуулах хэлбэр (бартерийн төлбөр)	Бэлэн мөнгө
Үхэр/илжиг	20 үхэр тутамд нэг ямаа	50 KSh (US 0.70 доллар)
Хонь/ямаа	100 бог мал тутамд нэг ямаа	50 KSh (US 0.70 доллар)
Тэмээ	10 тэмээ тутамд нэг ямаа	50 KSh (US 0.70 доллар)

KSh = Кени улсын мөнгөн тэмдэгт шиллинг

Төслийн шууд ашиг хүртэгсдийн тоо Маршабит (*Marsabit*) дүүрэгт 2,107, Мояли (*Moyale*) дүүрэгт 1,560 гэр бүлийн ойролцоогоор нийт 27,600 хүн байсан. Төслийн үр нөлөөгөөр мал амьтны эрүүл мэндийн байдал сайжирч, малаас авах бүтээгдхүүн тухайлбал сүү, махны гарц нэмэгдэж, өвчнөөс сэргийлэх дархлаа бий болж, дараагийн ургацын улирлын өмнө гангийн нөлөө буурсан зэрэг эерэг үр дүн гарсан.

Урт хугацаандаа мал амьтны нөхөн үржилд эерэг нөлөө үзүүлж эцсийн үр дүнд хүнсний аюулгүй болон баталгаат байдал сайжрах үр нөлөөтэй юм. Дунд хугацаандаа ашиг хүртэгчдэд мал эмнэлгийн үйлчилгээний талаар эерэг ойлголт үзүүлж, мал сүрэг нь улам тэсвэртэй болж, гангийн нөлөөг тэсвэрлэх чадвар сайжирч, шуурхай хэрэгцээнд зориулагдсан сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэх зэргээр эерэг нөлөө үзүүлсэн. (эх сурвалж: Farm Africa, 2006)

Хавсралт 5.1: Мал эмнэлгийн үйлчилгээ *үзүүлэх жагсаалт болон үнэлгээний аргууд*

Шалгуур үзүүлэлт	Хэрэглээний аргууд
1. Хүрэлцээ. Хамгийн ойр байгаа сургагдсан мал эмнэлгийн ажилтан нар болон малчдын хоорондох бодит зай	**Оролцооны зураглал:** • Өгөгдсөн газрын талаар энгийн дэлгэрэнгүй биш зураглал гаргах • Мал амьтан болон малчдын байрлал • Хамгийн ойрын мал эмнэлгийн үйлчилгээнүүд/хэлбэрүүд • Зай (км, цаг болон бусад)
2. Хэрэгцээ Тухайн газар нутагт тохиромжтой байдал нягтрал болон бодит материаллаг үйлчилгээний хэмжээ	**Оролцооны зураглал:** дээрхийн адил **Шууд ажиглалт:** • Мал эмнэлгийн ажилчид • Мал эмнэлгийн барилга, байгууламж **Чөлөөт ярилцлага:** • Мал эмнэлгийн үйлчилгээний одоо байгаа материаллаг баазыг үнэлэх • Эм, эмнэлгийн хэрэгсэлийн чанар • Нийгмийн давхарга, жендер г.м суурилсан саад байгаа эсэх
3. Бололцоо Үйлчилгээнд төлбөр төлөх хүмүүсийн чадвар	**Зохион байгуулалттай ярилцлага:** **Ажиглалт:** • Мал эмнэлгийн үйлчилгээний байгууламж • Мал амьтны зах зээл • Үнийн жагсаалт Хэвийн үед хэрэглэдэг үйлчилгээний болон малын үнийг судлаж тогтоох, Хэрвээ, малын худалдаа хэвийн үйл ажиллагаа одоо болтол явагдаж байгаа буюу малын тоог бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бол мал эмнэлгийн үйлчилгээний зардал ба малын үнийг харьцуулан үзэх нь хүмүүс мал эмнэлгийн үйлчилгээний төлбөр төлөх боломжтой байхад тустай.
4. Хүлээн зөвшөөрөгдөх Нийгэм-соёлын хэм хэмжээ, хүйсийн асуудал, хэлний чадавхи болон бусад асуудлуудтай холбоотой мал эмнэлгийн ажилчдын соёл болон улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал	**Чөлөөт ярилцлага:** эрэгтэй, эмэгтэй малчид

5. Чанар Энэ хэсэгт мал эмнэлгийн ажиллагсадыг багтаана. Сургалтын түвшин Мэргэжлийн мэдлэг, ур чадвар Харилцааны ур чадвар Мал эмнэлгийн эм, вакцин болон тоног төхөөрөмжийн чанар, хүрэлцээ	**Чөлөөт ярилцлага** • Мал эмнэлгийн ажиллагсад **Шууд ажиглалт** Мал эмнэлгийн барилга байгууламж • Боловсролын гэрчилгээ • Үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл буюу , ур чадварыг сорих
Бүх шалгуур үзүүлэлт	**Матриксын үнэлгээ:** Тухайн нутагт үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа мал эмнэлгийн ажилтнуудын ажлыг дээрх таван үзүүлэлтээр оноо өгч дүгнэх ба энэ нь үзүүлэлт тус бүрийн давуу сул талыг харуулна.

Хавсралт 5.2: Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн жишээнүүд

	Үйл явцын шалгуур үзүүлэлт *(болж байгаа үйл ажиллагааг хэмжих)*	**Үр нөлөөний шалгуур үзүүлэлт *(болж байгаа үйл ажиллагааны үр дүнг хэмжих)***
Тогтолцоог төлөвлөх нь	• оролцооны судалгаа болон задлан шинжилгээ • олон нийт/олон нийтийн төлөөллийг оролцуулсан уулзалтын тоо • хувийн хэвшлийн болон хэрэгжүүлэгч байгууллагуудын мал эмнэлгийн ажиллагсдын хооронд болсон уулзалтуудын тоо	• Хүйсийн болон хөрөнгийн хувьд ялгаатай бүлгийн иргэдэд малын эрүүл мэндийн ямар бэрхшээл байгааг тодорхойлох • Малын эрүүл мэндийг сайжруулах боломжид дүн шинжилгээ хийх **Мал эмнэлгийн эрхийн бичиг** • мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгч хувийн хэвшил болон олон нийт (малчид) нь эрхийн бичгийн үнийг харилцан хүлээн зөвшөөрсөн байх • Ашиг хүртэгчдийг сонгох шалгуур үзүүлэлтийг харилцан хүлээн зөвшөөрсөн байх • Малын эм нийлүүлэгч хувийн болон улсын байгууллагад холбогдсон мал эмнэлгийн туслах ажилтны тоо • Нөхөн олгох тогтолцоог хувийн хэвшлийн ажиллагсад болон ханган нийлүүлэгч нар хүлээн зөвшөөрсөн байх • орон нутгийн түвшинд хяналт хийх тогтолцоог хүлээн зөвшөөрсөн байх **Хэрэгжүүлэгч байгууллагаас хүргүүлсэн эм** • хэрэгжүүлэгч байгууллагуудаас хүргүүлсэн мал эмнэлгийн туслах ажилтны тоо
Түргэвчилсэн мал эмнэлгийн сургалт/ давтан сургалт	• Сургагдсан мал эмнэлгийн ажилтны тоо, хүйс • Сургалтын үеэр хөндөгдсөн мал амьтны эрүүл мэндийн асуудлын тоо болон хэлбэр • Сургалтын зардал	• Сургалтанд хамрагдсан малын эмч нарын мэдлэг, ур чадвар сайжирсан байна.

Мал эмнэлгийн үйл ажиллагаа	**Мал эмнэлгийн эрхийн бичиг** • эрхийн бичиг тараагдсан газар нутаг, хамрагдсан өрх, хэлбэр, эрхийн бичгийн тоо • өрх тутамд байх малын төрөл, тоо, өвчин бүрт ноогдох эмчилгээний тоо • буцаан олгогдсон эрхийн бичгийн тоо, үнэ **Тусламжаар хүргэсэн эм:** • мал эмнэлгийн ажилтан нарт олгосон эмийн тоо, хэлбэр • мал эмнэлгийн ажилтан нарт олгосон эмийн үнэ	• мал амьтны өвчлөл, хорогдлын тоо төрөл тус бүрээр, өвчлөлийн суурь үзүүлэлтэд үндэслэх • мал эмнэлгийн ажилтан нарын газар зүйн байршил • үйлчилгээ авсан малчин өрх, малын харьцаа • сургалт хийсний дараа үйл ажиллагаа явуулж байгаа ажиллагсадын тоо, харьцаа • өвчний голомтыг устгах талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан • мал амьтны эрүүл мэнд сайжирсантай холбоотойгоор мал амьтны гаралтай хоолны тэжээллэг чанар (хүйсийн болон хөрөнгийн хувьд ялгаатай бүлгийн хувьд) • малын эрүүл мэнд сайжирсантай холбоотой өрхийн орлого • бодлогын нөлөөлөл
Мал эмнэлгийн үйл ажиллагаа (үргэлжлэл)	• нэг сард мал эмнэлгийн нэг ажилтны өвчтэй мал эмчилсэн малын төрөл тоо тус бүрээр • мал эмнэлгийн ажилтан нарт хүргүүлсэн хяналт үнэлгээний загварын тоо • мал эмнэлгийн ажилтан нараас мэдээлсэн өвчний гаралтын тоо	

Эх сурвалж: LEGS-н үнэлгээний арга хэрэгслийг доорх холбоосоор орж LEGS веб хуудаснаас үзэх боломжтой: <http://www.livestock-emergency.net/resources/general-resources-legs-specific/>.

Ашигласан хэвлэл ба цаашид уншиж судлах материал

Admassu, B., Nega, S., Haile, T., Abera, B., Hussein A., Catley, A. (2005) "Impact assessment of a community-based animal health project in Dollo Ado and Dollo Bay districts, southern Ethiopia", *Tropical Animal Health and Production* 37(1): 33–48 <http://dx.doi.org/10.1023/B:TROP.0000047932.70025.44>.

Aklilu, Y. (2003) "The impact of relief aid on community-based animal health programmes: the Kenyan experience", in K. Sones and A. Catley (eds), *Primary Animal Health Care in the 21st Century: Shaping the Rules, Policies and Institutions*, proceedings of an international conference, 15–18 October 2002, Mombasa, Kenya, African Union/Interafrican Bureau for Animal Resources, Nairobi, <http://www.eldis.org/go/home&id=13563&type=Document#. U38tmbkU_Vh> [accessed 17 May 2014].

Baker, J. (2011) *5-Year Evaluation of the Central Emergency Response Fund, Country Study: Mongolia*, United Nations Office for the Coordination of Humanitarian Affairs (OCHA), Ulaan bataar. Available from: <http://www.alnap. org/resource/11664> [accessed 24 May 2014].

Burton, R. (2006) *Humane Destruction of Stock*, PrimeFact 310, New South Wales Department of Primary Industries, Orange, New South Wales. Available from: <http://www.livestock-emergency.net/resources/veterinary-services/> [accessed 23 May 2014].

Catley, A., Leyland, T. and Blakeway, S. (eds) (2002) *Community-based Animal Healthcare: A Practical Guide to Improving Primary Veterinary Services*, ITDG Publishing, London.

Catley, A., Leyland, T., Mariner, J.C., Akabwai, D.M.O., Admassu, B., Asfaw, W., Bekele, G., and Hassan, H.Sh., (2004) "Para-veterinary professionals and the development of quality, self-sustaining community-based services", *Revue scientifique et technique de l"office international des* йpizooties 23(1): 225–252 <http://sites.tufts.edu/capeipst/files/2011/03/Catley-et-al-OIE-Apr-04.pdf> [accessed 18 May 2014].

Catley, A. (2005) *Participatory Epidemiology: A Guide for Trainers*, African Union/Interafrican Bureau for Animal Resources, Nairobi, <http://www.

participatoryepidemiology.info/PE%20Guide%20electronic%20copy.pdf> [accessed 18 May 2014].

Catley, A., Abebe, D., Admassu, B., Bekele, G., Abera, B., Eshete, G., Rufael, T. and Haile, T. (2009) "Impact of drought-related livestock vaccination in pastoralist areas of Ethiopia", *Disasters* 33(4): 665–685 <http://dx.doi.org/10.1111 /j.1467-7717.2009.01103.x>.

FAO (Food and Agriculture Organization of the United Nations) (2012) *An Assessment of the Impact of Emergency De-worming Activities"*, FAO report OSRO/ KEN/104/EC – FAOR/LOA NO. 008/2012, FAO, Nairobi.

FAO (2015) *Technical Interventions for Livestock Emergencies: The How-to-do-it Guide,* Animal Production and Health Division Guidelines Series, FAO, Rome.

Farm Africa (2006) *Immediate Support to Agro-Pastoral Communities as a Drought Mitigation Response: Marsabit and Moyale Districts*, Final Report to FAO, OSRO/RAF/608/NET (CERF2), Farm Africa, Nairobi.

Heath, S.E., Kenyon, S.J., and Zepeda Sein, C.A. (1999) "Emergency management of disasters involving livestock in developing countries", Revue scientifique et technique de l"office international des йpizooties 18(1): 256–271.

Iles, K. (2002) "Participative training approaches and methods" and "How to design and implement training courses", in A. Catley, T. Leyland, and S. Blakeway (eds), Community-based Animal Healthcare: A Practical Guide to Improving Primary Veterinary Services, ITDG Publishing, Rugby.

Leyland, T. (1996) "The case for a community-based approach, with reference to Southern Sudan", in The World Without Rinderpest, pp. 109–120, FAO Animal Health and Production Paper 129, FAO, Rome, <http://www.fao.org/ docrep/003/w3246e/W3246E09.htm> [accessed 18 May 2014].

Leyland, T., Lotira, R., Abebe, D., Bekele, G. and Catley, A. (2014) Community-based Animal Health Care in the Horn of Africa: An Evaluation for the US Office for Foreign Disaster Assistance, Feinstein International Center, Tufts University, Addis Ababa and Vetwork UK, Great Holland.

Linnabary, R.D., New, J.C. and Casper, J. (1993) "Environmental disasters and veterinarians" response", Journal of the American Veterinary Medical Association 202(7): 1091–1093

Mariner, J.C. (2002) "Community-based animal health workers and disease surveillance", in A. Catley, T. Leyland, and S. Blakeway (eds), Community-based Animal Healthcare: A Practical Guide to Improving Primary Veterinary Services, ITDG Publishing, Rugby.

Mutungi, P.M. (2005) External Evaluation of the ICRC Veterinary Vouchers System for Emergency Intervention in Turkana and West Pokot Districts, International Committee of the Red Cross (ICRC), Nairobi.

Oxfam (2005) Livestock Programming in Emergencies Guidelines, unpublished draft, Oxfam, Oxford.

Regassa, G. and Tola, T. (2010) Livestock Emergency Responses: The Case of Treatment Voucher Schemes in Ethiopia, FAO, Addis Ababa, <http://www. disasterriskreduction.net/fileadmin/user_upload/drought/docs/Livestock%20 Treatment%20Voucher%20Experience%20in%20Ethiopia.pdf> [accessed 20 May 2014].

Schreuder, B.E.C., Moll, H.A.J., Noorman, N., Halimi, M., Kroese, A.H., and Wassink, G. (1995) "A benefit-cost analysis of veterinary interventions in Afghanistan based on a livestock mortality study", Preventive Veterinary Medicine 26: 303–314 <http:// dx.doi.org/10.1016/0167-5877(95)00542-0>.

Simachew, K. (2009) Veterinary Voucher Schemes: An Emergency Livestock Health Intervention – Case Studies from Somali Regional State, Ethiopia, Save the Children USA, Addis Ababa.

UNDP (United Nations Development Programme) (2010) 2010 Dzud Early Recovery Programme, UNDP Project Document, United Nations Development Programme, Ulaanbataar, <http://www.undp.org/content/dam/undp/ documents/projects/MNG/00059396/Dzud%20early%20recovery_ProDoc. pdf> [accessed 18 May 2014].

Vetwork (2011) The Use of Cash Transfers in Livestock Emergencies and their Incorporation into the Livestock Emergency Guidelines and Standards (LEGS), Animal Production and Health Working Paper No. 1, FAO, Rome. Available from: <http://www.livestock-emergency.net/resources/general-resources-legs- specific/> [accessed 18 May 2014].

Санамж

1. Leyland, T., Lotira, R., Abebe, D., Bekele, G. and Catley, A. (2014) Африкийн Зүүн Хойт эргийн нутгийн иргэдэд түшиглэсэн малын эрүүл мэндийн үйлчилгээ: Үнэлгээ, АНУ-ын Гамшигт Нэрвэгдсэн Гадаад Орнуудад Тусламж Үзүүлэх Газар, Приштейн ОУ-ын төв, Тифтэ их сургууль, Аддис Абаба болон Ветворк, Англи, Голланд

2. Хоёрдогч мэдээллийн эх сурвалж, жишээ нь: засгийн газрын өвчний тандалтын тайлангууд, өөрийн орны судалгааны хүрээлэнгүүдийн өвчний судалгаа, мөн хэвлэгдсэн материалууд.

3. Хувийн эрх ашгийг харгалзах тохиолдолд тухайн үйлчилгээг авахын тулд төлбөр төлсөн этгээд л үүнээс үр дүнг нь хүртэнэ (жишээ малын бэртэл гэмтлийг эмчлэх гэх мэт). Харин нийтийн эрх ашгийн үүднээс авч үзвэл хувь хүн тухайн үйлчилгээг хэрэглэх нь бусад хүмүүс ижил төрлийн үйлчилгээг авах эрхийг хөндөхгүй, тухайн үйлчилгээг авахаар төлбөр төлсөн этгээд нь бусад хүнийг тухайн үйлчилгээ авахад саад болохгүй. (жишээ нь маханд хяналт шалгалт хийх гэх мэт).

БҮЛЭГ 6

Тэжээл хангамжийн техникийн стандарт

Тэжээл хангамжийн техникийн стандарт

Танилцуулга

Олон төрлийн гамшгийн үед мал амьтны тэжээлийн хүрэлцээ хомсддог. Гантай үед бороо хур тунадас хомс байснаас тэжээлийн хангамж багасдаг ба ердийн үед ч байдаг тэжээлийн хангамжийн эх үүсвэр хүрэлцэхгүй болдог. Хүчтэй үерийн дараа байгалийн нөөц устаж үгүй болдог. Энэхүү бүлэгт онцгой байдлын хариу арга хэмжээний үед тэжээлээр хангахын ач холбогдол, тэжээлээр хангах хувилбар болон түүнийг хэрэгжүүлэх оновчтой арга хэрэгслийн хамтаар танилцуулах болно. Энд дурдагдах стандарт, үндсэн үйл ажиллагаа, зааварчилгааг хувилбар тус бүрт дагаж мөрдөнө. Энэ бүлгийн төгсгөлд жишээ судалгааг харж болно. Дараа нь анхдагч үнэлгээ, мониторинг хийхэд ашиглах шалгах хуудсыг дагалдуулсан. Ашигласан хэвлэлийн жагсаалтыг бүлгийн төгсгөлд нь хавсаргав.

LEGS –*н амьжиргааг дэмжих зорилттой холбогдох нь*

Онцгой нөхцлийн үед тэжээлээр хангах асуудал нь LEGS-н амьжиргааг дэмжих хоёр ба гурав дахь зорилтуудтай шууд хамааралтай байдаг. Үүнд:

- гамшигт нэрвэгдсэн хүн амын хөрөнгө мал сүргийг хамгаалах
- гамшигт нэрвэгдсэн хүн амын гол хөрөнгө мал аж ахуйг сэргээх.

Хэрэв мал амьтны тэжээлийн хангамжийг баталгаажуулан тэднийг хамгаалан амьд үлдээж чадах юм бол тодорхой хугацааны дараа сүргийн нөхөн сэргэлт явагдаж чадна. Тэжээлээр хангах үйл ажиллагаа нь LEGS-н амьжиргааны нэг дэх зорилтыг биелүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Үүнд: *гамшигт нэрвэгдсэн хүмүүс өөрт байгаа мал аж ахуйн нөөцөө ашиглаж түүнээс нэн даруй ашиг хүртэх,* мал амьтныг амьд үлдээснээр айл өрх хүнсээр шууд хангагдах боломж бүрдэнэ.

Гамшгийн хариу арга хэмжээний үед тэжээлийн хангамжийг баталгаажуулах ач холбогдол

Мал амьтан нь түүнд шаардлагатай тэжээл, ус богино хугацаанд тасалдахад маш амархан сульдаж доройтдог учраас байнга тэжээл, усаар хангаж байх шаардлагатай. Гамшигт нэрвэгдсэн газар нутгийн мал амьтныг аврах зорилготой гамшгийн үеийн ямар ч хариу арга хэмжээний

үед тэжээлийн нөөцөөр тасралтгүй хангаж, хүрэлцээтэй хангамж, нөөцтэй байх ёстой.

Гангийн үед мал амьтан өвчнөөр бус ус, тэжээлийн хомсдолд орж олон тоогоор хорогддог учраас дээрх арга хэмжээ нь чухал ач холбогдолтой (Catley et al., 2014). Yерийн гамшгийн үед мал амьтан тэжээлийн хомсдолд орсноор үхэж хорогддог бол харин мөргөлдөөний үед аюултай байдлаас болж мал амьтан бэлчээрлүүлэхийг хориглодог. Гамшгийн үед (хар салхи, газар хөдлөлт, үер гэх мэт) тэжээлийн нөөц сүйрдэг учраас мал амьтны амьдрах чадавхийг тодорхой хугацаанд сайжруулах үүднээс тэжээлийн нөөцийг дахин бүрдүүлэх ба агуулах байр савыг дахин барьж сэргээх хэрэгцээ шаардлага бий болдог.

Гамшгийн үед мал аж ахуй эрхлэгчид мал амьтны тэжээлээр хангах асуудлыг нэн тэргүүнд шаардлагатай гэж үздэг. Малын эзэд хүнсний тусламжаар авсан хүнсээрээ малаа тэжээх эсвэл түүгээр малын тэжээл авах зэрэг тохиолдлууд гардаг. Тухайлбал, маш олон дүрвэгсэд Дарфураас Зүүн Чадад байрлах хуаранд өөрсдийн малаа авч очиж чадсан хэдий ч мал амьтанд оногдох ус, бэлчээр маш хомс байсан юм. Тэдний тодорхой хэсэг нь малаа амьд байлгахын тулд өөрсдөд оногдсон хүнсээр малаа тэжээж байв. (SPANA Хэвлэлийн тойм, 2007).

Мал амьтныг тэжээлээр хангах нь мал бүхий иргэдэд нэн тэргүүний асуудал гэдгийг харгалзан нөөц боломжоо (жишээ нь, тээвэр) ашиглан хүн болон малын хүнс,тэжээлийн хангамжийн туслалцааг үзүүлэх нь илүү үр дүнтэй байдаг. Тэжээлээр хангах үйл ажиллагаа нь энэ номны *Танилцуулга* хэсэгт дурьдсан мал амьтны тавлаг байдлыг хангах "таван эрх чөлөө" нийтлэг зарчмын *"өлсөх цангахаас ангид байдлгах*- эрүүл мэнд, биеийн хөгжлийг хэвийн хадгалахад шаардлагатай ус, тэжээлээр хангагдах*"* шаардлагыг хангахад хувь нэмэр оруулж байгаа юм.

Гамшгийн үед (ялангуяа ган гачгийн үед) малаа амьд байлгах зорилгоор гаргаж буй холбогдох зардлыг тооцохдоо онцгой нөхцөл цуцлагдасны дараагаар сүргийн нөхөн эргэлтийг бий болгох мал худалдаж авах зэргээр тодорхой хувилбарт чиглүүлсэн тооцоог гаргах хэрэгтэй. Кени улсын хойд хэсэг, Этиопын зүүн хэсэгт нүүдлийн мал аж ахуйтай газар нутагт хийсэн судалгааны дүнд, ган гачгийн дараа цөм сүрэг бий болгох дахин малжуулах төслийн зардал гамшгийн үед малыг тэжээлээр хангах замаар амьд байлгаж, даван туулах зардлаас даруй гурваас зургаа дахин өндөр өртөг зарцуулж байгааг харуулсан байна. (Catley, 2007).Зардал үр ашгийн тооцоо нь төлөвлөж байгаа тэжээлийн

холбогдох зардлыг бусад хувилбаруудтай харьцуулан үзэхийг хэлнэ. Тэжээлээр хангах ямар ч үйл ажиллагааны зардал тэжээл тээвэрлэж , хүргэх байршлын зай буюу тэжээлийн үнээс хамаардаг.

Тэжээлээр хангах хувилбарууд

Онцгой нөхцөлд олгож байгаа тэжээл нь гамшгийн нөхцлийн улмаас тэжээлийн нөөц хүрэлцэхгүй, буурах үед түүнийг нөхөж орлуулах замаар олгох юм. Онцгой байдлын үед тэжээлээр хангах арга хэмжээнд хэн нэг нь цуглуулсан, худалдаж авсан тэжээлийг ашиглах, эсвэл тэжээлийн хомсдол үүсэх үед хэрэглэхээр байнга бүрдүүлдэг уламжлалт нөөцөөс хэрэглэх бөгөөд үүнийг орон нутгийн иргэд өөрсдийн санаачлагаар хэрэгжүүлж болно. Заримдаа ийм төрлийн арга хэмжээ нь мал амьтны хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа мал бүхий иргэдэд хүрдэггүй, нээлттэй байж чаддаггүй. Иймээс мал амьтныг тэжээлээр хангах үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа байгууллагууд бүдүүн тэжээл, хүчит тэжээл, олон төрлийн эрдэс витамин агуулсан бэлдмэлүүд зэргийг олгох замаар тусламж хүргэх боломжтой.

Мал амьтны амьжиргаанд гүйцэтгэж байгаа үүргээс шалтгаалан гамшгийн үед тэжээлээр хангах стратеги өөр өөр байдаг. Тухайлбал нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг газар бүх малыг тэжээхээс илүүтэй зөвхөн үржлийн цөм сүргээ тэжээхэд анхаардаг. Харин цөөн тооны мал малладаг газар нутагт бүх айл өрхийг тэжээлээр хангах хөтөлбөрт хамруулахыг зорьдог. Гамшгийн үед тэжээлийн нөөц их хэмжээгээр сүйрсэн тохиолдолд эдгээр нөөцийг дахин бүрдүүлэх, агуулах савыг шинэчлэн барих зэрэг асуудлыг тэжээлийн хөтөлбөрт тусгах шаардлагатай байдаг.

Онцгой байдлын үед нийлүүлж байгаа тэжээл нь аюулгүй байдал, ложистик, хол газар тээвэрлэх гэвэл олон асуудлыг бүхэлд нь шийдвэрлэх шаардлага үүсдэг. Ийм төрлийн хөтөлбөр нь зардал өндөртэй байдаг. Иймд тэжээлээр хангах үйл ажиллагаа нь гамшгийн туршид тогтвортой байх, үе шаттай хэрэгжүүлэх тодорхой стратегитай байх хэрэгтэй. Хивэгч малыг тодорхой хугацаанд тэжээх шаардлагатай их хэмжээний тэжээл хэрэгцээтэй ба энэхүү том эзэлхүүн бүхий тэжээлийг тухайн нутгийн гадна талаас тээвэрлэж авчрах шаардлага үүсдэг. Тэжээлээр хангах хөтөлбөрт олон тооны малыг хамруулах бол нэрвэгдсэн бүс нутгийн экологийн тэнцвэртэй байдлыг хангахын тулд малын тоо толгойг бууруулах хөтөлбөрийг хамт хэрэгжүүлэх эсвэл хамгийн ашиг шим өгөх мал амьтныг хамруулах нь чухал байдаг.

Энэхүү бүлэг нь гамшгийн үед мал амьтныг газар дээр нь тэжээх; тэжээлийн баазад тэжээх гэсэн тэжээлээр хангах хоёр үндсэн аргыг тусгасан болно.

Хайрцаг 6.1 **Отор нүүдэл зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх**

Нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг ихэнх газарт отор нүүдэл зохион байгуулах нь өргөн уудам нутагт тэжээл усыг хүртэх гол стратеги болдог. Тухайлбал ган гачгийн үед тусгайлсан нөөц нутаг буюу шинэ газар нутгийг ашигладаг. Зарим оронд (тухайлбал, Камерун зэрэг баруун Африкийн улсуудын тодорхой хэсэгт) эдгээр нүүлгэн шилжүүлэлтийн эрхүүд нь бэлчээрийн эрхзүйн хүрээний хууль, журманд тусгагдсан байдаг ба малын хөдөлгөөний чиглэлийн хил хязгаарыг тогтоон өгсөн байдаг. Хөдөлгөөний чиглэл, хязгаар тогтоох нь Испани, Австрали зэрэг өндөр хөгжилтэй орнуудад ч байдаг байна. (IIED and SOSSahel UK, 2010;Cripps,2013).Отор нүүдэл зохион байгуулах стратегиуд нь онцгой байдлын үед малыг амьд гаргах, мал бүхий иргэдийн малыг нь цаашид ургэлжлүүлэн ашиглах боломж бий болгоход чухал ач холбогдолтой.

Хэдийгээр дээрх үйл ажиллагааны үр нөлөөний талаарх нотолгоо байхгүй, тухайн орон нутгийн отор нүүдэл хийх стратеги хязгаарлагдмал хэдий ч гадны байгууллагууд хөндлөнгөөс оролцож болох юм. Тухайлбал мал бүхий иргэдэд хил дамнан малаа бэлчээрлүүлэх зөвшөөрөл олгох эсвэл гангийн үед ашиглахаар нөөцөлсөн бэлчээрийг ашиглах талаар орон нутгийн эрх бүхий байгууллага, засгийн газартай зөвлөлдөх асуудлыг дэмжих гэх мэт (*Нийтлэг стандарт 7: Бодлого ба Нөлөөлөл* хэсгийг харна уу) Мөн түүнчлэн зам дагуу ус, тэжээлээр хангах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх бодит дэмжлэг үзүүлж болно. Энэхүү чиглэлээр явуулж байгаа ямар ч үйл ажиллагааны үед мал бүхий иргэдийн хувийн аюулгүй байдалд үүсэж болох эрсдэл, хүлээн авч байгаа газар иргэдтэй харилцах харилцаа, өвчний эрсдлийг нэмэгдүүлэх, эмзэг бүлгийнхний малын гаралтай бүтээгдэхүүнийг авч ашиглах боломж буурах, мөн хол газар мал туух шаардлагатайгаас ажлын байраа алдаж болох зэрэг амьжиргаатай холбоотой сөрөг үр дагавар гарч болзошгүйг анхаарах хэрэгтэй.

Уламжлалт отор нүүдэл хийх үйл ажиллагааг цаашид сайтар судалж, сайн дадал болгох хэрэгтэй. Дүрвэгсэд болон тэдгээрийн мал амьтанд шаардлагатай хэрэгцээ, бусад асуудлын талаар *Бүлэг8 Малын хашаа хороо ба байршуулалт* (*Онцгой байдлын үед Мал амьтанд чиглэгдсэн үйл ажиллагаанд баримтлах Заавар болон Стандартууд*, 2014) –ээс харна уу.

Хувилбар 1: Онцгой нөхцлийн үед газар дээр нь тэжээлээр хангах

Гамшгийн үед тэжээлийг мал амьтан байрлаж байгаа газар хүргэж ирдэг. Тэжээлийг тээвэрлэн авчирч хувь хүмүүс болон өрхүүдэд тарааж өгөх ба тэд өөрсдөө ирж аваад гэрлүүгээ авч явдаг. Бэлэн мөнгөний нөхцөлт тэтгэлэг болон хөнгөлөлтийн эрхийн бичиг ашиглах нь онцгой байдлын үед газар дээр нь тэжээлийн хангамж үзүүлэхэд үр дүнтэй механизм болох бөгөөд зах зээл хэвийн байгаа орон нутагт хэрэглэх шаардлагатай байдаг (*Бүлэг 3, Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох* хэсгээс харна уу).

Хувилбар 2: Онцгой байдлын үед тэжээлийн баазад тэжээх

Тэжээлийг тухайн мал амьтны байршиж байгаа газар хүргэж өгөх боломжгүй тохиолдолд тэжээлийн бааз бий болгон мал бүхий иргэдийг малаа авчирч тэжээх боломжийг олгодог. Тухайлбал, мөргөлдөөн үүссэн тэжээлийн эх үүсвэр багатай газар тэжээлийн баазыг байгуулж болох хэдий ч тэжээлийг тээвэрлэж авчрах нь өөрсдөө малаа тууж авчирснаас илүү эрсдэл багатай учраас аюулгүй газар байгуулах нь илүү оновчтой. Хүнсний болон "ажил-бэлэн мөнгө" хөтөлбөрүүдтэй тэжээлийн баазыг харуул хамгаалалт, удирдлага зохион байгуулалтын хувьд уялдуулан хэрэгжүүлэх боломжтой байдаг. Тэжээлийн баазын хоёр хэлбэрийг ашиглаж болно. Үүнд:

- *«Оруулан гаргах» тэжээлийн бааз.* Энэ тохиолдолд малчин өрхөөс авах малын тоо төрлийг тохирдог (тухайлбал нэг өрхөөс хоёр саалийн үнээ гэх мэтээр) малаа баазын хүлээн авсан тэжээлийн жортой уялдуулан өдөр өдрөөр хүлээн авдаг, Малыг тэжээлээр тасалдуулахгүй байх асуудлыг баталгаажуулдаг.
- *«Суурин тэжээх» тэжээлийн бааз.* Мал бүхий иргэдээс хүлээн авах малын тоо толгойг тохироод тэдгээрийг хүлээн авч онцгой байдлын үе дуустал тэжээх хэлбэр юм.

Тэжээлийн баазын давуу тал нь зохион байгуулагчдын зүгээс тэжээлийн ашиглалтад хяналт тавих, зорилтот нийцэх сүргийн төрлийг сонгож авах боломжтой болдог. Тээвэр ложистик болон зохион байгуулалттай холбогдох зардлууд нь газар дээр нь тэжээл хүргэж өгөхөөс хамаагүй өндөр байдаг.

Эдгээр хоёр хувилбарын давуу болон сул талуудыг нэгтгэн *Хүснэгт 6.1*-т үзүүлэв.

Хүснэгт 6.1 Тэжээл хангамжийн хувилбарын давуу ба сул талууд

Хувилбар	Давуу талууд	Сул талууд
1. Газар дээр нь тэжээлээр хангах, тусламжийн тэжээл тараах	• Эрсдлийн үед малыг амьд байлгах яаралтай хариу арга хэмжээ • Онцгой нөхцлийн бэлэн байдлын нэг хэсэг болгон тэжээлийн нөөцийг ашиглах боломж • Орон нутагт эх үүсвэр бэлэн байгаа тохиолдолд орон нутгийн эдийн засагт тохиромжтой ашиг бүрдүүлэх боломж • Гол үржлийн сүргийг сонгох • Гамшгийн үед алдагдсан тэжээлийн нөөцийг дахин нөхөх боломж	• Эрчимтэй болон өндөр зардал • Онцгой нөхцлийн бүхий л хугацаанд бэлэн байх хэрэгцээ • Удаан хугацаанд тогтворгүй • Хадгалалт, тээвэрлэлтэд аюулгүй нөхцөл шаардагддаг • Гаднаас өвчин, хортон шавьж, өвчин дамжуулагч дамжин орж ирэх эрсдэлтэй • Гаднаас тэжээл авах эх үүсвэр бий болгох нь орон нутгийн зах зээлд сөргөөр нөлөөлөх боломж бий болох • Хяналт шалгалт, зохион байгуулалт, удирдлага шаардагддаг
2. Онцгой байдлын үед тэжээлийн баазад тэжээх	• Дээр дурдсантай ижил бөгөөд: • Мал сүрэг болон хүний аюулгүй байдлыг нэмэгдүүлдэг • Тухайн орон нутгийн нөөц дуусан үед аль нэг газраас тэжээлийн бааз руу өвс тээвэрлэж авчрах боломжтой • Мал тэжээж арчлах ба харж хамгаалж байгаа хүмүүст орлогын эх үүсвэр бий болох боломж бүрдүүлэх	• Дээр дурьдсантай ижил бөгөөд: • Хашаа саравч/хаалт барих, ус, тэжээл олгох зэрэгт тохиромжтой газар шаардагддаг • Тусламжийн тэжээл тараахыг бодвол зохион байгуулалт, удирдлага менежмент илүү шаардагддаг ба мөн цалин, хүнс тэжээл гэх зэрэг зардал шаарддаг • Эд хөрөнгөнд хяналт тавих болон харж хамгаалах хөдөлмөр зохион байгуулалт шаардагддаг • Мал сүргийг тэжээлийн бааз хүртэл зөөвөрлөхөд эрүүл байлгах хэрэгтэй

Үйл ажиллагааг хэрэгжүүлэх зохистой хугацаа

Онцгой байдлын үеийн тэжээлийн хангамж нь үр дүнтэй хэдий ч маш өндөр зардалтай. Иймээс ерөнхийдөө богино хугацааны арга хэмжээ бөгөөд хор уршгийг шуурхай арилгах буюу гэнэтийн ба удаан явцтай гамшгийн үеийн онцгой байдлын шатласан арга хэмжээний үед мал хөрөнгийг удаан хугацаанд хамгаалж үр ашигтай байлгах боломж гаргах, байгалийн нөөц сэргэх хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээ юм.Үүнтэй холбоотойгоор, онцгой байдлын арга хэмжээний дараа хэдий хугацаанд тэжээлийн нөөц хуримтлагдах боломжтой байгаа зэрэг тооцооллуудыг гамшгийн үеийн хариу арга хэмжээ авах төлөвлөлтөд тусган улирлын байдлыг анхаарах хэрэгтэй байдаг (*Хүснэгт 6.2*).

Хүснэгт 6.2 Тэжээл хангамжийн үйл ажиллагааг явуулах зохистой хугацаа

Хувилбарууд	Гэнэтийн гамшиг			Удаан явцтай гамшиг			
	Гэнэтийн хор хохирол	Шуурхай нөхөн сэргээлт	Нөхөн сэргээлт	Сэрэмжлүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээлт
1. Онцгой үеийн тэжээлийг байран дээр нь хангах	→			→			
2. Онцгой үеийн тэжээлийг бааз дээр хангах	→				→		

Бусад бүлгүүдтэй холбогдох нь

Тэжээлийн хангамжийн үйл ажиллагааг баталгаажуулах үүднээс нь онцгой байдлын үед мал аж ахуйд чиглэгдсэн бусад арга хэмжээтэй хавсарган хэрэгжүүлэх тухайлбал мал амьтны тоо толгойг бууруулах хэрэгтэй болдог юм. (*Бүлэг 4, Мал амьтны тоо толгойг бууруулах;* мөн *Бүлэг 4-ийн төгсгөлд байгаа Үйл явцын жишээ судалгааг 4.7* харна уу) Зарим нэг малыг аж ахуйгаас тусгаарлаж тэжээл усаар хангаснаар тэдний тэсвэрлэн үлдэх чадварыг нэмэгдүүлэхээс гадна бусад үлдсэн сүргийн асуудалд ч анхаарал хандуулах шаардлагатай. Санаачлагч болон байгууллагуудын хоорондын уялдаа холбоог хангаснаар нэг үйл ажиллагаа нь нөгөө арга хэмжээг сүйтгэхээс сэргийлдэг. (*Бүлэг 2, Нийтлэг стандартууд ба мал*

*амьтанд хамааралтай нийтлэг асуудлууд, Нийтлэг стандарт 8: Уялдаа холбоо хар*на уу*).* Тэжээл хангамжийн үйл ажиллагаанууд нь гамшигт өртсөн өрхүүдийг малжуулах үйл ажиллагаанд нэмэлт дэмжлэг болох юм (*Бүлэг 9, Малжуулах*).

Нийтлэг болон харгалзан үзэх бусад асуудлууд

Хүйсийн ба нийгмийн тэнцвэрт байдал

Онцгой байдлын үед авч явуулж байгаа мал аж ахуйтай холбоотой үйл ажиллагааг төлөвлөхдөө мал маллах, арчлахтай холбогдсон хүйсийн тусгайлсан үүргүүдийг анхааралдаа авах хэрэгтэй. (энэхүү Бүлгийн төгсгөл хэсэгт байгаа үйл явцын *Жишээ судалгаа 6.1-г харах*). Онцгой байдлын өмнөх болон дараах гэсэн хоёр хугацааг хамруулан тус тусад нь хөдөлмөр ажлыг хүйсийн байдлаар ялгаварлан хуваарилах шаардлагатай. Зарим нийгэмд мал аж ахуйн менежменттэй холбогдох бүх үүргийг эмэгтэйчүүд гүйцэтгэдэг ба тэд эдгээр үйл ажиллагаанаас олсон ашгаас байнга тэнцвэртэй хүртээж чаддаггүй юм. Саалийн малаа саах ба хосолмол ашигаар өсгөж буй мал, малын хашаа хороо цэвэрлэх зэрэг нь тухайн өрхийн эмэгтэй гишүүдийн хувьд тэнцвэргүй олгогдсон үүрэг байдаг. Нэмж дурдахад тэжээл цуглуулах, хуваарилах олгох зэрэг нь ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдэд дарамттай үүрэг бүхий ажил болж оногддог. Ийм шалтгааны улмаас тэжээлийн нөөцийн хангамжийг баталгаажуулах зорилт бүхий бүрэлдэхүүн хэсэгтэй хөтөлбөрүүд нь эмэгтэйчүүдийн сонирхолыг бууруулахгүй байх, эсвэл эмэгтэйчүүдийн өдөр тутмын ажлын ачаалал болон гамшигт өртсөн хүн амын эмзэг бүлэгт сөргөөр нөлөөлөхгүй байх чиглэлээр тусгайлан анхаарсан үйл ажиллагааг явуулах ёстой. Жирийн үед эмэгтэйчүүд ихэнхдээ малын тэжээл худалдан авах үүрэг гүйцэтгэдэг хэдий ч энэ нь гамшгийн үед илүү хүндрэлтэй болдог. Зэвсэгт мөргөлдөөний үед тэжээлээ авах ердийн зам аюултай болдог. Эмэгтэйчүүд хол газар явган алхах эсвэл шошны үр зэрэг чанар муутай тэжээл олж цуглуулах зэрэгт илүү цаг зарцуулах үед тэдний ажлын ачаалал улам нэмэгддэг.

Онцгой байдлын үед тэжээл нийлүүлэхэд эмэгтэйчүүд суурин газарлуу тэжээл зөөхөд нэмэлт туслах хүч хэрэгцээтэй болдог. Түүнчлэн илжиг гэх мэтийн ачлагын мал маш чухал хэрэгцээтэй болно.

ХДХВ/ДОХ

ДОХ/ ХДХВ-ийн өвчлөлтэй гэр бүлд ажиллах хүчний боломж маш бага байдаг. Эдгээр тохиолдолд тэжээлээр хангах үйл ажиллагаанд нэрвэгдсэн айл өрхүүд дэмжлэг үзүүлж чаддаггүй учир нэмэлт хөдөлмөр хүчний зардал тооцох хэрэгцээ болдог. Аль эсвэл энэхүү гарын авлагын мал аж ахуйд холбогдох бусад үйл ажиллагаанд дурдсанчлан нэрвэгдсэн иргэдийн мал амьтныг хамгаалснаар малын гаралтай бүтээгдэхүүн хэрэглэх боломжийг олгож хоол хүнсээр найдвартай хангана.

Хамгаалалт

Онцгой нөхцөл байдал нь хууль бус үйл явдал, иргэний дайны улмаас үүсэж болох хэдий ч мөргөлдөөний дараа шууд бий болдоггүй. Малыг тэжээлээр хангах үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсний үр дүн нь малд ашигтай байхаас гадна өөрийнх нь үндсэн үнэлгээг нөхөх буюу нэмэгдүүлж байх ёстой. Олон тооны малыг цуглуулсан мал тэжээх цэг ялангуяа харуул хамгаалалт муутай газар хулгай дээрмийн анхаарлыг их татдаг. Мал бүхий ядуу иргэдийн хувьд малаа хулгай дээрмээс хамгаалах хэрэгсэл тоног төхөөрөмж муутай байж болох юм. Тийм учраас малыг яаж байнгын хяналт хамгаалалттай байх асуудлыг баталгаажуулах талаар онцгой анхааран хөтөлбөрт тусгах нь зүйтэй юм. Иймэрхүү хамгаалалтыг тодорхой шалтгааны улмаас баталгаажуулах боломжгүй болсон тохиолдолд мал амьтны тоог толгойг бууруулах зэрэг бусад оновчтой арга хэмжээ авах нь тохиромжтой. Олон тооны дүрвэгсэд өөрийн мал амьтны хамт шилжин суурьшсан эсвэл хуаранд ирсэн үед тухайн малын бэлчээр тэдний суурингийн гадна талд илүү хүрэлцээтэй байх нь тэднийг халдлагад өртөх эсвэл хувийн аюулгүй байдалд эрсдэл учруулдаг тул тухайн хуаран эсвэл суурьшлийн бүсэд мал амьтны тэжээлээр хангах нь илүү зохимжтой байдаг.

Байгаль орчин

Тэжээлийн хангамжийн чиглэлээр төлөвлөж санаачилж буй үйл ажиллагаанууд нь байгаль орчны нөлөөг тусгах ёстой. Малын тэжээлийг хангах асуудал их болон бага хэмжээгээр экосистемд нөлөөлдөг бөгөөд эрчимжсэн мал аж ахуйн тэжээлийн хаягдал бүтээгдэхүүн бүр ч илүү хэмжээгээр экосистемд нөлөөлж байна. Гамшигт экосистем хүчтэй өртсөн тохиолдолд үүний нөлөөлөл нь богино хугацаанд байдлыг нилээн дордуулахаас гадна хэвийн байдалд орох хугацааг хойшлуулахад хүргэх магадлалтай. Ийм нөхцөлд хөтөлбөрөөс тэжээлийн хангамжийг сайжруулах замаар хурдан хугацаанд малын тоо толгойг нэмэгдүүлж малчдын амьжиргааг дэмжих асуудлыг эргэн харах шаардлага гардаг. Түүнээс гадна байгаль орчны нөлөөлөлд анхаарлаа хандуулж байгаа тохиолдолд тэжээл тээвэрлэх байгаль орчны зардлыг тооцоолох ёстой байдаг. Тэжээлээр хангах үйл ажиллагаанууд нь мөн малын усан хангамжийн хүрэлцээг харгалзан үзэх ёстой. (*Бүлэг 7, Усан хангамж* хэсгээс харна уу).

Эмзэг бүлгийг сонгох

Гамшгийн үед авч байгаа бүхий л арга хэмжээ нь хамгийн хэрэгцээтэй байгаа хэсэгт чиглэгдэх ёстой байдаг бөгөөд энэ нь төвөгтэй асуудал хэвээр байна. Учир нь тэжээлийн нөөц гэдэг бол бараа (тэжээлийн хангамж хомсдолд орсон үед илүү ашиглах), бөгөөд тээвэр ложистик асуудлыг зориулсан газарт нь хүрч чадахаар зохицуулах ёстой. Ийм хяналт хийгдэж чаддаггүй газарт тухайн нутгийн хамгийн хөрөнгө чинээтэй, хамгийн хүч чадалтай хүмүүс өөрсдийнхөө малдаа өгөх тэжээлийг нөөцөөс маш их хэмжээгээр авч завших, эсвэл тэжээлийг өөр тийш зөөвөрлөх, ашиг олох зорилгоор малгүй иргэд тэжээлийг бусдад зарах зэрэг сөрөг үзэгдлүүд гардаг.

Үе дамжин мал маллаж ирсэн туршлагатай малчин өрхийн хувьд ч гамшигт өртснөөр нөхөн сэргэх хугацааны үеэр мал амьтан тэдний хувьд цаашид амьжиргаагаа залгуулах гол эх үүсвэр байж

чадахаа больдог. Ийм учраас үйл ажиллагааны хөтөлбөрүүд нь цаашид амьжиргаагаа авч явах боломжтой эсэхийг харгалзан үзэх хэрэгтэй. Иймд айл өрхүүдтэй зөвлөлдөж хэлэлцэх замаар хэрэгжүүлэх нь хамгийн сайн бөгөөд ялангуяа хямралын үеийг даван туулах хүртэл хөрөнгө болсон мал амьтныг хамгаалж авч үлдэхийн тулд тэжээлийн нөөц бэлтгэх үйл ажиллагааг явуулах нь зүйтэй. Хэрэв гамшгийн дараа малчин айл өрхүүд өөрсдийн мал сүргийг тараахаас өөр аргагүй байдалд хүрвэл онцгой байдлын үед мал тэжээсэн арга хэмжээнээс гарах үр ашиг тун бага байна.

Менежментийн чадавхи

Олон жилийн нүүдлийн аж ахуйтай газар нутагт ч гэсэн гамшгийн улмаас менежментийн чадавхи доройтдог. Өрхийн гишүүд шилжин нүүх ба нас барах, эрүүл мэнд муудаж, хөдөлмөрийн болон менежментийн чадвараа алдаж болно. Хүчит болон олон төрөлт тэжээлийн бэлдмэлийг олгох гэх зэрэг урьд өмнө нь мэддэггүй байсан тэжээл тараах мэтээр шинэ менежментийн хувилбарыг нэвтрүүлэх нь нэрмээс болж өгдөг. Тэжээлээр хангах хөтөлбөр нь дээрх хүчин зүйлс арга хэмжээний үр дүнд саад болох, зохион байгуулалтын болон ажиллах хүчний чадавхид (сургалтын хөтөлбөр ба гаднын ажиллах хүчнийг дэмжих) бодит дэмжлэг болж чадах эсэхийг анхааран үзэх хэрэгтэй.

Орон нутгийн чадавхи ба уламжлалт арга хэмжээний стратеги

Гамшгийн эсрэг хариу арга хэмжээнд нэрвэгдсэн хүн амын өөрсдийн уламжлалт мэдлэг, чадавхийг ашиглах хэрэгтэй бөгөөд ялангуяа тэдний гамшгийг урьдчилан сэрэмжлүүлэх механизмийг ашиглана. Малын арчилгаа маллагааны талаарх тэдний мэдлэг, ур чадвар нь тэжээлийн хөтөлбөрт хамруулах мал амьтдыг зөв сонгох, үржлийн цөм сүргийг хамгаалж авч үлдэх боломжийг бий болгодог. Орон нутгийн иргэд тэжээлийн олдоц, хамгийн тохиромжтой тэжээлийг худалдан авах, хадгалах талаар өргөн мэдлэгтэй байдаг. Мөн өөрсдийнхөө олон

нийтийн сүлжээг ашиглан хил залгаа нутгийнхаа бэлчээрийг ашиглах тал дээр зөвшилцөх боломжийг бүрдүүлдэг. Дэлхийн олон улс орнуудад хүмүүс гаднын тусламж ирэхээс өмнө гамшгийн нөхцлөөс үүссэн хор хохиролтой нүүр тулах шаардлагатай болдог. Гаднын тусламжийн үүрэг тодорхой байгаа үед холбогдох байгууллагууд нь орон нутгийн иргэдийн өөрсдөө бий болгосон энэхүү стратегиудыг хайхралгүй орхиж болохгүй, учир нь тэд гамшигт нэрвэгдсэн хүн амыг нөхөн сэргээхэд зориулсан гол зорилтуудыг маш сайн тодорхойлсон байдаг. Тухайлбал, нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг газарт хүндрэл үүссэн нөхцөлд ашиглах нөөц бүс нутагтай байдаг (*Хайрцаг 6.1*-ийг харах). Гамшгийг даван туулах уламжлалт стратегиудын чиглэлээр үр дүн гарсан жишээнүүдийг дор дурьдсан *Үндсэн үйл ажиллагаа ба Зааварчилгаа* хэсэгт тодорхой бичсэн байна.

Хортон шавьж, өвчин болон халдвар тараагч

Гамшгийн голомт бүхий бүс нутгийн гадна талаас тэжээл тээвэрлэн хүргэх нь эрсдэлтэй бөгөөд тэдгээрээр дамжин өвчин, хортон шавьж орж ирэх магадлалтай байдаг. Ургамал эрүүл ахуйн арга хэмжээг төгс хэрэгжүүлэх менежмент нь эдгээр эрсдлийг багасгахад маш чухал ач холбогдолтой. Тиймээс тэжээлийг хүлээн авах үедээ чанарын хяналтыг хөндлөнгийн лабораторийн шинжилгээтэй хослуулан хийж тэжээллэг чанар (энерги ууараг), хуурай бодис, хүчилд уусдаггүй үнс, бусад нэмэлт бодис, мөөгөнцөр, хорт бодис зэргийг тогтоох нь ердийн практикт нэвтэрсэн юм.

Орон нутгийн зах зээлд учрах саад бэрхшээл

Тэжээлийн нөөцийг гамшгийн бүс нутагт тээвэрлэн хүргэх нь ложистикийн хувьд хамгийн “амархан» хувилбар байж болох юм. Гэхдээ орон нутгийн эх үүсвэр, боломжийг судалж энэ нь хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд дээрх аргыг хэрэглэх хэрэгтэй. Дээр дурьдсан өвчний эрсдэл дээр нэмж дурьдахад орон нутгийн фермер, худалдаачдын хангаж чадах тэжээлийн нөөцийг хаа нэг газраас авчруулж болохгүй. Орон нутгийн

эх үүсвэрийг ашиглах нь үйл ажиллагааны ашиг, хүртээмжийг гамшигт өртсөн илүү олон газар хүргэхэд чухал ач холбогдолтой. Орон нутгийн зах зээлээс худалдан авалт хийх нь хүмүүсийн тэжээл худалдан авах эргэлзээг тайлахаас гадна орон нутгийн зах зээлд үзүүлэх нөлөөг (мөн үнийн хөөрөгдөл гарч болзошгүй байдлаас зайлсхийх) хязгаарладаг. Үнийн хөөрөгдөл гарч болзошгүй эрсдлийг үнэлэх, хянахын тулд анхдагч үнэлгээ хийх, олон нийттэй зөвшилцөх нь хамгийн чухал байдаг. Зах зээлийн үнэлгээ нь тусламжийн тэжээл түгээхэд эрхийн бичиг хэрэглэх үед чухал байдаг.

Хуаран

Хүмүүс өөрсдийн мал сүрэгтэйгээ хуаран руу ирсэн үед бэлчээр, тэжээлтэй холбоотой тусгайлсан төлөвлөлтийн асуудлууд (түүнчлэн ус зэрэг бусад асуудлууд; *Бүлэг 7, Усан хангамж*) хөндөгдөн гардаг. Хуаранд хүмүүс хүлээн авах нь үндсэн оршин суугчдын ядуу, нөөц хомстой хэсэгт нийгэм, эдийн засаг, байгаль орчин уламжлалт зан харилцаанд их хэмжээний дарамт учруулдаг. Нийтийн эзэмшлийн тэжээл, бэлчээр усны нөөцийг хэрэглэхэд өрсөлдөөн, зөрчил үүсдэг. Хуаран байгуулах газраа сонгож, төлөвлөлт хийхдээ эдгээр нөөцийг бүхэлд нь нарийвчлан судлах хэрэгтэй бөгөөд шилжин ирсэн болон үндсэн оршин суугчдын аль алиных нь хэрэгцээг хангаж чадахаар байна. Дүрвэгсэд өөрсдийн малтайгаа ирж байгаа тохиолдолд газраа сонгохдоо хуарангийн дотор мал байршуулах шаардлагатайг харгалзаж үзэх ёстой. (*Бүлэг 8, Мал амьтны хашаа хороо ба байршуулалт*).

Стандартууд

Гамшгийн үеийн тэжээлтэй холбогдох үйл ажиллагааг санаачлан эхлүүлэхээс өмнө *Бүдүүвч 6.1*-т тусгасны дагуу олон янзын хувилбаруудын хэрэгжих боломж, хамгийн оновчтой хувилбарыг сонгон авахад анхаарах хэрэгтэй.

Бүдүүвч 6.1 Тэжээлийн хувилбаруудад ашиглах шийдвэрийн модны загвар

Тайлбар:
"Үйлдэл хийхгүй" гэсэн үр дүн (онцгойлон үзэх асуудал гараагүй бол)"гэдэг нь газар дээр нь ямар нэг арга хэмжээ авч болохгүй гэсэн үг яг биш гэхдээ гол асуултуудад "тийм" гэсэн хариулах боломжтой байх үүднээс цаашид шаардлагатай сургалт буюу чадавхийг сайжруулах асуудлууд шаардлагатай байж болох юм.

Тэжээлийн стандарт 1: Үнэлгээ ба төлөвлөлт

Тэжээлийн нөөц бүрдүүлэх хувилбаруудыг орон нутгийн хэрэгцээ, туршлага боломжид тулгуурлан үнэлнэ.

Үндсэн үйл ажиллагаа

- Тэжээл нийлүүлэх үйл ажиллагааг зөвхөн ашиг хүртэгчид гамшгийн дараа малаа авч үлдэж цааш нь үргэлжлүүлэн маллах боломжтой гэсэн тохиолдолд л хэрэгжүүлж эхлүүлэх (*Зааварчилгаа 1* харна уу).
- Энэхүү бүлэгт туссан хувилбарууд суурилсан төлөвлөгөөг оролцогч талуудын бүрэн оролцоотой, гамшгийг даван туулах нутгийн уламжлалт стратеги, орон нутгийн эх үүсвэр, болон орон нутгийн зах зээлд учирч болзошгүй саад бэрхшээлүүдийг харгалзан боловсруулсныг баталгаажуулах (*Зааварчилгаа 2* харна уу).
- Тэжээлд хамрагдах мал амьтныг сонгохдоо малын биеийн нөхцөл байдал, тэдгээрийн гамшгийг тэсвэрлэн гарах магадлал, цаашид эдгээр малын хөрөнгийг нөхөн сэргээхэд тэдний чухал ач холбогдолтой байдал зэргийг харгалзах (*Зааварчилгаа 3* харна уу).
- Үнэлгээ болон төлөвлөлтийн явцад тэжээл ба бэлчээрийн хүртээмжийн талаарх бодлого, ялангуяа сөргөөр нөлөөлж болзошгүй бодлогын асуудлуудад нарийвчлан анхаарах (*Зааварчилгаа 4* харна уу).

Зааварчилгаа

1. **Малаа авч үлдэж цаашид бойжуулж чадах ашиг хүртэгчид**
   Зарим өрхүүд гамшгийн уршгаар удаан хугацааны эрсдэлд учрах магадлалтай байдаг. Учир нь тэд олон тооны малаа алддаг эсвэл амь насаа алдах, шилжин суурьших болон өвчний улмаас цаашид малаа маллах чадалгүй болох зэргээр тухайн өрхийн хөдөлмөрлөх чадварт сөргөөр нөлөөлдөг юм. Богино хугацаанд малаа амьд байлгаж авч үлдэхэд дэмжлэг үзүүлэх гэж буй үйл ажиллагааг хэрэгжүүлэхээсээ өмнө хамгийн тохиромжтой ашиг хүртэгчийг сонгох орон нутгийн шийдвэр гаргах арга барилыг ашиглан ашиг хүртэгч өрхүүд малаа авч үлдэж цаашид удаан хугацаанд үргэлжлүүлэн авч явж чадна гэдэгт оролцогч байгууллагууд бат итгэлтэй байх ёстой.

2. **Гамшгийг даван туулах уламжлалт стратеги болон орон нутгийн зах зээлд суурилсан оролцооны аргаар төлөвлөх**. Өмнө дурьдсанчлан, маш олон тооны малчид тэжээлийн хомсдлыг даван туулах талаар уламжлалт стратегитай байдаг. Эдгээрийг нарийвчлан харгалзан үзэж, дээрх арга барилыг улам бэхжүүлэх эсвэл боломжтой газар шинээр бий болгосноор орон нутгийнхан өөрсдөө илүү эзэмших болон тэдний оролцоог идэвхитэй болгоход чухал ач холбогдолтой байдаг *(Үйл явцын жишээ судалгаа 6.3*-г харах). Даван туулах механизм байгаа боловч ашиглагдахгүй байгаа газарт үйл ажиллагааг хэрэгжүүлэхээсээ өмнө түүний шалтгааныг нарийвчлан судалж дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Орон нутгийн зах зээл нь тэжээл худалдан авах тээвэрлэхэд сөргөөр нөлөөлөхгүй байх хэрэгтэй бөгөөд энэхүү зах зээлийг мөн дэмжин ажиллах хэрэгтэй. Гамшиг тохиолдохоос өмнө бэлэн байдлын нэг хэсэг болгон орон нутгийн малын тэжээл үйлдвэрлэлийн эх үүсвэрт үнэлгээ хийх ёстой (*Бүлэг 2, Нийтлэг стандартууд ба мал аж ахуйд хамааралтай нийтлэг асуудлууд , Нийтлэг стандарт 2: Бэлэн байдал*). Зарим тохиолдолд орон нутгийн тэжээлийн нөөцийг гамшгийн бэлэн байдлын нэг хэсэг болгон бүрдүүлсэн байдаг бөгөөд энэ нь гамшгийн үед орон нутагт хамгийн чухал тэжээлийн эх үүсвэр болдог (*Үйл явцын жишээ, судлал 6.3*). *Хавсралт 6.1*–д үнэлгээ болон төлөвлөлтийн явцыг үнэлэх шалгах хуудсыг хавсаргав.

3. **Мал амьтан сонгох**. Зарим төрлийн мал бусад малыг бодвол тэжээл усны хомсдолыг даван туулах чадвар, тэдгээрээр хангаснаар нөхөн сэргээхдээ хурдан байдаг. Зарим нь магадгүй ямар нэгэн тусламж дэмжлэггүйгээр тэсэн үлдэх чадвартай, зарим нь тусламж өгөх шаардлагатай, эсвэл тусламж аваад ч амьдрах чадваргүй болсон мал амьтан байдаг. Гамшгийн үед тэжээлээр хангах үйл ажиллагаа хэрэгжүүлэх нөөц ихэнх тохиолдолд хязгаарлагдмал байдаг. Ийм учраас сүргийн бүрэлдэхүүнд байгаа бүх малын хэрэгцээг хангах боломжгүй байдаг тул зөвхөн илүү үнэ цэнэтэй малыг сонгох хэрэгтэй. Бодит байдалд энэ нь чанартай үржлийн мал, ажлын мал эсвэл бага тэжээл зарцуулдаг ч зах зээлд боломжийн үнэд хүрдэг мал амьтан юм. Иймээс мал амьтныг орон нутгийн иргэдийн оролцоотойгоор сонгож, үйл ажиллагааг төлөвлөх хэрэгтэй бөгөөд ингэснээр тэжээлийн хомсдолд янз бүрээр өртсөн эмзэг бүлгийнхний хэрэгцээг хангаж чадахуйц

малын төрөл, зүйлийг хамруулж чадна.

4. **Бодлогын төлөв байдал**. Анхдагч үнэлгээнд тэжээлийн хангамжтай холбоотой бодлогын асуудлуудад дүн шинжилгээ хийнэ. Үүнд тэжээлийн сүлжээ, худалдан авалтад гарч болох саад бэрхшээлийг үнэлнэ. (тухайлбал, худалдан авалтыг зохицуулах дотоод журам). Энэхүү дүн шинжилгээгээр хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргахаас гадна бусад ухуулах, нөлөөлөл үзүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлно (*Бүлэг 2, Нийтлэг стандарт 7: Бодлого ба нөлөөлөл*).

Тэжээлийн стандарт 2: Тэжээх түвшин

Хөтөлбөрийн дэмжлэг бүхий тэжээлийн хангамжийн түвшин нь хамгийн оновчтой үр ашигтай үр дүн бий болох боломжийг бий болгох ёстой ба хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа дуусаны дараа тогтвортой байх ёстой

Үндсэн үйл ажиллагаа

- Тэжээлээр хангах хөтөлбөрт тэжээх норм ба түүнээс авах ашиг шимийн харьцааг нарийвчлан гаргана (*Зааварчилгаа 1, 2* харна уу).
- Тэжээлээр хангах хөтөлбөрийн хүрээнд малыг тэжээх түвшинг тогтоох нь хөтөлбөрийн хүртээмж, тогтвортой байдал чухал байдаг (*Зааварчилгаа 2* харна уу).
- Гамшгийн улмаас малын тэжээлийн нөөцөө алдаж мал сүрэгт шууд аюул нүүрлэсэн бол тэжээлээр хангах хөтөлбөрийн нэг хэсэг болгон агуулахуудыг нөхөн дүүргэх арга хэмжээ авах (*Зааварчилгаа 3* харна уу).

Зааварчилгаа

1. **Шим тэжээлийн хангамжийн зарчим.** Хүрэлцэхүйц шим тэжээлтэй байх зарчим нь малын тэжээлийн ямар нэгэн туйлын стандарт хэмжээг заахгүй гэдгийг ойлгох нь чухал байдаг. Гангийн нөхцөлд малыг хоёр сар амьд байлгах шим тэжээлийн хангамж нь хот орчмын саалийн үнээний өдөрт 25 литр сүү гаргах хүрэлцэхүйц шимт тэжээлтэй адил бус нь ойлгомжтой. Энэ мэдээллээ сонгосон үйл ажиллагаандаа мэдээлэх, тээвэр ложистик бусад зохион байгуулалтын ажилдаа ашиглана.

2. **Тэжээлийн төсөвлөлт.** Хөтөлбөрийн хүрээнд шаардагдах тэжээлийн хэмжээг төлөвлөхөд тэжээлийн хөтөлбөрт хамрагдаж байгаа малын хэрэглэх тэжээл ба тэжээлийн цэгрүү түгээх тэжээлийн баланс хэрэгтэй байдаг. Үүнд дараах тооцоолол шаардагдана.
   - *зааварчилгаа 1*-т тусгагдсан хэрэгцээт зорилтод үндэслэн, тэжээхээр сонгосон төрөл бүрийн малын өдөр тутмын тэжээлийн хэрэгцээ
   - тэжээлийн хөтөлбөрийн төсвийн хүрээнд авч болох боломжит тэжээлийн эх үүсвэрийн хэмжээ
   - тэжээлийн эх үүсвэрийн байршлын зай
   - санал болгож буй хөтөлбөрийн хугацаа
   - бодитоор хамрагдаж болох малын тоо.

Хэрэв хамрагдаж буй малын тоонд хэрэгцээтэй нөөц хангалтгүй байгаа бол хөтөлбөрийн ерөнхий зорилтод дахин үнэлгээ хийх шаардлага гарч болох ба жишээ нь, малын жин нэмэгдүүлэхээс илүүтэй зөвхөн ихэнх малын амьдын жинг тогтвортой байлгах нэмэлт санхүүжилт шаардлагатай болдог.

3. **Тэжээлийн агуулахыг нөхөн дүүргэх.** Гэнэтийн гамшгийн маш олон тохиолдолд тэжээлийн агуулах эвдэрч сүйрдэг. Хэрэв эдгээр хохирол мал сүрэгт шууд аюул учруулахаар бол үндсэн хөрөнгө болох мал амьтныг хамгаалах үүднээс гамшгийн үеийн тэжээлийн хөтөлбөрт эдгээр хангамжийг нөхөн сэргээх асуудлыг (шаардлагатай агуулахын байрыг дахин засварлахтай хамтатган) хамруулах ёстой.

Тэжээлийн стандарт 3: Тэжээлийн аюулгүй байдал

Гамшигт нэрвэгдсэн нутагт тэжээл оруулахдаа эрүүл ахуй, ургамал эрүүл ахуй, тэжээлийн аюулгүй байдалтай холбоотой бусад асуудалд анхаарлаа хандуулах ёстой.

Үндсэн үйл ажиллагаа

- Орон нутгийн малын нэрвэгдэх байдал болон тэжээлийн эх үүсвэрт хортон шавьж, өвчин, өвчин дамжуулагч байгаа эсэхэд хангалттай үнэлгээ хийх (*Зааварчилгаа 1*).

- Халдварын боломжит эх үүсвэр байгаа эсэхэд анхааран гамшигт өртсөн нутагт орж ирж байгаа тэжээлийн материалд сорилт хийж шалгах (*Зааварчилгаа 2*).
- Тээврийн хэрэгсэл болон агуулахын тоног төхөөрөмж цэвэрхэн бөгөөд эрүүл ахуйн шаардлага хангаж байгааг баталгаажуулсан хангалттай арга хэмжээг хэрэгжүүлэх, шаардлага хангасан агуулах байхгүй газар эрхийн бичгийн схемийг нэвтрүүлэх (*Зааварчилгаа 3* болон *4*).

Зааварчилгаа

1. **Эрсдлийн үнэлгээ**. Гамшгийн үед нарийвчилсан эрсдлийн үнэлгээг бүрэн хийж дуусгахад хүндрэлтэй байдаг. Гэхдээ тэжээл импортлох үйл ажиллагаа дуусахаас өмнө нөхөн сэргээлтийн шатанд гарч болзошгүй хамгийн өндөр эрсдлийг тогтоох нь чухал юм. Нэрвэгдсэн нутагт өмнө нь байсан асуудал ирээдүйд гарч болох эрсдлийн суурь болдог учраас өндөр эрсдэлтэй бүс нутагт тэжээл импортлох асуудалд илүү анхаарал хандуулж тэжээлийг хянан шалгах арга, менежмент байгаа, энэ нь хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг нягтална.
2. **Импортын тэжээлийн чанарын хяналт.** Гамшигт өртсөн нутагт оруулж ирж байгаа тэжээлийн материалд түгээхээсээ өмнө тогтмол чанарын хяналт хийнэ. Үүнд мэдрэхүйн эрхтний үзлэг хийх буюу нүдээрээ эсвэл микроскопийн шинжилгээгээр хортон шавьж, өвчний халдварлалтыг шалгах хэрэгтэй. Тодорхой тэжээлийн төрлүүдэд хортой бодисыг тогтоох лабораторийн шинжилгээнд хамруулах хэрэгтэй. Тухайлбал, эрдэнэ шиш, үр тариа будааны хувьд удаан хугацаанд тээвэрлэх, эсвэл хадгалдаг учраас афлотоксин гэх мэт мөөгөнцөрийн хорт бодисуудаар бохирдсон байх эрсдэлтэй байна.
3. **Ариун цэвэр, эрүүл ахуйн журам.** Ерөнхийдөө боломжгүй ч байсан тэжээл хүлээн авах цэг дээр чанарын хяналтын цогц журмыг хэрэгжүүлэх ёстой. Үүний үр дүнд, ялангуяа чанарын хяналтын дараа тэжээлийг нэрвэгдсэн газарт тэжээл оруулж гардан ажиллаж байгаа болон тээвэрлэж байгаа ажилчид эрсдлийг бууруулах журмыг мөрдөн ажиллах ёстой. Үүнд:
   - агуулах зоорь, тээврийн хэрэгслийг ачилт хооронд сайн угааж

цэвэрлэх (уурын цэвэрлэгээ сайн)

- цэвэрлэгээ хийсний дараа агуулах зоорь, тээврийн хэрэгслийг сайтар хатаах
- дамжин халдварлах эрсдлээс хамгаалах үүднээс зөөвөрлөсөн материалд сайтар тэмдэглэл хөтлөх – хөдөө аж ахуйн химийн бодис, сав суулга, хаягдал металл зэрэг аюултай материал өмнө нь тээвэрлэж байсан машинд дахин тээвэрлэхгүй байх
- тэжээлийг хадгалах болон тээвэрлэлтийн үеийн ажилчдын тэжээлтэй харьцахыг багасгах–жишээ нь, жолооч ачиж буй өвсний дээгүүр явж хэрхэвч болохгүй
- ил тээвэрлэж буй тэжээлийг берзентээр хучих
- тээвэрлэх болон хадгалах хугацааг хамгийн бага түвшинд барих.

4. **Эрхийн бичгийн схем.** Эрхийн бичгийн схем нь өрхүүдэд агуулах тоног төхөөрөмж хүрэлцээгүй болсон үед хэрэгтэй байдаг. Тэжээлийг төв агуулахад хадгалах ба эрхийн бичгийг тэжээл олгох үед ашиглана.

Тэжээлийн стандарт 4: Тэжээлийн эх үүсвэр ба түгээлт

Тэжээлийг боломжтой бол орон нутгийн эх үүсвэрээс худалдан авч, аюулгүй түгээх, орон нутгийн болон үндэсний зах зээлд сөрөг нөлөө багатай байх хэрэгтэй.

Үндсэн үйл ажиллагаа

- Тусламжийн байгууллагууд тэжээлийг хурдан худалдан авах захиргааны болон худалдан авалтын тогтолцоог баталгаажуулах (*Зааварчилгаа 1* харна уу).
- Орон нутгийн тэжээлийн нөөцийн санг оролцуулаад орон нутгийн боломжит тэжээлийн нөөцийг үнэлэх (*Зааварчилгаа* 2 харна уу).
- Үнэлгээний үед бэлэн мөнгө ашиглан тэжээл тараах хувилбарыг оруулан үнэлэх (*Зааварчилгаа 3* харна уу).
- Тэжээлийн зүйлийг нэрвэгдсэн нутгийн гаднаас оруулж ирэх гэж байгаа бол боломжтой, тогтвортой авах эх үүсвэр олж тогтоох (*Зааварчилгаа 4* харна уу).

- Санал болгож байгаа тэжээл түгээх тогтолцооны аюулгүй байдлыг үнэлэх (*Зааварчилгаа 5* харна уу).
- Боломжтой газар нь орон нутгийн уламжлалт тогтолцоог ашиглах, бэхжүүлэх (*Зааварчилгаа 6* харна уу).
- Хэрвээ шууд тараах боломжгүй байвал мал тэжээх цэг байгуулж хүн малын аюулгүй байдал, онцгой байдлын үед шаардагдах тэжээлийн нөөц бусад менежментийн асуудлыг зохицуулна (*Зааварчилгаа 7* харна уу).

Зааварчилгаа

1. **Зохион байгуулалтын арга хэмжээ**. Зарим байгууллагуудад хувийн худалдаачдаас тэжээл худалдан авах гэх мэтийн худалдан авалт хийх тохиромжтой тогтолцооо эсвэл дотоод журам, зохицуулалт байдаггүй. Иймээс онцгой байдлын үе шатанд бэлэн мөнгөний шилжүүлэг хийх явцад энэ системийг бий болгох хэрэгтэй болдог. Үүнийг гамшгийн бэлэн байдлын төлөвлөлтийн явцад тэжээл худалдан авах боломжтой нийлүүлэгчдийн жагсаалтыг гаргах зэргээр хийж болно (*Бүлэг 2, Нийтлэг стандартууд ба мал амьтанд хамааралтай нийтлэг асуудлууд, Нийтлэг стандарт 2: Бэлэн байдал, Нийтлэг стандарт 7: Бодлого ба нөлөөлөл*).
2. **Орон нутгаас авах боломжтой тэжээл**. Онцгой байдлын үед орон нутгийн эх үүсвэрээс тэжээл худалдан авах нь олон талын давуу талыг бий болгодог. Үүнд:
   - Нэрвэгдсэн газар нутагт тэжээлийн үнэ өндөр байсан ч тээврийн зардал харьцангуй хямд байдаг.
   - Богино зайнд тээвэрлэлт хийдэг тул хулгайд алдагдах эрсдэл багатай.
   - Орон нутгийн зах зээлд импортын тэжээл орж ирснээс үүсэж болох саатал, царцаалт үүсэхээс сэргийлдэг. («импорт» гэдэг нь энэ тохиолдолд гадаад улс орнуудаас гэсэн үг биш гамшигт нэрвэгдсэн бүс нутгийн гаднаас гэсэн үг.)
   - Тэжээл худалдан авснаар орон нутгийн зах зээлд бэлэн мөнгө оруулах.
   - Тэжээлийг тээвэрлэх, тараах зэрэгт орон нутгийн ажиллах хүчийг ашиглах боломжийг бий болгох.

- Гэвч орон нутгаас худалдан авалт хийх нь тухайн нутгийн тэжээл бүхий иргэдийн өрсөлдөөнийг бий болгож зах зээлийн уналт, иргэдийн эмзэг байдалд нөлөөлөх талтай. Зах зээл уналтад орохоос сэргийлж анхдагч үнэлгээ хийх шаардлагатай.

3. **Бэлэн мөнгө ашиглах.** Орон нутгийн зах зээлд хангалттай хэмжээний, чанарын шаардлага хангасан тэжээлийн эх үүсвэр байгаа тохиолдолд тэжээлээр хангахад бэлэн мөнгө, эрхийн бичгийг ашиглана. Эрхийн бичгийн үнэ цэнийг шударгаар үнэлэх хэрэгтэй. Эрэлт, нийлүүлэлт, улирлын чанартай өөрчлөлт, найрлагаас хамааран тэжээлийн үнэ хэлбэлзэж болно. Эрэлт ихтэй нийлүүлэлт багатай үед эсвэл худалдаачид үүссэн нөхцөл байдлыг ашиглаж үнээ нэмэх зэргээр орон нутагт байгаа тэжээлийн үнэ нь зарим тохиолдолд бодит биш байдаг. Түүнчлэн, алслагдсан нутагт бага хэмжээний (цөөн тооны) тэжээл хүргэхэд тээвэрлэлтийн зардал өндөр гардаг учраас тэжээлийн үнэ нэмэгддэг. Тэжээлийн үнийг нэмэлт зардал (тээвэрлэх, ачих, хадгалах), хүлээн зөвшөөрөгдөх ашгиийг харгалзан бодитойгоор тогтооно. Худалдаачдад эрхийн бичгийг хүлээн зөвшөөрүүлэхийн тулд урамшуулал болгож тэжээлийн үнийн дүнг бага хэмжээгээр нэмэх нь тохиромжтой байдаг.

4. **Тэжээлийг гаднын эх үүсвэрээс авах**. Зарим төрлийн тэжээлээр хангах хөтөлбөрийн үед орон нутгийн эх үүсвэрээс тэжээлийг хангах боломжгүй байдаг. Тухайлбал тусгай найрлагатай тэжээл, эрдэс бодис шаардлагатай болдог. Иймээс зарим тохиолдолд тэжээлийн эх үүсвэрийг нэрвэгдсэн газрын гадна талаас авах шаардлага үүсдэг. Ямар ч тохиолдолд тээврийн систем, дэд бүтэц шаардлагатай. Хэрэглэгчид болон түгээх цэг хоорондоо хол байх тусам нийлүүлэлтэд тэр хэмжээгээр эрсдэл үүсдэг. Энэхүү эрсдлийг бууруулахын тулд дараах зүйлүүдийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

   - түгээлтийн явцад ямар нэгэн саад учруулахад тэжээлийг хадгалах тохиромжтой агуулахтай байх, агуулахад тэжээл муудах эсвэл хулгайд алдах эрсдэлтэй гэдгийг анхаарах
   - олон төрлийн нийлүүлэлтийн сүлжээг ашиглах, учир нь нэг сүлжээ тасрахад дараагийн сүлжээ нь хөтөлбөрийг үргэлжлүүлдэг
   - богино хугацааны саатал гарах үед орон нутгийн боломжийг ашиглах, тухайлбал тодорхой хугацаанд өндөр уургийн

агууламжтай хөвөнгийн үр, тосны ургамлын үрээр хийсэн шахдас зэрэг нь түр зуур тусгай найрлагатай тэжээлийг орлож чаддаг

- нэрвэгдсэн бүсэд ажиллаж байгаа тээврийн хэрэгслийг ашиглах, тухайлбал мал амьтны тоо толгойг бууруулах зориулалтаар мал тээвэрлэхээр ирж байгаа машинд тэжээлийг ачиж явуулах
- яаралтай тэжээлээр хангах хөтөлбөр хэрэгжүүлж байгаа үед хамгийн боломжтой зорилтот нийцүүлэх, орон нутагт олдоцтой тэжээлийг ашиглах нь оновчтой, импортоор тэжээл оруулахад орон нутгийн зах зээлд сөрөг үр дагавар гардгийг мартаж болохгүй.

5. **Түгээлтийн аюулгүй систем бий болгох**. Тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлж тэжээл түгээх ажиллагаанд оролцож байгаа ажилтнуудын аюулгүй байдлыг нэн тэргүүнд авч үзнэ. Гамшгийн үед ёс зүйтэй холбоотой сөрөг үзэгдлүүд байнга гардгаас гадна түгээлтэд карго, ачааны машин ашигладаг учраас дээрмийн гол бай болдог. Ихэнх олон улсын тусламжийн байгууллагууд нь өөрсдийн үйл ажиллагааг үр дүнтэй явуулахын тулд аюулгүй байдлын тусгай журамтай байдаг бөгөөд энэ талаар орон нутгийн болон бусад хамгаалалтын байгууллагуудтай хамтран ажилладаг. Гэвч орон нутгийн санаачлагаар жижиг хэмжээний үйл ажиллагаа явуулж байгаа нөхцөлд бусадтай адил түвшинд аюулгүй байдлыг хангахад төвөгтэй байдаг.
6. **Уламжлалт түгээлтийн бүтэц.** Тэжээл тараах үйл ажиллагааг тухайн орон нутгийн уламжлалт түгээлтийн тогтолцоонд суурилан зохион байгуулах нь хамгийн оновчтой байдаг. Зөвхөн энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж орон нутгийн хороо байгуулах эсвэл тосгоны удирдагч, нөлөө бүхий хүмүүсийн сүлжээг ашиглах нь тэжээлийг тэгш хүртээмжтэй хуваарилах, эмзэг бүлгийнхэнд олгоход ач холбогдолтой.
7. **Тэжээлийн бааз**. Тэжээлийн баазыг хүрэх боломж, аюулгүй байдал, ашиг хүртэгч болон хэрэгжүүлэгч байгууллагуудад ашигтай байхаар төлөвлөж зохион байгуулна. Хэрвээ онцгой байдлын үед хүрэлцээтэй нөөц байгаа бол шаардагдагдах хөрөнгө оруулалтыг (малын хөдөлгөөн, мал амьтныг тэжээл усаар хангах, ажиллагсадын зардал) харгалзан малын тэжээх баазыг байгуулах хэрэгтэй. Тэжээлийн баазыг байгуулахдаа хамгийн их эрсдэлд

өртсөн мал бүхий иргэд, эмзэг бүлгийнхэнд чиглүүлнэ. Зохион байгуулах ажиллагсдыг урьдчилан төлөвлөж, орон нутгийн иргэд эсвэл байгууллагууд үйл ажиллагаанд хяналт тавих боломж олгоно (*Үйл явцын жишээ судалгаа 6.1* харна уу).

Тэжээлээр хангах үйл ажиллагааны жишээ судалгаа

6.1 Үйл явцын жишээ судалгаа: Этиоп дахь цөм сүргийг тэжээлээр хангах хөтөлбөрт эмэгтэйчүүд тусалсан тухай

Этиоп улсад 2006 оны эхээр болсон гангийн үеэр АНУ-ын Хүүхдийг Хамгаалах сангаас мал амьтан нь амьжиргааны гол эх үүсвэр болсон эмзэг бүлгийн нүүдэлчин малчдад тэдгээрийн цөм сүргийг тэжээлээр хангах төслийг хэрэгжүүлсэн байна. Мояле дүүрэгт эмчилгээ тэжээлийн гурван цэгийг байгуулж, ашиг шим өндөртэй мал амьтныг сонгон авч тэжээж, эмчилгээ хийн вакцинжуулсан байна. Гангийн ид үед нийт 1000 хонь, ямаа 400 үхрийг эмчилгээ тэжээлийн цэгт малласны дараа малын эздэд буцаан өгчээ.

Төслийн үйл ажиллагаанд өрх толгойлсон бүх эмэгтэйчүүдийг хамруулж, тэд төслийн ашгийг хүртсэн байна. Мөн эмэгтэйчүүд нь мал амьтныг өдрийн цагт арчилж маллах зэргээр эмчилгээ, тэжээлийн цэгийн үйл ажиллагаанд оролцжээ. Эмэгтэйчүүдийг оролцуулах асуудлыг омгийн ахлагч нартай урьдчилан хэлэлцэж тохиролцсноос гадна Сомалийн хонь, ямаа маллахад эмэгтэйчүүдийн үүргийг бий болгохыг зорьсон (Эх сурвалж: Nejat Abdi Mohammed, personal communication, 2008).

6.2 Үр нөлөөний жишээ судалгаа: Этиоп дахь үхрийн нэмэлт тэжээлээр хангасан ажлын үр дүн

АНУ-ын Хүүхдийг Хамгаалах сан 2006 онд мал амьтныг тэжээлээр хангах төслийн туршлага дээр үндэслэн 2008 оны эхээр болсон гангийн үед дээрх төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлжээ. Энэхүү төслөөр нийт 10 эмчилгээ тэжээлийн цэг байгуулж, 6750 үхэр тэжээсэн байна. Зарим үхрийг дан нэмэлт тэжээл өгсөн бөгөөд зарим үхрийг бэлчээж нэмэлт тэжээл өгөөгүй байна.

2008 оны 5 сард нэмэлт тэжээлд хамрагдсан болон хамрагдаагүй үхрийн хорогдлын талаар харьцуулсан үнэлгээ хийжээ. Ган ихээр тохиолдсон газар байрлах хоёр тэжээлийн цэгийг сонгон авч судалгаанд хамруулжээ. Нэмэлт тэжээлээр тэжээх хугацааг өөр өөрөөр тогтоож судалсан байна. Булбу тэжээлийн цэгт 1000 үхэрт 22 хоногийн турш харин Вэб цэгт 800 үхэрт 67 хоногийн турш нэмэлт тэжээл өгчээ. Айл өрхийг түүвэрлэн авч малын хорогдлын судалгаа хийсэн байна.

Хүснэгт 6.3 Хоёр тэжээлийн цэгт гарсан үр дүн

Байрлал/Бүлэг	Хорогдол	
Булбул: ганд дунд зэрэг нэрвэгдсэн; 2008 оын 3 дугаар сарын 15-наас эхлэн 22 хоногийн турш тэжээсэн		
Нэмэлт тэжээлд хамрагдаагүй бэлчээрлэсэн үхэр	108/425	(25.4%)
АНУ-ын Хүүхдийн сангийн төсөлд хамрагдаж нэмэлт тэжээл өгсөн үхэр	13/161	(8.1%)
Вэб: ганд ихээр нэрвэгдсэн, 2008 оны 2 дугаар сарын 9-ноос эхлэн 67 хоногийн турш үхрийг тэжээсэн		
Нэмэлт тэжээлд хамрагдаагүй бэлчээрлэсэн үхэр	139/407	(34.2%)
АНУ-ын Хүүхдийн сангийн төсөлд хамрагдаж нэмэлт тэжээл өгсөн үхэр	49/231	(21.2%)

- *Хорогдол.* Тэжээлийн цэгт нэмэлт тэжээлээр хангасан үхрийн хорогдол харьцангуй бага.
- *Биемахбодын байдал.* Тэжээлийн цэгт биемахбодын байдлын үнэлгээгээр муу гарсан үхрийн 70 хувь нь дунд гэсэн үзүүлэлт рүү шилжсэн.
- *Сүү ба тугал.* Зарим үнээ нь тэжээлийн цэгт тугалласан бөгөөд тугал нь борооны улирал хүртэл эхээ хөхөх боломжтой байсан. Хоёр тэжээлиин цэгт нийт 198 тугал бойжуулжээ. Нийт 5640 литр сүү сааж хүүхдүүдэд өгсөн байна.
- *Үр ашгийн үнэлгээ* .Булбугийн тэжээлийн цэгийн үр ашиг-зардлын харьцаа 1.6:1 харин, Вэб бүсийнх 1.9:1 байсан байна. Мэдрэмжийн үнэлгээгээр энэхүү үйл ажиллагааг сайн гэж үнэлэгдсэнээс гадна үр ашиг-зардлын үр дүнд зах зээлийн өөрчлөлт нөлөөлөөгүй байна. (*Эх сурвалж: Bekele and Abera, 2008*)

6.3 Үйл явцын жишээ судалгаа: Нигер дарь гангийн бэлэн байдалд зориулсан тэжээлийн нөөц

Нигер улсын Дакор мужид Нүүдэлчдийг хамгаалах ба нөхөн сэргээх төслийг Лютерийн Дэлхийн Тусламж (LWR) байгууллага Үндсэн боловсролын төвтэй (CEB) хамтран хэрэгжүүлжээ. Энэхүү төслийг 2005 онд Нигерт болсон өлсгөлөнгийн үед яаралтай хүнсний тусламж үзүүлэх төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлжээ. Төслийн зорилго нь нэрвэгдсэн

хүн амын болзошгүй ган, өлсгөлөнд бэлэн байдлыг хангахад чиглэгдсэн байна. Орон нутгийн иргэдтэй зөвлөлдсөний үндсэн дээр дараах дөрвөн арга хэмжээг хэрэгжүүлэхээр тохирчээ:

- малжуулах
- тэжээлийн фонд бий болгох
- уст цэг байгуулах
- төслийг хэрэгжүүлэхэд гарах тухайлбал газар тариалангийн ферфер болон малчдын хороондох маргаан, бусдын эрхийг хангахтай холбоотой мэтийн асуудлыг нутгийн иргэдийн форум хийж шийдвэрлэх .

Нутгийн иргэд нь тэжээлийн фондыг ажиллуулж, жилийн турш боломжийн үнээр тэжээл авах боломжтой болсон. зургаан тэжээлийн фонд нь мөн хамтарсан бөөний агуулах хэлбэрээр ажиллаж, банкны данстай болоход дэмжлэг үзүүлжээ. Тэжээлийн фондийг малчдын холбоо хариуцаж, тэжээл хямд үед худалдаж авч нөөцлөн, зөвхөн үйл ажиллагааны зардлаа нэмж малчдад жилийн турш заржээ. Энэ нь малчдын хувьд сайн тэжээл хямд үнээр худалдан авснаар малаа сайн тэжээж үнэтэй зарах, гэр бүлдээ хоол хүнс авах боломжийг бүрдүүлсэн.

Тэжээлийн цэгүүдийн байрлалыг малчдын хүрэх боломж, аюулгүй байдал, нүдэнд харагдахуйц, тосгонд тэдний уулздаг газар эсвэл нүүдлийн зам дагуу гэх мэт зүйлийг харгалзан орон нутгийн малчид өөрсдөө сонгосон байна. Орон нутгийн иргэд ажиллах хүч, орон нутагт олдоцтой элс, хайрга зэргээр хувь нэмэр оруулж удирдан зохион байгуулах хүмүүсийг малчдын холбоо өөрсдөө томилжээ.

Нутгийн иргэдийн амьжиргаанд малын эрүүл мэнд сайжирснаар сүүний гарц нэмэгдэх, шимт чанар сайтай тэжээлээр малаа тэжээх, орлого нэмэгдэх гэх мэт гангаас хамгаалсан богино болон урт хугацааны турш ашиг хүртжээ. Мөн тэжээлийн фондыг ашигласнаар цаашид малын хорогдлыг бууруулах, малаа зарахаас аргагүй байдалд хүрэх дарамтаас сэргийлэх боломжтой.

Тэжээлийн фонд байгуулахын зэрэгцээ нутгийн уламжлалт аргыг хэрэглэн малжуулах ажлыг хийсэн байна. (*Бүлэг 9, Малжуулах, Үйл явцын жишээ судалгаа 9.2, харна уу*). Дакоро мужид мал аж ахуй эрхлэгчдийн хувьд мал амьтны худалдаанд эерэг үр дүн үзүүлжээ. (Эх сурвалж: LWR, 2005; Burns, 2006; Evariste Karangwa, Meghan Armisted and Mahamadou Ouhoumoudou, personal communication, 2008)

6.4 Үйл явцын жишээ судалгаа: Энэтхэг дэх ашиглагдаж буй тэжээлийн сүлжээ, тараах цэгийг сайжруулсан тухай

2001 онд Энэтхэгийн Гужарат мужид газар хөдлөлт болох үед өмнө нь нэг жилийн турш гантай байсан байна. Засгийн газраас гангийн хор уршгийг бууруулах, мониторинг хийх арга хэмжээ хэрэгжүүлж үндэсний хороо байгуулсан. Гангийн үед нэрвэгдсэн газар мал амьтны тэжээл хүргэх машин, галт тэрэгний сүлжээ үүсгэж тээвэр хийж байсан тул эдгээрийг ашиглан газар хөдлөлтийн дараагийн долоо хоногт тэжээлийг түгээх цэгүүдэд хүргэжээ. Орон нутгийн ТББ болон бусад байгууллагууд мал амьтныг түр зуурын хашаа саравчаар хангах, аюулгүй барилгад оруулах, ус тэжээл өгөх зэрэг ажлыг зохион байгуулжээ. Дээрх байгууллагууд нь газар хөдлөлтөнд зориулан хувийн болон ТББ аас өгсөн малын тэжээлийг хүлээн авах, түгээх ажилд тусалсан байна. (*Эх сурвалж: Goe, 2001a; Goe,2001b)*

6.5 Үр нөлөөний жишээ судалгаа: Этиоп дахь мал амьтныг нэмэлт тэжээлээр хангах замаар хүний хоол тэжээлийн шимт чанарт нөлөө үзүүлсэн тухай

Этиопийн Сомали мужид урт хугацааны хуурай улирлын дараа мал амьтны бэлчээр хомсдсоны улмаас сүүний гарц муудаж хүүхэд хоол тэжээлийн дутагдалд орох эрсдэл үүсчээ. Тюфтын Их сургууль, Хүүхдийг Хамгаалах сан хамтран дээрх улирлын үед хүүхдийг малын сүүгээр хангах туршилтын төсөл хэрэгжүүлжээ. Орон нутгийн эмэгтэйчүүдтэй зөвлөлдсөний дараа саалийн үед байгаа үнээ болон ямааг хуурай улирлын туршид нэмэлт тэжээл, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх үйлчилгээгээр хангаж, тухайн хугацаанд хүүхдэд өгсөн сүүний хэмжээг тодорхойлох ажлыг хийжээ.

Төслийг ганд нэрвэгдсэн газарт ердийн хуурай улирлаас гангийн үе болох хугацааг сонгон хэрэгжүүлсэн байна. Төсөл хэрэгжүүлсэн хоёр газар үнээ, ямааны сүүний гарцанд гарсан өөрчлөлтийг нэгтгэн *Хүснэгт 6.4* харуулав.

Хүснэгт 6.4 Үнээ, ямааны сүүний гарцад гарсан өөрчлөлт

Малын төрөл	Саалийн үе	Сүүний хэмжээ (мл)	
		2010 онд ердийн хуурай улирал, ямар нэг арга хэмжээ хэрэгжүүлээгүй	2011 онд хуурай улирал, нэмэлт тэжээлээр хангасан
Ямаа (n=352)	Эрт	224	628
	Дунд	54	567
	Сүүлийн	8	382
Үнээ (n=112)	Эрт	638	2197
	Дунд	293	2251
	Сүүлийн	46	860

Саасан бүх сүүгээ өөрсдийн хэрэгцээнд буюу хүүхдэдээ өгсөн гэж бүх эмэгтэйчүүд хариулжээ. Хүүхдүүдийн дунд мониторинг хийхэд төсөл хэрэгжсэн газрын хүүхдийн биеийн нөхцөл байдал нэмэгдсэн хэдий ч гангийн туршид хүүхдүүд хоол тэжээлийн дутагдал үргэлжилсэн дүн гарчээ. (*Эх сурвалж: Sadleretal., 2012*)

6.6 Үйл явцын жишээ судлал: Судан дахь малын тэжээлд зэрлэг мод ашигласан тухай

Зүүн Суданы Кассал муж мөргөлдөөн, албадан нүүлгэлт, дүрвэгсэд зэрэг олон асуудал сүүлийн 30 жилийн турш гарч байгаа тул ган гачгийн, хүнсний баталгаат байдлыг хангах, үерийн, түймэр, хавсарсан гамшгийн гэх мэт маш олон тооны хүмүүнлэгийн тусламж хэрэгжүүлж байна. Кассалагийн эдийн засаг нь хөдөө аж ахуй тэр дундаа байгалиас хамааралтай эсвэл усалгаатай тариалан, муж хооронд нүүдэллэдэг мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл юм. Гангийн улмаас хуурай улирлын сүүлээр тэжээлийн хомсдол үүсгэж байсан тул Суданы Улаан Загалмайн Нийгэмлэг (SRCS) орон нутагт зэрлэгээр ургадаг мескит буюу *Prosopis* модыг ашиглаж тэжээл үйлдвэрлэж хуурай улиралд ашиглажээ. Ингэснээр энэхүү ургамлыг малд хэрэглэхээс гадна ургалтыг давхар хянах боломж олгожээ.

Энэхүү *Prosopis* модноос гарсан шошийг цуглуулан авсан байна. SRCS нь Зүүн Атбара голын бүсэд шошийг бутлах тоног төхөөрөмж

нийлүүлж, Prosopis модны менежментийн талаар гарын авлагыг боловсруулжээ. Энэхүү мод нь голлох хөдөө аж ахуйн зориулалтын газар болон ойд их хэмжээгээр шигүү ургадаг байна. Буталсан шошоор орон нутгийн иргэд малаа тэжээсэн байна. Кени, Этиоп зэрэг бусад улсуудад энэхүү модны шошийг ямааны нэмэлт тэжээл болгон ашигладаг байна. (*Эх сурвалж: Gebruetal., 2013*)

6.7 Үйл явцын жишээ судалгаа: Болив дахь өвлийн улиралд малын тэжээлээр хангасан тухай

Боливын Андийн өндөр уулын бүсийн иргэд лама, хонь голдуу маллан амьжиргаагаа залгуулдаг. 2011 оны 6, 7 дугаар саруудад Потоси мужид болсон цасан шуурганы улмаас зарим газар нэг метр цасан бүрхүүл бий болж, агаарын хэм-20°С түүнээс доош оржээ. 1200 орчим лама тэжээлийн хомсдол болон малын өвчлөлөөс шалтгаалан хорогдсон байна. Далайн түвшнээс дээш 3600 метр газар амьдардаг иргэд ихээр нэрвэгджээ.

НҮБ-ын ХХААБ (FAO) гамшгийн хариу арга хэмжээ болгон мал амьтныг нэмэлт тэжээлээр хангах хөтөлбөр хэрэгжүүлсэн бөгөөд төслийн хүрээнд нийт 1800 айл өрхийн 140000 ламад хүрэлцэхүйц хэмжээний тэжээл, эрдэс бодисыг нийлүүлжээ. Мөн энэхүү төслийн хүрээнд орон нутгийн чадавхийг бэхжүүлэх, цаг агаарын хүнд нөхцлийг даван туулах чадавхийг сайжруулах зорилгоор газар тариалангийн болон тэжээлийн ургамлын үр нөөцлөх, газар тариалангийн сайжруулсан, богино мөчлөгтэй үр суулгах, өвсний гарцыг нэмэгдүүлэхийн тулд суваг шуудуу, газрын гүн хэсгийг хамгаалах зэрэг олон төрлийн арга хэмжээг хэрэгжүүлжээ.

Энэхүү бүс нутагт эрэгтэйчүүд ажил хайхаар хот суурин газарлуу нүүдэллэх нь элбэг, шилжилт хөдөлгөөний хориг тавигддаг учраас ихэвчлэн мал малладаг эмэгтэйчүүд хамрагдсан байна. Төсөлд хамрагдах айл өрх, тэжээл тараах бусад үйл ажиллагаанд оролцох хүмүүсийг орон нутгийн эрх бүхий байгууллага, тэдний төлөөллийг оролцуулан сонгосон байна. (*Эх сурвалж: Einstein Tejada, personal communication, 2014*)

Хавсралт 6.1: Тэжээлээр хангах үйл ажиллагааг үнэлэх шалгах хуудас

Энэхүү шалгах хуудас нь мал амьтныг тэжээлээр хангах, тэжээлийн эх үүсвэрийг шуурхай үнэлэхэд зориулагдсан. Мөн орон нутгийн иргэд болон яаралтай тусламж үзүүлж байгаа мэргэжилтнүүдийн саналыг авах зорилготой. Орон нутгийн тэжээлийн эх үүсвэр, ложистик, иргэдийн хүлээн зөвшөөрөх байдал зэрэг гол асуудлуудын талаар нарийвчилсан мэдээлэл цуглуулахад чиглэгдсэн.

Яаралтай тэжээлийн тусламж: Тухайн орон нутагт

Тэжээлийн тусламж ба тэжээллэг чанар

- Тэжээлээр хангах зохион байгуулалт, тусламжийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн зорилтод нийцэхээр төлөвлөсөн үү?
- Зорилтот ашиг хүртэгч нарт тэжээлийг түгээх үед гарч болох ложистикийн хүндрэлүүдийг тэжээлээр хангах үйл ажиллагааны зохион байгуулалтанд тооцсон уу?
- Тэжээлээр хангах үйл ажиллагааг зохион байгуулахад хангалтай төсөв байгаа юу?

Тэжээлийн аюулгүй байдал

Мал амьтанд аюул учруулж болох тэжээлийн бохирдолын эрсдлийн үнэлгээ хийсэн үү?

- Тэжээл тохиромжтой эсэхийг шалгах чанарын хяналтын аргыг хэрэглэсэн үү?
- Тэжээлийг хадгалах хугацаа нь тэжээлийн аюулгүй байдал чанарт нөлөөлөхгүй байж чадах уу?
- Тэжээлийн тээврийн хэрэгсэл, агуулах нь тэжээлийн цэвэр, ариун байдлын стандартыг хангах арга хэмжээг авсан уу?

Тэжээлийн эх үүсвэр ба түгээлт

- Тухайн байгууллагын удирдлагын систем нь тэжээлээр хангах хөтөлбөрийн хүрээнд тэжээлийг тасралтгүй хангах үйл ажиллагааг

зохион байгуулж чадах уу?

- Тээврийн зардлыг багасгах, орон нутгийн худалдаачид, бусад худалдаачдыг дэмжихийн тулд тэжээлийн эх үүсвэрийг орон нутгаас хангах боломжтой юу?
- Тэжээлийн эх үүсвэрийг орон нутгаас хангахад бусад оролцогч талуудад үүсэж болох эрсдлийг бууруулах арга хэмжээг авсан уу?
- Нөхөн сэргээлтийн үе шатанд нөөцөө шавхсан тэжээлийн агуулахуудад нөхөн бүрдүүлэлт хийсэн үү?
- Тэжээл түгээлтийн системд тээвэрлэлтийн үйл ажиллагааг үр дүнтэй ашиглах (нэрвэгдсэн бүс нутагруу тээвэр хийж байгаа машинууд очих болон буцахдаа ачаатай явах) ?
- Түгээлтийн сүлжээ нь аюулгүй байдлаас үүсэх эрсдлээс хамгаалагдсан уу?

Гамшгийн үед тэжээх: Тэжээлийн баазууд

Дээрхи асуултад нэмэхэд:

Тэжээлийн баазын хүлээн авах боломж ба ашиг хүртэгчдийг тодорхойлох

- Тэжээлийн бааз нь төрөл бүрийн ашиг хүртэгчдийн шууд болон урт хугацааны хэрэгцээг хангаж чадах эсэх талаар зохих үнэлгээ хийгддэг үү?
- Ашиг хүртэгчдэд тэжээлийн бааз алийг нь боломжтой гэх эсвэл алийг нь санал болгох боломжгүй мөн тэд аль нөхцөлд оролцож болох талаар мэдээлэл өгөх талаар газар дээр нь хэрэгжүүлэх нарийвчилсан журам байдаг уу?
- Санаачлагат үйл ажиллагаанд оролцсоноор тэдэнд учирч болох эрсдлийн талаар боломжит ашиг хүртэгч нарт нарийвчилсан мэдээлэл өгсөн үү?
- Боломжит ашиг хүртэгчид тэжээлийн баазын үйл ажиллагаанд оролцох шаардлагыг хангах боломжтой юу (мал хариулах зэрэг ажиллах хүчнээр хангах)?
- Тэжээлийн баазыг байгуулахад чиглэсэн боломжит ашиг хүртэгчид болон илүү тохиромжтой малын төрлийг тодорхойлох нарийвчилсан журам байдаг уу?

Ложистик ба менежментт

- Тэжээлийн баазыг байгуулахад ашиглагдах барилгын болон бусад материалыг орон нутгаас эсвэл бага зардлаар, эрсдэл багатайгаар газар дээр нь тээвэрлэх боломжтой юу?
- Тэжээлийн баазад урьдчилан тооцоолсон хугацааны түвшин хүртэл хангаж байх ус болон тэжээлийн хангамж хангалттай байгаа юу?
- Малын эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг зохих дэмжлэг үзүүлэх үйлчилгээ байдаг уу?
- Менежерүүд баазын үйл ажиллагааг явуулах боломжийн түвшний ур чадвартай юу?
- Менежментийн бүтэц зохион байгуулалт нь орон нутгийн бүх хамтран оролцогсдод тулгамдах хүндрэл болон хэрэгцээ шаардлагыг тогтоон ажиллах боломжтой юу?
- Баазад зориулсан түвшний хангалттай тооны ажиллагсад байна уу? Боломжтой нөхцөлд хөдөлмөр хүчинд оролцогч ашиг хүртэгчдийг хамруулах ёстой.

Хавсралт 6.2: Мал амьтныг тэжээлээр хангах үйл ажиллагааны мониторинг ба үнэлгээ хийх жишээ

	Үйл явцын шалгуур *үзүүлэлт (болж байгаа үйл ажиллагааг хэмжих)*	**Үр нөлөөний шалгуур *үзүүлэлт (болж байгаа үйл ажиллагааны үр дүнг хэмжих)***
Тогтолцоог бүрдүүлэх	• Орон нутгийнхан/ орон нутгийн төлөөлүүд болон холбогдох хувийн хэвшлийн нийлүүлэгчдийг хамруулсан бусад хамтрагчидтай хийж буй уулзалтууд	• Малын тэжээл нийлүүлэх талаар саналуудад дүгнэлт хийсэн уулзалтын тайлангууд • Үйл ажиллагааны төлөвлөгөө: – Төрөл бүрийн гүйцэтгэгчдийн үүрэг болон хариуцлага – Тэжээл нийлүүлэлт, тээвэрлэлт, түгээлт зэргийг агуулсан тэжээлийн ханган нийлүүлэлтийн хэрэгжүүлэх арга зам – Тэжээл олгох ашиг хүртэгч өрхүүд, тоо хэмжээ, малын төрлийг сонгоход орон нутгийнхныг хамруулах – Малд тэжээл олгох ажиллагааны зохицуулалтад орон нутгийнхныг хамруулах, жишээ нь тосгонд суурилсан тэжээлийн төв
Малын тэжээл нийлүүлэх	• Төслийн газарт нийлүүлсэн болон хүргэж өгсөн тэжээлийн тоо хэмжээ • Төслөөс тэжээл олгож байгаа малын тоо ба төрөл • Нэг малд өдөрт оногдож байгаа тэжээлийн хэмжээ ба төрөл • Тэжээх хугацаа	• Төслийн хүрээнд тэжээл өгсөн малын хорогдол ба төслийн хүрээнд тэжээл олгогдоогүй малын хорогдол • Хүний хоолны тэжээллэг байдал—малын хэрэглээ- нэг өрхөд болон өрхийн гишүүдэд төслийн малын эх үүсвэрээс оногдох хүнс (жишээ нь сүү) • Төслийн хүрээнд тэжээгдэж буй мал буюу тэжээл олгоогүй малын биеийн байдал тарга хүч • Малын тэжээл хүлээн авахад эмэгтэйчүүд, охидуудын хөдөлмөрийн ачааллыг нэмэгдүүлэх ба бууруулах • Бодлогод нөлөөлөх байдал

LEGS-н үнэлгээний арга хэрэгслийг доорх холбоосоор орж LEGS веб хуудаснаас үзэх боломжтой. <http://www.livestock-emergency.net/resources/general-resources-legs-specific/>.

Ашигласан хэвлэлийн жагсаалт ба цаашид уншиж судлах материал

Ayantunde, A.A., Fernбndez-Rivera, S., and McCrabb, G. (eds) (2005*) Coping with Feed Scarcity in Smallholder Livestock Systems in Developing Countries*, International Livestock Research Institute (ILRI), Nairobi, <http:// mahider.ilri.org/ handle/10568/855> [accessed 18 May 2014].

Bekele, G. and Abera, T. (2008*) Livelihoods-Based Drought Response in Ethiopia: Impact Assessment of Livestock Feed Supplementation*, Feinstein International Center, Tufts University, Digital Collections and Archives, Medford, MA <http:// hdl.handle.net/10427/71144> [accessed 18 May 2014].

Blackwood, I. (2006) *Survival Feeding in Drought*, PrimeFact 286, New South Wales Department of Primary Industries, New South Wales. Available from: <http:// www.livestock-emergency.net/resources/feed-supply/> [accessed 18 May 2014].

Blackwood, I. and Clayton, E. (2006) *Supplementary Feeding Principles,* PrimeFact 287, New South Wales Department of Primary Industries, New South Wales. Available from: <http://www.livestock-emergency.net/resources/feed-supply/> [accessed 18 May 2014].

Burns, J. (2006) *ARVIP Baseline* Survey and *Mid-Term Visit Report*, Feinstein International Center, Tufts University, Medford, MA.

Catley, A. (ed.) (2007) *Impact Assessment of Livelihoods-Based Drought Interventions in Moyale and Dire Woredas, Ethiopia*, Pastoralists Livelihoods Initiative, Feinstein International Center, Tufts University, Medford, MA, together with CARE, Save the Children USA, ad USAID-Ethiopia, <https://wikis.uit.tufts.edu/ confluence/download/attachments/14553622/IMPACT~1.PDF?version=1> [accessed 17 May 2014].

Catley, A., Admassu, B., Bekele, G. and Abebe, D. (2014) "Livestock mortality in pastoralist herds in Ethiopia and implications for drought response", *Disasters* 38(3): 500–516 <http://dx.doi.org/10.1111/disa.12060>.

Cripps, S. (2013) "Brinkworth drove stops Surat" in *Queensland Country Life*, <http:// www.queenslandcountrylife.com.au/news/agriculture/cattle/beef/brinkworth- drove-stops-surat/2668776.aspx> [accessed 20 May 2013].

Gebru, G., Yousif, H., Mohamed, A., Negesse, B. and Young, H. (2013) *Livestock, Livelihoods, and Disaster Response, Part Two: Three Case Studies of Livestock Emergency Programmes in Sudan, and Lessons Learned*, Feinstein International Center, Tufts University, Medford, MA, <http://fic.tufts.edu/publication-item/ livestock-livelihoods-and-disaster-response-part-two-2/> [accessed 18 May 2014].

Goe, M.R. (2001a) *Assessment of the Scope of Earthquake Damage to the Livestock Sector in Gujarat State, India*, Consultancy Mission Report, Food and Agriculture Organization of the United Nations (FAO), Bangkok/Rome.

Goe, M.R. (2001b) *Relief and Rehabilitation Activities for the Livestock Sector in Earthquake Affected Areas of Kachchh District, Gujarat State, India*, Technical Cooperation Project Proposal, FAO, Rome/Bangkok.

IIED (International Institute for Environment and Development) and SOS Sahel UK (2010) *Modern and Mobile: The Future of Livestock Production in Africa"s Drylands,* IIED and SOS Sahel UK, London, <http://pubs.iied.org/12565IIED. html?c=drylands/pastoral&r=p> [accessed 18 May 2014].

LEGS (Livestock Emergency Guidelines and Standards) (2014), *Livestock Emergency Guidelines and Standards, 2nd Edition*, Practical Action Publishing: Rugby.

LWR (Lutheran World Relief) (2005) *Lutheran World Relief Pastoralist Survival and Recovery Program (ARVIP)*, Proposal 2005, Lutheran World Relief, Niamey.

Sadler, K., Mitchard, E., Abdulahi, A., Shiferaw, Y., Bekele, G. and Catley, A. (2012) *Milk Matters: The Impact of Dry Season Livestock Support on Milk Supply and Child Nutrition in Somali Region, Ethiopia*, Feinstein International Center, Tufts University and Save the Children, Addis Ababa, <http://fic.tufts.edu/publication- item/milk-matters/> [accessed 18 May 2014].

БҮЛЭГ 7

Усан хангамжийн техникийн стандарт

Усан хангамж

Танилцуулга

Энэхүү бүлэгт онцгой байдлын хариу арга хэмжээ болгон мал амьтныг усаар хангахын ач холбогдол, усаар хангах хувилбар болон түүнийг хэрэгжүүлэх оновчтой арга хэрэгслийн хамтаар нь танилцуулах болно. Энд дурдагдах стандарт, үндсэн үйл ажиллагаа, зааварчилгааг хувилбар тус бүрт дагаж мөрдөнө. Энэ бүлгийн төгсгөлд жишээ судалгааг харж болно. Дараа нь анхдагч үнэлгээ, мониторинг хийхэд ашиглах шалгах хуудсыг дагалдуулсан. Ашигласан хэвлэлийн жагсаалтыг бүлгийн төгсгөлд нь хавсаргав.

LEGS-н амьжиргааг дэмжих зорилттой холбогдох нь

Онцгой байдлын үед мал амьтныг усаар хангах нь онцгой нөхцөл байдлын үед болон түүний дараа мал амьтныг үхэж, хорогдохоос сэргийлэхэд чиглэгдэх бөгөөд энэхүү үйл ажиллагаа нь LEGS-н амьжиргааг дэмжих хоёр ба гурав дахь зорилттой шууд холбогдоно. Үүнд:

- гамшигт нэрвэгдсэн хүн амын хөрөнгө, мал амьтныг хамгаалах
- гамшигт нэрвэгдсэн хүн амын гол хөрөнгө мал аж ахуйг сэргээх.

Иймд амьжиргааны эх үүсвэр болсон мал амьтныг усаар хангах замаар амьд үлдээх, тодорхой хугацааны дараа сүргийн нөхөн сэлбэлтийг хийнэ. Усаар хангах үйл ажиллагаа нь LEGS-н амьжиргааны нэг дэх зорилтыг биелүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Үүнд: гамшигт нэрвэгдсэн хүмүүс өөрт байгаа мал аж ахуйн нөөцөө ашиглаж түүнээс нэн даруй ашиг хүртэх, мал амьтныг амьд үлдээснээр айл өрх хүнсээр шууд хангагдах боломж бүрдэнэ.

Гамшгийн хариу арга хэмжээнд мал амьтныг усаар хангахын ач холбогдол

Онцгой байдлын үед усан хангамжийг бэртэж, гэмтсэн эсвэл өвчилсөн мал амьтныг эмчлэх мал эмнэлгийн үйлчилгээтэй хослуулан хийх нь магадгүй малчинд нэн даруй зайлшгүй шаардлагатай байгаа арга хэмжээний нэг нь байж болох юм. Мал амьтан (тэмээнээс бусад) усгүйгээр хэдхэн өдөр л амьдарна. Иймд онцгой байдлын үед усны хомсдол үүсвэл усаар хангах оновчтой арга шаардлагатай бөгөөд нэн тэргүүний асуудал юм.

Усны эх үүсвэр байгаа тохиолдолд тусламжийн хөтөлбөр үнэлгээ хийж,

шаардлагатай бол тусламжийн болон бусад үйл ажиллагааг усны хомсдолд орохоос сэргийлэхэд чиглүүлнэ. Мал амьтанд зориулсан ус нь чанарын нийтлэг шаардлагуудыг хангасан байх шаардлагатай хэдий ч энэхүү шаардлага нь хүнд зориулсан усны шаардлага шиг өндөр байж болохгүй. Хүнд зориулсан усны шаардлагыг хангаагүй усыг мал амьтанд хэрэглэж болно. Мал амьтныг усаар хангах нь эхний бүлэгт дурдсан малын тавлаг байдлыг хангах "таван эрх чөлөө" "*Өлсөх, цангахаас ангид байлгах*"- эрүүл мэнд, биеийн хөгжлийг хэвийн хадгалахад шаардлагатай ус, тэжээлээр хангагдах гэсэн шаардлагыг хангахад хувь нэмэр оруулна.

Усаар хангах хувилбарууд

Ус нь нэг л төрөл байдаг хэдий ч усан хангамж нь эх үүсвэрийн ялгаатай байдал, түгээх арга замаас шалтгаалдаг. Эрэлт ба нийлүүлэлтэд зохицох усан хангамжийн хувилбарыг олох нь илүү төвөгтэй байдаг. Иймд хамгийн үр ашигтай, тогтвортой байж болох хувилбарыг сонгох хэрэгтэй. Гэвч усыг нэн даруй түгээх шаардлага үүссэн үед өртөг өндөртэй, тогтвортой биш ч гэсэн ус зөөвөрлөх аргыг богино хугацаанд ашиглах хэрэгтэй. Мал амьтанд ус худалдан авах зорилгоор эрхийн бичиг тараах нь магадгүй үр ашигтай арга байж болох ч энэ нь зах зээл, хүртээмжээс шалтгаална. (*Бүлэг 3, Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох,* бэлэн мөнгө, эрхийн бичгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг харна уу)

Хувилбар 1: Уст цэгүүд

Уст цэгээр хангах нь усны хомсдолыг шийдэх хамгийн ашигтай, урт хугацааны шийдвэр бөгөөд тогтвортой менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжтой арга юм. Ус түгээх цэг нь худаг, цооног, гадаргын ус цуглуулах систем (жишээ нь: далан болон усан санг шалгах зэрэг) олон янзын хэлбэртэй байдаг. Гэвч тэдгээрийг байгуулах ажиллуулах зарчим, тохиолдох асуудлууд нь бараг адилхан байдаг. Гамшгийн үед мал амьтныг усаар хангахдаа дараах гурван арга замаас аль нэгийг сонгон хэрэгжүүлнэ. Үүнд:

1.1 нэрвэгдсэн хүн амд хүртээмжтэй ашиглуулахын тулд хуучин байсан уст цэгийн үйл ажиллагааг сайжруулах

1.2 эвдэрсэн уст цэгийг сэргээн засварлах

1.3 шинээр уст цэг байгуулах.

Эхний арга нь хамгийн бага зардлаар хэрэгжүүлэх боломжтой хэдий ч усны хүртээмж муу эсвэл үндсэн болон шинэ хэрэглэгчдийн аль алины хэрэгцээг хангахад түвэгтэй байдал үүсгэдэг. Удаан явцтай гамшгийн үед уст цэгийг сэргээн засварлах, шинээр байгуулах нь онцгой байдлын хариу арга хэмжээнээс илүү бэлэн байдлыг хангахад чухал үүрэгтэй.

Хүн амын усны хэрэгцээ үүсэхэд тэдний мал амьтныг усаар хангахад зөрчил үүсэж болох талтай. Гэвч усыг зөөвөрлөх асуудлын дэргэд энэ нь хүндрэлтэй асуудал биш юм. Төлөвлөлт, менежментийг сайн хийснээр хүн ам, мал амьтны хэрэгцээг зэрэг хангах уст цэгийн сүлжээг бий болгож болно.

Хувилбар 2: Ус зөөвөрлөх

Ус зөөвөрлөх арга хэмжээ нь ихэвчлэн гамшгийн эхэн үед яаралтай тусламжийн хэлбэрээр хэрэгжүүлдэг. Энэ арга нь өртөг өндөртэй, хүч хөдөлмөр их шаарддаг, ашиггүй арга юм. Гэхдээ энэ аргыг гамшгийн үед мал усгүйгээс болж үхэж хорогдох аюул нүүрлэсэн, усаар хангах өөр боломжгүй үед түр зуур хэрэглэдэг. Иймээс ус зөөвөрлөх аргыг богино хугацаанд усаар хангах өөр хувилбараар солих шаардлагатай.

Ус зөөвөрлөхөд тээврийн хэрэгсэл зайлшгүй шаардлагатай тул үүнийг ус зөөвөрлөх үйл ажиллагааны төлөвлөлт, менежментэд сайтар анхаарах хэрэгтэй. Тухайлбал, нөхцөл байдал өөрчлөгдөж болзошгүй тул ус зөөвөрлөх зам нээлттэй эсэх, жолоочийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын улмаас тээвэрлэх багийг өөрчлөх шаардлага гарах, усны сангуудыг үр ашигтай хэрэглэж байгаа эсэхэд анхаарч, байнга хяналт тавина.

Усаар хангах хувилбарын давуу болон сул талыг нэгтгэн *Хүснэгт 7.1-д.* харуулав.

Хүснэгт 7.1 Усаар хангах хувилбаруудын давуу болон сул тал

Хувилбар	Давуу тал	Сул тал
1.1 Одоогийн усны эх үүсвэрийн менежментийг сайжруулах	• Одоо байгаа боломж, нөөц бололцоог дээд зэргээр ашиглавал харьцангуй хямдхан тусна • Гамшгийн нөхцөлд хариу арга хэмжээ авахад маш хурдан хялбар байдлаар ашиглах боломжтой	• Уг зорилтод хүрэхийн тулд газрын боломж үргэлж хязгаарлагдмал • Одоо байгаа болон шинэ хэрэглэгчдийн дунд зөрчил үүсгэж болзошгүй1
1.2 Одоогийн усны эх үүсвэрийг сэргээн засварлах	• Бусад төрлийн аргыг бодвол харьцангуй хямд • Усны эх үүсвэрийн ашиглалтын менежментийн бүтэц, систем аль хэдийн бий болсон • Онцгой байдал удаан үргэлжлэх үед урт хугацаанд хэрэглэх шийдэл • Хүн ам, мал амьтны усны хэрэгцээг хангах бүрэн боломжтой • Эмзэг бүлгийн айл өрхийг ажил-бэлэн мөнгө төслөөр дамжуулан дэмжлэг үзүүлэх (далангийн суурийг солих, байгалийн ус цуглуулах, ус цуглуулагчийг засварлах)	• Анх бий болсон доройтлын шалтгаан хэвээр байх эсвэл давтагдах
1.3 Шинээр усны эх үүсвэр бий болгох	• Гамшгийн үед болон түүний дараа ч яаралтай хэрэгцээ шаардлага гарсан үед хүн амыг тогтвортой шинэ усны эх үүсвэрээр хангах боломжтой • Хүн ам, мал амьтныг хэрэгцээт усны нөөцөөр хангах	• Сэргээн засварлахаас илүү өндөр өртөгтэй, хөрөнгө оруулалт их шаардагдана • Богино хугацаанд (гамшгийн үед) хэрэгжүүлэхэд хүндрэлтэй • Ямар нэгэн зөрчил үүсэхээс сэргийлж, эрх тэгш хуваарилалтыг хангах, мөн усны нөөц ашиглалт, байгаль орчны тогтвортой байдлыг хангах зорилгоор орон нутагт

		тохирсон, хүлээн зөвшөөрөгдсөн менежментийн систем бий болгох • Хүн,мал ундаалж болох шинэ газар нутаг ашиглах сөрөг үр дагавартай (зөрчил, байгаль орчны доройтол) • Ердийн бэлчээрийн хүртээмжийг өөрчлөх эрсдэлтэй (хуурай улирлын бэлчээрт хялбар нэвтрэх, нүүдлийн замыг өөрчлөх, газрын маргаан гэх мэт)
2. Ус зөөвөрлөх	• Нэн шаардлагатай усны хэрэгцээг хангах боломжтой • Хүн амын хэрэгцээнд усны чанарын шаардлага хангаагүй усыг хэрэглэх боломжтой	• Өртөг өндөр, үр ашиг муутай, чанарын шаардлага хангаагүй усыг мал амьтанд хэрэглэх нь илүү тохиромжтой • Хүн хүч хөдөлмөр шаардсан, зөөвөрлөхөд хүндрэлтэй • Тогтвортой бус– зөвхөн түр зуурын арга хэмжээ • Хүн ам, мал амьтны усны хэрэгцээнд хамгийн их зөрчил гарах магадлалтай • Усыг эрх тэгш, хүртээмжтэй хүргэхийн тулд орон нутагт тулгуурласан менежмент шаарддаг • Усны эх үүсвэрийг хэрэглэж байгаа үндсэн хэрэглэгчидтэй зөрчил үүсгэх

Үйл ажиллагааг хэрэгжүүлэх зохистой хугацаа

Ус зөөвөрлөх арга нь түр зуурын, ихэвчлэн гэнэтийн эсвэл удаан явцтай гамшгийн эхэн үед яаралтай тусламжийн хэлбэрээр хэрэгжүүлдэг хэдий ч зардал өндөр, тогтвортой бус арга учраас цаашид үргэлжлүүлэх боломжгүй байдаг. Усны эх үүсвэрийг сэргээн засварлах эсвэл шинээр байгуулах ажлыг завсрын үе шатанд хэрэгжүүлж, тухайн орон нутагт хэрэгжиж байгаа урт хугацааны усны хөгжлийн хөтөлбөртэй уялдуулж уст цэгүүдийн менежментийг сайжруулах шаардлагатай. Шинээр усны эх үүсвэрийг бий болгох аргыг зөвхөн одоогийн хэрэглэж байгаа систем нь үр ашиггүй эсвэл сэргээн засварлахад тохиромжгүй үед хэрэглэнэ. (*Хүснэгт 7.2*).

Хүснэгт 7.2 Усаар хангах зохистой хугацаа

Хувилбар	Гэнэтийн гамшиг			Удаан явцтай гамшиг			
	Гэнэтийн хор хохирол	Эрт үеийн нөхөн сэргээлт	Нөхөн сэргээлт	Сэрэмжлүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээлт
1.1 Уст цэгүүд: менежментийг өөрчлөх	→	→	→	→	→	→	→
1.2 Уст цэгүүд: сэргээн засварлах	→	→	→	→	→	→	→
1.3 Уст цэгүүд: шинээр байгуулах	→	→	→		→	→	→
2.Ус зөөвөрлөх	→					→	→

Sphere ба LEGS-н бусад бүлэгтэй холбогдох нь

Усаар хангах ажиллагаа нь онцгой байдлын үед мал аж ахуйд чиглэсэн арга хэмжээний нэг бүрэлдэхүүн хэсэг юм. (*Бүлэг 6, Тэжээл хангамж, Бүлэг 4, Мал амьтны тоо толгойг бууруулах* харна уу). Зарим мал амьтан нь аж ахуйгаас бүрэн тусгаарлагддаг учир үлдсэн мал амьтныг амьд үлдээхийн тулд тэжээл, усаар зайлшгүй хангах шаардлагатай. Санаачлагч болон байгууллагуудын хоорондын уялдаа холбоог зохицуулсанаар нэг үйл ажиллагаа нь нөгөө арга хэмжээг сүйтгэхээс сэргийлнэ. (*Бүлэг 2, Нийтлэг стандартууд ба мал амьтанд хамааралтай нийтлэг асуудлууд, Нийтлэг стандарт 8: Уялдаа холбоо*).

Мал амьтныг усаар хангах нь хүн амыг усаар хангах үйл ажиллагааны нэг хэсэг байж болох бөгөөд ялангуяа усны эх үүсвэрийг сэргээн засварлах, шинээр байгуулахад усны чанар нь хүн, мал ундаалах боломжтой байдаг. Мал амьтанд зориулан ус зөөвөрлөх асуудлыг болгоомжтой хэрэгжүүлэхгүй бол хүн амын усан хангамжтай өрсөлдөөн бий болгодог. Хүн амын усан хангамжийн талаар мэдээллийг Sphere гарын авлагын «Усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйг дэмжих» бүлгээс харна уу. (Sphere, 2011). Дүрвэгсдийн хуаранд амьдарч байгаа нөхцөлд газар нутаг, усны эх үүсвэр хязгаарлагдмал байдаг тул хүн ам, мал амьтныг усаар хангах асуудлыг хооронд нь уялдуулах шаардлагатай.

Нийтлэг болон харгалзан үзэх бусад асуудлууд

Хүйсийн асуудал ба эмзэг бүлэг

Онцгой байдлын үед тэжээлээр хангахын (*Бүлэг 6, Тэжээл хангамж*) нэгэн адил мал амьтныг усаар хангах асуудал нь ихэнх эмзэг бүлгийнхэнд тулгамдсан асуудлын нэг нь байдаг. Жишээ нь: чинээлэг малчид өөрсдийн мал амьтныг усаар хангах хувийн боломжтой байхад харин ядуу айл өрхүүдэд тийм боломж байдаггүй. Газрын эрх, угсаа гарал, орон нутгийн бодлого нь тодорхой бүлгийн хүмүүсийн усан хангамжид нөлөөлдөг. Иймд хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь тухайн хүн амын эмзэг бүлгийнхэнд тулгарч буй бэрхшээлийг харгалзан үзэж, ижил тэгш хүртээмжтэй байх боломжоор хангана.

Хүйсийн оролцоо, үр дагаварыг үнэлэх, ялангуяа ядуу эмэгтэйчүүд, охидууд мал амьтандаа ус авчрах гэж хол газар явдаг бол хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй эсвэл усны тэгш бус ашиглалт, хуваарилалтаас шаналж болохыг судална.

Хамгаалалт

Хувь хүний аюулгүй байдал, хамгаалалтыг авч үзэх шаардлагатай. Жишээ нь: уст цэг дээр малаа услах үед ялангуяа эмэгтэйчүүд малаа хулгайд алдах эсвэл халдлагад өртөх эрсдэлтэй. Одоогийн байгаа усны менежментийн систем нь амжилт олохгүй бол (нийтийн эсвэл орон нутгийн, засгийн газрын) шинэ хэрэглэгчид эсвэл бусад байгууллагуудын хооронд маргаан үүсгэж болзошгүй. Уст цэгийн менежментэд цаашид эздийн зөрчлөөс сэргийлэх, ижил тэгш хүртээмж, системийн тогтвортой байдлыг хангах үүднээс дээрх асуудлуудыг уст цэгүүдийг сэргээн засварлах, шинээр байгуулахаас өмнө анхаарах хэрэгтэй. Усны менежментийн асуудал нь хуарангийн эргэн тойронд амьдарч байгаа ус хэрэглэгчдийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Жишээ нь: Хуарангийн оршин суугч нь хуарангийн гадна орших уст цэгээс малаа услах шаардлага гарвал тухайн цэгийн үндсэн хэрэглэгчидтэй зөрчилдөх магадлалтай. Оролцогч талуудтай эртнээс тохиролцоонд хүрэх нь үүсэх зөрчлийг багасгадаг.

Байгаль орчин

Онцгой байдлын үед мал амьтныг усаар хангах үйл ажиллагаанд байгаль орчны талаар дараах асуудлаас зайлсхийх хэрэгтэй. Үүнд: усны түвшинд нөлөөлөхүйц хэт их олборлолт хийх (усны эх үүсвэрийн нягтрал эсвэл их хэмжээгээр олборлох), байгаль орчны доройтол үүсгэж болзошгүй уст цэгийн орчим малын бөөгнөрөл. Нөгөө талаар зарим тохиолдолд (нүүдлийн мал аж ахуй эрхлэгчид) усан хангамжийг одоогийн байгаа байгалийн эх үүсвэрийг ашиглах менежментийг хэрэглэх нь байгалийн нөөцийг тэнцвэртэй, үр дүнтэй ашиглаж, байгаль орчинд эерэгээр нөлөөлнө. Хүн амд зориулсан ус нь мал амьтны гаралтай бохирдолгүй, бохирдсон усаар дамжин зэрлэг амьтдад тэр дундаа устаж үгүй болж байгаа амьтдад болон цаашид бусад мал амьтанд халдвар тархахгүй байх нөхцлийг бүрдүүлнэ.

Орон нутгийн чадавхи

Гамшигт нэрвэгдсэн хүн ам өөрсдийн чадавхид тулгуурласан хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ. Жишээ нь: байгалийн нөөцийн талаарх уламжлалт мэдлэг, ялангуяа усны болон байгалийн нөөц хоорондын уялдаа холбоог ашиглах. Орон нутгийн усны менежмент, нутгийн уугуул иргэдийн байгууллага нь уст цэгүүдийг зохион байгуулахад чухал үүрэг гүйцэтгэхээс гадна янз бүрийн зөрчил гарахаас сэргийлдэг.

Стандартууд

Усаар хангах үйл ажиллагаа эхлэхээс өмнө янз бүрийн хувилбар, хэрэгжүүлэх боломж, гарах зардлыг авч үзэх хэрэгтэй. *7.1. Бүдүүвчид* харуулав.

Бүдүүвч 7.1 Усны хувилбарын шийдвэрийн модны загвар

Өмнөх хуудаснаас
Усны хомсдолоос шалтгаалж мал амьтан богино хугацаанд олноор хорогдох эрсдэл үүссэн үү?
Бусад усаар хангах хувилбарыг авч үзэх, дараагийн хуудсанд шилжих
Шинээр байгуулах уст цэгүүдийн байрлал ус шаардлагатай байгаа айл өрхийг хангах тохиромжтой юу?
Усны хэмжээ, чанар шаардлага хангасан уу?
Шинээр уст цэг байгуулахад газар эзэмших маргаантай асуудал бүрэн шийдэгдсэн эсэх ?
Шинээр уст цэг байгуулахад дэмжлэг үзүүлэх хангалттай нөөц байгаа юу?
Шинээр байгуулах уст цэгүүдийг ажиллуулах орон нутгийн усны менежментийн систем (эсвэл шинээр хийх боломжтой) байгаа юу?
Шинэ уст цэгүүд нь дунд, урт хугацаанд ашиглах боломжтой юу?
Байгаль орчинд үзүүлэх хор нөлөө, эрсдлийг үнэлсэн үү?
Уст цэгүүдийг шинээр байгуулах

Тайлбар:
"Үйлдэл хийхгүй" гэсэн үр дүн (онцгойлон үзэх асуудал гараагүй бол)"гэдэг нь газар дээр нь ямар нэг арга хэмжээ авч болохгүй гэсэн үг яг биш гэхдээ гол асуултуудад "тийм" гэсэн хариулах боломжтой байх үүднээс цаашид шаардлагатай сургалт буюу чадавхийг сайжруулах асуудлууд шаардлагатай байж болох юм.

Усны стандарт 1: Үнэлгээ ба төлөвлөлт

Мал амьтныг усаар хангах нь хэрэгцээ, боломж, орон нутгийн усны мененжментийн систем зэргийн дүн шинжилгээнд тулгуурлана.

Үндсэн үйл ажиллагаа

- Одоогийн байгаа усны эх үүсвэрийн менежментийн системийг үнэлэх, усаар хангах үйл ажиллагааны үндсэн арга болгож ашиглаж болох хувилбаруудад дүн шинжилгээ хийх зэргээс эхлэнэ (*Зааварчилгаа 1* харна уу).
- Одоогийн байгаа болон хуучин, дарагдсан усны эх үүсвэрүүдээс хангалттай, чанартай ус түгээх (*Зааварчилгаа 2,3* харна уу).
- Янз бүрийн бүлгийн хэрэглэгчдэд шаардлагатай, ямар нэгэн зөрчил үүсгэхгүй, сайн чанарын усаар хангахын тулд үр дүнтэй менежментийн аргыг тодорхойлох хэрэгтэй (*Зааварчилгаа 4* харна уу).
- Усны хүртээмжид гарч болох бэрхшээлд дүн шинжилгээ хийх, түүнийг шийдвэрлэх оновчтой арга хэмжээ хэрэгжүүлэх *(Зааварчилгаа 5* харна уу*).*

Зааварчилгаа

1. **Хувилбарт дүн шинжилгээ хийх, одоогийн байгаа усны эх үүсвэрийг үнэлэх**. Усаар хангах үйл ажиллагааны төлөвлөлтийг одоогийн байгаа болон орхигдсон эсвэл удаан хугацаанд ашиглагдаагүй усны эх үүсвэрээс хангаж болох усны хэмжээ, чанарт үнэлгээ хийх ажлаар эхлүүлнэ. Орон нутагт ажиллаж байгаа байгууллагуудаас энэ талын мэдээллийг авч болно. (*Бүлэг 2, Нийтлэг стандартууд ба мал амьтанд хамааралтай нийтлэг асуудлууд, Нийтлэг стандарт 2: Бэлэн байдал* хэсгийг харна уу). Энэ нь одоогийн байгаа дэд бүтцийг сайжруулж, хямд үнэтэй, байнгын усаар хангах боломжийг бүрдүүлдэг. Уст цэгүүдэд түргэвчилсэн үнэлгээ хийх шалгах хуудсыг *Хавсралт 7.1-д* үзүүлэв. Үнэлгээнд байршил, байгаль орчинд нөлөөлөх байдал, усны эх үүсвэрийн хүчин чадал зэргийг харгалзан үзнэ. Усны эх үүсвэрийн байршил нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болох талтай

ч уст цэгүүдийг байгалийн нөөцийн менежментийн стратегитэй уялдуулбал байгаль орчин, мал амьтан байгалийн нөөцөд нөлөөлөх байдал нь ашигтай байж болох юм. Ус зөөвөрлөх нь өртөг өндөртэй учир мал амьтныг одоогийн байгаа усны эх үүсвэрлүү шилжүүлэх мэтийн бусад боломжтой хувилбарыг сонгоно. Хүн амын усан хангамжийг энэхүү судалгааны нэг хэсэг болгон авч үзнэ (дор дурдсан *Уст цэгийн стандарт 1* харна уу).

2. **Усны чанар.** Мал амьтны усны чанарын асуудал нь ерөнхийдөө хүн амын усны чанарын асуудлыг бодвол чухлаар тавигддаггүй хэдий ч мал амьтанд усаар дамжин салмонелла, боом, колибацилус зэрэг өвчин халдварлана. Усны бичил биетний бохирдолыг тодорхойлох түргэвчилсэн тест байхгүй үед орон нутгийн иргэдийн дэмжлэгтэйгээр химийн бодис (ойролцоох үйлдвэрүүд), бичил биетэн/ органик бохирдол (хүн амын суурьшил) байж болох аюулыг судална (*Хавсралт 7.1* харна уу).

3. **Усны эх үүсвэрийн бохирдол**. Хүн, мал, амьтан усны нэг эх үүсвэрээс ундаалдаг бол ус нь мал амьтны ялгадсаар амархан бохирдож, хүний эрүүл мэндэд нөлөөлнө. Ус бохирдохоос сэргийлж мал амьтныг усны онгоцоор эсвэл саваар услах гэх мэт энгийн аргыг юуны өмнө хэрэглэнэ. Мөн усны эх үүсвэр пестицид, бусад химийн бодисоор бохирдохоос сэргийлсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4. **Одоогийн байгаа усны менежментийн системийг үнэлэх.** **У**сны цооног, гадаргын болон гүний худаг нь ихэвчлэн орон нутгийн харьяанд (уламжлалт) байдаг. Иймээс одоогийн байгаа усны эх үүсвэрийг сэргээн засварлах, шинээр байгуулахад энэ асуудлыг харгалзан үзэж, усаар тогтвортой хангах ижил тэгш хэрэглэхэд эмэгтэйчүүдийг татан оролцуулахыг зөвлөдөг. Ус зөөвөрлөн түгээх ажлыг орон нутгийн усны менежментэд тулгуурлан хийх нь оршин суугчдад усыг тэгш хуваарилах, хүртээмжтэй байх нөхцөлийг бүрдүүлдэг. Хуарангийн оршин суугчид малаа услах боломжоор хангагдсан байх шаардлагатай бөгөөд үндсэн оршин суугчдын усны эх үүсвэрийг хамтран хэрэглэх тул урьдчилан тохиролцоонд хүрэх нь зөрчил гарахаас сэргийлдэг. Цэвэр устай, тэгш хуваариалалт бүхий усны менежментийн системийг бий болгох нь урт хугацаанд- сэргээн босголт, дараагийн үе шатуудад чухал аж холбогдолтой. Туршлагаас харахад үйл ажиллагаа эхлэхээс

өмнө дээрх асуудлуудыг авч үзэхгүй бол онцгой нөхцөл байдал дуусаны дараа усны эх үүсвэрүүд ашиглалтгүй болдог.

5. **Бодлогын хязгаарлалт**. Усны эх үүсвэр байгаа хэдий ч албан ба албан бус бодлогын хязгаарлалтаас шалтгаалан ашиглах боломжгүй эсвэл хориглосон байж болно. Үнэлгээний явцад энэхүү асуудлыг судлан үзэж, шийдвэрлэх арга замыг төлөвлөгөөнд тусгана (*Бүлэг 2, Нийтлэг стандартууд ба мал амьтанд хамааралтай нийтлэг асуудлууд, Нийтлэг стандарт 7* хэсгийг харна уу).

Уст цэгийн стандарт 1: Уст цэгийн байршил

Усны эх үүсвэрийг сэргээн засварлах, шинээр байгуулах хөтөлбөрт нэрвэгдсэн бүсийн хамгийн эмзэг бүлгийн айл өрх мал сүргээ услах ижил тэгш боломжтой газар байрлахаар тусгана.

Үндсэн үйл ажиллагаа

- Орон нутгийн хүн ам, мал амьтны аль алины одоогийн ба ирээдүйн хэрэгцээг хангах үнэлгээнд тулгуурлан уст цэгийн байршлыг сонгоно (*Зааварчилгаа 1* харна уу).
- Ханган нийлүүлэгч тал онцгой байдлын турш, түүний дараа шаардлагатай усны хэрэгцээг хангах үүднээс усны эх үүсвэрийн хүчин чадлыг сайтар тооцоолж хэрэглэнэ (*Зааварчилгаа 2* харна уу).
- Хэрэглэгчид уст цэгээс ус авах, усыг хэрэглэгчдэд түгээх үйл ажиллагааг зохион байгуулахдаа бүх эмзэг бүлгийнхэнд тэгш, хүртээмжтэй байгаа эсэхэд сайтар анхаарна (*Зааварчилгаа 3* харна уу).
- Уст цэгийг ашиглах үед хэрэглэгчдийн болон тэдний мал амьтны аюулгүй байдлыг хангах зохих арга хэмжээг хэрэгжүүлнэ (*Зааварчилгаа 4* харна уу).
- Уст цэгийн зохион байгуулалт, менежментийг орон нутгийн удирдагчид, ялангуяа уугуул усны менежментийн системийг бий болгосон хүмүүстэй хамтран хэрэгжүүлнэ (*Зааварчилгаа 5* харна уу).

Зааварчилгаа

1. **Усны хэрэгцээг үнэлэх**. Усны хэрэгцээг тухайн орон нутагт байгаа малын тоо, орон нутгийн эрх бүхий байгууллагын мэдээлэл зэргийг үндэслэн орон нутгийн иргэдтэй зөвлөлдөн тодорхойлно. Зарим бүс нутагт малын худалдаачид, ченжийн бизнес эрхэлдэг хүмүүс нь үнэтэй мэдээлэл өгдөг. Уст цэгт хүрэх зай, усны хүртээмж зэргийг харгалзан үзэж хэрэгцээг тодорхойлохдоо хэрвээ мал амьтныг уст цэгт туун ирж услах бол тухайн хамрагдах газар нутаг, тууж ирэх зай зэргийг харгалзан үзнэ. Тухайн мал амьтан байрлаж байгаа газарт усыг түгээх бол мөн адилхан үнэлгээ хийнэ.

2. **Зохистой усан хангамж**. Уст цэгийн усны хэмжээ нь тухайн усны хэрэгцээг хангаж чадахгүй бол нэмэлт арга хэмжээ (тухайлбал, ойролцоо газар нэмэлт уст цэг байгуулах эсвэл ус зөөвөрлөлтийг нэмэгдүүлэх) авч хэрэгжүүлнэ. Одоогийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа нөхцөлд ердийн болон бусад онцгой нөхцөл байдал үүсэх үед уст цэгүүдийг хэрхэн үр дүнтэй, зохистой ашиглах талаар ашиглалтын үнэлгээ хийнэ. Уст цэгүүд нь ирээдүйд онцгой байдлын улмаас үүсэж болох аюулыг бууруулах боломжтой байх ёстой.

3. **Зохистой, тэгш ашиглах**. Хүн амын усны хэрэгцээ нь онцгой байдлын үед нэн тэргүүний асуудал юм. Гэвч хүн амын усны хэрэгцээ шаардлагыг хангаагүй усыг мал амьтанд хэрэглэж болно. Зарим газар янз бүрийн ястан, омог эсвэл нийгмийн янз бүрийн давхаргын бүлгүүд нэг уст цэгээс усаар хангагдах боломжгүй нийгмийн холбоотой бэрхшээл гардаг. Ийм тохиолдолд асуудлыг няхуур авч үзэн, бүх хүмүүс усаар тэгш хангагдах боломжоор хангана.

4. **Аюулгүй байдлын зохион байгуулалт.** Мал услахаар уст цэгт очсон хүмүүс малаа алдах эсвэл бусад төрлийн халдлагад өртөх эрсдэлтэй байдаг. Учир нь тэдний хөдөлгөөнийг урьдчилан мэдэхэд амархан байдаг. Энэ нөхцөлд ялангуяа эмэгтэй хүний аюулгүй байдал нэн чухал. Гамшигт нэрвэгдсэн газар нутагт аюулгүй байдлыг хариуцан ажиллаж байгаа байгууллагууд төлөвлөгөө гаргахдаа дээрх гарч болох эрсдлүүдийг бууруулах арга хэмжээг тусгасан байна.

5. **Орон нутгийн удирдагчид.** *Усны стандарт 1*-д дурьдсаны дагуу орон нутгийн усны менежментэд уст цэгийг сэргээн засварлах, эсвэл шинээр байгуулах үйл ажиллагааг зохион байгуулахдаа орон нутгийн нөлөө бүхий хүмүүсийг оролцуулах шаардлагатай. Энэ нь онцгой байдлын дараа усны эх үүсвэрийг ашиглах, орон нутгийн иргэд бүгд тогтвортой, ижил тэгш усаар хангагдахад чухал үүрэгтэй. Ялангуяа хуарангийн болон орон нутгийн оршин суугчдын хооронд усны эх үүсвэрийн өрсөлдөөн гардаг. Энэ тохиолдолд орон нутгийн нөлөө бүхий удирдагчтай хэлэлцээр, тохиролцоо хийх нь хамгийн үр дүнтэй арга байдаг. Орон нутгийн усны хэрэглээний талаарх хэлэлцээрийг эмэгтэйчүүд голдуу хийдэг учраас усны менежментийг зохицуулах зөвлөлд тэднийг оролцуулахыг зөвлөдөг.

Уст цэгийн стандарт 2: Уст цэгийг сэргээн засварлах, шинээр байгуулах

Сэргээн засварлах эсвэл шинээр байгуулах нь үр ашигтайгаас гадна мал сүргийг хангалттай хэмжээний цэвэр усаар хангахад ашиглах тогтвортой арга юм.

Үндсэн үйл ажиллагаа

- Уст цэгүүдийг сэргээн засварлах арга хэмжээг зөвхөн гамшигт нэрвэгдсэн бүсэд одоогийн байгаа уст цэгүүдийг өргөтгөн ашиглах замаар усны хэрэгцээг хангах боломжгүй үед хэрэгжүүлнэ. (*Зааварчилгаа 1* харна уу).
- Эвдэрч, дарагдсан уст цэгүүдийн талаарх цогц судалгаа хийж , усны хэрэгцээ үүссэн эсвэл үүсэж болзошгүй гамшигт нэрвэгдсэн газар нутгийн бүх байршилд байгаа хуучин уст цэгүүдийн доройтлын шалтгааныг тогтооно (*Зааварчилгаа 2* харна уу).
- Уст цэгүүдийг шинээр байгуулах арга хэмжээг зөвхөн одоогийн байгаа эсвэл сэргээн засварласан уст цэгүүдийг ашиглах боломжгүй, гарч болох үр дагаварыг тооцсны үндсэн дээр хэрэгжүүлнэ (*Зааварчилгаа 3* харна уу).
- Тухайн орон нутгийг сэргээн засварлах/шинээр байгуулах хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, материалаар хангана (*Зааварчилгаа 4* харна уу).

- Уст цэгүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах, өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх хүн (сургагдсан) боловсон хүчээр хангана *(Зааварчилгаа 5* харна уу).

Зааварчилгаа

1. **Уст цэгүүдийг сэргээн засварлах хэрэгцээ**. Одоогийн байгаа уст цэгүүдийг өргөтгөж ашиглах нь сэргээн засварлах аргаас хямдхан хэдий ч одоогийн болон шинэ хэрэглэгчдийн дунд зөрчил үүсгэж болзошгүй учраас төлөвлөлтийн шатанд сайтар үнэлэх хэрэгтэй. Бодит амьдрал дээр одоогийн байгаа эх үүсвэрийг гамшигт нэрвэгдсэн хүн амын зарим хэсгийг хамруулан ашиглаж болох хэдий ч энэ нь нэгдсэн хөтөлбөр дэх сэргээн засварлах ажлын нэг хэсэг болж хэрэгжих нь зүйтэй.
2. **Сэргээн засварлах боломжтой уст цэгүүдийг тодорхойлох**. Усаар хангах үр дүнтэй хөтөлбөр хэрэгжүүлэхэд иж бүрэн судалгаа хийх нь чухал ач холбогдолтой. Энэ нь уст цэг тус бүрт:
   - усны чанар
   - сэргээн засварлах хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц
   - боломжтой хүчин чадал (тоо хэмжээ, тасралтгүй байдал)
   - эвдрэлийг засах, хэвийн сэргээн ажиллуулах зардал
   - хэрэглэгчдийн хэрэгцээ
   - ямар шалтгааны улмаас доройтсон талаарх мэдлэг, амжилттай сэргээн засварласны дараа гарч болох хүндрэл (зөрчил, усны чанар, эзэмшигчийн ташаа ойлголтоос болж усны хомсдол үүсэх, ашиглалт гэх мэт асуудлууд).
3. **Шинээр уст цэг байгуулах хэрэгцээ**. Сэргээн засварласан уст цэгүүд нь гамшигт нэрвэгдсэн хүн амын хэрэгцээг хангаж чадахгүй үед шинээр байгуулах асуудлыг авч үзнэ. Гэхдээ шинээр уст цэг байгуулахад гарч болзошгүй үр дагаврыг (газар эзэмшлийн маргаан, бэлчээрийн төлөв байдалд өөрчлөлт орох, байгаль орчны доройтол, эх үүсвэрийг ашиглах өрсөлдөөн гэх мэт) урьдчилан тооцоолно.
4. **Техникийн үзүүлэлтүүд**. Сэргээн засварлах схемийг төлөвлөхөд яагаад уст цэгүүд ашиглагдахгүй болсон шалтгааныг харгалзан үзснээр техникийн үзүүлэлтийг боловсруулахад дэмжлэг болно.

Дараах ерөнхий шаардлагыг тавина. Үүнд:

- шаардлага хангасан усны инженер, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүн хүчний хүрэлцээ
- уст цэгт шаардлагатай тоног төхөөрөмжийг хүргэх, боломжтой замыг сонгох
- худаг болон цооногийн дагалдах хэрэгслийн тасралтгүй хангамж.

Дээрх шаардлагыг сэргээн засварлах болон шинээр байгуулах уст цэгүүдэд хэрэглэх бөгөөд шинээр уст цэг байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж нь овор хэмжээ ихтэй учраас (жишээ нь: худаг гаргах өрөм/экскаватор гэх мэт) тэдгээрийг тээвэрлэх хүчин чадалтай тээврийн хэрэгсэл, сайн чанарын тээвэрлэх зам зэргийг урьдчилан тооцоолсон байна.

5. **Хариуцлага.** Уст цэгүүдэд өдөр тутмын менежмент, хэвийн үйл ажиллагааг хангах хүн (орон нутгийн хүн эсвэл байгууллагын ажилтан) ажиллах шаардлагатай бөгөөд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- усны чанар өдөр тутам шалгаж, усан хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангах
- бүх хэрэглэгчдэд тэгш хүртээмжтэй байгаа эсэхэд мониторинг хийх
- янз бүрийн хэрэглэгчдийн дунд гарах маргааныг зохицуулах
- өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахын тулд эвдэрсэн хэсгийн захиалга өгөх, сольж тавих (гар худаг нь цооногийг бодвол харьцангуй бага эвдрэл гардаг)
- орон нутгийн хэрэглэгчдийн усны зөвлөлд шаардлагатай сургалт хийх (хүйс болон бусад эмзэг бүлгийн асуудлыг харгалзан үзэх).

Ус зөөвөрлөх стандарт 1: Усны эх үүсвэр ба чанар

Үйл ажиллагаа хэрэгжүүлэх хугацаанд чанарын баталгаа хангасан, хангалттай хэмжээгээр нийлүүлэх боломжтой эх үүсвэрээс усыг зөөвөрлөнө.

Үндсэн үйл ажиллагаа

- Ус зөөвөрлөх арга хэмжээг зөвхөн бусад төрлийн аргыг хэрэглэх боломжгүй үед хэрэглэнэ (*Зааварчилгаа 1* харна уу).
- Төлөвлөсөн хугацааны турш усан хангамж хэвийн байх нөхцөлийг бүрдүүлнэ (*Зааварчилгаа 2* харна уу).
- Тээврийн хэрэгслээр усыг зөөвөрлөхөд тухайн усны эх үүсвэрийн үндсэн хэрэглэгчдэд саад болохгүй, холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна (*Зааварчилгаа 2, 3* харна уу).
- Усны эх үүсвэрийг ашигласнаар хүн амын усан хангамж буурахгүй байх нөхцлөөр хангана (*Зааварчилгаа 3, 4* харна уу).
- Усны чанар нь мал амьтанд хэрэглэж болох шаардлагыг хангасан байна (*Зааварчилгаа 5* харна уу).
- Усны сав, нөөцлүүрийг хэрэглэхээс өмнө сайтар цэвэрлэсэн байна (*Зааварчилгаа 6* харна уу).

Зааварчилгаа

1. **Түр зуурын арга хэмжээ.** Ус зөөвөрлөх арга нь мал амьтныг амьд үлдээхийн тулд хэрэглэж байгаа эцсийн арга хэмжээ бөгөөд энэ нь зардал өндөр, зохион байгуулахад төвөгтэй арга юм. Тэр ч байтугай хүний хэрэглээний усыг тээврийн хэрэгслээр зөөвөрлөхийг дэмждэггүй. Усыг тээврийн хэрэгслээр зөөвөрлөхөөс өмнө мал амьтныг усны эх үүсвэр бүхий ойролцоо газар нутаг руу шилжүүлэх гэх мэт бусад боломжийн талаар сайтар судлан үзэх хэрэгтэй..
2. **Тасралтгүй хангамж**. Ус зөөвөрлөх арга хэмжээг богино хугацаанд хэрэглэх зорилготой байдаг хэдий ч энэ нь зарим тохиолдолд боломжгүй байдаг. Арга хэмжээний хугацаа ямар байхаас шалтгаалахгүйгээр төлөвлөлтийн шатанд усан хангамжийн үргэлжлэх хугацааг бодитойгоор үнэлэх хэрэгтэй. Үүнийг дараах дараалаар хийнэ. Үүнд:
   - Тухайн усны эх үүсвэрийн хүчин чадал хэрэгжүүлж буй арга хэмжээний туршид усаар хангах боломжтой эсэхийг үнэлнэ. Сонгож авсан усны эх үүсвэр нь гамшгийн хамрах хүрээ

нэмэгдвэл түүнд өртөх боломжтой эсэхийг энэхүү үнэлгээнд харгалзан үзнэ.

- Одоогийн хэрэглэгчдээс эсвэл холбогдох эрх бүхий байгууллагаас эх үүсвэрийг ашиглах зөвшөөрөл авна.
- Эх үүсвэрт хүрэх зам хэвийн ажиллагаатай байх, тухайлбал олон удаа тээвэрлэлт хийснээр эх үүсвэрт хүрэх зам доройтож болзошгүй.
- Санхүүжилтэд хүндрэл гарч болзошгүйг тооцох, учир нь ус зөөвөрлөх үйл ажиллагаа нь өндөр өртөгтэй байдаг. Үйл ажиллагааны зардал хангалттай байх шаардлагатай, учир нь өөр хувилбараар ус түгээх ажил хойшлогдвол ус зөөвөрлөлтийг нэмэгдүүлэх шаардлага гарна. Усны эх үүсвэр нь эцсийн хуваарилалтын цэгийн ойролцоо байршилтай байвал зардал харьцангуй хэмнэгдэнэ. Гэвч энэ нь үндсэн хэрэглэгчдийн дунд зөрчил гарах эрсдэлтэйгээс гадна тасралтгүй нийлүүлэхэд нөлөөлнө.

3. **Үндсэн хэрэглэгчдийн хэрэгцээг авч үзэх.** Ус зөөвөрлөх үйл ажиллагаанд хэрэглэж байгаа усны эх үүсвэр нь үндсэн хэрэглэгч байхгүй юм шиг харагддаг. Зөрчил нь үйл ажиллагааны үр дүнд ноцтой нөлөөлдөг. Хамгийн муу тохиолдолд сөрөг нөлөөнд өртсөн айл өрхийн шинэ давхаргыг үүсгэж болзошгүй. Ус хэрэглэх шаардлагатай газрын ойролцоо усны эх үүсвэрийг байрлуулах нь санхүүгийн хувьд илүү тохиромжтой арга хэдий ч үндсэн хэрэглэгчдэд эрсдэл үүсэж болзошгүй газар нутгийг хамруулж болохгүй. Ус зөөвөрлөх төлөвлөлтийн үе шатанд менежер нь орон нутгийн удирдагч, бусад оролцогч талуудыг татан оролцуулж, боломжтой бол орон нутагт зуучлалын журмыг ашиглаж үндсэн хэрэглэгчдийн хэрэгцээг бүрэн тооцоолсон байна.

4. **Хүн амын эрэлт хэрэгцээнд гарах зөрчил**. Усны хомсдол үүссэн эсвэл ус зөөвөрлөх үйл ажиллагаа нь хязгаарлагдмал үед хүн амыг нэн даруй усаар хангах асуудлыг тэргүүн зэрэгт авч үзнэ. Гэвч хүн ам, мал амьтныг хэрэгцээт усаар хангах үйл ажиллагаа нь боломжгүй зүйл биш юм. Өргөн газар нутгийг хамарсан гамшгийн үед зөөврийн аргаар хүн, мал амьтныг зэрэг усаар хангах нь тохиромжгүй байдаг. Гэхдээ бага хэмжээний газар нутагт чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулснаар нэгдсэн үйлчилгээгээр хүн, мал амьтныг усаар зэрэг хангах боломжтой. Ус зөөвөрлөх тээврийн

хэрэгсэл, хүн хүчээр хангахаас гадна мал амьтанд хэрэглэх ус нь хүний хэрэгцээнд чанарын шаардлага хангаагүй усны эх үүсвэрээс гаралтай байж болно.

5. **Усны чанар**. Ус зөөвөрлөлтийг хүн, мал амьтан аль алинд нь зориулан хийж байгаа бол Sphere стандартын усны чанар бүлгийг авч ашиглана. Гэхдээ сайн чанарын усны эх үүсвэр хязгаарлагдмал, гол эсвэл тогтмол нуурын чанаргүй усыг хүн амын усны хэрэгцээнд зориулан цэвэршүүлэх боломжгүй, эсвэл цэвэршүүлэхэд эдийн засгийн хувьд хүндрэлтэй тохиолдолд мал амьтанд хэрэглэхээр нөөцөлж болно.

6. **Савны ариун цэвэр**. Усан сан, усны савыг өмнө нь хортой пестицид, гербицид, уусгагч бодис, түлш, бохир ус гэх мэт төрөл бүрийн шингэн тээвэрлэхэд ашиглаж байсан байж болно. Тухайн савыг өмнө нь юуны зориулалтаар ашиглаж байсан нь тодорхой байсан ч бүх сав суулга, тоног төхөөрөмжийг ус зөөвөрлөх үйл ажиллагаанд ашиглахаас өмнө цэвэрлэж, халдваргүйтгэсэн байх ёстой.

Ус зөөвөрлөх стандарт 2: Тээвэрлэлт ба түгээлт

Нэрвэгдсэн бүс нутагт усыг аюулгүй тээвэрлэн хүргэх, эрх тэгш хуваарилахаар зохион байгуулалт хийж, хэрэгжүүлнэ.

Үндсэн үйл ажиллагаа

- Үйл ажиллагааны туршид менежер, ажилтнуудыг тогтвортой ажиллуулах (*Зааварчилгаа 1* харна уу).
- Түлшний урсгал зардал, усны савыг цэнэглэх үйлчилгээ, бусад шаардлагатай тоног төхөөрөмжийн нөөц хангалттай байх (*Зааварчилгаа* 2 харна уу).
- Боломжтой бол ус зөөвөрлөх том оврын тээврийн хэрэгсэл нь байнга зорчих үед эвдэрч гэмтэхээргүй замыг сонгох (*Зааварчилгаа* 3 харна уу).
- Тохиромжтой газруудад ус түгээх цэгүүдийг байгуулах, үйл ажиллагааны явцад аливаа малын хөдөлгөөнийг зохицуулах (*Зааварчилгаа 4, 5* харна уу).
- Ус түгээх үеийн аюулгүй байдлын зохих үнэлгээ хийх (*Зааварчилгаа 6* харна уу).

Зааварчилгаа

1. **Хүн хүчний хангалт.** Ус зөөвөрлөх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд тогтмол, тогтвортой ажиллах хүн хүчээр хангана. Ялангуяа ур чадвартай, туршлагатай менежер, удирдагчдыг сонгон ажиллуулна. Түүнчлэн жолооч, туслах ажилтнуудыг урам зоригтой байлгахын тулд нөхөн төлбөр олгох, амьжиргааны тэтгэмж, хувийн аюулгүй байдал зэрэг бусад төрлийн хэрэгцээнд анхаарал хандуулах нь чухал.

2. **Засвар үйлчилгээ ба түлшний хангамж.** Ус зөөвөрлөх үйл ажиллагааны туршид мэргэшсэн механикч, бохирдолгүй түлш найдвартай нийлүүлэх ханган нийлүүлэгч бэлэн байх шаардлагатай. Түүнчлэн насос, усны сав болон түгээх тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай төрөл бүрийн материал бэлэн байна. Дараах асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

   - *Зардал ба түлшний хангалт.* Жолооч нар ус зөөвөрлөх үед замаас хазайлгүй түлшээ цэнэглэх боломжтой байвал илүү үр дүнтэй. Гэхдээ энэ нь түлшийг тусад нь тээвэрлэх, үйл ажиллагааны явцад зохиомлоор хүндрэл үүсгэж болзошгүй. Мөн усны эх үүсвэрийг эргэж харах шаардлагатай болно.
   - *Сэлбэг хэрэгсэл.* Олдоц сайтай, орон нутагт үйлдвэрлэсэн, засварлахад хялбар байвал илүү тохиромжтой.

   Эдгээр асуудлууд нь (ялангуяа засвар үйлчилгээ) ямар төрлийн тээврийн хэрэгслийг сонгон (жишээ нь: ачааны машин эсвэл трактороор ус тээвэрлэх, усны сав чирэх) ус зөөвөрлөх талаар шийдвэр гаргахад нөлөөлнө.

3. **Хангалт хийх замын бүрэн бүтэн байдлыг хангах**. Ачааны усны цистерн явахад боломжтой зам байх ёстой. Өөр зам ашиглах тохиолдолд тэдгээрийг засварлах, үйлчилгээ хийх шаардлага гарна.

4. **Түгээх цэгүүдийг зохион байгуулах.** Малчин усыг түгээх цэгээс авч зөөвөрлөн малаа услах эсвэл малаа туун авчирч усны сав эсвэл усан сангаас шууд услах боломжтой хэлбэрээр зохион байгуулна. Ямар ч тохиолдолд боломжтой бол орон нутгийн усны менежментийн системд тулгуурлан хэрэгцээт хүмүүст эрх тэгш хуваарилах, тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлнэ. (*Усны*

стандарт 1, Зааварчилгаа 3 харна уу). Боломжтой газар ус нөөцлөх байгууламж байгуулах нь усыг хурдан юүлэх, олон удаа рейс хийснээр ус хүлээх цагийг багасгаж зөөвөрлөх үйл ажиллагаа илүү үр дүнтэй болно.

5. **Нүүлгэн шилжүүлсэн мал амьтанд зориулан ус зөөвөрлөх**. Ган гачгийн үед мал амьтныг нүүлгэн шилжүүлэх нь уламжлалт хариу арга хэмжээ юм. (*Бүлэг 6 Тэжээл хангамж, Хайрцаг 6.1* харна уу).Ийм тохиолдолд ус зөөвөрлөх үйл ажиллагааг нүүлгэн шилжүүлэлттэй уялдуулах шаардлагатай. Энэ нь ус зөөвөрлөх үйл ажиллагааг илүү цогц хэлбэрээр зохион байгуулахыг шаарддаг.

6. **Аюулгүй түгээх сүлжээ бий болгох**. Гамшгийн үеийн тусламжийн хөтөлбөрт ус зөөвөрлөх үйл ажиллагаанд оролцох хүмүүсийн хувийн аюулгүй байдалд үүсэх эрсдлийг тооцох нь ямагт чухлаар тавигддаг. (*Бүлэг 6, Тэжээл хангамж , Тэжээлийн стандарт 4, Зааварчилгаа 5* харна уу).

Усаар хангах үйл ажиллагааны ***жишээ судалгаа***

7.1 Үйл явцын жишээ судалгаа: Этиоп дахь усан станцын үр нөлөө

Зүүн Африкийн Хөгжлийн үйл ажиллагаа ТББ нь Зүүн Этиопын Боранийн бэлчээрийн газар нутагт усан станцуудыг байгуулсан байна. Энэхүү станцуудаас ус нийлүүлэх үйл ажиллагаа нь маш амжилттай болсон бөгөөд сүүлийн жилүүдэд ган гачигт нэрвэгдсэн газар нутагт олон тооны мал амьтныг амьд үлдээхэд дэмжлэг үзүүлсэн. Гэвч энэхүү амжилтад хүрэхэд тодорхой гарз хохирол амссан юм. Усны станцын орчим мал амьтан ихээр бөөгнөрснөөс тэжээлийн хомсдол бий болсон. Ингэснээр цаашид баялаг бэлчээр бүхий газар нутагт усан станцуудыг байгуулах замаар үүсэж болох асуудлыг шийдвэрлэх шаардлага бий болсон. Түүнчлэн хөтөлбөрийн ус, тэжээлээр хангах бусад үйл ажиллагааг нь тухайн мал амьтан хангалттай хэмжээний тэжээл, усаар хангагдах нөхцлийг бүрдүүлэхэд чиглүүлэх шаардлага гарсан байна (*Эх сурвалж: IRIN News*).

7.2 Үйл явцын жишээ,судалгаа: Сомали дахь ган гачигийг даван туулахад ус зөөвөрлөх ажиллагаа

VETAID-ээс Сомалийн хамгийн их ган гачигт нэрвэгдсэн Жедо, Бари, Каркаар бүсүүдийн малчдад ус зөөвөрлөн хүргэж тэднийг дэмжих зорилгоор НҮБ-ийн Хүмүүнлэгийн Ажлыг Зохицуулах Албанаас санхүүжилт авсан байна. Жедод хэрэгжүүлсэн төслөөр Бардера, Элвак дүүргийн бэлчээрийг үр ашигтай ашиглуулах зорилгоор үржлийн 2,500 үхэр, болон 1,100 хонь ямаанд ус зөөвөрлөж өгсөн байна. Энэхүү оролцоо нь хүмүүст малаа нөөцлөх боломж олгохоос гадна хамгийн чухал үржлийн малаа авч үлдэх замаар ган гачигийн хямралыг хурдан даван туулахад тусалдаг байна. Мөн түүнчлэн усны нөөцийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах чиглэлээр VETAID нь усны нөөцлүүрийн бүтцийг сэргээн босгох болон худаг,далангаас малын сэг зэмийг зайлуулах ажлуудыг хийсэн байна (Эх сурвалж: VETAID төслийн бичиг баримт).

7.3 Үйл явцын жишээ,судалгаа: Пакистан дахь усан хангамжийн дэд бүтцийг бэхжүүлэх хөтөлбөр

2000 онд Пакистанд болсон ган гачигийн үеэр мал амьтанд үзүүлж буй хор хөнөөлийг бууруулах зорилгоор төр, хувийн хэвшил, ТББ-ын

салбаруудыг оролцуулсан олон тооны санаачлагуудыг хэрэгжүүлсэн. Чолистаны Хөгжлийн Албанаас нарны эрчим хүчээр ажилладаг шахуурга бүхий усны худагаар хангах ажлыг ихээхэн дэмжиж ажилласан. Энэхүү санаачлагын хүрээнд ган гачигаас болж хүнд хэцүү байдалтай болсон малчдад тусламж үзүүлэх зорилгоор Чолистан Цөл-ийн 6 акр талбайд ундны усны станцуудыг байгуулсан. Энэ бол улсын зарим газар нутагт амьдарч буй хүн ардын 50-иас илүү хувьд нь нөлөөлсөн ган гачигтай тэмцэж буй ажлын нэг гол илэрхийлэл байсан юм. Энэхүү ган гачигийн эсрэг арга хэмжээнд зэвсэгт хүчнийхэн мөн оролцсон бөгөөд Панжабын хамгаалагч нар өөрсдийн хилийн заставын ойролцоо 6 тунгалаг уст худаг болон 60 усаа өөрөө цэвэршүүлдэг усны хангамжийн системийг байгуулсан байна. Ингэснээр ойролцоогоор 500 гаруй малчид болон мал амьтныг 70 усны станцаар дамжуулан хангах боломжтой болсон (*Эх сурвалж: IJGlobal, 2000*).

7.4 Үйл явцын жишээ судалгаа: Судан дахь хафир даланг ашиглан мал амьтныг усаар хангасан нь

Суданы Хойд Дафтур муж ган гачиг, өлсгөлөнд нэрвэгдсэн түүхтэй. Өнгөрсөн арван жилийн хугацаанд Хойд Дафтурт нийлмэл онцгой нөхцөл байдал үүсэж, урьд өмнө байгаагүй их хэмжээний олон улсын хүмүүнлэгийн тусламжийг авсан. Бүх амьжиргааны систем гамшигт нэрвэгдэж, ялангуяа нүүлгэн шилжүүлэлтийн явцад ихэнх хүмүүс мал сүргээ алдсан байна. Түүнчлэн малчид, фермер гэх мэт бусад төрлийн мал аж ахуйн үйлдвэрлэгчид мөн адил гамшигт өртсөн.

Хафир бол үхэр болон бусад төрлийн мал амьтанд зориулан гадаргын ус цуглуулах зориулалтаар барьсан далан юм. Олон улсын хамтын ажиллагаа ТББ (COOPI) мал амьтныг усаар хангах ажиллагааг усны салбарын үйл ажиллагааны нэг хэсэг болгох зорилгоор хафирыг байгуулахад дэмжлэг үзүүлсэн байна. Олон нийтийн бүлгүүдийн хооронд үүсэх зөрчлөөс сэргийлэн Хафир далангийн байршлыг орон нутгийнхантай харилцан тохиролцсоны үндсэн дээр сонгосон. COOPI "ямар ч хохиролгүй хийх» ба "зөрчил-мэдрэмж» хандлагын дагуу далан барих газрын сонголт болон хафир далан тус бүрийг цаашид ашиглах менежментийн асуудалд орон нутгийн бүх төрлийн бүлгүүдийг эрх тэгш оролцуулж, зөвлөгөө авсан. Жишээ нь: далангийн газар дээр мал амьтан бэлчээрлүүлэх, бусад амьжиргааны үйл ажиллагааг явуулахаар бол нийгмийн бүлгүүдийн ашиглах хил хязгаарыг тогтоож өгөх Хафирыг

барихаас өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийж, барилгын төлөвлөгөөг батлуулсан. Судан дахь НҮБ мэдээлснээр хафир нь механикжсан барилгын үндсэн зарчимд нийцэж байсан. (UNOPS, өдөр тодорхойгүй). Тухайн үед Суданы Үндэсний усны бодлого төслийн шатандаа байсан хэдий ч хафирт хамааралтай Үндэсний усан хангамж, эрүүл ахуйн бодлого 2009 онд батлагдаж хэрэглэх боломжтой болсон. Мөн Олон нийтийн усны корпорациас засгийн газраас гаргасан холбогдох зааврыг авах боломжтой байсан бөгөөд тэдгээрийг усны төрөл бүрийн арга хэмжээ хэрэгжүүлэхдээ удирдамж болгон ашигласан (*Эх сурвалж: Gebruetal. 2013*).

7.5 Үр нөлөөний жишээ судалгаа: Кени дэх усаар хангах ажлын хөлсөнд бэлэн мөнгө олгох ажиллагаа

2011 онд Хойд Кенийн хуурай, хагас хуурай газар нутгийн нүүдэлчин айл өрхүүд олон жилийн ган гачиг, сонгуулийн дараах хүчирхийлэл, өндөр үнэ бүхий хүнс, шатахуун, El Nico холбоотой үер зэргийг даван туулж, сэргэх шатандаа байна. Бэлчээр, усны хомсдолын улмаас мал амьтны биеийн байдал доройтож, үхэж хорогдсон.Тухайн үед усны цооногууд байнга эвдэрч, орон нутагт ус авах гэж урт дараалал үүсэж, хэвийн ажиллагаатай цөөн тооны уст цэгүүдээс хүн ам, мал амьтныг усны хэрэгцээг хангахад хүндрэлтэй болж зөрчил үүсгэхэд хүргэсэн байна. Мал амьтны гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөн идэвхжиж, сүүний гарц буурсан. Хүнсний бүтээгдэхүүн үнэ байнга өсөж, мал амьтны үнэ буурснаар хүнсний олдоц, хүртээмж улам муудсан.

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн хөтөлбөрийн дэмжлэгтэй Хуурай ба Зах хязгаарын газар нутгийг сэргээх консорциум (Arid and Marginal Lands Recovery Consortium), Өлсгөлөнгийн эсрэг үйл ажиллагааг (ACF) байгууллагууд нь Хойд Кенийн Исиоло мужийн Мерти, Гарбатулла дүүрэгт хуурай улирлын голлох бэлчээрийг хамгаалах, мал амьтны усан хангамжийг сайжруулах чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

Газрын зураглал гаргах дасгал хийх, голлох нүүдлийн зам дагуух үйл ажиллагаа нь зогссон уламжлалт бэлчээр ашиглалтын зөвлөлийг сэргээн ажиллуулснаас гадна мал амьтанд зориулсан уст цэгийг сэргээн засварлах, шинээр байгуулахад ажлын хөлсөнд бэлэн мөнгө олгох (CFW) хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Хөтөлбөрт ган гачгийн улмаас мал сүргээ алдсан эмзэг бүлгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг тэгш оролцуулсан.

Ажлын хөлсөнд бэлэн мөнгө олгох (CFW)-доо барилгын ажилд орон нутагт үйлдвэрлэсэн барилгын материалыг ашиглаж, нутгийн хүмүүсийг ажиллуулсан байна. Бэлчээрийн менежмент, усны зөвлөлийг сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлж, бэлчээр зохион байгууллалтын төлөвлөгөө гаргаж өгсөн.

Хөтөлбөрийн эцсийн үнэлгээнд дурдсанаар, услуур, худаг, цооног, усны нөөцлүүр танк, усалгааны цэг (мал услахад зориулсан шуудуу) гэх мэт усны эх үүсвэрүүдийг сэргээн засварласан эсвэл шинээр байгуулснаар ойролцоогоор 186440 мал амьтан, 40845 мал аж ахуй эрхлэгчид хөтөлбөрийн үр шимийг хүртэсний зэрэгцээ 1359 хүн ажлынхаа хөлсөнд бэлэн мөнгө авах хөтөлбөрт хамрагдаж уст цэгийг сэргээн засварлах болон шинээр байгуулах ажилд оролцсон байна. Ажлын хөлсөнд бэлэн мөнгө олгох хөтөлбөр нь нэн даруй тусламж шаардлагатай айл өрхүүдэд зориулсан уст цэгүүдийг хамгийн түрүүнд сэргээн засварлах эсвэл шинээр байгуулснаар айл өрхүүд сүүний үнээгээ суурин газрын ойролцоо маллаж, хүүхдүүдийг сүүгээр хангах, илүү гарсныг борлуулж ашиг олох нөхцлийг бүрдүүлсэн. Түүнчлэн уст цэгүүд болон бэлчээрийн менежмент нь бэлчээрийн мал аж ахуй зах зээлд нэвтрэх, малчин тогтмол ашиг орлоготой болоход нь хувь нэмрээ оруулсан. Энэхүү хөтөлбөрийн туршлагаас харахад онцгой байдлын үед ч гэсэн ямар нэгэн арга хэмжээ нь мал аж ахуйг зохистой удирдах орон нутгийн чадавхийг бий болгох, хөгжүүлэхэд чиглүүлэх шаардлагатайг харуулж байна. Тухайлбал, орон нутгийн болон уугуул иргэдийн бэлчээр, ус ашиглалтын бүтэц, мэдлэг туршлагыг ашигласнаар илүү бодитой, богино хугацаанд яаралтай тусламжийг үзүүлж чадна. Жишээ нь мал амьтны тоо толгойг бууруулах, эсвэл тэжээл, ус тараахад үр дүнтэй. Бэлэн мөнгө нь дээрх зорилгод нэгэн зэрэг хүрэх чухал арга хэрэгсэл юм (*Эх сурвалж: Daniel Nyabera, Muriel Calo and Charles Matemo, personal communication, 2014)*.

Хавсралт 7.1: Уст цэгүүдийн шуурхай үнэлгээний хуудас

Энэхүү үнэлгээний хуудсанд онцгой нөхцөл байдлын үед мал бүхий иргэдэд зориулан ашиглаж болох уст цэгүүдийг үнэлэхэд авч үзэх шаардлагатай асуудлуудыг нэгтгэн харуулсан болно. Энэхүү шалгах хуудасны асуултанд хариу өгөх мэдээллийн эх сурвалж нь орон нутгийн түргэвчилсэн үнэлгээ (зарчмын хувьд наад зах нь), усны чанарын лабораторийн шинжилгээний дүнгээс хамааран өөр өөр байж болно. Энэ нь тухайн орон нутгийн янз бүрийн оролцогч талуудын санал бодлыг тусгасан байна.

Усны хангамж

- Уст цэгээс одоогийн нөхцөлд ус гарч байгаа юу?
- Хэрвээ тийм бол:
  - Онцгой байдлын хариу арга хэмжээний үед уст цэгийн ус ширгэх эрсдэлтэй юу?
  - Орон нутгийн мал амьтныг услах уст цэг ямар хүчин чадалтай вэ?
- Хэрвээ үгүй бол:
  - Орон нутгийн мал амьтны усны хэрэгцээг хангахын тулд дээрх уст цэгийг техникийн (зардал, цаг хугацааны аль алины) хувьд сэргээн засварлах боломжтой юу ?
  - Уст цэгийг сэргээн засварлах ажлыг зохион байгуулах хэрэгжүүлэх хүн хүч хүрэлцээтэй юу ?

Хүртээмж

- Нэрвэгдсэн мал амьтны шаардлагатай хэсэг нь хялбар хүрэх боломжтой юу?
- Уст цэгийг мал услах зориулалтаар ашиглахад нийгэм, ёс заншил, уламжлал эсвэл улс төртэй холбоотой бэрхшээл байгаа юу?
- Эх үүсвэрээс хангах ус нь мал бүхий иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэх боломжтой юу ? (Нас, хүйс, угсаа гарал эсвэл баян эсэхээс үл хамаарна)
- Нэрвэгдсэн мал амьтанд уст цэгийг дараах нөхцөл үүсгэхгүйгээр

ашиглаж болох уу?:

- Үндсэн хэрэглэгчдийн хэрэглээнд асуудал үүсгэх үү (хүн ам эсвэл мал амьтан)?
- Мал бүхий иргэдийн хувийн аюулгүй байдалд эрсдэл үүсэх үү?
- Хүмүүнлэгийн тусламжийн бусад асуудалд саад учруулах уу?

Усны чанар

- Эх үүсвэрийн усны чанарт шаардлагатай шинжилгээг (хээрийн нөхцөлд эсвэл лабораторид) хийх боломжтой юу ?
- Хэрвээ тийм бол:
  - Лабораторид шинжлэх боломжтой бол ямар төрлийн химийн бодисуудыг тодорхойлж чадах вэ?
  - Шинжилгээний цомог байгаа бол уст цэг/усны эх үүсвэрт ашиглахаар төлөвлөж байгаа юу?
  - Усны эх үүсвэрт бичил биетний бохирдлыг үнэлэх зохих шаардлага хангасан техникийн ажилтан тухайн орон нутагт байгаа юу?
- Хэрвээ үгүй бол, дараах асуултууд газар дээр нь шуурхай үнэлгээ хийхэд дэмжлэг болно. Үүнд:
  - Усны эх үүсвэр тунгалаг эсвэл булингартсан байна уу?
  - Тухайн газар нутагт давсжилт үүссэн нотолгоо байна уу? (жишээ нь: саванд давсны үлдэгдэл үүссэн үү)?
  - Химийн бохирдолыг илэрхийлэх ямар нэгэн орон нутгийн нөхцөл байна уу? (жишээ нь: бордоо, пестицид хэрэглэж байсан, арьс ширний эсвэл хөнгөн аж үйлдвэрийн жижиг үйлдвэрүүд байгаа юу)?
  - Эх үүсвэрт хамааралтай усаар халдварласан өвчний ямар нэгэн тохиолдол гарсан уу?

Хавсралт 7.2: Усаар хангах ажиллагааны мониторинг ба үнэлгээний шалгуур үзүүлэлтийн жишээ

	Үйл явцын шалгуур *(үзүүлэлт болж байгаа үйл ажиллагааг хэмжих)*	**Үр нөлөөний шалгуур *(үзүүлэлт болж байгаа үйл ажиллагааны үр дүнг хэмжих)***
Системийг загварчлах	• Орон нутгийн иргэд, тэдний төлөөлөл болон оролцогч талуудтай хийсэн уулзалтын тоо (шаардлагатай үед хувийн хэвшлийн нийлүүлэгч тал)	• Усаар хангах хувилбарт дүн шинжилгээг тусгасан уулзалтын тэмдэглэл • Үйл ажиллагааны төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгасан байна. Үүнд: – Янз бүрийн оролцогчдын үүрэг ба хариуцлага – Усаар хангах арга хандлага, одоогийн байгаа эх үүсвэрийг сэргээн засварлах, шинээр байгуулах – Уст цэгүүдийг сэргээн засварлах эсвэл шинээр байгуулахад орон нутгийн иргэдийн оролцоо
Усаар хангах	• Төрөл тус бүрээр сэргээн засварласан эсвэл шинээр байгуулсан уст цэгийн тоо ба байршил • Уст цэгийн нийлүүлэх хүчин чадал • Зөөвөрлөсөн усны хэмжээ	• Хэрэглэгч, ялангуяа эмзэг бүлэг тэдний мал амьтанд усанд хүрэх боломж (ус хүртэлх бодит зай) • Усны хүртээмж –мал амьтны хэрэгцээнд хангалттай • Усны чанар – мал амьтанд тохиромжтой • Уст цэгийг ашигласан мал бүхий айл өрхийн тоог мал амьтанд нь ус шаардлагатай байгаа мал бүхий айл өрхийн тоонд харьцуулах; үзүүлэлтийг эмзэг бүлгээр нарийвчлан гаргах • Уст цэг ашигласан мал амьтны тоо, төрлөөр; усласан давтамж • Мал амьтандаа ус авахаар ирсэн эмэгтэйчүүд, охидуудын тооны өсөлт ба бууралт • Бодлогод нөлөөлсөн байдал

LEGS-н үнэлгээний арга хэрэгслийг доорх холбоосоор орж LEGS веб хуудаснаас үзэх боломжтой: <http://www.livestock-emergency.net/resources/general-resources-legs-specific/>.

Ашигласан хэвлэл ба цаашид уншиж судлах материал

Gebru, G., Yousif, H., Mohamed, A., Negesse, B. and Young, H. (2013) *Livestock, Livelihoods, and Disaster Response, Part Two:Three Case Studies of Livestock Emergency Programmes in Sudan, and Lessons Learned*, Feinstein International Center, Tufts University, Medford, MA, <http://fic.tufts.edu/publication-item/ livestock-livelihoods-and-disaster-response-part-two-2/> [accessed 16 May 2014].

House,S.andReed,R.(2004)*EmergencyWaterSources–Guidelines for Selection and treatment*, 3rdedn, Water, Engineering and Development Centre (WEDC), Loughborough, <https://wedc-knowledge.lboro.ac.uk/details.html?id=18064>[accessed16May2014].

IJGlobal (2000) "Solar-powered pumps for drinking water provision", <http://www. ijonline.com/articles/1874>.

Markwick,G.I.(2007)*WaterRequirementsforSheepandCattle*,Prime-Fact326,New South Wales Department of Primary Industries, New South Wales.Available from: <http://www.livestock-emergency.net/resources/water-supply-2/> [accessed16May2014].

Reed,R.andShaw,R.J.(1995)"Emergencywatersupply",TechnicalBriefNo.44, in*Waterlines*,Vol.13,No.4,ITPublications,London,<http://www.lboro.ac.uk/well/resources/technical-briefs/44-emergency-water-supply.pdf> [accessed 23 May2014].

UNOPS(UnitedNationsOfficeforProjectServices)(undated)*AnnexItoITBsection VSchedule2–ScopeofWorksConstructionofMechanizedHafir:Technical Specification*, UNOPS, Copenhagen, <https://www.unops.org/ApplyBO/File.aspx/Annex%20I%20to%20ITB%20Section%20V%20Schedule%202%20%E2%80%93Scope%20of%20Works.pdf?AttachmentID=18b83c9d-13e9- 47b6-a127-b2c540aa54bc> [accessed 16 May2014].

WEDC, Loughborough University (2011a) "Cleaning and disinfecting wells in emergencies", *Technical Notes on Drinking-Water, Sanitation and Hygiene inEmergencies*,Number1,WorldHealthOrganization(WHO),Geneva,<http://www.who.int/water_sanitation_health/hygiene/envsan/technotes/en/> [accessed16May2014].

WEDC, Loughborough University (2011b) "Cleaning and disinfecting boreholes in emergencies", *WHO Technical Notes on Drinking-Water, Sanitation and Hygiene in Emergencies*, Number 2, WHO, Geneva, <http://www.who.int/ water_sanitation_health/hygiene/envsan/technotes/en/> [accessed 16 May 2014].

WEDC, Loughborough University (2011c) "Delivering safe water by tanker", *WHO Technical Notes on Drinking-Water, Sanitation and Hygiene inEmergencies*, Number 12, WHO, Geneva, <http://www.who.int/water_sanitation_health/ hygiene/envsan/technotes/en/>[accessed-16May2014].

Санамж

1. Бүлэг *3, Үнэлгээний асуумж дахь Нөхцөл байдлын үнэлгээ* харна

БҮЛЭГ 8

Мал амьтны хашаа хороо ба байршуулалтын техникийн стандарт

Мал амьтны хашаа хороо ба байршуулалт

Танилцуулга

Энэхүү бүлэгт онцгой байдлын хариу арга хэмжээний үед мал амьтныг хашаа хороо, байршуулах боломжоор хангахын ач холбогдол, хашаа хороогоор хангах хувилбар болон түүнийг хэрэгжүүлэх оновчтой арга хэрэгслийн хамтаар нь танилцуулах болно. Энд дурдагдах стандарт, үндсэн үйл ажиллагаа, зааварчилгааг хувилбар тус бүрт дагаж мөрдөнө. Энэ бүлгийн төгсгөлд жишээг харж болно. Анхдагч үнэлгээ, мониторинг хийхэд ашиглах шалгах хуудсыг дагалдуулсан. Ашигласан хэвлэлийн жагсаалтыг бүлгийн төгсгөлд нь хавсаргав.

LEGS –н амьжиргааг дэмжих зорилттой холбогдох нь

Малын хашаа хороо нь гамшгийн үед мал амьтан амьд үлдэхэд амин чухал хэрэгсэл юм. Мал амьтныг хашаа хороогоор хангах нь гамшигт нэрвэгдсэн айл өрх ялангуяа гамшигт нэрвэгдсэн бүс нутгийн мал амьтан нь амьжиргааны гол хэрэгсэл болсон айл өрх, тэдэнд үлдсэн мал амьтныг хамгаалахад чиглэгддэг тул LEGS-н амьжиргааг дэмжих хоёр дахь зорилттой шууд хамааралтай.

Онцгой байдлын үед мал амьтны хашаа хороо, байршуулалтын ач холбогдол

Байгалийн гамшиг эсвэл зэвсэгт мөргөлдөөний дараа малчид хамгийн түрүүнд мал амьтныхаа аюулгүй байдал, хамгаалалт, тавлаг байдалд санаа зовдог. Ихэнх тохиолдолд малчин өөрийн мал амьтанд хэрэгцээтэй хашаа хороог нэн тэргүүнд авч үздэг бөгөөд тусламжийн байгууллага нь дэмжлэг үзүүлэх эсэхийг анхааран үздэггүй. Жишээ нь:

- Дүрвэгсэд өөрсдийн орон гэрт зориулан тараасан материалыг мал амьтандаа хашаа хороо барихад ашигладаг.
- 1999 онд Косовод болсон мөргөлдөөний улмаас орон гэр нь сүйрсэн, хүйтэн цаг агаарт тохиромжтой гэр орноор хангах боломжгүй байсан учраас айл өрхүүд малынхаа хороонд амьдарч байсан. Өвлийн хүйтэн шөнө малтайгаа хамт байснаар бие нь дулаацдаг байжээ. Ингэж хамт байснаар үндсэн хөрөнгө болох малаа хулгайд алдахаас сэргийлэх боломжтой байсан байна (*A.Porter, хувийн мэдээлэл, 2008*).
- Бангладешид олон газар гол ба далайн усны үерт автдаг тул *килла*

буюу мал амьтан хамгаалах зориулалттай өргөн, нягтшил сайтай шороон даланг байгуулсан бөгөөд үерийн түгшүүр өгөхөд мал амьтныг энэ газарт туун аваачдаг байна. Орон нутгийн иргэдэд зориулан циклоноос хоргодох байр *килла*-гийн хажууд байгуулж, хүн, мал амьтныг хамтад нь хамгаалах боломжтой болсон. Ийм төрлийн байгууламж байхгүй байхад зарим хүмүүс өөрсдөдөө зориулан хоргодох хороо барихаас татгалздаг байсан байна. (BUET/BIDS,1993)

Малчдад тэдний мал амьтныг хамгаалах хашаа хороо чухал асуудал хэдий ч онцгой байдлын хариу арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэгт ордог нийтлэг асуудал биш, энэ төрлийн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн жишээ хязгаарлагдмал байдаг.

Онцгой байдлын үед мал амьтны хашаа хороог засаж сэлбэх эсвэл шинээр барих ажиллагаа хэрэгжүүлэх нь зохистой гэдгийг харуулах олон жишээнүүд бий. Тухайлбал:

- өмнө нь мал маллаж байсан хашаа хороо үгүй болдог. Жишээ нь: үер, газар хөдлөлтийн улмаас хашаа хороо эвдэрч сүйрдэг .
- онцгой байдлын улмаас малын эзнийг нүүлгэн шилжүүлэх үед мал амьтны хуучин хашаа хороог хэрэглэх боломжгүй эсвэл шилжин очсон нутагт шинээр барих шаардлага үүсдэг. Жишээ нь: хуаранд шилжин суурьших үед
- хашаа хороогүй мал амьтанд цаг агаарын тааламжгүй нөхцөл, (хэт халуун эсвэл хүйтэн) мөргөлдөөн, аюулгүй байдал алдагдах үед шинээр хашаа хороо барих шаардлага гардаг.
- хариу арга хэмжээний нэг хэсэг болгон мал амьтан тараах үед тэднийг цаг агаарын тааламжгүй нөхцөл, хулгай эсвэл араатан амьтдаас хамгаалахын тулд хашаа хороогоор хангах шаардлага гардаг.

Гамшгийн хариу арга хэмжээний нэг хэсэг болгон мал амьтныг хашаа хороогоор хангах нь *Танилцуулга бүлэгт* дурдсан малын тавлаг байдлын "таван эрх чөлөө" хэсгийн Тохь тухгүй байдлаас ангид байлгах – хашаа, хороо, амрахад тохиромжтой газар бүхий орчин нөхцлөөр хангагдах зарчимд хувь нэмрээ оруулна.

Энэ бүлэгт мал амьтныг хашаа хороогоор хангах, байршуулахтай холбоотой асуудлын талаар өгүүлэх болно. Малын хашаа хороо гэдэг нь мал амьтан амьд үлдэх, цаг агаарын гэнэтийн өөрчлөлт, араатан амьтад,

хулгайгаас хамгаалахад зориулсан, түр зуурын эсвэл урт хугацаанд ашиглах биет бүтэц юм (энэ бүлгийн төгсгөлд *Жишээ судалгаа 8.3* харна уу). Мал амьтныг хашаа хороогоор хангахад хүн ам байршуулахад шаардах нөхцөлийг ашиглана. Байршуулалт гэдэг нь байгаль орчны хувьд илүү өргөн хүрээг хамарсан ойлголт бөгөөд мал амьтан шилжсэн, өмнөх хашаа хороог сэлбэх боломжгүй үед мал амьтныг хашаа хороогоор хангахад дэмжлэг үзүүлэхийг хэлнэ. Жишээ нь: 2005 онд Пакистанд болсон газар хөлдөлтийн үед хариу арга хэмжээг хэрэгжүүлэхдээ өндөр уулын бүсэд маллаж байгаа мал амьтан цочир хүйтрэлд өртөх, тэжээлийн дутагдалд орох эрсдэлтэй байсан тул тэдэнд зориулан хашаа хороо барьсан бөгөөд малчид уулнаас бууж малаа маллах боломжоор хангагдсан байна. Гэвч зарим малчид гэр орон, газар болон хөрөнгөө алдахаас айж ууландаа үлджээ (*P. Manfield, хувийн мэдээлэл, 2008*).

Sphere гарын авлагад хүн амыг байршуулах талаар нарийвчлан заасан. Энэ бүлэг нь мал амьтныг байршуулахтай холбоотой газрын эрх, байгаль орчны менежмент, барилга байгууламж, хуаран байгуулах дэд бүтцийг төлөвлөх, загварчлах зэрэг асуудлуудад илүү анхаарсан (дор дурдсан, *Үйл явцын жишээ судалгаа 8.4* харна уу)

Мал амьтныг хашаа хороогоор хангах, байршуулах хувилбарууд

Мал амьтныг хашаа хороогоор хангах, байршуулах хэрэгцээ, шаардлага нь гамшигт нэрвэгдсэн хүн амын нөхцөл байдлаас шалтгаална. Sphere гарын авлагад зааснаар онцгой байдлын улмаас хүн амын суурьшилтай холбоотой дараах нөхцөл байдал үүсдэг. Үүнд: нэрвэгдсэн хүн ам дүрвэсэн эсвэл тухайн газар нутагтаа үлдсэн, тэд түр зуурын эсвэл шилжилтийн байранд амьдардаг, эдгээр байрыг сэлбэх, дахин барих шаардлага үүссэн, эсвэл үүсээгүй (Sphere, 2011:245).

Суурьшил гэдгийг эхлээд сайтар ойлгох хэрэгтэй ба энэ нь мал амьтныг хашаа хороогоор хангах үр дагаврыг үүсгэдэг. Жишээ нь, малчид хүнд нөхцөлтэй газар суурьшсан бол (хулгай дээрэм ихтэй, эсвэл бэлчээр, усны хүртээмж муу), мал амьтныг түр зуурын хашаа хороогоор хангах шаардлагатай.

Мал амьтныг хашаа хороогоор хангах нь ихэвчлэн гэнэтийн гамшиг болох үер, газар хөдлөлт, цочир хүйтрэх үед мал амьтныг цаг агаарын гэнэтийн өөрчлөлт, хулгай, араатан амьтдаас хамгаалах шаардлагаас

үүдэн гардаг. Гэвч үргэлжилсэн мөргөлдөөн, ган гачгийн улмаас малчид шилжин суурьших тохиолдолд тэдний мал амьтныг хашаа хороогоор хангах шаардлагатай болдог (*Үйл явцын жишээ судалгаа 8.4* харна уу).

Энэ бүлэгт дээрх тодорхойлолтод тулгуурлан хоёр төрлийн хувилбарыг харуулав. Үүнд: байршуулалт ба мал амьтныг хашаа хороогоор хангах. Эдгээр нь түр зуурын эсвэл удаан хугацаанд ашиглах зориулалттай байж болно.

Хувилбар 1: Мал амьтны байршуулалт

Мал амьтныг байршуулах арга хэмжээ нь малын хашаа хороо нэмж барих, ялангуяа шилжин суурьшсан хүн амд дэмжлэг үзүүлэхэд чухал ач холбогдолтой дараах арга хэмжээнээс бүрдэнэ. Үүнд:

- газрын эрх эсвэл бэлчээр, хашаа хороо ашиглах талаар хэлэлцээ хийх, бусад төрлийн бодлогын асуудалд дэмжлэг үзүүлэх
- газар нутгийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, хуарангийн менежертэй хамтран дүрвэгсдийн мал амьтныг байршуулах арга хэмжээ авах
- дүрвэгсдийн мал амьтанд шаардлагатай дэд бүтцээр хангах
- хүний болон малын эрүүл мэндийг хамгаалахын тулд хуарангийн хүн малын хэрэгцээг хангахад байгаль орчны менежментийн асуудлыг авч үзэх.

Хувилбар 2: Мал амьтны хашаа хороо

Мал амьтныг хашаа хороогоор хангах түр зуурын болон урт хугацааны арга хэмжээ хэрэгцээ шаардлага болон онцгой байдлын нөхцөл байдлаас шалтгаалан янз бүрийн хэлбэрээр хийгдэж болно. Жишээ нь:

- хашаа хороо сэлбэх, засварлах эсвэл шинээр барих (барилгачид, байгууллагууд эсвэл шууд оролцогч талууд)
- хашаа хороо барихад мал өмчлөгч иргэдийг материалаар хангах. Хүн амд зориулан байр, сууц барих материалаар хангаж, хаягдлаар нь малын хашаа барьж болохыг ойлгуулах
- хүн амыг байр сууцаар хангах хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлэх (хаягдал материалыг мал амьтны хашаа хороо барихад ашиглах гэх мэт)

- хашаа хороо барих сургалт хийх
- хашаа хороо барих хэрэгцээнд тулгуурлан бэлэн мөнгө ба эрхийн бичиг хуваарилах.

Онцгой байдлын улмаас мал амьтныг хашаа хороогоор хангах шаардлага үүссэн газар түр зуурын хашаа хороо барих боломжтой. Үүнийг малчин өөрсдөө эсвэл хөндлөнгийн байгууллагын дэмжлэгтэйгээр барьж болно. Гэвч боломжтой бол урт хугацаанд ашиглаж болох материалаар хийх нь үр дүнтэй бөгөөд байршуулалт хийхдээ газрын эрх болон эзэмшигчдийн талаарх асуудлыг харгалзан үзнэ.

Боломжтой бол мал амьтныг хашаа хороогоор хангах, байршуулах туслалцааг тухайн айл өрх, хүн ам оршин суудаг газар хийх нь зүйтэй. Хэрэв малын эзнийг мал амьтны хамт нүүлгэн шилжүүлсэн бол хашаа хороогоор хангах, байршуулах туслалцааг түр зуурын төлөвлөсөн эсвэл өөрсдөө суурьшсан хуаран зэрэг хүн амьдрахад зориулагдсан бүлэг суурингуудаас тодорхой зайнд тохирох томоохон талбайд, нэгдсэн байдлаар зохион байгуулна.

Энэхүү хувилбаруудын давуу болон сул талыг *Хүснэгт 8.1-д* харуулав.

Хүснэгт 8.1 Мал амьтныг хашаа хороогоор хангах, байршуулалтын давуу ба сул талууд

Хувилбар	Давуу тал	Сул тал/ Бэрхшээл
1. Мал амьтан ба байршуулах үйл ажиллагаа	• Энэ нь хүн амыг олноор байршуулах үед түүнийг загварчлах, төлөвлөх үед мал амьтны болон гамшгийн дараах янз бүрийн нөхцөлд байгаа, хуаран болон нүүлгэн шилжүүлэлтэд ороогүй малын өмчлөгчийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх боломжоор хангана. • Эзэмшигч иргэдтэй үүсэж болох маргаан, зөрчлөөс сэргийлэхэд дэмжлэг үзүүлнэ.	• Онцгой байдлын нөхцөл үе шатаас шалтгаалдаг, хэрэгцээ шаардлагыг нэн даруй хангахад эзэмшигчтэй зөвшилцөх хугацаа хязгаарлагдмал • Хүмүүнлэгийн байгууллагууд нь нэрвэгдсэн хүн амын хувьд мал амьтан нь тэдний үндсэн хөрөнгө учраас мал амьтныг анхаарах нь чухал ач холбогдолтой гэдгийг тэр бүр авч үздэггүй учраас мал амьтныг байршуулах асуудлыг эсэргүүцэх асуудал гардаг.
2.1 Мал амьтны түр зуурын хашаа хороо	• Мал амьтанд шаардлагатай байгаа хашаа хороог шууд барих • Урт хугацааны шийдвэрээс илүү хямд тусдаг	• Хэрвээ урт хугацааны турш байршилд хүрэх боломж, эзэмшлийн асуудлыг харгалзахгүй бол нураах эсвэл дахин барих шаардлага үүсдэг.
2.2 Урт хугацаанд ашиглаж болох мал амьтны хашаа хороо	• Онцгой байдал дуусаны дараа мал өмчлөгч, урт хугацааны турш ашиглах хөрөнгөтэй үлдэх • Урт хугацаанд нөөцийг илүү эдийн засгийн хувьд үр дүнтэй ашиглах	• Түр зуурын хашаа хороог бодвол илүү өртөг өндөртэй • Онцгой байдал дуусаны дараа эргээд оршин сууж байсан газартаа буцах нүүлгэн шилжүүлсэн хүн амд тохиромжгүй

Sphere ба LEGS-н бусад бүлэгтэй холбогдох нь

Мал амьтныг хашаа хороогоор хангах нь бусад бүлэгт тусгасан мал амьтанд чиглэсэн арга хэмжээний нэмэлт бүрэлдэхүүн хэсэг юм. Жишээ нь: онцгой байдлын үед хуаран эсвэл бөөнөөр амьдрах баазад нүүлгэн шилжүүлсэн иргэдийн мал амьтанд чиглэсэн цогц арга хэмжээг тэжээл, (*Бүлэг 6, Тэжээл хангамж*), ус (*Бүлэг 7, Усан хангамж*), мал эмнэлгийн

үйлчилгээний (*Бүлэг 5, Мал эмнэлгийн үйлчилгээ*) хамт төлөвлөх шаардлагатай. Хэрвээ хүйтэн уур амьсгалтай газар нутагт мал амьтныг тараавал түүний өмнө мал амьтан амьд үлдэх, бие махбодын хэвийн үйл ажиллагааг хангахын тулд хашаа хороогоор зайлшгүй хангах шаардлагатай. *(Бүлэг 9, Малжуулах*). Ялангуяа, онцгой байдлын хариу арга хэмжээний үеэр иргэдэд урьд өмнө нь маллаж байгаагүй мал амьтан тараавал тухайн амьтныг маллахад хэрэгцээтэй байр (бусад менежмент)-ын талаар урьдчилж зөвлөгөө өгнө.

Мал амьтны хашаа хороог хүн амын байр сууц, суурьшлаас нь тусдаа байгуулж болохгүй. Зарим тохиолдолд онцгой байдлын үед хүн, мал амьтан аль алинд нь байр хэрэгцээтэй болдог. Хамтад нь зохицуулах арга хэмжээ авснаар хүний амь насыг аварч, амьжиргааг дэмждэг тул энэ нь дунд болон урт хугацаанд хүн, мал амьтан хоёуланд нь сайн үр нөлөө үзүүлдэг. (*Нийтлэг стандарт 8, Бүлэг 2 харна уу*). Энэ бүлгийг Sphere гарын авлагын "Байр, сууц ба хүнсний бус зүйлийн наад захын стандарт" бүлгийн төгсгөлд хавсаргасан хэвлэлийн жагсаалт дахь UN-HCR, 2007, Corsellis and Vitale, 2005 болон бусад холбогдох материалын хамт унших шаардлагатай (Sphere, 2011).

Үйл ажиллагааг хэрэгжүүлэх зохистой хугацаа

Мал амьтныг хашаа хороогоор хангах, байршуулах туслалцааг онцгой байдлын бүх үе шатанд буюу онцгой байдлын үеэс эргэн сэргэх, нөхөн сэргээх болон бусад урт хугацаатай шийдвэрийн үед хэрэгжүүлнэ.

Ямар төрлийн хувилбар илүү оновчтой байх нь гамшгийн нөхцөл байдлаас шалтгаалдаг. Гэнэтийн гамшгийн дараа цаг агаарын гэнэтийн өөрчлөлт эсвэл хулгай, араатан амьтдын дайралтад өртөх эрсдэл өндөр байдаг тул мал амьтныг хашаа хороогоор нэн даруй хангах шаардлагатай байдаг. Жишээ нь: 2005 онд Пакистанд болсон газар хөдлөлтийн үеэр дүрвэгсдийн мал амьтанд зориулсан талбай бүхий (орон нутгийн загварыг ашиглан) түр зуурын байр, сууц барьж өгсөн байна. (UN-Habitatetal., 2008: 65). Ийм түр зуурын арга хэмжээ нь онцгой байдлын сүүлийн шатанд урт хугацааны арга хэмжээ хэрэгжүүлэх хүртэл тогтвортой хэрэглэгддэг. Удаан явцтай онцгой байдлын үед мал амьтныг хашаа хороогоор хангах, байршуулах хэрэгцээг төлөвлөх, бэлтгэх цаг хугацаа илүү хангалттай байдаг учир түр зуурын арга хэмжээг зөвхөн онцгой байдлын үе шатанд хэрэгжүүлдэг (*Хүснэгт 8.2*). Жишээ нь:

Мөргөлдөөнөөс болж Өмнөд Суданы дүрвэгсэд Этиопын дүрвэгсдийн хуаранд хэдэн зуун мянган малтай хамт ирсэн тул тэдгээрийг хашаа хороогоор яаралтай хангах шаардлага үүссэн байна (UN-Habitatetal., 2012:24–26).

Хүснэгт 8.2 Мал амьтныг хашаа хороогоор хангах, байршуулалт хийх зохистой хугацаа

Хувилбар	Гэнэтийн гамшиг			Удаан явцтой гамшиг			
	Гэнэтийн хор хохирол	Эрт үеийн нөхөн сэргээлт	Нөхөн сэргээлт	Сэрэмжлүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээлт
1.Байршуулах үйл ажиллагаа	→	→	→	→	→	→	→
2.1 Түр зуурын хашаа хороо	→				→		
2.2 Урт хугацаанд ашиглах хашаа хороо	- - - - →				→	→	→

Нийтлэг болон харгалзан үзэх бусад асуудлууд

Хүйсийн асуудал ба нийгмийн тэгш байдал

Онцгой байдлын үед мал амьтныг хашаа хороогоор хангах, байршуулах арга хэмжээнд тухайн нийгэмд мал амьтныг маллаж байгаа хүмүүсийн одоогийн үүрэг, хөдөлмөрийн хуваарилалт нас, хүйс, малын хашаа хүний орон сууцтай ойр байх мэт уламжлалт мал маллагааны хэм хэмжээг анхааран үзнэ. Барилгын ажилд хүйсийн оролцоог анхаарахаас гадна бусад арга хэмжээг хэрэгжүүлэхдээ энэ асуудлыг авч үзнэ. Хашаа хорооны загвар гаргах, барих, байршуулах ажлыг төлөвлөхдөө эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг тэгш оролцуулна. Тэдгээр нь гол хэрэглэгчид байж болно.

Малын хашаа хорооны байршил нь эмзэг бүлгийнхэн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдэд чухал байдаг. Малын хашаандаа очиход хүн амын суурин газраас хүрэх зай, үүсэж болох аюул, эсвэл үер мэтийн байгалийн аюултай үзэгдэл үргэлжлэх зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг. Ингэснээр малаас сүү, өндөг зэрэг бүтээгдэхүүнээ авч чадахгүй байдалд хүргэдэг. Ялангуяа, хүүхэд, өндөр настан, өвчтэй, ХДХВ өвчилсөн хүмүүс гэх мэт эмзэг бүлгийнхэнд нөлөөлнө.

Хамгаалалт

Малын хашаа хорооны байрлал, бэлчээр/тэжээлд хүрэх зай зэрэг байршуулалтын асуудал нь мал бүхий иргэдийг хамгаалахад нөлөөлдөг. Жишээ нь: мөргөлдөөний бүс нутагт малын хашаа хороо нь хүн амын суурин газраас хол зайтай байх нь эмэгтэйчүүд, хүүхдүүдийн хувьд эрсдэлтэй байдаг. Алслагдсан бүс нутагт хашаа хороо барих үед эмэгтэйчүүд барилгын материал хайх шаардлага гарвал тэднийг хамгаалах асуудал хөндөгдөнө.

Байгаль орчин

Малын хашаа хороо барих, байршуулалтын дэд бүтцийг төлөвлөхөд байгаль орчны асуудлыг анхаарна. Хэрэв мал амьтныг олноор маллах хашаа хороо байгуулбал энэ нь бэлчээр ашиглалтад нөлөөлж байгаль орчинд хор хохирол учруулдаг. Мал олноор суурьшсан эсвэл суурин газрын ойролцоо маллах нь малын хаягдлаас үүдэн хүн амын эрүүл мэнд, эрүүл ахуйн нөхцөл алдагддаг. Барилгын ажилд орон нутгийн материалыг их хэмжээгээр ашигласнаар байгаль орчинд сөргөөр нөлөөлдөг. Эдгээр асуудал нь хуарангийн суурьшилтай илүү хамааралтай бөгөөд дор дурдсан Малын хашаа хороо ба байршуулалтын стандарт 2-т нарийвчлан тусгасан.

Орон нутгийн чадавхи

Гамшигт нэрвэгдсэн иргэд онцгой байдлын хариу арга хэмжээнд өөрсдийн боломжоор оролцдог. Тухайлбал: малын хашаа хороо барихад тохиромжтой барилгын материал, хашаа хорооны загвар, барих ур чадвар зэрэгт тэдний уламжлалт мэдлэгийг ашигладаг.

Стандартууд

Мал амьтныг хашаа хороогоор хангах, байршуулалт хийхээс өмнө хэрэгжүүлэх арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл болон зохистой эсэх талаар *Бүдүүвч 8.1*-д заасны дагуу үнэлгээ хийнэ.

Малын хашаа хороо ба байршуулалт Стандарт 1: Үнэлгээ ба төлөвлөлт

Үнэлгээ ба төлөвлөлтийг орон нутгийн иргэдийн зөвлөмж, уламжлалт мэдлэг, байгаль орчинд гарч болох үр дагавар, тогтвортой амьжиргааг хангах боломж зэрэгт үндэслэн хийнэ.

Үндсэн үйл ажиллагаа

- Уламжлалт хашаа хороо барих арга, байршуулах туршлагын талаар нэрвэгдсэн нутгийн иргэдтэй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг тэгш оролцуулан зөвлөлдөх. Үүнийг анхдагч үнэлгээ хийх *Бүлэг 3, Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох*-д заасны дагуу хийх хэрэгтэй (*Зааварчилгаа 1* харна уу).
- Малын хашаа хорооны загвар, байршуулалтын дэд бүтэц нь уламжлалт загварт тулгуурлах *(Зааварчилгаа 1* харна уу).
- Малын хашаа хороо нь нэрвэгдсэн хүн амын хамгийн эмзэг бүлгийн хэрэгцээнд нийцэж байх (*Зааварчилгаа 2* харна уу).
- Малын хашаа хороо барих ажлын байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх, сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ авах (*Зааварчилгаа 3* харна уу).
- Үнэлгээний нэг хэсэг болгон орон нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааны хэрэгцээг тодорхойлох, яаралтай хариу арга хэмжээ авах *(Зааварчилгаа 4* харна уу).
- Боломжтой бол малын хашаа хороо барих, байршуулах туслалцаанд бэлэн мөнгө ба эрхийн бичиг ашиглаж болох талаар зах зээлийн судалгаа хийх (*Зааварчилгаа 5, Үйл явцын жишээ судалгаа 8.6* харна уу).
- Малын хашаа хороо барих, суурьшуулалт хийхдээ холбогдох бүх оролцогч талуудтай зөвшилцсөн байх (*Зааварчилгаа 6* харна уу).

Бүдүүвч 8.1 Мал амьтныг хашаа хороогоор хангах, байршуулалтын шийдвэрийн модны загвар

Тайлбар:
"Үйлдэл хийхгүй" гэсэн үр дүн (онцгойлон үзэх асуудал гараагүй бол)"гэдэг нь газар дээр нь ямар нэг арга хэмжээ авч болохгүй гэсэн үг яг биш гэхдээ гол асуултуудад "тийм" гэсэн хариулах боломжтой байх үүднээс цаашид шаардлагатай сургалт буюу чадавхийг сайжруулах асуудлууд шаардлагатай байж болох юм.

Зааварчилгаа

1. **Орон нутгийн иргэдийн оролцоо**. Орон нутгийн туршлагатай малчид нь ямар төрлийн мал амьтныг ямар хашаа хороонд маллах, тэдний хэрэгцээг хангахад ямар төрлийн загварыг (ашиглах материал, барих газар, хүрэх боломжтой газар, эрүүл ахуй, мал аж ахуйн менежментийн талаар), ашиглах, хэрхэн хэнээр бариулах талаар мэдлэг, туршлагатай байдаг. Хөтөлбөрийн бүх үе шатанд (анхдагч үнэлгээ, загварчлах, хэрэгжүүлэх, үнэлэх) нутгийн ард иргэдийг оролцуулж дараах асуудлыг анхааран үзнэ. Үүнд:

   - малын хашаа хороо барихад тэдний үүрэг, хариуцлага (нас хүйсэд тулгуурласан хөдөлмөрийн хуваарилалт)
   - орон нутаг болон илүү өргөн хүрээнд сурталчлахтай холбоотой бодлогын асуудлууд (*Бүлэг 2, Нийтлэг стандартууд ба мал амьтанд хамааралтай нийтлэг асуудал, Стандарт 7: Бодлого ба Нөлөөлөл* хэсгийг харна уу)
   - хуаранд шилжин ирсэн мал бүхий иргэд байгаа тохиолдолд орон нутгийн үндсэн иргэдийг оролцуулах
   - орон нутгийн иргэдийн мэдлэгийг ашиглах
   - уламжлалт загвар, барилгын материал, ёс заншлын хэм хэмжээ, арга технологийг ашиглах (маш ховор тохиолдолд «хашаажуулах систем» эсвэл угсрах зориулалттай байрыг ашигладаг)
   - нийтийн эсвэл хувь хүн ашиглах зориулалттай байх эсэхийг ёс заншлын хэм хэмжээ, одоогийн нөхцөл байдлын (аюулгүй байдал, цаг агаар гэх мэт) талаар нэрвэгдсэн иргэдтэй зөвлөлдсөний үндсэн дээр сонгоно. Онцгой байдал үүсэхээс өмнө хувь айл өрх ашиглах зориулалттай хашаа хороогоор хангах нь илүү тохиромжтой байдаг хэдий ч зарим тохиолдолд энэ нь боломжгүй, тохиромжгүй эсвэл түүнийг барих хөрөнгө хүч дутагдалдай байдаг. (*Жишээ, судалгаа 8.2 ба 8.7* харна уу).

2. **Эмзэг байдал**. Үнэлгээ ба төлөвлөлтийн шатанд эмзэг бүлгийнхэн тухайлбал нэн тэргүүнд туслалцаа шаардлагатай байгаа, өөрсдийн мал амьтанд хашаа саравч барьж чадахгүй өндөр настан, өвчтэй эсвэл хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг судална. Барилгын материал авч чадахгүй байгаа бүлэгт мөн нэмэлт

туслалцаа үзүүлнэ (*Хавсралт 8.1: Мал амьтныг хашаа, хорооны хэрэгцээг үнэлэх шалгах хуудас* харна уу). Тусламжийн ямар ч арга хэмжээ хэрэгжүүлэх үед эмзэг бүлгийнхэнд үзүүлж байгаа туслалцаа нь орон нутгаас өөрсдийн гамшигтай тэмцэх стратегийн хүрээнд дээрх бүлэгт үзүүлж байгаа дэмжлэг, туслалцааг үзүүлэх чадварыг сулруулж болохгүй.

3. **Орон нутгийн байгаль орчны нөлөөлөл**. Малын хашаа хороо, байршуулалт нь тогтвортой бус орон нутгийн материал ашиглах эсвэл хязгаарлагдмал газар нутагт мал олноор маллахаас үүсэж болох байгаль орчинд нөлөөллийн үнэлгээ хийнэ. Үүнийг хуарангийн суурьшил бий болсон үед илүү чухлаар авч үзэх хэрэгтэй бөгөөд энэ талаар *Малын хашаа хороо, байршуулалт Стандарт 2*-д тусгасан байгаа.

4. **Тогтвортой амьжиргаа**. Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн түр зуурын туслалцааг үзүүлэх шаардлага тулгарсан үед малын хашаа хороо барих, байршуулалт хийх хүчин чармайлт бүр нь нэрвэгдсэн иргэдийн амьжиргааны хэрэгцээг хангах, урт хугацаанд ашиглаж болохуйц байна. Иймээс газрын ашиглалт, иргэдийн амьжиргаа,онцгой байдлын дараа нөхөн сэргэх үед мал аж ахуйн менежментэд гарч болох өөрчлөлт зэргээс үүсэх үр дагаврыг анхааран үзнэ.

5. **Зах зээлийн үнэлгээ**. Барилгын материал нь орон нутагт олдоцтой бол орон нутгийн зах зээлийг дэмжих, нэрвэгдсэн иргэдийн хийж буй ажлыг илүү хянахын тулд бэлэн мөнгө, эрхийн бичиг тараах боломжийг судална (бэлэн мөнгө тараах талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг *Бүлэг 3, Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох* хэсгийг харна уу).

6. **Хамтрагч талуудын оролцоо**. Малыг хашаа хороогоор хангахдаа ялангуяа иргэдийг нүүлгэн шилжүүлсэн үед нэрвэгдсэн иргэд, оролцогч талуудтай зөвшилцөх шаардлагатай. Дүрвэгсдэд зориулан малын хашаа хороо, байршуулалтыг зохион байгуулахдаа төлөвлөлтийн уялдаа холбоог хангах, үйл ажиллагааг нөхөх зорилгоор хүн амыг байр сууцаар хангах, суурьшуулах ажилтай хамт хэрэгжүүлнэ. Хөдөө аж ахуй, усан хангамж, эрүүл ахуй, газар ашиглалт, барилгын асуудал хариуцсан байгууллагуудын оролцоог хангана. *Зааварчилгаа 1*-д дурдсан нэрвэгдсэн иргэдийг нүүлгэн шилжүүлсэн бол тухайн орон нутгийн үндсэн иргэдтэй зөвшилцөх

нь Малын хашаа хороо, суурьшлын дэд бүтцийн байршил нь ямар нэгэн зөрчил, байгаль орчны ачаалал, ажил хийх, байгалийн нөөц ашиглах өрсөлдөөн бий болохоос сэргийлнэ.

Хүний байр сууц, хамгаалалт, ус, эрүүл ахуй, хуарангийн менежмент зэрэг бусад салбарт оролцож буй хүмүүнлэгийн ажилтнуудын туршлагыг авч үзэх нь чухал ач холбогдолтой. Өргөн хүрээг хамарсан гамшгийн үед "кластерын хандлага"-г (*Нэр томьёоны тайлбарыг* харна уу) ашиглаж байгаа үед хүнсний аюулгүй байдал, хамгаалалт, яаралтай байр сууц, хуарангийн зохицуулалт, менежмент (СССМ) багцыг шуурхай нөхөн сэргээх үйл ажиллагааны явцад хамтруулан хийж болно. Мал амьтныг хашаа хороогоор хангах байгууллага нь мал амьтныг хашаа хороогоор хангах, байршуулах ажилд дэмжлэг үзүүлэхийн тулд энэхүү багц үйл ажиллагаанд идэвхтэй оролцох хэрэгтэй. Ялангуяа нүүлгэн шилжүүлсэн хүн амд чиглэсэн тэдний үйл ажиллагаа нь багцын стратеги, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байх хэрэгтэй.

Малын хашаа хороо ба байршуулалт Стандарт 2: Мал амьтан ба байршуулалт

Мал амьтныг байршуулах нь хүн мал хамт байхад аюулгүй, тогтвортой байх, мал сүргийн аюулгүй, эрүүл, байгаль орчны тогтвортой нөхцөлөөр хангахад тусалдаг

Үндсэн үйл ажиллагаа

- Мал амьтныг байршуулах арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт нь хүний аюулгүй байдал, хүн, мал хамтдаа аюулгүй байхад дэмжлэг үзүүлэх (*Зааварчилгаа 1* харна уу).
- Мал амьтныг байршуулах, хашаа хороогоор хангах туслалцаа нь орон нутгийн байгаль орчны нөлөөллийг багасгах (*Зааварчилгаа* 2 харна уу).
- Мал амьтныг байршуулах, хашаа хороогоор хангах үйл ажиллагаа хүн амын тогтвортой суурьшлын зорилтод нийцсэн байх (*Зааварчилгаа* 3 харна уу).
- Суурьшлын дэд бүтэц нь эрүүл мэнд, аюулгүй байдал, тогтвортой мал аж ахуйн менежментийг дэмжих (*Зааварчилгаа* 4 харна уу).
- Суурьшлын дэд бүтэц нь нийгмийн эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг бууруулсан байх (*Зааварчилгаа 5* харна уу).

Зааварчилгаа

1. **Хүний аюулгүй байдал ба хүн мал хамт байх**. Малын хашаа хорооны байршил нь малын эзний аюулгүй байдал, хамгаалалтад нөлөөлнө. Жишээ нь: мөргөлдөөний бүс нутагт Малын хашаа хороог хүн амын суурин газраас хол зайтай баривал малчид, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдэд эрсдэлтэй. Эсрэгээрээ, малын хашаа хороог, суурьшлын дэд бүтэц хүн амын суурин газар хэт ойрхон барьвал өвчин тархах эрсдлийг нэмэгдүүлдэг. Суурьшлын төлөвлөлтийг хүн ам, мал амьтан хамтдаа аюулгүй байхаар зохицуулна. Энэ нь малаас хүнд дамжин халдварладаг шувууны томуу гэх мэт өвчний эрсдлийг бууруулах, малын ялгадаснаас дамжуулагч амьтдаар (вектор) дамжин халдварладаг өвчнөөс урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой.

2. **Орон нутгийн байгаль орчны нөлөөлөл.** Мал амьтныг байршуулах, хашаа хороогоор хангах нь орон нутгийн байгаль орчны нөлөөллийг багасгасан байна. Ялангуяа малын хашаа хороо барихад орон нутгийн материал ашиглах, ашиглалтыг дэмжсэнээр байгаль орчны байнгын доройтлыг үүсгэх эрсдэлтэй. Малын байр, хашаа хороо барихад зориулан мод тайрах, тоосго шатаах нь тодорхой эрсдлийг бий болгодог. Барилгын материалыг тогтвортой эх үүсвэрээс худалдан авах эсвэл бэлтгэх хэрэгтэй. Малын хашаа хороонд орон нутгийн материал ашиглахын оронд «амьд хашаа» буюу байгалийн ургамал ашиглан барьж болно. Малын бөөгнөрөл, нягтрал үүсгэхгүй байх нь бэлчээрийн талхагдал, байгаль орчин доройтох эрсдлийг бууруулдаг.

   Хуаранд мал амьтан маллах нь тухайн орон нутгийн байгаль орчин түүний нөөцөд нэмэлт ачаалал үүсгэдэг. Орон нутгийн мал амьтны эх үүсвэрийг ашиглах нь зөрчил үүсэх шалтгаан болдог учраас бэлчээр ашиглах талаар орон нутгийн иргэдтэй зөвшилцөх шаардлагатай.

3. **Хүн, малын тогтвортой суурьшил**. Хүн амын хэрэгцээ нь мал амьтны байршуулалтаас ямагт дээгүүр тавигддаг. Иймээс мал амьтныг байршуулах арга хэмжээ нь хүний суурьшилд сөрөг нөлөө үзүүлэхээргүй байх ёстой. Ихэнх тохиолдолд хүн ба малыг байршуулах хэрэгцээ нь харилцан хамааралтай байдаг нь хамтарсан зохицуулалт, төлөвлөлт шаардлагатай байдгийг харуулдаг. (дээр дурьдсан *Малын хашаа хороо ба суурьшуулалт*

Стандарт 1, Зааварчилгаа 6 харна уу).

Энэхүү зохицуулалт хийх нь дүрвэгсдэд чухал ач холбогдолтой. Дүрвэгсдийн суурин тархай бутархай байдаг. (жишээ нь: дүрвэсэн иргэд үндсэн оршин суугчтай эсвэл бусдын газар нутаг дээр байрладаг). Мөн бүлэглэсэн суурьшил үүсгэдэг. (нийтээр амьдрах газар эсвэл хуаранд гэр бүлээрээ хамт байх гэх мэт). Бүлэглэсэн суурьшил нь нарийн төвөгтэй, хөрөнгө хүч шаардсан, урт хугацааны, тогтвортой шийдвэр гаргахад саад тотгор болдог. Хуарангийн оршин суугчдын нягтшил нь шувуунаас бусад мал амьтныг хамт байршуулах боломжгүй болгодог. Учир нь байгаль орчны доройтол үүсэх, өвчин тархах эрсдэлтэй байдаг. Онцгой байдлын үе шатанд мал бүхий дүрвэгсдэд шууд туслалцаа үзүүлэхээс өөр аргагүй байдаг боловч хүчин чармайлт бүр нь тэднийг гэрлүүгээ буцахад дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэх хэрэгтэй.

Мал бүхий иргэд шилжин ирсэн бол суурьшлыг зохион байгуулахад орон нутгийн бэлчээр ашиглах эрх, менежментийн бүтэц, ашиглах боломж, газрын эрх, ээмшигчдийг харгалзан үзэх шаардлагатай. Асуудлыг шийдвэрлэх тогтвортой шийдэл олохын тулд оролцогч талуудтай сайтар зөвлөлдөх, орон нутгийн эрх бүхий байгууллага, мэргэжилтнүүдээс зөвлөгөө авах хэрэгтэй. (дээр дурдсан *Малын хашаа хороо ба суурьшуулалт Стандарт 1, Зааварчилгаа 6* харна уу)

4. **Аюулгүй байдал, тогтвортой мал аж ахуйн менежмент**. Малын хашаа хороо, (дор дурдсан Малын хашаа хороо ба байршуулалт Стандарт *3* харна уу) байршуулалтын дэд бүтэц нь аюулгүй, мал аж ахуйн тогтвортой менежментийг хангасан байна. Энэ нь тэжээлийн эх үүсвэрт хүрэх боломжтой, хулгай, араатан амьтнаас хамгаалах хашлагатай байна. Хашлага хийснээр мал амьтанд тэжээл (*Бүлэг 6, Тэжээл хангам*ж харна уу), ус (*Бүлэг 7,Усан хангамж* харна уу) авчирч өгөх шаардлага үүсэж эмэгтэйчүүдийн ачааллыг нэмэгдүүлэх, паразиттах зэрэг малын эрүүл мэндэд асуудал үүсгэх, бусад мал амьтанд халдвар тараах, мал эмнэлгийн эм бэлдмэл нөөцлөх эсвэл мал нядлах цэг байгуулах шаардлага гарах зэрэг хүндрэл бий болгодог**.** (*Бүлэг 5, Мал эмнэлгийн үйлчилгээ*). Суурьшлын бүх дэд бүтцийг уламжлалт мэдлэг, туршлагад тулгуурлан хийнэ. (дээр дурдсан *Малын хашаа хороо ба суурьшуулалт стандарт 1* харна уу).

5. **Нийгмийн эрүүл мэндийн нөлөөлөл**. Байршуулалт нь эрүүл

ахуйн менежментийг хэрэгжүүлэх, мал амьтны ялгадсыг устгах боломжоор хангасан байна. Ялангуяа, мал бүхий иргэд шилжин суурьшсан хуаранд илүү ач холбогдолтой. Менежментийн хувилбар нь дараах асуудлыг багтаасан байна. Үүнд:

- малын өтөг бууцыг зайлуулахад бэлэн мөнгө эсвэл бусад төрлийн урамшуулал олгох
- бэлчээрийн нөхцөлд таваас долоо хоног тутам малын шөнийн хашлагыг зөөх
- хүн амын суурьшил газрын эргэн тойрон мал орохоос сэргийлсэн хашлага хийх
- хүн амын байр сууц ба малын хашаа хороо хангалттай зайтай байх.

Малын тоо толгойг аюулгүй түвшинд байлгах шаардлагатай. (төрөл бүрийн мал амьтанд шаардлагатай орон зайн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг UNHCR, 2005:30 харна уу).

Малын хашаа хороо ба байршуулалт Стандарт 3: Малын хашаа хороо

Мал амьтан нь өөрийн онцлог, ашиглах зориулалтанд тохирсон эрүүл, аюулгүй орчноор хангагдсан байна.

Үндсэн үйл ажиллагаа

- Малын хашаа хороо нь цаг уурын зонхилох нөхцөл байдалд тохирсон, өдөр тутмын ба улирлын цаг агаарын гэнэтийн өөрчлөлтөөс мал амьтныг хамгаалж чадахуйц байх (*Зааварчилгаа 1* харна уу).
- Малын хашаа хороо нь тухайн төрөл зүйл, ашиглах зорилгод тохирсон байхын зэрэгцээ түр зуур ашиглах бол материал, бүтэц нь урт хугацаанд ашиглаж болох эсвэл дасан зохицоход хялбар байх (*Зааварчилгаа 2* харна уу).
- Мал амьтныг хулгай, араатан амьтдын халдлагаас хамгаалахаар байх (*Зааварчилгаа 3* харна уу).
- Бусад төрлийн тусламж ирэхээс өмнө тэжээлийн хомсдолд орохоос сэргийлж мал амьтныг түр бэлчээрлүүлэх боломжтой

байх (*Зааварчилгаа 4* харна уу).

Зааварчилгаа

1. **Эрүүл, аюулгүй амьдрах орчин**. Халуун цаг агаартай бол Малын хашаа хороо нь агааржуулалт сайтай, сүүдэртэй байна. Хүйтэн цаг агаарын нөхцөлд хашаа хороо нь нэвт салхилахаас сэргийлсэн битүүмжлэл сайтай байхаас гадна газар дор агааржуулалттай байна. Эрс тэс уур амьсгалтай газар мал амьтныг тараахаас өмнө хашаа хороогоор хангана.

2. **Тохиромжтой загвар**. Хашаа хороог орон нутгийн загвар хийцэд тулгуурлан орон нутгийн материал ашиглан барина. Байгалийн гамшгийн дараа нурсан барилга, байгууламж, дэд бүтцийн үлдэгдлийг ашиглах, ашиглахыг дэмжиж багаж хэрэгслээр хангаж, сургалт хийнэ.

   Зарим онцгой байдлын үед мал амьтныг амьд үлдээхийн тулд хашаа хороогоор яаралтай хангах шаардлага үүсдэг. Энэ тохиолдолд хашаа хороог удаан хугацаанд хэрэглэх боломжгүй байдаг тул иргэд өөрсдөө засаж сэлбэн цаашид ашиглахад дэмжлэг үзүүлнэ. Онцгой байдлын үед бий болгосон малын хашаа хороо нь цаашид илүү тогтвортой ашиглах боломжтой байвал илүү үр дүнтэй. Жишээ нь: дээврийг урт хугацаанд ашиглах материалаар хийвэл дараа нь хана, хаалга, хашаа зэргийг нэмж засан урт хугацаанд ашиглах боломжтой.

3. **Хулгай ба дээрэм.** Мал амьтныг хашаа хороогоор хангах, байршуулах үйл ажиллагаа нь тухайн орон нутагт хулгай, бусад зэрлэг амьтдын халдлагаас сэргийлсэн байх ёстой. Тухайн хашаа хороо нь хаалгатай эсвэл мал амьтны байрны эргэн тойрон сайтар хамгаалагдсан байх хэрэгтэй.Мөн мал амьтны хашаа хорооны аюулгүй байдлын үүднээс хүн амын сууринтай ойрхон байршилтай байхаар төлөвлөнө.

4. **Хашигдсан мал амьтан.** Туршлагаас харахад тухайн мал амьтны эзэн алагдсан эсвэл бэртсэн тохиолдолд мал амьтан ялангуяа сүүний чиглэлийн буффало, үнээ нь хашигдах, алдагдсаны улмаас үхэж хорогддог. Энгийн арга хэмжээ нь тухайн малыг бусад сүрэгтэй нийлүүлэх, хашигдсан газраас гаргаж тэжээл, усаар хангагдах боломжийг олгох хэрэгтэй. Эдгээр малыг будгаар юмуу өөр аргаар тэмдэглэх хэрэгтэй бөгөөд сүрэгтээ буцаж нийлэх

боломжтой болно. Гамшгийн үеийн хариу арга хэмжээ нь (*Бүлэг 4, Мал амьтныг хашаа хороогоор хангах ба байршуулалт* харна уу) тухайн мал амьтны эзэн цаашид учирч болох гамшгийн үед сэрэмжлүүлэх хугацаа хангалттай байвал өөрсдийн малаа тэмдэглэхийг зөвлөх хэрэгтэй.

Малын хашаа хороо ба байршуулалт Стандарт 4: Гамшгийн эрсдлийг бууруулах ба бэлэн байдал

Малын хашаа хороо ба байршуулалтын төлөвлөлт нь ирээдүйд үүсэж болох гамшгийн үр дагаварыг бууруулахад чиглэгдэнэ.

Үндсэн үйл ажиллагаа

- Ирээдүйд үүсэж болох гамшгийн эрсдлийг үнэлэх (*Зааварчилгаа 1* харна уу).
- Малын хашаа хороо барих, байршуулалтын үйл ажиллагаа нь мал амьтан, тэдний эздэд учирч болох эрсдлийг багасгах, цаашид онцгой байдлыг даван туулах чадварыг нэмэгдүүлэх *(Зааварчилгаа 2* харна уу).

Зааварчилгаа

1. **Ирээдүйд үүсэж болох эрсдлийг үнэлэх.** Мал амьтныг хашаа хороо ба байршуулалтын төлөвлөлтийн нэг хэсэг болгон цаашид үүсэж болох гамшгийн эрсдлийг үнэлнэ.
2. **Малын хорогдлыг бууруулах.** Малын хашаа хороо барих, байршуулалтын туслалцаа нь ирээдүйд үүсэж болох гамшгийн үр нөлөөг бууруулахад чиглэгдэнэ. Ирээдүйд үүсэж болох эрсдлийн үнэлгээнд байршлын сонголт, загвар хийц, барилга угсралт зэрэг малын үхэж хорогдох эрсдлийг бууруулахад чиглэгдсэн эсэхийг авч үзнэ.

   Эрсдлийн үнэлгээнд дараах асуудлыг хамруулна Үүнд: .

- *Газар хөдлөлт.* Малын хашаа хороо ба байршуулалтын дэд бүтцийг тогтвортой, цаашид нуралт болон доргилт үүсэх эрсдэлгүй газар байгуулна. Хашаа хорооны загвар хийцийг чичирхийлэлд бат бөх, хөнгөн жингийн газар хөдлөлтөнд тэсвэртэй байхаар төлөвлөнө. Уламжлалт материал, технологийг ашиглаж болох боловч

шаардлагатай бол түүнийг өөрчилж газар хөдлөлтөнд тэсвэртэй материал ашиглана (дор дурдсан *Үйл явцын жишээ 8.3* харна уу).

- *Үер.* Боломжтой бол малын хашаа хороог гэнэтийн үерийн аюулд өртөх эрсдэлгүй газар барина. Боломжгүй бол ус зайлуулах хоолой хийх эсвэл өмнөх үерийн түвшингээс дээр байхаар барина. Барилга нурах эрсдлээс сэргийлж суурийг бат бөх, бэхэлгээтэй байхаар төлөвлөнө.
- *Циклон.* Малын хашаа хорооны загвар хийц бат бөх, дээвэр нь сайтар бэхлэгдсэн байхаас гадна далайн давалгаанд автах гэнэтийн эрсдэлтэй бол түүнд өртөхөөргүй эргээс хол барина.
- *Цунами* Хашаа хороог аль болох эргээс хол барина.

Дээрх бүх тохиолдолд гамшгийг бууруулах барилга байгууламжийн сайн туршлагыг авч ашиглахын тулд барилгын мэргэжилтнүүдээс зөвөлгөө авах шаардлагатай. *(Ашигласан хэвлэлийн жагсаалт* харна уу)

Малын хашаа хороо ба байршуулалтын жишээ судалгаа

8.1 Үр нөлөөний жишээ судалгаа: Бангладешийн үерийн үед бэлэн байх, хариу арга хэмжээ хэрэгжүүлэх

Бангладешийн чарс нь элсэрхэг арлууд бөгөөд усны түвшингээс нам дор газар байрладаг учраас байнга усны урсгалд элэгдэж, эргэн сэргэж байдаг. Их Британы Олон улсын хөгжлийн газрын санаачилсан (DFID), Чарсын Амьжиргааны Төсөл (CLP) Хойд Жамунагийн чарсын оршин суугчдын амьжиргааг дэмжих зорилгоор байр сууцыг үерийн үед тэсвэртэй болгоход дэмжлэг үзүүлэх, усаар хангах, сургалт хийх зэргээр чадавхийг бэхжүүлэх төсөл хэрэгжүүлсэн байна. Үерийн усны түвшинд байрлах орон сууцны өндөр хашлага хийснээр их үерийн үед хүмүүс гэртээ үлдэж хөрөнгөө алдах, эх газар луу нүүхээс сэргийлж чадсан байна. Энэхүү хашлагыг бусад айл өрхийг эд хөрөнгө, мал амьтны хамт түр зуур байрлуулах зориулалтаар ашиглах боломжтой.

2007 оны 7 дугаар сард энэ улсын газар нутгийн 60 хувь нь гэнэтийн үерт автаж Хойд Жамуна муж илүү хохирлол амссан. CLP нь үерийн аюул дуустал хоёр долоо хоногийн турш хүмүүнлэгийн тусламж үзүүлжээ. Тусламжинд хүнсний тусламж, ус цэвэршүүлэх шахмал, аврах ажиллагаа, мал амьтныг дэмжих үйл ажиллагаа зэрэг багтсан байна. 15000 үхэрт 8 хоногийн турш хүрэлцэхүйц малын тэжээл нийлүүлсэн нь төсөл хэрэгжсэн газрын айл өрхийн 90 хувьд нь хангалттай хүрсэн байна. Мөн 3800 хүнийг 3375 үхрийн хамт аварсан байна.

Үерийн дараах хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар айл өрхийн 0,3 хувьд нь үхэр хорогдсон буюу малын хорогдлын хувь маш бага, энгийн үеийнхтэй адил дүн гарчээ. Нийт өрхийн 4,6 хувьд хонь, ямаа хорогдсон дүн гарсан нь энгийн үеийн хорогдолтой мөн адил үр дүн үзүүлжээ. Энэ нь хүн, мал амьтныг хамгаалах өндөр хашлага хийж, мал амьтныг тэжээлээр хангах ажлыг хослуулан хийсэн нь үерийн үед мал олноор хорогдохоос сэргийлж чадсаныг харуулж байна. (*Эх сурвалж: Marks and Islam, 2007*)

8.2 Үйл явцын жишээ судалгаа: Пакистан дахь газар хөдлөлтийн үед нийтээр ашиглах малын хашаа хороо

2005 онд Пакистанд болсон газар хөдлөлтийн үеэр маш олон тооны

хонь, ямаа бэлчээрээс буцах замдаа хорогдсон байна. Малын байр нурснаас болж суурин маллагаатай буффало, үхэр, шувууны хорогдлын тоо түүнээс өндөр гарсан байна. Амьд үлдсэн хүмүүст мал амьтан байх нь туйлын ач холбогдолтой, учир нь тэд өвлийн цагт сүүний эх үүсвэр болж, өөрсдийн үнэ цэнээ хадгалж байдаг. Хариу арга хэмжээний үеэр Бруук малчид олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийтийн малын хашаа хороо барих санал гаргасан. Учир нь хашаа хороо барих нөөц боломж, газар нутаг хязгаарлагдмал байсан тул нийтийн малын хашаа нь өвлийн турш мал амьтныг хамгаалж чадна гэж үзжээ.

Ойролцоо амьдарч байгаа айл өрхүүд хамтран мал хашихад хангалттай зай бүхий модон хороо барихад дэмжлэг үзүүлсэн. (30 хүртэл тооны мал багтахаар). Хашаа хороо барихад зориулж гялгар хавтас, хадаас, атираат төмөр хуудсаар хангах болон техникийн дэмжлэг үзүүлсэн. Хамгийн эмзэг, тусламж хэрэгцээтэй байгаа хүмүүсийг олох судалгаа хийж, тосгоны удирдагчтай зөвлөлдөж айл өрхийг сонгосон. Хэрэв дээрх айл өрх өөрсдөө хороо барьж чадахгүй үед Бруук тэдэнд туслалцаа үзүүлсэн. Малын хашаа хороо барьж эхлэх үед өвчин тарах эрсдэлтэй гэж болгоомжлон эсэргүүцэж байсан хэдий ч Бруук мал амьтныг хашаа хороонд цуглуулан хийхээс өмнө эрүүл мэндийн үзлэг хийж, вакцинжуулсан байна. Төсөл нь эмэгтэйчүүд малаа ээлжлэн маллах болсноор тэдний хөдөлмөрийг хэмнэж нэмэлт ашиг авчирчээ. Төслийн дараа Бруук урт хугацаанд мал амьтныг эрүүл, тавлаг байлгахын тулд эмэгтэйчүүдэд малын эрүүл мэнд, мал аж ахуйн талаар, албан ёсны орон нутгийн иргэдэд түшиглэсэн малын эрүүл мэндийн ажилтан (CAHWs) бэлтгэх зэрэг сургалт явуулсан байна. (Эх сурвалж: Julia Macro, хувийн мэдээлэл, 2008).

8.3 Үйл явцын жишээ судалгаа: Пакистан дахь газар хөдлөлтийн дараах малын хашаа хороо

2005 Пакистанд болсон газар хөдлөлтийн дараа Дости Хөгжлийн Сан, НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага (FAO), НҮБ-ын Дэлхийн Хүнсний Хөтөлбөр (WFP), Пакистан улсын Засгийн Газар нар хамтарсан төсөл санаачилж Мансехра, Баттаграм дүүргийн фермерүүдэд малын хашаа хороо, үхрийн нэмэлт тэжээлээр хангах ажлыг хийсэн байна. Хөтөлбөрийн зорилго нь малын эрүүл мэнд, ашиг шимийг сайжруулах, торон барилгын техникт тулгуурлан газар хөдлөлтөнд тэсвэртэй хашаа саравч барих аргад сургах байсан байна. Тор гэдэг нь элс, шавар, урт сүрэлний холимог юм. Барих арга нь энгийн, материал нь хямд, орон

нутагт олдоцтой. Ашиг хүртэгчдэд барих аргын талаар сургалт явуулсан.

Нийт 3,000 хашаа барьж (108 тосгон өөрсдийн нөөц боломжийг ашиглаж хийсэн), мал амьтнаас хамааралтай хамгийн эмзэг бүлгийнхэнд үхрийн нэмэлт тэжээл олгожээ. (*Эх сурвалж: Dosti Development Foundation and FAO, 2007*)

8.4 Үйл явцын жишээ судалгаа: Мавритан дахь Мали дүрвэгсдэд зориулсан мал байршуулах үйл ажиллагаа

2012 оны нэгдүгээр сард болсон цэргийн үйл ажиллагааны улмаас хүмүүнлэгийн нөхцөл байдал хүндэрч, тогтворгүй байдал 2013 оны эхэн хүртэл үргэлжилсэн нь олон тооны энгийн иргэдэд сөрөг үр дагавар авчирсан. 2012 оны 11 сард 354000 хүн гэр орноо орхин явахад хүргэсэн бөгөөд тэдний 155000 нь Алжир, Буркина Фасо, Гвиней, Мавритан, Нигер, Того улс руу дүрвэжээ. 2013 оны 5 сард 74000 гаруй дүрвэгсэд Мафританы Бассикноуд байрласан байна.

Дүрвэгсэд хүмүүнлэгийн болон сайн санаат гэр бүл, найз нөхдийн тусламжаас хамааралтай, маш хүнд нөхцөлд амьдарч байв. Түүнээс гадна дүрвэгсэд ирсэн нь аль хэдийн хүн ам, мал амьтан нь ган гачигт нэрвэгдсэн орон нутгийн иргэдийн амьжиргаа, тогтвортой байдалд дарамт учруулж, гангийн нөлөөг улам гүнзгийрүүлсэн байна.

Олон Улсын Дүрвэгсдийн Байгууллага (IOM) Бассикноуд үнэлгээ хийхээр очиход орон нутгийн иргэдийн санаа зовоосон, зөрчил үүсгэж буй гол асуудал нь дүрвэгсдийн малын бэлчээрийн асуудал байсан байна. Ярилцаж зөвлөлдсөний эцэст бэлчээрийн газрыг тодорхой хуваарийн дагуу баталгаатай, тусдаа ашиглах болсон нь бусдын мал амьтныг хөөх, дүрвэгсэд болон орон нутгийн иргэдийн хооронд үүсэх зөрчлийг багасгажээ. Мавритан дахь Олон Улсын Дүрвэгсдийн Байгууллага нь тэжээлийн дутагдалд орсон, ган гачигт нэрвэгдсэн мал амьтандмал эмнэлгийн үйлчилгээ үзүүлж, 2400 мал амьтныг вакцинд хамруулсан.

Олон Улсын Дүрвэгсдийн Байгууллагын Бассикноу дахь туршлагаас харахад үйл ажиллагаа хэрэгжүүлэхээс өмнө нөхцөл байдал, хэрэгцээнд үнэлгээ хийж, орон нутгийнхантай зөвшилцөх нь онцгой ач холбогдолтойг харуулж байна. Зөвшилцөх сувгийг бий болгосноор орон нутгийн иргэд дүрвэгсэдтэй холбоотой өөрсдийн айдас, санаа зовсон асуудлаа илэрхийлэх боломж олгож, урт хугацаанд хэрэгжих хамтын шийдвэр гаргаж чаддаг. Энэхүү жишээ нь хүн, мал амьтныг байршуулах

төлөвлөлтөнд байршлыг сонгох асуудал чухал үүрэг гүйцэтгэдгийг тодотгож байна. (*Эх сурвалж: Shelter Centre, personal communication, 2013*)

8.5 Үйл явцын жишээ судалгаа: Судан дахь дүрвэгсэд, мал амьтны байршуулалтын төлөвлөгөө

Суданы Дафтурт болсон хямралын улмаас хэдэн мянган дүрвэгсэд Зүүн Өмнөд Чад руу дүрвэсэн. Тэдний ихэнх нь өөрсдийн үрхийн хамт хил давсан нүүдэлчид байсан. UNHCR, дүрвэгсдийг байр сууцаар хангах асуудлыг хариуцаж Суданы хилээс 40 км зайд орших Абгадамд шинэ суурин байгуулж, 18000 гаруй хүнийг байр сууцаар хангаснаас тал хувь нь Чадад ирсэн Суданы дүрвэгсэд байсан байна.

Абгадамын суурин нь дүрвэгсэд малаа авчирч байршуулах, эргэн тойрныхоо бэлчээрт малаа чөлөөтэй хариулах боломжтой байхаар төлөвлөсөн. Төлөвлөгөөнд шинээр суурьших мал амьтныг орон нутгийн малаас салангид маллахаар тусгаж, малаа авчрахад нь мал эмнэлгийн хяналт тавьж, вакцин тарих болон бусад халдварт өвчин тархахаас сэргийлсэн арга хэмжээг авсан байна. (*Эх сурвалж: IRIN News, 2013*)

8.6 Үйл явцын жишээ,судалгаа: Пакистан дахь үерийн үед мал амьтныг хашаа хороогоор хангах зах зээлийн зураглал гаргах

2010 оны 7 сарын сүүлчээр Пакистан улсад их хэмжээний үер болж энэ нь Индус голыг даган Хубер Пахтунква (KPK) муж дундуур өнгөрч Баруун Панжаб Синдх мужийн зүүн хэсэгт хүрсэн байна. Үндэсний Гамшгийн Менежментийн төвөөс мэдээлснээр 20 сая хүн өртөж, 1.8 сая орон сууц нуран сүйрч, 1.3 сая га тариалангийн талбай устаж үгүй болжээ. Гэнэтийн маш хүчтэй үерийн усны улмаас хойд бүсийн хөндийн газар гүнзгий өртөж, тээврийн дэд бүтэц сүйрч улмаар гол үерлэж өмнөд зүгрүү чиглэсэн байна. KPK мужид 1.2 сая мал, 6 сая шувуу хорогдож, олон тооны мал амьтан шаардлагатай тэжээл, мал эмнэлгийн үйлчилгээ дутагдсанаас өвчилжээ.

2010 оны 9 сард олон байгууллага, салбараас бүрдсэн KPK-ийн баг Шуурхай зах зээлийн зураглал ба үнэлгээ хийх аргыг (EMMA) ашиглан үнэлгээ хийсэн байна. (Albu, 2010 харна уу).

EMMA багийнхан улаан буудайн үр, мал аж ахуй, газар тариалангийн ажиллах хүч, мод шургаагны (малын хашаа хороо хийх) зах зээлд анхаарлаа хандуулж судалгаа хийсэн. Мал аж ахуйн бүрэлдэхүүн хэсгийн судалгаагаар мал амьтан нь жижиг фермер, газаргүй ажилчид

болох гол зорилтот бүлгийн хувьд чухал аюулгүй байх сүлжээ гэдэг нь тогтоогджээ. Түрээсийн фермерүүд хэмнэлт хийх, мал амьтнаа улаан буудай мэт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр солихыг илүүд үздэг. Мал аж ахуйтай холбоотой үерийн үр дагавар нь хөдөө аж ахуйд учирсан хохиролоос хамаардаг, учир нь малын бэлчээр, тэжээл үгүй болсноор мал амьтны биеийн байдал, эрүүл мэнд доройтдог. Орон нутгийн зах зээл дээр малын үнэ унадаг учраас өвчтэй мал амьтныг борлуулах нь ашиггүй байдаг. Уулархаг бүсэд өвлийн цагт амьжиргааны эх үүсвэр болсон малаа алдахгүйн тулд хашаа хороо яаралтай хэрэгцээтэй болдог тул мал амьтныг хөдөө аж ахуйн газраар солих шаардлага үүсдэг. Ямар ч байгууллага ийм нөхцөлд хашаа хороогоор хангах хувилбарыг авч үздэггүй байна. Судалгааны баг улаан буудай, хөдөлмөр, банз, модны нийлүүлэлттэй холбоотой зөвлөмжүүдийг харгалзан мал амьтанд чиглэсэн дөрвөн үйл ажиллагааг явуулахыг зөвлөсөн байна. Үүнд::

- бэлэн мөнгөнд суурилсан мал амьтныг тэжээл/ хашаа хороогоор хангах хөтөлбөрийг (тал газар тэжээл ба хашаа хороо, уулын бүсэд хашаа хороогоор хангах) яаралтай хэрэгжүүлэх, өвлийн турш үргэлжлүүлэх
- үлдсэн мал амьтныг хамгаалах хөтөлбөр яаралтай эхлүүлж дунд хугацааны үр дүн гарах хүртэл үргэлжлүүлэх
- банз, түлшний мод, талбайн захад тарьсан ургамлын холимог бүхий тэжээлээр хангах ажлыг яаралтай эхлүүлж дунд хугацааны үр дүн гарах хүртэл үргэлжлүүлэх
- уулын бүсэд өвлийн улирал эхлэхээс өмнө хүн амыг сууцжуулах хөтөлбөртэй хамтран малын хашаа хороог яаралтай барих (*Эх сурвалж: Vetwork, 2011*).

8.7 Үйл явцын жишээ,судалгаа: Мянмар дахь циклоны дараа олон зорилгоор ашиглаж болох хашаа хороо барьсан тухай

Маянмарт болсон Наргис Циклоны дараа нөхөн сэргээх төслийг хэрэгжүүлэх зорилгоор дөрвөн байгууллагаас бүрдсэн Концориум 2009 оны 7 сард байгуулагдсан. Консорциумын гишүүн байгууллага нь Олон Улсын Тусламжийн үйл ажиллагаа (Action Aid International), Настангуудад туслах Олон Улсын байгууллага (Help Age International) , Липросу Олон улсын байгууллага (The Leprosy Mission International) , Үүрдийн Ногоон бүлэг (Ever Green Group) нар юм. Энэхүү бүлэг нь Богал дүүргийн 51

тосгонд тогтвортой амьжиргааг дахин сэргээх амьжиргааны хөрөнгө болох мал амьтанд зориулан циклонд тэсвэртэй хашаа хороо барих зорилгоор ажилласан байна. Ялангуяа өөрийн газаргүй ажилчид, жижиг загасны аж ахуй эрхлэгчид, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, өрх толгойлсон эмэгтэйчүүд зэрэг эмзэг бүлгийнхэнийг илүү анхааран үзсэн.

Шуурхай үнэлгээгээр орон нутгийн дэд бүтэц байхгүй газар байнгын хашаа хороогүй ч гэсэн хүмүүс амьжиргааны хөрөнгө болох үр тариа, бордоо, багаж хэрэгсэл болон мал амьтнаа авч үлдэж чадсан байна. Иймээс нөхөн сэргээх төсөл нь эд хөрөнгөө хадгалах агуулах бий болгохын тулд (MPUs) байгуулсан. Энэхүү нэгж нь цаашид циклоны үр нөлөөг бууруулах, амьжиргааны хөрөнгийг хамгаалахад чиглэгдсэн.

MPUs буюу олон зорилгоор ашиглах нэгжийг барьж дуусаны дараа байгууламжийг ашиглах, тогтвортой ажиллуулах журам, зохицуулалтыг орон нутгийн иргэдтэй зөвлөлдөн, хамтран гаргасан байна. Энэ ньмал амьтан болон амьжиргааны хөрөнгөө хадгалах, уулзалт хийх, олон нийтийн дунд өөрсдөө эзэмшдэг мэдрэмжийг бий болгох зэрэг олон зорилгоор ашиглах боломжтой нэгж юм. Циклонд тэсвэртэй хашаа хороо барих ур чадвар нэмэгдсэн байна. Консорциумын туршлага нь одоогийн байгаа мэдлэг, орчин үеийн барилгын техникийг хослуулан ажиллах нь үр дүнтэйг харуулж байна. (*Эх сурвалж: Alam, 2010*).

8.8 Үйл явцын жишээ судалгаа: Болив дахь өвлийн хашаа хороогоор хангасан тухай

2001 оны дундуур Боливд болсон цасан шуурга, цочир хүйтрэлийн дараа НҮБ-ын ХХААБ мал амьтныг нэмэлт тэжээл, хашаа хороогоор хангах ажлыг зохион байгуулсан байна. (*Үйл явцын жишээ судалгаа 6.7* харна уу). Уламжлалт малын хашаа буюу дээвэргүй чулуу, шавраар хийсэн хана бүхий хашаа хороо байгуулжээ. Цаг агаарын гэнэтийн өөрчлөлт, бусад төрлийн араатан амьтны халдлагаас сэргийлэх зорилгоор лама гөрөөс, бусад төрлийн амьтан маллах хашаа хороог орон нутгийн материал ашиглаж, уламжлалт хийц загвараар барихад туслалцаа үзүүлсэн байна. Энэхүү санаачлага нь 50-аас бага лама гөрөөс малладаг айл өрхийг хамруулж, бага зардлаар хашаа хороо барих загвар болгон ашиглаж бусад айл өрх өөрсдөө санаа авч хийх боломжоор хангажээ. (Эх сурвалж: Einstein Tejada, personal communication, 2014).

Хавсралт 8.1: Мал амьтныг хашаа хороогоор хангах, байршуулалтын хэрэгцээг үнэлэх шалгах хуудас

Байршуулалтын асуудал

- Малчид суурьшлын ямар хэв маягтай вэ ?
  - Малчид өөрсдийн үндсэн газар нутгаас шилжин суурьшсан эсэх?
  - Түр зуурын, шилжилтийн эсвэл хуучин хашаа хороог сэлбэн засах, дахин барих шаардлага үүссэн үү?(Sphere Гарын авлага , хуудас 245.)
  - Мал амьтан бүхий өөр өөр төрлийн бүлэг хүмүүсийн хооронд зөрчил үүсэх боломжтой юу? жишээ нь, шилжин ирсэн болон үндсэн иргэдийн хооронд
  - Тухайн орон нутагт бэлчээрийн эх үүсвэр хангалттай юу? Онцгой байдлын дараа шилжин ирсэн иргэд, тэдний мал сүргээс шалтгаалан бэлчээрийн доройтол үүсэх эрсдэлтэй юу?
  - Одоогийн байгаа нийтийн буюу дундын хашаа хорооны газрын эрх, менежментийн систем ба байршуулалт нь ямар дэд бүтэцтэй вэ? Тэдгээр нь шинээр хашаа хороо барихад тохиромжтой эсэх ?
  - Малчдад өөр ямар төрлийн байршуулалт хийх хэрэгцээтэй байна вэ?

Хашаа хороо (түр зуур болон урт хугацаанд ашиглах)

- Нэн даруй малын хорогдлыг бууруулах хэрэгжүүлж болох арга хэмжээ байна уу? (газар хөдлөлтийн дараа боогдсон мал амьтныг чөлөөлөх гэх мэт)
- Түр зуурын малын хашаа хороо нэн даруй шаардлагатай байна уу?
- Ямар төрлийн хэдэн тооны мал амьтанд хашаа хороо шаардлагатай байна вэ?
- Өөр өөр төрлийн мал амьтан, уур амьсгал, байгаль орчны нөхцөлд тохирсон ямар хашаа хороо байх шаардлагатай вэ?
- Голлох ямар нийгмийн бүлэг байна вэ?

- Мал маллахад эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд ямар үүрэгтэй вэ?
- Тухайн орон нутагт хашаа хороо барих ажлыг голдуу хэн хариуцдаг вэ?
- ДОХ өвчтэй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд гэх мэт тусгай хэрэгцээтэй эсвэл эмзэг бүлгийнхэн байгаа эсэх?

- Орон нутагт ямар төрлийн малын хашаа хорооны хийц загвар, барих арга, түүхий эд материал ашигладаг вэ?
- Энэхүү барилгын туршлага нь ирээдүйд үүсэж болох гамшгийн үед мал хорогдох эрсдлийг бууруулж чадах уу?
- Орон нутагт барилгын материал олдоцтой юу?
  - Орон нутгийн барилгын материалыг яаж бэлтгэх вэ?
  - Хашаа хороо барих нь байгаль орчинд ноцтой нөлөөлөх үү?
  - Хашаа хороо барих ажлыг дэмжихэд орон нутгийн зах зээлд нөлөөлөхгүйгээр бэлэн мөнгө, эрхийн бичиг тараах арга тохиромжтой юу?
  - Барилгын материалыг тухайн газарлуу тээвэрлэх боломжтой юу?

Шинэ төрлийн мал амьтанд зориулсан хашаа хороо (жишээ нь, шувуу ба туулай)

- *Шинэ төрлийн мал амьтан маллахад зориулсан хашаа хороо бэлтгэж өгөхөд эмзэг бүлгийнхэнд ашигтай юу?*
- *Ашиг хүртэгчдэд хашаа хороо барих, менежментийн талаар сургалт явуулах шаардлагатай юу?*

Хавсралт 8.2: Малын хашаа хороогоор хангах ба байршуулалтын үйл ажиллагааны мониторинг ба үнэлгээний шалгуур үзүүлэлтийн жишээ

	Үйл явцын шалгуур үзүүлэлт *(болж байгаа үйл ажиллагааг хэмжих)*	**Үр нөлөөний шалгуур үзүүлэлт *(болж байгаа үйл ажиллагааны үр дүнг хэмжих)***
Тогтолцоог төлөвлөх	• Орон нутгийн иргэд, тэдний төлөөлөл, хувийн хэвшлийн нийлүүлэгч гэх мэт бусад оролцогчталуудтай хийсэн уулзалтын тоо	• Мал амьтныг хашаа хороогоор хангах хувилбаруудад дүн шинжилгээг тусгасан уулзалтын тэмдэглэл • Үйл ажиллагааны төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгасан байна: Үүнд: – Янз бүрийн оролцогчдын үүрэг ба хариуцлага – Хашаа хороогоор хангах техникийн үзүүлэлт – Загвар хийц, барилга, зохион байгуулалтад нутгийн иргэдийн оролцоо
Малын хашаа хороогоор хангах, байршуулах туслалцаа	• Хашаа хорооны тоо, төрөл байршилаар • байршуулалтын үйл ажиллагааны тоо, төрөл	• Хашаа хороотой болсон айл өрх/ малын тоог хашаа хороо хэрэгцээтэй байсан айл өрх/ малын тоонд харьцуулсан дүн • Хашаа хороонд малласан малын хорогдлыг хашаа хороогүй малласан малын тоонд харьцуулсан дүн • Хашаа хороогоор хангах үйл ажиллагааны үр дүнд малын гаралтай бүтээгдэхүүн өссөн эсвэл буурсан дүн, ялангуяа эмзэг бүлгийнхэн • Шилжин суурьшсан ба үндсэн иргэдийн хоорондох харилцаа • Нэрвэгдсэн хүн амын хэрэгцээт бэлчээр, дэд бүтэц, бусад байршуулалтын хүртээмж • Бодлогод нөлөөлсөн байдал

LEGS-н үнэлгээний арга хэрэгслийг доорх холбоосоор орж LEGS веб хуудаснаас үзэх боломжтой:<http://www.livestock-emergency.net/resources/general-resources-legs-specific/>.

Ашигласан хэвлэл ба цаашид уншиж судлах материал

Alam, K. (2010) *Joint review of the project "Reducing the vulnerability of under- assisted Cyclone Nargis affected populations"*,implemented-bytheConsortium of ActionAid International (AAI), HelpAge, Ever Green Group (EGG), and The Leprosy Mission International (TLMI) and funded by the Department for International Development(DFID).

Albu,M.(2010)*EmergencyMarketMappingandAnalysisToolkit*(EMMA),Practical ActionPublishing,Rugby.

BUETandBIDS(BangladeshUniversityofEngineering&TechnologyandBangladesh Institute of Development Studies) (1993) *Multipurpose Cyclone Shelter Programme*,FinalReport,Part1,July,PlanningCommission,Governmentof Bangladesh,Dhaka.

Corsellis, T. and Vitale, A. (2005) *Transitional Settlement: Displaced Populations*, Oxfam,Oxford.

CRS(CatholicReliefServices),EmergencyOperationsandEmergencyResponse Team (Shelters and Settlements) (2013) *Managing Post-Disaster (Re)-Construction Projects*, How-To Guide, CRS, Baltimore, MD,<http://www.crsprogramquality.org/publications/2013/1/11/managing-post-disaster-re- construction-projects.html>[accessed16May2014].

DostiDevelopmentFoundationandFoodandAgricultureOrganizationoftheUnited Nations(FAO)(2007)*LivestockShelterandSupplementaryCattleFeedProjectReport,2006–2007*,DostiDevelopmentFoundationandFAO,Pakistan.

IRINNews(2013)"WaveofnomadicpastoralrefugeeshitsChad"[newsreport]<http:// www.irinnews.org/fr/report/98657/wave-of-nomadic-pastoral-refugees-hits- chad>[accessed25May2014].

Jha,A.K.withBarenstein,J.D.,Phelps,P.M.,Pittet,D.,Sena,S.(2010)*SaferHomes, StrongerCommunities:AHandbookforReconstructingafterNaturalDisasters*, WorldBank,Washington,D.C.,<http://hdl.handle.net/10986/2409>[accessed 25 May2014].

Marks,M.andIslam,R.(2007)*TheCLPFloodReliefActivities(Aug2007):SummaryofReliefEffortsandCustomerSatisfactionSurvey*,Innovation,Monitoringand Learning Division, Chars Livelihood Programme, Maxwell Stamp,

DFID and GovernmentofBangladesh,LondonandDhaka.

NRC/CMP (Norwegian Refugee Council/Camp Management Project) (2008) *The Camp Management Toolkit*, NRC/CMP, Oslo, <http://www.nrc.no/camp> [accessed24June2014].

ShelterCentre(2012)*TransitionalShelterGuidelines*,ShelterCentre,Geneva,<http:// sheltercentre.org/node/4063>[accessed18May2014].

Shelterwebsites:

Shelter Centre Library: <http://www.sheltercentre.org/library>Shelter Cluster: <http://www.sheltercluster.org/Pages/default.aspx>

Shelter Case Studies: <www.sheltercasestudies.org> [all accessed 18 May 2014].

Sphere Project (2011) *Humanitarian Charter and Minimum Standards inHumanitarian Response* (the Sphere Handbook), The Sphere Project, Geneva, <www. sphereproject.org/>[accessed15May2014].

UNDRO(UnitedNationsDisasterReliefOrganization)(1982)*ShelterafterDisaster: GuidelinesforAssistance*,OxfordPolytechnicPress,Oxford.

UN-Habitat, IFRC and UNHCR (International Federation of Red Cross and Red Crescent Societies and Office of the United Nations High Commissioner for Refugees),*ShelterProjects2008,2009,2010and2011–2012*[website],<www.sheltercasestudies.org/>[accessed18May2014].

UNHCR(1998)*Livestockin Refugee Situations*,UNHCREnvironmentalGuidelines, UNHCR, Geneva, <http://home.wfp.org/stellent/groups/public/documents/ ena/wfp037503.pdf>[accessed18May2014].

UNHCR(2005)*Livestock-KeepingandAnimalHusbandryinRefugeeandReturnee Situations: A Practical Manual of Improved Management*, UNHCR and InternationalUnionforConservationofNature(IUCN),Geneva,<http://www. unhcr.org/protect/PROTECTION/4385e3432.pdf>[accessed-18May2014].

UNHCR(2007)*HandbookforEmergencies*,3rdedn,UNHCR,Geneva,<http://www. unhcr.org/472af2972.html>[accessed18May2014Vetwork (2011) *The Use of Cash Transfers in Livestock Emergencies and their IncorporationintotheLivestockEmergencyGuidelinesandStandards(LEGS)*, Animal Production and Health Working Paper No. 1, Food and Agriculture Organization of the United Nations (FAO), Rome. Available from: <http:// www.livestock-emergency.net/resources/general-resourc-

es-legs-specific/>[accessed18May2014].

White,C.M.(2006)*PakistaniCobAnimalShelter(technicaldrawings)*,unpublished.

Санамж

1. LEGS дэх «хуаран» гэсэн ойлголтыг Хуарангийн Менежмент Гарын авлага дахь (NRC/CMP, 2008) «төрөл бүрийн хуаран эсвэл хуаран маягийн суурьшил – дүрвэгсдэд зориулан төлөвлөсөн эсвэл өөрсдөө хуаран үүсгэсэн, хамтын төв, дамжин өнгөрөх, буцаах төв гэх мэт- түр зуурын суурин» гэсэн тодорхойлолтыг ашигласан. Үүнд: нүүлгэн шилжүүлэлтийн төв хамаарна.
2. LEGS нь үйлдвэржсэн аж ахуйд хамааралтай био-аюулгүй ажиллагааны талаар авч үзээгүй болно.

БҮЛЭГ 9

Малжуулах үйл ажиллагааны техникийн стандартууд

Малжуулах үйл ажиллагаа

Танилцуулга

Энэхүү бүлэгт онцгой байдлын дараа үеийн арга хэмжээний хүрээнд малжуулах (мал болон амьтан) үйл ажиллагааны ач холбогдлын талаар хэлэлцэх болно. Тус бүлэгт авах арга хэмжээний хувилбаруудыг тухайн арга хэмжээ нь зохистой эсэхийг тодорхойлоход хэрэглэгдэх аргачлалын хамтаар тусгасан. Хувилбар тус бүрт хамаарах Стандарт, Үндсэн үйл ажиллагаанууд болон Зааварчилгааг бүлгийн төгсгөлд багтаасан. Улмаар анхдагч үнэлгээ, мониторинг болон төгсгөлийн үнэлгээ хийхэд шаардлагатай хяналтын хуудас бүхий хавсралтуудыг тухайн бүлэгт оруулсан. Ашигласан хэвлэлийн жагсаалтыг бүлгийн төгсгөлд хавсаргав.

LEGS –н амьжиргааг дэмжих зорилтуудтай холбогдох нь

Малжуулах (мал, амьтан өгөх) үйл ажиллагаа нь мал аж ахуйд тохиолдсон онцгой байдлын үед баримтлах зааварчилгаа болон стандартад дурдагдсан *гамшигт нэрвэгдсэн ард иргэдийн үндсэн хөрөнгө болсон мал сүргийг нөхөн сэргээх* гэсэн гурав дахь зорилттой хамааралтай бөгөөд онцгой байдал тохиолдоход гамшгийн дараа үеийн болон нөхөн сэргээх үе шатанд хамрагдана.

Онцгой байдлын хариу арга хэмжээн дэх малжуулах үйл ажиллагааны ач холбогдол

Гамшиг, ялангуяа гэнэтийн гамшгийн үр дүнд ихээхэн хэмжээний мал хорогдох тохиолдолд малжуулах нь гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн эдийн засгийн ач холбогдол бүхий хөрөнгийг нөхөн сэргээж, мах, сүү зэрэг малын гаралтай, чанартай хүнсний бүтээгдэхүүнээр хангах хамгийн үр дүнтэй арга байдаг. Харин удаан явцтай гамшгийн үед малын тоо толгойг бууруулах, мал эмнэлгийн үйлчилгээний дэмжлэг үзүүлэх, малын тэжээл, усаар хангах зэрэг мал, амьтан олон тоогоор хорогдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг юуны өмнө харгалзан үзэх шаардлагатай.

Малжуулах үйл ажиллагаа хэр амжилттай болох нь мал амьтан онд орох, гамшгийг тэсвэрлэн гарах, малжуулах үйл ажиллагааны ашиг хүртэгчдийн амьжиргаанд эерэг хувь нэмэр болохуйц хэмжээнд өсөн

үржих боломж зэргээр тодорхойлогдоно. Малжуулах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх арга замыг хэрэгжүүлснээр Танилцуулга хэсэгт дурдсан малын тавлаг байдлын таван нийтлэг зарчмыг мөн хангана:

- *өлсөх, цангахаас ангид байлгах*
- *тохь, тухгүй байдлаас ангид байлгах*
- *гэмтэл, өвчнөөс ангид байлгах*
- *төрөлхийн араншингаа хэвийн байдлаар илэрхийлэх*
- *айдас, дарамтаас ангид байлгах*

Хэрэв малын тавлаг байдлыг хангах сайн дадлыг хэрэгжүүлсэн тохиолдолд малжуулах үйл ажиллагаа нь малын амьд үлдэх боломжийг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний гарцыг сайжруулснаар иргэдийн амьжиргаанд эерэг нөлөө үзүүлэх юм.

Малжуулах хувилбарууд

Амьжиргааны стратеги болон ашиг хүртэгчдэд буй боломжид суурилан малжуулах үйл ажиллагааг доорх дурдсан хоёр хэлбэрийн аль нэгийг ашиглан гүйцэтгэж болно.

1. *Мал хөрөнгийг шинэчлэх сэлбэх (бүтэц өөрчлөх):* Тухайн өрхийн амьжиргаанд мал амьтны гүйцэтгэж буй үүргээс шалтгаалан энэхүү үйл ажиллагааг өөр өөр хэлбэртэйгээр явуулж болно:
   - **1.1** Бэлчээрийн болон газар тариалан-бэлчээрийн хосолсон мал аж ахуй эрхлэгчдийн сүрэгт өөрчлөлт хийх, сэлбэх
   - **1.2** Бага хэмжээний тариалан эрхлэгчдийн цөөн тооны мал, амьтныг нөхөн сэлбэж орлого олох боломжийг хангах (жишээ нь тээвэр, ердийн хөсөгт ашиглах мал амьтан)
2. *Мал хөрөнгө бий болгох:* Амьжиргааг дэмжих үйл ажиллагаанд зориулан шинээр малжуулах.

Энэхүү бүлэг нь малжуулах үйл ажиллагааны дээрх гол төрлүүдийн талаар дурдахын зэрэгцээ бүхий л хувилбар дээр адил хэмжээнд баримтлах шаардлагатай дөрвөн стандартыг мөн багтаасан болно.

Хувилбар 1: *Мал хөрөнгийг шинэчлэх/сэлбэх*

1.1 Бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид болон тариалан, мал аж ахуйг хавсран эрхлэгчдийн мал хөрөнгийг шинэчлэх/сэлбэх. Мал, амьтан нь хүнс тэжээл, орлого болон нийгмийн сайн сайхан байдалд онцгой хамааралтай байдаг тул бэлчээрийн аж ахуй болон мал аж ахуй- газар тариалан хослуулан эрхэлдэг газар нутгуудад онцгой байдал үүссэн тохиолдолд бүх мал сүргээ алдах эрсдэл тулгаран, үүнээс үүдэн иргэдийн амьжиргаанд үзүүлэх нөлөөлөл нь ноцтой хэмжээнд хүрдэг. Эдгээр хүмүүсийн ихэнх нь Африкийн хагас хуурай нам доор газраас эхлээд Монголын тал нутаг хүртэл өргөн уудам нутаг дэвсгэрийг хамран амьдарч байна. Зарим хэсэг нь хонь, ямаа, үхэр, тэмээ зэрэг олон төрөл малыг хариулан амьдардаг бол нөгөө хэсэг нь сарлаг эсвэл цаа буга зэрэг зөвхөн нэг төрлийн малаас хамааралтай амьдардаг.

Амьжиргааны арга барил олон төрөл байдгийг харгалзан мал хөрөнгө шинэчлэх, сэлбэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд олон талт хэтийн төлвийг тооцсоноос илүүтэйгээр орон нутагт амьжиргааны дүн шинжилгээ хийх нь илүү ач холбогдолтой юм. Амьжиргаанд хүрэлцэхүйц малын тоо хэмжээ ямар байх, хичнээн тооны ямар төрлийн мал амьжиргааг хангаж болохыг тодорхойлоход нутгийн иргэдтэй нь харилцан зөвлөлдөх нь чухал юм. Уламжлалт мэдлэг нь тухайн орон нутагт хамгийн зохистой бөгөөд тэр нь хэдий сул, сайн ажилладаггүй ч гэсэн мал хөрөнгийг дахин хуваарилах уламжлалт тогтолцоо тухайн газруудад аль хэдийн үүсэн бий болсон байдаг. Иймд үйл ажиллагаа нь тухайн орон нутагт үйлчилж буй механизм, арга ажиллагаанд (*Бүлгийн төгсгөлд буй Хавсралт 9.4 болон Нийтлэг стандарт 1: Оролцоо* хэсгийг харна уу) үндэслэх хэрэгтэй. Эдгээр иргэдэд мал, амьтан хэрхэн арчлах, хариулах, өсгөхтэй холбоотой сургалт шаардлагагүй байж болно. Харин нэг өрхөд ноогдох нийт зардал нь өндөр байж болох ба учир нь тодорхой хугацаанд багтаан, шаардлагатай хамгийн доод хэмжээний мал, амьтнаар хангахуйц тооны мал шаардлагатай байдаг.

Онцгой байдлын дараах нөхөн сэргээлтийн шатанд малжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж буй байгууллагууд нь малаас хамааралтай ард иргэдийн чадавхийг бэхжүүлэх, ирээдүйд тулгарч болох гамшиг, сорилтуудыг даван туулах, дасан зохицох чадварыг нэмэгдүүлэхүйц өргөн хүрээний, урт хугацааны хандлагыг судлан үзэх шаардлага гарна. Тулгарч болох бэрхшээлүүд нь эдийн засаг болон бодлогын орчин, мөн байгалийн нөөцөөс хамааралтай байна. Ялангуяа нүүдлийн мал аж ахуй

эрхэлдэг газруудад мал сэлбэх/шинэчлэх нь урт хугацааны бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэх санаачилгуудтай нягт уялдах шаардлагатай. Жишээ нь зах зээлд бараа бүтээгдэхүүн гаргах нөхцлийг сайжруулах, түүнчлэн зах зээлд суурилсан үйлдвэрлэлийн чадавхийг бэхжүүлэх зэргийг мал, амьтан сэлбэх, шинэчлэх үйл ажиллагаатай зэрэг явуулах хэрэгтэй.

1.2 Бага хэмжээний тариалан эрхлэгчдийн цөөн тооны мал, амьтныг сэлбэн шинэчлэж орлого олох боломжийг хангах. Зарим улс орны нөхцөл байдлаас авч үзвэл харьцангуй цөөн тооны мал амьтан өсгөх нь амьжиргааг дэмжих үр ашигтай хэлбэр байдаг. Хэдий тухайн хүмүүс цөөн тооны малтай ч (зарим тохиолдолд малын гаралтай бус хүнсний бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэдэг) тухайн мал, амьтнаас авдаг хүнс эсвэл олдог орлого нь тэдний амьжиргааны чухал бүрэлдэхүүн хэсэг байж болно. Жишээ нь Тайланд, Вьетнамын тариаланчид цөөн тооны үхэр, гахай болон/эсвэл шувуу үржүүлдэг бөгөөд гол зорилго нь бэлэн мөнгөний хэрэгцээ гарахад зарж борлуулах эсвэл хурим зэрэг тэмдэглэлт арга хэмжээний үеэр хэрэглэх явдал ажээ. Үүний нэгэн адил ногоо тариалагч Африкийн жижиг бизнесүүд сүүний чиглэлээр өсгөдөг цөөн тооны үнээтэй, өндөгийг нь зарж борлуулах тахиатай, газар хагалах зорилгоор шар үхэртэй байдаг. Бэлчээрийн болон хагас суурин аж ахуйд фермерүүд мал өсгөх, хариулах ихээхэн туршлагатай, ур чадвартай хэдий ч малын тоо толгой нь харьцангуй цөөн байдаг юм.

Түүнчлэн зарим өрхүүд зөвхөн нэг төрлийн мал, амьтнаас (жишээ нь тээвэр хийхэд ашиглах илжиг, луус гэх мэт) эсвэл цөөн тооны мал, амьтнаас (орлогын гол эх үүсвэр) ихээхэн хамааралтай байдаг. Хүмүүнлэгийн тусламж хүргэхэд ч мал, амьтан ашиглаж болдог. Непал улсад алслагдсан ууархаг бүсийн ард иргэдэд хүнсний тусламж хүргэхэд луус ашигладаг. Дээр дурдсан мал, амьтныг сольж шинэчлэн сэлбэх нь гамшигт нэрвэгдсэн иргэдийн амьжиргаанд ихээхэн үнэтэй хувь нэмэр оруулна.

Хувилбар 2: Малжуулан хөрөнгөтэй болгох

Бага хэмжээнд эрхэлж буй ч мал аж ахуй нь ядуу, эмзэг бүлгийн иргэдэд доорх болон бусад нөхцөлд ч гэсэн амьжиргааны ихээхэн чухал боломжийг бий болгодог:

- мөргөлдөөнөөс үүдэн тариалангийн талбай, бэлчээрийн хүртээмж хомсдох (*Жишээ судалгаа болгон Хавсралт 9.3:* дүрвэгсдийн хуаран дахь хүмүүсийг малжуулах хэсгийг харна уу)
- тариалан эрхлэх боломжтой газрын эрхийг нийгмийн тодорхой давхарга эсвэл отог омог түлхүү эзэмшдэг үед
- орлогын эх үүсвэр хомсдох
- "гангийн гэнэтийн сан" хэлбэрээр ашиглах (*Бүлгийн эцэст буй Үйл явцын Жишээ судалгаа 9.2* харна уу)
- байгалийн нөөц их ч амьжиргааны бусад боломжууд хязгаарлагдмал байх.

Мал амьтан нь өдөр тутмын үйл ажиллагаанд (тээвэр, ердийн хөсөг) чухал үүргийг гүйцэтгэх тул хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд (газар хагалах, үр тариа цайруулах, бордох гэх мэт) үр дүнтэй бүрэлдэхүүн хэсэг болж байдаг. Харин хөдөө аж ахуй эрхлэгчдийг шинээр малжуулах үйл ажиллагаанд хамрагдсан хүмүүс нь өмнө нь мал, амьтан ашиглаж байгаагүйн улмаас маллах туршлага хомс байж болно. Энэ тохиолдолд мал аж ахуй, бэлчээр тэжээллэгийн сургалт, хэрэгцээтэй бол маркетингийн сургалт нь малжуулах үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг болно.

Эдгээр хувилбаруудын давуу болон сул талууд, үзүүлэх нөлөөлөл зэргийг *Хүснэгт 9.1* дээр тоймлон харууллаа.

Хүснэгт 9.1 Малжуулах хувилбаруудын давуу болон сул талууд

Хувилбарууд	Давуу тал	Сул тал	Нөлөөлөл
1.1 Мал хөрөнгийг шинэчлэх, сэлбэх: Бэлчээрийн болон газар тариалан-бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийн сүрэгт өөрчлөлт хийх, сэлбэх	• Их хэмжээний малын хорогдлыг нөхөх • Ирээдүйн амьжиргааны хөрөнгийг нэмэгдүүлэх, улмаар амьжиргааг бэхжүүлэх боломж бүхий урт хугацааны хариу арга хэмжээ • Орон нутгийн уугуул мал сүргийн дахин хуваарилалтын тогтолцоонд суурилах боломж • Амьжиргаа нь худалдаа болон мал аж ахуйн гаралтай үйлдвэрлэлээс (боловсруулах үйлдвэрлэл, дуудлага худалдаачид, тээвэрлэгчид гэх мэт) хамаардаг бусад талуудад үр дүнг хүртээх боломж	• Өрх бүрт шаардлагатай хамгийн доод тооны малыг хангах тул нэг өрхөд ноогдох зардал өндөр байх • Шаардлагатай төрөл болон үүлдрийн мал амьтныг худалдан авах, хүргэхэд ихээхэн хэмжээний ложистик үйл ажиллагааны удирдлага шаардагдана	• Ашиг хүртэгч ард иргэдийн амьжиргаа нь үндсэндээ зөвхөн мал, амьтнаас л хамааралтай бол хэрэгжүүлэхэд зохистой • Мал аж ахуйг үргэлжлүүлэн явуулахад ашиг хүртэгчдэд хангалттай хөрөнгө шаардлагатай (Нийгмийн харилцаа холбоо, бэлчээр болон усны хүртээмж, техникийн мэдлэг гэх мэт) • Мал аж ахуйтай холбоотой бусад дэмжлэг (мал эмнэлгийн үйлчилгээ, өвс тэжээл, хашаа хороо гэх мэт) шаардагдаж болно • Шилжилтийн хугацаанд амьжиргаанд хандсан бусад дэмжлэг (жишээ нь хүнсний тусламж) шаардагдаж болно • Тохирох мал, амьтныг хангах эх үүсвэрийг ойролцоо зайд олж тогтоох
1.2 Мал хөрөнгийг шинэчлэх, сэлбэх: Бага хэмжээний тариалан эрхлэгчдийн цөөн тооны мал, амьтныг сэлбэн шинэчлэж орлого олох боломжийг хангах	• Хорогдсон малыг орлон доорх үр дүнг хүргэх: - хоол хүнсний хангамж - орлого олох (бүтээгдэхүүнээ борлуулах, тээврийн бизнес) - ердийн хөсөг, тээврийн хэрэглээ	• Амьжиргаа дэмжих бусад үйл ажиллагаатай харьцуулбал мал хөрөнгө сэлбэх шинэчлэх үйл ажиллагааны зардал өндөр байж болно	• Бусад нэмэлт дэмжих үйл ажиллагаа (мал эмнэлэг, өвс тэжээл, хашаа хороо гэх мэт) шаардагдаж болно • Тохирох мал, амьтныг хангах эх үүсвэрийг ойролцоо зайд олж тогтоох

Хувилбарууд	Давуу тал	Сул тал	Нөлөөлөл
2. Мал хөрөнгө бий болгох: Амьжиргааг дэмжих үйл ажиллагаанд зориулан шинээр малжуулах	• Хорогдсон малыг орлон доорх үр дүнг хүргэх: – хоол хүнсний хангамж – орлого олох (бүтээгдэхүүнээ борлуулах, тээврийн бизнес) – ердийн хөсөг, тээврийн хэрэглээ • Мөргөлдөөн, эмзэг байдал болон бусад саад тотгороос хамааран амьжиргааны бусад хувилбарууд хязгаарлагдмал үед амьжиргааны боломжуудыг хангах	• Шинэ төрлийн эсвэл үүлдрийн мал амьтан нийлүүлэх нь хүлээн авсан хүмүүст нэмэлт дэмжлэг, сургалт хийх шаардлага үүсгэнэ • Амьжиргаа дэмжих бусад үйл ажиллагаатай харьцуулбал малжуулах үйл ажиллагааны зардал өндөр байж болно	• Тохирох мал, амьтныг хангах эх үүсвэрийг ойролцоо зайд олж тогтоох • Шинээр мал маллаж эхэлж буй хүмүүст мал маллагааны менежментийн сургалт чухал

Үйл ажиллагааг хэрэгжүүлэх зохистой хугацаа

Мал шинэчлэн сэлбэх, фермерийн аж ахуй эрхлэх болон орлогын эх үүсвэр бий болгох эсвэл шинээр хэрэгжүүлж буй санаачилга зэрэг аль ч хэлбэрийн малжуулах үйл ажиллагааг үндсэндээ гэнэтийн болон удаан явцтай гамшиг, онцгой байдлын дараах нөхөн сэргээх/сэргээн босгох шатанд авч хэрэгжүүлдэг. Энэхүү үйл ажиллагаа нь өргөн хүрээний төлөвлөлт, захиргааны чиглэлийн арга хэмжээг шаардах тул тухайн онцгой байдлын үе шатанд хэрэгжүүлэх боломжгүй байж болно. Мөн онцгой байдлын үеэр устан, хомсдсон нэмэлт дэмжлэг (тэжээл, ус, хашаа хороо, мал эмнэлгийн үйлчилгээ) үзүүлэхийг шаардана. Түүнчлэн тухайн хүн ам нь нэмэлтээр өгсөн эсвэл сэлбэн шинэчилсэн мал, амьтныг арчлах наад захын чадавхигүй байж болно (*Стандарт 2 Малжуулах, Зааварчилгаа 5*-ыг харна уу). Гэхдээ малд шаардлагатай байгалийн нөөц шавхагдаагүй, мөн ханган нийлүүлэх малын тоо нь харьцангуй бага нөхцөлд онцгой байдлын эрт үеийн сэргээн босголтын шатанд малжуулах үйл ажиллагааг эхлүүлж болно (*Хүснэгт 9.2*). Малжуулах үйл ажиллагааг аль болох боломжоор урт хугацааны хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан, ашиг хүртэгч бүлэгт дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

Хүснэгт 9.2 **Малжуулах үйл ажиллагааны зохистой хугацаа**

Хувилбарууд	Гэнэтийн гамшиг			Удаан явцтай гамшиг			
	Гэнэтийн хор хохирол	Шуурхай нөхөн сэргээлт	Нөхөн сэргээлт	Сэрэмжлүүлэг	Түгшүүр	Онцгой байдал	Нөхөн сэргээлт
1.1 Мал хөрөнгийг шинэчлэх, сэлбэх: сүрэгт өөрчлөлт хийх, сэлбэх			→				→
1.2 Мал хөрөнгө шинэчлэх, сэлбэх: орлого олох боломжийг хангах		→	→				→
2. Мал хөрөнгө бий болгох**:** Амьжиргааг дэмжих үйл ажиллагаанд зориулан шинээр малжуулах		→	→				→

Sphere ба LEGS-н бусад бүлэгтэй холбогдох нь

Онцгой байдал үүссэний дараах хариу арга хэмжээ болгон авч хэрэгжүүлэх малжуулах үйл ажиллагаа нь мал аж ахуйн бусад үйл ажиллагаатай нягт уялдаа холбоотой байхыг шаарддаг. Мал аж ахуйд өвс тэжээл, ус, хашаа хороо болон мал эмнэлгийн үйлчилгээ янз бүрийн хэмжээгээр шаардлагатай байдаг. Иймд мал аж ахуйд тохиолдсон онцгой байдлын үед баримтлах заавар болон стандартуудын энэхүү гарын авлагад дээрх асуудлын талаар дэлгэрэнгүй тусгагдсан бөгөөд холбогдох үйл ажиллагааны Стандартыг анхааралдаа авч, харилцан зөвлөлдөж, хэрэгжүүлэх шаардлагатай. (*Бүлэг 5, 6, 7 болон 8-ыг* харна уу). Ялангуяа малжуулах үйл ажиллагааг хийхдээ тухайн малыг худалдсан этгээд хүлээн авагчид шууд хүргэж өгөх бол мал эмнэлгийн үйлчилгээг харгалзан үзэх ёстой.

Шаардлагатай мал, амьтнаар хангахад малыг хүлээн авсан өрхүүдэд үндсэн хэрэгцээгээ хангахын тулд бусад төрлийн нэмэлт туслалцаа шаардлагатай болно. Бэлчээрийн мал аж ахуй болон мал аж ахуй-

тариалан хосолсон нөхцөлд малжуулах арга хэмжээ хэрэгжүүлэхэд хүлээн авсан айл өрхийн хувьд нэмэлт туслалцаагүйгээр өөрийн мал сүргийг өсгөх, тоо толгойг нь нэмэгдүүлэхэд олон сар, жил шаардлагатай болно. (*Малжуулах стандарт 4*-ийг харна уу). Иймд малжуулах үйл ажиллагааг бусад тусламж, дэмжлэгтэй уялдуулсан байх шаардлагатай. Sphere гарын авлагад (2011) тусгагдсан "Хүнсний баталгаат байдал, тэжээллэгийн наад захын стандартууд" болон "Хашаа, хороо, хүнс тэжээлийн бус зүйлийн наад захын стандарт" зэргийг сайтар судлан үзэх шаардлагатай.

Нийтлэг болон харгалзан үзэх бусад асуудлууд

Малжуулах үйл ажиллагаа нь иргэдийн эмзэг байдал, чадавхи болон байгууллагын чадавхиас шалтгаалан тодорхой бэрхшээл тулгарч болно. Иймд малжуулах хөтөлбөрийг амжилттай явуулахын тулд хэд хэдэн асуудалд анхаарлаа хандуулан, харгалзан үзэж байх шаардлагатай.

Хүйсийн асуудал болон нийгмийн тэгш байдал

Эмзэг бүлгийн иргэд, өрхүүдийн үүрэг, хэрэгцээг харгалзан үзэх шаардлагатай бөгөөд үүнд мал амьтны хариулга, маллагаа, менежмент дэх хүйсийн үүргийг сайтар харгалзах шаардлагатай. Зарим газар нутагт эмэгтэйчүүд мал, амьтны албан ёсны эзэмшигч нь байж, мал хариулах, арчлах үүргийг хүлээж, ялангуяа цөөн тооны мал, амьтантай бол энэхүү үүрэг нь улам нэмэгдэж ирдэг. Иймд малжуулах санаачилга нь эдгээр ард иргэдийн үүрэг, уламжлалт мэдлэгт суурилан, малжуулснаар тухайн хүмүүст ирэх ажлын ачаалал, ажил, үүргийн хуваарилалт зэргийг харгалзан үзэх шаардлагатай. Үүний зэрэгцээ малаас хүртдэг ашиг шимтэй холбоотой хэм хэмжээг харгалзан үзэж, эмзэг бүлгийн иргэд тухайн малжуулах үйл ажиллагааны үр дүнг үргэлжлүүлэн, аль болох их хэмжээгээр хүртэж байхыг баталгаажуулах хэрэгтэй. Жишээ нь мал хариулах болон услах үүргийг ихэнх тохиолдолд хүүхдүүд хийж гүйцэтгэдэг, бэлчээрт малаа сааж уух нь тэдний хувьд хүнс тэжээлийн эх үүсвэр байж болно. Гэхдээ дээрх ажлыг байнга хийх нь хүүхдүүдийг сургуулиас завсардахад хүргэж болно. Иймд боловсролын хөтөлбөртэй үйл ажиллагааг уялдуулан, хүүхдүүд мал хариулах болон сургуульд сурах боломжийг зэрэг хангах ёстой.

ХДХВ-ын халдвартай хүмүүс

ХДХВ/ДОХ-той хүмүүс нь малаас хүнд дамждаг өвчнөөр халдварлах өндөр эрсдэл бүхий бүлэг юм. ХДХВ-тэй гэр бүлд мал хариулах хангалттай ажиллах хүч хомс байдаг. Үүний зэрэгцээ энэхүү гарын авлагад дурдсанаар малын гаралтай бүтээгдэхүүн нь ХДХВ-тэй хүмүүсийн хүнс тэжээллэгийн хэрэгцээг хангахад ихээхэн үүрэгтэй байдаг.

Хамгаалалт

Хамгаалалт, аюулгүй байдлын асуудлууд нь малжуулах үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болно. Аюултай нөхцөлд байдалд зэвсэглэсэн босогчид, цагдаа, аюулгүйн албаныхан эсвэл гэмт хэрэгтнүүдэд мал амьтан нь үнэ цэнэтэй, хялбархан олз олох эх үүсвэр болдог. Зарим тохиолдолд зэвсэгт бүлэглэлүүд болон Засгийн газар ч гэсэн мал, амьтныг дээрэмдэх, хураан авах, олон нийтийг айлган сүрдүүлэх болон эд хөрөнгөнөөс нь салгах тактикын арга хэмжээг ашигладаг. Үүнээс үүдээд зарим нөхцөлд малжуулах нь эмзэг бүлгийнхнийг хүчирхийлэлд өртөх илүү өндөр эрсдэлд оруулдаг. Малжуулахаар сонгон авч буй малын төрөл нь хулгайд алдах эрсдлийг бууруулж болох ба жишээ нь үхэртэй харьцуулбал малын хулгайч нар ямааг харьцангуй бага сонирхдог. Нөөц эх үүсвэр хомс газар их хэмжээний мал нийлүүлэн малжуулах нь малчид, тариаланчдын хооронд эсвэл малчдын хооронд зөрчил үүсгэх нэг шалтгаан болж болно. Мөргөлдөөн бүхий бүсэд ажиллаж буй байгууллагууд нь хулгайлагдсан мал, амьтныг худалдан авахгүй байхад анхаарлаа хандуулах шаардлагатай.

Байгаль орчин

Малжуулах үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд анхаарлаа хандуулах шаардлагатай. Урьд өмнө нь олон тооны мал бэлчээх даацгүй байсан газар нутагт гэнэт олон тооны мал нийлүүлэх нь цаашид бэлчээрийн доройтолд хүргэж болно. Гэхдээ ихэнх тохиолдолд сүрэг сэлбэх, шинэчлэх нь эмзэг, үржил шим багатай бүс нутгуудад, мал аж ахуйг удирдах механизмуудыг хөгжүүлсэн бэлчээрийн аж ахуй болон мал аж ахуй-тариалан хосолсон газруудад тэнцвэртэй байгаль орчин бүхий газарт л хэрэгжинэ. Үүнтэй зэрэгцээд сүрэг шинэчлэх, сэлбэх үйл ажиллагаа нь орон нутгийн байгаль орчны нөхцөл байдалд

тэнцвэртэйгээс гадна хүлээн авч буй өрхийн амьжиргааг хангах тооны мал нийлүүлэхийг баталгаажуулж байх нь чухал. Мөн тухайн тооны малд хүрэлцэхүйц хэмжээний тэжээл, усан хангамж буй эсэхийг шалгах шаардлагатай.

Зорилтот бүлэг тодорхойлох

Мал сүрэг сэлбэх, шинэчлэхтэй холбоотойгоор зорилтот бүлэгт төвлөрөх онцлог асуудлууд байдаг. Бэлчээрийн мал аж ахуй болон мал аж ахуй-тариалан хосолсон нөхцөлд малжуулах үйл ажиллагаа нь мал аж ахуйд суурилсан амьжиргааг нэн даруй сэргээхийг гол зорилгоо болгоно. Энэ нөхцөл байдалд хамгийн эмзэг эсвэл ядуу өрхүүдийг зорилтот бүлэг болгон малжуулах бус харин тодорхой тооны малтай, мал аж ахуйд суурилсан амьжиргаагаа сэргээх эрмэлзлэл, мал амьтан өсгөх мэдлэг, туршлага бүхий өрхүүдэд төвлөрөн, тэднийг зорилтот бүлэг болгон, үйл ажиллагааг хэрэгжүүлэх ёстой. Ийнхүү тодорхой зорилтот бүлгийг тодорхойлоход нь хоёр үндсэн асуулт гарч ирдэг. Нэгдүгээрт "Хүмүүнлэгийн арга хэмжээний хүрээнд хамгийн эмзэг бус бүлэгт малжуулах туслалцаа үзүүлэхээр зорин ажиллах нь тохиромжтой юу?", Хоёрдугаарт "Эмзэг өрхүүдэд ямар төрлийн туслалцаа хамгийн зохистой байх вэ?" гэсэн асуулт урган гарна. Эдгээрт зохих хариулт өгөх нь нээлттэй бөгөөд хэлэлцүүлэг зохион байгуулах бөгөөд хариулт нь тухайн орон нутгийн иргэдээс шалтгаална. Олон нийтийн оролцоо нь тухайн сонгон авсан зорилтот бүлгийг хүлээн зөвшөөрөх, ашиг хүртэгч бус хүмүүст ойлгуулахад ач холбогдолтой, ил тод үйл явц байдаг.

Жижиг тариалан эрхлэгч фермерүүдэд болон орлого нэмэгдүүлэх зорилгоор мал, амьтныг сэлбэх, шинэчлэхэд болон шинээр малжуулахад ч тодорхой бүлэгт анхаарлаа хандуулах шаардлага байдаг. Үндсэндээ малаас хамаарал багатай хүмүүсийн хувьд амьжиргааны анхан шатны үнэлгээ хийх зорилго нь хөрөнгө чинээ, хүйсээс хамааран мал аж ахуй эрхлэх байдлыг тодорхойлж, үүний үндсэн дээр тусламжийн үйл ажиллагааг төлөвлөх явдал юм. . Ерөнхийдөө эрэгтэйчүүд болон чинээлэг хэсэг нь үхэр, адуу, тэмээ зэрэг бод мал эзэмшиж байдаг бол ядуус, эмэгтэйчүүд ихэнхдээ хонь, ямаа зэрэг бог мал, тахиа шувууг эзэмшиж байдаг. Энэ тохиолдолд бог мал эсвэл тахиа шувуу зэрэг амьтнаар хангах нь ядуус, эмзэг бүлэгт дэмжлэг үзүүлэх хамгийн тохиромжтой арга болно.

Өвчин тархах

Мал, хүн ойр амьдрах, малтай ойроос харьцах зэрэг тохиолдолд мал, амьтнаас хүнд өвчин дамжих боломжтой бөгөөд ялангуяа хот орчмын болон хуарангийн нөхцөл байдалд үүсэж болно. *(Хавсралт 9.3-ыг харна уу)*. Иймд нийт малын тоо хэмжээ болон нэмэлт дэмжлэг нь орон нутгийн нөхцөл байдалд нийцсэн, мал сүргийн дунд өвчин тархах эрсдлийг бууруулсан байх ёстой.

Орон нутгийн чадавхи

Гамшигт нэрвэгдсэн ард иргэд өмнө тохиолдож байсан гамшгаас авсан сургамж дээр нь суурилсан өөрийн гэсэн чадавхитай байдаг. Мал аж ахуй эрхэлдэг улс орнууд тухайн нутгийн онцлог бүхий, уламжлалт малжуулах тогтолцоотой байдаг ба энэ тохиолдолд эмзэг бүлгийн, ядуу өрхүүд үнэ төлбөргүй эсвэл бэлэг хэлбэрээр мал амьтан авч, гарсан төлийг нь эсвэл тухайн өгсөн мал амьтныг дараагийн хүлээн авагчид шилжүүлэх байдлаар хэрэгжиж байдаг. Ийм төрлийн механизм нь малжуулах үйл ажиллагааны үндэс суурь болж энэхүү нутгийн онцлог, уламжлалт мэдлэгт суурилах нь малжуулах үйл ажиллагааны ирээдүйн тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ *(Бүлгийн төгсгөлд Үйл явцын жишээ судалгаа 9.2-ыг харна уу)*.

Байгууллагын чадавхи болон төлөвлөлт

Малын ашиг шимийг олон янзаар хүртэж болох ч онцгой байдал үүссэний дараа эсвэл сэргээн босголтын үе шатанд малжуулах үйл ажиллагаа техникийн болон үйл ажиллагааны хувьд ихээхэн ээдрээтэй, үүний зэрэгцээ зардал өндөртэй үйл ажиллагаа юм. Малжуулах нь нийгэм, байгаль орчин, эдийн засгийн эерэг болон сөрөг нөлөөллийг үзүүлж болдог. Малжуулах үйл ажиллагааны олон хэсэг дээр маргаантай байдаг ба жишээ нь тухайн онцгой байдал дахин үүсэх тохиолдолд авсан арга хэмжээний тогтвортой байдал, хүлээн авагчдын чадавхи болон буруу төлөвлөлт гэх мэт олон асуудлаар сөрөг үзэл бодол гарч байдаг. Үүнээс гадна нийт өрхийн тоонд харьцуулж үзвэл малжуулах төсөл нь харьцангуй өндөр зардалтай, ялангуяа малжуулах үйл ажиллагаанд мал эмнэлгийн үйлчилгээ, хашаа хороо болон сургалт хамтран хэрэгжих тохиолдолд энэхүү зардлын хэмжээ өсдөг.

Малжуулах үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөн, хэрэгжүүлэхэд нарийн төвөгтэй асуудлууд гардаг учраас байгууллагууд нь энэ төрлийн арга хэмжээ хэрэгжүүлэх чадавхи байгаа эсэхээ сайтар нягтлан үзэх шаардлагатай. Олон байгууллагуудад гадны экспертүүдийг татан оролцуулах шаардлага гардаг тул цаг хугацаа, хүч хөдөлмөр ихээхэн шаардагдана. Өнөөгийн байдлаар тодорхой бүс нутагт урт хугацааны хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлсэн туршлага бүхий байгууллагууд нь малжуулах үйл ажиллагааг явуулахад хамгийн тохиромжтой бөгөөд учир нь тухайн байгууллагууд орон нутгийн мал амьтны хэрэглээ, нийгмийн тогтолцооны талаар сайн мэдээлэлтэй байдаг.

Бэлэн мөнгө ашиглах

Орон нутгийн зах зээл бодитоор үйл ажиллагаа явуулан мал амьтан болон түүнд шаардлагатай нэмэлт зүйлсийг (*Бүлэг 3, Анхдагч үнэлгээ болон хариу арга хэмжээг тодорхойлох* гэсэн хэсэг дээрх бэлэн мөнгө дэд хэсгийг харна уу) ханган нийлүүлэх боломжтой тохиолдолд бэлэн мөнгө хэрэглэх нь малжуулах үйл ажиллагаанд хэрэглэх зохистой механизм байж болно. Мал худалдан авахад зориулан бэлэн мөнгө эсвэл эрхийн бичиг олгох замаар малжуулах нь ашиг хүртэгчдийг өөрсдийн хэрэгцээт мал, амьтан худалдан авах боломжоор хангана. Малын үзэсгэлэн худалдаа нь худалдагч, худалдан авагч нарыг нэг доор цуглуулснаар энэхүү үйл явцыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой (Малын үзэсгэлэн худалдааны тухай *Хавсралт 9.5 ба Үйл явцын жишээ судалгаа 9.1 сүрэг сэлбэн шинэчлэхэд бэлэн мөнгө ашиглах тухай, Үйл явцын жишээ судалгаа 9.3 малын үзэсгэлэн худалдаа*, дээр харна уу).

Хуаран

Хавсралт 9.3 дээр хуаранд амьдарч буй хүмүүст зориулан малжуулах үйл ажиллагаа явуулахад тулгардаг асуудлууд болон тухайн нөхцөл байдал болон оршин сууж буй хүн амын эмзэг байдлын талаарх асуудлуудыг харуулсан.

Стандартууд

Малжуулах үйл ажиллагааг эхлэхээс өмнө тухайн үйл ажиллагаа тохиромжтой, хэрэгжих боломжтой эсэх (*Бүдүүвч 9.1* дээрх шийдвэрийн модны загвар дээр тодруулсан хэсэг) үзүүлсэн бөгөөд тухайн үйл ажиллагаа нь ямар нөлөөлөл үзүүлж болохийг сайтар судлах шаардлагатай.

Малжуулах үйл ажиллагааны стандарт 1: Үнэлгээ ба бэлэн байдал

Малчдын амьжиргаанд мал аж ахуйн гүйцэтгэх одоогийн болон ирээдүйн боломжит үүрэг, малжуулах үйл ажиллагааны нийгэм, эдийн засаг, орчны нөлөөллийг үнэлнэ.

Үндсэн үйл ажиллагаа

- Ердийн нөхцөлд мал аж ахуйн амьжиргаанд гүйцэтгэж байгаа үүргийг судлах (*Зааварчилгаа 1* харна уу).
- Нутгийн уугуул иргэдийн бие биеэ малжуулдаг арга барилыг үнэлэх (*Зааварчилгаа 2* харна уу).
- Малжуулах үйл ажиллагаанд хамрагдах ашиг хүртэгчид малаа маллах боломжтой эсэхийг тогтоохын тулд тэдний нийгэм, биет, байгалийн гаралтай амьжиргаанд туслах эд хөрөнгийг тооцон үзэх (*Зааварчилгаа 3* харна уу).
- Малжуулах үйл ажиллагааг бусад боломжит өөр үйл ажиллагаа, гадаад, дотоод бодлогын хүндрэлүүдтэй харьцуулан зардлын үр ашигтай эсэхэд үнэлгээ хийх (*Зааварчилгаа 4* харна уу).
- Орон нутгийн малын зах зээлээс олон тооны мал худалдан авахад гарч болзошгүй үр нөлөөг үнэлэх (*Зааварчилгаа 5* харна уу).
- Амьжиргааг хангахад малчин өрхөд шаардагдах хамгийн бага байж болох малын тоог гаргах (*Зааварчилгаа 6* харна уу).
- Малжуулах үйл ажиллагааны байгаль орчны нөлөөллийг үнэлэх (*Зааварчилгаа 7* харна уу).
- Малжуулах үйл ажиллагаанд хамрагдсан малын тавлаг байдал, учирч болох эрсдлийг тооцох (*Зааварчилгаа 8* харна уу).
- Өвчин тархах эрсдлийг үнэлэх (*Зааварчилгаа 9* харна уу).
- Малжуулах хөтөлбөрийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөөлөлд үнэлгээ хийж, малжуулах үйл ажиллагааг мал сүрэг болон ашиг хүртэгч иргэдийн аюулгүй байдал хангагдсан тохиолдолд л хэрэгжүүлнэ (*Зааварчилгаа 10* харна уу).

Зааварчилгаа

1. ***Амьжиргааны дүн шинжилгээ.*** Малжуулах үйл ажиллагаа нь тухайн хөтөлбөрт хамрагдах иргэдийн амьжиргаанд мал, амьтны гүйцэтгэх үүргийн талаарх хангалттай мэдээлэлд суурилсан байх ёстой. Хэрэв мал маллагаа нь тэдгээр хүмүүсийн амьдралд чухал байр суурь эзэлдэггүй, амьжиргааны стратегийн нэг хэсэг биш бол малжуулахаас өмнө тухайн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөллийг сайтар судлан үзэх шаардлагатай (*Зааварчилгаа 3-9*-ийг харна уу). Мал сүргийн менежмент болон мал, амьтны амьжиргаан дахь үүргийг тодорхойлох үнэлгээний шалгах хуудсыг *Бүлэг 3: Анхдагч үнэлгээ ба хариу арга хэмжээг тодорхойлох , Хавсралт 9.1: Малжуулах үйл ажиллагааны үнэлгээний шалгах хуудас* гэсэн хэсгээс харж болно. Хэрэв хуарангийн нөхцөлд амьдарч буй хүмүүсийг малжуулж буй бол ирээдүйд мал маллагааг тогтвортой үргэлжлүүлэх боломжийг нь харгалзах шаардлагатай (*Хавсралт 9.3: Хуарангийн нөхцөлд малжуулах нь* хэсгийг харна уу).
2. ***Уламжлалт малжуулах арга.*** Мал бүхий олон газарт бие биенээ малжуулах уламжлалт тогтолцоо хэдийн бүрдсэн байдаг. Жишээ нь: тодорхой ядуу, эмзэг бүлгийн хүмүүст зээлээр өгөх эсвэл бусдад мал бэлэглэх зэрэг нийгмийн тусламж дэмжлэг байдаг. Боломжтой бол малжуулах үйл ажиллагааг эдгээр уламжлалт механизм дээр үндэслэн хэрэгжүүлвэл энэ нь олон нийтийн хамтын удирдлага, өөриймсөг хандлагыг бий болгох, тогтвортой байдлыг сайжруулахад чухал байдаг.
3. ***Амьжиргааны хөрөнгө.*** Ашиг хүртэгч айл өрхүүд нь авсан мал амьтнаа арчилж, маллах хангалттай амьжиргааны хөрөнгөтэй байх нь маш чухал. Энэхүү хөрөнгөнд ажиллах хүч, тоног төхөөрөмж, ур чадвар, нийгмийн харилцаа (Ялангуяа нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдэд нийгмийн харилцаа чухал үүрэгтэй байдаг) болон бэлчээр, тэжээл, ус зэрэг байгалийн нөөц багтана. (*Үйл явцын жишээ судалгаа 9.6-г* харна уу).

Бүдүүвч 9.1 Малжуулах үйл ажиллагааны шийдвэрийн модны загвар

Тайлбар:
"Үйлдэл хийхгүй" гэсэн үр дүн (онцгойлон үзэх асуудал гараагүй бол) гэдэг нь газар дээр нь ямар нэг арга хэмжээ авч болохгүй гэсэн үг яг биш гэхдээ гол асуултуудад «тийм» гэсэн хариулах боломжтой байх үүднээс цаашид шаардлагатай сургалт буюу чадавхийг сайжруулах асуудлууд шаардлагатай байж болох юм.

Нүүдлийн мал аж ахуй, мал аж ахуй-тариалан хослон эрхлэгчдийг малжуулах, тэдний мал сүргийг сэлбэх үйл ажиллага нь амжилттай хэрэгжих эсэх нь тухайн хүмүүс өөрсдийн малаа алдсанаас үл хамааран дээр дурдсан хөрөнгө хангалттай байгаа эсэхээс шалтгаална. Малжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлснээр урт хугацаанд бий болсон ядуурлыг бууруулж чадахгүй. Иймд тухайн орон нутгийн нийгмийн бүлгийн бүтцэд үнэлгээ хийж, ашиг хүртэгч бүлгийн боломжит хөрөнгө болон хэтийн төлөв байдлыг судлан үзэх шаардлагатай.

4. ***Зардал ба үр ашигтай байдал.*** Малжуулах үйл ажиллагаа нь зардал өндөртэй (санхүүгийн болон захиргааны) байдаг учраас мал амьтан үхэж хорогдохоос сэргийлсэн арга хэмжээг аваагүй тохиолдолд үр дүнд сөргөөр нөлөөлдөг. (жишээ нь нэмэлт тэжээл ба усан хангамж, малын эрүүл мэндийн үйлчилгээ- *Бүлэг 6,7* болон *5*-ыг харна уу) Малжуулах үйл ажиллагааны зардал ба үр ашигтай байдлыг бусад төрлийн сэргээн босгох үйл ажиллагаатай харьцуулан судлах, ялангуяа мал, амьтан нь амьжиргааны гол хэрэгсэл биш тохиолдолд энэ талаар онцгойлон судалж үзэх хэрэгтэй. Жишээ нь хүнс, бэлэн мөнгө эсвэл үр тараах зэрэг бусад төрлийн үйл ажиллагаа нь гамшгийн дараа айл өрхүүдийн амьжиргааг тогтвортой дэмжих зардал багатай арга зам байж болно. Үйл ажиллагаанд саад учруулж болзошгүй гадаад (мал худалдан авах болон малын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой), дотоод (үйл ажиллагаа явуулж буй байгууллагын худалдан авалтын журам) бодлогуудыг арга хэмжээг төлөвлөхөд анхааран үзэх шаардлагатай.

5. ***Орон нутгийн зах зээлд үзүүлэх нөлөө.*** Иргэдийг малжуулах зорилгоор орон нутгийн зах зээлээс олон тооны мал худалдан авах нь зах зээлийн үнэд нөлөөлж болох ба ялангуяа, гамшгийн дараа үржлийн мал ховордсоноос шалтгаалан малын үнэнд нөлөөлдөг. Энэ нь өөрсдийн эд хөрөнгийг дахин бий болгох хүсэлтэй мал аж ахуй эрхлэгч чинээлэг бус иргэдэд сөрөг нөлөө үзүүлж болно.

6. ***Ашигтай байхуйц хэмжээний сүргийн тоо толгой.*** Мал амьтан нь амьжиргааны гол эх үүсвэр болдог бүс нутагт нутгийн иргэд үр ашигтай байхын тулд нэг өрхөд байх шаардлагатай малын тоо толгойн талаарх мэдээллийг гарган өгөх боломжтой. Энэ нь зохистой малын төрөл болон үүлдэр, гэр бүлийн хэрэгцээг хангахуйц малын бүтээгдэхүүн, бэлчээр, тэжээл, ус

зэрэг байгалийн нөөцийн боломж зэрэг тэдний мэдлэг дээр үндэслэгдсэн байдаг. Мал аж ахуй эрхлэх нь нийтлэг бус газар нутагт ч гэсэн малжуулахад тохиромжтой малын төрөл, үүлдэр, тоо, тэжээлийн боломж талаарх орон нутгийн иргэдийн үнэлгээг харгалзан үзнэ. (*Хавсралт 9.4*: Амьжиргааны наад захын хэрэгцээг хангах тоо толгой хэсгийг харна уу). Мал амьтны бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх зорилгоор ашиг шим өндөртэй үүлдрийн мал тараах бол цөөн тооны мал хэрэгцээтэй байж болно. Гэхдээ энэ тохиолдолд мал хүлээн авч буй иргэд нь тухайн шинэ үүлдрийн малыг хариулан маллах чадавхитай тэжээл, мал эмнэлгийн үйлчилгээ авах боломжтой байх хэрэгтэй (*Дээрх Зааварчилгаа 3*-ыг харна уу). Сайжруулсан үүлдрийн мал амьтан тараах нь нутгийн үүлдрийн малын генийн санд нөлөөлж, үүлдэр угсаа устах болон ашиг шимийн чанарт сөргөөр нөлөөлнө. Энэхүү сөрөг нөлөөлөлийг ашиг шим өндөртэй үүлдрийн мал амьтан тараахад ард иргэдэд нөлөөлөх үр дүнтэй харьцуулан судлах хэрэгтэй.

7. ***Байгаль орчинд нөлөөлөх байдал.*** Ашигтай байх малын тоо толгойд үндэслэн (*Дээрх Зааварчилгаа 6*-г харна уу) малжуулах үйл ажиллагааний байгаль орчны нөлөөлөлийн үнэлгээ хийнэ (*Бүлэг 2 Нийтлэг стандартууд ба мал амьтанд хамааралтай нийтлэг асуудлууд: Нийтлэг стандартууд хэсэг дэх байгаль орчны нийтлэг асуудлуудын* талаар харна уу). Энэ нөхцөлд орон нутгаас мал амьтныг худалдан авах нь орон нутаг дахь малын сүргийн эргэлт дээр суурилах тул бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байхад анхаарах нь чухал. Хуаранд амьдарч буй хүмүүсийг малжуулахад, тухайн орон нутагт нь малын төвлөрөл хэт өндөр байгаа бол малжуулах үйл ажиллагаанаас гарч болох байгаль орчны нөлөөллийг судлан үзэх хэрэгтэй.

8. ***Мал амьтны тавлаг байдал.*** Мал амьтны арчилгаа, маллагаа болон тавлаг байдлыг хангах нөхцлийг хангасны дараа мал амьтныг тараана (*Танилцуулга* хэсэгт заасан "таван эрх чөлөө" нийтлэг зарчмыг харна уу). Жишээ нь: Зарим тохиолдолд хуурай, цөлөрхөг бүс нутагт хангалттай хэмжээний өвс, тэжээлийн нөөц байхгүй, эсвэл гамшгийн дараа цаг уур хүйтрэл үргэлжилсэн нөхцөлд мал амьтныг маллах хашаа, хороо байхгүйн улмаас мал үхэж хорогддог.

9. ***Өвчний эрсдэл.*** Мал амьтны зарим төрлийн халдварт өвчин

маш хурдан тархдаг учраас энэ нь нийгэм, эдийн засгийн хувьд ихээхэн ихээхэн хор хохирол учруулдаг. Иймд орон нутгийн болон хил дамжин халдварладаг өвчний эрсдлийг тооцох хэрэгтэй. Онцгой байдлын дараах сэргээн босголтын үе шатанд мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх боломж хомс байдаг тул малжуулах төслийг төлөвлөхдөө мал амьтны өвчнөөс сэргийлэх арга хэмжээг заавал багтаасан байна. Мал амьтныг хил дамнан худалдан авах шаардлага үүссэн, мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд малжуулах үйл ажиллагаа хэрэгжүүлэхгүй байхыг зөвлөж байна.

10. ***Аюулгүй байдлын үнэлгээ.*** Малжуулах үйл ажиллагааны аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийг тухайн арга хэмжээг хэрэгжүүлж эхлэхээс өмнө нарийвчлан судлах шаардлагатай. Энэхүү үнэлгээнд мал хүлээн авсан иргэд нь хулгай, хүчирхийллийн золиос болох эсвэл байгалийн нөөцийг ашиглахад зөрчил үүсэж (жишээ нь тариаланчид, малчдын хооронд эсвэл малчид хоорондоо) болзошгүйг анхаарах хэрэгтэй. Малын хашаа хороо барьж өгөх зэрэг нэмэлт туслалцаа үзүүлэх нь илүү аюулгүй байдаг. Малжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлснээр ашиг хүртэгчдийн эмзэг ба аюулгүй байдлыг нэмэгдүүлэхээр бол хэрэгжүүлэхгүй байх хэрэгтэй.

Малжуулах үйл ажиллагааны стандарт 2:
Багцын тодорхойлолт

Зорилтот бүлэгт ашигтай, тогтвортой үр шимийг хүртээхийн тулд зохистой төрлийн мал, амьтныг зохистой тоогоор, зохистой арга механизмаар дамжуулан түгээх.

Үндсэн үйл ажиллагаа

- Малжуулах үйл ажиллагааны төлөвлөгөөнд орон нутгийн уламжлалт малжуулах аргыг авч үзнэ (*Зааварчилгаа 1*-ийг харна уу).
- Орон нутгийн иргэдийн оролцоо, туршлага дээр тулгуурлан ашиг хүртэгчдийг сонгоно. (*Зааварчилгаа 2*-ыг харна уу).
- Хэрвээ бэлэн мөнгө, эрхийн бичиг ашиглан малжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх бол мал амьтны зах зээлийн үнэлгээг

харгалзан малын үнийг зохицуулна. (*Зааварчилгаа 3*-ыг харна уу).

- Нийлүүлж буй малын төрөл болон тоо нь амьжиргааг дэмжихэд тохиромжтой байхаас гадна өндөр ашиг шимтэй, эрүүл, орон нутгийн уур амьсгалд дасан зохицох чадвартай мал амьтан байна (*Зааварчилгаа 4*-ийг харна уу).
- Мал амьтныг тохиромжтой цаг хугацаанд нийлүүлэх (*Зааварчилгаа 5*-ыг харна уу).

Зааварчилгаа

1. ***Уламжлалт малжуулах тогтолцоо.*** Энэхүү тогтолцоо нь тухайн орон нутагт сайтар хөгжсөн, логик бүхий байдаг. Тухайн ашиг хүртэгчдэд тохиромжтой мал амьтны төрлийг сонгож нийлүүлнэ. Энэхүү тогтолцоо нь олон жилийн туршид бүрэлдэн бий болсон, мал маллах байгаль орчны нөхцөл байдалд зохицож, малжуулах туршлагад үндэслэгдсэн байдаг. Иймд малжуулах үйл ажиллагааг төлөвлөхдөө уламжлалт тогтолцоонд тулгуурлах хэрэгтэй.
2. ***Ашиг хүртэгчдийг сонгох.*** Хөтөлбөрийн ашиг хүртэгч бүлгийг тодорхойлохдоо орон нутгийн туршлага, мал амьтыг маллахад шаардлагатай наад захын хөрөнгөтэй (хөрөнгөөр эрэмбэлэх дасгал) эсэхийг харгалзан үзэж уламжлалт тогтолцооны арга барилд дээр суурилна (Дээрх *Стандарт 1, Зааварчилгаа 3*-ыг харна уу). Дээр дурдсанчлан хамгийн ядуу хэсэг нь тухайн хөтөлбөрийн үр ашгийг хүртэх гол бүлэг боловч хэрэв тэдэнд цаашид мал аж ахуйг эрхлэх, чавар дутмаг байгаа бол хамгийн зохистой ашиг хүртэгчид болж чадахгүй. Мал амьтан худалдан авахад зориулан бэлэн мөнгө зээлэх, үр төлөөр нь буцаан төлөх нөхцөлтэй малжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа бол эргэн төлөх чадварыг ашиг хүртэгчдийг сонгох шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Гэвч энэ нь цаашид тухайн орон нутгийн ядуу айл өрхөд сөргөөр нөлөөлнө. Ашиг хүртэгчдийн шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо орон нутгийн иргэдийг оролцоог хангаж, тэдгээрээр хүлээн зөвшөөрүүлэх нь хамгийн тохиромжтой айл өрхийг сонгох, бусдын дургүйцлийг төрүүлэхгүйгээр сонголтыг ил тод, нээлттэй болгодог.
3. ***Мөнгөний үнэ цэнийг тогтоох.*** Бэлэн мөнгө эсвэл эрхийн бичгийг малжуулах үйл ажиллагааны түгээлтийн механизм байдлаар ашиглаж буй бол орон нутгийн зах зээлийн үнэ, олдоц зэргийг

үнэлэн үзэж, үүний дагуу мөнгөний үнэ цэнийг тодорхойлох шаардлагатай. Энэхүү үнэлгээ нь ханган нийлүүлэлтийн цар хүрээ, хөтөлбөрөөс зах зээлд үзүүлэх сөрөг нөлөөллийг тогтоон, эдгээр нь орон нутгийн худалдаачид болон цаашдын зах зээлд нөлөө үзүүлэхгүй байхыг баталгаажуулах шаардлагатай.

4. ***Нийлүүлэх малын төрөл.*** Малжуулах төслийн хүрээнд өгөх малын төрлийг сонгохдоо төрөл, үүлдэр, нас, хэрэглээ болон хүйс зэргийг харгалзан үзнэ. Малжуулах үйл ажиллагаанд орон нутаг болон байгаль цаг агаарын нөхцөл, гэнэтийн өөрлөлтөнд дасан зохицох чадвартай, өвчинд тэсвэртэй залуу, үржлийн, ашиг шим өндөртэй, нутгийн үүлдрийн мал амьтныг сонгоно. Түүнчлэн орон нутгийн иргэд нь нь нутгийн үүлдрийн мал, амьтныг арчлах, маллах туршлага, мэдлэгтэй байдгийн зэрэгцээ нутгийн үүлдэр нь сайжруулсан болон ашиг шим өндөртэй үүлдэртэй харьцуулбал үнэ хямд, олж нийлүүлэхэд хялбар байдаг. Малын төрөл болон үүлдэр нь айл өрх бүрээр ялгаатай байх ба жишээ нь эмэгтэйчүүдийн хувьд үндсэндээ хамгийн их орлого олж болохоос илүүтэйгээр хүнсний хангамжид нэмэр болохуйц мал амьтныг илүүд үздэг.

Сүрэг сэлбэн шинэчлэхэд шаардлагатай хамгийн бага тооны малын тоо болон сүргийн бүтцийг харгалзан (*Стандарт 1 Малжуулах үйл ажиллагаа, Зааварчилгаа 6, Хавсралт 9.4*-ийг харна уу) малжуулах багцыг тодорхойлох ба өрхийн ам бүлийн тоо, цаашид мал маллагаанд гарах зардал, зорилтот бүлгийн мал, амьтны хэрэгцээ (жишээ нь саалийн үнээ, ямаа зэрэг ашиг шим сайтай мал эсвэл илжиг, тэмээ зэрэг уналга, ачлаганд ашиглаж болох мал гэх мэт) зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Нэг өрхөд нийлүүлэх хамгийн доод хэмжээ нь тухайн мал, амьтны амьжиргаанд үзүүлэх үүрэг, тухайн мал, амьтны өрхийн эдийн засагт оруулах хувь нэмэр зэргээс хамаарна.

Боломжтой бүхий л тохиолдолд мал хүлээн авч буй иргэдэд нээлттэй, ил тод байдлыг хангах үүднээс өөрсдөө малаа сонгох боломжийг олгоно. Хэдийгээр ашиг олж болохуйц тооны мал амьтныг нийлүүлэх нь зардал өндөртэй байж болох ч (ялангуяа мал аж ахуйгаас хамааралтай орон нутагт), хэрэв тухайн тооноос бага тооны мал өгөх тохиолдолд тэдгээр өрхүүдэд авсан мал нь өсөж, ашигтай ажиллахуйц тоонд хүрэх хүртэл (олон жил шаардагдана) нэмэлт хүнсний тусламж, дэмжлэгийг ханган өгөх

хэрэгтэй. Нэг эсвэл цөөн тооны мал өгөхөд эдгээр мал амьтан нь өрхийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэхээр байна. Боломжтой бол иргэдэд олгож буй тусламжийн багц нь тодорхой өрхийн тэргүүлэх хэрэгцээнд нийцсэн, уян хатан байснаар энэ нь зээлийн систем ашиглаж буй төслийн хувьд эргэн төлөлтийг сайжруулан, өрхийн амьжиргаанд эерэг нөлөөллийг үзүүлнэ.

5. ***Түгээлтийн цаг хугацаа.*** Орон нутгийн туршлагад үндэслэн мал амьтныг тэжээл (бэлчээр, тэжээл, тэжээллэг), ус хангалттай байх цаг хугацаанд тараахаар төлөвлөх нь мал амьтны өсөлт, ашиг шим, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгадаг. Мөн байгаль цаг агаарын нөхцөл байдал, малын үржлийн цикл, өвчлөлийн хөдлөл зүй болон малчны ажлын хуанли зэргийг харгалзан үзнэ.

Малжуулах үйл ажиллагааны стандарт 3:
Зээл, худалдан авалт, тээвэрлэлт болон түгээлтийн механизм

Зээл, худалдан авалт, тээвэрлэлт болон түгээлтийн механизм нь үр ашигтай, зардалд хэмнэлттэй байж, малжуулах үйл ажиллагаанд чанартай дэмжлэг үзүүлж байх.

Үндсэн үйл ажиллагаа

- Боломжтой бол мал амьтны худалдан авалтыг орон нутгийн зах зээлээс авах (*Зааварчилгаа 1* харна уу).
- Худалдан авалтыг хууль журмын дагуу явуулж, шалгуур үзүүлэлт хангасан мал амьтныг худалдан авах *(Зааварчилгаа 2* харна уу).
- Мал, амьтан худалдан авах үед мал эмнэлгийн үзлэг, хяналт хийх (*Зааварчилгаа 3* харна уу).
- Тарааж байгаа мал амьтныг аль болох зээлийн системээр олгох, ашиг хүртэгчдийн сонирхолыг төрүүлэх, мал амьтны ашиг шимийг бууруулахгүй, амьжиргаагаа тогтвортой залгуулахад чухал үүрэгтэй. Мал амьтныг бэлгийн журмаар олгож болно. (*Зааварчилгаа 4* харна уу).
- Тээвэрлэлтийн явцад мал амьтан үхэж хорогдохоос сэргийлэх, мал амьтны тавлаг, аюулгүй байдлыг хангана. (*Зааварчилгаа 5* харна уу).

Зааварчилгаа

1. ***Орон нутгаас худалдан авалт хийх.*** Орон нутгаас худалдан авалт хийх нь орон нутгийн зах зээлд дэмжлэг болж, малын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой ложистик, эрүүл мэнд, байгаль орчин болон санхүүгийн хүндрэл гарахаас сэргийлдэг. Ялангуяа мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй, мал эмнэлгийн баталгаажуулалт хийгдээгүй мал амьтныг хил дамнан худалдан авч болохгүй. Орон нутгийн иргэд ямар төрлийн мал амьтан тухайн нөхцөл байдалд илүү тохиромжтой талаар хамгийн сайн мэдлэгтэй байдаг тул мал амьтныг худалдан авах үйл явцад ашиг хүртэгч иргэд өөрсдөө эсвэл тэдний төлөөллийг байлцуулна. Тухайн орон нутгийн иргэд нь туршлагатай малчин, худалдаачин, эсвэл орон нутгийн өндөр настай хүмүүсийг өөрсдийн өмнөөс мал амьтныг худалдан авалтанд байлцуулдаг. Малын үзэсгэлэн худалдаа нь ашиг хүртэгч талууд өөрсдөө малаа сонгох боломжийг олгодог нэг хувилбар юм. (*Хавсралт 9.5* харна уу). Гэхдээ онцгой байдлын дараа томоохон хэмжээний малжуулах төслийн хүрээнд олон тооны залуу эсвэл хээлтэгч мал орон нутгаас олдох боломж бага байдаг.

2. ***Худалдан авалтын үйл явц, журам.*** Мал худалдан авахтай холбоотой дүрэм журмыг (татвар, хорио цээр, хил гаргах асуудлууд гэх мэт) судлан үзэх шаардлагатай. Хорио цээрийн дэглэм нь төслийн хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлэх талтай. Үүнд мал амьтныг түгээхээс өмнө нэмэлт цаг зарцуулах, ложистик, нөөц боломж, мал сүргийг маллах зэрэгт хүндрэл гардаг. Нийлүүлэгч нартай гэрээ хийхээс өмнө малын гарал үүсэл, төрөл, үүлдэр, хүйс, нас зэрэг шалгууруудыг нарийвчлан тодорхойлж, шалгуур үзүүлэлтэд нийцэж буйг баталгаажуулах ёстой. Мал амьтныг тараахаас өмнө мэргэжлийн хүмүүс болон ард иргэдийн төлөөлөл оролцуулан сүргийн чанарт шалгалт хийлгэнэ. Мөргөлдөөн эсвэл хулгай дээрэм газар авсан бүс нутгуудад малжуулах төсөл хэрэгжүүлж буй байгууллагууд нь хулгайн мал амьтан худалдан авахаас сэргийлэх шаардлагатай.

3. ***Мал эмнэлгийн үзлэг, хяналт.*** Мал амьтны хорогдлыг багасгах, ашиг шимийг нэмэгдүүлэх үүднээс мал амьтан худалдан авах үед малын эмнэлгийн үзлэг, хяналт хийлгэнэ. Малын эмч нь төсөлтэй

гэрээ хийсэн орон нутгийн хувийн эсвэл улсын малын эмч байж болно. Энэхүү үзлэгээр мал амьтны эрүүл мэндтэй холбоотой асуудал байгаа эсэхийг нягтлана.

4. **Зээлийн систем нь ашиг шимд эрсдэл учруулахгүй байх**. Зээлээр малжуулах (хэрэв зээлээр олгох бол эргүүлэн төлөх механизм ямар байх) эсвэл мал амьтныг шууд олгох хувилбарын алийг хэрэгжүүлэх эсэхийг төслийн төлөвлөлтийн шатанд шийдвэрлэнэ. Уг шийдвэрийг ашиг хүртэгч нартай зөвлөлдөж, орон нутгийн бүх айл өрхүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр гаргана. Малыг зээлээр олгож буй бол тухайн зээлээр өгсөн малыг нэг бол төлөөр нь эсвэл бэлэн мөнгөөр эргүүлэн төлнө. Мөнгөн хэлбэрээр эргүүлэн төлөх нь орон нутгийн иргэдийг зах зээлийн эдийн засагт зохицож ажиллахыг шаарддаг учраас ихэнх тохиолдолд малаар эргүүлэн төлөх нь уламжлалт тогтолцоон дээр суурилсан хамгийн зохимжтой хэлбэр байдаг. Гэхдээ эргүүлэн төлөх нөхцлийг (нөхөн төлбөр хийх малын төрөл, малын төлөв байдал, төлбөрийн хугацаа) анхааралтай төлөвлөж, малжуулах төсөлд хамрагдсан иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлөхгүй хэмжээнд байлгах хэрэгтэй. Хэрэв малжуулах төслөөр өгсөн мал нь ашиг шим муутай, эргэн төлөлт нь хүлээн авсан хүнийг өрөнд оруулж, дарамт учруулна. Дараагийн ээлжинд хамрагдах айл өрхийг (Анхдагч ашиг хүртэгч нараас бэлэн мөнгө эсвэл төл авч тараах) эхний ээлжинд малжуулах төсөлд хамрагдах иргэдийг сонгох ажилтай хамтад нь хийж, эргэн төлөлтөд байнга мониторинг хийнэ.

5. ***Тээвэр төлөвлөлт.*** Тээвэрлэлтийн хуваарь, үргэлжлэх хугацаа, тухайн үеийн цаг агаарын нөхцөл байдал, зай, гаалийн ажиллах хуваарь, ачих цэгүүд болон зогсолт хийх цэгүүдийг урьдчилан төлөвлөж, тээвэрлэлтийн үеэр мал тэжээх, услах болон саах тоног төхөөрөмж, бусад холбогдох хангамжийг урьдчилан төлөвлөнө. Мал амьтныг тууварлах, тээвэрлэх үед мал амьтны тавлаг байдлыг хангана. Хэт олон тоогоор ачихгүй байх, (агаар дутагдсанаас үүдэн мал хорогдох), хэвийн байдлаар зогсох болон хэвтэх зайтайгаар тээвэрлэх, унаж бэртэхээс сэргийлэн хооронд нь холбох (төрлөөр нь) зэрэг арга хэмжээг авна. Мал амьтныг ачихаас өмнө болон дараа нь тээврийн хэрэгслийг ариутган халдваргүйтгэж зохих ёсоор агааржуулах ёстой. Хүргэх газарт нь хангалттай хэмжээний, тэжээл, хашаа болон хороо бэлтгэсэн байна.

Малжуулах үйл ажиллагааны стандарт 3: Нэмэлт туслалцаа

Малжуулах ажлын туслалцаа (мал эмнэлгийн үйлчилгээ, сургалт, хүнс) ашиг хүртэгчдийн амьжиргаанд эерэг, тогтвортой нөлөө үзүүлэх

Үндсэн үйл ажиллагаа

- Малыг тараахаас өмнө мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах үзлэг эмчилгээг хий (*Зааварчилгаа 1*-ийг харна уу).
- Нөхөрлөлийн гишүүдэд мал эмнэлгийн үйлчилгээг хүргэх тогтолцоог бүрдүүлэх (*Зааварчилгаа 2*-ыг харна уу).
- Ашиг хүртэгчдийн мал аж ахуйн мэдлэг, ур чадварын үнэлгээнд тулгуурлан чадавхийг бэхжүүлэх сургалт хийх (*Зааварчилгаа 3* харна уу).
- Ашиг хүртэгчдийн сургалтын хөтөлбөрт болзошгүй гамшгийн аюул занал, бэлэн байдлыг хангах талаар тусгах (*Зааварчилгаа 4* харна уу).
- Sphere төслийн "Хүнсний баталгаат байдлын наад захын шимт тэжээллэгийн стандартууд"-ын дагуу хоол хүнсний хангамжинд үнэлгээ хийж, стандартад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах (*Зааварчилгаа 5* харна уу).
- Sphere төслийн "Хашаа хороо, байршуулалт болон хүнсний бус зүйлийн стандартууд"-ын дагуу хашаа хороо болон хүнсний бус хэрэгцээг тодорхойлон, стандартад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах (*Зааварчилгаа 6* харна уу).
- Мал сүрэг/эсвэл эдийн засгийг дэмжих яаралтай үйл ажиллагаанууд нь дээрх төрлийн туслалцаанаас хараат бус болсон тохиолдолд хүнсний баталгаат байдлын дэмжлэгийг зогсооно. (*Зааварчилгаа 7* харна уу).

Зааварчилгаа

1. ***Урьдчилан сэргийлэх мал эмнэлгийн үйлчилгээ.*** Мал, амьтан тараахаас өмнө орон нутгийн мал амьтны өвчлөлийн нөхцөл байдлаас хамааран бүх мал, амьтанд вакцин, туулгалт

хийхээс гадна шаардлагатай бүх эмчилгээ, боловсруулалт болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна. Ихэнх тохиолдолд дээрх үйлчилгээг цогц байдлаар, үнэ төлбөргүй хийдэг. Гэхдээ Бүлэг 5 (*Мал эмнэлгийн үйлчилгээ*) дээр дурдсан зардал нөхөх асуудалд анхаарал хандуулах шаардлагатай.

2. ***Урт хугацааны мал эмнэлгийн үйлчилгээ.*** Малжуулах хөтөлбөрийн ашиг хүртэгчид нь мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх болон эмчлэх байнгын үйлчилгээг Бүлэг 5 (*Мал эмнэлгийн үйлчилгээ*) хэсэгт заасан стандарт, зааварчилгааны дагуу авах боломжтой байх хэрэгтэй. Байнгын үйлчилгээний тогтолцоог мал, амьтан тараахаас өмнө бий болгохоос гадна шаардлагатай тохиолдолд эмчилгээ, үйлчилгээ үзүүлнэ. Энэхүү урт хугацааны тогтолцоо нь мониторинг, үнэлгээний мэдээлэл цуглуулах боломжийг олгодог.

3. ***Сургалт болон чадавхи бэхжүүлэх.*** Ашиг шимийг хүртэгч бүлэг нь (ихэвчлэн бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид, мал аж ахуй-газар тариалан хослон эрхлэгчид) мал аж ахуй эрхлэх талаар ихээхэн хэмжээний мэдлэг, туршлагатай байдаг учраас мал сүрэг сэлбэх, шинэчлэх үйл ажиллагаанд мал аж ахуйн сургалтыг заавал хийх шаардлагагүй.Гэхдээ амьжиргааг нь дэмжиж буй мал сүргийг нь сэлбэхээр эсвэл шинээр малжуулахаар сонгогдсон өрхүүдийн мэдлэг, туршлага хязгаарлагдмал эсвэл онцгой байдал удаан хугацаанд үргэлжилсэн бол энэхүү мэдлэг нь мартагдсан байж болно. Ийм тохиолдолд малжуулах үйл ажиллагааг мал аж ахуй эрхлэх чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаатай хослуулан явуулснаар тухайн нийлүүлсэн мал амьтныг үхэж хорогдохоос сэргийлж, онцгой байдлын дараа айл өрхийн амьжиргаанд чухал дэмжлэг болдог. Зах зээлийн эдийн засгийн тухай сургалт хийх болон/эсвэл мэдээлэлээр хангах нь мал сүрэгт суурилсан амьжиргааг урт хугацаанд баталгаажуулахад тустай.

4. ***Ирээдүйд үүсэж болох онцгой байдлын бэлэн байдал.*** Мал маллагааны туршлага багатай олон нийтийн хувьд бэлэн байдлын ур чадварыг нь нэмэгдүүлэх замаар болзошгүй гамшгийн үед мал амьтнаа алдах явдлыг нь бууруулах боломжтой. Ур чадвар бий болгох үйл ажиллагааны тоонд тэжээл хадгалах, бэлчээр хамгаалах, мал аж ахуйн зах зээлийг оновчтой болгох, гамшгаас өмнө малын тоо толгойг бууруулах, хашаа хороо барих, мал

эмнэлгийн үйлчилгээг ашиглах, усны эх үүсвэрийг засаж сэлбэх зэрэг байж болно (Эдгээр арга хэмжээг бусад бүлгүүдэд тусгасан).

5. ***Хүнсний баталгаат байдлын туслалцаа.*** Малжуулсны дараагаар удалгүй тухайн малыг зарж борлуулах, хүнсэнд хэрэглэх зэрэг явдал түгээмэл гардаг нь ашиг хүртэгч нарт хүнсний баталгаат байдлын яаралтай хэрэгцээ үүссэнийг харуулж байгаа учраас бусад амьжиргааг дэмжих үйл ажиллагаанаас ажиллах хүч болон нөөцийг шилжүүлэн ашиглах шаардлага үүсдэг. Ашиг хүртэгч айл өрхийн хүнсний баталгаат байдлын хэрэгцээг үнэлэн, өгсөн мал амьтан хэрэгцээг хангахуйц ашиг шимээ өгөх хүртэл нэмэлт туслалцааг үзүүлсээр байх нь чухал. Sphere төслийн гарын авлагад "Хүнсний баталгаат байдал, шимт тэжээллэгийн стандартуудыг" тусгасан байдаг (Sphere, 2011). Бэлэн мөнгө эсвэл эрхийн бичиг олгох механизм нь энэхүү дэмжлэгийг үзүүлэхэд тохиромжтой арга байж болно.

6. ***Хашаа хороо болон хүнсний бус туслалцаа.*** Ашиг хүртэгч айл өрхөд хашаа хороо, өрхийн үндсэн эд хэрэгсэл, усны сав болон мал амьтанд шаардлагатай тэрэг, тоног хэрэгсэл, анжис зэрэг зүйлсээр туслалцаа үзүүлэх шаардлага үүсдэг. Энэхүү туслалцаагүйгээр тухайн өрхүүд нь авсан малаа зарахаас өөр аргагүй байдалд хүрч болно. Бэлэн мөнгө эсвэл эрхийн бичиг ашиглах механизмыг энэхүү дэмжлэгийг үзүүлэхэд судлан ашиглаж болно.

7. ***Хүнсний баталгаат байдлын дэмжлэгийг зогсоох.*** Туслалцаа авсан хүмүүс нь тэдний мал, амьтан эсвэл/болон амьжиргааг дэмжих бусад үйл ажиллагаа нь хангалттай хэмжээний дэмжлэгийг өрхөд үзүүлэхүйц болсон тохиолдолд хүнсний баталгаат байдлыг дэмжлэгийг зогсооно. Ингэснээр нийлүүлсэн малыг эрт нядлах болон тогтвортой бус аж ахуй эрхлэхээс сэргийлнэ. Сайтар төлөвлөсөн оролцооны мониторингын систем нь сүргийн өсөлтийг тооцож, амьжиргаанд суурилсан бусад үзүүлэлт нь хүнсний тусламжийг зогсоох зохистой цаг хугацааг тодорхойлно.

Малжуулах үйл ажиллагааны ***жишээ судалгаа***

9.1 Үр нөлөөний жишээ судалгаа: Кени улсад мөнгөн тусламж олгох замаар мал сүрэгт шинэчлэл, сэлбэлт хийсэн нь

Кени улсын Исиола муж нь 2005 онд томоохон ганд нэрвэгдсэний улмаас олон тооны мал хорогдож, нялх хүүхдийн дундах тэжээлийн дутагдалд гүнзгий нэрвэгджээ. 2006 оны 4-5 дугаар саруудад удаан хугацаагаар үргэлжлэн орсон борооны дараагаар Канадын хүүхдийг ивээх сан нийт 22 нутгийн 750 өрхөд 30,000 Кени шиллингийн (ойролцоогоор 490 ам доллар) тусламжаар олгожээ. Энэхүү бэлэн мөнгө нь өөрсдийн хорогдсон мал сүргийг эргүүлэн нөхөн сэргээх эсвэл өөр бусад үйлдвэрлэл бүхий хэрэглээнд хөрөнгө оруулалт хийх зорилготой байсны зэрэгцээ өрхийн нэн тэргүүний хэрэгцээг хангахуйц хэмжээний бэлэн мөнгийг тараажээ.

Бэлэн мөнгө тараасны улмаас орон нутгийн зах зээл дээрх үнэ ханшид томоохон өөрчлөлт гараагүй ч зарим худалдаачид гэнэтийн эрэлт үүссэнийг далимдуулан өндөр үнээр зарах оролдлого гарч байжээ. Энэхүү ханшийн уналттай тэмцэхээр төслийн ашиг хүртэгчид олон янзын аргыг ашигласны тоонд илүү хол зайтай зах зээлээс худалдан авалт хийх, худалдан авалтаа хойшлуулах замаар зах зээлийг хэвийн байдалд оруулах зэрэг аргууд багтаж байв.

Мөнгө тарааснаас хойш 7 сарын дараа хийсэн үнэлгээгээр тусламж хүлээн авсан хүмүүс нь энэхүү бэлэн мөнгө тараах арга хэмжээг өндрөөр үнэлсэн ба учир нь бэлэн мөнгөтэй болсноор тэд өөрсдийн сонгосон мал, амьтныг худалдан авах, шууд мал нийлүүлснээс илүү сайн чанарын мал, амьтан худалдан авах боломжийг бий болгосон хэмээн үзжээ. Үүний зэрэгцээ авсан мөнгөний зарим хэсгийг бусад хэрэгцээндээ зарцуулахыг тухайн хүмүүст зөвшөөрсөн байна. Нийт мөнгөний 85%-ийг мал худалдан авахад зарцуулсан ба үндсэндээ ямаа, хонь, үхэр болон илжиг худалдан авсан байна. Үлдэх 15%-ийг хашаа хороо барих, бизнес/жижиг худалдаанд хөрөнгө оруулах, өрөө төлөх, мал эмнэлгийн үйлчилгээ авах,эрүүл мэнд, боловсрол болон хоол хүнсэнд зарцуулсан байна. Тусламж хүлээн авсан өрхүүдийг бусад өрхтэй харьцуулбал хүүхдийн сургуульд суралцах байдал, ялангуяа охидын дунд сургуульд хамрагдалт илүү өндөр болжээ.

Энэхүү хөтөлбөр нь нийт өрхийн зөвхөн 11% дээр л төвлөрөн ажилласан бөгөөд хэрэгцээтэй бүх хүмүүст хүрэх боломжгүй юм. Гэхдээ

их хэмжээний мөнгийг хэрэгцээтэй бүх хүнд хуваарилан бага хэмжээгээр тарааснаас их хэмжээний мөнгийг цөөн тооны хүмүүсд тараах нь илүү үр дүнтэй нь харагджээ.

Бэлэн мөнгө тарааснаас 7 сарын дараа хүнсний баталгаат байдлын нөлөөлөл нь боломжит түвшинд хүрсэн байна. Хүлээн авсан хүмүүс нь өөрсдийн хүнсний хэрэглээний олон янз байдлыг сайжруулсан ба гол нь сүүний хангалт нэмэгдсэн байв. Гэхдээ хүнсний тусламжаас хамаарах байдал нь их хэмжээгээр буураагүй байна. Эхний 5-7 сарын хугацааны сүргийн өсөлтөд (үхэр +3%, ямаа +16%, хонь +25%) үндэслэн тухайн өссөн тооны мал сүрэг нь хоёр жилийн дотор хүнсний баталгаат байдлыг хангахад хүрэлцээтэй хэмээн тооцсон ба энэ нь ямар ч үйл ажиллагаа явуулаагүйтэй харьцуулбал хамаагүй хурдан байсан юм. Гэхдээ хөтөлбөрийн эцсийн нөлөөлөл нь олон жилийн дараа нь тодорхой болох ба тодруулан хэлбэл дараагийн удаа ган болоход л тухайн үр шимийг хүртэгч иргэдийн даван туулах, дасан зохицох чадвар нь хэр буйг шалгах юм. (*Эх сурвалж:* O"Donnell, 2007; Croucher et al., 2006).

9.2 Үйл явцын жишээ судалгаа: Нигер улсад гангийн бэлэн байдлыг хангахын тулд уламжлалт малжуулах арга хэмжээнд туслалцаа үзүүлсэн нь

Нигер улсын Дакаро муж дахь Лютерийн дэлхийн тусламж (Lutherian World Relief) байгууллагаас өөрийн түншлэгч байгууллага болох Үндсэн боловсрол олгодог байгууллага (Contribution a l"Education de Base) байгууллагатай хамтран Мал аж ахуйн салбарыг дэмжих, сэргээн босгох төслийг хэрэгжүүлж байжээ. Тус төсөл нь 2005 онд Нигер улсад болсон хүнсний хямралын дараагаар Лютерийн дэлхийн тусламж байгууллагаас хэрэгжүүлсэн гамшгийн үеийн хүнсний туслалцаа үзүүлэх төслийн дараагаар үргэлжлэн хэрэгжиж, ирээдүйд тохиож болох ган болон өлсгөлөнгийн үед нутгийн иргэдийн даван туулах, дасан зохицох чадвар, бэлэн байдлыг сайжруулах зорилготойгоор үйл ажиллагаа явуулжээ. Дакоро мужийн иргэдтэй хэлэлцүүлэг хийсний дүнд үндсэн дөрвөн үйл ажиллагааг тодорхойлон гаргажээ. Үүнд:

- малжуулах
- тэжээлийн нөөц бий болгох

- уст цэгийг хөгжүүлэх
- төслийн бүхий л үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоог хангах олон нийтийн форум (фермер болон нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн хоорондын зөрчилдөөн зэрэг асуудлыг шийдэх болон эрхийн талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх).

Дээрх арга хэмжээний үр дүнд суурилан оролцооны төлөвлөлтийн форумыг зохион байгуулан төслийн үйл ажиллагааны дөрвөн бүрэлдэхүүн хэсгийн загварыг гарган, төлөвлөлт хийжээ. Малжуулах үйл ажиллагааг 2005 онд болсон өлсгөлөнгийн дараа үүсэж болох гангийн эсрэг хариу арга хэмжээ болгон хэрэгжүүлэх үүднээс бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийг нэн тэргүүнд хамруулахаар болжээ. Тус бүс нутагт ган болоход эрэгтэйчүүд ихэнх малаа аваад өмнө зүг рүү бэлчээр хөөн нүүдэллэдэг бол нүүдэллэх боломжгүй эмэгтэйчүүд, хөгшид цөөн тооны малтайгаа үлддэг байна. Шаардлагатай нөөц хомсдох үед хамгийн түрүүнд эмэгтэйчүүдийн малладаг цөөн тооны мал хорогдож, хөрөнгөө алдах эсвэл зарж борлуулахад хүргэдэг. Иймээс орон нутгийн иргэд өөрсдөө мал сүргийг сэлбэн шинэчлэх хэрэгцээ, эмэгтэйчүүдийн хүнсний баталгаат байдлыг хамгаалах, үндсэн мал хөрөнгөө худалдан борлуулахаас сэргийлэх арга хэмжээг тодорхойлжээ.

Энэхүү үйл ажиллагаа нь мал сүргийг дахин сэргээх гэхээс илүү гангийн бэлэн байдлыг хангахад чиглэгдсэн тул харьцангуй цөөн тооны мал амьтныг хамруулжээ. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс зах зээлийн үнэ илүү учраас хонь, ямаа хольж өгөх санал гаргасан хэдий ч нутгийн иргэд хонийг дангаар өгөхийг илүүд үзжээ.

Төслийн малжуулах бүрэлдэхүүн хэсэг нь тухайн орон нутгийн уламжлалт (Хаббанай хэмээн нэрлэдэг) малжуулах аргыг ашигласан бөгөөд энэ нь эхний жил мал авсан хүн нь төл авсаныхаа дараа, тухайн эхний малыг дараагийн хүндээ шилжүүлэх байдлаар явагддаг байна. Олон нийтээс гарсан саналын дагуу анхдагч ашиг хүртэгч хүн тус бүрт нэг эр, дөрвөн эм хонь олгожээ. Анхлан мал авах 200 хүнийг орон нутгийн иргэд өөрсдийн шалгуурыг ашиглан тодорхойлсон бөгөөд үндсэндээ энэ нь шалгуур нь ядуурлын түвшинд суурилжээ. Өнөөгийн байдлаар малжуулсан эхний хүмүүс бүгд төл хүлээн авч, анх авсан малаа дараагийн хүмүүстээ шилжүүлсэн байна.

Энэхүү төслийн үр дүн нь өмнө нь 7-30 буюу цөөн тооны малтай байсан, эдгээр малаа гангийн улмаас алдсан хүмүүс буюу ихэнхдээ эмэгтэйчүүд хамрагдаж, хамгийн багадаа дөрвөн малтай болсон нь

хүндрэл тохиолдоход зарж борлуулах эсвэл дараагийн жилүүдэд малаа өсгөн хөрөнгөтэй болох боломж нээгдсэн байна. Өөрөөр хэлбэл тараан өгсөн мал нь эмэгтэйчүүдийн хувьд гангийн үеийн гэнэтийн нөөцийн санг бий болгожээ.

Малжуулах үйл ажиллагааг уст цэгийг сайжруулах, тэжээлийн нөөц бий болгох үйл ажиллагаатай хамт хийснээр (*Бүлэг 6-ийн төгсгөлд буй Үйл явцын жишээ, Судалгаа 6.3: Тэжээлийн хангамжийн баталгаажуулах* гэсэн хэсгийг харна уу) айл өрхүүдэд олгосон малыг онд оруулах, эд хөрөнгийг нь хамгаалахад дэмжлэг болжээ (*Эх сурвалж:* ARVIP, 2005; Burns, 2006; Evariste Karangwa, Meghan Armisted, and Mahamadou Ouhoumoudou, 2008).

9.3 Үр нөлөөний жишээ судалгаа: Нигер улс дахь мал, амьтны үзэсгэлэн худалдаа

2005 оны 6 дугаар сараас 2006 оны 6 дугаар сар хүртэл нүүдлийн мал аж ахуй, бага хэмжээний тариалан голлон эрхэлдэг бүс нутаг болох Нигер улсын Дакоро мужийн хойд хэсэгт нийт малын 60% хорогдсоны ихэнх нь үхэр байв. Ийм хэмжээний хорогдол гарсан нь гамшгийн өмнөх хэвийн нөхцөл байдалд оруулахад 30 жилийн хугацаа шаардахаар байна. Тус нутгийн иргэдийн хувьд орлогын үндсэн эх үүсвэр нь малын гаралтай бүтээгдэхүүнээс орж ирдэг байна. Оксфам байгууллага болон орон нутгийн түншлэгч болох АРЕН (AREN-Association pour le Renouveau de l"Elevage au Niger) байгууллагууд малын үзэсгэлэн худалдааны системийг ашиглан дахин малжуулах, мал хөрөнгийг нөхөн сэргээх санаачилгыг хэрэгжүүлж эхэлжээ.

Тус үйл ажиллагааны хүрээнд нийт 1500 ашиг хүртэгч сонгогдон, тэдгээр хүмүүст өөрийн сонгосон малаа (үхэр, хонь, ямаа, илжиг гэх мэт) 2006 оны 1-2 дугаар саруудад зохион байгуулсан 8 удаагийн малын үзэсгэлэн худалдааны үеэр орон нутгийн худалдаачид, чинээлэг малчдаас худалдан авахад нь зориулан 360 ам долларын хэмжээ бүхий эрхийн бичиг олгожээ. Айл өрхүүд нэн тэргүүний хэрэгцээгээ хангахын тулд малаа зарж бэлэн мөнгө болгохоос сэргийлэх үүднээс хүн бүрт 30 ам долларыг нэмж бэлнээр олгожээ.

Үзэсгэлэн худалдааг ПРОЭКСЭЛ (Proxel – Белгийн VSF болон орон нутгийн Каркара байгууллагууд хамтран хэрэгжүүлж буй) төсөлтэй хамтран зохион байгуулсан ба тус төсөл нь худалдаанд гаргахаас өмнө

малд үзлэг хийж, худалдан авсаны дараа вакцинжуулах үйл ажиллагааг гүйцэтгэжээ. Оксфам нь ПРОЭКСЭЛ байгууллагатай гэрээ хийн тараасан малыг дунд хугацаанд нь шалган, үнэлэх, ашиг хүртэгчдэд техникийн туслалцаа үзүүлэн, урьдчилан сэргийлэх болон мал маллагааны шинэ арга техникийн талаар мэдлэг олгох хөтөлбөрүүдийг тус байгууллагаар дамжуулан хэрэгжүүлжээ.

Нэг жилийн дараагаар тус хөтөлбөрт хийсэн үнэлгээгээр дунд хугацааны үнэлгээ хийхийн ач холбогдлыг харуулсан байна. Энэ хугацаанд сүргийн өсөлт 74%-д хүрчээ. Зохион байгуулсан үзэсгэлэн худалдаанаас нийт 11 476 мал худалдан авсан бөгөөд нэг жилийн дараа нийт малын тоо 20 000 гаруй болж өссөн байна. Үүний зэрэгцээ зарж борлуулсан, өрхийн хэрэгцээнд ашигласан малын тоо маш бага гарсан нь (ямаа: 0.4%; хонь: 0.6%) мал сүргийг дахин сэргээх төслийн зорилтод нийцсэн үзүүлэлт болжээ. Үнэлгээ хийсэн байгууллага нь мал эмнэлгийн байнгын үйлчилгээ үзүүлсэн, мал хүлээн авсан иргэдэд сургалт хийж байсан нь эерэг үр дүн гарахад нөлөөлсөн гэж дүгнэжээ. Мөн олон нийтийн зүгээс тус төслийн үр дүнд төсөлд хамрагдаагүй айл өрхүүд мал эмнэлгийн үйлчилгээ авах эрэлт нь нэмэгдсэн хэмээн тэмдэглэжээ. (*Эх сурвалж:* Oxfam GB/VSF-B, 2007; Bernard, 2006)

9.4 Үйл явцын жишээ судалгаа: Этиоп улсад мал сэлбэн шинэчлэхэд олон нийтийн оролцоо

2006 онд болсон гангийн хариу арга хэмжээ болгон АНУ-ын Хүүхдийг ивээх сан өмнөд Этиопын өмнөд хэсгийн таван дүүрэгт мал сүрэг сэлбэн шинэчлэх арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Энэхүү үйл ажиллагааг тухайн орон нутгийн уламжлалт малжуулах механизм дээр суурилан төлөвлөсөн байна. Борана мужид уламжлалт дахин малжуулах үйл ажиллагааг Буссар Гонифа (Bussa Gonifa) хэмээн нэрлэдэг байна. Энэхүү системийн дагуу ган, мөргөлдөөн, хулгай зэргээс үүдэн малаа алдсан эсвэл таваас доош тооны үхэртэй үлдсэн малчид өөрсдийн омгоос хамгийн багадаа таван үнээ авч, цаашид мал маллагаагаа үргэлжлүүлэн тухайн системдээ үлддэг байна. Сомалийн Дегодад ч гэсэн үүнтэй дахин хуваарилалтын систем байдаг ажээ.

Бог мал түргэн өсөж үрждэг, гангийн нөхцөлд илүү дасан зохицох чадвартай тул АНУ-ын Хүүхдийг ивээх сан нь үнээний оронд харин хонь, ямаа тараахаар шийдсэн байна. Орон нутгийн иргэдтэй

хэлэлцүүлэг хийснээр Хүүхдийг ивээх сан нь 15-20 хонь/ямаа (1-2 эр мал оруулаад), мөн уналга, ачлагын зориулалттай нэг малыг ашиг хүртэгч тус бүрт өгөхөөр болсон бөгөөд энэ тооны мал нь тухайн орон нутагт баримталдаг малжуулах тогтолцоонд нийцэж байв. Иргэдэд олгох нийт малын тоог тогтоохдоо нэг өрхөд байвал зохих хамгийн цөөн тооны малыг тэргүүлэх зорилтот бүлэг болон ихэнх малаа гангийн улмаас алдсан өрхүүдэд өгөхөөр тооцсон байна.

Энэхүү үйл ажиллагааг АНУ-ын Хүүхдийг ивээх сан болон орон нутгийн иргэдийн байгууллагын төлөөлөл хамтран удирдан явуулжээ. Орон нутгийн иргэдийн байгууллагын төлөөлөл нь мал худалдан авах үйл ажиллагаанд хяналт тавих, зорилтот өрхүүдийг тодорхойлох болон олон нийтийн оруулах хувь нэмрийг удирдан зохицуулах үүргийг хүлээсэн байна. Хүүхдийг ивээх сан нь тухайн малыг иргэдэд түгээхээс өмнө вакцинжуулах, эрүүлжүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэжээ.

Хоёр дүүрэг дээр Хүүхдийг ивээх сангийн олгосонтой тэнцэх хэмжээний малыг нутгийн иргэдийн зүгээс нэмж гарган, төслийн үйл ажиллагаанд хувь нэмэр оруулж төслийг амжилттай хэрэгжихэд дэмжлэг болжээ. Олон нийтийн зүгээс нийт 1,364 хонь, ямаа гаргасан бөгөөд нутгийн иргэд ч худалдан авсан малаас илүү тааваарлаг мал нийлүүлсэндээ бахархаж байлаа. Бусад зорилтот бүс нутгуудад олон нийтийн зүгээс оруулах хувь нэмэр бага байсан нь үндсэн хоёр шалтгаантай байжээ. Нэгдүгээрт зарим газарт гангаас үүдсэн сөрөг нөлөөлөл маш өргөн хүрээтэй байсан тул тухайн орон нутгийн иргэд ядуурал өртсөн учраас тухайн омгийн гишүүдээс хувь нэмэр оруул гэж шаардахаас нутгийн иргэдийн байгууллагууд цааргалсан. Хоёрдугаарт омгийн гишүүдийн зүгээс мал өгч хувь нэмэр оруулах хүсэлтэй байсан хэдий ч тухайн хамтран ажиллагч байгууллагын орон нутаг дахь үйл ажиллагааны чанар, төслийг хэрэгжүүлсэн нийт хугацаа зэргээс хамааран хэрэгжүүлэх боломжгүй байсан байна. Мөн урьд өмнө нь олон нийтэд суурилсан хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаанаас эерэг үр дүн гарсан газруудад олон нийтийн зүгээс хувь нэмэр оруулах нь элбэг хялбар байсан бөгөөд харин богино хугацаанд хэрэгжсэн төсөл эсвэл олон нийтийн харилцаа муу байсан газруудад энэ нь тийм ч хангалттай түвшинд байж чадаагүй юм.

АНУ-ын Хүүхдийг ивээх сан орон нутгаас хувь нэмэр оруулан, ижил тооны мал нэмж хандивлах нь цаашид тодорхой нэг газрыг хамарсан гангийн үед илүү ашигтай, үр дүнтэй болохыг нотолжээ.

Ялангуяа үйл ажиллагаа явуулж буй байгууллага болон орон нутгийн иргэдийн хооронд сайн харилцаа тогтсон газруудад эсвэл иргэд нь гангийн эрсдэлд харилцан адилгүй өртсөн тохиолдолд ашиглахад үр дүнтэй арга байна хэмээн дүгнэжээ. (*Эх сурвалж:* Gebru, 2007)

9.5 Үйл явцын жишээ судалгаа: Пакистаны газар хөдлөлтийн дараах малжуулах үйл ажиллагаа

2005 онд Пакистан улсад газар хөдлөлт болж, хүнсний бүтээгдэхүүн, майхан, хөнжил зэрэг тусламжийн бараа бүтээгдэхүүнийг хүргэсний дараагаар Германы Улаан загалмайн зүгээс газар хөдлөлтөд өртсөн айл өрхийн хүүхдүүдийн хоол тэжээллэгийн байдлыг сайжруулахын тулд тугалтай үнээ тараах төсөл санаачилсан байна. Зорилтот бүлэг нь бүх малаа алдсан эсвэл эмзэг бүлэгт хамаарах (өрх толгойлсон эмэгтэй бүхий эсвэл 4-өөс илүү хүүхэдтэй ядуу гэр бүл), өмнө нь малгүй байсан өрхүүд байв. Тосгоны хороод буюу настайчууд, янз бүрийн нийгмийн давхаргын төлөөлөл, эмэгтэйчүүд, шашны удирдагчид болон багш нарыг багтаасан хороог байгуулан, ашиг хүртэгчдийг сонгох ажлыг хийлгэсэн байна. Сонгох үйл ажиллагааг орон нутагт ажиллаж, орон нутгийн иргэдтэй зөвлөлдөж давхар баталгаажуулжээ.

Малыг тухайн зорилтот иргэдэд тараахаас өмнө хүлээн авах хүмүүст мал маллагааны менежментийн талаар сургалт хийсэн ба үүнд мал тэжээх, өсгөн үржүүлэх, эрүүл мэндийн хангах болон бусад сэдэв багтжээ. Тараах зорилгоор мал сонгохдоо тодорхой төрөл болон үүлдрийн малыг, урьдчилан тохирсон шалгуурын дагуу (хүйтэн цаг уурт дасан зохицох боломж, сүүний гарц, биеийн хэмжээ, жин болон нас гэх мэт) сонгон авчээ. Худалдан авах үнээг орон нутгийн гэрээт ханган нийлүүлэгч нар нийлүүлсэн ба Улаан загалмайн зүгээс малын эрүүл мэндийг шалган мастит буюу хөхний идээт үрэвсэл, хачиг гуурыг эмчилж, иргэдэд түгээхээс өмнө вакцинжуулсан байна. Харин иргэдэд тараахдаа сугалааны системийг ашиглажээ.

Олон нийтэд суурилсан малын эрүүл мэндийн ажилтан (CAH-Ws) сурган, бэлтгэж давтан сургалтыг төслийн хэрэгжилтийн хугацааны туршид хийж иржээ. Малын эрүүл мэндийн ажилтнуудыг төрийн зүгээс үзүүлдэг зохиомол хээлтүүлэг, үржил селекцийн ажил гэх мал эмнэлгийн ажил үйлчилгээнд татан оролцуулжээ.. (*Эх сурвалж:* Matthew Kinyanjui, 2008)

9.6 Үйл явцын жишээ судалгаа: Пакистаны газар хөдлөлтийн дараа малжуулах үйл ажиллагаанаас татгалзсан нь

2005 оны 10 дугаар сарын 8-ны өдөр Пакистаны Азад Жамму болон Кашмир мужийн таван дүүрэг, Баруун Хойд хил (одоо Кайбер Пахтунхва гэж нэрлэх болсон)орчмын таван дүүрэгт хүчтэй газар хөдлөлт болжээ. Засгийн газраас авч хэрэгжүүлж буй богино хугацааны сэргээн босгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO) Засгийн газраас хэрэгжүүлсэн дээрх хөтөлбөрийн мал аж ахуйтай холбоотой бүрэлдэхүүн хэсэгт 2006 оны 5 болон 6 дугаар саруудад үнэлгээ хийжээ. Үүний гол зорилго богино хугацааны сэргээн босголтын үйл ажиллагааны эхний 6 сарын хугацааны стратегийг боловсруулан гаргах явдал байв. Энэхүү үнэлгээ нь газар хөдлөлтийн дараах малын тэжээлийн эрэлт, нийлүүлэлтийн нөхцөл байдлыг тодорхойлон гаргажээ. Тухайн үнэлгээгээр тодорхойлсон нөхцөл байдлыг *Хүснэгт 9.3* дээр тоймлон харууллаа.

Хүснэгт 9.3 Газар хөдлөлтийн дараах тэжээлийн эрэлт, нийлүүлэлт

Орон нутгийн тойргууд	**Нийт тэжээлийн эрэлт**	**Нийт тэжээлийн нийлүүлэлт**	**Зөрүү (дутагдаж буй)**
	MJME (m)	**MJME (m) мега жоул илчлэгтэй тэжээл**	**MJME (m) мега жоул илчлэгтэй тэжээл**
Азад Жамму болон Кашмир			
Музаффарабад	5,361	7,560	2,199
Багх	2,688	1,757	(931)
Равалакот	5,092	3,306	(1,787)
Баруун хойд хилийн бүс			
Мансехра	9,339	7,096	(1,242)
Баттаграм	4,037	1,871	(2,165)
Шангла	3,097	2,901	(197)
Абботабад	6,339	3,336	(3,003)
Кохистан	11,962	11,103	(860)

MJME– мега жоул илчлэгтэй тэжээл, (*m*)-сая

Газар хөдлөлтийн дараагаар Музафарабад дүүрэг их хэмжээний тэжээлийн илүүдэлтэй байсан ба Шангла болон Кохистан дүүргүүдэд малын хорогдол ихээр гараагүй ч тэжээлийн эрэлт, нийлүүлэлтийн хувьд тэнцвэртэй байжээ. Харин бусад дүүргүүдийн хувьд тэжээлийн хомсдол үүсжээ.

Энэхүү үр дүн дээр үндэслэн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага нь газар хөдлөлтөд өртсөн хүмүүсийг малжуулах өөрийн анхны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, харин гол үйл ажиллагааг газар хөдлөлтийн дараа үлдсэн мал сүргийг (2006/07) тэжээлээр өвлийн турш хангах, малын хашаа хороо барих, малын эрүүл мэндийг хамгаалах чиглэлд төвлөрүүлэх болжээ. Малын тэжээл ханган нийлүүлэх нь цаашид тогтвортой байх эсэх талаар асуултууд гарч байсан бөгөөд Азад Жамму болон Кашмир мужид малжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн 9 байгууллага, Баруун хойд хилийн бүсэд төсөл хэрэгжүүлсэн 13 байгууллагуудын нийлүүсэн тэжээл нь:

- нийт бод малын 27%.
- нийт бог малын 33%.
- нийт бод, бог малын 33%
- нийт малын 7% ийг хангаж чадахуйц хэмжээтэй байжээ (*Эх сурвалж:* Simon Mack, хувийн харилцаа холбоо, 2008).

9.7 Үр нөлөөны жишээ судалгаа: Иран дахь газар хөдлөлтийн дараах малжуулах арга хэмжээ

2003 оны 12 дугаар сарын сүүлээр Иран улсын өмнөд хэсэг дэх Бам болон Керман мужид хүчтэй газар хөдлөлт болжээ. Ердөө 15 секунд үргэлжилсэн энэхүү газар хөдлөлтөөр ойролцоох хот, тосгодын нийт барилгын 70% нь нурж, тус нутгийн 130 000 хүн амын 40 000 гаруй нь амь үрэгдсэн байна. Бам мужид амьдарч байсан хүмүүсийн ихэнх нь тухайн үед фермерүүд эсвэл фермийн ажилчид байсан бөгөөд тэд хүнс тэжээлээ хангах, өрхийн орлогоо нэмэгдүүлэх зорилгоор цөөн тооны үхэр, хонь, ямаатай байжээ. Багахан хэмжээний газартай эсвэл огт газаргүй ядуу фермерүүдийн хувьд малтай байх нь маш чухал ач холбогдолтой байжээ. Тухайн газар хөдлөлтөөр тус нутгийн нийт үхрийн 31%, хонь, ямааны 26% нь хорогджээ. Ихэнх мал нь эзнийхээ гэрийн хажууд энгийн хашаанд байсан тул байшингийн нурангид дарагдаж

үхжээ. Үлдсэн мал нь газар хөдлөлтөөс үүдэн үргэн алга болсон, зарим нь хулгайд алдагдсан эсвэл газар хөдлөлтийн дараа гэнэтийн мөнгөний шаардлагаас болоод заримыг нь зарж борлуулсан байна.

Энэхүү хор хохирлыг арилгах зорилгоор Испанийн Өлсгөлөнгийн эсрэг үйл ажиллагаа буюу Action Against Hunger (ACF) байгууллага нь газар хөдлөлтөд нэрвэгдсэн Бам мужийн 17 тосгоны 1200 өрх нэг бүрт хоёр ямаа, 300 кг тэжээл тараан малжуулах төслийг төлөвлөжээ. Тус төслийн зорилго нь тухайн зорилтот бүлгүүдэд гэр бүлийн хүнсний хэрэгцээндээ сүүтэй болох, цаашид нэмэлт орлого олох боломжийг хангах явдал байв. Төсөл нь газар хөдлөлтөд малаа алдсан ядуу өрхүүд, ялангуяа бэлэвсэн үлдсэн эмэгтэйчүүд, бусад эмзэг бүлэгт төвлөрч байсан ч сонгон авах шалгуур нь тухайн хүмүүс өмнө нь хонь, ямаа маллаж байсан туршлагатай байх, малын хашаа хороотой байж, төслийн тогтвортой байдлыг хангах явдал байв. Ашиг хүртэгчдийг сонгон авах болон малжуулах үйл ажиллагааг орон нутгийн захиргаатай хамтран явуулжээ. Мөн төслийн хүрээнд Ираны мал эмнэлгийн сүлжээтэй гэрээ хийж, худалдан авч буй малыг иргэдэд тараахын өмнө үзлэг хийлгэж, дотрын халдварт хордлогын эсрэг вакцинжуулж, туулгалт, эрдэс болон витаминаар хангажээ.

Улмаар 1200 өрх бүрт хоёр толгой эм ямааг (нэг нь нутгийн Махалти үүлдрийн, нөгөө нь Рачти буюу махали болон өндөр ашиг шимтэй Пакистани үүлдрийн эрлийз) 300 килограмм тэжээлийн арвайн хамтаар олгожээ. Төслийн анхны төлөвлөгөөгөөр хээлтэй мал олгохоор байсан ч энэ нь тээвэр, ложистикын хувьд хүндрэлтэй, газар хөдлөлтийн дараа голдуу үржлийн ухна үлдсэн нь хээлтэгч ямаа тараасны дараа богино хугацаанд үржих боломжтой болсон байна. Ямаа түргэн өсөх боломжтой, малжуулсны дараа хийгдсэн мониторингын дүнгээс харвал мал хүлээн авсан өрхүүдийн 84% нь тухайн сонгосон үүлдэрт сэтгэл ханамжтай, 87% нь малжуулсан үйл явцад сэтгэл хангалуун байжээ. 9 өрх нь нэг ямаа сааж, хоёр өрх хоёр ямаа сааж, харин 27 нь ямаагаа хээлтүүлэгт оруулсан байжээ.

Судалгааны үеэр төслийн үзүүлсэн нөлөөллийн талаар асуумж судалгаа хийхэд ашиг хүртэгчид нь сүү, ноос зэрэг эдийн засгийн үр өгөөжийг хамгийн түрүүн нэрлэсэн ч энэ судалгаа нь малын үржлийн бус үед таарсан тул цаашид олон үр дүнг гарах боломжтой юм. Мөн хүмүүсийн зүгээс сэтгэл зүйн нөлөөллийг ихээр нэрлэсэн бөгөөд жишээ нь хүүхдүүд малтай тоглох, бусад үйл ажиллагаа эрхлэхэд нь ихээхэн дэмжлэг болж, урам

өгсөн хэмээн хэлжээ. Ихэнх оролцогчид бүх малаа эсвэл зарим малаа газар хөдлөлтөд алдсаны дараа мал аж ахуй эрхлэх ажлаа үргэлжлүүлэх боломж өгсөн хэмээн эерэг сэтгэгдэлтэй байжээ. (*Эх сурвалж:* ACF-Испани, 2004; Leguene, 2004).

9.8 Үр нөлөөний жишээ судалгаа: Сомали улс дахь малжуулах болон мал эмнэлгийн үйлчилгээний эрхийн бичиг

Сомали улсын Хиран мужид орон нутгийн айл өрхүүд нийт орлогынхоо 50-60%-ийг мал аж ахуйгаас олдог байна. 2011/12 онд болсон гангийн улмаас олон тооны мал, хүний амь үрэгдэж, тухайн мужийн ядуу өрхүүд дунджаар 54 мал (хонь/ямаа) алдсан байна. 2012 онд Хүүхдийг ивээх сангаас Норвегийн гадаад харилцааны яам, Австралийн олон улсын хөгжлийн агентлаг, Британийн олон улсын хөгжлийн газрын санхүүжилтээр малжуулах болон мал сүргийг эрүүлжүүлэх төслийг санаачилжээ. Төслийн зорилго нь малжуулах замаар мал хөрөнгийг сэргээх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх замаар малын өвчлөлийг бууруулан, тэжээллэгийг нэмэгдүүлэх явдал байв.

Төслийн хүрээнд суурь судалгаа хийснээр тухайн өрхүүдэд анхлан байсан малын тоо, мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмж, орлого болон хүнсний эх үүсвэр, малын өвчний гаралтын нөхцөл байдлыг тодорхойлжээ. Төсөл нь ядуу өрхүүдийн хорогдсон малын тоо болон хүүхдийн хоол тэжээллэгийн дутагдал зэрэг эмзэг байдлын шалгууруудыг ашиглан зорилтот бүлгээ сонгон авчээ. Тараан өгөх малын нас, төрөл дээр тохирсоны дараа малын худалдаачидтай нээлттэй тендерийн хүрээнд мал ханган нийлүүлэх гэрээ хийж, стандарт мал эмнэлгийн тусламжийн багцын тогтоон, худалдан авчээ. Орон нутгийн малын эмч нарт мөн дахин сургалт хийж, мал эмчилгээний багцыг нийлүүлсэн байна.

Улмаар өрх нэг бүрт гарган өгсөн тодорхойлолт, бүсчлэлийн дагуу 5-10 мал худалдан авах эрхийн бичиг өгөхийн зэрэгцээ 20 бог малд мал эмнэлгийн эмчилгээ хийлгэх эрхийн бичиг мөн олгожээ. Малын наймаачид зарах малаа тосгонд авчрахад нутгийн иргэд тэднийг эрхийн бичгээр худалдан авдаг ажээ. Орон нутгийн "Мал аж ахуйн мэргэжилтнүүдийн холбоо" нь гэрээт эмийн сангуудаас шаардлагатай эм авчиран, малын эмч нараас бүрдсэн багийг томилон тосгодоор ажиллуулсан ба нутгийн иргэд эмчилгээ, сургалтын хөлсөнд эрхийн бичгээр төлбөр хийж байв. Мөн гомдол гаргах механизмыг бий болгон, талуудын зүгээс төслийн

талаарх өөрсдийн саналыг илэрхийлэх боломжийг хангасан байна.

Нийтдээ 2,583 өрх малтай болж, 3,310 өрх мал эмнэлгийн эмчилгээ, үйлчилгээ авчээ.Эрхийн бичиг болон орон нутгийн ханган нийлүүлэгчдийг ашигласан нь тухайн аюулгүй байдал бүрэн хангагдаагүй бүсэд мал тээвэрлэх зэрэг үед тулгарах асуудлуудыг даван гарахад ихээхэн түлхэц болжээ.

Төсөлд хийсэн хөндлөнгийн үнэлгээгээр төсөл нь сүүний хүртээмжийг нэмэгдүүлсэн, мал маллах байдлыг сайжруулсан, малын эрүүл мэндийн сайжруулсан болон зорилтот бүлгийн гангийн бэлэн байдлыг бий болгосон үр дүн гарсан хэмээн дүгнэжээ. Ашиг хүртэгчдийн гуравны хоёроос илүү нь тэдний өрхийн үйлдвэрлэл нэмэгдсэн, болзошгүй гамшгийг даван туулах, дасан зохицох чадвар нэмэгдсэн гэдэгт итгэлтэй буйгаа илэрхийлжээ. Төслөөс үзүүлсэн бусад эерэг нөлөөллийн тоонд орон нутгийн малын эмийн сан, малын эмч нар, тээвэрлэгчид зэрэг орон нутгийн бизнес эрхлэгчдэд дэмжлэг болсон, мөн өрх толгойлсон эмэгтэйчүүд бүхий өрхийн хүүхдэд өгөх сүүний хангамжийг сайжирсан, хүнс тэжээллэгийн тал дээр дэмжлэг болсон (35%) зэргийг дурдсан байна.

Гол сургамжууд гэвэл юуны өмнө маш богино хугацаанд сүүний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд хээлтэй болон төллөсөн эм малыг түгээх нь ач холбогдолтой болох нь батлагдсан. Түүнчлэн эрхийн бичиг ашиглах нь ашиг хүртэгчдийн хариуцлагатай байдлыг сайжруулж, аудитаар баталгаажуулахад хялбар, мөн аюултай нөхцөлд малжуулалт хийхэд ихээхэн үр дүнтэй байна. Эцэст нь малжуулах үйл ажиллагаа нь иж бүрэн цогц байдлаар хэрэгжүүлсэн, малжуулах, малын эмчилгээ хийх, сургалт зэргийг хамтад нь зохион байгуулсан нь төслийн үр нөлөөллийг нэмэгдүүлэхэд ихээхэн түлхэц болсон байна. (*Эх сурвалж:* Олон улсын Хүүхдийг ивээх сан, 2013)

Хавсралт 9.1: Малжуулах үйл ажиллагааны үнэлгээний шалгах хуудас

Хувилбарууд болон үр нөлөө

- Онцгой байдал үүсэхээс өмнө мал, амьтан нь амьжиргаанд ямар үүрэгтэй байсан бэ?
  - Амьжиргааны гол хөрөнгө?
  - Шаардлагатай нэмэлт хүнсний бүтээгдэхүүнээр хангах?
  - Орлого төвлөрүүлэх?
  - Тээвэр, уналга ачилга?
- Ямар төрөл, үүлдрийн мал, амьтныг, ямар зориулалтаар хариулан маллаж байсан бэ?
- Ямар төрөл, үүлдрийн малаа алдаж, дахин сэргээн малжуулах шаардлагатай вэ?
- Хэрэв мал, амьтан нь амьжиргааны арга, стратегийн нэг хэсгийг бүрдүүлэхээ больсон бол:
  - Нэмэлт хоол хүнс болон орлого олох хэрэгцээг хангахын тулд мал, амьтантай болгох боломж бий юу?
  - Ямар төрөл, үүлдрийн мал, амьтныг түгээхэд хамгийн тохиромжтой байх вэ?
- Малжуулахаас өөр, зардлын хувьд үр ашигтай хувилбаруудын талаар бодож үзсэн үү?
- Малжуулах орон нутгийн уламжлалт ямар механизм байна вэ?
- Тухайн орон нутагт хэдэн тооны мал байх тохиолдолд айл өрх амьжиргаагаа залгуулж чадах вэ?
- Тухайн орон нутагт тэрхүү зохистой тооны мал, амьтныг тараах нь ямар нөлөөлөл үзүүлэх вэ?
  - Хангалттай бэлчээр эсвэл тэжээлийн нөөц байна уу?
  - Ус хангалттай хэмжээнд байна уу?
  - Хангалттай тооны хашаа хороо байгаа эсвэл барих боломжтой юу?
  - Мал аюулгүй орчинд байж чадах уу эсвэл малжуулах үйл ажиллагаа нь малчид болон малд учрах эрсдлийг нэмэгдүүлэх үү?

Ашиг хүртэгчид

- Ирээдүйд мал маллагааг амжилттай үргэлжүүлэн явуулахад дэм болох нийгмийн, биет болон байгалийн гаралтай амьжиргааны ямар хөрөнгийг боломжит ашиг хүртэгч тал эзэмшиж байна вэ?
- Шаардлагатай бол мал аж ахуй эрхлэх сургалт хийж болох уу?
- Мал хариулах, арчлахад эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд ямар үүрэгтэй оролцож байгаа, малжуулсанаас үүдэн хөдөлмөрийн хуваарилалтад ямар нөлөө үзүүлэх вэ?
- Мал аж ахуй эрхлэх болон малын гаралтай бүтээгдэхүүний хүртээмжийн чиглэлээр эмзэг бүлэгт тодорхой яг ямар хэрэгцээ байна вэ?
- Ашиг хүртэгчдэд мал аж ахуйтай холбоотой, шаардлагатай тохиолдолд дэмжлэг үзүүлэх хангалттай нөөц эх үүсвэр байна уу (жишээ нь мал эмнэлгийн үйлчилгээ, тэжээл болон хашаа хороо гэх мэт)?
- Шаардлагатай тохиолдолд ашиг хүртэгчдэд мал аж ахуйн бус дэмжлэг үзүүлэх хангалттай нөөц эх үүсвэр байна уу (жишээ нь мал сүрэг өсөж байх хугацаанд олгох хүнс болон бусад төрлийн дэмжлэг)?

Худалдан авалт

- Орон нутгийн зах зээл дээрээс олон тооны мал худалдан авахад ямар нөлөөлөл үзүүлж болох вэ?
- Ашиг хүртэгч талд ойрхон, хялбар тээвэрлэн хүргэхүйц ойр газарт хангалттай тоогоор худалдан авах мал байна уу?
- Хэрэв тээвэрлэх боломжтой бол тухайн малын арилгаа, нөхцөл байдалд ямар нэгэн эрсдэлгүйгээр тэднийг тээвэрлэн авчрах боломжтой юу?
- Өөр бүс нутгаас мал, амьтан авчрахад өвчинтэй холбоотой ямар эрсдлүүд байж болох вэ?

Хавсралт 9.2: Малжуулах үйл ажиллагааны мониторинг, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн жишээ

	Үйл явцын шалгуур үзүүлэлт (болж байгаа үйл ажиллагааг хэмжих)	Үр нөлөөний шалгуур үзүүлэлт (болж байгаа үйл ажиллагааны үр дүнг хэмжих)
Тогтолцоог төлөвлөх	• Олон нийтийн төлөөлөл болон шаардлагатай тохиолдолд хувийн хэвшлийг төлөөлсөн ханган нийлүүлэгч нар зэрэг бусад оролцогч талуудтай хийсэн уулзалтуудын тоо	• Малжуулах хувилбаруудад хийсэн дүн шинжилгээ бүхий уулзалтын тайлангууд • Үйл ажиллагааны төлөвлөгөө, үүнд доорх зүйлс багтана: – олон тал нэг бүрийн үүрэг хариуцлага – ашиг хүртгэгчдийг сонгох олон нийтийн үйл явц болон шалгуур үзүүлэлтүүд – түгээх малын төрөл болон үүлдрийн талаарх олон нийтийн санал, давуу тал өгч буй төрөл, үүлдэр – худалдан авалт, тээвэр, түгээлтийн төлөвлөгөө, ашиг хүртэгчдийн оролцоотой хийх – мал эмнэлгийн үзлэг болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ
Бэлчээрийн болон газар тариалан-бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийн сүрэгт өөрчлөлт хийх, сэлбэх	• Өрх нэг бүрт өгсөн малын тоо, малын төрлөөр • Өрх нэг бүрт үзүүлсэн нэмэлт туслалцааны (хүнсний тусламж, багаж хэрэгсэл гэх мэт) төрөл болон үнийн дүн	• Нийлүүлсэн малын хорогдол болон өмнө байсан малын хорогдолтой харьцуулсан дүн • Нийлүүлсэн малаас авсан төлийн тоо, төлийг юунд хэрэглэсэн (жишээ нь борлуулсан, орлого олоход хэрэглэсэн гэх мэт) • Хүний хоол тэжээллэг – мал хүлээн авсан өрх дэхь хүүхдүүдийн сүүний хэрэглээ • Сүргийн өсөлт болон цаашид гадны тусламжаас хамаарах түвшин • Бодлогод үзүүлсэн нөлөөлөл

	Үйл явцын шалгуур үзүүлэлт (болж байгаа үйл ажиллагааг хэмжих)	**Үр нөлөөний шалгуур үзүүлэлт (болж байгаа үйл ажиллагааны үр дүнг хэмжих)**
Мал, амьтныг сэлбэх: Бага хэмжээний тариалан эрхлэгчид болон бусад орлогын эх үүсвэр олох зорилгоор	• Өрх нэг бүрт өгсөн малын тоо, малын төрлөөр • Өрх нэг бүрд үзүүлсэн нэмэлт туслалцааны (хүнсний тусламж, багаж хэрэгсэл гэх мэт) төрөл болон үнийн дүн • Шаардлагатай тохиолдолд хийсэн мал аж ахуй эрхлэх, үйлдвэрлэлийн сургалт	• Нийлүүлсэн малын хорогдол болон өмнө байсан малын хорогдол, харьцуулсан • Нийлүүлсэн малаас авсан төлийн тоо, төлийг юунд хэрэглэсэн (жишээ нь борлуулсан, орлого олоход хэрэглэсэн гэх мэт) • Хүний хоол тэжээллэг – мал хүлээн авсан өрх дэх хүүхдүүдийн сүүний хэрэглээ
Малжуулах: Амьжиргааг дэмжих үйл ажиллагаанд зориулан шинээр малжуулах	• Өрх нэг бүрт өгсөн малын тоо, малын төрлөөр • Мал аж ахуйн үйлдвэрлэл, удирдлага болон маркетингийн сургалт	• Нийлүүлсэн малын хорогдол болон өмнө байсан малын хорогдол, харьцуулсан • Нийлүүлсэн малаас авсан төлийн тоо, төлийг юунд хэрэглэсэн (жишээ нь борлуулсан, орлого олоход хэрэглэсэн гэх мэт) • Хүний хоол тэжээллэг – мал хүлээн авсан өрх дэхь хүүхдүүдийн сүүний хэрэглээ

Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар болон стандартуудын Үнэлгээний аргачлалыг <http://www.livestock-emergency.net/resources/general-resources-legs-specific/>. вебсайтнаас харна уу:

Хавсралт 9.3: Хуаранд амьдарч буй хүмүүсийг малжуулах

Хуаран болон түүнтэй ижил төстэй суурьшилд амьдарч буй хүмүүсийг малжуулахдаа юуны өмнө тухайн хуаранг хариуцаж буй байгууллагатай хэлэлцэх шаардлагатай. Хуаранд оршин сууж буй хүмүүстэй хамтран, тухайн хуаранг ажиллуулж буй байгууллага нь үндсэн оршин суугчтай хэлэлцэн үйл ажиллагааг зохион байгуулна. Боломжтой тохиолдолд хуарангийн хороод нь энэхүү үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тодорхой үүргийг гүйцэтгэж болно. Жишээ нь ажиглалт хийх бүлэг байгуулан, малын аюулгүй байдалд хяналт тавих, харин хашаа хороо хариуцсан бүлэг нь малын хашаа хороо барих ажилд дэмжлэг үзүүлэх зэргээр ажиллаж болно.

Хуаранд буй иргэдийг малжуулах үйл ажиллагаанд эрүүл ахуй, аюулгүй байдлын хувьд тодорхой асуудлууд үүсэж болно. Тухайлбал хүн, мал ойрхон байснаас эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл байдалд хүндрэл гардаг. Хэт олон тооны хүн бөөгнөрсөн хуаран дээр тэдгээрийг зохицуулах, эрүүл мэндийн нөхцөл байдалд хүндрэл учрахаас гадна малжуулах үйл ажиллагааг хуаран дээр явуулсанаар үндсэн оршин суугчидтай зөрчилдөх, усны нөөц эх үүсвэрийн хомсдол үүсэх, хуарангийн оршин суугчдад эрсдэл бий болгох зэрэг асуудлууд гарч нөхцөл байдлыг улам хүндрүүлдэг.

Дээрх нөхцлүүд үүсээгүй хуаран дээр малжуулах үйл ажиллагаа явуулах бүрэн боломжтой бөгөөд эрүүл мэнд, ариун цэврийн асуудлыг сайтар анхааран, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсанаар малаас хүнд болон хүнээс малд дамжих өвчнөөс сэргийлнэ. Ийм чиглэлийн үйл ажиллагааны тоонд мал сүрэг хуаран дотуур бэлчихээс сэргийлэх, мал маллах газрыг хүн амьдарч буй орчноос аль болох хол байгуулах, ханган нийлүүлэх малын төрлийг сайтар судлан тогтоож (хаягдал бага гаргах гэх мэт), гарсан төлийг түргэн хугацаанд зарж борлуулан тоо толгойг зохистой хэмжээнд байлгаж, хэт олон тоогоор өсөхөөс сэргийлэн зохистой тооны үржлийн малыг байлгах зэрэг багтаж болно. Түүнчлэн вакцинжуулалт, хорио цээр, био аюулгүй байдлын арга хэмжээ, өвчинд тандалт хийх систем зэрэг шаардлагуудыг чанд баримтлах шаардлагатай.

Мал сүрэгт зайлшгүй шаардлагатай байгалийн болон бусад нөөцийн хүртээмжийг тухайн хуарангийн удирдлагын төлөөлөл болон оршин сууж буй ард иргэдтэй тохиролцсоны үндсэн дээр зохицуулан,

зөрчил болон хомсдол үүсэх эрсдлээс сэргийлнэ. Усны олдоц, хүртээмж нь хамгийн гол хүндрэл болох ба ялангуяа хүний ундны усны хангамж хомс байх үед мал усалснаар тухайн хуарангийн хүн амын усан хангамжид хүндрэл учруулдаг усан хангамж багатай хуаранд тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх хэрэгтэй.

Малын хашаа хороо болон аюулгүй байдалд анхаарал хандуулан (*Бүлэг 8: Малын хашаа хороо ба байршуулалт* гэсэн хэсгийг харна уу) мал сүргийг цаг агаарын гэнэтийн өөрчлөлт болон хулгайн эрсдлээс хамгаална.

Малжуулах малын төрөл болон үүлдэр зэргийг сонгохдоо малжуулах төслийн үр ашгийг хүртэх хүн амын нөхцөл байдалтай уялдуулан хийнэ. Жишээ нь бага зай, бага тэжээл шаардах бог мал, амьтан (тахиа шувуу, хонь, ямаа) нь бод малтай харьцуулбал хуарангийн нөхцөлд илүү тохиромжтой байж болно. Нөхөн үржихүйн мөчлөг түргэнтэй мал, амьтан буюу түргэн хугацаанд үр төлийг нь борлуулах боломжтой мал, амьтан байвал илүү тохиромжтой. Хуарангийн түр оршин суух зориулалтаар төлөвлөдөг ч ихэнх хуарангууд удаан хугацаанд үйл ажиллагаа явуулж байдаг (ялангуяа мөргөлдөөн бүхий газарт) ба малжуулах үйл ажиллагаандаа оршин суугчид нь тодорхой хугацаанд тэрхүү хуаранд амьдарна гэдгийг анхаарах шаардлагатай.

Хавсралт 9.4: Амьжиргааны наад захын хэрэгцээг хангах сүрэгт байх малын тооны талаарх хэлэлцүүлэг

Бэлчээрийн мал аж ахуй бүхий бүс нутагт хэрэгжиж буй мал сүрэг сэлбэх, шинэчлэх чиглэлийн төслүүд дээр "Амьжиргааны наад захын хэрэгцээг хангах малын тоо" хэмээх үзэл баримтлалыг байнга ашигладаг бөгөөд үүнийг ашиглан тухайн бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид нь амьдралын хэв маягаа үргэлжлүүлэн авч явахад шаардагдах малын доод тоог тодорхойлдог. Хэдийгээр Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар болон стандартууд (LEGS) зэрэг стандарт, зааварчилгаанууд нь тухайн малчдад ханган өгөх малын зохистой тоо, төрлийг шууд дурдаж болох ч бодит байдал дээр энэ нь тухайн орон нутаг, нийгмийн бүлэг бүрт ялгаатай тул ямар нэгэн стандарт тоог шууд гаргах боломжгүй юм. Үүний нэгэн адил тариалан, мал аж ахуй хослон

эрхэлдэг фермерүүдийн нөхцөлд баримтлах малжуулах мал, амьтны тоог шууд гаргах нь хүндрэлтэй юм.

Бодит байдал дээрх туршлагаас үзвэл хэдэн тооны, ямар төрлийн мал өгөхөд амьжиргаагаа хангаж чадах эсэхийг нь оролцооны дүн шинжилгээ, орон нутгийн иргэдтэй хэлэлцэх замаар тодорхойлох нь шилдэг арга зам юм. Энэ үйл явцын дунд төслийн үр ашгийн талаар тайлбарлах, малын төрөл, үүлдэр нэг бүрээр хамаарах асуудлуудыг тодорхойлон хэлэлцэх, эдгээр нь тухайн хүмүүсийн эд хөрөнгө, хүйс, настай нь хэрхэн холбогдохыг тогтоох болон орон нутагт ашигладаг уламжлалт малжуулах тогтолцооны тухай танилцах зэрэг олон зүйлийг хамарна.

Дараагийн анхаарах асуудал нь "амьжиргааны наад захын хэрэгцээг хангах малын тоог" дээрх аргаар тогтоож болох ч үүний зэрэгцээ малжуулах төсөл хэрэгжүүлж буй олон байгууллагын хувьд төсөв хөрөнгө хязгаарлагдмал байдаг тул хэрэв нэг өрхөд өгөх малын тоо нэмэгдвэл, төсөлд хамрагдах нийт өрхийн тоо буурах нөхцөл үүснэ.

Английн Хүүхдийг ивээх сан 2002 болон 2003 онуудад Зүүн Этиопын дотоодод шилжин суурьшсан 500 өрхөд гангийн дараах хариу арга хэмжээний хүрээнд, бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг тухайн өрх нэг бүрт 30 үржлийн хонь/ямаа өгч малжуулах төслийг хэрэгжүүлжээ. Тухайн төслийг Этиоп улсын Засгийн газрын гамшгийн бэлэн байдал, урьдчилан сэргийлэх хороо болон Сомали мужийн мал аж ахуйн газартай хамтран хэрэгжүүлжээ. Төслийн нийт төсөв нь ойролцоогоор 244,500 ам доллар буюу нэг өрхөд 489 ам доллар ноогдохоор байсан ажээ. Энэ төсөв нь хүнсний тусламж болон бусад өрхөд шаардлагатай зүйлсийн зардлыг багтаагаагүй бөгөөд учир нь Христийн тусламж, хөгжлийн байгууллага болон НҮБ-ын Хүүхдийн сан зэрэг бусад байгууллагууд үүнд шаардлагатай нэмэлт санхүүжилтыг гаргаж байжээ. Төслийн хийсэн үнэлгээгээр төсөл нь малжуулах үйл ажиллагаагаар дамжуулан ихээхэн хэмжээний үр ашгийг иргэдэд авчирсан ч нэг өрхөд очих багц нь хамгийн багадаа 50 хонь/ямаа байж тухайн өрх нь амьжиргаанд нь хүрэлцэхүйц, ашигтай байхуйц хэмжээнд хүрэхийг тогтоосон байна. Хэрэв энэхүү тоог баримталж, 500 өрхийг зорилтот бүлэг хэвээр нь үлдээвэл төслийн төсөв нь 41%-иар өсөхөөр байв. Эсвэл, анхлан төсөвлөсөн мөнгөө хэвээр нь үлдээн зарцуулбал энэ нь нийт 300 өрх нэг бүр 20 мал авч өгөхөд хүрэлцэх юм. Үнэлгээгээр нэг зорилтот өрхөд амьжиргаанд хүрэлцээтэй хэмжээнд хүргэхийн тулд нэг өрхөд ойролцоогоор 690 ам долларын

төсөв зарцуулах шаардлагатайг тогтоожээ (Wekesa, 2005).

Энэхүү жишээ нь хэдэн өрхийг малжуулах, хэдэн тооны мал өгөхийг тодорхойлон гаргахад тусламжийн байгууллагуудад тулгардаг асуудлууд, тухайн нөхцөлд тохируулан "малын тоо толгойг" сонгохын ач холбогдол зэргийг харуулж байна.

Хавсралт 9.5: Малын үзэсгэлэн худалдаа

Малын үзэсгэлэн худалдаа нь мал хүлээн авч буй иргэдэд олон төрөл, үүлдэр, насны малаас сонгох боломжийг олгодог арга зам юм. Уламжлалт сонгодог малжуулах аргатай харьцуулбал малын үзэсгэлэн худалдаа нь тухайн малжуулах үйл ажиллагааг илүү өөриймшүүлж, эрх мэдлийн сэтгэгдлийг төрүүлдэг, орон нутгийн эдийн засгийг эрчимжүүлэхэд дэмжлэг болдог юм. Төслөөс хийсэн хөрөнгө оруулалт нь тухайн зорилтот бүс нутгийн эдийн засагт шууд орж, мэргэжилтнүүд болон худалдаачид идэвхтэй оролцсноор санаачилга, бизнес сэтгэлгээг илүү дэмжиж өгдөг.

Малын үзэсгэлэн худалдаа нь орон нутгийн худалдаачид, малчдыг нэг доор урин авчирч зарж борлуулах, худалдан авах үйл ажиллагааг багтаасан онцлог зах зээл юм. Урьдчилан сонгогдсон ашиг хүртэгчид нь мөнгөн дүн бүхий эрхийн бичиг авч, тухайн эрхийн бичгээр өөрсдийн сонгосон малыг худалдан авдаг. Хэлцэл хийгдсэний дараа эрхийн бичиг дээр үндэслэн худалдсан талд тухайн улсын мөнгөн тэмдэгтээр төлбөрийг нь төлж барагдуулдаг. Малын үзэсгэлэн худалдаа нь мал аж ахуйн үйл ажиллагаа эрхлэж буй хүмүүсийг нэг доор цуглуулан, туршлага, мэдээлэл хуваалцах боломжийг олгодог.

Малын үзэсгэлэн худалдаа нь бүх төрлийн малжуулах хувилбарт зохимжтой. Нигер улсад хийгдсэн малын үзэсгэлэн худалдааны талаар, *Үйл явцын жишээ судалгаа 9.3*-ыг харна уу.

Ашигласан хэвлэлийн жагсаалт ба цаашид уншиж судлах материал

(ACF-Spain) Action Against Hunger – Spain (2004) *Livelihoods Recovery Project (Livestock Distribution)*, ACF-Spain, Bam.

ARVIP–Lutheran World Relief Pastoralist Survival and Recovery Program (2005) *ARVIP Proposal and Baseline Survey, Lutheran World Relief, Niamey.*

Bernard, J. (2006) *Animal Fairs, an Oxfam GB Trial in the Sahel,* Oxfam, Dakoro. Burns, J. (2006) *Mid-Term Visit Report on ARVIP,* Feinstein International Center, TuftsUniversity, Medford, MA.

Catley, A. and Blakeway, S. (2004) "Donkeys and the provision of livestock to returnees: lessons from Eritrea", in P. Starkey and D. Fielding (eds), *Donkeys, People and Development: A Resource Book of the Animal Traction Network for Eastern and Southern Africa (ATNESA)*, pp. 86–92, Technical Centre for Agricultural and Rural Cooperation, Wageningen, The Netherlands,<http://www.atnesa.org/donkeys/donkeys-catley-returnees-ER.pdf> [accessed 14 May 2014].

Croucher, M., Karanja, V., Wako, R., Dokata, A. and Dima, J. (2006) *Initial Impact Assessment of the Livelihoods Programme in Merti and Sericho,* Save the Children Canada, Nairobi.

Gebru, G. (2007) Project documentation from the *Save the Children-USA restocking implementation programme in Somali and Oromia regional states*, Save the Children USA, Addis Ababa.

Heffernan, C. (1999) *Livestock, Destitution and Drought: The Impact of Restocking on Food Security Post-Disaster*, Overseas Development Institute (ODI), London,<http://www.fao.org/wairdocs/LEAD/X6186E/X6186E00.HTM> [accessed 18May 2014].

Heffernan, C. and Rushton, J. (1999) *Restocking: A Critical Evaluation*, ODI, London.Heffernan, C., Misturelli, F. and Nielsen, L. (2004) *Restocking Pastoralists: A Manual ofBest Practice and Decision Support Tools,* Practical Action Publishing, Rugby.IFAD (International Fund for Agricultural Development) (2007) "Issues on Restocking",in *IFAD Supporting Pastoralism: Livestock and Infrastructure* [web page], IFAD, Rome, <http://www.ifad.org/lrkm/theme/livestock.htm#issues> [accessed 18 May 2014].

INEE (Inter-Agency Network for Education in Emergencies) (2010) *Minimum Standards for Education: Preparedness, Response, Recovery*, INEE, New York, <http:// toolkit.ineesite.org/toolkit/Toolkit.php?PostID=1002> [accessed 15 May 2014]. Kelly, K. (1993) *Taking Stock: Oxfam"s Experience of Restocking in Kenya*, Oxfam,Oxford.

Knight-Jones, T. (2012a) *Restocking and Animal Health: A Review of Livestock Disease and Mortality in Post-Disaster and Development Restocking Programmes*, World Society for the Protection of Animals (WSPA), London.

Knight-Jones, T. (2012b) *Restocking in the Former Yugoslavia: Post-War Restocking Projects in Bosnia-Herzegovina and Kosovo,* WSPA, London.

LEGS (Livestock Emergency Guidelines and Standards) (2014), *Livestock Emergency Guidelines and Standards*, 2nd Edition, Practical Action Publishing: Rugby.

Leguene, P. (2004) *Evaluation Report: Restoration of the Livelihood and Longer-term Food Security for the Earthquake-Affected Farmers and Agricultural Labourers in Bam, South-East Iran*, project implemented by ACF-UK & ACF-Spain, London.

Lotira, R. (2004) *Rebuilding Herds by Reinforcing Gargar/Irb among the Somali Pastoralists of Kenya: Evaluation of Experimental Restocking Program in Wajir and Mandera Districts of Kenya*, African Union/Interafrican Bureau for Animal Resources, Nairobi, <http://sites.tufts.edu/capeipst/files/2011/03/Lotira- Restocking-evaluation.pdf> [accessed 18 May 2014].

O"Donnell, M. (2007) *Cash-based Emergency Livelihood Recovery Programme, Isiolo District, Kenya*, project evaluation draft report, Save the Children, Nairobi.

Oxby, C. (1994) *Restocking: A Guide – Herd Reconstitution for African Livestock Keepers as Part of a Strategy for Disaster Rehabilitation,* VETAID, Midlothian.

Oxfam GB/Veterinaires sans Frontиres Belgium (VSF-B) (2007) *Rapport d"activite: Operation de reconstitution du cheptel, dйpartement de Dakoro, Region de Maradi, Niger, janvier 2006–mars 2007*, Oxfam GB/VSF-B, Niamey.

Save the Children International (2012) *Contribution of Cash Programming to*

Resilience, Hiran, Save the Children International, Nairobi.

Save the Children International (2013) *Drought Early Warning and FSL Needs Assessment in Hiran and Puntland; Livestock Baseline for Hiran, DFID Project; Evaluation of Livelihoods/Resilience Activities, Hiran; and Livestock and Cash Grants Project Baseline for Hiran,* Save the Children International, Nairobi.

Scott, M.F. and Gormley, B. (1980) "The animal of friendship: an indigenous model of Sahelian pastoral development in Niger", in D. Brokensha, D.M. Warren andO. Werner (eds), *Indigenous Knowledge Systems and Development*, University Press of America, Lanham, MD.

Sphere Project (2011) *Humanitarian Charter and Minimum Standards in Humanitarian Response* (the Sphere Handbook), The Sphere Project, Geneva, <www. sphereproject.org/> [accessed 21 May 2014].

Toulmin, C. (1995) "Tracking through drought: options for destocking and restocking", in I. Scoones (ed.), *Living with Uncertainty: New Directions in Pastoral Development in Africa*, pp. 95–115, Intermediate Technology Publications, London.

Vetwork (2011) *The Use of Cash Transfers in Livestock Emergencies and their Incorporation into the Livestock Emergency Guidelines and Standards (LEGS)*, Animal Production and Health Working Paper No. 1, FAO, Rome. Available from: <http://www.livestock-emergency.net/resources/general-resources-legs- specific/> [accessed 18 May 2014].

Wekesa, M. (2005) *Terminal Evaluation of the Restocking/Rehabilitation Programme for the Internally Displaced Persons in Fik Zone of the Somali Region of Ethiopia,* Save the Children UK, Addis Ababa and Acacia Consultants, Nairobi.

Санамж

1. INEE,2010 харна уу
2. Өрхөд хамаарах тоог нэгтгэн, шаардлагатай тоог бүс нутаг болон төслөөр гаргаж болно.

Хавсралтууд

Хавсралт А: Нэр томьёоны тайлбар

акарицид	хачиг хувалз устгадаг химийн бодис (цацах, дусаах болон угаах байдлаар хэрэглэдэг шингэн бодис)
түгшүүр	удаан явцтай гамшгийн хоёрдугаар шат
сэрэмжлүүлэг	удаан явцтай гамшгийн нэгдүгээр шат
антгельмент	паразит хорхойн эсрэг үйлчилгээ
буцах ачаа	барааг ямар нэг тээврийн хэрэгсэлээр тээвэрлэн буулгаж, буцахдаа өөр бараа тээвэрлэх явц (жишээ нь малын худалдаачид ирэхдээ малын тэжээл авчраад буцахдаа тухайн газраас мал ачиж буцах) гэх мэт
хөрөнгө	амьжиргааны хөрөнгө гэснийг харна уу
үргэлжилсэн гамшиг	ямар нэгэн гамшиг эргэн "хэвийн" байдалдаа оролгүйгээр, гамшгийн үе шатууд нь (сэрэмжлүүлэг, түгшүүр, онцгой байдал, сэргээн босгох) дараалан дахин дахин тохиолдох үйл явц
кластерын хандлага	онцгой байдлын үед хариу арга хэмжээний хүрээнд олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа болон тэдгээрийн санаачлага; кластер нь тодорхой тусламжийн салбарт (жишээ нь ус, ариун цэвэр эсвэл хүнс гэх мэт) төвлөрөх ба кластер нэг бүрийг тэргүүлэх байгууллагыг сонгож, тухайн байгууллага нь гишүүн байгууллагуудын өмнө хариуцлага хүлээн, хамтарсан стратеги боловсруулдаг
хүйтэн хэлхээ	хөргөгч болон зөөврийн хөргөлттэй төхөөрөмжийг ашиглан мал эмнэлэг болон хүн эмнэлгийн зориулалтай эм бэлдмэлийг хадгалах, тээвэрлэлтийн шатанд нь тодорхой температурийн хэмд хадгалах систем
хавсарсан гамшиг	дотоод болон гадаад зөрчил, мөргөлдөөнөөс хамаарч эрх мэдэл нь бүрэн эсвэл ихээр

	суларч унасан улсад нэг болон хэд хэдэн орны олон улсын байгууллага эсвэл НҮБ-ын хэрэгжүүлж буй хөтөлбөрийн чадавхиас давсан хэмжээнд хүрч хумүүнлэгийн хямрал үүссэн нөхцөл байдал
гангийн мөчлөгийн удирдлага	ганг үндсэн дөрвөн үе шатанд (сэрэмжлүүлэг, түгшүүр, онцгой байдал, сэргээн босгох) хуваан авч үздэг гангийн эсрэг хариу арга хэмжээний загвар; эдгээрийг онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд чиглэсэн баримтлах зааварчилгаа болон стандартуудад (LEGS) удаан явцтай гамшгийн үеийн дөрвөн үе шат хэмээн тодорхойлон хэрэглэдэг.
онцгой байдлын үе шат	удаан явцтай гамшгийн гуравдугаар шат
эрт үеийн сэргээн босголт	гэнэтийн гамшгийн хоёрдугаар шат
хафир	Судан улс дахь гадаргын усыг малын усан хангамжид зориулан цуглуулан авч, хадгалдаг далан
гэнэтийн хор хохирол	гэнэтийн гамшгийн нэгдүгээр үе: тохиосны яг дараах, үр нөлөө нь хамгийн өндөр буй нөхцөл байдал
нөлөөллийн үзүүлэлт	Авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд ашиг хүртэгчидийг ямар үр дүнд хүрсэнийг тодорхойлах илэрхийлэл.
үзүүлэлтүүд	үйл ажиллагааны үр дүнд гарсан ахиц дэвшлийг хэмжих хэмжүүр (тоон эсвэл чанарын); эдгээр нь үйл явцын үзүүлэлт болон нөлөөллийн үзүүлэлт хэмээн хуваагддаг
анхдагч үнэлгээ	өрхийн амьжиргаанд мал, амьтны үзүүлэх үүрэг, онцгой байдлын нөхцөл байдлын талаарх холбогдох мэдээлэл цуглуулах, тэдгээрт үндэслэн нөхцөл байдалд шинжилгээ хийх явдал
техникийн тусламж	онцгой нөхцөл үүссэн тохиолдолд үзүүлэх техникийн хариу арга хэмжээг тухайлбал: малын тоо толгойг бууруулах, мал эмнэлгийн

	үйлчилгээ үзүүлэх, тэжээл, ус, хашаа хороо, малаар хангах зэрэг ба үйл ажиллагаа нэг бүрээр хэд хэдэн сонголт болгон задлана.
үндсэн үйл ажиллагаа	стандартад хүрэхэд хувь нэмэр оруулж байгаа арга хэмжээ үе шат
амьжиргаа	эд хөрөнгө болон үйл ажиллагааг бий болгох эсвэл ард иргэд амьжиргаагаа залгуулахуйц хөрөнгө, тоног төхөөрөмж, нөөц, ур чадвар, бий болгох үйл ажиллагаа
амьжиргааны хөрөнгө	хувь хүмүүс, өрхийн амьжиргаагаа залгуулахад ашиглаж байгаа нөөц, тоног төхөөрөмж, ур чадвар, давуу тал, харилцаа холбоо эдгээрийг нийгмийн, хүний, байгалийн, санхүүгийн болон биет хэмээн ангилах ба эдгээр нь амьжиргааны хүрээг бүрдүүлдэг
амьжиргааны хүрээ	хувь хүмүүс болон өрхүүд өөрсдийн хөрөнгийг ашиглан амьжиргаагаа хэрхэн залгуулдаг болох, мөн тухайн хүмүүс хэрхэн өөрсдөө эмзэг байдлын нөлөөнд өртдөг болон тэдний амьдарч буй ахуй ~~бодлого~~ болон үйл ажиллагааны орчныг харуулсан загвар
мал, амьтны тоо толгойг бууруулах	цөөлөх, зарж борлуулсан эсвэл сүргээс тусгаарлан, зарцуулсан мал, амьтан
наад захын стандарт	минимум стандарт, онцгой байдлын нөхцөлд ашиглах боломжтой чанарын хэм хэмжээ
өвчлөл	эрүүл мэнд муудах эсвэл өвчний эмнэлзүйн шинж тэмдэг илэрч өвчлөх тохиолдол
хувилбарууд	техникийн үйл ажиллагаа нэг бүрийг хэд хэдэн сонголтуудад хуваан авч үздэг бөгөөд эдгээр нь техникийн хариу арга хэмжээг гүйцэтгэх өөр өөр арга замуудыг харуулдаг (жишээ нь зөөврийн усаар хангах эсвэл худаг гаргах гэх мэт)
үйл явцын үзүүлэлт	(ахицын үзүүлэлт) үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх лавлах цэг; ихэнхдээ чанарын үзүүлэлтүүд байна

зорилтот түүвэр	тодорхой шинж чанар дээр нь суурилан хэсэг бүлгийг (жишээ ганд өртсөн малчид, мал бүхий эмэгтэйчүүд, үерт автсан тосгоны оршин суугчид) төлөөлөх бүлгийг сонгох үйл явц
ургамлын хорио цээр, ариун цэвэр	хүнсний аюулгүй байдалтай хамааралтай; «Ариун цэвэр, ургамлын ариун цэврийн арга хэмжээг ашиглах гэрээ» нь хүнсний аюулгүй байдал болон ургамлын эрүүл ахуйн стандартыг тогтоодог; дэлгэрэнгүй мэдээллийг доор үзнэ үү <http://www.wto.org/english/tratop_e/sps_e/ spsund_e.htm>
гэнэтийн гамшиг	газар хөдлөлт, үер эсвэл цунами зэрэг гэнэт тохиож, ямар нэгэн сэрэмжлүүлэггүй явагддаг гамшиг; гурван гол үе шатанд хуваагддаг ба үүнд: гэнэтийн хор хохирол, эрт үеийн нөхөн сэргээлт, нөхөн сэргээлт гэж хуваадаг
бодит цагийн үнэлгээ	үйл ажиллагааны хэрэгжилтийн үеэр (ихэвчлэн хүмүүнлэгийн) хамаарах талуудын саналыг авч, шаардлагатай бол ажилд өөрчлөлт оруулах зорилго бүхий үнэлгээ (Sandison, 2003; and Herson and Mitchell, 2005 дээр буй Бүлэг 2: Үндсэн мал аж ахуйн бүхий л үйл ажиллагаанд хамаарах стандартууд гэсэн хэсгийг ~~үзнэ~~ харна уу)
сэргээн босгох	түргэн хурдацтай үүссэн гамшгийн гуравдахь шат эсвэл удаан хурдацтай үүссэн гамшгийн дөрөвдэхь шат
удаан явцтай гамшиг	ган болон хэт хүйтрэлт зэрэг үр нөлөө нь удаан хугацаанд үргэлжлэх нь мэдэгдэж байсан гамшиг; сэрэмжлүүлэг, түгшүүр, онцгой байдал, сэргээн босгох гэсэн дөрвөн шатанд хуваагдаг
стандарт	наад захын стандарт гэснийг харна уу.
эмзэг байдал	Цочрол болон хандлагад тэсэн үлдэх хүмүүсийн боломж; Sphere төслийн гарын авлагад эмзэг бүлгийн хүмүүсийг “байгалийн болон хүний нөлөөгөөр үүссэн гамшиг эсвэл

	мөргөлдөөнд биет, нийгмийн, байгаль орчны болон улс төрийн хүчин зүйлсийн улмаас өртөх магадлал бүхий хүмүүс " хэмээн тодорхойлдог (Sphere, 2011: 54)
зооноз	(зооноз өвчин) мал, амьтнаас (мөн хүнээс мал, амьтанд) хүнд дамжин халдварлах өвчин

Хавсралт Б: Товчилсон үгс

ACF	Өлсгөлөнгийн эсрэг үйл ажиллагаа
ACORD	Хамтын ажиллагаа, судалгаа, хөгжлийн агентлаг
ARV	Ретровирусын эсрэг эмчилгээ, ХДХВ эмчилгээ
AU-IBAR	Африкийн холбоо – Африк хоорондын малын нөөц эх үүсвэрийн газар
CAHW	Олон нийтэд суурилсан мал эмнэлгийн ажилтнууд
CBAH	Олон нийтэд суурилсан малын эрүүл мэндийн үйлчилгээ
CCCM	Хуарангийн зохицуулалт болон хуарангийн удирдлага
CFW	Бэлэн мөнгөний ажил
CPMS	Хүүхэд хамгааллын наад захын стандарт
CPWG	Хүүхэд хамгааллын ажлын хэсэг
CSO	Иргэний нийгмийн байгууллага
DFID	Олон улсын хөгжлийн газар
DRR	Гамшгийн эрсдэл бууруулах
EMMA	Онцгой байдлын зах зээлийн зураглал, шинжилгээ
EMPRES	Гамшгаас сэргийлэх систем (мал, ургамлын хил дамнасан шавьж болон өвчлөлийн)
EWS	Эрт урьдчилан сэргийлэх систем
FAO	НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага
FEWS-NET	Өлсгөлөнгийн эрт урьдчилан сэргийлэх системийн сүлжээ
FSNAU	Сомали улсын хүнсний аюулгүй байдал, тэжээллэгийн шинжилгээний нэгж
GIEWS	Дэлхийн мэдээлэл, эрт урьдчилан сануулах систем
HAP	Хүмүүнлэгийн хариуцлагатай байдлын түншлэл
HEA	Өрхийн эдийн засгийн хандлага
HPAI	Өндөр хоруу чанартай шувууны томуу
IASC	Агентлаг хоорондын байнгын хороо

ICRC	Олон Улсын Улаан Загалмайн Хороо
INEE	Онцгой байдлын үеийн боловсролын байгууллага хоорондын сүлжээ
IOM	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
IPC	Хүнсний аюулгүй байдал, хүмүүнлэгийн үе шатны нэгдсэн шинжилгээ
LEGS	Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар болон стандартууд
M&E	хяналт-шинжилгээ, үнэлгээ
MERS	Эдийн засгийн сэргээн босголт минимум стандарт
MPU	Олон зорилгот нэгж
OCHA	НҮБ-ын Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах алба
OIE	Дэлхийн Мал, Амьтны Эрүүл Мэндийн Байгууллага
PLHIV	Хүний дархлал хомсдлын вирустэй хүмүүс
PRA	Орон нутгийн оролцооны үнэлгээ (мөн оролцооны суралцах болон үйл ажиллагаа явуулах хэмээн нэрлэдэг)
PRIM	LEGS-н Оролцооны хариу арга хэмжээ тодорхойлох матриц
RDA	Зөвлөж буй тэжээллэгийн хэмжээ
SADC	Өмнөд Африкийн хөгжлийн хамтын нийгэмлэг
SMART	Гамшиг, шилжилтийн үеийн стандартчилсан мониторинг, үнэлгээ
UNDP	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
UNHCR	НҮБ-ын Дүрвэгсэдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын алба
USAID	АНУ-ын олон улсын хөгжлийн агентлаг
VAC	Эмзэг байдлын үнэлгээний хороо
VSF	Хил хязгааргүй малын эмч нар
WFP	НҮБ-ын Дэлхийн хүнсний хөтөлбөр
WHO	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
WSPA	Дэлхийн мал, амьтан хамгаалах нийгэмлэг

Хавсралт С: Ерөнхий номзүй

Aklilu, Y., Admassu, B., Abebe, D. and Catley, A. (2006) *Guidelines for Livelihoods- Based Livestock Relief Interventions in Pastoralist Areas*, United States Agency for International Development (USAID), Addis Ababa/ Feinstein International Center, Tufts University, Medford, MA.

CPWG (Child Protection Working Group) (2012) *Minimum Standards for Child Protection in Humanitarian Action*, CPWG, Geneva, <http://cpwg.net/ minimum-standards> [accessed 14 May 2014].

FAO (Food and Agriculture Organization of the United Nations) (2015) *Technical Interventions for Livestock Emergencies: The How-to-do-it Guide*, Animal Production and Health Manuals Series, FAO, Rome.

Hedlund, K. (2007) *Slow-Onset Disasters: Drought and Food and Livelihoods Security*

– *Learning from Previous Relief and Recovery Responses*, Active Learning Network for Accountability and Performance in Humanitarian Action (ALNAP) and ProVention Consortium, Geneva, <http://www.alnap.org/resource/5243. aspx>. [Accessed: 26 May 2014]. Also available from: <http://www.livestock- emergency.net/resources/general-resources/> [accessed 17 May 2014].

Honhold, N., Douglas, I., Geering, W., Shimshoni, A. and Lubroth, J. (eds) (2011) *Good Emergency Management Practice: The Essentials*, FAO Animal Production and Health Manual No. 11, FAO, Rome, <http://www.fao.org/docrep/014/ba0137e/ ba0137e00.pdf> [accessed 17 May 2014].

INEE (Inter-Agency Network for Education in Emergencies) (2010) *Minimum Standards for Education: Preparedness, Response, Recovery*, INEE, New York, <http:// toolkit.ineesite.org/toolkit/Toolkit.php?PostID=1002> [accessed 15 May 2014]. Morton, J., Barton, D., Collinson, C., and Heath, B. (2002) *Comparing Drought Mitigation Interventions in the Pastoral Livestock Sector*, Natural Resources Institute (NRI), University of Greenwich at Medway, Chatham, <http://www.nri.org/projects/pastoralism/interventions.pdf> [accessed 17 May 2014].

OCHA (United Nations Office for the Coordination of Humanitarian Affairs) (1999) *OCHA Orientation Handbook on Complex Emergencies*, UN OCHA, New York, <http://reliefweb.int/report/world/ocha-orien-

tation-handbook-complex- emergencies> [accessed 17 May 2014].

Powers, L. (2002) *Livestock Interventions: Important Principles for OFDA*, Office of US Foreign Disaster Assistance (OFDA), Washington, D.C Available from: <http:// www.livestock-emergency.net/resources/general-resources/> [accessed 17 May 2014].

SEEP (Small Enterprise Education and Promotion) Network (2010) *Minimum Economic Recovery Standards,* SEEP Network, Washington, DC, <http://www.seepnetwork.org/minimum-economic-recovery-standards-resources-174. php> [accessed 15 May 2014].

Sphere Project (2011) *Humanitarian Charter and Minimum Standards in Humanitarian Response* (the Sphere Handbook), The Sphere Project, Geneva, <www. sphereproject.org/> [accessed 15 May 2014].

USAID (United States Agency for International Development) (2005) *Field Operations Guide for Disaster Assessment and Response*, USAID, Washington, DC. Available from: <http://www.livestock-emergency.net/resources/general- resources/> [accessed 26 May 2014].

Хавсралт Д: Талархал ба хувь нэмэр оруулагчид

LEGS-н удирдах бүлгийн гишүүд

Rob Allport	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
Philippe Ankers	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
Andy Catley	Тюфтын Их сургууль дахь Фейнштэйн Олон Улсын Төв,
Wendy Fenton	Хилийн чанд дахь хөгжлийн хүрээлэнгийн Хүмүүнлэгийн Бодлогын Бүлэг,
Guido Govoni	Улаан загалмайн Олон Улсын хороо
David Hadrill	Их Британий Мал эмнэлгийн байгууллага
Solomon Haile Mariam	ПАТТЭК Африкийн Холбооны Хөдөө орон нутгийн Эдийн засаг, Хөдөө аж ахуйн Зохицуулалтын Газар,
Serena Zanella	Бие даасан зөвлөх
Cathy Watson	LEGS-н зохицуулагч

Үүсгэн байгуулагч Удирдах зөвлөлийн гишүүд

Simon Mack	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
Ongorn Prasarnphanich	Дэлхийн Мал Хамгаалах байгууллага
Piers Simpkin	Улаан Загалмайн Олон Улсын хороо

Зохицуулалт

Их Британий Мал эмнэлэгийн байгууллага (Vetwork UK)

Донорууд

LEGS төсөл нь санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлсэн дараах донорууддад гүн талархал илэрхийлж байна:

- Африкийн холбоо
- Их Британий Олон Улсын хөгжлийн Хэлтэс
- Европын холбооны Хөгжил, хамтын ажиллагааны хэлтэс (DG DEVCO- EuropeAid)
- Европын Комиссийн/Холбооны Хүмүүнлэгийн Тусламж, Иргэний Хамгаалалтын хэлтэс (ECHO)
- Тюфтын Их сургууль дахь Фейнштэйн Олон Улсын Төв
- НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
- Хилийн чанд дахь хөгжлийн хүрээлэнгийн Хүмүүнлэгийн Бодлогын Бүлэг
- Улаан загалмайн Олон Улсын Хороо
- АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Гадаад орнуудын гамшгийн тусламжийн газар
- Оксфам (Oxfam GB)
- Трикайре (Trycaire)
- Белгийн Хил хязгааргүй малын эмч нар
- Дэлхийн мал хамгаалах байгууллага
- Их Британий Мал эмнэлгийн хүрээлэн (VetworkUK)

Эдгээр хандивлагчид LEGS-н гарын авлагыг бэлтгэх, хэвлэх, тараах болон холбогдох сургалтын хөтөлбөрийг боловсруулахад хувь нэмэр оруулсан юм.

Бүлгийн зохиогчид

LEGS гарын авлагын энэхүү хоёр дахь хэвлэлт нь маш нягт нямбай засварлагдан хүрч байна.

2009 онд хэвлэгдсэн анхны гарын авлагын зохиогчид болон 2014 онд засварлагдсан хоёр дахь хэвлэлтийн зохиогчдод хамтад нь талархал илэрхийлье. Эдгээр зохиогчид нь:

Мал аж ахуй, малчдын амьжиргаа ба онцгой байдал: Cathy Watson/Andy Catley

Нийтлэг стандартууд: Andy Catley/Cathy Watson

Анхны үнэлгээ ба хариу үйлдэлийг тодорхойлох нь: Cathy Watson/Andy Catley Destocking: Yacob Aklilu/Simon Mack

Мал эмнэлгийн дэмжлэг: Andy Catley and David Ward/David Hadrill

Тэжээлийн хангамж: Peter Thorne/Philippe Ankers

Усны хангамж: Peter Thorne/Guido Govoni

Малын хашаа саравч ба суурин байдал: David Hadrill and Peter Manfield/Cathy Watson

Малжуулах: Helene Berton and Andy Catley/Ong-orn Prasarnphanich

Зохицуулагч редактор: Cathy Watson

Редактор: Green Ink and Cordelia Lilly

Фото зураглаачид

Танилцуулга, Бүлэг 4, Бүлэг 5, Бүлэг 7 and Бүлэг 9: Kelley Lynch/АНУ-ын Хүүхдийг ивээх сан USA

Бүлэг 1: Marco Longari-FAO-НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага

Бүлэг 2: Ana Urgoiti

Бүлэг 3: Astrid de Valon

Бүлэг 6: David Hadrill

Бүлэг 8: The Brooke

Товч танилцуулах хуудас

*LEGS төслийн товч танил*цуулах хуудас нь удирдлагын багт энэхүү гарын авлагыг хянан засварлахад зориулсан хуудас юм. Энэхүү хуудсын зохиогчид нь:

- *Мал амьтны тавлаг байдал: Ian Dacre*
- *Бэлэн мөнгө тараах: Tim Leyland*
- *Уур амьсгалын өөрчлөлт: John Morton*
- *Жендер: Beth Miller*
- *Мал амьтан ба хуаран: The Shelter Centre and Julia Macro*

LEGS-н зөвлөх баг ба цахим хаягийн жагсаалт

Сонирхсон талуудад энэхүү гарын авлагын анхны болон хоёр дахь хэвлэлтэд цахим хаягаар дамжуулан өөрийн санал хүсэлтээ илгээж зөвлөхийг урьсан билээ. LEGS гарын авлагын анхны болон хоёр дахь хэвлэлтийн аль аль нь эдгээр санал хүсэлтээр баяжигдсан юм. Энд нэрийг нь жагсаахад дэндүү олон тооны хүмүүс өөрийн мэдлэг ур чадвар, туршлагаасаа хуваалцсан билээ. LEGS төслийн зүгээс эдгээр бүх хүмүүст үнэтэй санал зөвлөмжөө өгсөнд нь ихэд талархаж байгаагаа илэрхийлье.

Хавсралт E: LEGS-н сургалтын хөтөлбөр

LEGS-н сургалтын хөтөлбөрийг тус стандартыг таниулах гурван өдрийн Бүсийн сургагч багшийн сургалтаар оролцогчдод өгөгдсөн мэдлэг чадвар, арга зүй, материалд тулгуурлан боловсруулна. Сургагч багшийн сургалт (ТОТ) төгсөгчид нь LEGS-н сургагч багш болох бөгөөд өөрийн улсынхаа эрэлтэд тулгуурлан энэхүү сургалтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. "LEGS-н гэрчилгээжсэн сургагч багш" нь ТОТ хамрагдсанаас хойших хоёр жилийн дотор хоёр сургалтыг амжилттай зохион байгуулсан байх ба тэдний холбоо барих хаяг нь LEGS-н албан вэбсайт дээр бүртгэгдсэн байна. LEGS-н төсөл өөрөө дээрх гурван өдрийн сургалтыг хийхгүй байгаа ч LEGS-н сургагч багшийн датабаазыг хөтлөн энэ сургалтыг үргэлжлүүлэн хянаж байна. Эдүгээ дэлхий даяар 300 гаруй LEGS-н сургагч багш байна.

LEGS –н энэхүү гурван өдрийн сургалтыг гамшгийн хариу арга хэмжээ хэрэгжүүлэгч ажилтнуудад зориулан боловсруулсан LEGS-н гарын авлага номонд суурилан хэрэгжүүлнэ. Эмэгтэйчүүд ихэвчлэн мал маллагч,

арчлагч (малын эзэн гэхээс илүү) байдаг шигээ голдуу мал аж ахуйд чиглэсэн үйл ажиллагааны оролцогч байдаг. Тэгэхээр тэдэнд хүрч ажиллаж чадах эмэгтэй мал аж ахуйн сургагч ажилтнууд хэрэгцээтэй болдог. Энэ үүднээс LEGS-н сургалтад хамрагдах эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэхийг зорьдог. Энэхүү сургалт нь тэдэнд LEGS-н гарын авлагын гол хэсгүүдтэй өөрсдөө танилцаж, тэдгээрийг мал сүрэгт тохиолдсон онцгой байдлын үе шат бүр авч ашиглах, үе шат бүрт хэрэглэх арга хэрэгслийг мэдэж авахад тусалдаг. Тухайлбал:

1. Анхдагч үнэлгээний үе шатанд-амьжиргаанд мал сүргийн гүйцэтгэх үүргийг оролцуулаад
2. Хариу арга хэмжээ тодорхойлох шатанд PRIM-аар
3. Мал амьтанд чиглэсэн хариу арга хэмжээ тус бүрийн хувьд шийдвэрийн модны загвар, стандарт, голлох үйл ажиллагаа ба зааварчлага зэрэг оролцооны арга хэрэгслийг ашиглан хамгийн зохистой, боломжтой, цаг хугацаагаа олсон үйл ажиллагааны хувилбараа сонгоход
4. Мониторинг ба үнэлгээний шат

Бүдүүвч Е.1 LEGS-н хариу арга хэмжээний үе шатууд

Бүдүүвч Е.2 LEGS-н хариу арга хэмжээний үе шатуудад зориулсан арга хэрэгслүүд

3-р үе шатны тухайд LEGS-н сургалтын үед хариу арга хэмжээг төлөвлөх таван алхамд доорх арга хэрэгслийг ашиглана (*Хайрцаг Е.1* үзнэ үү).

Хайрцаг E.1 Хариу арга хэмжээний хөтөлбөрийг төлөвлөх таван алхам

1. Тухайн хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбогдох хувилбарын талаарх дүгнэлт ба тэдгээр ач холбогдлыг тоймлон үзэх
2. Давуу ба сул талын хүснэгтийг хянаж нягтлах
3. Зохистой хугацааны хүснэгтийг хянах
4. Шийдвэрийн модны загвар дээр ажиллах
5. Хөтөлбөрийн хариу арга хэмжээг төлөвлөхдөө стандартууд, голлох үйл ажиллагаа ба зааварчлагыг дагаж мөрдөх.

LEGS төсөл нь шийдвэр гаргагчид ба ивээн тэтгэгчдэд зориулсан LEGS-н талаар ойлголт буй болгох хагас өдрийн сургалтыг зохион байгуулдаг. Энэ сургалт нь мал сүрэгт нүүрлэсэн онцгой байдлын үеийн хариу арга хэмжээтэй холбоотой гол асуудлууд, LEGS-н гарын авлагын агуулгын тойм ба голлох шийдвэр гаргах арга хэрэгслүүдийг таниулдаг юм.

LEGS-н сургалтын хөтөлбөртэй холбоотой илүү дэлгэрэнгүй мэдээллийг LEGS-н сургалтын вэб хуудаснаас авах буюу LEGS-н сургалтын Зохицуулагчтай <Training@livestock-emergency.net>хаягаар холбоо барина уу.

LEGS-н талаар холбоо барих:

Visit the LEGS website: <www.livestock-emergency.net/> Email: <Coordinator@livestock-emergency.net>

LEGS-н гарын авлагыг захиалах бол дараах хаягаар хандана уу:

Via the LEGS website: <www.livestock-emergency.net/> or direct from the publisher: <https://developmentbookshop.com/livestock-emergency- guidelines-and-standards>

LEGS-н амьжиргааг дэмжих зорилтууд

1. Мал сүргийн нөөцөө ашиглан хүмүүст яаралтай тусламж үзүүлэх
2. Амьжиргааны голлох мал хөрөнгийг хамгаалах
3. Амьжиргааны голлох мал хөрөнгийг нөхөн сэргээх

Салбар бүрт хамаарах асуудал

1-Хүйсийн ба нийгмийн тэгш байдал
2-ХДХВ ДОХ
3-Хамгаалал
4-Хүрээлэн байгаа орчин ба уур амьсгал

Хүний эрхэнд тулгуурласан арга барилтай холбогдох нь

- Хооллох эрх
- Амьдрах эрх

Наад захын стандарт, үндсэн үйл ажиллагаа ба зааварчилгаа

Наад захын стандарт

- Онцгой байдлын хариу арга хэмжээний хамгийн чухал хэсгийг тодорхойлон гаргадаг
- Чанарын ерөнхий шаардлагууд